

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ



ТОЙМ АГУУЛГА

- ◇ Макро эдийн засаг
- ◇ Эрх зүй, төрийн байгуулал
- ◇ Эдийн засгийн бодит салбар

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

“Судалгааны эмхэтгэл” (XXII боть)-ийг
Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.

Хянасан:

Ц.Норовдондог (PhD)

Эмхэтгэсэн:

Д.Жигваагүнсэл

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Г.Сугарсүрэн

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ГАРЧИГ

I БҮЛЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСАГ

- 1.1 Монгол Улс дахь хөрөнгө оруулалтын бодлогын эрх зүйн орчин** 8-17
Ц.Норовдондог (PhD), Ц.Болормаа, Д.Жигваагүнсэл, Б.Нандингэрэл, Ч.Онончимэг, Д.Халиун
- 1.2 Гадаадын зарим орны барьцаалан зээлдүүлэх журмаар олгох /ломбард/ зээлийн хүүгийн хязгаарыг тогтоохтой холбоотой эрх зүйн зохицуулалт** 18-21
Г.Алтан-Оч (PhD), Ц.Болормаа, Ө.Мөнхтунгалаг О.Нарантуяа, Б.Нандингэрэл, И.Жаргалзаяабямба Д.Жигваагүнсэл, Ч.Онончимэг, Г.Чулуун, А.Пагма
- 1.3 Жижиг дунд үйлдвэрийн хөгжлийн бодлого, эрх зүйн орчны тойм судалгаа** 22-44
Ц.Болормаа, Ч.Онончимэг, Д.Халиун
- 1.4 Эдийн засаг, бизнесийн өсөлтөд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь: жижиг дунд үйлдвэрлэлийн салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоо, тулгамдсан асуудлууд** 45-52
Ц.Норовдондог (PhD)

II БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

- 2.1 Их Британи, Израилийн Парламентын сонгуулийн дүн - 2015** 54-55
Р.Хатанбаатар, А.Пагма
- 2.2 Дэлхийн улс орнуудын төрийн удирдлагын хэлбэр, парламентын засагтай орнуудын сонгуулийн зарчим** 56-118
Ц.Болормаа, Д.Жигваагүнсэл, Ч.Онончимэг, Д.Халиун
- 2.3 Бүгд Найрамдах Сингапур Улсын засаг захиргааны нэгжийн бүтэц, зохион байгуулалт** 119-120
Ө.Мөнхтунгалаг
- 2.4 Дэлхийн улс орнуудын Үндсэн хуульд төрийн тэргүүний эрх зүйн статусыг тодорхойлсон байдал** 121-143
Ц.Болормаа, Д.Жигваагүнсэл, Б.Нандингэрэл, Ч.Онончимэг, Д.Халиун

2.5 Парламентын Бүгд Найрамдах Улсуудын сонгуулийн саналын босго болон 2015 оны 11 дүгээр сард явагдсан парламентын сонгуулийн талаарх лавлагаа	144-150
--	----------------

Д.Халиун

2.6 Гадаадын зарим орны Дэгийн тухай хуулиар парламентын хэлэлцүүлгийн дэгийг зохицуулсан байдал	151-168
---	----------------

*Р.Хатанбаатар, А.Пагма, Ц.Болормаа
Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг,
О.Нарантуяа, Б.Нандингэрэл, Д.Халиун*

2.7 Байнга төвийг сахих статустай улсууд: туршлага, сургамж	169-179
--	----------------

А.Пагма, Ц.Болормаа, Д.Жигваагүнсэл

2.8 Сонгуулийн пропорционал тогтолцоо бүхий улс орнуудын суудал хуваарилах арга, босгын хувь болон тойргийн хэлбэр	180-185
---	----------------

*Ц.Болормаа, Д.Жигваагүнсэл,
Ч.Онончимэг, Д.Халиун*

2.9 Хууль болон олон улсын гэрээ конвенцийг хэвлэн нийтлэх, хүчин төгөлдөрт тооцох албан ёсны орчуулга хийх эрх зүйн зохицуулалтын талаарх бусад орны туршлага	186-198
---	----------------

*Г.Алтан-Оч (PhD), Ц.Болормаа, Ө.Мөнхтунгалаг
О.Нарантуяа, Б.Нандингэрэл, И.Жаргалзаяабямба
Д.Жигваагүнсэл, Ч.Онончимэг, Г.Чулуун, А.Пагма,
Д.Халиун*

2.10 Гадаадын зарим орны парламентын дэгийг тогтоодог эрх зүйн актын лавлагаа	199-201
--	----------------

*А.Пагма, Ц.Болормаа, О.Нарантуяа,
Б.Нандингэрэл, И.Жаргалзаяабямба,
Д.Жигваагүнсэл, Ч.Онончимэг, Д.Халиун*

III. БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ САЛБАР

3.1 Гадаадын зарим орны уул уурхайн баялгийн сангийн зохицуулалт, туршлага	204-219
---	----------------

*О.Нарантуяа, Б.Нандингэрэл,
Ч.Онончимэг*

3.2	Монгол болон гадаадын улс орнуудын уул уурхайгаас ангид бүс байгуулахтай холбогдсон эрх зүйн орчин, практик ач холбогдол.....	220-237
------------	--	----------------

*Ц.Болормаа, Д.Жигваагүнсэл,
Д.Халиун, Г.Чулуун*

3.3	Мега төсөл хэрэгжүүлэх шийдвэр гаргах процесс, оролцогч талууд, тэдгээрийн онцлог	238-263
------------	--	----------------

*Ц.Болормаа, Б.Нандингэрэл,
Д.Жигваагүнсэл, Ч.Онончимэг, Д.Халиун*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1

БҮЛЭГ

МАКРО ЭДИЙН ЗАСАГ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**МОНГОЛ УЛС ДАХЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
БОДЛОГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

*Ц.Норовдондог (PhD), Ц.Болормаа, Д.Жигваагүнсэл,
Б.Нандингэрэл Ч.Онончимэг, Д.Халиун*

Өнөөгийн байдлаар Монгол улсад хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны хүрээнд ерөнхий зохицуулалтын 30, салбарын зохицуулалтын 34 хууль үйлчилж байна. Мөн хөрөнгө оруулалтыг дэмжих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд батлан гаргасан УИХ-ын тогтоол 14, Засгийн газрын тогтоолоор баталсан 29 журам тус тус хүчин төгөлдөр үйлчилж байна. /Лавлагаа хавсаргав/.

2013 онд **Хөрөнгө оруулалтын** тухай хуулийг батлан гаргаснаар “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль”, “Стратегийн ач холбогдолтой аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль” хүчингүй болж, хөрөнгө оруулагчдыг дотоод, гадаадын хөрөнгө оруулагч гэж ялгаварлалгүйгээр төрөөс тэгш, шударга дэмжих эрх зүйн орчин бүрдсэн гэж хэлж болно.

“Хөрөнгө оруулалтын тухай” хуульд зааснаар хөрөнгө оруулалтын дараах хэлбэрүүд байна. /5-р зүйл / Үүнд:

- Хөрөнгө оруулагч дангаараа болон бусад хөрөнгө оруулагчтай хамтран аж ахуйн нэгж байгуулах;
- Хөрөнгө оруулагч хувьцаа, өрийн бичиг, бусад төрлийн үнэт цаасыг худалдан авах;
- Компанийг нэгтгэх, нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх;
- Концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах;
- Санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх
- Хуулиар хориглоогүй бусад хөрөнгө оруулалт.

Түүнчлэн, хөрөнгө оруулалт нь гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт гэсэн ерөнхий хэлбэртэй бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт нь шууд ба шууд бус, дотоодын хөрөнгө оруулалт нь төсвийн болон концессийн хөрөнгө оруулалт хэлбэртэй байхаар хуульчилсан.

Хуулийн 5 дугаар бүлгийн 20 дугаар зүйлд зааснаар **500 тэрбум төгрөгөөс** дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай, түүнийг хүсэлт гаргасан тохиолдолд үйл ажиллагаа явуулах орчныг нь тогтвортой байлгах зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээг байгуулахаар заасан.

Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд /21-р зүйл/ уул уурхай, банк санхүү, хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг эзэмшихээр бол хуулиар тогтоосон зохих шалгуурыг хангаж Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авахаар хуульчлан тогтоосон байдаг.

Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд гэдэгт нийт гаргасан хувьцааных нь 50, түүнээс дээш хувийг гадаад улсын төр шууд болон шууд бусаар эзэмшиж байгаа хуулийн этгээдийг ойлгохоор хуульчилсан байна.

Түүнчлэн, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн бас нэгэн шинэлэг зохицуулалт нь “Тогтворжуулах гэрчилгээ” буюу татварын орчны тогтворжуулалт юм. Энэ нь 16 дугаар зүйлд зааснаар татварын орчинг тогтворжуулахад дараах шалгуур тавигдаж байна.

- **Уул уурхайн олборлолт, хүнд үйлдвэр, дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан дараах хугацаагаар татварын орчныг тогтворжуулна. Үүнд:**

Хөрөнгө оруулалтын хэмжээ /тэрбум төгрөгөөр/	Хөрөнгө оруулалт хийж дуусах хугацаа /жилээр/					
	Улаанбаатарын бүс	Төвийн бүс Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өмнөговь, Сэлэнгэ, Төв	Хангайн бүс Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай Хөвсгөл	Зүүн бүс Дорнод, Сүхбаатар, Хэнтий	Баруун бүс Баян-Өлгий, Говь- Алтай, Завхан, Увс, Ховд	Тогтворжуулах гэрчилгээ олгох хугацаа /жилээр/
30-100 хүртэл	5	6	6	7	8	2
100-300 хүртэл	8	9	9	10	11	3
300-500 хүртэл	10	11	11	12	13	4
500-аас дээш	15	16	16	17	18	5

- **Уул уурхайн олборлолт, хүнд үйлдвэр, дэд бүтцээс бусад салбарт:**

Хүснэгт 1

Хөрөнгө оруулалт хийж дуусах хугацаа /жилээр/						
Улаанбаатарын бүс	Төвийн бүс Говьсүмбэр Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өмнөговь, Сэлэнгэ, Төв/	Хангайн бүс /Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай Хөвсгөл/	Зүүн бүс /Дорнод, Сүхбаатар, Хэнтий/	Баруун бүс /Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд/	Хөрөнгө оруулалтын хэмжээ /тэрбум төгрөгөөр/	Тогтворжуулах гэрчилгээ олгох хугацаа /жилээр/
10-30 хүртэл	5-15	4-12	3-10	2-8	5	2
30-100 хүртэл	15 -50	12-40	10-30	8-25	8	3
100-200 хүртэл	50 -100	40-80	30-60	25-50	10	4
200-аас дээш	100-аас дээш	80-аас дээш	60-аас дээш	50-аас дээш	15	5

Түүнчлэн дараах төслийг хэрэгжүүлэх тохиолдолд тогтворжуулах гэрчилгээний хугацааг дээр заасан хугацаанаас 1.5 дахин уртасган тооцохоор заасан. Үүнд:

- Улс орны нийгэм, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжилд онцгой ач холбогдол бүхий импортыг орлох болон экспортлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, техник, эдийн засгийн үндэслэл батлагдсан өдрийн Төв банкны албан ханшаар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх тооцоотой, бүтээн байгуулалтын ажилд гурваас дээш жил шаардагдах төслийг байршил, салбар харгалзахгүйгээр;
- Хуулийн 16.1-д заасан шалгуурыг хангасан хөрөнгө оруулагч хуулийн этгээд нэмүү өртөг шингэсэн боловсруулах үйлдвэрлэл эрхлэн, үндсэн бүтээгдэхүүнээ экспортод гаргаж байгаа;

Монгол Улсад хөрөнгө оруулж буй тохиолдолд дараах татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхээр хуульд заасан. /ХОТХ, 10-р зүйл/ Үүнд:

Татварын дэмжлэг:

- Албан татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх, татвар ногдох орлогоос элэгдлийн зардлыг хасах, алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох, ажилтны сургалтын зардлыг татвар ногдуулах орлогоос хасч тооцох гэх мэт.

- Импортын техник, тоног төхөөрөмжийг тодорхой нөхцөлд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг тэглэх хүртэл арга хэмжээ авах

Татварын бус дэмжлэг /12-р зүйл/

- Газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах;
- Чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулах тохиолдолд бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсөн горимоор үйлчлэх;
- Дэд бүтэц, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, боловсролын салбарын бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоог нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, холбогдох зөвшөөрлийг хөнгөвчилсөн горимоор олгох;
- Инновацийн төслийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, экспортод чиглэсэн инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн санхүүжилтэд батлан даалт гаргах;
- Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн гадаадын хөрөнгө оруулагч, түүний гэр бүлд олон удаагийн орж гарах виз болон байнга оршин суух зөвшөөрөл олгох гэх мэт.

Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг Газрын тухай, Чөлөөт бүсийн тухай, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Инновацийн тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

Хөрөнгө оруулалтын тухай хууль батлагдсанаар хөрөнгө оруулалтын орчинд дараах зэрэг өөрчлөлт гарсан гэж зарим судлаачид үзсэн байна.

1. Тогтворжуулах гэрчилгээ: Хөрөнгө оруулалтын тухай хуулийн зарчмын үндсэн том өөрчлөлтийн нэг нь Тогтворжуулах гэрчилгээ олгох замаар татварын орчныг тогтворжуулах зохицуулалт хийсэн. 1993 онд баталсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд Тогтвортой байдлын гэрээг хөрөнгө оруулагчидтай байгуулахаар заасан байдаг. Энэхүү Тогтвортой байдлын гэрээг Тогтворжуулах гэрчилгээгээр сольсон бөгөөд гэрээгээр биш хуулиар тогтвортой байдлыг бий болговол хөрөнгө оруулж байгаа болон хөрөнгө оруулалт татаж байгаа аль аль талдаа ашигтай юм. Энэ бодлого Хөрөнгө оруулалтын тухай хуульд шингэж, “Тогтворжуулах гэрчилгээ” гэсэн шинэ нэр томъёо орж ирсэн байна.
2. Тогтвортой байдлын гэрээ: 1993 онд батлагдсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд Монгол Улсад 20 сая ам.доллар буюу түүнтэй тэнцэх төгрөгөөс доошгүй хэмжээний хөрөнгө оруулагчтай тогтвортой байдлын гэрээ байгуулах тухай заасан байдаг. Харин энэ хуулиар тогтвортой байдлын гэрээг “Тогтворжуулах гэрчилгээ” болгосноор хөрөнгө оруулагчид 4 төрлийн татварын орчныг тогтвортой байлгахад хуульчилсан нь тус зохицуулалт урт хугацаанд тогтвортойгоор үйлчлэх байх гэсэн итгэлийг хөрөнгө оруулагчдад өгч, улмаар аль ч хөрөнгө оруулагч нарт эрх зүйн таатай нөхцлийг бүрдүүлсэн юм.
3. Тогтворжуулах гэрчилгээний шалгуур, хязгаарлалт-ыг хуульчлан тогтоож өгсөн. Ингэснээр 10 сая долларын хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгж болгон Тогтворжуулах гэрчилгээ авах боломжгүй болох бөгөөд хөрөнгө оруулах нөхцөл бодитоор дээшилсэн байна. Тогтворжуулах гэрчилгээ авахад байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх, шинээр ажлын байр бий болгох, шинэ техник технологи нэвтрүүлж буй эсэхийг харгалзан үзнэ. Эдгээр шалгуурыг хангасан хөрөнгө оруулагчдад Тогтворжуулах гэрчилгээ олгоно. Тогтворжуулах гэрчилгээний давуу тал нь гэрчилгээ олгосон үндэслэл нээлттэй ил тод байна.
4. Хөрөнгө оруулалтын гэрээ: Хөрөнгө оруулалтын гэрээ хийх эрх бүхий хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын босгыг өндөр болгосноор хөрөнгө оруулалтаас

үүсэх мөнгөн урсгалын хэмжээ ихсэж, эдийн засагт эерэгээр нөлөөлөх нөхцөл бүрдсэн. Хөрөнгө оруулалтын гэрээг гадаадын хөрөнгө оруулагчтай ихэвчлэн хийдэг байсан бол Хөрөнгө оруулалтын тухай хуулиар гадаад, дотоод хөрөнгө оруулагч гэж ялгахгүй бөгөөд зөвхөн 500 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулалт хийсэн ямар ч хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтын гэрээ хийх боломжтой болсон. Дотоодын хөрөнгө оруулагчдад ижил тэгш хандаж байгаа энэ бодлогыг үндэсний компаниудаа дэмжих том бодлого хэмээн компаниуд хүлээн авч байгаа нь судалгаанаас харагдаж байна.

5. Тогтвортой байдлын гэрчилгээ олгох субъектийг хуулиар тусгайлан заасан: Тогтворжуулах гэрчилгээг олгох эсэхийг шийдвэрлэх гол байгууллага нь шинээр байгуулагдах Хөрөнгө оруулалтын зөвлөл. Уг зөвлөл Тогтворжуулах гэрчилгээ авахыг хүссэн аж ахуйн нэгж, төслийг хянаж гэрчилгээ олгох эсэхийг шийдвэрлэхээс гадна гадаадын төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа явуулах эсэхэд зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх чиг үүрэг бүхий байнгын бус ажиллагаатай байгууллага юм. Зөвлөлөөс зөвшөөрсөн тохиолдолд хөрөнгө оруулалт хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Тогтворжуулах гэрчилгээг олгох юм.
6. Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд хөрөнгө оруулалт хийх: Түүнчлэн гадаадын төрийн өмчит хуулийн этгээд Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх тохиолдолд хяналт болон үндэсний аюулгүй байдлын бусад харилцааг харгалзан үзэж тодорхой зохицуулалт хийсэн байна. Үүнд: Уул уурхай, банк санхүү, хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх, Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл авахаар заасан нь үндэсний язгуур эрх ашиг, аюулгүй байдлыг хангахад ач холбогдол бүхий зохицуулалт болсон.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийг батлан гаргахад дараах нөхцөл байдлуудыг харгалзан үзэх шаардлагатай байсан гэсэн шүүмжийг хэлэлцүүлгийн явцад судлаач, нийтлэлчдийн зүгээс гаргасан байна. Үүнд:

Судлаачдын зүгээс Хөрөнгө оруулалтын хуульд зохицуулаагүй орхисон, хэт ерөнхийлсөн санаа байна гэж шүүмжилдэг. Тухайлбал:

- Тогтворжуулалтын гэрчилгээ олгохоос татгалзах үндэслэл тодорхой бус
- “нэмүү өртөг шингээсэн үйлдвэрлэл” гэж яг юуг ойлгох тухай тодорхой тусгах шаардлагатай.
- Зөвхөн 4 төрлийн татварыг л тогтворжуулахаар заасан нь экспортын татвар, онцгой албан татвараар хөрөнгө оруулагчдыг дарамтлахад хүргэх вий гэсэн болгоомжлол төрүүлж болох,
- Хөрөнгө оруулалтын татварын бус дэмжлэгийн тухай зарим заалт нь иргэний нийгмийн байгууллагыг болгоомжлоход хүргэж байна. Тухайлбал:
 - газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 жил хүртэл хугацаагаар сунгах,
 - гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоо, хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, холбогдох зөвшөөрлийг хөнгөвчилсөн горимоор олгох,
 - чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх, бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсөн горимоор үйлчлэхээр заасан нь иргэний нийгмийн зүгээс ихээхэн шүүмжлэл дагуулдаг.

2. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зохицуулалт

Түүнчлэн дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжиж, үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг сайжруулах, үнэ цэнэ шингэсэн байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний экспортын чиг баримжаа бүхий үйлдвэрлэлийг хөгжүүлэх, импортыг орлох үйлдвэрлэлийг төрөөс дэмжин хөгжүүлэх зорилгоор 2015 оны 7 сард Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль баталсан болно.

Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг УИХ-аар 2015 оны 07 сарын 29-ны өдөр хэлэлцэн баталсан бөгөөд тус хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт тарьж ургуулсан, өсгөж үржүүлсэн, олборлосон, эсхүл импортын түүхий эдээр үнэ цэнэ шингээж боловсруулалт хийсэн экспортын чиг баримжаатай, импортыг орлох эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг төрөөс дэмжих харилцааг зохицуулсан болно.

Өөрөөр хэлбэл, Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хуулийн этгээд мөн ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах үйл ажиллагааг дээрх дэмжлэгт хамааруулаагүй болно.

Төрөөс үйлдвэрлэлийг дэмжих хэлбэрийг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

1. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа үндэсний үйлдвэрт технологийн шинэчлэл хийсэн хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгөд зориулан арилжааны банкнаас олгосон зээлийн хүүгийн зөрүүг олгох;
2. Өндөр үр ашиг бүхий дэвшилтэт технологи болон өндөр технологи бий болгон, нэвтрүүлж нутагшуулсан экспортын үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэлх хугацаанд судалгаа, хөгжилд зарцуулсан зардлын 75 хүртэлх хувьтай тэнцэх дэмжлэгийг нэг удаа улсын төсвөөс тухайн үйлдвэрт буцааж олгох;
3. Экспортын үйлдвэрлэлийг экспортын санхүүжилтийн төрөл бүрийн арга хэрэгсэл, түүний дотор факторингийн үйлчилгээг хөгжүүлэх замаар дэмжих зэрэг болно.

Дээрх дэмжлэгийг Үйлдвэрлэлийг дэмжих сангаар дамжуулан дотоодын түүхий эд болон импортын түүхий эдийн нөөцөд тулгуурлан үнэ цэнийн сүлжээг бий болгосон нөхцөлд олгох ба дараах шаардлагыг хангасан бол давуу эрх олгохоор тусгажээ.

Үүнд:

- *нээлттэй хувьцаат компани байх;*
- *үйлдвэрлэлийн үндсэн болон туслах материал, бусад хэрэгцээт бараа, ажил, үйлчилгээний 60-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэгчээс хангасан байх;*
- *технологийн бүртгэлийн нэгдсэн санд бүртгэлтэй байх.*

Үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгө нь улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, олон улсын байгууллага, гадаад улсаас үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгосон зээл, олон улсын байгууллага, гадаад улсаас өгсөн хандив, тусламж зэргээс бүрдэх ба уг улсын төсвөөс жил бүр хөрөнгө хуваарилахаар хуульчилсан байна.

Хавсралт1

**МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХАРИЛЦААГ
ЗОХИЦУУЛЖ БУЙ ГОЛ ХУУЛИУД**

№	Огноо	Хуулийн нэр	Нэмэлт өөрчлөлт орсон огноо
1	2002-01-10	Иргэний хууль	2015-07-02
2	2013-10-03	Хөрөнгө оруулалтын тухай хууль	2015-05-14
3	2013-10-03	Хөрөнгө оруулалтын сангийн тухай	-
4	2011-10-06	Компанийн тухай хууль	2015-06-19
5	2010-01-28	Концессийн тухай хууль	2015-10-30
6	2008-05-20	Татварын ерөнхий хууль	2015-07-09
7	2006-07-08	Ашигт малтмалын тухай хууль	2015-06-04
8	2001-02-01	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	2015-08-07
9	2006-06-29	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	2015-06-04
10	2001-04-12	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль	2015-02-12
11	2012-05-17	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	2015-01-23
12	2008-05-20	Гаалийн тухай хууль	2015-05-29
13	2008-05-20	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль	2014-07-01
14	2005-07-01	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль	2013-02-07
15	2014-07-01	Газрын тосны тухай хууль	2015-07-09
16	2011-02-10	Монгол Улсын хөгжлийн банкны тухай хууль	2014-10-16
17	2015-07-09	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль	-
18	2006-06-29	Онцгой албан татварын тухай хууль	2015-10-30
19	2015-02-18	Өрийн удирдлагын тухай хууль	2015-10-30
20	2006-06-22	Санхүүгийн түрээсийн тухай хууль	-
21	2010-06-24	Төсвийн тогтвортой байдлын тухай хууль	2015-11-10
22	2011-12-23	Төсвийн тухай хууль	2015-11-10
23	2009-06-25	Улсын бүртгэлийн ерөнхий хууль	2015-11-13
24	2015-07-09	Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль	-
25		Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль	-
26	2010-01-21	Хөрөнгийн үнэлгээний тухай хууль	-
27	2011-06-02	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль	2015-11-10
28	2010-04-23	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль	-
29	2015-01-29	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль	-
30	2015-02-12	Чөлөөт бүсийн тухай хууль	-

**МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫГ ЗОХИЦУУЛЖ БУЙ
ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛИУД**

№	Огноо	Холбогдох хуулийн нэр	Нэмэлт өөрчлөлт орсон огноо
1	1998-01-02	Авто замын тухай хууль	2014-05-15
2	2012-05-17	Агаарын тухай хууль	2015-11-13
3	2010-06-24	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль	2015-11-13
4	2015-06-19	Аудитын тухай хууль	-
5	2000-05-05	Аялал жуулчлалын тухай хууль	2011-01-20
6	2012-05-17	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль	-
7	1995-03-30	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	2015-07-08
8	2010-01-28	Банкны тухай хууль	2015-07-09
9	2008-02-05	Барилгын тухай хууль	2015-07-02
10	2003-05-30	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай	2014-10-31
11	2002-06-07	Газрын тухай хууль	2015-07-08
12	1997-04-24	Газрын төлбөрийн тухай хууль	2012-05-22
13	1988-11-29	Газрын хэвлийн тухай хууль	1995-04-17
14	2009-07-16	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай	-
15	2007-07-27	Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль	2015-01-29
16	2012-02-10	Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль	-
17	2011-10-20	Зээлийн мэдээллийн тухай хууль	-
18	2012-05-22	Инновацийн тухай хууль	2015-01-23
19	2002-06-27	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль	2012-05-18
20	1994-05-31	Нийгмийн даатгалын тухай хууль	2015-01-30
21	2015-06-19	Нийслэл хотын албан татварын тухай	-
22	2015-06-19	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	-
23	2010-06-10	Өрсөлдөөний тухай хууль	2015-06-19
24	2008-02-06	Татварын өршөөл үзүүлэх тухай хууль	2008-05-09
25	2005-12-01	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль	2015-07-09
26	2014-01-09	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль	-
27	2012-05-17	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль	-
28	2012-05-17	Усны тухай хууль	2012-08-17
29	2002-11-07	Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай	2011-10-28
30	2008-05-29	Хот байгуулалтын тухай хууль	2015-06-26
31	2006-06-16	Хувь хүний орлогын албан татварын тухай	2015-07-09
32	2009-11-18	Хүний хөгжил сангийн тухай	2015-05-21
33	1995-01-16	Цахилгаан, дулааны эрчим хүч, нүүрсний төлбөрийн тухай	-
34	2003-06-19	Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль	2011-10-20

Хавсралт 2

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ
УИХ-ЫН ТОГТООЛ**

№	Тогтоолын дугаар	Баримт бичгийн нэр	Огноо
1	51	Засгийн газрын өрийн удирдлагын 2016-2018 оны стратегийн баримт бичиг батлах тухай	2015.05.22
2	87	Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлалын тухай	1995 .12 .4
3	57	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай	2001. 6.14
4	24	Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги батлах тухай	2003.06.12
5	64	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай	2009-10-15
6	62	Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай	2015-06-19
7	65	Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого батлах тухай	2011-12-23
8	34	Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай	2010-06-24 2012-08-17
9	29	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай	2003-06-18
10	18	Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай	2014-01-16
11	54	Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай	2003.12.11
12	29	Үндэсний хөтөлбөр батлах тухай /Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр/	1998.04.09
13	23	Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай	2013.02.08
14	41	Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай	2015-02-18

Хавсралт 3

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Хөрөнгө оруулалтыг зохицуулж буй Засгийн газрын нийт 29 тогтоолын 14 тогтоол нь уг асуудлыг голлон зохицуулж байна.

№	Он дугаар	Тогтоолын нэр
1	2012 оны № 171	Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр
2	2005 оны № 201	Бүсийн тулгуур төв хотуудыг 2020 он хүртэл хөгжүүлэх хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлах тухай
3	2004 оны № 29	Дэд бүтцийн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих тухай /захирамж/
4	2015 оны № 66	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зарим арга хэмжээний тухай
5	2010 оны № 299	Журам батлах тухай (Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор олгох)
6	2008 оны № 61	Журам батлах тухай (Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийг байршуулах..)
7	2011 оны №221	Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ноос боловсруулах үндэсний үйлдвэрлэгчийг засгийн газрын бондын эх үүсвэрээр дэмжих хөрөнгийг зарцуулах, хяналт тавих, тайлагнах тухай журам
8	2012 оны №118	Давамгайл байдлалтай хуулийн этгээд бусад хуулийн этгээдтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, өрсөлдөгчийн хувьцааг худалдан авахад дүгнэлт гаргах журам
9	2009 оны № 287	Уул уурхай, дэд бүтцийн салбарт алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох журам
10	2006 оны № 185	Журам батлах тухай /Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам/
11	2006 оны №258	Журам батлах тухай /Эрсдэлийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам", "Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам"/
12	2005 оны № 39	Журам батлах тухай /Бүсийн хөгжлийг дэмжих сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, хяналт тавих/
13	2015 оны № 146	Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавих шаардлага, авлага барагдуулах журам
14	2014 оны № 371	Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжих журам
15	2013 оны № 75	Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх журам
16	2014 оны № 222	Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам
17	2015 оны № 295	Уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журам
18	2014 оны № 52	Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам
19	2015 оны № 296	Орон сууцны ипотекийн зээлийн баталгааны журам
20	2007 оны № 306	Монгол Улсад үндэсний инновацийнт огтолцоог хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай
21	2010 оны №0123	Нийтлэг журам батлах тухай (Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах)

22	2001 оны № 125	Үзэл баримтлал батлах тухай санхүүгийн салбарын шинэчлэлийн дунд хугацааны үзэл баримтлал
23	2009 оны №222	Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр
24	2008 оны №183	“Транзит Монгол” Үндэсний Хөтөлбөр
25	2012 оны №223	Монгол Улсын 2013-2017 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
26	2014 оны №278	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр (2014-2016)
27.	2007 оны 131	“Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх” хөтөлбөр
28.	2009 оны №299	Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр (2009-2016)
29.	2008 оны №184	Монгол Улсыг хөгжүүлэх сангаас эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг төлөвлөхөд 2009-2015 онд баримтлах чиглэл

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ БАРЬЦААЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ЖУРМААР ОЛГОХ
/ЛОМБАРД/ ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ХЯЗГААРЫГ ТОГТООХТОЙ ХОЛБООТОЙ
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Г.Алтан-Оч (PhD), Ц.Болормаа, Ө.Мөнхтунгалаа
О.Нарантуяа, Б.Нандингэрэл, И.Жаргалзаяабямба
Д.Жигваагүнсэл, Ч.Онончимэг, Г.Чулуун, А.Пагма*

№	Улсын нэр	Эрх зүйн зохицуулалт
1	АНУ	<p><i>Алабама муж /Alabama/</i> Section 5-19A-7 Ломбардны хүү Барьцааны зээлийн хүү сард зээлдүүлсэн үнийн дүнгийн 25 хувиас хэтрэхгүй.</p> <p><i>Аляска муж /Alaska/</i> Sec.08.76.210. Санхүүгийн хураамж Барьцаалан зээлдүүлэх зээлийн хүү сард зээлдүүлсэн үнийн дүнгийн 20 хувиас хэтрэхгүй.</p> <p><i>Аризона муж /Arizona/</i> Sec.44-1626. Барьцаалан зээлдүүлэх зээлийн хүү эхний 2 сард 8 хувиас хэтрэхгүй бөгөөд да раагийн сараас зээлийн хүүг 6 хувь хүртэл бууруулна.</p> <p><i>Колорадо муж /Colorado/</i> Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний дүрэм, журмыг мужийн засаг захиргаанаас хариуцан тусгай зөвшөөрөл олгодог.</p> <p>Sec.6-7-420. Барьцаалан зээлдүүлэх зээлийн хүү Зээлийн үнийн дүнгийн 1/5 хувиас хэтрэхгүй.</p> <p><i>Флорида муж /Florida/</i> SECTION 539.001 Барьцаалан зээлдүүлэх хүү сард зээлүүлсэн үнийн дүнгийн 25 хувиас хэтрэхгүй.</p> <p><i>Жоржиа муж /Georgia/</i> SECTION 44-12-131 Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний зээлийн хүү эхний 90 хоногт зээлдүүлсэн үнийн дүнгийн 25 хувиас хэтрэхгүй.</p> <p>Эх сурвалж: Online Pawn Shops Consumer Reports http://www.pawnshopsonline.info/state-regulation-interest-rates-comparisons/</p>
2	Австри	<p>Европын Төв Банкны Европын бүс болон Австри улсын Үндэсний Бичил Санхүүгийн Байгууллага (MFI)-ын Хүүгийн Хувь хэмжээ (MIR)¹ [жилийн], 2015 оны 11-р сарын байдлаар:</p> <p>Шинэ бизнесийн зээл:</p> <ol style="list-style-type: none"> Хувь хүнд өгөх <ol style="list-style-type: none"> Эргэлтийн зээл, хэтрүүлэг 4.30 1 жил хүртэлх хэрэглээний зээл 4.78 1-5 жил хүртэлх хэрэглээний зээл 4.07 Орон сууцны зээл 1.94 Санхүүгийн бус байгууллага <ol style="list-style-type: none"> Эргэлтийн зээл, хэтрүүлэг 2.20 0.25 сая € хүртэл, 3 сар хүртэл 2.20 0.25 сая € хүртэл, 3 сар-1 жил 1.66 0.25 сая-1 сая €, 3 сар хүртэл 1.87 0.25 сая-1 сая €, 3 сар-1 жил 1.40 1 сая €-оос их, 3 сар хүртэл 1.43 1 сая €-оос их, 3 сар-1 жил 1.75

¹ Европын Төв Банкны Европын бүс болон Австри улсын Үндэсний Бичил Санхүүгийн Байгууллага (MFI)-ын Хүүгийн Хувь хэмжээ-Euro area and national MFI interest rates (MIR): Austria https://www.ecb.europa.eu/stats/money/interest/interest/html/interest_rates_AT_2015.en.html

3	Герман	<p>Германы Холбооны Банк²ны Ломбардын хүүгийн хувь хэмжээний статистик 1999/1/1-ний өдрөөс эхлэн зогссон бөгөөд хамгийн сүүлд жилийн 4.5% (1996/4/19-1998/12/31 хүртэл хүчинтэй мөрдөгдсөн)³ байсан байна.</p> <ul style="list-style-type: none"> - Германы дээд шүүх хуулийн тайлбар гаргаж, аливаа зээлдүүлэгч нь дундаж зах зээлийн хүүгийн хувиас 2 дахин ихгүйгээр хүү бодохоор хязгаарласан. - Дундаж хүүгийн хувиас 12%-аас илүүгүй байхаар хүүгийн таазыг тогтоосон. Жишээ нь: дундаж хүү 12.1% байгаа бол 2 дахинаас илүүгүй байх таазын хэмжээ (24.2%) биш, харин удаах зохицуулалтын дагуу 24.1%-иар таазыг тогтооно⁴. <p>Ломбардын үйлчилгээ</p> <p>Германы Ломбардын Холбоо (ZDP, 2009)-ны гишүүн 200 орчим байгууллага Германд ломбардын үйлчилгээ үзүүлж байна. 2003 оны байдлаар, 450 сая € ломбардын зээл олгосон нь Германы жилийн нийт хэрэглээний зээлийн 0.2% болж байна. Үйлчилгээ авсан хүмүүсийн тоо 2000 онд 160,000 байсан нь нийт зээл авсан өрхийн 2%-тай тэнцэж байна.</p> <p>Зээлийн хэмжээ нь 50€ - 10,000€ хүртэл хэлбэлзэнэ.</p> <p>2002 оны байдлаар, ломбардын дундаж зээлийн хэмжээ 230€ ба сарын хүү 1% байсан. Түүнээс гадна тогтсон журмын дагуу хэрэглэгч нь хадгалалтын болон даатгал, захиргааны хураамж төлнө. Эдгээрийг нэмээд ломбардын жилийн хүү 36% байв.</p> <p>Эх сурвалж: http://www.microfinancegateway.org/topics/interest-rates-and-pricing</p>
4	Ирланд	<p>Ломбардны тухай хууль (Pawnbrokers act, 1964)</p> <p>20. (1) Барьцаалан зээлдүүлэгч нь төлбөл зохих зээлийн хүүг энэ хуулийн 5 дугаар хавсралтын 1 дэх хэсэгт зааснаас хэтрүүлэлгүйгээр тогтооно. 5 дугаар хавсралт: I Хэсэг</p> <p>Зээлийн хүүгийн дээд хэмжээ (Maximum rate of interest on loans)</p> <p>1. Хүүгийн хамгийн дээд хэмжээ нь сар болгон зээлийн 2 шиллинг бүрт хагас пенс байна.</p> <p>2. 1 дүгээр зүйлийн утга нь:</p> <p>(а) Зээлийн хугацаа нэг сараас бага гэдгийг нэг сар гэж тооцно.</p> <p>(с) Зээлийн 2-оос доош шиллинг гэдгийг 2 шиллингээр тооцно.</p> <p>Эх сурвалж: http://www.irishstatutebook.ie/eli/1964/act/31/enacted/en/print#sched5</p>
5	Канад	<p>Барьцаалдан зээлдүүлэх тухай хууль "Pawnbrokers Act, 1996", 19-р зүйл: Зээлийн хэмжээ 25% байна.</p> <p>Хүүгийн тухай хууль "Interest Act, 1985"</p> <p>3-р зүйлд заасны дагуу</p> <p>Хүүгийн гэрээ хуулийн дагуу төлөх бол гэрээгээр тогтоосон хүүгийн түвшин жилд 5 %-аар тооцно.</p> <p>Эх сурвалж: http://laws-lois.justice.gc.ca/eng/acts/l-15/</p>
6	Кыргызстан	<p>Хэт хүүлэхийг хязгаарлах тухай хууль</p> <p>Зээлийн хүүний дундаж номиналь хэмжээг Үндэсний Банк тогтооно. Зээлийн хүүний байж болох дээд хязгаар нь энэхүү дундаж номиналь хэмжээг тодорхой пунктээр өсгөсөн үзүүлэлт (15%) –ээр тодорхойлно.</p>
7	Казахстан	<p>Улс Санхүүгийн бичил байгууллагын тухай хууль (Закон РК "О микрокредитных организациях")</p> <p>Казахстаны Үндэсний Банкны 2012 оны тогтоол (2012.12.24 –ны өдрийн №377)</p> <p>ББСБайгууллагаас олгох зээлийн, эффект бүхий жилийн хүүгийн дээд хэмжээ нь 56% -ээс ихгүй байна.</p>
8	Молдав	<p>Засгийн газрын 1995 оны 204 тоот тогтоол "Ломбард ажиллуулах нийтлэг журам"</p> <p>20 дугаар зүйл: Ломбардууд үзүүлж байгаа үйлчилгээнийхээ үнэ тарифыг өөрөө тогтооно.</p>

² Deutsche Bundesbank-германаар

³ Deutsche Bundesbank Interest rate statistics 2015 file://S11BTDDISCOUNT.pdf

⁴ ЕХ-ны Хүүгийн хувь хэмжээний хязгаарын талаарх судалгаа-Study on interest rate restrictions in the EU Final Report, Project No. ETD/2009/IM/H3/87 file://irr_report_en.pdf

9	ОХУ	<p>“Хэрэглээний зээлийн тухай” (Федеральный закон от 21.12.2013 “О потребительском кредите (займе)”</p> <p>8, 11 дүгээр зүйл:</p> <p>Оросын Банк улирал тутамд хэрэглээний зээлийн нийт зардлын зах зээлийн дундаж үнэлгээг хэрэглээний зээлийн ангилал тус бүрээр тооцоолон гаргаж журамлана.</p> <p>Хэрэглээний зээлийн гэрээ байгуулахдаа Оросын Банкнаас тогтоосон тухайн үеийн хэрэглээний зардлын хэмжээг гуравны нэгээс илүүгээр хэтрүүлж үл болно гэжээ.</p> <p>Эх сурвалж: www.finanal.ru, www.kodeks.systecs.ru</p>
10	Сингапур	<p>Ломбардны тухай хууль, 2015 (Pawnbrokers act, 2015)</p> <p>50 дугаар зүйл. Зөвшөөрөгдсөн ашиг, төлбөр, хураамж</p> <p>(2) Барьцаалан зээлдүүлэх гэрээнд үндэслэн барьцаалан зээлдүүлэгч нь зээлээс ашиг олох эрхтэй бөгөөд энэ хуулийн Хоёрдугаар Хавсралтад зөвшөөрөгдсөний дагуу зээлийн хүү болон бусад төлбөрийг тогтооно.</p> <p>Хоёрдугаар Хавсралт:</p> <p>1. Барьцаалан зээлдүүлэгчийн зээлээс авах хүү нь:</p> <p>(a) Бүхэл сар тус бүрт (нэг сар) үндсэн зээлийн 1,5%-аас хэтрэхгүй байна.</p> <p>(b) Хэрэв зээлийн хугацаа нь бүхэл саруудад хуваагдах боломжгүй бол (нэг сараас бага бол) нийт зээлийн үнийн дүнгийн 1.5 хувийн тухайн үлдэгдэл хоногт ногдож байгаа хэмжээгээр хүүг тогтооно.</p> <p>Эх сурвалж: http://statutes.agc.gov.sg/aol/download/0/0/pdf/binaryFile/pdfFile.pdf?CompId:11976303-0755-4eac-9369-2268bbe94e22</p>
11	Солонгос	<p>Ломбардны үйл ажиллагааны журам</p> <p>10 дугаар зүйл. Хүүгийн хязгаарлалт</p> <p>Зээлийн хүү нь зээлийн хэмжээнээс хамаарч дээд тал нь 6 хувь, доод тал нь 3 хувийн хүүтэй байна.</p> <p>Эх сурвалж: http://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=26810#AJAX</p>
12	Хонг Конг	<p>“Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ үзүүлэгчид зориулсан журам”</p> <p>Pawnbrokers ordinance 30/06/1997</p> <p>1-р Хавсралт</p> <p>Зээлийн дээд хэмжээ 10000\$, зээлийн сарын хүү 3,5% -аас ихгүй байна.</p> <p>Эх сурвалж: http://www.legislation.gov.hk/blis_pdf.nsf/6799165D2FEE3FA94825755E0033E532/B70084E79CE4FE4D482575EE0048B417/\$FILE/CAP_166_e_b5.pdf</p> <p>http://www.hkexnews.hk/listedco/listconews/SEHK/2013/0227/01319_1550405/E115.pdf</p>
13	Хорват	<p>Decision on the interest rates, the discount rate and remunerations of the Croatian National Bank (Official Gazette 115/2015)</p> <p>1. Барьцаалан зээлдүүлэх зээлийн хүүг Хорватын Төв Банкнаас жилийн 2.5 %-аас хэтрүүлэхгүй тооцож байхаар тогтоожээ.</p> <p>Хорватын Төв Банкнаас Хөрвөх чадвартай богино хугацааны зээлийн хүүг дараах байдлаар тогтоосон байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> - Барьцаалан зээлдүүлэх зээлийн хүүгийн хэмжээг тооцоходоо 3 сар хүртэл хугацаанд 1 %-аар өсгөх ба, - 3 сараас хэтэрсэн тохиолдолд 1.5 %-аар өсгөн тооцно. <p>Эх сурвалж: www.hnb.hr/.../e-odluka-stope-kamatne-eskontna-n</p>
14	Хятад	<p>Хятадын Ардын Банкны тухай хууль</p> <p>22 дугаар зүйл: Тус Банк нь Үндсэн хүүгийн хэмжээг тогтоох тухай заасан.</p> <p>2005 оны “Барьцаалан зээлдүүлэх газруудыг удирдах аргачлал” гэсэн хуулийн 38 дугаар зүйлд “Ломбардуудын зээлийн хүүг Ардын Банк тогтооно” гэж заажээ.</p> <p>Эх сурвалж: www.chinalawinfo.ru</p>

15	Польш улс	<p>Иргэний хууль / Civil Code/ Хэрэглээний зээлийн тухай /Consumer Credit Act/</p> <p>Одоогийн ломбардын хувь хэмжээ 20 % ба хамгийн дээд тал нь 5 % байна. Үүнтэй уялдуулан зээлийн төлбөр гэрээтэй холбоотой нэмэлт төлбөрийг зохицуулж байгаа бөгөөд 5 хувиас хэтрэхгүй байна.</p> <p>Эх сурвалж: www.irr_report_en</p>
16	Энэтхэг	<p>Pawnbrokers act, 23 of 1943</p> <p>Хавсралтын</p> <p>а) Энгийн хүү нь жилд ес ба наймны гурван хувьтай, тодорхой хэлбэл, энэ нь сарын энгийн хүү нь нэг рупи-д нэг ба тавин пэйса /бутархай мөнгө/ эсхүл хорин тав буюу түүнээс бага хэмжээний рупи-ний жилийн энгийн хүү нь нэг ба хагас анна байна;</p> <p>б) бусад тохиолдолд нэг жилийн энгийн хүү нь зургаа ба дөрөв хуваасны нэг буюу сарын энгийн хүү нь нэг рупи-д нэг пэйса эсхүл жилийн энгийн хүү нь нэг рупи-д нэг анна байна.</p> <p>Эх сурвалж: www.vimalamahmoodfoundation.com</p>
17	Япон	<p>Money Lending Business Act (Act No. 32 of May 13, 1983) Interest Rate Restriction Act (Act No. 100 of May 15, 1954)</p> <p><u>1-р зүйл: Зээлдэгч нь хэрэглээний зардлын зээлтэй холбоотойгоор зээлдүүлэгчтэй гэрээ байгуулах бөгөөд хэрэв гэрээнд дор дурьдсан хүүний хязгаарлалтаас давсан хүүгээр гэрээ байгуулсан нөхцөлд зээлдэгчийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэн, гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцно.</u></p> <p>Үндсэн зээл нь 100,000 иень-ээс бага бол жилийн 20 % Үндсэн зээл нь 100,000 – 1,000,000 иень бол жилд 18% Үндсэн зээл нь 1,000,000 иень-ээс дээш бол жилийн 15%-ийн хүүтэй байна.</p> <p>Эх сурвалж: http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_download/?ff=09&id=2134 http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_download/?ff=09&id=1956</p>

МОНГОЛ УЛС ДАХЬ ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ: ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Ц.Болормаа, Ч.Онончимэг
Д.Халиун

АГУУЛГА

1. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН
 - a. *Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлого, үндсэн чиглэлийг зохицуулсан байдал*
 - b. *Татварын орчин*
 - c. *Жижиг дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага*
2. САНХҮҮЖИЛТ
 - a. *Сум хөгжүүлэх сан*
 - b. *Зээлийн батлан даалтын сан*
 - c. *Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан*
3. ЭМЭГТЭЙ ЭЗЭНТЭЙ ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР /ЖДҮ/ ЭРХЛЭГЧ ИРГЭН, ААН-ИЙН ДУНД ЯВУУЛСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮН
4. ДҮГНЭЛТ
5. АШИГЛАСАН МАТЕРИАЛ
6. ХАВСРАЛТ 1. *Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч эмэгтэйчүүдийн дунд явуулсан санал асуулга*
ХАВСРАЛТ 2. *Монгол Улсын Засгийн газар болон олон улсын байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн жагсаалт*

1. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2007 онд Улсын Их Хурлаас Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль баталсан бөгөөд тус хуулиар:

- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч, түүний бүртгэл;
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хамаарахгүй этгээд;
- Жижиг, дунд үйлдвэрийн талаарх төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх;
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн эрх үүрэг;
- Төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлого, үндсэн чиглэл;
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих арга хэмжээний удирдлага, зохион байгуулалтын тухай харилцааг зохицуулсан байна.

Түүнчлэн, салбарын дараах 14 хууль тогтоомжоор жижиг, дунд үйлдвэртэй холбоотой харилцааг зохицуулж байна. Үүнд:

1. Зээлийн батлан даалтын тухай хууль;
2. Инновацийн тухай хууль;
3. Засгийн газрын тусгай сангийн тухай;
4. Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль;
5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль;
6. Санхүүгийн түрээсийн тухай хууль;
7. Компанийн тухай хууль;

8. Нөхөрлөлийн тухай хууль;
9. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
10. Татварын ерөнхий хууль;
11. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
12. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
13. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;
14. Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль зэрэг нийт 15 хууль тогтоомж үйлчилж байна.

Харин Жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ)-ийн салбарын харилцааг зохицуулж буй УИХ-ын 16 тогтоол, Засгийн газрын 24 тогтоол байгаагаас 2014 онд Засгийн газраас баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг (2014-2016) дэмжих хөтөлбөр”-ийг тусгайлан авч үзэх болно.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн тухайд хэдийгээр салбарын харилцааг зохицуулах бие даасан хууль батлагдсан нь сайшаалтай боловч төрөөс ЖДҮ-ийн салбарт баримтлах бодлогыг зохицуулсан гол зохицуулалт нь хэт ерөнхий, тодорхойгүй, тунхагын шинж чанартай зохицуулалт байгаа нь жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг сааруулж, зарим тохиолдолд зогсонги байдалд оруулж байна.

Иймээс хуульд төрөөс ЖДҮ-ийг дэмжих бодлого, үндсэн чиглэлийг хэрхэн хуульчилсан, мөн хууль тогтоомж дахь ЖДҮ-ийн татварын орчин, ЖДҮ-ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын талаар тусгайлан авч үзье.

а) Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлого, үндсэн чиглэлийг зохицуулсан байдал:

Хуулийн 5 дугаар бүлэгт төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлого, үндсэн чиглэлийг хуульчилсан бөгөөд дараах бодлого баримтлахаар заасан байдаг. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн бизнесийн шинэчлэл, шинээр бизнес эрхлэх болон бүтээлч үйл ажиллагааг дэмжих;
- Жижиг, дунд үйлдвэрийн менежментийн нөөц, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар жижиг, дунд үйлдвэрийн менежментийн үндэс суурийг бэхжүүлэх;
- Жижиг, дунд үйлдвэрийн менежментийн тогтвортой байдлыг хангах, бизнесийг хувирган өөрчлөх боломжийг бүрдүүлэх замаар жижиг, дунд үйлдвэрийн эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөд зохицох чадварыг нэмэгдүүлэх;
- Жижиг, дунд үйлдвэрийг санхүүгийн талаар дэмжих, тэдгээрийн өөрийн хөрөнгийн хангалттай байдлыг сайжруулах бодлого баримтална.

гэснээс үзэхэд “таатай нөхцөлийг бүрдүүлэх”, “үйл ажиллагааг дэмжих” гэдэг нь хэт ерөнхий, тодорхойгүй, тунхагийн шинж чанартай байгаа юм.

Түүнчлэн, бизнесийн шинэчлэл, шинээр бизнес эрхлэх болон бүтээлч үйл ажиллагааг дэмжихэд төрөөс дараах дэмжлэг үзүүлэхээр заасан:

- шинэ бүтээгдэхүүн бий болгох, шинэ үйлчилгээ нээхэд шаардагдах технологийн хөгжлийн талаарх судалгааг дэмжих;
- бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон борлуулалтын бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлэх, санхүүгийн түрээс зэрэг хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах;
- шинэ бүтээгдэхүүн бий болгох, түүнийг үйлдвэрлэх, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагааг нэгтгэн удирдах удирдлага, менежментийн шинэ аргыг нэвтрүүлэхийг дэмжинэ.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг шинээр бизнес эрхлэхэд дараах дэмжлэг үзүүлнэ:

- шинээр бизнес эрхлэхэд шаардагдах мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах;
- жижиг, дунд үйлдвэр эрхлэх хэрэгцээ, шаардлага, ач холбогдлын талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх;
- шинээр бизнес эрхлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрээр хангана.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн бүтээлч үйл ажиллагааг дараах арга хэмжээгээр дэмжинэ:

- бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, үйлчилгээ үзүүлэх шинэ технологийн хөгжлийн талаарх судалгааг дэмжих;
- шаардлагатай хөрөнгийг хувьцаа, бонд гаргах замаар бүрдүүлэх тогтолцоог бий болгох;
- бүтээлч үйл ажиллагаанд шаардагдах боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх байдлаар дэмжинэ.

Жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилтийг дэмжих, өөрийн хөрөнгийн хангалттай байдлыг сайжруулах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- жижиг, дунд үйлдвэрийн санхүүгийн эх үүсвэрийн тогтвортой байдлыг хангах үүднээс санхүүгийн байгууллагын чиг үүргийг тодорхой болгох, даатгалын тогтолцоог хөгжүүлэх;
- банк болон банк бус санхүүгийн байгууллагатай тохирсны үндсэн дээр жижиг, дунд үйлдвэрт зориулсан санхүүжилтийг бий болгох;
- урт хугацааны, хөнгөлөлттэй зээл олгох;
- зээлийн баталгаа, батлан даалт гаргах;
- зарим төрлийн даатгалд хамруулах;
- гадаадын болон олон улсын байгууллагын санхүүжилт бүхий төсөл, тусламжийн арга хэмжээнд хамруулна.

Жижиг, дунд үйлдвэрийн өөрийн хөрөнгийн хангалттай байдлыг сайжруулах зорилгоор хөрөнгө оруулалтын тогтолцоог боловсронгуй болгох, татварын ачааллыг зохицуулах арга хэмжээ авна.

б) Татварын орчин

ЖДҮ-ийн татварын орчны хувьд төрөөс тусгайлсан дэмжлэг, хөнгөлөлт, чөлөөлөлт байхгүй бөгөөд бусад хуулийн этгээдийн адилаар татварын багц хуульд заасан хувь хэмжээгээр татвар болон нийгмийн даатгалыг төлж байна. Харин 2009 оноос эхэлсэн жижиг, дунд үйлдвэрийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор импортоор оруулж байгаа жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татвараас чөлөөлөх хуулийн зохицуулалт үйлчилж байсан. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг 2015 онд шинэчлэн баталсан бөгөөд “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, үйлдвэрлэн борлуулсан жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө” гэж заажээ. Түүнчлэн, 2016 онд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиудын шинэчилсэн найруулга УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд явж байна.

- *Жижиг дунд бизнес эрхлэгчдийг татварын бодлогоор дэмжих:*

Монгол Улсын татварын шинэчлэлийн нэг гол зорилго нь аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд татварын таатай орчинг бий болгосноор иргэдэд ажлын байрыг бий болгох, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх явдал юм.

Өнөөгийн үйлчилж буй татварын багц хуулиудын хувьд ихэнх нь зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн эхэн, туршлага багатай үед боловсруулснаас сүүлийн үед маргаантай асуудлууд ихээхэн гарах болсон, мөн нэмэлт, өөрчлөлт их ордог асуудлуудын хувьд энгийн хүнд ойлгоход хүндрэлтэй болсон нь харагддаг.

1990 оноос хойш батлагдсан татварын хууль болон түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг судлан үзэхэд татварын төрлийн хувьд давхардсан тоогоор нийт 101 төрлийн хууль батлагдсанаас 46 төрлийн хууль нь хүчингүй буюу үйлчлэл нь дуусгавар болж, 55 төрлийн хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Татварын хуульд нийтдээ 232 удаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа 668 төрлийн нэмэлт, өөрчлөлт оруулсны 53% нь Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг өөрчилсөн өөрчлөлт, 22% нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой өөрчлөлт эзэлж байгаа нь татварын тэгш, шударга, тогтвортой байх зарчмыг үндсэнд нь алдагдуулсан гэж үзэж болохоор дүр зураг гарч байна.

Түүнчлэн ЖДҮ-ийн үйл ажиллагаанд татварын албаны хэмжээнд татвар төлөгчидтэй харилцах харилцааг зохицуулах зорилго бүхий 109 журам, заавар, аргачлал мөрдөгдөж байна.

Мөн татварын хууль тогтоомжийн хувьд татварын харилцааг зохицуулж, агуулгын хувьд давхардал үүсгэж байгаа нь иргэд, аж ахуй нэгжийн төрийн үйл ажиллагаанд итгэх итгэлийг бууруулан, хүнд суртлыг бий болгож, татвар төлөгчийн үйл ажиллагаанд ихээхэн хүндрэл учруулж байгаа юм.

Нийгэм, эдийн засгийн харилцаа өөрчлөгдөхийн хэрээр татварын хууль тогтоомжийн зарим зүйл, заалт шинээр гарч ирж буй нөхцөл, шаардлага, харилцааг зохицуулахад учир дутагдалтай болж ойлголтын зөрүү үүсч, уялдаа холбоогүй болох, улмаар татвар төлөгч, татварын албаны хооронд маргаан гарах асуудал ихсэх хандлагатай байна.

Татварын маргаан таслах зөвлөлд сүүлийн 5 жилийн байдлаар шийдвэрлэгдсэн судалгаанаас үзэхэд 274 татвар төлөгчид хамаарах 726,135.2 сая төгрөгийн маргааныг шийдвэрлэснээс татвар төлөгчийн талд 66.8%-ийг нь шийдвэрлэсэн дүн мэдээ гарсан бол Дэлхийн банкнаас хийгдсэн бизнес эрхлэлтийн судалгаагаар татварын дарамтын хувьд манай улс сүүлийн жилүүдэд байнга ухарсан үзүүлэлт гарсан байна.

Тиймээс татварын багц хуулиудыг шат дараатай шинэчлэх, татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, татварын таатай орчинг бий болгох хүрээнд УИХ-аас 2015.07.09-нд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулиудын шинэчилсэн найруулгын төслүүд өргөн баригдаад байна.

в) Жижиг дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

Хуулийн 3 дугаар бүлэгт жижиг дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага, түүний эрхийн тухай хуульчилсан байдаг. Одоогоор жижиг дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Аж үйлдвэрийн яамны “Жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар” юм. Тус газар нь жижиг, дунд үйлдвэрийн бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээнэ. Энэ үндсэн үүргийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг хангахад чиглэсэн эрх зүй, бодлого, хөтөлбөрийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах, жижиг, дунд үйлдвэрийг аж үйлдвэрийн нэгдсэн бодлоготой уялдуулах, кластераар хөгжүүлэх, шинжлэх ухаан-төр-бизнес хамтын ажиллагааг өргөжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, жижиг, дунд үйлдвэрийг чадавхжуулах, бизнес инкубаторын тогтолцоог хөгжүүлэх, борлуулалтын сүлжээг дэмжих

сургалт, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, жижиг дунд үйлдвэрийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, татвар, зээл, зээлийн батлан даалт, санхүүгийн түрээсийн үйлчилгээг хөгжүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, сайдын эрхлэх ажлын хүрээний жижиг дунд үйлдвэрийн Засгийн газрын тусгай сан болон сум хөгжүүлэх санг удирдлага, зохицуулалтаар хангах, ахуйн үйлчилгээний салбарын эрх зүй, бодлого хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах, жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн талаар бодлогын судалгаа хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох мэдээллээр хангах чиг үүрэг хэрэгжүүлж байна.

“Жижиг, дунд үйлдвэрийг (2014-2016) дэмжих хөтөлбөр”⁵

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 278 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг (2014-2016) дэмжих хөтөлбөр” батлагдсан. Тогтоолд Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “*Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр*”, Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор баталсан “*Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө*”-нд жижиг, дунд үйлдвэрийн асуудалтай холбоотой зорилтуудыг тусгасан юм.

Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн талаарх асуудал нь аль ч улс орны хувьд хөгжлийн ямар ч шатанд авч үзэх, шийдвэрлэх шаардлагатай гол асуудлын нэг байдаг. Иймээс ч жижиг, дунд үйлдвэрийг 2014-2016 онд дэмжих хөтөлбөрийг боловсруулахдаа 2012 оны “Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн улсын зөвлөгөөн”-ий зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Засгийн газрын 51 дүгээр тогтоол, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2013 оны 154 дүгээр тогтоолоор баталсан “Ажилтай, орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөрт жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих, хөгжүүлэх талаар тусгасан зорилтуудтай уялдуулан боловсруулж жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлж буй олон улсын туршлага, өөрийн орны онцлог, давуу тал, сул тал, эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын орчин, түүхий эд, хүний нөөцийн боломж зэргийг харгалзан боловсруулсан байна.

Засгийн газраас 1999, 2005 онд баталж, хэрэгжүүлсэн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрүүдийн үр дүнд 2007 онд Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль батлагдан эрх зүйн таатай орчин бүрдэж, санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэр нэмэгдэн, өрхийн болон хувиараа бизнес эрхлэгчдийн дунд албан ёсны жижиг, дунд үйлдвэр эрхлэх сонирхол, санаачилга идэвхижсэн.

Жижиг, дунд үйлдвэрийн менежер, ажилтнуудын ур чадвар, чадамжийг хөгжүүлэх нь тухайн аж ахуйн нэгжийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай байхад чухал нөлөө үзүүлдэг. Санхүүгийн хүртээмжийг сайжруулах нь ЖДҮ-ийн салбарт учирч байгаа томоохон асуудал бөгөөд санхүүгийн түрээс, факторинг, хувьцаагаар хөрөнгө оруулах зэрэг санхүүжилтийн бусад арга хэрэгслүүдийг үе шаттайгаар нэвтрүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Иймээс дээрх асуудлуудыг цогцоор шийдэх, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан жижиг, дунд үйлдвэрийн чиглэлийн 15 зорилт, 43 үйл ажиллагааг хэрэгжүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдсан нэгдсэн зорилго, зорилт бүхий үндэсний хөтөлбөрийг боловсруулсан байна.

Тус хөтөлбөр нь ЖДҮ-ийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд дараах зургаан зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- хууль, эрх зүйн орчныг сайжруулах;
- кластераар хөгжүүлэх;
- судалгаа боловсруулалт болон инновацийг хөгжүүлэх;
- жижиг, дунд үйлдвэрийг чадавхжуулах;
- санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хүртээмжийг хангах;

⁵ Монголын жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр Монгол Улсын Засгийн газар болон олон улсын байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг Хавсралт 2-с үзнэ үү.

- зах зээлийг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх зорилтыг дэвшүүлэн тус хөтөлбөрийг улс даяар хэрэгжүүлжээ.


2. САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлэхээр хөтөлбөрт заасан байдаг. Үүнд:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан улс, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;
- Засгийн газрын бонд;
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө;
- Сум хөгжүүлэх сангийн хөрөнгө;
- Орон нутгийг хөгжүүлэх тусгай сангийн хөрөнгө;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө;
- Инновацийг дэмжих сангийн хөрөнгө;
- Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө;
- Олон улсын болон хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр заасан.

Хөгжлийн банкнаас гаргасан мэдээлэлд 2019 он хүртэл Бондын мөнгөнөөс ЖДҮ-ийн салбарт 70 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төсөвлөжээ.

Жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилтийн тухайд нийт банк санхүүгийн байгууллагуудын жижиг, дунд үйлдвэрлэлд олгосон зээлийн хэмжээ 2,048 тэрбум төгрөг хүрч өмнөх онохоос 5.9% хувиар буурсан байна. Иргэдэд олгосон зээлийн 15.7%-ийг ЖДҮ-д олгосон зээл эзэлж байна.



2009-2015 оны 4 улирлын байдлаар ЖДҮ эрхлэгч иргэн, ААН-д олгосон зээлийн хэмжээ болон зээлдэгчдийн тоог доорх хүснэгтээр харууллаа.

(Эх сурвалж: Монголбанк)

	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Зээлдэгчдийн тоо-Иргэд	43094	45532	53331	50378	52947	57220	49945
Зээлдэгчдийн тоо-ААН	2229	2502	3308	3438	3660	4618	5232
ЖДҮ эрхлэгч иргэдэд олгосон зээл /мян.төг/	255636884	347544413	568858792	601363656	833434844	905541780	778684044
ЖДҮ эрхлэгч ААН-д олгосон зээл	227430818	277618137	473698455	590174081	971078774	1270618709	1270097395

Хөнгөлөлттэй зээлийн нөхцөл

	<i>Аймаг, дүүрэг</i>	<i>Нийслэл</i>	<i>Бүс нутгийн хэмжээнд</i>	<i>Лизинг</i>
Зээлийн хэмжээ	1-100 сая хүртэл	101-200 сая хүртэл	201 саяас дээш	100 сая хүртэл
Зээлийн хүү /жил/	7%	7%	7%	10.8%
Зээлийн хугацаа	5 жил	5 жил	5 жил	4 жил
Үндсэн зээлээс чөлөөлөх хугацаа	1 жил	1 жил	1 жил	1 жил
Төсөл хүлээн авагч	Аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтэс	Нийслэлийн хөдөлмөрийн газар	Хөдөлмөрийн яам, ЖДҮ-ийг хөгжүүлэх сан	

Санхүүжилт болон хэрэгжилт

<i>Эх үүсвэр</i>	<i>Зарцуулалт</i>	<i>Үр дүн</i>
<ul style="list-style-type: none"> Улсын төсөв Олон Улсын зээл, тусламж Бусад эх үүсвэр Зээлийн эргэн төлөлт Засгийн газрын бонд 	<ul style="list-style-type: none"> Хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгох Санхүүгийн түрээс /лизинг/ Зээлийн давхар батлан даалт 	<ul style="list-style-type: none"> Орон нутаг, бүс нутагт ЖДҮ-ийг хөгжүүлэх Ажлын байрыг нэмэгдүүлэх Импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

а) Сум хөгжүүлэх сан

Сумдад жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр 2011 онд «Сум хөгжүүлэх сан»-г байгуулсан. Монгол улсын 330 суманд байгуулсан бөгөөд өнөөгийн байдлаар сумдад 150 саяас- 1,0 тэрбум хүртэл төгрөгийн эх үүсвэр бүрдсэн байна.

Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлэхээр тогтоосон байна. Үүнд:

- улсын төсвөөс олгох сумын хөгжлийн сангийн эргэлтийн хөрөнгө;
- гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив;
- иргэн, аж ахуйн нэгжид сангаас олгосон зээлийн хүүгийн орлого.

Санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг тухайн суманд жижиг, дунд үйлдвэрлэл хөгжсөн байдал, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, өмнөх жилийн зээлийн ашиглалт, зээл авах хэрэгцээ, шаардлага зэргийг харгалзан Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нарын хамтарсан тушаалаар тогтоохоор заасан байна.

Улсын хэмжээнд 2013 онд Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс нийт 7627 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 42,936.7 сая төгрөгийн зээлийг жилд 1-3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай олгосноос 7521 зээлдэгчийн авсан 41,215.0 сая төгрөгийн зээл нь үр дүнгээ өгч шинээр 10677 байнгын ажлын байр, 1844 түр ажлын байр нэмэгдэж, 6892 ажлын байр хадгалагдсан байна.

	<i>Зээлийн ангилал</i>	<i>Зээлдэгчийн тоо</i>	<i>Мөнгөн дүн /сая төг/</i>	<i>Эзлэх хувь</i>
1	Хэрэгжиж байгаа төсөл	7521	41219.0	95.9
2	Төрийн албан хаагч авсан	11	37.8	0.09
3	Үйл ажиллагаа нь түр зогссон, эхлээгүй	29	1,393.2	3.4

4	Хүүгүй олгосон зээл	2	30.0	0.07
5	Харьяа газраа үйл ажиллагаа явуулаагүй	3	16.4	0.04
6	Явуулах үйл ажиллагаа тодорхой бус	61	240.3	0.5
	Нийт дүн	7627	42,936.7	100.0

2014 онд Монгол Улсын Үндэсний Аудитын газрын Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтад хийсэн шалгалтаар шалгаруулсан нийт төслөөс 106 төслийн 1,717.7 сая төгрөгийн зээлийг “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хяналт тавих журам”-ыг зөрчиж шалгаруулсан байна.

б) Зээлийн батлан даалтын сан

Монгол Улсын “Зээлийн батлан даалтын сангийн тухай” хууль 2012 онд батлагдсанаар барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд батлан даалт гаргах эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд 2012 оны 11-р сарын 06-ны өдөр Сангийн дүрэм батлагдсанаар “Зээлийн батлан даалтын сан” үүсгэн байгуулагдсан. Сангийн байгуулагч нь Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо юм. Сан нь ашгийн төлөө бус байгууллага бөгөөд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах ба өнөөгийн байдлаар 250,0 сая хүртэл төгрөгийн батлан даалт гаргаж байна.

2015 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 364 аж ахуй нэгж байгууллага, иргэдийн 59.6 тэрбум төгрөгийн зээлэнд 24.4 тэрбум төгрөгийн батлан даалтыг гаргах шийдвэр гаргасан байна. Сангаас гаргасан батлан даалтын дээд хэмжээ 250 сая төгрөг, доод хэмжээ 600 мянган төгрөг байна.



Зээлийн батлан даалтын сан нь 10 банк, 6 банк бус санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаагаас 8 банкаар дамжуулан батлан даалтын үйлчилгээг хүргэсэн. Нийт гаргасан батлан даалтын 25.5 хувийг Голомт банк, 21.2 хувийг Хас банк, 13.2 хувийг Хаан банкны зээлэнд тус тус гаргасан бөгөөд банкнаас олгосон дундаж зээлийн хэмжээ 164 сая төгрөг бол дунджаар зээлийн дүнгийн 48 хувьд нь батлан даалт гаргасан байна.

Батлан даалт олгосон байгууллагууд

№	Банк, санхүүгийн байгууллага	Батлан даалтын тоо	Батлан даалттай зээлийн хэмжээ / төгрөгөөр/	Батлан даалтын хэмжээ / төгрөгөөр/	Хувь
1	Голомт банк	93	18,240,010,000	7,820,385,000	25,5%
2	Капитал банк	47	6,894,900,000	2,789,793,400	12%
3	Төрийн банк	74	10,816,200,000	3,685,865,000	20,3%
4	ХААН банк	48	8,271,289,470	3,590,722,145	13,2%
5	Хас банк	77	8,649,000,000	3,817,361,000	21,2%
6	Чингис хаан банк	0	-	-	0%
7	Худалдаа хөгжлийн банк	22	6,498,600,000	2,631,434,000	6%
8	ҮХО-н банк	1	140,000,000	80,880,800	0,3%
9	Капитрон банк	2	192,500,000	57,092,500	0,5%
	НИЙТ	364	59,702,499,470	24,473,533,845	100%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

е) Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгож, тэднийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих чиглэлээр төрөөс баримталж буй бодлогын хүрээнд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулж 5 хүртэл жилийн хугацаатай, жилийн 9 хувийн хүүтэй, эхний жилд үндсэн зээлийн төлбөрөөс 100 хувь чөлөөлөгдөж 2 дахь жилээс үндсэн зээлээ төлж эхлэх нөхцөлтэйгээр хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкаар дамжуулан олгох мөн санхүүгийн түрээс буюу лизингээр үйлдвэрийн тоног төхөөрөмжийг авч ашиглах боломжийг олгож байна.

3. ЭМЭГТЭЙ ЭЗЭНТЭЙ ЖДҮ ЭРХЛЭГЧ ИРГЭН, ААН-ИЙН ДУНД ЯВУУЛСАН САНАЛ АСУУЛГЫН ҮР ДҮН

Санал асуулга явуулсан хугацаа: 2016.02.29- 2016.03.02

Асуулгыг ЖДҮ эрхлэгч 10 иргэн, ААН-ээс авсан бөгөөд ингэхдээ ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийг сонгов. Судалгааны зорилгын хүрээнд 25 асуулт бүхий анкетын асуулга авч, фокус бүлгийн ярилцлага хийв.


Санал асуулгад оролцсон:

- ЖДҮ эрхлэгч иргэн -3, хоршоо -3, ХХК -4
- Үйл ажиллагаа явуулж буй салбарын хувьд: үйлдвэрлэл үйлчилгээ -7, худалдаа -3
- Үйл ажиллагаа явуулж буй хугацааны хувьд: 1-13 жил
- Ажилчдын тооны хувьд: /1-9 ажилтантай/ - 7, /10-19 ажилтан/ - 3 тус тус байна.


Санал асуулгыг асуулт нэг бүрээр дүнг нэгтгэвэл:

- ААН, иргэнээр бүртгүүлэхэд хэр төвөгтэй байдаг вэ гэсэн асуултанд: Амархан - 5, Хэцүү - 3, маш хэцүү - 2
- Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авахад хэдий хугацааг зарцуулсан бэ гэсэн асуултанд: Амархан - 2, Хэцүү - 2, маш хэцүү - 6

- ЖДҮ эрхлэгч иргэн, ААН бүртгүүлсэн үү гэдэгт:
бүртгүүлсэн - 2, үгүй - 8
- Яагаад бүртгүүлээгүй вэ гэдэгт:
бүртгэлийн сангийн талаар мэдэхгүй - 6, бүртгүүлэхэд чирэгдэл ихтэй - 2
- Та төрөөс ЖДҮ-г дэмжих аливаа төсөл, хөтөлбөрт хамрагдаж байсан уу гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан ААН, иргэд 100 хувь үгүй гэсэн хариултыг өгсөн бөгөөд яагаад хамрагдаагүй талаар асуухад ЖДҮ-г дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдахад хүндрэл чирэгдэл ихтэй-50%, хамрагдах хүсэлт гаргасан боловч хүлээж аваагүй гэдэгт-30%, тавигдах шаардлагыг хангасан боловч хүлээж аваагүй-10%, тавигдсан шаардлагыг хангаагүй -10% гэсэн хариултыг тус тус өгсөн байна.




- Төрөөс ЖДҮ-г дэмжих аливаа хөтөлбөрт хамрагдахад танд ямар бэрхшээл тулгарч байна вэ?
 - Төрийн байгууллагын хүнд суртал-6 буюу нийт судалгааны хамрагдагсдын 30%
 - Авилга, хээл хахууль нэхдэг – 5 буюу 25 %
 - Ашиг сонирхлын зөрчил – 8 буюу 40%
 - Хүйсээр ялгавартай хандах хандлага – 1 буюу 5% байна.



- Та эмэгтэй бизнес эрхлэгчийнхээ хувьд төрөөс ямар нэгэн дэмжлэгт хамрагдаж байсан уу: Үгүй – 10
- Та бизнесээ ямар эх үүсвэрээр санхүүжүүлсэн бэ?
- Өөрийн хөрөнгөөр – 8, банкны зээлээр - 2
- Та ЖДҮ эрхлэгчийн хувьд төрөөс ямар дэмжлэгийг хүсч байна вэ?
 - Хөнгөлөлттэй зээл олгох - 4
 - Татварын урамшуулал – 6
 - Ажлын байрны урамшуулал – 3
- ЖДҮ эрхлэхэд зориулан олгодог зээлийн талаар та мэдэх үү?
 - Мэднэ - 8
 - Мэдэхгүй – 2

- ЖДҮ эрхлэх зориулалтаар олгож буй зээлийн талаарх таны бодол?
 - Хүү өндөр -2
 - Хугацаа богино -0
 - Зээлд хамрагдахад тавигдах шаардлага өндөр -3
 - Зээлд хамрагдахад танил тал шаардлагатай - 8
 - Авилга хээл хахууль – 2
 - Ялгавартай хандлага-0
- ЖДҮ-г дэмжих хөнгөлөлттэй зээлд хамрагдахад тулгарч буй бэрхшээл?
 - Бичиг баримт бүрдүүлэлт - 4
 - Барьцаа хөрөнгө хангалтгүй - 3
 - Зээлийн гэрээ хатуу - 1
 - Зээлийн эх үүсвэр хүрэлцдэггүй -1
 - Мэдэхгүй -1
- Таны бизнесийн үйл ажиллагаанд аль нь хамгийн их хүндрэл учруулж байна вэ?
 - Хууль эрх зүйн орчин - 0
 - Төрийн байгууллага, албан тушаалтны хүнд суртал - 8
 - Татвар – Хяналт шалгалт - 10
 - Санхүүжилт - 4
- ЖДҮ явуулахад ямар бэрхшээл тулгарч байна вэ?
 - Өөрийн хөрөнгөгүй
 - Зээл олдохгүй
 - Эдийн засгийн байдал хүнд /Худалдан авах чадвар
 - Мөнгөний ханшны уналт
 - Засгийн газрын дэмжлэг муу
 - Тоног төхөөрөмж худалдан авах чадвар хомс
 - Өөрийн гэсэн ажлын байргүй
 - Татварын дарамт их
 - Төрийн байгууллагын хяналт шалгалт их
 - Албан тушаалтны хууль бус хандлага
- ЖДҮ-г хөгжүүлэх сангаас танд хүрч ажиллаж чадаж байна уу.
 - Үгүй – 10
- ЖДҮ-г хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг та хэрхэн дүгнэж байна вэ?
 - Хангалтгүй – 10
- Та эмэгтэй бизнес эрхлэгчийг дэмждэг төрийн болон төрийн бус байгууллагын талаар мэдэх үү?
 - Мэдэхгүй – 10
- Төрөөс эмэгтэй бизнес эрхлэгчийг дэмжих чиглэлээр бодлого хэрэгжүүлэх шаардлагатай гэж үздэг үү?
 - Хэрэгтэй – 8
 - Хэлж мэдэхгүй байна – 2



ДҮГНЭЛТ

Судалгаанаас үзвэл манай улсын хувьд ААН-ээр бүртгүүлэх нь чирэгдэл багатай, хэдий ч төрийн байгууллагаас үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авах нь нэлээдгүй төвөгтэй байна.

Санал асуулгын дүнгээс үзэхэд ЖДҮ эрхлэгчдэд дараах бэрхшээл бодитойгоор тулгарч байна.

- **Төрийн байгууллагын хүнд суртал:** Тухайлбал төрийн болон орон нутгийн зүгээс зохион байгуулж буй төсөл, хөтөлбөрт хамрагдахад зардал чирэгдэл ихтэй, холбогдох байгууллага, албан тушаалтан нь зөвлөгөө мэдээлэл өгдөггүй, бичиг баримтыг цаг тухай бүрт нь хүлээн авч шийдвэрлэдэггүй зэрэг хүнд суртал үүсдэг байна.
- **Авилга хээл хахууль:** ЖДҮ дэмжих зээл болон төсөл хөтөлбөрт шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан, туслах ажилтан нь дэмжлэгийн 10-20 хувийг авилгад өгөхийг шууд шаарддаг. Нийтийн хоолны үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэлийн салбарт эрх бүхий албан тушаалтан бараа бүтээгдэхүүнийг үнэ хөлсгүйгээр авах, үйлчлүүлэх гэсэн дарамт байнгын шинжтэй байдаг.
- **Ашиг сонирхлын зөрчил:** Төрөөс ЖДҮ-ийг дэмжих төсөл, хөтөлбөр батлан хэрэгжүүлж байгааг ЖДҮ эрхлэгчид мэддэг хэдий ч хамрагдах сонирхол байдаггүй. Учир нь тавигдах шаардлагыг бүрэн хангасан хэдий ч танил талгүйн улмаас зээл, тусламж, төсөл хөтөлбөрт хамрагдаж чадахгүй байх нь элбэг. Тиймээс илүү цаг, зардал гаргах сонирхол байдаггүй нь ярилцлагын явцад ажиглагдлаа.
- **Татварын дарамт:** НӨАТ-ын буцаан төлөлттэй холбоотойгоор сарын цэвэр ашгаас хэд дахин давсан зардлаар шинэ тоног төхөөрөмж авахыг төрөөс шаарддаг. Түүнчлэн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх хууль эрх зүйн орчин байдаггүй.
- **Санхүүжилт:** Зээлийн хүү өндөр, зээл авахад шаардагдах барьцаа хөрөнгө их, хугацаа богино түүнчлэн зээл авахад танил талгүй бол зээл авах магадлал хомс байдаг. Нийт зээлийн дүнгийн 10-20 хувийг хахуульд өгсөн тохиолдолд ЖДҮ сангаас зээл авах боломжтой болдог нь амьдрал дээр бодитойгоор бий болсон байна. Энэ мэт хүндрэл бэрхшээлээс болж олон ЖДҮ эрхлэгчид үйл ажиллагаагаа зогсооход хүрдэг байна.
- **Бодлого, эрх зүйн орчин:** Хэдийгээр ЖДҮ эрхлэгчдийг дэмжих хууль, эрх зүйн орчин хангалттай болов ч бодит амьдрал дээр хууль эрх зүйн орчны хэрэгжилт туйлын хангалтгүй байна. Учир нь төрийн бодлогыг хэрэгжүүлэх дунд шатны байгууллагын зүгээс ЖДҮ эрхлэгч нарт бодитойгоор хүрч ажилдаггүй. Энэ нь дараах зүйлээр баталгаажиж байна.

Фокус бүлэгт хамрагдсан ЖДҮ эрхлэгч нарын ярилцлага:

- 1/ УИХ-ын Тамгын газрын хуулийн хэрэгжилтийг хянах чиг үүрэг бүхий хяналт шалгалтын хэлтэст ЗГХЭГ-аас ирүүлсэн хуулийн хэрэгжилтийн мэдээнээс үзэхэд ЖДҮ-ийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар 2015 оны байдлаар ямар ч мэдээлэлгүй байна;
- 2/ ЖДҮ-ийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болох Аж үйлдвэрийн яамны холбогдох газраас ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх 2014-2015 оны тайлан өдийг хүртэл эцэслэн гараагүй болно;
- 3/ ЖДҮ эрхлэгчдэд зориулсан байнгын мэдээллийн урсгал байхгүй. Өөрөөр хэлбэл хууль эрх зүйн орчны талаарх иргэдэд зориулсан хялбаршуулсан мэдээлэл, хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлтийн мэдээлэл байхгүй, холбогдох төрийн

байгууллагууд өөрийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан эрх зүйн орчны талаарх мэдээлэл болон ЖДҮ талаарх тоон мэдээлэл байхгүй;

- 4/ Статистик тоон мэдээллийг гаргах эрх бүхий төрийн байгууллагын зүгээс бизнес регистрийн санд аж ахуйн нэгжийн тоон мэдээллийг гаргахдаа ЖДҮ ангилал, хүйсийн ангиллаар гаргадаггүй байна.
- **Төрийн албан хаагчийн ёс зүй:** Төрийн албан хаагчид хууль тогтоомжид заасан Төрийн албан хаагчийн ёс зүйг баримталдаггүй улмаас ЖДҮ эрхлэгчдэд ёс зүйн дарамт ирдэг байна. Тухайлбал, эрх мэдлээр далайлгах, айлган сүрдүүлэх, ашиг хонжоо хайх үүднээс эрхшээлдээ оруулахыг хүсэх үйлдлүүд тогтмол гардаг байна. Энэ нь ихэвчлэн төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг улсын байцаагч, өөрөө удирдах ёсны байгууллагад ажилладаг албан хаагчдаас гардаг ёс зүйн алдаа юм.
 - **Жендерийн мэдрэмжтэй бодлого:** Эмэгтэй бизнес эрхлэгч нарт хандсан төрийн болон болон төрийн бус байгууллага байхгүй, эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд энэ талаарх мэдээ мэдээлэл огт байхгүй байна. Энэ талаарх төрийн бодлого, зохицуулалт дутмаг байна.

Хавсралт 1

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН
ДУНД ЯВУУЛСАН САНАЛ АСУУЛГА**
(Questionnaire)

1-р хэсэг. Ерөнхий мэдээлэл

- Q1. Компанийн нэр:**
- Q2. Үйл ажиллагааны салбар:**
- Q3. Үйл ажиллагаа явуулж буй хугацаа:**
- Q4. Ажиллагсдын тоо:**

2-р хэсэг. ЖДҮ-ийг эхлүүлэх болон бүртгүүлэх

Q5. Та дараах ангиллаас өөрт тохирохыг сонгоно уу?

1. Хувиараа бизнес эрхлэгч иргэн
2. Нөхөрлөл (гэр бүлийн гишүүдийг оролцуулан)
3. ХХК
4. Хоршоо

Q6. ААН бүртгүүлэх, бизнес эхлүүлэхэд хэр төвөгтэй байсан бэ?

1. Маш амархан
2. Амархан
3. Амархан биш
4. Хэцүү
5. Маш хэцүү

Q7. Үйл ажиллагаа явуулах /тусгай/ зөвшөөрөл авахад хэдий хугацааг зарцуулсан бэ?

1. Маш амархан (Миний хийх зүйл бараг байгаагүй) ажлын 1 өдөр буюу 8 цаг зарцуулсан
2. Амархан (бага зэрэг ажиллагаатай боловч, хэцүү биш байсан) ажлын 3 өдөр буюу нийт 24 цаг зарцуулсан
3. Амархан биш байсан (Нэлээн цаг хугацаа зарцуулах шаардлагатай болсон) ажлын 5 өдөр буюу 40 цаг зарцуулсан
4. Хэцүү байсан (Нэлээн их ажил болсон) ажлын 5 өдөр буюу 40 цагаас илүү хугацаа зарцуулсан
5. Маш хэцүү ажлын 5-аас дээш адар болсон

Q8. Та Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжээр бүртгүүлсэн үү?

1. Тийм
2. Үгүй

Q9. Үгүй бол яагаад?

1. Бүртгэлийн сангийн талаар мэдэхгүй
2. Бүртгүүлэхэд чирэгдэл ихтэй
3. Амжаагүй
4. Бүртгэхээс татгалзсан
5. Бусад

УИН.МН
СУДАЛГААНЫ САН

3-р хэсэг – Дэмжлэг, санхүүжилт

Q10. Та төрөөс ЖДҮ-г дэмжих аливаа төсөл, хөтөлбөрт хамрагдаж байсан уу?

1. Тийм
2. Үгүй

Q11. Үгүй бол яагаад?

1. Дэмжлэг, хөтөлбөрийн талаар мэдэхгүй
2. Дэмжлэг, хөтөлбөрт хамрагдах нь хүндрэл, чирэгдэлтэй
3. Хамрагдахаар хүсэлт гаргасан боловч тавигдах шаардлагыг хангаагүй
4. Бусад

Q12. Та төрөөс ЖДҮ-г дэмжих аливаа хөтөлбөрт хамрагдахад ямар бэрхшээл тулгарч байна вэ?

1. Төрийн байгууллагын хүнд суртал
2. Авилга, хээл хахууль
3. Ашиг сонирхлын зөрчил
4. Хүйсээр ялгавартай хандах хандлага
5. Бусад

Q13. Та эмэгтэй бизнес эрхлэгчийнхээ хувьд төрөөс ямар нэгэн дэмжлэгт хамрагдаж байсан уу?

1. Тийм /Тийм бол ямар:...../
2. Үгүй

Q14. Та бизнесээ ямар эх үүсвэрээр санхүүжүүлсэн бэ?

1. Өөрийн хөрөнгөөр
2. Төрөөс хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрөөр
3. Бондын мөнгөөр
4. Орон нутгийн төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр
5. Банкны зээл
6. ББСБ-ийн зээл
7. Олон улсын байгууллагын зээл, тусламж
8. Бусад.....

Q15. Та ЖДҮ эрхлэгчийн хувьд төрөөс ямар дэмжлэгийг хүсч байна вэ?

1. Хөнгөлөлттэй зээл олгох
2. Татварын урамшуулал
3. Ажлын байрны урамшуулал
4. Бусад.....

Q16. ЖДҮ эрхлэхэд зориулан олгодог зээлийн талаар та мэдэх үү?

1. Мэднэ
2. Мэдэхгүй

Q17. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгож буй зээлийн талаарх таны бодол?

1. Хүү өндөр
2. Хугацаа богино
3. Зээлд хамрагдахад тавигдах шаардлага өндөр
4. Зээлд хамрагдахад танил тал шаардлагатай
5. Авилга хээл хахууль
6. Ялгавартай хандлага
7. Бусад.....

Q18. ЖДҮ-г дэмжих хөнгөлөлттэй зээлд хамрагдахад тулгарч буй бэрхшээл?

1. Бичиг баримт бүрдүүлэлт
2. Барьцаа хөрөнгө хангалтгүй
3. Зээлийн гэрээ хатуу
4. Зээлийн эх үүсвэр хүрэлцдэггүй
5. Мэдэхгүй
6. Бусад

4-р хэсэг – Хүндрэл бэрхшээл

Q19. Таны бизнесийн үйл ажиллагаанд аль нь хамгийн их хүндрэл учруулж байна вэ?

1. Хууль эрх зүйн орчин
2. Төрийн байгууллага, албан тушаалтны хүнд суртал
3. Татвар – Хяналт шалгалт
4. Санхүүжилт
5. Бусад

	Жижиг, дунд үйлдвэрлэл явуулахад ямар бэрхшээл учирч байна вэ?	Тийм	Үгүй
1	Өөрийн хөрөнгөгүй		
2	Зээл олдохгүй		
3	Эдийн засгийн байдал хүнд /Худалдан авах чадвар		
4	Мөнгөний ханшны уналт		
5	Засгийн газрын дэмжлэг муу		
6	Улс төрийн нөлөөлөл их байдаг		
7	Тоног төхөөрөмж худалдан авах чадвар хомс		
8	Өөрийн гэсэн ажлын байргүй		
9	Татварын дарамт их		
10	Төрийн байгууллагын хяналт шалгалт их		
11	Албан тушаалтны хууль бус хандлага		
12	Бусад		

Q20. ЖДҮ-г хөгжүүлэх сангаас танд хүрч ажиллаж чадаж байна уу.

1. Тийм
2. Үгүй

Q21. ЖДҮ-г хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг та хэрхэн дүгнэж байна вэ?

1. Хангалттай
2. Хангалтгүй
3. Мэдэхгүй

5-р хэсэг – Эмэгтэй бизнес эрхлэгч

Q22. Та Эмэгтэй бизнес эрхлэгчийг дэмждэг төрийн болон төрийн бус байгууллагын талаар мэдэх үү?

1. Мэднэ
2. Мэдэхгүй

Q23. Төрөөс эмэгтэй бизнес эрхлэгчийг дэмжих чиглэлээр бодлого хэрэгжүүлэх шаардлагатай гэж үздэг үү?

1. Маш их хэрэгтэй
2. Хэрэгтэй
3. Хэлж мэдэхгүй байна
4. Шаардлагагүй

Q24. Таны хувьд цаашид ЖДҮ-ийг хөгжүүлэхэд төрийн ямар бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үздэг вэ?

.....

.....

.....

САНАЛ ӨГСӨН ТАНД БАЯРЛАЛАА

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хавсралт 2

АЖ ҮЙЛДВЭРИЙН ЯАМНААС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР	
1 Жижиг Дунд Үйлдвэрийг Хөгжүүлэх Сан	<p>Зорилго: Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн хөнгөлттэй нөхцөл бүхий зээл олгож, тэднийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх</p> <p>Зорилтууд: ЖДҮ эрхлэгчдэд зориулж урт хугацааны, хөнгөлөлттэй зээл олгох; төрөөс дэмжлэг авч үйл ажиллагаагаа өргөжүүлсэн, ажлын байр бий болгосон ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах; ЖДҮ эрхлэгчдэд зориулсан сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх</p>
2 Жижиг, дунд үйлдвэрийг (2014-2016) дэмжих хөтөлбөр	<p>Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 278 дугаар тогтоолоор батлагдсан.</p> <p>Хөтөлбөрийн зорилго: Жижиг, дунд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг бий болгон хөдөлмөр эрхлэлтийн нэмэгдүүлэхэд оршино.</p> <p>Зорилт: Хууль, эрх зүйн орчныг сайжруулах; Кластераар хөгжүүлэх; Судалгаа боловсруулалт болон инновацийг хөгжүүлэх; Жижиг, дунд үйлдвэрийг чадавхжуулах; Санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хүртээмжийг хангах; Зах зээлийг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх</p>
3 Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр (2014-2016)	<p>Засгийн газрын 2014 оны 08 сарын 28-ны 279 дүгээр тогтоолоор “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг баталсан.</p> <p>Хөтөлбөрийн зорилго: Иргэдийн таатай амьдрах боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай ахуйн үйлчилгээний цогцолбор төвийн тоог нэмэгдүүлэн үйлчилгээг ойртуулах, ажилгүйдлийг бууруулах, албан бус хөдөлмөр эрхлэлт, шилжилт хөдөлгөөнийг багасгахад оршино.</p> <p>Зорилт:</p> <ul style="list-style-type: none"> • Ахуйн үйлчилгээний төвүүдийг улсын төсвийн болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар бий болгох; • төр, хувийн хэвшлийн түншлэлээр бий болсон ахуйн үйлчилгээний төвийн үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх; • албан бус хөдөлмөр эрхлэлтээс зохистой албан хөдөлмөрт шилжин орох ахуйн үйлчилгээ эрхлэгч иргэдийн санал, санаачилгыг урамшуулах; • салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих тогтолцоог боловсронгуй болгож, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх
4 Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр	<p>Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 299 дүгээр тогтоолоор «Монгол Улсыг үйлдвэржүүлэх» хөтөлбөрийг 2009-2016 онд хэрэгжүүлэхээр баталсан.</p> <p>Хөтөлбөрийн зорилго: Дотоодын түүхий эд, нөөц боломжид тулгуурласан, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, дэвшилтэт технологи бүхий боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэн, олон тулгуурт эдийн засгийг бий болгож, улс орны өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино.</p>
5 Арьс ширний үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох зээл	<p>Арьс ширний үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг өргөтгөх, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой.</p> <p>Зээлийн хэмжээ - АҮЯ-аас тогтоосон дүн Зээлийн хугацаа - 5 жил хүртэлх Зээлийн хүү (жил) - 7.0%</p> <p>Тавигдах шаардлага:</p> <ol style="list-style-type: none"> 1. АҮЯ-наас төсөл нь дэмжигдсэн байх; 2. Зээл хүсэгч нь хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт түүний үр ашигтай нөхцөлийг хангасан ажлын байр шинээр бий болгож байх; 3. 1 жилээс дээш хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх; 4. Зээл хүсэгч нь өмнөх улирлын тайлан балансаа гаргаж, татварын албаар баталгаажуулсан байх; 5. Эрхзүйн хувьд бүрэн чадамжтай байх; 6. Бусад банк болон ББСБ-д хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНААС ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД	
6 Хүнсний аюулгүй байдал үндэсний хөтөлбөр	Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоолоор “Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөр 2009-2016 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр баталсан. Хөтөлбөрийн зорилго: Иргэн, төр, олон нийт, хувийн хэвшлийн зохистой оролцоог хангах замаар хүн амыг тэжээллэг, эрүүл ахуйн баталгаатай хүнсээр жигд, хүртээмжтэй, тогтвортой хангаж, эрүүл аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх, Монгол брэндийн органик хүнсийг бий болгож гадаад, дотоодын зах зээлд өрсөлдөхүйц эдийн засгийн шинэ чадавхыг бүрдүүлэхэд оршино.
7 Монгол мал үндэсний хөтөлбөр	Монгол Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг 2 үе шаттайгаар (I үе шат 2010–2015 он, I үе шат 2016 – 2021 он) хэрэгжүүлэхээр баталсан. Хөтөлбөрийн зорилго: Мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцөлийг бүрдүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, экспортыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.
8 Чацаргана хөтөлбөр	Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 60 дугаар тогтоолоор “Чацаргана” хөтөлбөрийг 2 үе шаттайгаар (I үе шат-2010-2012 он, II үе шат-2013-2016 он) хэрэгжүүлэхээр баталсан. Хөтөлбөрийн зорилго: Чацарганыг аж ахуйн болон өрхийн тариалангийн чиглэлээр 20 мянган га хүртэл талбайд тариалж цөлжилтөөс сэргийлэх, хөрс, байгаль орчныг хамгаалах, хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр тогтвортой хангахад оршино.
9 Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр	Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 160 дугаар тогтоолоор “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийг 2 үе шаттайгаар (I үе шат 2003-2008 он, II үе шат–2009-2015 он) хэрэгжүүлэхээр баталсан.

ДОНОР ОРНУУД БОЛОН ОУБ-ТАЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨСЛҮҮД	
Төслийн нэр, хэрэгжих хугацаа	Донор байгууллага
10 Монгол төмс хөтөлбөр /2012-2015 он 2-р үе шат/ Төмсний үр үйлдвэрлэлийг үр ашигтай, тогтвортой болгон хөгжүүлж, үрийн хангалтын системийг төвлөрлөөс гаргаж, сайн чанарын үрийн хүрэлцээ хангамжийг сайжруулах замаар төмс үйлдвэрлэлийн үр ашгийг үндэсний болон орон нутгийн түвшинд сайжруулах болно.	Швейцарийн хөгжлийн агентлаг Төслийн баг Т.Төрмандах ХАА-н хоршоологчдын байр 115 тоот Утас:460158 contact@monpotatopro.mn
11 Цаг Уурт дасан зохицсон хөдөөгийн амьжиргааг бүрдүүлэх /2012-2016 он/ Малчдын бүлэг өртөг нэмсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бусад орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааг эрхлэх боломжтой болно. Орлогын төрлөө нэмэгдүүлэх нь байгаль цаг уурт өртөмхий мал аж ахуйгаас бага хамаарч цаг уурт зохицох зорилготой.	Азийн хөгжлийн банк Төслийн баг Д.Нямдорж ЗГ-ын 11-р байр 708 тоот Утас: 70108810 99117994
12 Хүнсний баталгаат байдал хөтөлбөрийг дэмжих Техник туслалцааны төслийн II үе шат /2014-2016 он/ Мал үржүүлэг зохиомол хээлтүүлэг, шувууны аж ахуй, хүлэмжийн аж ахуй, зөгийн аж ахуйн чиглэлээр БНХАУ-ын мэргэжилтнүүд аж ахуйн нэгжүүдэд ажиллаж мэргэжил аргагүйн зөвлөгөө өгнө.	НҮБ-ын ХХААБ, Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар Төслийн баг Г.Гантулга Хоршоологчдын холбооны байр, 501 тоот Утас:99175578
13 Хөдөө аж ахуйн маркетинг төсөл /2012-2016 он/ Улс орнууд хүнсний баталгаат байдлыг хангах, хөдөө аж ахуйн хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд дутагдаж буй санхүүжилтийг нэмэх	Даян дэлхийн хүнсний баталгаат Байдал хөтөлбөр Төслийн баг Ц.Ванчин 99112476 ЗГ-ын 11-р байр 601-б тоот

14	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл /2012-2016 он/ Хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлж амьжиргааг дээшлүүлэх замаар ядуурлыг бууруулах	ХААХОУС Төслийн баг Д.Далантайням ЗГ-ын 11-р байр 702,703 тоот Утас: 311853, 311897 dalaid@pmpmd.mn
15	“Монгол Улсад амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи, эрүүл ахуйн хяналтын системийг сайжруулах”-төсөл /2013-2015/ Технологи нэвтрүүлэх, боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, эрүүл ахуйн хяналтын системийг сайжруулах зорилго бүхий төсөл	БНСУ-ын KRC байгууллага Хүнсний технологийн коллежийн захирал Барамсай 99112632
16	Монгол Улсын Органик хөдөө аж ахуйд дэмжлэг үзүүлэх төсөл /2014-2016/ Органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн стандартын шаардлага хангасан органик хүнсний сүлжээний бүх үе шатанд баталгаажуулалтын эрх зүй, бүтэц зохион байгуулалтын орчинг бүрдүүлэх, органик хүнсний үйлдвэрлэлд хэрэглэх бодисын жагсаалт гаргах, олон улсын жишигт нийцүүлэх	НҮБ-ын ХХААБ Үндэсний зохицуулагч Б.Чулуунцэцэг 99907641
17	Загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх цөөрмийн аж ахуйг Монголд хөгжүүлэх төсөл /2014-2016/ Загасны аж ахуйг дэмжих замаар хүн амын хүнсний хэрэглээнд загас, загасан бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх улмаар хүмүүсийн шим тэжээллэг хоол хүнсний хэрэглээг нэмэгдүүлж эрүүл мэндийг хамгаалах юм. Хот орчмын бүсэд загасны аж ахуйг дэмжсэнээр хүмүүсийн амьжиргаанд мөн эерэгээр нөлөөлөх юм	НҮБ-ын ХХААБ Үндэсний зохицуулагч М.Нармандах 99781972

**НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨРИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА
ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД**

18	Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр Хөтөлбөрийн зорилго: Бичил бизнес эрхлэдэг болон эрхлэх хүсэлтэй Нийслэлийн иргэдийг хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, амьжиргааны түвшинг тасралтгүй дээшлүүлэхэд оршино. Хөтөлбөрийн хүрээнд иргэдийг дэмжих арга хэмжээ <ul style="list-style-type: none"> • Бичил зээлд хамруулах • Иргэдийг чадавхжуулах сургалтад хамруулах 	
	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг • төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр холбогдох журмын дагуу нэн тэргүүнд худалдан авах • Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах боломжийг бүрдүүлэх 	
19	40-өөс дээш насны иргэдийг ажлын байраар хангах төсөл Хөтөлбөрийн зорилго: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 40-өөс дээш насны иргэдийг ажлын байраар хангахад төслийн зорилго оршино. Хөтөлбөрийн хамрах хүрээ: 40-өөс дээш насны, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн байгууллагад бүртгэлтэй ажилгүй иргэн энэхүү хөтөлбөрт хамрагдана. Хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөл <ul style="list-style-type: none"> • Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах төсөл • Иргэдийн эргүүл, байгаль хамгаалах, нөхөн сэргээх, осол гэмтлээс сэргийлэхэд бүлгээр ажиллуулах төсөл • Ерөнхий боловсролын сургуулийн орчимд явган хүний гарц зохицуулах төсөл 	
	Холбоо барих хаяг: Нийслэлийн хөдөлмөрийн газар Утас: 7011-0502, 7012-0502 Факс: 976-11-329-752 Цахим хаяг: www.ubbirj.ub.gov.mn	

20 ОРГАНИК МОНГОЛ ХӨТӨЛБӨР

Ерөнхий зохион байгуулагчид: МҮХАҮТ, ХасБанк, ПЕТРОВИС ХХК, Макс групп, Энержи Ресурс ХХК

Хамтран ажиллагч: АДРА ОУБ, Хөгжлийн Шийдэл ТББ

Хөтөлбөр хэрэгжих аймгууд: УБ хот, Дархан хот, Эрдэнэт хот, дагавар хорооллууд 21 аймаг сум, харьяа суурин газрууд

Хөтөлбөрт хамруулах төслүүд:

- Эко хэрэглээ эко үйлдвэрлэл байх- Байгаль орчинд ээлтэй ажлын байр бий болгох
- Органик брэнд бүтээгдэхүүн байх- бүтээгдэхүүнийг өргөн хэрэглээ болгох хөгжүүлэх, зах зээлд гаргах бүрэн боломжтой байх
- Эко бизнесийн шинэ санаа, шинэ бүтээгдэхүүн
- Өрхийн амжиргааг дээшлүүлэх, өөрсдийн үйл ажиллагааныхаа ашгаас зээлээ эргэн төлөх боломжтой жижиг дунд эко төслүүд байх

Холбоо барих хаяг:

МҮХАҮТанхимын байр 310 тоот

Махатма Гандийн гудамж, Хан Уул дүүрэг 1-р хороо , УБ хот

Хөтөлбөрийн зохион байгуулах баг

Утас: 55 25 35 33

Имэйл: info@organicmongol.mn

Web: www.organicmongol.mn

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДААС ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

21 ЖДҮ-үүдэд техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх зээл- ханган нийлүүлэгчийг хөгжүүлэх хөтөлбөр /QSDC/

Хөтөлбөрийн зорилго :

- Тодорхой эрэлт эсвэл гэрээг биелүүлэхийн тулд үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх
- ISO, HACCP гэх мэт олон улсын чанарын системийг нэвтрүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, стандартыг сайжруулах
- Шинэ технологи нэвтрүүлэх
- Худалдан авагчийн тодорхой шаардлагад нийцсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох
- Түүхий эд, материал нийлүүлэгч илүү сайн ханган нийлүүлэгч олох
- Шинэ зах зээлд нэвтрэх.

Дараах байдлаар туслалцаа үзүүлнэ:

- Санхүүгийн туслалцаа: тоног төхөөрөмж худалдан авах, урсгал зардлыг санхүүжүүлэх г.м.
- Техникийн туслалцаа: гадаад, дотоодын мэргэжилтэн олох, тэднээр зөвлөгөө өгүүлэх, ажиллагсдыг нь сургах г.м.

- ЖДҮ-ийг шинэ худалдан авагчидтай холбож өгөх, нэмэлт санхүүжилт олоход нь туслах зэргээр ХНХЧТ-ийн хамтран ажилладаг бизнес эрхлэгчид, санхүүгийн байгууллагуудтай холбож өгөх

Шалгуур үзүүлэлт:

- Тодорхой худалдан авагчтай байх. Тус төвийн туслалцаа нь тодорхой эрэлтийг (худалдах, худалдан авах гэрээтэй байх г.м.) хангахад чиглэгдсэн байдаг. Туслалцаа хүсэгч байгууллагын эрэлт, худалдан авагч бүрэн тодорхой биш байвал бид ЖДҮ-дэд хэрхэн худалдан авагчийн худалдан авах хүсэлтийг олж авах талаар анхан шатны зөвлөгөө л өгөх боломжтой.
- Тус төвийн туслалцааны үр дүнд нэмэгдэх борлуулалтын хэмжээ нь тус төвөөс санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын үнийн дүнгээс доод тал нь 5 дахин их байх.

Холбоо барих хаяг:

Утас: (976-11) 32 13 75

Факс: (976-11) 32 78 25

Цахим шуудан: info@qsdc.mn

Цахим хаяг: www.qsdc.mn

<p>22 Бичил эдийн засгийг дэмжих хөтөлбөр-АДРА Эдийн Засгийг Дэмжих хөтөлбөр нь бичил санхүү болон бизнес хөгжлийн шинэлэг, үр дүнтэй үйлчилгээгээр дамжуулан дэмжлэг шаардлагатай иргэд болон олон нийтийн өөртөө туслах чадавхыг нэмэгдүүлж орон нутгийн нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулдаг. Төслийн үйл ажиллагааны үр дүнд хоршооны удирдлага, гишүүдийг бизнесийн болон мэргэжлийн шат дараалсан сургалтад хамруулж ур чадвартай боловсон хүчинг бий болгоход анхаарч, ажлын байранд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ, ноос, сүү цагаан идээ, газар тариалангийн чиглэлээр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг олон ажлыг зохион байгуулдаг.</p> <p>Холбоо барих хаяг: Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Токиогийн гудамж, Палаззо цамхаг, 8-401 Утас: 976-11-450734 Факс: 976-11-450726 Цахим хаяг: www.adra.org.mn</p>	<p>23 Европын сэргээн босголт хөгжлийн банкны Бизнесийн зөвлөх үйлчилгээ (БЗҮ) Монгол хөтөлбөр Бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд төрөл бүрийн чиглэлээр зөвлөх үйлчилгээг авч, үндэсний зөвлөх мэргэжилтнийг ажиллуулахад зардал хуваалцан дэмжлэг үзүүлдэг хөтөлбөр. Зөвлөх үйлчилгээнээс санхүүжилт хүртэл хэрхэн танд туслах ноу хау-г хуваалцах боломжтой. Төслийн цэвэр зардлын 25-75 хувийг буцалтгүй тусламжийн дээд хэмжээ €10000) олгоно.</p> <p>Холбоо барих хаяг: Жижиг Дунд Бизнесийг Дэмжих Баг Утас: 976-11-319278 / 317974 Факс: 976-11-315844 Э-шуудан: knowhowmongolia@ebrd.com Цахим хуудас: www.ebrd.com/sbs/mongolia</p>
<p>24 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төслийн зээл /3 дах шат нь үргэлжилнэ/-JICA Японы олон улсын агентлаг JICA-ын эх үүсвэрээр жижиг дунд үйлдвэрлэл болон байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн эргэлтийн хөрөнгө, тоног төхөөрөмж болон үйл ажиллагаатай холбоотой барилга байгууламжийн өргөтгөлийн санхүүжилтийг хангахад оршино. Арилжааны банкуудаар дамжуулан авах боломжтой.</p> <p>Зээлийн хэмжээ 400.0 мянга хүртэлх USD, түүнтэй тэнцэх төгрөг Зээлийн хугацаа 10 жил хүртэлх Зээлийн хүү (жил) MNT - 7.0 % USD - 5.0 %</p>	<p>25 KFW банкны төслийн зээл Герман улсын KFW банкны эх үүсвэрээр Монгол улсын экспортын чиглэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих төслийн зээл.</p> <p>Зээлийн хэмжээ 250.0 мянга хүртэлх EUR, түүнтэй тэнцэх төгрөг Зээлийн хугацаа 5 жил хүртэлх Зээлийн хүү (жил) MNT - 15.8 % EUR - 8.5 %</p> <p>Тавигдах шаардлага:</p> <ol style="list-style-type: none"> 1. Зээл хүсэгч нь хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт түүний үр ашигтай нөхцөлийг хангасан ажлын байр шинээр бий болгож байх; 2. 1 жилээс дээш хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх; 3. Зээл хүсэгч нь өмнөх улирлын тайлан балансаа гаргаж, татварын албаар баталгаажуулсан байх; 4. Тогтсон хаяг дээр үйл ажиллагаа явуулдаг байх; 5. Эрхзүйн хувьд бүрэн чадамжтай байх; 6. Барьцаанд тавих үл хөдлөх хөрөнгөтэй байх; 7. Бусад банк болон ББСБ-д хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх.

26 Азийн Хөгжлийн банкны АБНТЗээл

АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй жижиг дунд бизнесийн үйл ажиллагаа явуулдаг, ажлын байр шинээр бие болгох иргэд болон аж ахуйн нэгжийн зээл.

Зээлийн хэмжээ 30 сая хүртэл төг

Зээлийн хугацаа 24 сар

Зээлийн хүү (жил) 10%

Тавигдах шаардлага:

1. Зээл хүсэгч нь хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт түүний үр ашигтай нөхцөлийг хангасан ажлын байр шинээр бий болгож байх;
2. 1 жилээс дээш хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;
3. Зээл хүсэгч нь өмнөх улирлын тайлан балансаа гаргаж, татварын албаар баталгаажуулсан байх;
4. Тогтсон хаяг дээр үйл ажиллагаа явуулдаг байх;
5. Эрхзүйн хувьд бүрэн чадамжтай байх;
6. Барьцаанд тавих үл хөдлөх хөрөнгөтэй байх;
7. Бусад банк болон ББСБ-д хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх.

Холбоо барих хаяг:

Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар

СБД, 2-р хороо, М Си Эс Плаза, Чингисийн өргөн чөлөө, 2 давх, (1-р сургуулийн замын урд) УБ 14251

Утас: 329836, 323507

Факс: 311795

И-мэйл: adbmnrm@adb.org

Цахим хуудас: www.adb.org/mnrm

/Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим/

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН ӨСӨЛТӨД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ
ДЭМЖИХ НЬ: ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР ДАХЬ
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД
(Бодлогын тойм судалгаа)**

Ц. Норовдондог –доктор (PhD)

Ерөнхий мэдээлэл:

Монгол улс дахь эмэгтэйчүүдийн чадавхын үзүүлэлт сонирхолтой дүр зургийг харуулж байна. Нэг талаас, Монгол улс 2014 оны Олон улсын Gender Gap Index (GGI) -ээр дэлхийн 142 орноос 42-т, эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцооны үзүүлэлтээр 10-т эрэмбэлэгдэж байгаа боловч Монгол Улсын Засгийн газраас хамгийн сүүлд гаргасан Бээжин +20-ийн хэрэгжилтийн тайланд "...хотжилтын хурдацтай үйл явц, эдийн засгийн тэгш бус байдлын өсөлт нь хүйсийн тэгш бус байдал, нас болон нийгмийн анги давхаргын ялгаанд суурилсан төрөл бүрийн ялгавартай байдлыг бий болгож байна" хэмээн дурьдсанаас үзэхэд нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт жендерийн ялгавартай байдал түгээмэл оршсоор байна.

Судалгаанаас үзэхэд, ардчилсан нийгэмд шилжсэнээр хөдөлмөрийн зах зээл дэх жендерийн ялгавартай байдал нэмэгдсэн бөгөөд ялангуяа эрэгтэйчүүд давамгайл ажилладаг уламжлалт салбарууд болон үйлдвэрлэлийн салбарт эрэгтэйчүүдийн оролцоо илүү байна (UNESCO, 2014). Эмэгтэйчүүд ихэвчлэн эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллаж байхад эрэгтэйчүүд барилга, зам тээвэр гэх мэтийн салбарт түлхүү ажилладаг байна (DFAT, 2015). Дэлхийн банкны судалгаагаар, Монгол Улсын нийт эмэгтэй ажиллах хүчний 64% нь албан бус секторт ажилладаг гэсэн тоо байх бөгөөд нийт эмэгтэйчүүдийн 29% нь өрх толгойлсон эмэгтэйчүүд бөгөөд өрхийн орлогоо дангаар бүрдүүлэхийн зэрэгцээ ихэвчлэн албан бус секторт ажилладаг гэсэн байна.

Монгол Улс бол дунджаас доогуур орлоготой, байгалийн баялаг ихтэй хөгжиж байгаа орон юм. Эдийн засгийн огцом өсөлтийн жилүүдэд уул уурхайн салбарын нөлөөгөөр Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2013 онд 11,7%-д хүрч байсан бол сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт буурсанаар эдийн засгийн өсөлт буурч байна. Үндэсний Статистикийн Хорооны мэдээнээс үзвэл, 2014 оны байдлаар Дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бүрдүүлэгч гол салбарууд нь үйлчилгээний салбар (44.9%), барилга болон аж үйлдвэрийн салбар (32%), газар тариалангийн салбар (14%) байна. Эдгээр салбарууд дахь аж ахуйн нэгжүүдийн 98% нь жижиг дунд бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүд байх боловч нийт дүнгээрээ ДНБ-ний дөнгөж 25%-ийг үйлдвэрлэж, нийт ажиллах хүчний 52% нь эдгээр салбарт ажилладаг гэдгийг судалгаагаар тогтоожээ. (IFC, 2014).

Статистикаас үзэхэд, Монгол Улсад нийт 125169 бүртгэлтэй ААН байгаагаас 65711 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг, нийт бүртгэлтэй ААН-үүдийн 80% нь 9 хүртэл ажилтантай жижиг бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүд байна (NSO, 2015). Албан бус судалгаанаас үзэхэд, жижиг дунд бизнес эрхлэгчдийн 60 хувь орчим нь эмэгтэй эзэнтэй байх бөгөөд эмэгтэй бизнес эрхлэгчдийн тооны өсөлт нь эрэгтэй бизнес эрхлэгчдийн тооны өсөлтийн дунджаас доогуур байна. (IFC, 2011). Монгол Улс "Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц" (CEDAW)-д 1981онд нэгдэн орсноор эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх явдал нь ядуурлыг бууруулах, эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чухал хөшүүрэг мөн гэдгийг хүлээн зөвшөөрсөн боловч эдийн засгийн салбар дахь жендерийн тэгш бус байдал нь "эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломж болон оролцоо"-ны үзүүлэлт доогуур байгаагаар илэрч байна. (World Bank, 2014) Эмэгтэй эзэнтэй жижиг дунд үйлдвэрүүд эдийн засгийн өсөлтөд нөлөө бүхий сегмент болон төлөвшихөд тодорхой саад бэрхшээлүүд тулгарч байна.

Судалгааны зорилго:

Энэхүү бодлогын судалгааны тойм нь Монгол Улсын Жижиг дунд үйлдвэрийн салбарт эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх асуудлыг судлахад чиглэгдэнэ. Судалгааны явцад Монгол Улс дахь ЖДҮ-ийн салбарын хөгжлийн өнөөгийн байдлыг жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх талаас нь авч үзсэнээр эмэгтэй бизнес эрхлэгчид, ялангуяа шинээр бизнес эрхлэх хүсэлтэй эмэгтэйчүүдэд тулгарч буй асуудал, хүндрэл бэрхшээлүүдийг тодорхойлж холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудад хандан тодорхой санал, зөвлөмж боловсруулан хүргэхийг зорьсон болно.

Асуудлын шинжилгээ:

Жижиг дунд үйлдвэрлэлийн салбар бол Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг тодорхойлогч гол салбар бөгөөд нийт ажиллах хүчний дийлэнх нь энэхүү салбарт харьяалагдаж байгааг харгалзан Монгол Улсын Засгийн газраас жижиг дунд үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэхэд онцгой анхаарч дорвитой арга хэмжээнүүдийг авсаар ирсэн. Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчинг бүрдүүлэх тал дээр ахиц дэвшил гарч байгаа бөгөөд Засгийн газраас ЖДҮ-ийг дэмжих, хувийн секторыг идэвхжүүлэх зорилтот хөтөлбөрүүдийг удаа дараа хэрэгжүүлж байна. ЖДҮ-ийг дэмжих эрх зүйн орчны хүрээнд Жижиг дунд үйлдвэрлэлийн тухай хууль (2007), Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль /2012/, Санхүүгийн лизингийн үйлчилгээний тухай хууль /2006/, Хөдлөх хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль /2015/ зэргийг батлан гаргаж, Татварын хуулинд хэд хэдэн удаа өөрчлөлт оруулж ЖДҮ-үүдэд татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлсэн нь жижиг дунд бизнесийг дэмжих, санхүүжилтийн механизмыг бий болгоход чиглэсэн чухал алхамууд болсон байна. Засгийн газраас “ Жижиг дунд үйлдвэрлэлийн тухай” хуульд нийцүүлэн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр батлан хэрэгжүүлж байна.

Бодлого, эрх зүйн хүрээнд авсан арга хэмжээ, хийгдсэн ажлууд нь жижиг дунд үйлдвэрлэлийн салбарын өсөлтийг ерөнхий утгаараа дэмжиж байгаа хэдий ч практикт тулгамдсан олон асуудлууд байсаар байна. Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлж буй 3 дахь удаагийн зорилтот хөтөлбөр нь ЖДҮ-дийг эхлэлтийн болон өсөлтийн шатанд нь татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх, санхүүгийн эх үүсвэр бүрдүүлж хөнгөлөлттэй зээл тусламж олгох, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, захиргааны шат дамжлага, дарамт шахалтыг бууруулах болон зах зээлд бүтээгдэхүүнээ гаргах, инновацийн санаачлагыг нь дэмжих, улмаар ЖДҮ-ийн салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмрийг өсгөх, эдийн засгийн бааз суурийг нэмэгдүүлж солонгоруулах зорилт дэвшүүлсэн. Гэвч бодит байдал дээр байдал өөр байна.

ОУВС-ийн 2014 онд хийсэн санал асуулгын судалгаагаар жижиг дунд аж ахуйн нэгжүүдийн 40% орчим нь төр, засгаас явуулж буй бодлого, авч буй арга хэмжээ нь тэдгээр аж ахуйн нэгжүүдийг бизнесээ өргөтгөх, хөл дээрээ босоход тодорхой дэмжлэг болж чадахгүй байна хэмээн үзсэн байна. Тухайлбал, ихэнх ААН-үүд Засгийн газрын хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадахгүй байгаа бөгөөд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалт тодорхойгүй, Засгийн газрын хөнгөлөлттэй зээл олгох процесс ихээхэн хүнд сурталтай, улс төрчдийн оролцоо их байдаг гэж судалгаанд оролцогсодын ихэнх нь үзсэн байна. Мөн түүнчлэн ЖДҮ-ийн салбарт хэрэгжиж буй эрх зүйн актууд болон Засгийн газраас хэрэгжүүлж буй зорилтот хөтөлбөрүүдийг жендерийн мэдрэмжтэй болгох, эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжих талаар бодлогын хүрээнд тодорхой арга хэмжээ авах шаардлага байна хэмээн үзсэн байна.

Үүнээс үзэхэд эрх зүйн орчин болон Засгийн газрын дэмжлэг үзүүлж буй одоогийн арга механизмыг сайжруулах, шударга хуваарилалтын зарчимд нийцүүлэх шаардлага

практикаас урган гарч байна. Жижиг дунд үйлдвэрийн тухай хуульд зааснаар, хуулиар тавигдаж буй шаардлагыг хангасан жижиг дунд аж ахуйн нэгжүүд нь ЖДҮ-ийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага /Аж үйлдвэрийн яамны Бодлого зохицуулах, хэрэгжүүлэх газар/-т хүсэлт гарган ЖДҮ эрхлэгчдийн нэгдсэн санд бүртгүүлэх ёстой. ЖДҮ-ийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлсэнээр ЖДҮ-үүд нь Засгийн газрын хөнгөлөлттэй зээлд хамрагдах, татварын хөнгөлөлт эдлэх, мэдээлэл судалгаа, мэргэжил, арга зүйн дэмжлэг авах, сургалт сурталчилгаанд хамрагдах боломжтой болох юм. Гэвч одоогийн байдлаар эрх бүхий байгууллага жижиг дунд аж ахуйн нэгжийг бүртгэж авахдаа хүйсийн ялгамжтай бүртгэл хийхгүй байгаа учраас судалгааны гол объект болох эмэгтэй эзэнтэй жижиг дунд бизнес эрхлэгчдийн талаарх статистик мэдээллийн олдоц муу байна. Тухайлбал, Монгол улсын хэмжээгээр хичнээн эмэгтэй жижиг дунд бизнес эрхэлж байна, аль салбарт эмэгтэй бизнес эрхлэгчид түлхүү ажиллаж байна, эмэгтэй бизнес эрхлэгчдэд тухайлан ямар бэрхшээл тулгарч байна, цаашид ямар арга хэмжээ авах замаар тэднийг дэмжих нь зохистой байна вэ? гэдэг талаар судалгаа тооцоо хийж бодлогын зөвлөмж гаргахад бэрхшээлтэй байна.

Олон улсын байгууллагуудын гаргасан судалгаа, зөвлөмжөөс харахад эрх зүйн орчны хүрээнд шийдвэрлэх ёстой хэд хэдэн асуудал байгаа нь харагдаж байна. Тухайлбал, 2007 онд батлагдсан “Жижиг дунд үйлдвэрийн тухай” хуульд заасан жижиг дунд үйлдвэрийн хууль ёсны тодорхойлолт нь тухайн ААН-д ажиллагсадын тоо, жилийн орлогын хэмжээнээс хамааруулан хэд хэдэн ангилалаар тогтоосныг эдийн засгийн нөхцөл байдал, төгрөгийн ханшийн хэлбэлзэлтэй харьцуулахад оновчтой бус бөгөөд практикт төдийлөн мөрдөх боломжгүй байна хэмээн судалгаанд хамрагдсан аж ахуй эрхлэгчид болон холбогдох байгууллагууд үзсэн байна.

Хэдийгээр жижиг дунд аж ахуйн нэгжүүд Монгол Улсын хэмжээнд бүртгэлтэй нийт ААН-үүдийн 98% (үүнээс 80% орчим нь бичил бизнес) байгаа хэдий ч тэдгээрийн ДНБ-д оруулж буй хувь нэмэр нь харьцангуй бага (ДНБ-ны 25%), гэтэл тухайн салбарт ажиллагсадын тоо нь нийт ажиллах хүчний 52%-ийг эзэлж байна (IFC, 2014). ОУВС-ийн гаргасан зөвхөн энэ судалгаанаас үзэхэд Монгол Улсад жижиг дунд үйлдвэрийн салбарыг дэмжих хэрэгцээ шаардлага ямар их байгаа нь харагдаж байна.

Өнөөгийн байдлаар төрийн байгууллагуудад ч тэр, банк санхүүгийн байгууллагуудын хувьд ч тэр “эмэгтэй эзэнтэй жижиг дунд аж ахуйн нэгж” гэсэн ойлголт, нэр томьёо бий болж хэвшээгүй байгаа ба эмэгтэй бизнес эрхлэгчдийг эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулж буй тусгайлсан сегмент байдлаар авч үзэхгүй байна. Эмэгтэй эзэнтэй ЖДҮ-ийн эрх зүйн тодорхойлолт болон албан ёсны статистик ангилал байхгүй байгаа явдал нь бодлого боловсруулагчид болон шийдвэр гаргагчдын эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих санаа сэдлийг идэвхжүүлэх, судалгаа тооцоонд суурилсан жендерийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөр боловсруулах, зөвлөмж гаргах үйл явцыг бэрхшээлтэй болгож байна.

Олон улсын хэмжээнд энэ асуудалд хэрхэн хандаж байна вэ?

Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO), Олон улсын Эмэгтэй бизнес эрхлэгчдийн хөгжлийн хөтөлбөр (WED)-өөс гаргасан судалгаа, дүгнэлтээр дэлхийн хэмжээний албан ёсны нийт бизнесийн ¾-ийг эмэгтэйчүүд эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн дийлэнх нь өсөлтийн чадавх муутай жижиг болон бичил бизнес байна.

Судалгаанд тулгуурлан эмэгтэйчүүдийн эрхэлж буй бизнесийн өсөлтөд саад болж буй хэд хэдэн нийтлэг асуудал байна гэдгийг судлаач, шинжээчид өндөр давтамжтайгаар тогтоосон байна. Үүнд: институцийн болон эрх зүйн зохицуулалтын хомсдол, санхүүгийн эх үүсвэрийн дутагдал, бизнесийн боловсрол болон ажлын туршлага харьцангуй бага, гадуурхагдах эрсдэл, ашиг орлого багатай өсөж хөгжих боломжгүй салбарт бизнес эрхлэх,

гэрийн эзэгтэйн ачааллыг давхар үүрэх (IFC, 2011) гэх мэтийн асуудлууд байдаг байна. Олон улсын Хувийн ААН-ийн хөгжлийн төв-Center for International Private Enterprise (CIPE)-ийн судалгаанаас үзэхэд эмэгтэйчүүд бизнес эрхлэхэд гарааны шатанд хамгийн их тулгамддаг асуудлууд бол эрх зүй-зохицуулалт талаасаа

- 1) эхлэлтийн хөрөнгийн өндөр шаардлага
- 2) бизнес бүртгэлийн төвөгтэй процедур
- 3) өндөр татвар болон татварын ойлгомжгүй систем
- 4) гэрээ үл хэрэгжих байдал
- 5) тусгай зөвшөөрлийн өртөг өндөртэй шаардлага болон олгох процедурын төвөгтэй байдал зэргийг дурдсан байна.

Энэхүү бодлогын тойм судалгааг гүйцэтгэх явцдаа олон улсын болон үндэсний хэмжээний судалгааны тайлангууд, албан ёсны эх сурвалжууд болон статистик мэдээллүүдийг харьцуулан судалж, судалгааны үр дүн, санал зөвлөмжүүдийг уялдаа холбоотойгоор нэгтгэн шинжилсний үндсэн дээр Монгол Улсад эмэгтэйчүүд бизнес эрхлэх, тэр тусмаа ЖДҮ эрхлэхэд тулгамдаж буй асуудлуудыг дараах байдлаар тодорхойлсон болно. Үүнд:

1. Эмэгтэй эзэн /өмчлөгч/-тэй аж ахуйн нэгжийн албан ёсны хүйсийн ялгамжтай бүртгэлийн систем, мэдээллийн сан бүрдээгүй байна.

Монгол Улсад жижиг дунд үйлдвэрлэлийн асуудал хариуцсан Засгийн газрын холбогдох байгууллагууд, Үндэсний Статистикийн Хороо болон банк санхүүгийн байгууллагууд эмэгтэй эзэнтэй ЖДҮ-ийн бүртгэлийн тусгайлсан ангилалыг үүсгээгүй байна. Судалгааны тайлангуудад дурдсан мэдээллийн эх сурвалжууд өөр өөр, хоорондоо зөрүүтэй байгаа байдал ажиглагдаж байна. Тухайлбал, ОУСБ- IFC's Mongolia Enterprise Survey-д дурдсанаар Монгол Улсын нөлөө бүхий хэд хэдэн томоохон банк, банк бус санхүүгийн байгууллагуудын удирдлагатай хийсэн ярилцлагаас үзэхэд эмэгтэйчүүд дангаараа болон гэр бүлийн хүрээндээ хамтран эзэмшдэг ААН-үүдийн тоо энэ салбарын хэмжээнд нийт бизнесийн 60% орчмыг эзэлж байгаа гэсэн бол Дэлхийн банкны 2013 оны судалгаагаар 38,9 % гэж тооцсон байна. Албан ёсны статистик мэдээллээс энэ тоо баримтыг харъя гэхэд яг ийм ангилалаар гаргасан статистик байхгүй, байсан ч итгэл үнэмшил төрүүлэхүйц биш байна. Учир нь ҮСХ-ны мэдээлэл нь нийт ААН-үүдийн тоо, идэвхтэй, идэвхгүй ААН-үүдийн тоог харуулахаас бус ЖДҮ-үүдийг хуульд заасан ангилалаар нь бүртгэх, үүнээс эмэгтэй эзэнтэй ЖДҮ -ийн статистик мэдээллийг тусгайлан гаргадаг систем алга байна. ЖДҮ-үүдийг албан ёсоор бүртгэдэг ч гэлээ энэхүү процедур нь төвөгтэй, олон шат дамжлага дамжиж олон янзын материал бүрдүүлэх гэх мэтийн хүнд суртал ихтэй байгаагаас ЖДҮ-үүд төдийлөн бүртгэлд хамрагдахгүй байна. ЖДҮ-үүд албан ёсны бүртгэлд хамрагдаж төрийн дэмжлэг авах, хөнгөлөлттэй зээл тусламжид хамрагдах боломжоо тэр бүр ашиглаж чадахгүй байх, албан бусаар үйл ажиллагаа явуулах байдал түгээмэл байна. Ялангуяа эмэгтэй бизнес эрхлэгчид төрийн дэмжлэг, тусгайлсан хөтөлбөрт тэр болгон хамрагдаж чадахгүй байгаа учраас эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжихийн тулд юуны өмнө ЖДҮ-ийн бүртгэлийн системийг жендерийн ялгамжтай болгож эмэгтэй эзэнтэй ЖДҮ-ийн бүртгэлийн ангилалыг тогтоож өгөх нь чухал байна. Эмэгтэй эзэн /өмчлөгч/-тэй ААН-үүдийн бүртгэлийг тусгайлан гаргаснаар жендерийн ангилал бүхий бизнес эрхлэгчдийн статистик мэдээллийн сан бүрдэж, эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх, эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог судлан шинжлэхэд дөхөмтэй болох болно хэмээн үзэж байна.

2. Санхүүгийн эх үүсвэрийн дутагдал нь эмэгтэй, эрэгтэй эзэнтэй ЖДҮ-ийн аль алиных нь хувьд тулгамдсан асуудал бөгөөд ялангуяа эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд хамгийн хүндрэлтэй асуудал болоод байна.

Арилжааны банкуудын олгож байгаа зээл нь хугацаа богино, өртөг өндөртэй байхаас гадна барьцаа хөрөнгийн шаардлага маш өндөртэй байдаг. Арилжааны банкуудын хувьд хөдлөх хөрөнгийн бүртгэлийн систем одоогоор бүрдээгүй байгаа учраас үндсэндээ үл хөдлөх хөрөнгийг барьцаалан зээл олгож байна. Гэр бүлийн доторх өмчлөлийн эрхийн хувьд нөхөр/эхнэр ялгаатай байгаа учраас ялангуяа эмэгтэйчүүд арилжааны банкнаас зээл авах үедээ барьцаа хөрөнгийн асуудалтай ихээхэн тулгардаг. 1990 онд зах зээлд шилжиж хувьчлал явагдах үед газар, мал болон томоохон үл хөдлөх хөрөнгө ихэвчлэн өрхийн тэргүүний нэр дээр бүртгэгдсэн бөгөөд эмэгтэйчүүд тэр болгон өмчлөх буюу хамтран эзэмших боломжгүй болсон учраас гэр бүлийн өмчлөлд байгаа хөрөнгөө барьцаалж хувиараа бизнес эрхлэх болбол нөхөр болон гэр бүлийн гишүүдээсээ хамтын хөрөнгөө барьцаанд тавих зөвшөөрөл авах, хамтын зөвшилцөлд хүрэх шаардлага гардаг. Жишээлбэл, Дэлхийн банкнаас 2008 онд хийсэн судалгаагаар, судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн 88% нь гэр бүлийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгө болон томоохон хөрөнгө өрхийн тэргүүний нэр дээр бүртгэлтэй, зөвхөн 12% нь л хамтран өмчилдөг гэсэн байна. Гэтэл арилжааны банкууд болон банк бус санхүүгийн байгууллагуудаас авсан судалгаагаар (NBFIs) эрэгтэй/эмэгтэй зээлдэгчдийн зээл эргэн төлөлтийн хувийг харьцуулж үзэхэд эмэгтэй зээлдэгчид зээлээ илүү сайн, хугацаанд нь төлдөг гэсэн байна. Банк санхүүгийн байгууллагуудын хувьд эмэгтэй зээлдэгчдийг бизнесийн онцгой сегмент, зах зээлд гарах боломжтой ирээдүйтэй субъект гэдгээр нь анхаарч үзэх хандлага сул байна. Эрх зүйн орчны төгс бус байдал, хуулийн хэрэгжилт сул байгаа зэрэг байдал нь банк санхүүгийн байгууллагуудыг хөдлөх хөрөнгийг барьцаанд авахаас зайлсхийхэд хүргэж байна. Гэтэл (Rockefeller Foundation 2013) судалгаагаар Монголын эмэгтэйчүүд хөдлөх хөрөнгө түлхүү эзэмшдэг гэсэн байна. Хөдлөх хөрөнгийг барьцаалах эрх зүйн орчин бүрдсэн тохиолдолд эмэгтэйчүүдийн барьцаа хөрөнгийн чадавх сайжрах магадлалтай хэмээн үзэж байна. Мөн ЖДҮ-ийн компаниуд, тэдгээрийн орлого ашгийн талаарх хүйсийн ялгамжтай бүртгэл-мэдээллийн систем бий болсон тохиолдолд банк санхүүгийн байгууллагуудын зүгээс эмэгтэй бизнес эрхлэгчдийг тодорхой хэмжээгээр дэмжих, зээл-санхүүгийн үйлчилгээ үзүүлэх боломж нэмэгдэнэ хэмээн үзэж байна. Одоогоор БСБ-ууд барьцаа хөрөнгийн дутагдалтай байгаа байдлаас шалтгаалан эмэгтэйчүүдэд зээл олгох нь эрэгтэйчүүдэд олгосноос илүү эрсдэлтэй хэмээн үзэх хандлагатай байна.

3. Төр, засгийн зүгээс эмэгтэй эзэнтэй ЖДҮ-ийг дэмжих талаар дорвитой арга хэмжээ авахгүй байгаа ба ЖДҮ-ийг дэмжих төрийн бодлого нь жендерийн мэдрэмжгүй хэвээр байна.

ЖДҮ-ийн ААН-ийн хэлбэр, орлого ашиг, жилийн эргэлт болон санхүүгийн эрэлт хэрэгцээний тухайд тусгайлан гаргасан хүйсийн ялгамжтай тооцоо судалгаа байхгүй байгаа учраас төр засгийн зүгээс ЖДҮ-ийг дэмжих бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ жендерт суурилсан бодлого хэрэгжүүлж чадахгүй байна. Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих төрийн бодлого үндсэндээ байхгүй гэж хэлж болно. Гэтэл эмэгтэй бизнес эрхлэгчид худалдаа, үйлчилгээ, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт өндөр оролцоотой байж эдийн засгийн суурь салбаруудыг авч яваа бөгөөд тэдэнд төр засгийн дэмжлэг маш их хэрэгцээтэй байгаа нь харагдаж байна. ЖДҮ-үүдэд олгосон Засгийн газрын хөнгөлөлттэй зээлд хичнээн эмэгтэй эзэнтэй ЖДҮ хамрагдсан нь тодорхой бус. Бидэнд олдсон ганцхан судалгаанаас эшлэвэл, “Ноос, ноолуур, оёдол, ногоон байгууламж болон эрчимт мал аж ахуйг дэмжих” Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт хамрагдсан ЖДҮ-үүдийн санхүүжилтийн явцын тайлан мэдээнээс үзэхэд эмэгтэй эзэнтэй ААН-үүд нийт хөтөлбөрт хамрагдсан ААН-үүдийн 60% гэсэн байна. Засгийн газрын ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөр, санхүүгийн дэмжлэг, чадавхжуулах

сургалтын хөтөлбөрүүд, менежментийн дэмжлэг эмэгтэй эзэнтэй ЖДҮ-үүдэд ус, агаар мэт хэрэгтэй байгаа боловч эмэгтэйчүүд энэхүү дэмжлэгийг хэрхэн авах, яаж хамрагдахаа мэдэхгүй, тэдэнд зориулсан тусгайлсан бодлого, хөтөлбөр байхгүй байсаар байна. Засгийн газар харьяа яам, агентлагууд, банк санхүүгийн байгууллагаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох, бизнесийн зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрт хамруулах ажлууд зохион байгуулдаг ч эмэгтэйчүүд төдийлөн хамрагдаж чадахгүй байна. Засгийн газрын хөнгөлөлттэй зээл болон арилжааны банкны зээлд хамрагдаж чадахгүй байгаа учраас эмэгтэй бичил бизнес эрхлэгчид ихэвчлэн банк бус санхүүгийн байгууллага, ХЗХ-ноос өндөр хүүтэй зээл авах, улмаар бизнес нь өргөжин хөгжихгүй, дампуурах, өр төлбөрт орох байдал ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь өрх толгойлсон, дөнгөж хөл дээрээ босохыг хичээж байгаа хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүдийн аж байдалд сөрөг нөлөө үзүүлж нийгмийн олон сөрөг үр дагаврыг авчрах хандлагатай байна.

4. Монголын эмэгтэйчүүд нийгмийн статус, боловсролын түвшингийн хувьд өндөр боловч эдийн засаг дахь оролцооны хувьд харьцангуй доогуур үзүүлэлттэй байна.

Монголын эмэгтэйчүүд аж байдлын уламжлалт хэв маягаа тодорхой хэмжээнд хадгалсаар ирсэн. Тухайлбал монгол эмэгтэйчүүд ихэвчлэн гэр бүлийн хүрээний бизнес эрхлэх хандлагатай байгаа бөгөөд уламжлалт аж байдал, соёлын онцлогоос шалтгаалан гэр бүл, ах дүүсээ дэмжих, нүүдэлчин маягийн бүлсэг хэв маягтай хэмээн үздэг. Өнөө цагийн нийгмийн харилцаанд орохдоо ч гэсэн гэр бүл, ах дүүсээ дэмжих хандлага давамгайлж байгаа учраас эмэгтэйчүүд гэр бүлийн бизнестээ тодорхой үүрэг рольтой байж ААН-ийг өмчилдөггүй ч гэлээ үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцож, шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсээр байна. Нөгөө талаас монгол эмэгтэйчүүдийн боловсрол өндөр, нийгмийн харилцаанд эрэгтэйчүүдтэй тэгш байдлаар оролцдог нь социализмын үеэс улбаатай юм. 1990 онд зах зээлийн харилцаанд шилжсэн ч гэлээ эмэгтэйчүүдийн нийгэм-эдийн засгийн амьдралд оролцох оролцоо, эрх тэгш байдал хэвээр хадгалагдаж эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн нэгэн адилаар бизнес эрхлэх, эдийн засгийн салбарт тодорхой үүрэг рольтой байх нөхцөл бүрдсэн юм. ОУСБ (IFC, 2014)-ын судалгаанаас үзэхэд, Монгол Улс дахь нийт бизнесийн 45% орчим нь гэр бүлийн бизнес байх бөгөөд энэ нь эмэгтэйчүүд дангаар эзэмшдэг бизнесээс илүү өндөр хувьтай байна. Эмэгтэйчүүдийн нийтлэг онцлог бол зөвхөн бизнес эрхлэх төдий бус үүний хажуугаар үр хүүхэд, гэр бүлээ асран халамжлах давхар давхар үүрэг хариуцлага хүлээдэг учраас харьцангуй ачаалал ихтэй байдаг. Эмэгтэй бизнес эрхлэгчдэд нэн шаардлагатай зүйл бол бизнесийн хүрээнийхэн болон төр, төрийн бус байгууллагынхантайгаа харилцаа холбоо тогтоож мэдээлэл авах, сургалтын болон чадавхжуулах хөтөлбөрт хамрагдах явдал юм. Түүнчлэн эмэгтэйчүүдийн бизнесийг дэмжих олон төрлийн дэмжлэг шаардлагатай байгаа бөгөөд зах зээлд бүтээгдэхүүнээ гаргахад нь дэмжлэг үзүүлэх, зах зээлийг нь хамгаалах, хэрэгцээтэй тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн технологийг олж нийлүүлэхэд нь туслах, татварын болон санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх замаар тогтвортой бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх шаардлага байсаар байна.

5. Эмэгтэй бизнес эрхлэгчид, ялангуяа шинээр бизнес эрхэлж байгаа эмэгтэйчүүдэд чадавх бэхжүүлэх сургалт семинар зохион байгуулах, мэдээлэл сурталчилгааны дэмжлэг үзүүлэх, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд нь туслах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэргээр дэмжиж туслах явдал хангалтгүй байна.

Аж үйлдвэрийн яам болон холбогдох бусад төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ЖДҮ эрхлэгчдэд зориулсан сургалт, семинар зохион байгуулах,

чадавхжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх болон мэдээлэл хуваалцах, хамтран ажиллах нөхцөл боломжийг нь бүрдүүлэх шаардлагатай байна. Судалгаанаас үзэхэд, Улаанбаатар хотод нийт ЖДҮ-үүдийн 63% орчим нь төвлөрч байгаа (IFC 2013) ба Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв одоогийн байдлаар зөвхөн УБ хот болон харьяа дүүргүүдэд тодорхой хэмжээгээр ажиллаж хөдөө орон нутгийн ЖДҮ-үүд энэ төрлийн үйлчилгээ, дэмжлэгийг төдийлөн сайн авч чадахгүй байна. Мөн түүнчлэн ЖДҮ эрхлэгчдэд зориулсан сургалт, чадавхжуулах хөтөлбөрүүд нь жендерийн мэдрэмжтэй хөтөлбөрт суурилахгүй байгаа учраас эрэгтэй, эмэгтэй бизнес эрхлэгчид, тэдгээрийн чадавх, сургалтын эрэлт хэрэгцээнд суурилсан ялгаатай хөтөлбөрүүдээр сургалт семинар зохион байгуулахгүй байгаа нь харагдаж байна. Эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан сургалтыг ганц нэг төрийн бус байгууллага зохион байгуулж байгаа хэдий ч сургалтанд хамрагдаж байгаа бизнес эрхлэгчдийн мэдлэгийн түвшин, эрэлт хэрэгцээнд нийцсэн чанартай сургалтыг зохион байгуулж чадахгүй байна. Жишээлбэл, эрэгтэй, эмэгтэй бизнес эрхлэгчид аль алинд нь маркетинг, борлуулалт, эрх зүйн чиглэлийн сургалт хэрэгцээтэй байдаг бол эмэгтэйчүүдэд бизнесийн өртөг зардлыг тооцох, хүний нөөцийн болон санхүүгийн менежментийн гэх мэтчилэн тусгайлсан сургалт авах эрэлт хэрэгцээ байж болно. Иймэрхүү маягаар тухайн бизнес эрхлэгчдийн бизнесийн үе шат, мэдлэгийн түвшинд суурилсан сургалт семинарыг зохион байгуулж явуулах нь илүү өгөөжтэй байх болов уу. Австрали Улсын туршлагаас үзэхэд, салбарын яам агентлагууд болон эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжих төвүүд нь эмэгтэйчүүдэд зориулсан тусгайлсан бодлого хөтөлбөр хэрэгжүүлж, бараа бүтээгдэхүүнийг нь зах зээлд гаргах, сурталчлах, бизнесийн салбарт манлайлагч эмэгтэйчүүдийн имижийг бүрдүүлэх тал дээр практик ач холбогдолтой олон зүйлийг хийж хэрэгжүүлж байдаг юм байна.

ЗӨВЛӨМЖ

- 1. Хүйсэд тулгуурласан бизнес бүртгэлийн систем бий болгох:** Жижиг дунд үйлдвэрлэлийн /ЖДҮ/ асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага /Аж үйлдвэрийн яам/-д бүртгүүлээгүй жижиг дунд үйлдвэрүүдийн хувьд Засгийн газраас хэрэгжүүлж буй ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөрт хамрагдах, хөнгөлөлттэй зээл тусламжид хамрагдах боломж нь хязгаарлагддаг учраас Засгийн газрын байгууллагууд ЖДҮ-ийн бизнесийн бүртгэлийн оновчтой системийг нэвтрүүлж, ЖДҮ эрхлэгчдийн бизнесээ бүртгүүлэх хүсэл сонирхолыг нь идэвхжүүлэх, хөхиүлэн дэмжих кампанит ажлыг зохион байгуулах нь зүйтэй байна. Үүний тулд юуны өмнө ЖДҮ-ийн бүртгэлийг хүйсийн ангилалаар гаргахын тулд одоо мөрдөж байгаа бүртгэлийн журамд өөрчлөлт оруулж жижиг дунд аж ахуйн нэгжийг бүртгэх маягт дээр тухайн ААН-ийг өмчлөгч /эзэмшигч/-дийн хүйсийг асуусан асуулт оруулж өгөх нь зүйтэй байна. Аж Үйлдвэрийн Яамны энэхүү бүртгэл нь ЖДҮ эрхлэгчдийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг хариуцан гаргадаг учраас энэхүү санд жендерийн асуулгатай мэдээллийг оруулснаар ЖДҮ үйлдвэрлэл эрхлэгчдийн талаарх мэдээллийг хүйсийн ялгамжтай байдлаар анхан шатны бүртгэлд бүртгэж мэдээлэл судалгаа гаргах, цаашид эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан бодлого боловсруулах болон шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах боломж бүрдэнэ хэмээн үзэж байна. Энэхүү мэдээлэл судалгааны сан нь албан бус бизнесийг албан ёсны болгож далд эдийн засгийг бууруулах, эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байх болно.
- 2. Засгийн газрын байгууллагууд, Үндэсний Статистикийн Хороо болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд, банк санхүүгийн байгууллагуудыг ЖДҮ эрхлэгчдийн талаарх хүйсийн ангилалтай мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээ тайлан гаргах үйл ажиллагааг идэвхжүүлэх.**

Эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийн талаарх бодит байдлыг ойлгоход статистик мэдээлэл нэн шаардлагатай байна. Засгийн газрын байгууллагууд, бүртгэл-статистикийн байгууллагууд болон жижиг дунд үйлдвэрүүдтэй харьцаж ажилладаг бүх байгууллагууд эрэгтэй, эмэгтэй бизнес эрхлэгчдийн талаар хүйсийн ялгамжтай асуулгыг холбогдох маягтад оруулж, мэдээллийг нэгтгэн гаргах тогтолцоо бүрдүүлэх нь чухал байна. Энэхүү зөвлөмж нь Үндэсний статистикийн хороо, Монгол банк, Аж үйлдэрийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам зэрэг Засгийн газрын байгууллагууд болон холбогдох бусад байгууллагуудад хамаарна.

3. **Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих байгууллагуудын хүрээг тэлж, эмэгтэй бизнес эрхлэгчдэд чиглэсэн сургалт семинарыг эрчимжүүлэх.** Засгийн газрын холбогдох байгууллагууд ЖДҮ-ийг дэмжин ажилладаг бусад байгууллагуудтай нягт хамтран ажиллаж эмэгтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, хүрч үйлчлэх хүрээгээ тэлэх хэрэгтэй. Эмэгтэй бизнес эрхлэгчдийн чадавхыг дээшлүүлэхдээ НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагын 7 зарчмыг тусган хэрэгжүүлвэл илүү үр дүнтэй болно. Мөн ЖДҮ-ийг дэмжин ажилладаг байгууллагууд болох ЖДҮ-ийг хөгжүүлэх төв, Бизнес инкубатор төвүүдийн үйл ажиллагааг орон нутагт тэлэх нь чухал байна. Иймэрхүү төвүүд нь эмэгтэй бизнес эрхлэгчдэд шаардлагатай сургалт, семинарыг илүү сайн өгч чадна. Энэхүү сургалт, семинараар дамжуулан бизнес эрхлэгчид маань хоорондоо танилцаж, бизнесээ цаашид хөгжүүлэх тэлэхэд туслах зөвлөх хүмүүсийг олж чадна.
4. **Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төрийн болон төрийн бус байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг эрчимжүүлэх.** Монгол Улсын Засгийн газар, ЖДҮ-ийг дэмждэг сангууд болон доноруудтай хамтран ажиллаж, эмэгтэй эзэнтэй ЖДҮ-ийг дэмжих үүднээс байгууллагын худалдан авалтыг хийхэд эмэгтэй эзэнтэй жижиг дунд үйлдвэрүүдээс авах квот тогтоож, тэдний санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн дэмжих боломжтой. Мөн эдгээр оролцогч талуудтай илүү нягт хамтран ажилласнаар ЖДҮ-ийг дэмжих нарийн зохион байгуулалт бүхий цогц санхүүгийн механизм гаргаж ирэх нь маш чухал юм. Төрийн байгууллагууд эмэгтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах чиглэлээр холбогдох төрийн бус байгууллагууд болон институцуудтай мэдээлэл солилцож, хамтран ажиллах хэрэгтэй байна.
5. **Эмэгтэйчүүдийн жижиг дунд үйлдвэр эрхлэлтийг дэмжих чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргах байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх.** Монгол Улсын Засгийн газрын дэргэдэх ЖДҮ-ийн Үндэсний хороо болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын зүгээс жендерт суурилсан жижиг дунд үйлдвэрлэлийн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажиллах нь чухал байна. Засгийн газрын дэргэдэх ЖДҮ-ийн Үндэсний хорооны бүрэлдэхүүнд эмэгтэйчүүдийн төлөөллийг оролцуулах, эмэгтэй бизнес эрхлэгчдийг тусгайлан дэмжих бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх, эмэгтэйчүүдийн бизнес, эдийн засаг дахь манлайллыг нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагааг нь сурталчлан таниулах зэрэг олон чухал арга хэмжээг төрийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх нь зүйтэй болов уу.

2

БҮЛЭГ

ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ИХ БРИТАНИ, ИЗРАЙЛИЙН ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ДҮН 2015

Р.Хатанбаатар, А. Пагма

Их Британийн парламентын сонгууль 2015 оны 5 дугаар сарын 7-нд боллоо. Сонгуулийн дүнгээр Консерватив нам Төлөөлөгчдийн танхимд олонхын суудал авч, дангаараа Засгийн газар байгуулах боломжтой болжээ.

Нийтийн танхимын суудлын тоо - 650

Засгийн газар байгуулахад шаардагдах суудлын тоо – 326

Сонгуулийн систем – мажоритар

Нийт оролцсон намын тоо – 67

Нийт нэр дэвшигчид – 3921

Нийт сонгогчид - 46,425,386

Сонгуулийн ирц – 66,1 %

Нийт сонгогдсон гишүүдийн 29% буюу 191 нь эмэгтэй.

	<i>Нам, намын дарга</i>	<i>Авсан саналын тоо, хувь</i>	<i>Төлөөлөгчдийн танхимд авсан суудлын тоо, хувь</i>
1	Консерватив нам Дэвид Камерон	11 334 920 (36,9%)	331 50.8%
2	Лейборист нам Эд Милибэнд	9 344 328 (30,4%)	232 35.7%
3	Шотландийн Үндэсний нам Никола Старжен	1 454 436 (4,7%)	56 8.6%
4	Либерал демократууд	2 415 888 (7,9%)	8 1.2%
5	Ардчилсан юнионист нам	184 260 (0,6%)	8 1.2%
6	Шинн Фейн	176 232 (0,6%)	4
7	Уэльсийн нам	181 694 (0,6%)	3
8	Социал демократ лейборист нам	99 809 (0,3%)	3
9	Ольстерийн юнионист нам	114 935 (0,4%)	2
10	Нэгдсэн вант улсын тусгаар тогтнолын нам	3 881 129 (12,6%)	1
11	Англи, Уэльсийн ногоон нам	1 157 613 (3,8%)	1
12	“Альянс” нам	61 556 (0,2%)	0
13	Бусад		1

Израильд парламентын сонгуулийг пропорциональ системээр явуулдаг бөгөөд 3 хувийн босготой юм. 2015 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Израйльд парламентын ээлжит бус

сонгууль явагдаж Ерөнхий сайд Биньямин Нетаньяхугийн тэргүүлдэг эрх баригч “Ликуд” нам сонгогчдын 23,40 хувийн санал авч ялалт байгуулсан байна. “Ликуд” нам Кнессетийн 120 суудлаас 30 суудлыг авсан байна. Тус сонгуульд нийт 25 улс төрийн нам, эвсэл оролцсоноос дараах 10 нам, эвсэл Кнессетэд суудал авчээ.

№	Нам, эвсэл	Жагсаалтад өгсөн саналын тоо	Саналын хувь	Мандатын тоо
1	“Ликуд”	985,408	23,40	30
2	“Сионист лагерь”	786,313	18,67	24
3	“Нэгдсэн жагсаалт”	446,583	10,61	13
4	“Еш атид”	371,602	8,82	11
5	“Кулану”	315,360	7,49	10
6	“Байт Иегуди”	283,910	6,74	8
7	“ШАС”	241,613	5,74	7
8	“Бидний гэр Израйль”	214,906	5,10	6
9	“Яхадута-Тори”	210,143	4,99	6
10	“Мерец”	165,529	3,93	5

Энэ удаагийн парламентын сонгуулийн ирц 72,3 хувь байсан ба энэ нь 1999 оноос хойших хугацаанд явагдсан 6 удаагийн сонгуулийн хамгийн өндөр ирцтэй сонгууль болжээ.

Сар гаруй үргэлжилсэн яриа, хэлэлцээрийн дүнд Израйльд эвслийн засгийн газар байгуулагдсан.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- "Election 2015 results". BBC. Retrieved 8 May 2015.
- 2015 general election results, BBC News.
- Election 2015 results in Israel. http://www.ipu.org/parline-e/reports/2155_E.htm

**ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХЭЛБЭР, ПАРЛАМЕНТЫН
ЗАСАГТАЙ ОРНУУДЫН СОНГУУЛИЙН ЗАРЧИМ**

*Ц.Болормаа, Д.Жигваагүнсэл
Ч.Онончимэг, Д.Халиун*

АГУУЛГА**СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХЭЛБЭР:
ШИНЖ ЧАНАР

*Хүснэгт 1. Дэлхийн улс орнуудын төрийн удирдлагын хэлбэр: ангилал,
шинж чанар*

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ПАРЛАМЕНТЫН БҮГД НАЙРАМДАХ УЛСУУДЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ БОЛОН ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙГ
СОНГОХ ЗАРЧИМ

*Хүснэгт 2. Парламентын бүгд найрамдах улсуудын Ерөнхийлөгч болон
Парламентын сонгуулийн зарчим*

ГУРАВДУГААР БҮЛЭГ: МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХ,
ЕРӨНХИЙЛӨГЧ БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮНИЙГ
СОНГОХ ЖУРМЫГ ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Нэг. Ерөнхийлөгч, засгийн газрын тэргүүнийг сонгох журам

Хүснэгт 3. Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдыг сонгох журам

1. Монгол Улс
2. Болгар Улс
3. Финланд
4. Серб
5. Чрна Гора
6. Хорват
7. Исланд
8. Сингапур
9. Словак
10. Турк
11. Македон
12. Кыргызстан

Хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зарим орны Ерөнхийлөгчийн
бүрэн эрхтэй харьцуулсан байдал

2.1. Монгол Улсын болон зарим орны Ерөнхийлөгчийн бие даан
хэрэгжүүлдэг бүрэн эрхийн харьцуулалт

Хүснэгт 4

2.2. Монгол Улсын болон зарим орны Ерөнхийлөгчийн хамтран
хэрэгжүүлдэг бүрэн эрхийн харьцуулалт

Хүснэгт 5

2.3. Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд
харгалзах эрхийг бусад орны холбогдох хууль тогтоомжид тусгасан
байдал

Хүснэгт 6

ХАВСРАЛТ


СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгаанд НҮБ-ын гишүүн 188 орны төрийн удирдлагын хэлбэр, хууль тогтоох дээд байгууллага болон гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүнийг сонгох сонгуулийн зарчмыг судлан эдгээрээс Парламентын засаг бүхий 54 орны Ерөнхийлөгч болон Парламентын гишүүнийг сонгох журмыг нарийвчлан судлав. Дээрх 54 орноос эрх зүйн бүл, төрийн удирдлагын хэлбэр, парламентын танхимын тоо болон сонгуулийн тогтолцоо зэргийг шалгуур болгон Монгол Улстай төсөөтэй төрийн удирдлага бүхий 11 орныг сонгон эрх зүйн зохицуулалтыг Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд харьцуулсан болно.

Судалгааны нэгдүгээр бүлэгт: 188 орны төрийн удирдлагын хэлбэр, ангилал, шинж чанар, сонгуулийн зарчмын талаар авч үзлээ. Онолын хувьд төрийн удирдлагын хэлбэрийг **Бүгд Найрамдах** болон **Хаант засаг** гэсэн хоёр үндсэн хэлбэрт хуваах бөгөөд судалгаанд хамрагдсан 188 орны хувьд доорх байдалтай байна. Үүнд:

Төрийн удирдлагын хэлбэр			Орон
Бүгд Найрамдах Улс	Ерөнхийлөгчийн		42 орон
	Хагас Ерөнхийлөгчийн		49 орон
	Парламентын		54 орон
Хаант засагтай	Хэмжээт эрхт	Үндсэн хуульт буюу Парламентын	28 орон
		Хоёрдмол буюу Дуалист шинж бүхий	9 орон
	Хэмжээгүй эрхт		6 орон

Зураг 1.



Судалгааны хоёрдугаар бүлэгт: Судалгаанд хамруулсан 188 орноос төрийн удирдлагын хэлбэрийн хувьд Парламентын Бүгд Найрамдах, улс төрийн дэглэмийн хувьд ардчилсан дэглэм бүхий 51 орныг сонгон авч Ерөнхийлөгчийн болон парламентын сонгуулийн зарчмыг харьцуулан судалсан болно.

Судалгаанаас үзэхэд Ерөнхийлөгчийг сонгохдоо:


- Бүх нийтийн 2 үе шат бүхий сонгуулиар сонгодог 15 улс,
- Бүх нийтийн энгийн олонхын саналаар сонгодог 4 улс,
- Хууль тогтоох дээд байгууллагаас сонгодог 26 улс,
- Сонгогчдын коллеги болон Сонгуулийн хорооноос сонгодог 6 улс байна.

Харин хууль тогтоох дээд байгууллагын хувьд сонгосон 51 орноос 37 нь Парламентын нэг танхимтай бол 14 нь Парламентын хоёр танхимтай улс орнууд байна. Парламентын 2 танхимтай орны хувьд доод танхимыг **шууд сонгуулиар** сонгодог бол дээд танхимыг **шууд** болон **шууд бус сонгуулиар** сонгож байна. Зарим улс орны хувьд дараах онцлогтой байна. Тухайлбал,

- Ботсван Улсын Парламентын дээд танхимыг үе залгамжлуулан буюу томилдог;
- Герман Улсын Парламентын дээд танхимыг муж улсын төлөөллөөс сонгодог;
- Ирланд Улсын Парламентын дээд танхимыг намаас нэрийн жагсаалтаар томилдог;
- Словени Улсын Парламентын дээд танхимыг сонирхлын бүлгийн төлөөллөөс болон бүх ард нийтээс сонгодог байна.

Энэ бүлэгт сонгосон 51 орноос хууль тогтоох дээд байгууллагыг бүх ард нийтээс сонгодоггүй нэг улс байгаа нь Ливи Улс /Парламентын нэг танхимтай/ бөгөөд Парламентыг Төлөөлөгчдийн зөвлөл /Council of Representatives/-өөс сонгодог байна.

Зураг 2.



Судалгааны гуравдугаар бүлэгт: Ерөнхийлөгч, парламентыг /парламентын нэг танхимтай/ бүх нийтээр сонгодог Монгол Улстай ижил төстэй сонгуулийн тогтолцоо бүхий 11 улс байна. Үүнд:

№	Улс орон	Ерөнхийлөгч	Нэг танхимтай парламент
1	Болгар	✓	✓
2	Исланд	✓	✓
3	Кыргызстан	✓	✓
4	Македон	✓	✓
5	Сингапур	✓	✓
6	Серби	✓	✓
7	Словак	✓	✓

8	Турк	✓	✓
9	Финланд	✓	✓
10	Хорват	✓	✓
11	Чрна Гора	✓	✓

Эдгээр орны Ерөнхийлөгч болон Засгийн газрын тэргүүнийг сонгох журам, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Монгол Улсын холбогдох эрх зүйн зохицуулалттай харьцуулсныг дараах хоёр хэсэгт хуваан авч үзлээ. Үүнд:

Нэгдүгээр хэсэгт Ерөнхийлөгч болон Засгийн газрын тэргүүнийг сонгохтой холбоотой эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжоос түүвэрлэн авч үзэхэд Ерөнхийлөгчийг сонгох хэлбэр, Парламентын танхимын тоо, Засгийн газрын тэргүүнийг томилох хэлбэрээрээ Монгол Улстай ижил төстэй зохицуулалт бүхий 4 улс байна. Үүнд: Болгар, Финланд, Серби, Чрна Гора /Монтенегро/ зэрэг болно.

Эдгээр 4 улс нь Ром-Германы эрх зүйн бүлд хамаарах бөгөөд Парламентын засагтай, нэг танхимтай байна. Мөн Парламент, Ерөнхийлөгч, Ерөнхий сайдыг сонгодог хэлбэрээр нь авч үзвэл:

- Ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар, 2 үе шаттайгаар сонгодог;
- Парламентыг бүх нийтийн сонгуулиар шууд сонгодог;
- Ерөнхий сайдыг Болгар, Финланд улсуудад олонх болсон нам, эвслээс нэр дэвшүүлж байгаа нь Монгол Улстай ижил төстэй боловч Парламент бус харин Ерөнхийлөгч томилдгоороо ялгаатай байна. Харин Серби, Чрна Гора улсуудад Ерөнхий сайдыг томилохдоо олонх болсон нам, эвслээс бус Ерөнхийлөгч санал болгож, Парламент баталдаг байна.

Хоёрдугаар хэсэгт Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн дангаар болон бусад субьекттэй хамтран хэрэгжүүлдэг бүрэн эрхийг судалгаанд хамруулсан 11 улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй харьцуулсан болно.

Ийнхүү харьцуулахад Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн **бие даан хэрэгжүүлдэг** 13 бүрэн эрх байгаагаас “Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрх” зөвхөн Исланд Улсын Ерөнхийлөгчид байх бөгөөд бусад 10 орны Ерөнхийлөгч нь хууль санаачлах эрхгүй байна. Харин “Уучлал үзүүлэх эрх” нь 11 орны Ерөнхийлөгчид олгогдсоноороо нийтлэг байна. Бусад 11 бүрэн эрхийн хувьд улс орон бүрт харилцан адилгүй байгааг судалгааны үндсэн хэсгээс үзнэ үү.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн **хамтран хэрэгжүүлдэг бүрэн эрхийн** хувьд нийт 8 бүрэн эрх олгогдсон бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд заасан “Өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх...” эрхийг бусад 11 улсад Үндсэн хуулиар зохицуулаагүй байна. Хамтран хэрэгжүүлдэг бусад бүрэн эрхийн хувьд харилцан адилгүй зохицуулалттай байгааг судалгааны үндсэн хэсгээс үзнэ үү.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд харгалзах эрхийг бусад орны холбогдох хууль тогтоомжид хэрхэн тусгасныг эрх тус бүрээр нь харьцуулсныг Хүснэгт 6-аас дэлгэрүүлэн үзнэ үү.


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХЭЛБЭР:
ШИНЖ ЧАНАР, СОНГУУЛИЙН ЗАРЧИМ

Эрдэмтэн судлаачид, олон улсын байгууллага болон улс төрийн шинжлэх ухааны салбар хүрээлэнгүүд нь дэлхийн улс орнуудыг төрийн удирдлагын хэлбэрийнх нь хувьд янз бүрээр ангилан хуваасан байдаг нь судалгааны түвшинд багагүй маргаан дагуулдаг.⁶ Өнөөгийн байдлаар дэлхийн улс орнууд нь төрийн дээд эрх мэдлийг хэн хэрэгжүүлж байгаагаар нь төрийн удирдлагын хэлбэрийг **Бүгд найрамдах** ба **Хаант засагт** гэсэн хоёр үндсэн хэлбэрт хувааж байна.⁷ Үүнээс:

- **Бүгд Найрамдах Улс нь:** ерөнхийлөгчийн, хагас ерөнхийлөгчийн, парламентын;
- **Хаант засаг нь:** хэмжээт эрхт, хэмжээгүй эрхт хаант засагт гэх бөгөөд хэмжээт эрхт хаант засгийг үндсэн хуульт хаант засаг, хоёрдмол шинж бүхий хаант засаг гэж ангилна. Үүнийг зураглан үзүүлбэл:

Схем 1.



Бүгд Найрамдах Улс гэдэг нь ард түмнээс сонгогдсон төлөөлөх эрх бүхий субъект (Парламент, Ерөнхийлөгч) төрийн дээд эрх мэдлийг хэрэгжүүлэхийг ойлгоно. Хаант засаг бүхий улс гэдэг нь төрийн дээд эрх мэдлийг угсаа залгамжилсан хаан хэрэгжүүлдэг төрийн удирдлагын хэлбэр юм.

Хэмжээгүй эрхт хаант засаг нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл нь зөвхөн хааны мэдэлд төвлөрнө. Хэмжээгүй эрхт хаант засаг бүхий оронд ард түмний хүсэл зориг, ашиг сонирхлыг илэрхийлсэн төлөөллийн байгууллага байх боловч тэр нь хэлбэрийн төдий байдаг.

Хэмжээт эрхт хаант засаг нь хааны эрх хэмжээг Үндсэн хуулийн дагуу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлээр хязгаарласан төрийн удирдлагын хэлбэр юм. Хааны эрх хэмжээг Үндсэн хуулиар хязгаарласан байдлыг шалгуур болгон хоёр үндсэн төрөлд ангилж байгаа нь дуалист хаант засаг, парламентын хаант засаг болно.

⁶ Political system, <http://www.britannica.com/topic/political-system> **Country Comparison to the World**. <https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/2128.html> Төр улсуудын засгийн газар. Дэлхийн улс төрийн тогтолцооны гарын авлага. УБ., 2012

⁷ Төрийн онол, Н.Лүндэндорж. УБ., 2008 он, 150 дахь тал

Дуалист буюу хоёрдмол шинж бүхий хаант засаг гэдэг нь хууль тогтоох эрх мэдлийг төлөөллийн байгууллага, гүйцэтгэх эрх мэдлийг хаан хэрэгжүүлдэг төрийн удирдлагын хэлбэрийг хэлнэ.

Үндсэн хуульт буюу парламентын хаант засаг гэдэг нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг төлөөллийн байгууллага хэрэгжүүлдэг төрийн удирдлагын ардчилсан хэлбэр юм. Ийм оронд хаан нь төр ёсны бэлгэдэл, үндэсний эв нэгдлийн илэрхийлэл болдог.

Судалгаанд хамруулсан 188 орныг төрийн удирдлагын хэлбэр, ангилал, төрийн удирдлагын шинж чанарыг шалгуур болгон ангилан хуваасныг Хүснэгт 1-ээр үзүүлэв.

Хүснэгт 1. Дэлхийн улс орнуудын төрийн удирдлагын хэлбэр: ангилал, шинж чанар

Төрийн удирдлагын хэлбэр, ангилал		Голлох шинж чанар	Орнууд
БНУ	Ерөнхийлөгчийн-42 орон	Ийм хэлбэрийн засагтай улсад Ерөнхийлөгч нь нэгэн зэрэг төрийн болон засгийн газрын тэргүүн байдаг. Ихэвчлэн ерөнхий сайдын албан тушаал байдаггүй. Ерөнхийлөгчийн засаглалын нэг онцлог нь Ерөнхийлөгчийг парламентын оролцоогүйгээр сонгож, засгийн газрыг мөн парламентын оролцоогүйгээр Ерөнхийлөгч бүрдүүлдэг. Засгийн газар зөвхөн Ерөнхийлөгчийн өмнө хариуцлага хүлээнэ. Ихэнхдээ Ерөнхийлөгч парламентыг тараах эрхгүй, парламент засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлыг илэрхийлэх эрхгүй, харин парламент импичментын процедураар Ерөнхийлөгчийг огцруулах эрхтэй байдаг.	Ангол, АНУ, Аргентин, Афганистан, Боливи, Бразил, Бурунди, Венесуэль, Гамби, Гана, Гватемал, Гондурас, Доминиканы БНУ, Замби, Зимбабве, Иран, Кени, Колумби, Коморос, Конго, Коста Рика, Куба, Либериа, Малави, Мальдив, Мексик, Мьянмар, Никарагуа, Нигери, Палау, Панам, Парагвай, Сейшелийн Арлууд, Сьерра Леон, Өмнөд Судан, Судан, Туркменистан, Уругвай, Филиппин, Хойд Солонгос, Чили, Эквадор
	Хагас Ерөнхийлөгчийн-49 орон	Ийм хэлбэрийн засагтай улсад ерөнхийлөгч, ерөнхий сайдтай ба ерөнхийлөгч нь гүйцэтгэх эрх мэдлийг бодитоор хэрэгжүүлдэг. Гэхдээ засгийн газрын тэргүүний зарим чиг үүргийг ерөнхий сайд гүйцэтгэдэг. Ерөнхийлөгчийн хүчтэй засаглалын зэрэгцээ парламентын зүгээс гүйцэтгэх эрх мэдлийг хянах үр дүнтэй арга механизмтай (итгэл үзүүлэх эсэх г.м), Ерөнхийлөгч засгийн газрыг заавал парламентын оролцоотой бүрдүүлдэг онцлогтой. Ийнхүү засгийн газар Ерөнхийлөгч, парламентын аль алиных нь өмнө хариуцлага хүлээнэ.	Азербайджан, Алжир, Армян, Беларусь, Бенин, Буркина Фасо, Габон, Гвиней, Йемен, Казахстан, Камерун, Кабо-Верде, Кот д'Ивуар, Мозамбик, Намиби, Нигер, Өмнөд Солонгос, Перу, Руанда, Сальвадор, Танзани, Того, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Уганда, Узбекистан, Экваторын Гвиней, Гайти, Гүрж, Гайана, Гвиней-Бисау, Жибути, Зүүн Тимор, Конго /БНАКУ/, Литва, Мадагаскар, Мали, Мавритани, Орос, Польш, Португал, Румын, Сан-Томе Принсипи, Сири, Сенегал, Тайвань, Тажикистан, Франц, Шри-Ланк, Индонез,

	Парламентын-54 орон	Төрийн эрх барих дээд байгууллага нь парламент бөгөөд засгийн газрыг парламент бүрдүүлж, огцруулна. Засгийн газар нь парламентын өмнө хариуцлага хүлээнэ. Төрийн тэргүүнийг парламентаас эсвэл тусгайлан байгуулсан парламентын коллегияс сонгоно. Ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар сонгодог ч улс орон бий (Австри, Болгар, Монгол). Парламентын засагтай улсын нэг онцлог нь засгийн газар нь парламентын итгэлийг хүлээсэн тохиолдолд л эрх мэдлээ хэрэгжүүлэх боломжтой.	Австри, Бангладеш, Болгар, Босни-Герцеговин, Ботсван, Вануату, Вьетнам, Герман, Грек, Доминика, Ирак, Ирланд, Израиль, Исланд, Итали, Кирибати, Кыргызстан, Лаос, Латви, Ливан, Ливи, Маврикий, Мальт, Македон, Маршаллын Арлууд, Микронез, Молдав, Монгол, Науру, Өмнөд Африк, Пакистан, Сан-Марино, Самоа, Сингапур, Серби, Словак, Словени, Сомали, Суринам, Тринидад Тобаго, Тунис, Турк, Непал, Унгар, Фижи, Финланд, Хорват, Хятад, Чех, Чрна Гора, Швейцар, Энэтхэг, Эстони, Этиоп
Хаант	Үндсэн хуульт буюу парламентын хаант засаг-28 орон	Эдгээр улс орнуудад эзэн хааны эрх зүйн байдал нь хууль эрх зүйн хувьд болон бодит амьдралд хуулиар хязгаарлагдсан байдаг тул төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцох оролцоо бага, зөвхөн ёслол, уламжлалын чиг үүрэгтэй, бэлгэдлийн шинж чанартай байдаг онцлогтой. Хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү парламент, гүйцэтгэх эрх мэдлийг засгийн газар хэрэгжүүлнэ. Засгийн газар парламентын өмнө хариуцлага хүлээнэ. Иймээс үндсэн хуульт хаант засагтай ихэнх улс орон парламентын ардчилалтай оронд тооцогддог.	Андорра, Австрали, Багамын арлууд, Барбадос, Бельги, Белиз, Камбож, Канад, Дани, Гренада, Испани, Их Британи, Лесото, Люксембург, Малайз, Нидерланд, Норвеги, Папуа-Шинэ Гвиней, Сент-Китс ба Невис, Сент Лусиа, Сент-Венсент ба Гренадин, Соломоны арлууд, Тайланд, Тувалу, Шинэ Зеланд, Швед, Япон, Ямайк
	Дуалист буюу Хоёрдмол шинж бүхий-9 орон	Эдгээр улсуудад эзэн хаан нь гүйцэтгэх эрх мэдлийг бүрэн хэрэгжүүлж, зарим хууль тогтоох ба шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцоно. Төлөөллийн байгууллага нь хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлнэ. Гэвч хаан хуульд бүрэн хориг тавих болон өөрийн үзэмжээр төлөөллийн байгууллагыг тараах эрхтэй.	Бахрейн, Бутан, Йордан, Кувейт, Лихтенштейн, Монако, Марокко, Тонга, Арабын Нэгдсэн Эмират Улс
	Хэмжээгүй эрхт-6 орон	Эдгээр улсуудад эзэн хааны эрх мэдлийг ямар нэг хууль эрх зүйн актаар хязгаарлаагүй, засгийн бүх эрх мэдэл хааны гарт байдаг.	Бруней, Ватикан, Оман, Катар, Саудын Араб, Свазиленд

Судалгаанд хамруулсан 188 орны төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүн, хууль тогтоох байгууллагыг сонгох зарчим, түүнчлэн тэдгээр орны ерөнхийлөгчтэй эсэх, парламентын танхимын тоо зэргийг ангилан авч үзсэнийг судалгаанд Хавсралт 1-ээр оруулав. Үүнээс Парламентын Бүгд Найрамдах Улс бүхий 51 орныг сонгон авч, Ерөнхийлөгч болон парламентын сонгуулийн зарчмыг судалгааны хоёрдугаар бүлэгт дэлгэрүүлэн судалсан болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ**ПАРЛАМЕНТЫН БҮГД НАЙРАМДАХ УЛСУУДЫН ЕРӨНХИЙЛӨГЧ БОЛОН
ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙГ СОНГОХ ЗАРЧИМ**

Энэ бүлэгт судалгаанд хамруулсан 188 орноос захиалагчийн хүсэлтийн дагуу төрийн удирдлагын хувьд Парламентын Бүгд Найрамдах, улс төрийн дэглэмийн хувьд ардчилсан дэглэм бүхий 51 орныг сонгон авч Ерөнхийлөгчийн болон парламентын сонгуулийн зарчмыг харьцуулан судалсан болно.

Сонгуулийн эрх зүйн онолын үүднээс авч үзвэл **Шууд сонгууль гэдэг нь** сонгогч саналаа ямар нэг төлөөлөлгүйгээр өөрөө гаргах замаар сонгуульд оролцох үйл явцыг ойлгоно. Харин **Шууд бус сонгууль** гэдэг нь 2 ба түүнээс дээш шат дамжин явуулах сонгуулийг хэлнэ.

Судалгаанаас үзэхэд Ерөнхийлөгчийг сонгохдоо:

- Ерөнхийлөгчийг бүх нийтийн 2 үе шат бүхий сонгуулиар сонгодог 15 улс,
- Ерөнхийлөгчийг Бүх нийтийн энгийн олонхын саналаар сонгодог 4 улс,
- Ерөнхийлөгчийг хууль тогтоох дээд байгууллагаас сонгодог 26 улс,
- Ерөнхийлөгчийг Сонгогчдын коллеги болон Сонгуулийн хорооноос сонгодог 6 улс байна.

Энэ бүлэгт сонгон авсан 51 орноос хууль тогтоох дээд байгууллагыг сонгохдоо 48 улс нь Парламентыг шууд сонгуулиар сонгодог бол Ливи, Доминика болон Сомали зэрэг 3 улсын хувьд шууд бус сонгуулиар сонгодог байна.

Судалгаанаас харахад Вануату, Герман, Итали, Пакистан, Тринидад Тобаго, Энэтхэг зэрэг 6 улс нь Ерөнхийлөгчийг “Сонгогчдын коллеги” болон “Сонгуулийн хороо” гэх бие даасан субъектээс сонгож байна. **Сонгогчдын коллеги** болон **Сонгуулийн хороо** нь Парламентын гишүүн болон орон нутгийн төлөөллөөс бүрдсэн бие даасан байгууллага байна.

Хууль тогтоох дээд байгууллагын хувьд сонгосон 51 орноос 37 нь Парламентын нэг танхимтай бол 14 нь Парламентын хоёр танхимтай улс орнууд байна.

Парламентын 2 танхимтай орны хувьд доод танхимыг **шууд сонгуулиар** сонгодог бол дээд танхимыг **шууд** болон **шууд бус сонгуулиар** сонгож байна. Зарим улс орны хувьд дараах онцлогтой байна. Тухайлбал,

- Ботсван Улсын Парламентын дээд танхимыг үе залгамжлуулан буюу томилдог;
- Герман Улсын Парламентын дээд танхимыг муж улсын төлөөллөөс сонгодог;
- Ирланд Улсын Парламентын дээд танхимыг намаас нэрийн жагсаалтаар томилдог;
- Словени Улсын Парламентын дээд танхимыг сонирхлын бүлгийн төлөөллөөс болон бүх ард нийтээс сонгодог байна.

Энэ бүлэгт судалсан 51 орноос хууль тогтоох дээд байгууллагыг бүх ард нийтээс сонгодоггүй нэг улс байгаа нь Ливи Улс /Парламентын нэг танхимтай/ бөгөөд Парламентыг Төлөөлөгчдийн зөвлөл /*Council of Representatives*/-өөс сонгодог байна.

*Хүснэгт 2. Парламентын Бүгд Найрамдах Улсуудын Ерөнхийлөгч болон
Парламентын сонгуулийн зарчим*

№	Улс	Ерөнхийлөгчийг хэрхэн сонгодог	Парламент /Хууль тогтоох дээд байгууллага/-ыг хэрхэн сонгодог	
			Доод танхим	Дээд танхим
1	Австри	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
2	Бангладеш	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
3	Болгар	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
4	Босни-Герцеговин	Бүх нийтийн сонгуулиар /энгийн олонхын саналаар/ сонгоно.	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
5	Ботсван	Парламентаас сонгоно. /Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна./	Шууд сонгуулиар	Үе залгамжлах болон томилох
6	Вануату	Сонгогчдын коллеги, эсхүл сонгуулийн хорооноос сонгоно.	Шууд сонгуулиар	
7	Герман	Сонгогчдын коллеги, эсхүл сонгуулийн хорооноос сонгоно.	Шууд сонгуулиар	Муж улсын төлөөллөөс
8	Грек	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
9	Доминика	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар болон томилдог	
10	Ирак	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
11	Ирланд	Бүх нийтийн сонгуулиар /энгийн олонхын саналаар/ сонгоно.	Шууд сонгуулиар	Намаас нэрийн жагсаалтаар томилдог
12	Израиль	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
13	Исланд	Бүх нийтийн сонгуулиар /энгийн олонхын саналаар/ сонгоно	Шууд сонгуулиар	
14	Итали	Сонгогчдын коллеги, эсхүл сонгуулийн хорооноос сонгоно.	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
15	Кирибати	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
16	Кыргызстан	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
17	Латви	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
18	Ливан	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
19	Ливи	Парламентаас сонгоно.	Төлөөлөгчдийн зөвлөлөөс сонгоно	
20	Маврикий	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
21	Мальт	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
22	Македон	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
23	Маршаллын Арлууд	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
24	Микронез	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
25	Молдав	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
26	Монгол	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
27	Науру	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	

28	Өмнөд Африк	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
29	Пакистан	Сонгогчдын колледи, эсхүл сонгуулийн хорооноос сонгоно.	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
30	Сан-Марино	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
31	Самоа	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
32	Сингапур	Бүх нийтийн сонгуулиар /энгийн олонхын саналаар/ сонгоно.	Шууд сонгуулиар	
33	Серби	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
34	Словак	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
35	Словени	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	Сонирхлын бүлгийн төлөөллөөс
36	Сомали	Парламентаас сонгоно.	Шилжилтийн тогтолцоотой байгаа	
37	Суринам	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
38	Тринидад Тобаго	Сонгогчдын колледи, эсхүл сонгуулийн хорооноос сонгоно.	Шууд сонгуулиар	Томилдог
39	Тунис	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
40	Турк	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
41	Непал	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
42	Унгар	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
43	Фижи	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
44	Финланд	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
45	Хорват	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
46	Чех	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
47	Чрна Гора	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
48	Швейцар	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
49	Энэтхэг	Сонгогчдын колледи, эсхүл сонгуулийн хорооноос сонгоно.	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
50	Эстони	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
51	Этиоп	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар

Эдгээр 51 орноос эрх зүйн бүл, төрийн удирдлагын хэлбэр, парламентын танхимын тоо, Ерөнхийлөгч болон хууль тогтоох дээд байгууллагыг сонгох зарчим зэргийг харгалзан үзэж Болгар, Финланд, Серби, Чрна Гора, Хорват, Исланд, Сингапур, Словак, Турк, Македон, Кыргызстан зэрэг 11 улсыг сонгон Монгол Улсын холбогдох эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалсныг гуравдугаар бүлэгт нарийвчлан оруулсан болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХ, ЕРӨНХИЙЛӨГЧ БОЛОН
ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮНИЙГ СОНГОХ ЖУРМЫГ ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Энэхүү бүлэг нь сонгон авсан 11 орны Ерөнхийлөгч болон Засгийн газрын тэргүүнийг сонгох журам болон Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Монгол Улсын холбогдох эрх зүйн зохицуулалттай харьцуулсан харьцуулалт зэрэг үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

- Нэгдүгээр хэсэгт Ерөнхийлөгч болон Засгийн газрын тэргүүнийг сонгохтой холбоотой эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжоос түүвэрлэн авсныг Хүснэгт 3-аар нарийвчлан үзүүлэв.
- Хоёрдугаар хэсэгт Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн дангаар болон бусад субьекттэй хамтран хэрэгжүүлдэг бүрэн эрхийг сонгон авсан 11 улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй харьцуулсныг Хүснэгт 4, Хүснэгт 5-аар тоймлон харуулав.

Мөн түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зарим орны хууль тогтоомжид тусгасан байдлыг Хүснэгт 6-аар үзүүлэв.

НЭГ. ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮНИЙГ СОНГОХ ЖУРАМ

Судалгаанд хамрагдсан орнуудын Ерөнхийлөгчийг сонгох болон чөлөөлөх хэлбэр, бүрэн эрх, Засгийн газрын тэргүүнийг сонгох, чөлөөлөх хэлбэрийг нарийвчлан авч үзвэл дараах байдалтай байна.

1/ Болгар

Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох:

Үндсэн хуулийн 99 дүгээр зүйлд зааснаар Ерөнхийлөгч парламент дахь бүлгүүдтэй зөвшилцсөний дараа хамгийн олон гишүүнтэй парламентын бүлгээс дэвшүүлсэн ерөнхий сайдад нэр дэвшигчид засгийн газрыг бүрдүүлэх үүрэг өгнө. Хэрэв энэ нэр дэвшигч нь 7 хоногийн хугацаанд Сайд нарын зөвлөлийн бүрэлдэхүүнийг санал болгож чадаагүй бол парламентын хоёр дахь олон гишүүнтэй бүлгийн нэр дэвшигчид засгийн газрыг бүрдүүлэх үүрэг өгнө.

Хэрэв Сайд нарын зөвлөлийг бүрдүүлэх даалгавар хэрэгжвэл Ерөнхийлөгч Ардын Хуралд хандан ерөнхий сайдад нэр дэвшигчийг санал болгоно.

Үндсэн хуулийн 84 дүгээр зүйлд зааснаар Ардын Хурал ерөнхий сайдыг томилж, чөлөөлнө. Ерөнхий сайдын санал болгосноор Сайд нарын зөвлөлийн гишүүдийг томилж, чөлөөлнө. Мөн ерөнхий сайдын санал болгосноор засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулна.

2/ Финланд

Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох.

Үндсэн хуулийн 61 дүгээр зүйлд зааснаар ерөнхий сайдыг сонгохын өмнө Эдускунта /цаашид Парламент гэх/ дахь намын бүлгийн төлөөлөгчид нэр дэвшигчдийн Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон бүрэлдэхүүнтэй танилцсан дүнгээ Ерөнхийлөгчид мэдээлж, ерөнхий сайдад нэр дэвшигчийг Парламентад санал болгохыг хүснэ.

Хэрэв нэр дэвшигч Парламентын ил санал хураалтаар олонхын санал авч чадвал ерөнхий сайдаар сонгогдсонд тооцно. Үүний дараа Үндсэн хуулийн 58 дугаар зүйлд зааснаар Ерөнхийлөгч нь ерөнхий сайдыг албан үүргээ гүйцэтгэхээр томилно. /Финландын 2000 онд батлагдсан Үндсэн хуулиар энэхүү эрх орсон/.

Бусад сайд нарыг ерөнхий сайдын санал болгосноор Ерөнхийлөгч томилно.

Хэрэв засгийн газрын бүрэлдэхүүнд томоохон өөрчлөлт оруулах бол Парламентад танилцуулна.

3/ Серб

Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох.

Үндсэн хуулийн Ерөнхийлөгчийн эрх мэдлийн тухай 112 дугаар зүйл болон Засгийн газрыг сонгох тухай 127 дугаар зүйлд зааснаар Ерөнхийлөгч парламентад сонгогдсон сонгогчдын жагсаалтуудын төлөөллийн саналыг авч үзсэний үндсэн дээр ерөнхий сайдад нэр дэвшигчийг Үндэсний ассамблейд санал болгоно.

Ерөнхий сайдад нэр дэвшигч Үндэсний Ассамблейд Засгийн газрын мөрийн хөтөлбөрөө танилцуулж, засгийн газрын бүрэлдэхүүнээ санал болгоно.

Үндэсний Ассамблей Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг дэмжих эсэх, ерөнхий сайдыг сонгох, Засгийн газрын гишүүдийг сонгох гэсэн дарааллаар санал хураалт явуулж, нийт гишүүдийн олонхын саналаар засгийн газрын гишүүдийг сонгоно.

4/ Чрна Гора

Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох.

Үндсэн хуулийн 95 дугаар зүйлд зааснаар Ерөнхийлөгч парламент сонгогдсоноос хойш 30 хоногийн дотор парламентад төлөөлөл бүхий улс төрийн намуудын төлөөлөгчид, Үндсэн хуулийн шүүхийн дарга болон шүүгчид, Хүний эрх, эрх чөлөөний хамгаалагчтай зөвлөлдсөний үндсэн дээр парламентад ерөнхий сайдад нэр дэвшигчийг танилцуулна.

Үндсэн хуулийн 103 дугаар зүйлд зааснаар Ерөнхий сайдад нэр дэвшигч нь Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон бүрэлдэхүүнээ танилцуулж, парламент мөрийн хөтөлбөр болон засгийн газрын бүтцийг нэгэн зэрэг шийднэ.

Үндсэн хуулийн 82 болон 91 дүгээр зүйлүүдэд зааснаар парламент нийт гишүүдийнхээ талаас илүүгийн саналаар ерөнхий сайд ба засгийн газрын гишүүдийг сонгоно.

5/ Хорват

Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох.

Үндсэн хуулийн 98 дугаар зүйлд Ерөнхийлөгч нь намуудын Парламентад авсан суудлын тоог харгалзан парламентын гишүүдийн олонхын итгэлийг хүлээсэн Ерөнхий сайдад нэр дэвшигчид Засгийн газар байгуулах эрх олгоно.

Мөн хуулийн 110-р зүйлд Засгийн газрыг бүрдүүлэх эрх олгогдсоноос хойш 30 хоногийн дотор Ерөнхий сайд танхимаа бүрдүүлж, мөрийн хөтөлбөрөө Парламентад танилцуулна. Парламентын нийт гишүүдийн олонхын саналаар Ерөнхий сайд болон Засгийн газарт итгэл үзүүлэхийг дэмжвэл Засгийн газрын бүрэн эрх хэрэгжиж эхлэх бөгөөд Ерөнхийлөгч Парламентын гаргасан шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайдыг томилж, Парламентын дарга давхар гарын үсэг зурна. Засгийн газрын бүрэлдэхүүнийг Ерөнхий сайд томилох бөгөөд Парламентын дарга давхар гарын үсэг зурж баталгаажуулна.

6/ Исланд

Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох.

Исландын Үндсэн хуулийн 15-р зүйлд Ерөнхийлөгч нь сайд нарыг томилж, чөлөөлнө. Ерөнхийлөгч нь засгийн газрын бүрдүүлэх сайд нарын болон эрх үүргийг тогтоож, хариуцлага хүлээлгэнэ.

7/ Сингапур

Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох.

Үндсэн хуулийн 25-р зүйлд Сингапурын Ерөнхийлөгч Парламентын гишүүдийн олонхын итгэлийг хүлээх чадвартай гэж үзсэн Парламентын гишүүнийг Ерөнхий сайдаар томилох бөгөөд Ерөнхий сайдын зөвлөснөөр Парламентын гишүүд дундаас Засгийн газрыг бүрдүүлэх сайд нарыг томилно.

Мөн хуулийн 26-р зүйлд Ерөнхий сайд нь Ерөнхийлөгчид огцрох тухай өргөдлөө бичгээр гаргасан, эсхүл Ерөнхийлөгч нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд Ерөнхий сайдыг Парламентын олонхын итгэлийн хүлээхгүй байна гэж үзсэн тохиолдолд Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг огцруулна. Харин бусад сайд нарын хувьд Ерөнхий сайдын зөвлөсний дагуу сайдыг тухайн албан тушаалаас нь албан ёсоор огцруулах тухай шийдвэрийг Ерөнхийлөгч гаргана.

8/ Словак

Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох.

Үндсэн хуулийн 110-р зүйлд зааснаар Словак улсын Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдыг томилж, чөлөөлнө. 111-р зүйлд зааснаар Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын санал болгосноор Ерөнхийлөгч томилж, чөлөөлөх эрхтэй болно. Словак улсын Үндэсний зөвлөлөөс Ерөнхий сайдад итгэл үл үзүүлэх санал гарган баталсан тохиолдолд Словак улсын Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг эгүүлэн татна. Ерөнхий сайдыг эгүүлэн татах нь Засгийн газрыг татан буулгаж буй хэрэг мөн.

9/ Турк

Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох.

Үндсэн хуулийн 109-р зүйлд зааснаар Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдыг Үндэсний Их хурлын гишүүд дундаас томилно. Ерөнхий сайд нь Засгийн газрыг сайд нарыг Үндэсний Их хурлын гишүүд дундаас, эсхүл Үндэсний Их хурлын гишүүнд тавигдах шаардлагыг хангасан этгээдийг томилох бөгөөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын санал болгосны дагуу үүрэгт ажлаас нь чөлөөлж болно.

10/ Македон

Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох.

Үндсэн хуулийн 90-р зүйлд заасны дагуу Парламент нь Ерөнхий сайдыг томилохоос өмнө хурлаараа Засгийн газрын бүтэц зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэнэ. Ийнхүү шийдвэр гарсанаас хойш 10 хоногт багтааж Ерөнхийлөгч нь Засгийн газрыг байгуулах эрхийг Парламентад олонх болсон нам эвсэлд, эсхүл нам эвслийн санал болгосон Ерөнхий сайдад нэр дэвшигчид олгоно.

11/ Кыргызстан

Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох.

Үндсэн хуулийн 84-р зүйлд заасны дагуу Жогорку Кенешт талаас илүү суудал авсан бүлэг, эсвэл эвслийн бүлэг нь анхны хуралдаанаас хойш 15 хоногийн дотор Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ. Ерөнхий сайдад нэр дэвшигч Засгийн газрын хөтөлбөр, бүтэц, бүрэлдэхүүнийг Жогорку Кенешт санал болгоно. Хэрэв Жогорку Кенеш нь Засгийн газрыг хугацаандаа баталж чадаагүй бол, эсвэл сонгуулийн дүнд аль ч улс төрийн нам талаас илүү тооны суудал аваагүй бол Ерөнхийлөгч намын бүлгүүдийн аль нэгэнд 15 хоногийн дотор олонхоо бүрдүүлж, Ерөнхий сайдад нэр дэвшүүлэхийг санал болгоно. Хугацаандаа баталж чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дараагийн намын бүлэгт санал болгоно. Хэрэв хуульд хугацаандаа баталж чадаагүй бол намын бүлгүүд өөрсдийн санаачилгаар 15 хоногийн дотор олонхоо бүрдүүлж, Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ.

Ерөнхийлөгч Ерөнхий сайд болон Засгийн газрын бусад гишүүдийг томилох шийдвэрийг 3 хоногт гаргана. Хэрэв хугацаандаа томилж чадаагүй бол нэр дэвшигчдийг томилогдсон гэж үзнэ.

Хүснэгт 3. Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдыг сонгох журам

1. Монгол Улс

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцруулах /чөлөөлөх субъект
Ерөнхийлөгч	31.1. Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна. 31.3. Анхан шатны сонгуульд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаар саналаа нууцаар гаргана. 31.4 Ерөнхийлөгч анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхын санал авсан нэр дэвшигчийг УИХ Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана. 31.5. Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхын санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна. Дахин санал хураалтаар сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхын санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана. 6. Хэрэв хоёр дахь санал хураалтаар Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхын санал аваагүй бол дахин сонгууль явуулна.	31.2. Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлнэ.	25.1.Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: 5/ Ерөнхийлөгчийг сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргах, чөлөөлөх, огцруулах; 31.4.Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхын санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана.	35.2.Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчөөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхын саналаар огцруулна.
Ерөнхий сайд		33.1.2/ Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг, хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхоороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах.	25.1.Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: 6/ Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах;	

2. Болгар Улс

Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгчтэй байна	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцруулах /чөлөөлөх субъект
	93.3. Ерөнхийлөгчийн сонгууль нь нийт сонгогчдын талаас илүү хувь нь оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд талаас илүү хүчинтэй саналыг авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно. 93.4. Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн аль нь ч олонхын санал аваагүй бол саналаараа тэргүүлсэн хоёр нэр дэвшигч дээр долоо хоногийн дотор дахин санал хураана.	Сонгуулийн тухай хуулийн 6-р зүйл 1/ Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгчид улс төрийн нам, эвслээс болон бие даагчдын үндэсний нэрсийн жагсаалтаас нэр дэвшүүлнэ.	96. Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгч нь энэхүү Үндсэн хуулийн 76.2-т заасан тангаргийг Ардын Хурлын өмнө өргөснөөр эрх мэдлээ хэрэгжүүлж эхэлнэ.	103.1 Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгч нь Үндсэн хууль зөрчих, эх орноосоо урваснаас бусад тохиолдолд өөрсдийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор хийсэн үйлдэлдээ хуулийн хармуцлага хүлээхгүй. 103.2. Ардын Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүйн саналаар Ерөнхийлөгчийг буруутгах асуудлыг хэлэлцэх бөгөөд нийт гишүүдийн гуравны хоёр нь дэмжсэн бол түүний буруутайг хэмээн үзнэ. 103.3. Үндсэн хуулийн шүүх Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгчийн эсрэг мэдүүлгийг гарснаас хойш сарын дотор шийдвэрлэнэ. Үндсэн хуулийн шүүхээр Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгчийг эх орноосоо урвасан, эсхүл Үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдовол Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгчийн бүрэн эрх дуусгавар болно.
Ерөнхий сайд		99-р зүйл 1/Ардын Хурлын бүлгүүдтэй зөвшилцөн, хамгийн олон санал авсан бүлгээс Ерөнхий сайдад нэр дэвшигчид Засгийн газрыг бүрдүүлэхийг үүрэг болгоно. 2/ Нэр дэвшигч сайд нарын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 7 өдрийн дотор бүрдүүлж чадаагүй бол Ерөнхийлөгч хоёр дахь бүлгээс нэр дэвшсэн хүнд үүрэг өгнө. 3/ Хоёр дахь нэр дэвшигч өмнөх хэсэгт заасан тогтоосон хугацаанд Засгийн газрыг бүрдүүлж чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дараагийн бүлэгт Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх үүрэг өгнө. 4/ Хэрэв сайд нарын зөвлөлийг амжилттай бүрдүүлбэл нэр дэвшигчийг Ерөнхий сайд болгох саналыг Ардын Хуралд оруулна. 5/ Хэрэв Засгийн газрыг бүрдүүлэх талаар зөвшилцөлд хүрч чадаагүй бол Ерөнхийлөгч Ардын Хурлыг тарааж, сонгуулийг товлж, түр Засгийн газрыг томилоно. Ардын Хурлыг тараасан Ерөнхийлөгчийн актаар шинэ сонгуулийн хугацаа тодорхойлогдоно.	84-р зүйл Ардын Хурал нь : 6/ Ерөнхий сайдыг сонгож, огцруулах; Ерөнхий саналаар Сайд нарын зөвлөлийн гишүүдийг томилж, чөлөөлөх; Ерөнхий сайдын саналаар Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;	89-р зүйл 1.Ардын Хурлын гишүүдийн тавны нэгээс доошгүй гишүүд Засгийн газарт итгэл үл үзүүлэх тухай санал гаргавал Ардын Хурал санал хураалт явуулна.Ардын Хурлын нийт гишүүдийн дийлэнх олонх нь дэмжсэн тохиолдолд тэдний саналыг хүчинтэйд тооцно. 2. Ардын Хурал Ерөнхий сайд, Засгийн газарт үл итгэх шийдвэр гаргавал Ерөнхий сайд Засгийн газрыг огцруулах тухай өргөдлөө гаргана. 3. Ардын Хурал Засгийн газарт итгэл үзүүлэхээр шийдвэрлэсэн бол уг үндэслэлээр Засгийн газарт итгэл үл үзүүлэх асуудлыг дараагийн 6 сард дахин тавихгүй.

3. Финланд

Ерөнхийлөгч	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцуулах /чөлөөлөх субъект
	54-р зүйл Бүгд Найрамдах Ерөнхийлөгчийг бүх нийтийн шууд сонгуулиар 6 жилийн хугацаагаар сонгоно. Сонгуульд талаас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгоно. Аль нэг нэр дэвшигч нь олонхын саналыг авч чадаагүй бол хамгийн их санал авсан 2 нэр дэвшигчийн хооронд шинэ сонгууль явуулна. Шинэ шатны сонгуулиар хамгийн их санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгоно. Зөвхөн нэг нэр дэвшигчтэй бол түүнийг сонгууль явуулахгүйгээр Ерөнхийлөгчөөр томилно.	54-р зүйл Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх эрхийг Парламентад доод тал нь нэг суудал авсан улс төрийн намд олгох ба үүнээс гадна санал өгөх эрх бүхий 20000 иргэний бүлэг нэр дэвшүүлэх эрх эдэлнэ.	55-р зүйл Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа албан тооцогдсоны дараа сарын эхний өдөр эхэлнэ.	55-р зүйл Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа шинээр сонгогдсон Ерөнхийлөгч албан тушаалдаа сонгогдсоноор дуусгавар болно. Ерөнхийлөгч нас барсан, эсхүл Засгийн газар нь Ерөнхийлөгч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадамжгүй гэж үзсэн тохиолдолд шинэ Ерөнхийлөгчийг аль болох түргэн сонгоно.
Ерөнхий сайд		61-р зүйл. Засгийн газрыг бүрдүүлэх Ерөнхий сайдыг сонгохоос өмнө Парламентад төлөөлөл бүхий бүлгүүд Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг хэлэлцэнэ. Хэлэлцээг үндэслэн, Парламентын спикер болон парламентын бүлгүүдийн саналыг сонссоны үндсэн дээр Ерөнхийлөгч Парламентад Ерөнхий сайдад нэр дэвшигчийг танилцуулна. Нэр дэвшигч нь хангалттай санал аваагүй тохиолдолд, мөн адил журмын дагуу өөр нэр дэвшигчийг дэвшүүлнэ. Хоёр дахь нэр дэвшигч талаас дээш хувийн санал авч чадаагүй тохиолдолд, Ерөнхий сайдын сонгуулийг Парламентын нээлттэй санал хураалтаар явуулна. Ингэсэн тохиолдолд хамгийн их санал авсан этгээдийг Ерөнхий сайдаар сонгоно.	61-р зүйл. П а р л а м е н т Ерөнхий сайдыг сонгох бөгөөд Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч тухайн албан тушаалд томилно. Нэр дэвшигчийг Парламентын нийт гишүүдийн талаас дээш хувь нээлттэй санал хураалтаар дэмжсэнээр Ерөнхий сайдаар сонгоно. /финландын 2000 онд батлагдсан Үндсэн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон ⁶ .	64-р зүйл Засгийн газар, эсхүл сайдыг огцуулах Бүгд Найрамдах улсын Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд болон сайд нараас үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээж авч шийдвэрлэнэ. Мөн Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын хүсэлтээр сайд нарыг үүрэгт ажлаас нь чөлөөлнө. Хэрвээ Засгийн газар эсхүл сайд нь Парламентын итгэлийг хүлээгээгүй тохиолдолд хүсэлт гаргасан эсэхийг үл харгалзан Ерөнхийлөгч Засгийн газар эсхүл сайдыг огцуулна. Сайд нь Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, эсхүл Парламентын спикерээр сонгогдсон бол түүнийг сонгууль явагдсан өдөр сайдын албан үүргээсээ огцорсонд тооцно.

⁶ <http://www.aspg.co/sites/default/files/documents/NJTCYJXYUTISQLTGTTUWLCDXVPERCE.pdf> Өмнө нь Засгийн газрыг Ерөнхийлөгч шууд томилдог байсныг 2000 оны Үндсэн хуулиар Парламентын ил санал хураалтаар сонгодог болсон.

4. Серб

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцруулах /чөлөөлөх субъект
Ерөнхийлөгч	114-р зүйл. Сонгууль Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийг хуульд заасны дагуу шууд, нууц санал хураалтаар сонгоно.	9-р зүйл. Ерөнхийлөгчид улс төрийн нам, эвсэл, эсхүл иргэний бүлгээс нэр дэвшүүлэх эрхтэй байна. 10-р зүйл. Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг дэмжиж доод тал нь 10000 гарын үсэг зурж шүүхээр баталгаажуулснаар дэвшүүлнэ.		117-р зүйл Ерөнхийлөгч нь өөрийн хүсэлтээр огцрох хүсэлтээ ард нийтэд болон Парламентын даргад мэдэгдэнэ. 116-р зүйл Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь огцрох өргөдлөө Парламентын даргад гаргана. 118-р зүйл Парламентын гишүүдийн 2/3-аас доошгүй саналаар Ерөнхийлөгчийг Үндсэн хуулийг зөрчсөн тухай үндэслэлээр огцруулна. Ерөнхийлөгчийг огцруулах тухай асуудлыг Парламентын гишүүдийн 2/3-аас доошгүй саналаар гаргаж болно.
Ерөнхий сайд		127-р зүйл Ерөнхийлөгч нь нэр дэвшигчдийн жагсаалтад төлөөлөгчдийн өгсөн саналыг харгалзан үзсэний үндсэн дээр Үндэсний Ассамблейд Ерөнхий сайдыг нэр дэвшүүлнэ.	127-р зүйл Ерөнхий сайдад нэр дэвшигч нь Үндэсний Ассамблейд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг танилцуулна. Үндэсний Ассамблей нь Ерөнхий сайд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг хамтад нь сонгоно. Засгийн газрыг Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн олонхын саналаар томилно.	133-р зүйл Засгийн газрын гишүүн нь огцрох тухай өргөдлөө Ерөнхий сайдад өргөн барьж болно. Ерөнхий сайд нь сайдын огцрох тухай хүсэлтийг Үндэсний Ассамблейн даргад өргөн барих ба хамгийн ойрын хуралдах Үндэсний Ассамблейн хуралдаанаар хэлэлцэнэ. Ерөнхий сайд нь Засгийн газрын гишүүнийг албан тушаалаас нь огцруулах тухай хүсэлтийг Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлэх ба огцруулах тухай асуудлыг дараагийн хуралдаанаар хэлэлцэж, нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

5. Чрна Гора

Ерөнхийлөгч	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцруулах /чөлөөлөх субъект
	<p>96-р зүйл. Сонгууль Чрна Гора улсын Ерөнхийлөгчийг нийтийн сонгуулиар шууд, нууц санал хураалтаар сонгоно.</p> <p>Сүүлийн 15 жилийн дотор доод тал нь 10 жил Чрна Гора улсад оршин сууж буй Чрна Гора улсын иргэнийг Ерөнхийлөгчөөр сонгож болно.</p> <p>Парламентын спикер нь Ерөнхийлөгчийн сонгуулийг зарлана.</p>	<p>Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль 2007 4-р зүйл.</p> <p>Ерөнхийлөгчид улс төрийн нам, эсхүл нийт сонгогчдын 1.5%-тай тэнцэх иргэний гарын үсэг зурсныг үндэслэн бүлэг хүмүүс нэр дэвшүүлж болно. Нэг нам, эсхүл иргэний бүлэг нь нэг л нэр дэвшигчийг дэвшүүлэх эрх эдэлнэ. Хоёр буюу түүнээс дээш улс төрийн нам нь хамтран нэр дэвшүүлж болно.</p>	<p>Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль 2007 17-р зүйл</p> <p>Чрна Гора улсын Ерөнхийлөгчийг сонгогчдын талаас дээш хувийн санал дэвшигч хангалттай санал авч чадаагүй нөхцөлд, 14 хоногийн дараа хоёр дахь шатны сонгуулийг хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн хооронд явуулна. Хоёр дахь шатны сонгуулиар хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгоно.</p>	<p>98-р зүйл. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох</p> <p>Ерөнхийлөгчийг бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон, эсхүл бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсны улмаас огцрох өргөдлөө өгсөн, эсхүл импичментээр огцруулна.</p> <p>Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийг зөрчсөний төлөө хариуцлага хүлээнэ.</p> <p>Парламент нь Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг тогтоход 25-аас доошгүй Парламентын гишүүдийн саналаар хэлэлцэнэ.</p> <p>Үндсэн хуулийн шүүх нь Ерөнхийлөгчийг Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг тогтоож, шийдвэрээ Парламент болон Ерөнхийлөгчид нэн даруй танилцуулна.</p> <p>Үндсэн хуулийг зөрчсөн нь тогтоодсон тохиолдолд Парламент Ерөнхийлөгчийн огцруулна.</p>
Ерөнхий сайд		<p>103-р зүйл. Сонгууль Чрна Гора улсын Ерөнхийлөгч нь Парламентыг сонгогдсоноос хойш 30 хоногийн дотор нэр дэвшигчийг санал болгоно.</p> <p>Ерөнхий сайдад нэр дэвшигч нь Парламентад мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг танилцуулна.</p> <p>Парламент нь нэгэн зэрэг нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг шийдвэрлэнэ.</p>		<p>105-р зүйл. Засгийн газрыг огцруулах болон импичмент Засгийн газар болон засгийн газрын гишүүн нь үүрэгт ажлаасаа огцорч болно.</p> <p>Ерөнхий сайд огцорсноор Засгийн газрыг огцорсонд тооцно.</p> <p>Ерөнхий сайд Парламентад Засгийн газрын гишүүнийг огцруулах хүсэлт тавьж болно.</p> <p>107-р зүйл. Итгэл үл үзүүлэх.</p> <p>Парламент нь засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал хураалт явуулж болно.</p> <p>Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлыг доод тал нь 27 парламентын гишүүний саналаар гаргана.</p> <p>Хэрэв Парламент нь Засгийн газарт итгэл үзүүлсэн тохиолдолд, санал гаргасан гишүүд 90 хоногийн дотор дахин итгэл үзүүлэх эсэх талаар санал оруулах эрхгүй байна.</p>

6. Хореат

Ерөнхийлөгч	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцруулах /чөлөөлөх субъект
Ерөнхийлөгч	95-р зүйл. Ерөнхийлөгч нь 5 жилийн хугацаагаар бүх нийтийн шууд сонгуулийн үндсэн дээр нууц санал хураалтаар сонгогдоно. Сонгогчдын олонхын санал авсан нэр дэвшигч Ерөнхийлөгчөөр сонгогдоно. Хэн ч олонхын санал аваагүй тохиолдолд сонгуулийг 14 хоногийн дараа дахин явуулна. Эхний сонгуулиар хамгийн их санал авсан 2 нэр дэвшигч дараагийн сонгуульд оролцох эрхтэй.	Хорват Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль. 7-р зүйл. Бүгд Найрамдах Хорват Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь Хорват улсад бүртгэлтэй улс төрийн нам болон бие даагч нэр дэвшигч байна. 2 болон түүнээс дээш улс төрийн нам 1 нэр дэвшигчдийг дэвшүүлж болно. 8-р зүйл. Бүгд Найрамдах Хорват Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь сонгогчдоос наад зах нь 10000 гарын үсэг цуглуулж байж нэр дэвших эрхтэй болно.	Хорват Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль. 49-р зүйл. Бүгд Найрамдах Хорват Улсын Ерөнхийлөгч нь ажил үүргээ хүлээн авсан өдрөө Хорватын Үндсэн хуулийн шүүхийн өмнө тангараг өргөснөөр бүрэн эрх нь хэрэгжиж эхэлнэ.	105-р зүйл. Бүгд Найрамдах Хорват Улсын Ерөнхийлөгчийг үүргээ гүйцэтгэж байхдаа Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзвэл Парламентын гишүүдийн 2/3-ийн саналаар огцруулах саналыг Үндсэн хуулийн шүүхэд оруулна. Үндсэн хуулийн шүүх нийт шүүгчдийн 2/3-ийн саналаар Бүгд Найрамдах Хорват Улсын Ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ. Хэрвээ Үндсэн хуулийн шүүх Ерөнхийлөгчийг үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл Ерөнхийлөгч албан үүргээсээ чөлөөлөгдөнө.
Ерөнхий сайд		98-р зүйл. 3/ Ерөнхийлөгч нь намуудын Парламентад авсан суудлын тоог харгалзан парламентын гишүүдийн олонхын итгэлийг хүлээсэн Ерөнхий сайдад нэр дэвшигчид Засгийн газар байгуулах эрх олгоно.	110-р зүйл. Ерөнхийлөгчөөс Засгийн газрыг бүрдүүлэх эрх олгосон нэр дэвшигч нь Засгийн газрын гишүүдийн нэрийг дэвшүүлнэ. Засгийн газрыг бүрдүүлмэгц, эсвэл Засгийн газрыг бүрдүүлэх эрх олгогдоноос хойш 30 хоногийн дотор Ерөнхий сайд танхимаа бүрдүүлж, мөрийн хөтөлбөрөө Парламентад танилцуулж, итгэл үзүүлэх эсэх асуудлыг Парламентад оруулна. Парламентын нийт гишүүдийн олонхын саналаар Ерөнхий сайд болон Засгийн газарт итгэл үзүүлэхийг дэмжвэл Засгийн газрын бүрэн эрх хэрэгжиж эхэлнэ. Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлаар Парламентын гаргасан шийдвэрийг үндэслэн Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг томилж, Парламентын дарга давахар гарын үсэг зурна. Ерөнхий сайд Засгийн газрын гишүүдийг томилох шийдвэрийг гаргаж, парламентын дарга давахар гарын үсэг зурж баталгаажуулна. Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүд Парламентад тангараг өргөнө.	116-р зүйл. Ерөнхий сайд, Засгийн газар, Засгийн газрын гишүүдийг огцруулах асуудлыг Парламентын гишүүдийн 1/5 саналаар оруулж парламент дэмжвэл Засгийн газар огцроно. Парламент дээрх асуудлыг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ. Засгийн газрыг огцруулах асуудлыг парламентын гишүүдийн олонх дэмжээгүй бол дээрх асуудлаар 6 сарын дотор дахин авч хэлэлцэхгүй.

			111-р зүйл. Засгийн газрыг байгуулах эрх олгогдсоноос хойш 30 хоногийн дотор Засгийн газрыг бүрдүүлж чадаагүй, эсхүл Парламентгаас Засгийн газарт итгэл үзүүлэх боломжгүй гэж үзвэл Ерөнхийлөгч Засгийн газрыг бүрдүүлэх хугацааг 30 хүртэлх хоногоор сунгаж болно. Энэ хугацаанд бүрдүүлж чадаагүй бол Ерөнхийлөгч Засгийн газрыг байгуулах эрх бүхий этгээдэд өөр нэр дэвшигчийг нэр дэвшүүлнэ.		
7. Исланд					
Ерөнхийлөгч	2-р зүйл. Ерөнхийлөгч нь бүх ард түмнээс сонгогдоно. 5-р зүйл. Ерөнхийлөгч болон Улсын Их Хурал нь бүх нийтийн, шууд санал хураалтаар сонгогдоно. Хэрэв олон нэр дэвшигч өрсөлдөж байгаа тохиолдолд олонхын санал авсан нэр дэвшигч, нэг нэр дэвшигч дэвшсэн бол түүнийг санал хураалтгүйгээр сонгоно.	Нэр дэвшүүлэх	5-р зүйл. Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь 1500-с багагүй, 3000-с ихгүй сонгогчдын дэмжлэг авснаар нэр дэвшинэ. Хэрэв олон нэр дэвшигч өрсөлдөж байгаа тохиолдолд олонхын санал авсан нэр дэвшигч, нэг нэр дэвшигч нэр дэвшсэн тохиолдолд түүнийг санал хураалтгүйгээр сонгогдсонд тооцно.	Томилдог /Баталдаг субъект	Огцируулах /чөлөөлөх субъект
Ерөнхий сайд				15-р зүйл. Ерөнхийлөгч нь сайд нарыг томилж, чөлөөлнө. Сайдын тоо болон эрх үүргийг тогтоож, хариуцлага хүлээлгэнэ.	

8. Сингапур

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцруулах /чөлөөлөх субъект
Ерөнхийлөгч	<p>20-р зүйл.</p> <p>1.Бүх нийтийн шууд сонгуулиар 6 жилээр сонгодог.</p> <p>Ерөнхий сайд нь Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх товыг зарлана, Нэр дэвшүүлэх өдөр зөвхөн нэг нэр дэвшигч материалгаа ирүүлсэн бол, түүнийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон оор зарлана. Нэгээс дээш нэр дэвшигч байгаа тохиолдолд сонгууль зарлаж сонгуулиар хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгоно.</p>	<p>19-р зүйл.</p> <p>Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь дараах болзлыг хангасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Сингапур Улсын иргэн байх • 45-с дээш насны сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгүүлсэн байх, • Сингапур улсад нийтдээ 10-с доошгүй жил оршин суусан байх • 45-р зүйлд заасан нөхцөлийг хангаагүй байх /Ерөнхийлөгчийн албан тушаалд харшлах нөхцөлд/ • Сонгуулийн хорооноос тавигдах ёс зүйн болзлыг хангасан байх • Нэр дэвших үедээ аль нэг намыг гишүүн бус байна • 3 жилээс дээш хугацаагаар дараах албан тушаалыг хашсан байх /Сайд, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Спикер, Ерөнхий прокурор, Нийтийн албаны комиссын дарга, Ерөнхий аудитор, Ерөнхий нягтлан бодогч эсхүл ТБНД, 22А-д заасан төрийн зөвлөлийн дарга, эсхүл ерөнхий захирал, 100 сая ам.доллаараас дээш хөрөнгө бүхий компанийн ТУЗ-ын дарга, эсхүл ерөнхий захирал, эсхүл дээрхтэй төстэй төрийн эсхүл хувийн байгууллагад, дээрхтэй төстэй албан тушаал эрхэлж байсан • Ерөнхийлөгчийн үүргийг гүйцэтгэхэд шаардагдах санхүүтэй холбоотой асуудлыг удирдаж, зохион байгуулах туршлагатай байх 	<p>20-р зүйл</p> <p>Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа нь албан үүргээ хүлээн авснаас хойш 6 жил байна.</p> <p>Шинээр сонгогдсон Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа нь өмнөх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан, эсхүл Ерөнхийлөгчийн албан тушаал эзгүй байгаа тохиолдолд сонгууль явагдсаны дараачийн өдөр эхэлнэ.</p> <p>Ерөнхийлөгч нь албан үүргээ хүлээж авахдаа Дээд шүүхийн ерөнхий шүүгч, эсхүл Дээд шүүхийн бусад шүүгчийг байлцуулж, тангараг өргөнө.</p>	
Ерөнхий сайд		<p>25-р зүйл. Ерөнхий сайдыг томилох</p> <p>Ерөнхийлөгч Парламентын гишүүдийн олонхын итгэлийг хүлээх чадвартай гэж үзсэн Парламентын гишүүнийг Ерөнхий сайдаар томилох бөгөөд Ерөнхий сайдын зөвлөснөөр Парламентын гишүүд дундаас сайд нарыг томилно. Ингэхдээ Парламент тарсан үед томилгоо хийхдээ өмнөх Парламентын гишүүнийг томилж болох ба тэрээр шинэ Парламентын анхны хуралдаан явагдсанаас хойш, тухайн Парламентын гишүүн бус нөхцөлд албан үүргээ үргэлжлүүлэх эрхгүй байна.</p> <p>Энэхүү зүйлд заасан томилгоог Ерөнхийлөгч хийх бөгөөд төрийн тамгаар баталгаажуулна.</p>	<p>26-р зүйл.</p> <p>А. Ерөнхий сайд огцрох тухай өргөдлөө Ерөнхийлөгчид бичгээр гаргасан, эсхүл</p> <p>Б. Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхийн хүрээнд Ерөнхий сайдыг Парламентын олонхын итгэлийн хүлээхгүй байна гэж үзсэн тохиолдолд,</p> <p>2А. Ерөнхий сайдаас бусад сайд нар дараах нөхцөлд огцруулна: Ерөнхийлөгч Ерөнхий сайдын зөвлөсний дагуу сайдыг тухайн албан тушаалаас нь албан ёсоор огцруулах тухай шийдвэр гаргасан.</p>	

9. Словак

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцируулах /чөлөөлөх субъект
Ерөнхийлөгч	101-р зүйл. 2/ Ерөнхийлөгчийг Словакийн иргэд шууд сонгуулиар нууц санал хураалтаар таван жилийн хугацаатай сонгоно. 4/ Нийт сонгогчдын талаас илүү хувийн санал авсан нэр дэвшигч Ерөнхийлөгчөөр сонгогдоно. Хэрвээ аль ч нэр дэвшигч сонгогчдын тухайлан заасан хэмжээний олонхын саналыг авч чадахгүй бол хоёр дахь санал хураалтыг 14 өдрийн дотор зохион байгуулна.	(3) Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг Парламентын 15-аас цөөнгүй гишүүд эсхүл Словак улсын Үндэсний зөвлөлийн сонгуулийн эрх бүхий 15000-аас доошгүй иргэдийн гарын үсэг бүхий санал өргөх үндсэн дээр дэвшүүлнэ. Сонгуулийн тов гаргасан өдрөөс хойш 21 өдрийн дотор нэр дэвшигчийн нэрийг Словак улсын Үндэсний зөвлөлийн даргад өргөн барина.	(7) Сонгогдсон нэр дэвшигч тангараг өргөснөөр Ерөнхийлөгчийн албаны эрх үүрэг нь эхэлнэ. Тэрээр өмнөх Ерөнхийлөгчийн албан хугацаа дуусгавар болох өдрийн үдээс өмнө Словак улсын Үндэсний зөвлөлийн өмнө Үндсэн хуулийн шүүхийн тэргүүний удирдлагаар тангараг өргөнө.	106-р зүйл. 1/ Ерөнхийлөгчийг хугацаанаас нь өмнө бүх нийтийн санал хураалтаар эгүүлэн татаж болно. Ерөнхийлөгчийг эгүүлэн татах тухай бүх нийтийн санал асуултыг Словак улсын Үндэсний зөвлөлийн дарга Словак улсын Үндэсний зөвлөлийн бүх гишүүдийн тавны гуравас багагүй хувь эзлэх олонхын санал бүхий шийдвэрт үндэслэн зарлана. 2/ Хэрвээ эрх бүхий сонгогчдын талаас илүү хувь нь түүнийг эгүүлэн татах санал өгвөл Ерөнхийлөгчийг эгүүлэн татна.
Ерөнхий сайд		110-р зүйл. Ерөнхий сайдыг Ерөнхий чөлөөлнө. 111-р зүйл. Ерөнхий сайдын болгосноор Ерөнхийлөгч Засгийн газрын гишүүдийг томилж, чөлөөлөх ба тэдэнд яамдыг удирдах бүрэн эрх олгоно.		115-р зүйл. 1/ Хэрвээ Словак улсын Үндэсний зөвлөл итгэл үл үзүүлэх санал хурааж баталбал, эсхүл Засгийн газрын итгэл үзүүлэх саналын хүсэлтийг хүлээн аваагүй бол Словак улсын Ерөнхийлөгч Засгийн газрыг эгүүлэн татна. 116-р зүйл. 2/ Засгийн газрын гишүүн нь огцрох хүсэлтээ Словак улсын Ерөнхийлөгчид өргөн барина. 4/ Засгийн газрын хэн нэгэн гишүүнийг эгүүлэн татах тухай саналыг Ерөнхий сайд Ерөнхийлөгчид өргөн барьж болно. 6/ Хэрвээ Словак улсын Үндэсний зөвлөлөөс Ерөнхий сайдад итгэл үл үзүүлэх санал гарган баталбаас Словак улсын ерөнхийлөгч түүнийг эгүүлэн татна. Ерөнхий сайдыг эгүүлэн татах нь Засгийн газрыг татан буулгаж буй хэрэг мөн.

10. Турк

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцируулах /чөлөөлөх субъект
Ерөнхийлөгч	102-р зүйл. 1/ Ерөнхийлөгчид бүх нийтийн сонгуулиар нийт сонгогчдын үнэмлэхүй олонхын санал авсан нэр дэвшигч сонгогдоно. 2/ Хэрвээ анхны санал хураалтаар үнэмлэхүй олонхын санал аваагүй бол 2 дахь ням гаригт нь 2 дахь шатны санал хураалтыг зохион байгуулна. 2 дахь санал хураалтад эхний санал хураалтаар хамгийн их санал авсан нэр дэвшигч нь Ерөнхийлөгчөөр сонгогдоно.	101-р зүйл. Улсын Ерөнхийлөгчөөр Туркийн Их Чуулган гишүүд дотроосоо 40 нас хүрсэн, дээд боловсролтой гишүүнийг, эсхүл Туркийн иргэд дундаас эдгээр шаардлагыг хангасан, депутатаар сонгогдох шаардлагыг хангасан иргэнийг сонгоно. Ингэхдээ дээрх шаардлага хангасан иргэнийг чуулганы доод тал нь 20 гишүүний бичгээр илэрхийлсэн саналыг үндэслэн нэр дэвшүүлнэ.	103-р зүйл. Ерөнхийлөгч нь Үндэсний зөвлөлийн өмнө тангараг өргөнө.	105-р зүйл. Ерөнхийлөгчийг Туркийн Үндэсний Их Чуулганы бүх гишүүдийн гуравны нэгээс доошгүй саналаар, эсхүл бүх гишүүдийн дөрөвний гуравас доошгүйн шийдвэрээр эх орноосоо урвасан хэмээн үзвэл огцруулж болно.
Ерөнхий сайд		109-р зүйл. Сайд нарын зөвлөл нь Ерөнхий сайд болон сайд нараас бүрдэнэ. Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдыг Үндэсний Их хурлын гишүүд дундаас томилно. Сайд нарын Зөвлөл нь Ерөнхий сайд болон сайд нараас бүрдэнэ. Ерөнхий сайд нь сайд нарыг Үндэсний Их хурлын гишүүд дундаас, эсхүл Үндэсний Их хурлын гишүүнд тавигдах шаардлагыг хангасан этгээдийг томилгох бөгөөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын санал болгосны дагуу үүрэгт ажлаас нь чөлөөлж болно.		

11. Македон

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцируулах /чөлөөлөх субъект
Ерөнхийлөгч	80-р зүйл. Ерөнхийлөгчийг ард нийтийн шууд сонгуулиар, нууц санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно.			87-р зүйл. Ерөнхийлөгч эрхээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хууль, бусад хуулийг зөрчөөл хариуцлага хүлээнэ. Ерөнхийлөгчид хариуцлага тооцох санаачилгыг Хурал нийт бүрэлдэхүүнийхээ 2/3-ын саналаар, хариуцлага тооцох шийдвэрийг Үндсэн хуулийн цэц гаргана.
Ерөнхий сайд		84-р зүйл. Ерөнхийлөгч Засгийн газрыг бүрдүүлэх эрхийг Ерөнхий сайдад олгоно. 90-р зүйл. Хурал бүтэц зохион байгуулалтынхаа асуудлыг шийдэж дууссаны дараа 10 хоногт багтаж Ерөнхийлөгч нь Засгийн газрыг байгуулах эрхийг сонгуульд ялж хуралд олонх болсон нам зэвсэгд, эсхүл нам эвслийн санал болгосон нэр дэвшигч [Ерөнхий сайд болох]-д олгоно.		

12. Кыргызстан

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцируулах /чөлөөлөх субъект
Ерөнхийлөгч	61-р зүйл. Ерөнхийлөгч нь ард нийтийн сонгуулиар, 6 жилийн хугацаатай сонгогдоно. (Ерөнхийлөгчийг улируулан сонгохгүй.)	62-р зүйл. Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн тоог хязгаарлахгүй. 30000 дэмжигчийн гарын үсэг цуглуулсан хүн Ерөнхийлөгчид нэр дэвшигчээр бүртгэгдэх боломжтой.		66-69-р зүйл. 1/ өөрийн хүсэлтээр 2/ эрүүл мэндийн шалтгаанаар 3/ гэм буруутай нь тогтоогдсон бол Ерөнхийлөгчийг буруутгах үндэслэлийг Жогорку Кенеш гаргахдаа "тусгай комиссын дүгнэлтэд үндэслэх" ба огцируулах саналыг түүний нийт бүрэлдэхүүний 2/3 –с багагүй хэсэг нь "дэмжсэн" байх шаардлагатай;
		84-р зүйл. 1. Жогорку Кенешт талаас илүү суудал авсан бүлэг, эсвэл эвслийн бүлэг нь анхны хуралдаанаас хойш 15 хоногийн дотор Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ. Ерөнхий сайдад нэр дэвшигч Засгийн газрын хөтөлбөр, бүтэц, бүрэлдэхүүнийг Жогорку Кенешт санал болгоно. 84.2 Хэрэв Жогорку Кенеш нь Засгийн газрыг хугацаандаа баталж чадаагүй бол, эсвэл сонгуулийн дүнд аль ч улс төрийн нам талаас илүү тооны суудал аваагүй бол Ерөнхийлөгч намын бүлгүүдийн аль нэгэнд 15 хоногийн дотор олонхоо бүрдүүлж, Ерөнхий сайдад нэр дэвшүүлэхийг санал болгоно. 84.3 Хугацаандаа баталж чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дараагийн намын бүлэгт санал болгоно. 84.4 Мөн хугацаандаа баталж чадаагүй бол намын бүлгүүд өөрсдийн санаачилгаар 15 хоногийн дотор олонхоо бүрдүүлж, Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ.	84-р зүйл. 5. Ерөнхийлөгч Ерөнхий сайд болон Засгийн газрын бусад гишүүдийг томилох шийдвэрийг 3 хоногт гаргана. Хэрэв хугацаандаа томилж чадаагүй бол нэр дэвшигчдийг томилгогдсон гэж үзнэ. 84.6 Хэрэв парламент Үндсэн хуульд заасны дагуу Засгийн газрын хөтөлбөр, бүтэц, бүрэлдэхүүнийг баталж чадаагүй бол Ерөнхийлөгч хугацаанаас өмнө Жогорку Кенеш (парламент)-ийн сонгуулийн зарлана.	

Хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зарим орны Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй харьцуулсан байдал

Энэхүү бүлэгт Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулиар тогтоосон бүрэн эрхийг Болгар, Исланд, Кыргызстан, Македон, Сингапур, Серб, Словак, Турк, Финланд, Хорват, Чрна Гора зэрэг 11 орны Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиар хэрхэн зохицуулсан талаар харьцуулан хүснэгтээр харууллаа.

Тайлбар:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн холбогдох зүйл, заалт нь дээр дурдсан 11 орны Ерөнхийлөгчид Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон тохиолдолд (+),
- хэрэв уг бүрэн эрх олгогдоогүй бол (-),
- Үндсэн хууль болон бусад хуулиар ижил төстэй хуулийн зохицуулалт байхгүй бол (□),
- бусад байгууллага, субъектүүдтэй хамтран хэрэгжүүлж байгаа бол (+3),
- дангаараа хэрэгжүүлдэг (+Д)

гэсэн тэмдэглэгээгээр тус тус орууллаа.

2.1. Монгол Улсын болон зарим орны Ерөнхийлөгчийн бие даан хэрэгжүүлдэг бүрэн эрхийн харьцуулалт

Хүснэгт 4. Монгол Улсын болон зарим орны Ерөнхийлөгчийн бие даан хэрэгжүүлдэг бүрэн эрхийг харьцуулсан тойм

№	Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрх	Болгар	Финланд	Серби	Чрна Гора	Хорват	Исланд	Сингапур	Словак	Турк	Македон	Кыргызстан
1	26. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ.	-	-	-	-	-	+	-	-	-	-	-
2	27. 3. Улсын Их Хурлын гишүүдийн гуравны нэгээс дээшихийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санаачилгаар ээлжит бус чуулган чуулж болно.	+	-	-	+	+	+	*	-	+	□	+
3	27. 4. Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг сонгууль явуулсан өдрөөс хойш гуч хоногийн дотор Ерөнхийлөгч, бусад чуулганыг Улсын Их Хурлын дарга товлон зарлана.	+	-	-	-	+	+	*	+	-	+	-
4	31. 7. Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно.	+	+	+	+	+	□	□	-	+	+	-
5	33.1. 6/ Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах;	+	+	+	+	+	-	-	+	+	+	+
6	33.1. 7/ улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах;	+	+	+	+	+	□	□	+	□	+	+
7	33.1. 8/ уучлал үзүүлэх;	+	+	+	+	+	+	+3	+	+	+	+
8	33.1. 9/ Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх;	+	-	-	-	-	-	-	-	-	-	+
9	33.1. 10/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх;	+	□	+	+	+	□	□	□	+	+	+
10	33.1. 11/ бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах;	+3	+3	□	□	□	□	-	+3	□	□	-
11	33.2. Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.	+	+	+	+	-	□	□	+	+	+	+
12	65. 1. Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.	+	-	+	-	-	-	+3	+	+	-	+
13	33.4. Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно.	□	+	-	+	-	□	-	+	+	+	+

□-Үндсэн хууль, холбогдох бусад хуульд ижил, төстэй заал тусгагдээгүй.

2.2. Монгол Улсын болон зарим орны Ерөнхийлөгчийн хамтран хэрэгжүүлдэг бүрэн эрхийн харьцуулалт

Хүснэгт 5. Монгол Улсын болон зарим орны Ерөнхийлөгчийн хамтран хэрэгжүүлдэг бүрэн эрхийг харьцуулсан тойм

№	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх	Bosnia	Финланд	Cyprus	Чрна Гора	Хорват	Исланд	Cyprus	Словак	Турк	Македон	Кыргызстан
1	33.1. 1/ Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ;	+	-	-	-	□	-	+3	-	+	-	-
2	33.1. 2/ Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;	+	+	+	-	+	+	+Д	+	+	+	+
3	33.1. 3/ өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх. Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно;	□	□	□	□	□	□	□	□	□	□	□
4	33.1. 4/ гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах;	+	+	+	+	+3	+	□	+3	+	+	+3
5	33.1. 5/ Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах;	+	+	+	+	+	□	□	+	+	+	+3
6	33.1. 12/ Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.	-	+3	-	-	-	□	□	-	-	+3	+
7	51. 2. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.	+	+	-	-	+	□	+	+	-	-	+
8	56. 2. Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.	+	+	-	-	-	□	+	+	+	-	+

2.3. Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд харгалзах эрхийг бусад орны холбогдох хууль тогтоомжид тусгасан байдал

Хүснэгт 6. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг бусад орны холбогдох хууль тогтоомжид тусгасан байдал

26-р зүйл. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ.

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	87 дугаар зүйл Үндэсний Ассамблейн гишүүн бүр, эсхүл Сайд нарын зөвлөл хууль санаачлах эрхтэй байна.
2	Финланд	70 дугаар зүйл. Хууль батлах хүсэлтийг Засгийн газраас санал болгосноор Парламент, эсхүл Парламентын гишүүн гаргаж болно. Парламентын гишүүн нь Парламентын чуулгантай үед хүсэлт гаргана.
3	Серби	107 дугаар зүйл. Хууль болон бусад шийдвэрийн төсөл санаачлах эрхийг: Парламентын гишүүн тус бүр, автономит мужуудын Ассамблей, эсхүл доод тал нь 30000 сонгогчийн санаачилгаар хууль санаачилна. Иргэний хамгаалагч болон Сербийн Үндэсний Банк нь өөрийн эрх мэдэлд хамаарах асуудлаар хууль өргөн мэдүүлэх эрхтэй байна.
4	Чрна Гора	93 дугаар зүйл. Хууль санаачлах эрхийг Засгийн газар болон Парламентын гишүүн эдэлнэ. Мөн хууль санаачлах эрхийг 6000 сонгогч өөрсдийн итгэмжилсэн Парламентын гишүүнээр дамжуулан хэрэгжүүлнэ.
5	Хорват	85 дугаар зүйл Хорватын Парламентын гишүүн, төлөөлөгчдийн парламентын бүлгүүд болон Парламентын байнгын хороод болон Засгийн газар нь хууль санаачлах эрхтэй байна.
6	Исланд	25 дугаар зүйл Ерөнхийлөгч нь хуулийн төсөл болон бусад шийдвэрийн төслийг Парламентад өргөн барих эрхтэй байна. 38 дугаар зүйл Парламентын гишүүд болон сайд нар хууль болон бусад шийдвэрийн төсөл санаачлах гаргах эрхтэй байна.
7	Сингапур	59 дүгээр зүйл Энэхүү Үндсэн хууль болон Парламентын тогтоолд заасны дагуу аль ч гишүүн хууль санаачлах эрхтэй байна.
8	Словак	87 дугаар зүйл Үндэсний зөвлөлийн байнгын хороод, Парламентын гишүүд болон Засгийн газар хууль санаачлах эрхтэй байна.
9	Турк	88 дугаар зүйл Сайд нарын зөвлөл болон Парламентын гишүүд хууль санаачлах эрхтэй байна.
10	Македон	71 дүгээр зүйл Хууль санаачлах эрхийг Парламентын гишүүн, Засгийн газар болон 10000 сонгогч эдэлнэ.
11	Кыргызстан	79 дүгээр зүйл Хууль санаачлах эрхийг: 10000 сонгогч, Парламентын гишүүн, Засгийн газар эдэлнэ.

27.3. Улсын Их Хурлын гишүүдийн гуравны нэгээс дээшихийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санаачилгаар ээлжит бус чуулган чуулж болно.

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	78 дугаар зүйл. Үндэсний Ассамблейн дарга Ассамблейг дараах тохиолдолд зарлан хуралдуулна. 1. Өөрийн санаачилгаар, 2. Тавны нэг гишүүдийн шаардлагаар 3. Ерөнхийлөгчийн хүсэлтээр 4. Сайд нарын зөвлөлийн хүсэлтээр
2	Финланд	33 дугаар зүйл. Шаардлагатай үед Парламентын спикер шинэ сонгууль явагдахаас өмнө Парламентын чуулганыг зарлана.
3	Серби	106 дугаар зүйл Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг гишүүдийн гуравны нэгээс дээшихийн шаардсанаар, эсхүл чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг баталсан тохиолдолд Засгийн газрын саналаар зарлаж болно.
4	Чрна Гора	90 дугаар зүйл. Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл Парламентын гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар Парламентын ээлжит бус чуулганыг зарлана.
5	Хорват	79 дүгээр зүйл Хорват Улсын Парламентын онцгой чуулганыг Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл гишүүдийн олонхын саналаар зарлан хуралдуулна. Ерөнхийлөгч, парламентын намын бүлгүүдтэй урьдчилан зөвлөлдсөний үндсэн дээр онцгой чуулганыг зарлах эрхтэй байна.
6	Исланд	23 дугаар зүйл Ерөнхийлөгч нь Парламентыг жилд нэг удаа хоёр долоо хоногоос ихгүй хугацаанд завсарлуулах эрхтэй байна. Ерөнхийлөгч өөрийн хүсэлтээр мөн Парламентын гишүүдийн олонхын шаардсанаар ээлжит бус чуулганыг зарлана.
7	Сингапур	-
8	Словак	83.2 дугаар зүйл Үндэсний зөвлөлийн дарга нь хүсэлтээрээ, эсхүл гишүүдийн тавны нэгээс дээшихийн саналаар ээлжит бус чуулган зарлана. Энэ тохиолдолд 7 хоногийн дотор ээлжит бус чуулганыг хуралдуулна.
9	Турк	93 дугаар зүйл. Ерөнхийлөгч өөрийн санаачилгаар, эсхүл Сайд нарын зөвлөлийн хүсэлтээр ээлжит бус чуулган зарлана. Мөн Парламентын спикер өөрийн хүсэлтээр, эсхүл гишүүдийн тавны нэгийн бичгээр гаргасан хүсэлтээр ээлжит бус чуулганыг зарлана.
10	Македон	-
11	Кыргызстан	64.2 дугаар зүйл Ерөнхийлөгч нь Парламентын ээлжит бус чуулган зарлах эрхтэй байна. Парламентын спикер нь Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл Парламентын гишүүдийн гуравны нэгээс доошгүйн хүсэлтээр ээлжит бус чуулганыг зарлана.

27. 4. Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг сонгууль явуулсан өдрөөс хойш гуч хоногийн дотор Ерөнхийлөгч, бусад чуулганыг Улсын Их Хурлын дарга товлон зарлана.

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	75 дугаар зүйл. Үндэсний Ассамблейн анхдугаар чуулганыг сонгууль явагдсанаас хойш нэг сарын дотор Ерөнхийлөгч товлон зарлана. Ерөнхийлөгч товлон зарлаагүй тохиолдолд Үндэсний Ассамблейн 1/5 гишүүдийн саналаар товлон зарлана.
2	Финланд	Парламентын дэгийн тухай журам 2 дугаар зүйл ⁹ Парламентын анхдугаар чуулганыг Хуулийн хэрэгжилт, хяналт хариуцсан түшмэл / <i>Chancellor of Justice</i> / гишүүдийг нэрсийн жагсаалтаар дуудаж эхлүүлнэ.
3	Серби	101 дүгээр зүйл Парламентын анхдугаар чуулганыг сонгуулийн дүн зарлагдсанаас хойш 30 хоногийн дотор өмнөх Парламентын спикер товлон зарлана.
4	Чрна Гора	88 дугаар зүйл Шинээр сонгогдсон Парламентын анхдугаар чуулганыг сонгуулийн дүн зарлагдсанаас хойш 15 хоногийн дотор өмнөх Парламентын спикер товлон зарлана.
5	Хорват	98 дугаар зүйл Ерөнхийлөгч нь Парламентын анхдугаар чуулганыг зарлан хуралдуулна.
6	Исланд	22 дугаар зүйл Ерөнхийлөгч Парламентын сонгууль явагдсанаас хойш 10 долоо хоногоос хэтрэлгүй Парламентын анхдугаар чуулганыг товлон зарлана.
7	Сингапур	-
8	Словак	82.2 дугаар зүйл Үндэсний зөвлөлийн нээлтийн чуулганыг Словак улсын Ерөнхийлөгч сонгуулийн дүн зарласнаас хойш 30 хоногийн дотор зарлана. Эсвэл Үндэсний зөвлөл нь сонгуулийн дүн зарлагдсанаас хойш 13 дахь өдөр хуралдана.
9	Турк	Парламентын дэгийн тухай журам 3 дугаар зүйл ¹⁰ Чуулган нь сонгуулийн дүн зарлагдсаны 5 дахь өдрийн 15 цагт хуралдана.
10	Македон	Парламентын дэгийн тухай хууль 9 дүгээр зүйл ¹¹ Анхны чуулганыг Ерөнхийлөгч зарлаагүй тохиолдолд чуулганыг сонгууль явагдсанаас хойш 21 дахь хоног дээр хамгийн ахмад гишүүд зарлан хуралдуулна.
11	Кыргызстан	71 дүгээр зүйл Парламентын хамгийн ахмад гишүүн анхны чуулганыг зарлан хуралдуулна.

31. 7. Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно.

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	93 дугаар зүйл Ерөнхийлөгч болон Дэд ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно.

⁹ Parliament's Rules Of Procedure 17 december 1999 (40/2000, amendments up to 895/2012 included) https://www.eduskunta.fi/FI/tietoa-eduskunnasta/julkaisut/Documents/ekj_3+2013.pdf

¹⁰ https://global.tbmm.gov.tr/docs/rules_of_procedure_en.pdf

¹¹ <http://parliament.am/library/kanonakarger/MACEDONIA.pdf>

2	Финланд	54 дүгээр зүйл Ерөнхийлөгч тухайн албан тушаалдаа дараалан хоёроос дээшгүй удаа сонгогдож болно.
3	Серби	116 дугаар зүйл Нэг хүнийг Ерөнхийлөгчөөр хоёроос дээш удаа сонгохгүй.
4	Чрна Гора	97 дугаар зүйл. Нэг хүнийг Ерөнхийлөгчид дээд тал нь 2 удаа сонгож болно.
5	Хорват	95 дугаар зүйл Нэг хүнийг Ерөнхийлөгчөөр хоёроос дээш удаа сонгохгүй.
6	Исланд	-
7	Сингапур	-
8	Словак	103 дугаар зүйл Нэг хүнийг Ерөнхийлөгчөөр дараалан хоёроос дээш удаа сонгохгүй.
9	Турк	101 дүгээр зүйл Нэг хүнийг Ерөнхийлөгчид дээд тал нь 2 удаа сонгож болно.
10	Македон	80 дугаар зүйл Нэг хүнийг Ерөнхийлөгчид дээд тал нь 2 удаа сонгож болно.
11	Кыргызстан	61 дүгээр зүйл Нэг хүнийг Ерөнхийлөгчөөр дахин сонгохгүй.

33.1. 6/ Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах;

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	98 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь: 6. Болгар улсад суух гадаад улсын дипломат төлөөлөгчийн итгэмжлэх болон эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авч, гадаад улс, олон улсын байгууллага дахь өөрийн орныг төлөөлөгчийг сайд нарын зөвлөлийн санал болгосноор томилох, чөлөөлнө.
2	Финланд	99 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь Финланд Улсад суух гадаад улсын дипломат төлөөлөгчдийн итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авна;
3	Серби	112 дугаар зүйл Ерөнхийлөгч нь Серби Улсад суух гадаад улсын дипломат төлөөлөгчдийн итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авна;
4	Чрна Гора	95 дугаар зүйл Ерөнхийлөгч нь Гадаад орны дипломатуудыг итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичиг хүлээн авна.
5	Хорват	99 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь Хорват улсад суух гадаад улсын төлөөлөгчийн итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авна
6	Исланд	-
7	Сингапур	-
8	Словак	102 дугаар зүйл Ерөнхийлөгч бүрэн эрхт дипломат төлөөлөгчдийн тэргүүнийг хүлээн авах, итгэмжлэх, эгүүлэн татах эрхтэй байна.
9	Турк	104 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь Турк улсаас гадаад улсад суух төлөөлөгчдийг итгэмжлэх бөгөөд Турк улсад томилогдсон гадаад орны төлөөлөгчдийг хүлээн авна.
10	Македон	84 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь Македон Улсад суух гадаад орны дипломат төлөөлөгчдийн итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичиг хүлээн авна.
11	Кыргызстан	64.6.4 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь Кыргызстан улсад суух гадаад орны дипломат төлөөлөгчдийн итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичиг хүлээн авна.

33.1. 7/ улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах;

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	98 дугаар зүйл Ерөнхийлөгч нь одон, медалиар шагнана.
2	Финланд	Улсын зөвшөөрлийг илэрхийлэх тухай хуулийн 1 дүгээр зүйл ¹² Ерөнхийлөгч нь улсын цол хүртээх, одон, медалиар шагнах эрхтэй байна.
3	Серби	112 дугаар зүйл Ерөнхийлөгч нь өршөөл үзүүлэх болон цол хүртээнэ.
4	Чрна Гора	95 дугаар зүйл Ерөнхийлөгч 8. Чрна Гора Улсын медалиар шагнах болон цол хүртээх эрхтэй байна.
5	Хорват	98 дугаар зүйл Ерөнхийлөгч нь Хуульд заасан улсын цол, бусад шагналыг гардуулна.
6	Исланд	-
7	Сингапур	-
8	Словак	102 дугаар зүйл Ерөнхийлөгч нь i. бусдад энэ эрхээ шилжүүлээгүй бол улсын цол хүртээнэ.
9	Турк	-
10	Македон	84 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь хуульд заасны дагуу улсын цол хүртээнэ.
11	Кыргызстан	64.10 дугаар зүйл Ерөнхийлөгч 1. Кыргызстан Улсын төрийн шагнал гардуулах, 2. Кыргызстан Улсын цол хүртээх, 3. Цэргийн дээд цол, дипломат цол болон бусад тусгай цол хүртээнэ.

33.1. 8/ уучлал үзүүлэх;

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	98 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь: 11. Уучлал үзүүлэх. /104-р зүйл Дэд Ерөнхийлөгч/
2	Финланд	58 дугаар зүйл, 105 дугаар зүйл Ерөнхийлөгчийн шийдвэр Дараах асуудлаар Ерөнхийлөгч Засгийн газрын саналыг үндэслэхгүй шийдвэр гаргана. Хуульд заасны дагуу, хувь хүний асуудлаар, эсхүл Засгийн газрын хуралдаанаар оруулах шаардлагагүй асуудлаар Ерөнхийлөгчийн уучлал үзүүлэх
3	Серби	97 дугаар зүйл Серби Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх 2. эрүүгийн гэмт хэрэгт өршөөл болон уучлал үзүүлэх.
4	Чрна Гора	95 дугаар зүйл. Чрна Гора Улсын Ерөнхийлөгч нь: 9. Өршөөл үзүүлнэ.
5	Хорват	98 дугаар зүйл Ерөнхийлөгч нь уучлал үзүүлнэ.

¹² Act on the displays of public recognition (1215/1999) <https://www.finlex.fi/fi/laki/ajantasa/1999/19991215>

6	Исланд	29 дүгээр зүйл Ерөнхийлөгч өршөөл болон уучлал үзүүлнэ.
7	Сингапур	22Р дугаар зүйл (1) Ерөнхийлөгч нь тухай нөхцөл бүрдсэн тохиолдолд, Кабинетын зөвлөсний үндсэн дээр: (а) гол/ аль нэг гол гэмт хэрэгтнийг/хэрэгтнүүдийг яллахад шаардагдах мэдээллийг олгосон хамсаатанд уучлал үзүүлнэ (б) гэмт этгээдэд Сингапурын аль ч шатны шүүхэд өмгөөллийн үйлчилгээг үнэгүй, эсхүл хуулиар тогтоосон нөхцөлийн дагуу олгох, таслан шийдвэрлэх тогтоолыг тохиромжтой хугацаагаар эсхүл бүр мөсөн хойшлуулах эрхтэй байна. (с) ял, торгууль эсхүл эд хөрөнгө хураахыг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь чөлөөлөх (2) Ямарваа нэгэн гэмт хэрэгтэн нь цаазын ялаар шийтгүүлж, тус ял нь давж заалдах шатны шүүхэд хэрэгсэхгүй болсон нөхцөлд Ерөнхийлөгч нь (1)-р хэсэгт заасан эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах материалыг шаардах эрхтэй байна
8	Словак	102 дугаар зүйл Ерөнхийлөгч Уучлал эсхүл өршөөл хэлбэрээр эрүүгийн хэргийн шүүхээр ногдуулсан шийтгэлийн бууруулах, хэргийг хэрэгсэхгүй болгоно.
9	Турк	104 дүгээр зүйл Ерөнхийлөгч Тодорхой этгээдүүдэд, хүнд өвчин, хөгжлийн бэрхшээл, эсхүл өндөр насыг харгалзан шүүхээр ногдуулсан шийтгэлийг бууруулах, хэрэгсэхгүй болгох.
10	Македон	84 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь хуульд заасны дагуу уучлал үзүүлнэ.
11	Кыргызстан	64.10 дугаар зүйл Ерөнхийлөгч нь уучлал үзүүлнэ.

33.1. 9/ Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх;

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	Болгарын харьяатын тухай хууль 36 дугаар зүйл ¹³ Болгар Улсын харьяат болох, харьяатаас гарах, харьяатыг сэргээх асуудлыг Болгар Улсын Ерөнхийлөгч зарлиг гарган шийдвэрлэнэ.
2	Финланд	Финландын харьяатын тухай хуулийн 3 дугаар зүйл ¹⁴ Финландын Цагаачлалын алба нь Финланд Улсын харьяат болох, харьяатаас гарах асуудлыг шийдвэрлэнэ.
3	Серби	Сербийн харьяатын тухай хууль 43 дугаар зүйл ¹⁵ Серби Улсын харьяат болох, харьяатаас гарах асуудлыг дотоод асуудал хариуцсан яам шийдвэрлэнэ.
4	Чрна Гора	Чрна Гора Улсын харьяатын тухай хуулийн 12 дугаар зүйл Чрна Гора Улсын харьяат болох асуудлыг дотоод асуудал хариуцсан яам шийдвэрлэнэ. Тусгай нөхцөлийн /шинжлэх ухаан, эдийн засаг, соёл урлаг, спорт болон бусад үндэслэлээр/ дагуу харьяат болгох асуудлыг Ерөнхийлөгч, Ерөнхий сайд болон Парламентын спикерийн санал болгосны дагуу дотоод асуудал хариуцсан яам, шийдвэрлэнэ.

¹³ http://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=1&ved=0CB4QFjAA&url=http%3A%2F%2Fwww2.ohchr.org%2FenGLISH%2Fissues%2Fwomen%2Fdocs%2FGovernments%2FBulgarianLawBulgarianCitizenship.doc&ei=QmWVXVdihLdHKogTFhYDo-CA&usq=AFQJCNer6KReRcVtZQOIIsuhoqAnRgpw&sig2=OnZE-29hIPQagDF_IainRQ&bvm=bv.96952980,d.cGU&cad=rja

¹⁴ <http://www.finlex.fi/en/laki/kaannokset/2003/en20030359.pdf>

¹⁵ <http://www.mup.gov.rs/domino/zakoni.nsf/Law%20on%20Citizenship.pdf>

5	Хорват	Хорватын харьяатын тухай хуулийн 25 дугаар зүйл ¹⁶ Хорват Улсын дотоод асуудал хариуцсан яам нь Хорват Улсын харьяат болох, харьяатаас гарах асуудлыг шийднэ.
6	Исланд	Исландын харьяатын тухай хуулийн 6 дугаар зүйл ¹⁷ Исланд Улсын харьяат болох асуудлыг Парламент нь бие даасан хуулиар шийдвэрлэнэ.
7	Сингапур	127 дугаар зүйл Засгийн газар нь 21 нас хүрсэн, өргөдөл гаргасан этгээдийг Сингапур Улсын харьяат болгож болно.
8	Словак	Словакийн харьяатын тухай хуулийн 8 дугаар зүйл ¹⁸ Словак Улсын харьяат болох асуудлыг Словак Улсын дотоод явдлын яаманд ирсэн иргэний өргөдлийн дагуу Дотоод явдлын сайд шийдвэрлэнэ.
9	Турк	Туркийн харьяатын тухай хууль ¹⁹ Турк Улсын дотоод асуудал хариуцсан яам болон сайд нарын зөвлөл нь Турк Улсын харьяат болох, харьяатаас гарах асуудлыг шийднэ.
10	Македон	Македон Улсын харьяатын тухай хуулийн 21 дүгээр зүйл ²⁰ Македон Улсын харьяат болох, харьяатаас гарах, дахин сэргээх асуудлыг Дотоод явдлын сайд шийдвэрлэнэ.
11	Кыргызстан	64.7 дугаар зүйл Ерөнхийлөгч Кыргызстан Улсын харьяат болох, харьяатаас гарах асуудлыг шийдвэрлэнэ.

33.1.10/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх;

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	100 дугаар зүйл 2. Ерөнхийлөгч нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөгөөнийг удирдан явуулах хуулиар тогтоосон статустай.
2	Финланд	-
3	Серби	Серби улсын аюулгүй байдлыг хамгаалах байгууллагуудын үндэсний тухай хуулийн 9 дүгээр зүйл ²¹ Серби Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг Ерөнхийлөгч тэргүүлэх бөгөөд түүний эзгүйд Ерөнхий сайд тэргүүлнэ.
4	Чрна Гора	131 дугаар зүйл. Батлан хамгаалах болон аюулгүй байдлын зөвлөл нь Ерөнхийлөгч, Парламентын Спикер болон Ерөнхий сайдаас бүрдэнэ. Ерөнхийлөгч нь Батлан хамгаалах болон аюулгүй байдлын зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэнэ.
5	Хорват	Аюулгүй байдал болон тагнуулын тогтолцооны тухай хуулийн 4 дүгээр зүйл ²² Аюулгүй байдлын зөвлөлийн хурлыг Ерөнхийлөгч тэргүүлэх бөгөөд аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийг Ерөнхийлөгч, Ерөнхий сайдтай хамтран гарын үсэг зурж баталгаажуулна.
6	Исланд	-

¹⁶ http://eudocitizenship.eu/NationalDB/docs/CRO%20Law%20on%20Croatian%20Citizenship_consolidated%2028_10_2011_ENGLISH.pdf

¹⁷ http://www.stosunki.pl/sites/default/files/images/020icelandic_nationality_act.pdf

¹⁸ <http://eudo-citizenship.eu/docs/CountryReports/recentChanges/Montenegro.pdf>

¹⁹ <http://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=2&ved=0CCEQFjAB&url=http%3A%2F%2Fwww.minv.sk%2F%3F-statne-obciansstvo->

²⁰ <http://eudo-citizenship.eu/NationalDB/docs/TUR%20Turkish%20citizenship%20law%202009%20%28English%29.pdf>

²¹ <http://www.uniset.ca/nold/zmac.txt>

²² Law on the Bases of Security Services Organization in the Republic of Serbia, 2007 http://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=3&cad=rja&uact=8&ved=0CCsQFjAC&url=http%3A%2F%2Fwww.nsa.gov.rs%2F%2F%2F_Law_on_the_Bases_of_Security_Services_Organization_in_the_Republic_of_Serbia.doc&ei=glucVc3TLZLXoATpqJTQDg&usg=AFQjCNHDgJ9BW-miNZqIC-QUCDQMQU6iKA&sig2=N5DRgbC6P-85nxsyrtlgEQ&bvm=bv.96952980,d.cGU

²³ https://www.soa.hr/UserFiles/File/Zakon_o_sigurnosno-obavjestajnom_sustavu_RH_eng.pdf

7	Сингапур	-
8	Словак	-
9	Турк	104 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь: - Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийг зарлан хуралдуулна, - Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийг даргална.
10	Македон	86 дугаар зүйл Бүгд найрамдах Улсын Ерөнхийлөгч нь Бүгд найрамдах улсын аюулгүй байдлын зөвлөлийн дарга мөн байна.
11	Кыргызстан	64.9 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь хуульд заасны дагуу байгуулагдсан Батлан хамгаалах зөвлөлийг даргалах эрхтэй байна.

33.1. 11/ бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах;

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	100 дугаар зүйл 4. Ерөнхийлөгч нь хуульд заасны дагуу Сайд нарын зөвлөлийн саналаар бүх нийтийн буюу хэсэгчлэн цэргийн дайчилгаа зарлана.
2	Финланд	129 дүгээр зүйл Засгийн газрын санал болгосноор Ерөнхийлөгч цэргийн дайчилгаа зарлана. Тухайн үед Парламентын чуулган хуралдаагүй байгаа бол нэн даруй хуралдуулна.
3	Серби	-
4	Чрна Гора	-
5	Хорват	-
6	Исланд	-
7	Сингапур	-
8	Словак	102 дугаар зүйл Ерөнхийлөгч нь т. Словак Улсын Засгийн газрын саналын дагуу цэргийн дайчилгаа зарлах, дайны байдал зарлах, эсхүл онц байдал зарлах болон цуцлах эрхтэй байна.
9	Турк	-
10	Македон	-
11	Кыргызстан	64 дүгээр зүйл 9. Ерөнхийлөгч нь: 3. бүх нийтийн болон хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах, Кыргызстан Улсын бүрэн эрхт байдалд бусад улсаас занал учруулж, зэвсэглэн халдвал дайны байдал зарлах бөгөөд энэхүү асуудлыг Парламентад нэн даруй тавина.

33.2. Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	100 дугаар зүйл. 1. Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Болгар улсын цэрэг, армийн хүчний Үндсэн командлагч байна.
2	Финланд	128 дугаар зүйл Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Онц байдлын үед Засгийн газрын санал болгосноор, Ерөнхийлөгч энэхүү үүргээ шилжүүлж болох бөгөөд уг үүргийг хүлээн авсан этгээд нь заавал Финланд улсын иргэн байна.

3	Серби	112 дугаар зүйл Хуульд заасны дагуу Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний командлагч байх бөгөөд Сербийн армийн албан хаагчдыг томилох, дэвшүүлэх болон чөлөөлөх эрхтэй байна.
4	Чрна Гора	95 дугаар зүйл 2. Ерөнхийлөгч нь Батлан хамгаалах болон аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу зэвсэгт хүчнийг командална.
5	Хорват	81 дүгээр зүйл Хорватын Парламент нь Үндэсний аюулгүй байдлын болон батлан хамгаалах стратегийг батална. Хорват улсын зэвсэгт хүчин болон аюулгүй байдлын албадын иргэний хяналтыг хэрэгжүүлнэ.
6	Исланд	-
7	Сингапур	-
8	Словак	102 дугаар зүйл Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний командлагч байна.
9	Турк	104 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь Үндэсний Их Хурлын нэрийн өмнөөс Туркийн зэвсэгт хүчний командлагчийн үүргийг гүйцэтгэнэ.
10	Македон	79 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь Македон Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.
11	Кыргызстан	64.8 дугаар зүйл Кыргызстан Улсын Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний цэргийн командлагч байх бөгөөд Кыргызстан Улсын Зэвсэгт хүчний дээд командлагчдыг томилох болон чөлөөлнө.

65. 1. Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	147 дугаар зүйл Үндсэн хуулийн шүүх нь 12 шүүгчтэй байна. Шүүгчдийн 1/3-г Үндэсний Ассамблей, 1/3-г Ерөнхийлөгч, 1/3-г Кассацийн дээд шүүх болон Захиргааны хэргийн дээд шүүхийн шүүгчдийн хамтарсан уулзалтаар тус тус томилно.
2	Финланд	-
3	Серби	172 дугаар зүйл Үндсэн хуулийн шүүх нь 15 шүүгчтэй байх бөгөөд 9 жилийн хугацаагаар томилох болон сонгоно. Үндсэн хуулийн шүүхийн 5 шүүгчийг Үндэсний Ассамблей, 5 шүүгчийг Ерөнхийлөгч, мөн 5 шүүгчийг Кассацийн дээд шүүхийн хуралдаанаар томилно. Үндэсний Ассамблей нь Үндсэн хуулийн дээд шүүхийн 5 шүүгчийг Ерөнхийлөгчийн нэр дэвшүүлсэн 10 нэр дэвшигч дундаас, Ерөнхийлөгч нь Үндэсний Ассамблейгаас нэр дэвшүүлсэн 10 нэр дэвшигч дундаас, Кассацийн дээд шүүх нь Дээд шүүх болон Улсын прокурорын зөвлөлөөс нэр дэвшүүлсэн 10 шүүгч дундаас тус тус томилно.
4	Чрна Гора	82 дугаар зүйл Парламент нь нийт гишүүдийн олонхын саналаар Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүгчдийг томилж, чөлөөлнө.

5	Хорват	126 дугаар зүйл Үндсэн хуулийн шүүх Парламентын нийт гишүүдийн 2/3-ийн саналаар нэр хүндтэй хуульч, шүүгч, прокурор, өмгөөлөгч болон их сургуулийн профессор нараас сонгогдсон 13 шүүгчээс бүрдэнэ. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид нэр дэвшүүлэх асуудлыг Парламентын үндсэн хуулийн асуудал хариуцсан хороо шийдвэрлэнэ.
6	Исланд	-
7	Сингапур	100 дугаар зүйл Ерөнхийлөгч нь доод тал нь Дээд шүүхийн 3 шүүгчээс бүрдэх шүүхэд Үндсэн хуулийн зүйл, заалттай холбоотой асуудлаар, эсхүл гарч магадгүй гэсэн асуудлаар саналыг нь асуух эрхтэй байна. 22 дугаар зүйл Үндсэн хуульд заасан бусад заалтыг үл харгалзан, Үндсэн хууль болон бусад хуульд заасны дагуу зөвшилцөж, эсхүл зөвлөлдөн гаргана гэсэн заалтад санал нь нийлээгүй тохиолдолд Ерөнхийлөгч нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд дараах албан тушаалд томилохоос татгалзах, эсхүл эгүүлэн татахаас татгалзах эрхтэй байна: (а) Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Дээд шүүхийн шүүгчид, Шүүхийн комиссарууд
8	Словак	102 дугаар зүйл Ерөнхийлөгч нь Словак Улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг, Үндсэн хуулийн шүүхийн дарга, дэд даргыг томилж, чөлөөлнө, Словак улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн болон Ерөнхий прокурорын тангаргийн өргүүлнэ.
9	Турк	104 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь с. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг, Төрийн зөвлөлийн гишүүдийн 1/4-ийг томилох, Ерөнхий прокурор болон Давж заалдах шатны шүүхийн Дэд прокурор, Цэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчдийг, Цэргийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийг болон Шүүх, прокурорын дээд зөвлөлийн гишүүдийг тус тус томилно. 146 дугаар зүйл Үндсэн хуулийн шүүх нь 17 гишүүнтэй байна. Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь дараах шүүхийн дарга болон гишүүд дундаас: <ul style="list-style-type: none"> - 3 шүүгчийг Давж заалдах шатны шүүхээс, - 2 шүүгчийг Төрийн зөвлөл, - 1 шүүгчийг Цэргийн дээд шүүхээс, - 1 шүүгчийг Цэргийн захиргааны дээд шүүхээс тус бүр 3 нэр дэвшигч дундаас холбогдох нэгдсэн хуралдаанаар томилно. <ul style="list-style-type: none"> - 3 шүүгчийг Боловсролын дээд хорооноос, - 4 шүүгчийг Хорооны гишүүн бус хууль, эдийн засаг, улс төрийн салбарын багш нараас, <ul style="list-style-type: none"> - 1 шүүгчийг төрийн дээд албан тушаалтнаас - 1 шүүгчийг хувиараа өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэгчдээс, - 1 шүүгчийг нэгдүгээр зэргийн шүүгч, прокурор эсхүл Үндсэн хуулийн илтгэгч дундаас тус тус томилно.
10	Македон	68 дугаар зүйл Македон Улсын Парламент нь: Македон Улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг сонгоно. 109 дүгээр зүйл Македон Улсын Үндсэн хуулийн шүүх нь 9 шүүгчээс бүрдэнэ. Парламент нь Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг нийт гишүүдийн олонхын саналаар сонгоно. XV нэмэлт өөрчлөлт 1.Парламент нь нийт гишүүдийн олонхын саналаар Үндсэн хуулийн шүүхийн 6 шүүгчийг сонгох бөгөөд 3 шүүгчийг нийт гишүүдийн олонхын саналаар сонгох ба үүнд Македон улсын хүн амын цөөнхийн төлөөллийн санал багтсан байх ёстой.

11	Кыргызстан	<p>64 дүгээр зүйл</p> <p>3. Ерөнхийлөгч нь Шүүхийн томилгооны хорооны саналыг үндэслэн Парламентад Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчдийг өргөн мэдүүлнэ</p> <p>74 дүгээр зүйл</p> <p>4 Парламент нь: Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр Дээд шүүхийн шүүгчдийг томилох, үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр чөлөөлөх.</p> <p>93 дугаар зүйл</p> <p>3. Үндсэн хуулийн танхим нь Дээд шүүхийн нэг хэсэг байна.</p> <p>97 дугаар зүйл</p> <p>1. Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхим нь үндсэн хуулийг чандлан сахиулах үүргийг гүйцэтгэх байгууллага мөн.</p>
----	------------	--

33.4. Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно.

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	-
2	Финланд	57 дугаар зүйл Ерөнхийлөгч нь Үндсэн хууль болон бусад хуульд тусгайлан заасан эрх үүргийг хэрэгжүүлнэ.
3	Серби	112 дугаар зүйл Ерөнхийлөгч нь 8. Үндсэн хуульд заасан бусад асуудлыг шийдвэрлэнэ.
4	Чрна Гора	95 дугаар зүйл Чрна Гора Улсын ерөнхийлөгч нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.
5	Хорват	98 дугаар зүйл Ерөнхийлөгч нь Үндсэн хуульд заасан бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.
6	Исланд	-
7	Сингапур	21 дүгээр зүйл 2.10. Үндсэн хуульд заасны дагуу бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.
8	Словак	102 дугаар зүйл 4. Ерөнхийлөгчийн 1-р хэсэгт заасан бүрэн эрхийг хуулиар нарийвчлан тогтоож болно.
9	Турк	104 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан сонгох, томилох болон бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.
10	Македон	84 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь Үндсэн хуульд заасан бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.
11	Кыргызстан	64 дүгээр зүйл 11. Ерөнхийлөгч нь энэхүү Үндсэн хуульд заасан бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.

33.1. 1/ Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ;

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	101 дүгээр зүйл 1/ Үндэсний Ассамблейн шийдвэрийг 15 хоногийн дотор нийтэд зарласнаас хойш хуулийг дахин хэлэлцүүлэхээр Ерөнхийлөгч Үндэсний Ассамблейд буцаах эрхтэй. Ийнхүү буцаагдсан хууль Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн дийлэнх олонхын саналаар батлагдана. 2/ Үндэсний Ассамблейн баталсан шинэ хуулийг Ерөнхийлөгч хүлээн авч гарын үсэг зурж зарлан тунхаглана.
2	Финланд	77 дугаар зүйл Ерөнхийлөгч хуулийг батламжлаагүй бол, хууль Парламентад дахин хэлэлцүүлэхээр буцаагдана. Парламент нь хуульд агуулгын хувьд өөрчлөлт оруулаагүй тохиолдолд батламжлах шаардлагагүйгээр хүчин төгөлдөр болно. Парламент хуулийг батлаагүй бол тус хуулийг батлаагүйд тооцно.
3	Серби	113 дугаар зүйл Ерөнхийлөгч хуулийг тунхаглан зарлиг гаргах, эсхүл хуулийн Парламентад дахин хэлэлцүүлэхээр бичсэн тайлбарын хамт хуулийг баталснаас 15 хоногоос хэтрэлгүй, хуулийг онцгой журмаар баталсан бол 7 хоногоос тус тус хэтрэлгүй буцаах эрхтэй байна. Буцаагдсан хуулиар дахин санал хураалт явуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд нийт гишүүдийн олонхын саналаар батална. Ийнхүү батлагдсан хуулийг Ерөнхийлөгч тунхаглан зарлах үүрэгтэй байна. Үндсэн хуульд заасан хугацаанд Ерөнхийлөгч тус хуулийг тунхаглан зарлаж зарлиг гаргаагүй бол, Парламентын спикер зарлиг гаргана.
4	Чрна Гора	94 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь хуулийг баталснаас хойш 7 хоногийн дотор, яаралтай журмаар батлагдсан хуулийг 3 хоногийн дотор зарлах, эсхүл Парламентад дахин хэлэлцүүлэхээр буцаах эрхтэй байна. Ерөнхийлөгч нь дахин батлагдсан хуулийг тунхаглан зарлах үүрэг хүлээнэ.
5	Хорват	-
6	Исланд	26 дугаар зүйл Парламентаар батлагдсан хуулийг 2 долоо хоногоос хэтрэлгүй Ерөнхийлөгчид зарлан тунхаглуулахаар өргөн барих бөгөөд, Ерөнхийлөгч зарлан тунхагласнаар хууль хүчин төгөлдөр болно. Хуулийг буцаасан тохиолдолд гишүүд нууц санал хураалтаар батална. Батлагдаагүй бол хуулийг хүчингүйд тооцно.
7	Сингапур	148D дугаар зүйл Ерөнхийлөгч нь төсвийн төслийг батлахад Ерөнхийлөгчийн зөвлөхүүдийн зөвлөгөөг үл харгалзан зөвшөөрлөө өгөөгүй тохиолдолд, Парламентын дийлэнх олонхын саналаар төсвийн төслийг тогтоол гарган батална. Тогтоол гарснаар Ерөнхийлөгчийн зөвшөөрөл олгогдсонд тооцно.

8	Словак	87 дугаар зүйл Ерөнхийлөгч хуулийг Парламентад тайлбарын хамт буцаасан тохиолдолд, Парламент дахин хэлэлцэж баталсан бол зарлан тунхагласанд тооцно. Хуулийг Ерөнхийлөгч, Парламентын дарга болон Ерөнхий сайд хамтран гарын үсэг зурж батламжлах бөгөөд буцаагдсан хуулийг Парламент баталж, Ерөнхийлөгч гарын үсэг зураагүй бол, Ерөнхийлөгч гарын үсэг зураагүйг үл харгалзан хүчинтэйд тооцно .
9	Турк	89 дүгээр зүйл Ерөнхийлөгч Парламентаар батлагдсан хуулийг 15 хоногийн дотор зарлан тунхаглана. Ерөнхийлөгч хуулийг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь зарлан тунхаглах боломжгүй гэж үзсэн бол тайлбарын хамт Парламентад заасан хугацаанд дахин хэлэлцүүлэхээр буцаана. Хэсэгчлэн буцаасан тохиолдолд Ерөнхийлөгч болон Парламент тухайн асуудлыг хэлэлцэж болно. Төсвийн тухай хуулиуд дээрхэд хамаарахгүй. Ерөнхийлөгчийн буцаасан хуулийг Парламент ямарваа нэгэн өөрчлөлтгүй баталбал хуулийг Ерөнхийлөгч тунхаглан зарлана. Өөрчлөлт оруулж баталсан тохиолдолд, Ерөнхийлөгч буцаах эрхтэй байна.
10	Македон	75 дугаар зүйл Хуулийг Ерөнхийлөгч болон Парламентын дарга нар хамтран гарын үсэг зурж, тунхаглана. Ерөнхийлөгч хуульд гарын үсэг зурахгүй байх шийдвэр гаргаж болно. Парламент хуулийг дахин хэлэлцэж нийт гишүүдийн олонхын саналаар баталсан тохиолдолд Ерөнхийлөгч гарын үсэг зурж зарлан тунхаглана. Хуулийг нийт гишүүдийн гуравны хоёр баталсан тохиолдолд Ерөнхийлөгч гарын үсэг зуран зарлан тунхаглах үүрэгтэй.
11	Кыргызстан	81.3 дугаар зүйл Парламент хуулийг дахин хэлэлцэж нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар хуулийг хэвээр нь баталсан тохиолдолд Ерөнхийлөгч 14 хоногийн дотор гарын үсэг зурж зарлан тунхаглана. Ерөнхийлөгч заасан хугацаанд хуулийг хэвээр нь гарын үсэг зурж тунхаглаагүй тохиолдолд Парламентын дарга гарын үсэг зурж, 10 хоногийн дотор нийтэлнэ.

33.1. 2/ Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхоороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	99 дүгээр зүйл 1/Ардын Хурлын бүлгүүдтэй зөвшилцөн, хамгийн олон санал авсан бүлгээс Ерөнхий сайдад санал авсан нэр дэвшигчид Засгийн газрын бүрдүүлэхийг үүрэг болгоно. 2/ Нэр дэвшигч сайд нарын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 7 өдрийн дотор бүрдүүлж чадаагүй бол Ерөнхийлөгч хоёр дахь бүлгээс нэр дэвшсэн хүнд үүрэг өгнө. 3/ Хоёр дахь нэр дэвшигч өмнөх хэсэгт заасан тогтоосон хугацаанд Засгийн газрыг бүрдүүлж чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дараагийн бүлэгт Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх үүрэг өгнө. 4/ Хэрэв сайд нарын зөвлөлийг амжилттай бүрдүүлбэл нэр дэвшигчийг Ерөнхий сайд болгох саналыг Ардын Хуралд оруулна. 5/ Хэрэв Засгийн газрыг бүрдүүлэх талаар зөвшилцөлд хүрч чадаагүй бол Ерөнхийлөгч Ардын Хурлыг тараах сонгуулийг товлож, түр засгийн газар томилно. Ардын Хурлыг тараасан Ерөнхийлөгчийн актаар шинэ сонгуулийн хугацаа тодорхойлогдоно.
2	Финланд	61 дүгээр зүйл. Засгийн газрыг бүрдүүлэх Ерөнхий сайдыг сонгохоос өмнө Парламентад төлөөлөл бүхий бүлгүүд засгийн газрын мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг хэлэлцэнэ. Хэлэлцээг үндэслэн, Парламентын спикер болон парламентын бүлгүүдийн саналыг сонссоны үндсэн дээр Ерөнхийлөгч Парламентад Ерөнхий сайдад нэр дэвшигчийг танилцуулна. Нэр дэвшигч нь хангалттай санал аваагүй тохиолдолд, мөн адил журмын дагуу өөр нэр дэвшигчийг дэвшүүлнэ. Хоёр дахь нэр дэвшигч талаас дээш хувийн санал авч чадаагүй тохиолдолд, Ерөнхий сайдын сонгуулийг Парламентын нээлттэй санал хураалтаар явуулна. Ингэсэн тохиолдолд хамгийн их санал авсан этгээдийг Ерөнхий сайдаар сонгоно.
3	Серби	127 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь нэр дэвшигчдийн жагсаалтад төлөөлөгчдийн өгсөн саналыг харгалзан үзсэний үндсэн дээр Үндэсний Ассамблейд Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ.
4	Чрна Гора	103 дугаар зүйл. Сонгууль Чрна Гора улсын Ерөнхийлөгч нь Парламентыг сонгогдсоноос хойш 30 хоногийн дотор нэр дэвшигчийг санал болгоно. Ерөнхий сайдад нэр дэвшигч нь Парламентад мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг танилцуулна. Парламент нь нэгэн зэрэг нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг шийдвэрлэнэ.
5	Хорват	98 дугаар зүйл. 3/ Ерөнхийлөгч нь намуудын Парламентад авсан суудлын тоог харгалзан парламентын гишүүдийн олонхын итгэлийг хүлээсэн Ерөнхий сайдад нэр дэвшигчид Засгийн газар байгуулах эрх олгоно.
6	Исланд	15 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь сайд нарыг томилж, чөлөөлнө. Сайдын тоо болон эрх үүргийг тогтоож, хариуцлага хүлээлгэнэ.

7	Сингапур	<p>25 дугаар зүйл. Ерөнхий сайдыг томилох</p> <p>Ерөнхийлөгч Парламентын гишүүдийн олонхын итгэлийг хүлээх чадвартай гэж үзсэн Парламентын гишүүнийг Ерөнхий сайдаар томилох бөгөөд Ерөнхий сайдын зөвлөснөөр Парламентын гишүүд дундаас сайд нарыг томилно. Ингэхдээ Парламент тарсан үед томилгоо хийхдээ өмнөх Парламентын гишүүнийг томилж болох ба тэрээр шинэ Парламентын анхны хуралдаан явагдсанаас хойш, тухайн Парламентын гишүүн бус нөхцөлд албан үүргээ үргэлжлүүлэх эрхгүй байна.</p> <p>Энэхүү зүйлд заасан томилгоог Ерөнхийлөгч хийх бөгөөд төрийн тамгаар баталгаажуулна.</p>
8	Словак	<p>110 дугаар зүйл</p> <p>Ерөнхий сайдыг Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.</p> <p>111 дүгээр зүйл</p> <p>Ерөнхий сайдын санал болгосноор Ерөнхийлөгч Засгийн газрын гишүүдийг томилж, чөлөөлөх ба тэдэнд яамдыг удирдах бүрэн эрх олгоно.</p>
9	Турк	<p>109 дүгээр зүйл.</p> <p>Сайд нарын зөвлөл нь Ерөнхий сайд болон сайд нараас бүрдэнэ. Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдыг Үндэсний Их хурлын гишүүд дундаас томилно.</p> <p>Ерөнхий сайд нь сайд нарыг Үндэсний Их хурлын гишүүд дундаас, эсхүл Үндэсний Их хурлын гишүүнд тавигдах шаардлагыг хангасан этгээдийг томилох бөгөөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын санал болгосны дагуу үүрэгт ажлаас нь чөлөөлж болно.</p>
10	Македон	<p>84 дугаар зүйл</p> <p>Засгийн газрын бүрэлдэхүүнийг тодорхойлох эрхийг Ерөнхийлөгч олгоно.</p> <p>90-р зүйл Хурал бүтэц зохион байгуулалтынхаа асуудлыг шийдэж дууссаны дараа 10 хоногт багтааж Ерөнхийлөгч нь Засгийн газрыг байгуулах эрхийг сонгуульд ялж хуралд олонх болсон нам эвсэлд, эсхүл нам эвслийн санал болгосон нэр дэвшигч [Ерөнхий сайд болох]–д олгоно.</p>
11	Кыргызстан	<p>84.1 дүгээр зүйл</p> <p>Жогорку Кенешт талаас илүү суудал авсан бүлэг, эсвэл эвслийн бүлэг нь анхны хуралдаанаас хойш 15 хоногийн дотор Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ. Ерөнхий сайдад нэр дэвшигч Засгийн газрын хөтөлбөр, бүтэц, бүрэлдэхүүнийг Жогорку Кенешт санал болгоно.</p> <p>84.2 Хэрэв Жогорку Кенеш нь Засгийн газрыг хугацаандаа баталж чадаагүй бол, эсвэл сонгуулийн дүнд аль ч улс төрийн нам талаас илүү тооны суудал аваагүй бол Ерөнхийлөгч намын бүлгүүдийн аль нэгэнд 15 хоногийн дотор олонхоо бүрдүүлж, Ерөнхий сайдад нэр дэвшүүлэхийг санал болгоно.</p> <p>84.3 Хугацаандаа баталж чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дараагийн намын бүлэгт санал болгоно.</p> <p>84.4 Мөн хугацаандаа баталж чадаагүй бол намын бүлгүүд өөрсдийн санаачилгаар 15 хоногийн дотор олонхоо бүрдүүлж, Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ.</p>

33.1. 3/ өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх. Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно;

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	-
2	Финланд	-
3	Серби	-
4	Чрна Гора	-
5	Хорват	-
6	Исланд	-
7	Сингапур	-
8	Словак	-
9	Турк	-
10	Македон	-
11	Кыргызстан	-

33.1. 4/ гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах;

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	92 дугаар зүйл 1. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн мөн. Тэрээр Олон улсын харилцаанд улс орноо төлөөлөх ба үндэсний нэгдмэл байдлыг хангана. 98 дугаар зүйл 3. Ерөнхийлөгч нь Хуулиар тогтоосон нөхцөл байдлыг харгалзан Олон улсын гэрээ байгуулна.
2	Финланд	93 дугаар зүйл Финланд Улсын гадаад бодлогыг Ерөнхийлөгч Засгийн газартай хамтран чиглүүлнэ. Гэхдээ Финландын олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй холбоотой асуудлаар, түүнийг хэрэгжүүлэх болон цуцлах асуудлыг Үндсэн хуульд заасны дагуу Парламент хэрэгжүүлнэ.
3	Серби	112 дугаар зүйл Ерөнхийлөгч нь Серби Улсыг гадаад болон дотооддоо төлөөлнө. 105 дугаар зүйл Парламент нийт гишүүдийн олонхын саналаар олон улсын гэрээ хэлэлцээр байгуулна.
4	Чрна Гора	95 дугаар зүйл Ерөнхийлөгч нь Чрна Гора Улсыг гадаадад болон дотоодод төлөөлнө. 82 дугаар зүйл Парламент олон улсын гэрээ хэлэлцээр байгуулна
5	Хорват	94 дүгээр зүйл Хорват Улсын Ерөнхийлөгч нь Хорват Улсыг гадаадад болон дотоодод төлөөлнө. 139 дүгээр зүйл Олон улсын гэрээг Үндсэн хууль, олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн, олон улсын гэрээ хэлэлцээрийн агуулгаас хамааран Парламент, Ерөнхийлөгч болон Засгийн газар байгуулна.

6	Исланд	21 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь бусад улс оронтой гэрээ байгуулна. Ерөнхийлөгч нь улс орны хараат байдал, газар нутаг болон эзэмшлийн далай, эсхүл улс орны тогтолцоонд өөрчлөлт оруулах утга агуулсан гэрээг Парламентаас өөрөөр заагаагүй бол байгуулах эрхгүй байна.
7	Сингапур	-
8	Словак	84 дүгээр зүйл Олон улсын гэрээг 7.3, 7.4-р заалтад заасны дагуу болон Ерөнхийлөгчөөс буцаагдсан хуулийг Парламентын нийт гишүүдийн олонхын саналаар тус тус батална.
9	Турк	104 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь олон улсын гэрээ байгуулна.
10	Македон	119 дүгээр зүйл Македон Улсын Ерөнхийлөгч нь Македон Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулна. Хуулиар заасны дагуу олон улсын гэрээг Засгийн газар байгуулж болно.
11	Кыргызстан	64.6 дугаар зүйл Ерөнхийлөгч 1/Ерөнхийлөгч нь Кыргызстан Улсыг гадаадад болон дотооддоо төлөөлнө. 2/ хэлцэл явуулж, Ерөнхий сайдын зөвшөөрөлтэйгөөр олон улсын гэрээ байгуулна, мөн дээрх үүргээ Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн болон бусад албан хаагчдад шилжүүлж болно.

33.1. 5/ Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах;

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	98 дугаар зүйл 6. Болгар улсад суух гадаад улсын дипломат төлөөлөгчийн итгэмжлэх болон эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авч, гадаад улс, олон улсын байгууллага дахь өөрийн орныг төлөөлөгчийг сайд нарын зөвлөлийн санал болгосноор томилох, чөлөөлнө.
2	Финланд	126 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь Ерөнхийлөгчийн тамгын газрын байнгын нарийн бичгийн даргыг болон Финланд Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилно.
3	Серби	112 дугаар зүйл Ерөнхийлөгч нь 6. Засгийн газрын саналыг үндэслэж Серби Улсаас гадаад улсад суух элчин сайдуудыг зарлиг гарган томилох болон эгүүлэн татах.
4	Чрна Гора	95 дугаар зүйл Ерөнхийлөгч 6. Чрна Гора улсаас гадаад улсад суух дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнийг Парламентын гадаад харилцаа асуудал хариуцсан хорооны саналыг үндэслэн Засгийн газартай зөвшилцөж томилох, эгүүлэн татах эрхтэй байна.
5	Хорват	99 дүгээр зүйл. Ерөнхийлөгч нь Хорватын Парламентын холбогдох хорооны саналыг харгалзан, Засгийн газрын саналыг үндэслэсэн Ерөнхий сайдтай хамтран гарын үсэг зурж Хорват Улсаас гадаад улсад суух дипломат төлөөлөгчдийг томилж, эгүүлэн татна.
6	Исланд	-
7	Сингапур	-

8	Словак	102 дугаар зүйл Ерөнхийлөгч бүрэн эрхт дипломат төлөөлөгчдийн тэргүүний хүлээн авах, итгэмжлэх, эгүүлэн татах эрхтэй байна.
9	Турк	104 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь Турк Улсаас гадаад улсад суух төлөөлөгчдийг итгэмжлэх, мөн Турк Улсад гадаад улс орноос томилогдсон төлөөлөгчдийг хүлээн авна.
10	Македон	84 дүгээр зүйл Македон Улсын Ерөнхийлөгч нь Македон улсаас гадаад улсад суух элчин сайд болон төлөөлөгчдийг зарлиг гарган итгэмжилж, эгүүлэн татна.
11	Кыргызстан	64.6 дугаар зүйл Ерөнхийлөгч нь 4. Ерөнхий сайдтай зөвшилцөж Кыргызстан Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчид болон олон улсын байнгын төлөөлөгчдийн газарт төлөөлөгчдийг томилох, эгүүлэн татах эрхтэй байна.



33.1. 12/ Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	84 дүгээр зүйл Парламент нь 10. Дайн зарлах болон энхийн гэрээ байгуулах.
2	Финланд	93 дугаар зүйл Ерөнхийлөгч Парламенттай зөвшилцөн дайн зарлах болон энхийн гэрээ байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.
3	Серби	99 дугаар зүйл Парламент нь 5. дайн зарлах, энхийн гэрээ байгуулах болон онц байдал зарлана.
4	Чрна Гора	82 дугаар зүйл Парламент нь Дайны байдал болон онц байдал зарлана. Энхийн гэрээтэй холбоотой асуудлыг шийдвэрлэнэ.
5	Хорват	81 дүгээр зүйл Хорватын парламент нь дайн зарлах болон энхийн гэрээ байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.
6	Исланд	-
7	Сингапур	-
8	Словак	84 дүгээр зүйл 4. Дайн зарлах асуудлыг Парламентын нийт гишүүдийн 3/5-ны саналаар шийдвэрлэнэ.
9	Турк	92 дугаар зүйл Парламент нь дайны байдал зарлах эрхтэй байна. Парламент завсарласан үед улс орны бүрэн эрхт байдалд бусад улсаас занал учруулж, зэвсэглэн халдаж нэн даруй шийдвэр гаргах шаардлагатай бол Ерөнхийлөгч нь Туркийн зэвсэгт хүчнийг хөдөлгөх шийдвэр гаргаж болно.

10	Македон	124 дүгээр зүйл Дайны байдлыг Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл доод тал нь 30 гишүүний саналаар Парламентын нийт гишүүдийн 2/3-ны саналаар зарлана. Парламент хуралдах боломжгүй бол дайны байдлыг Ерөнхийлөгч зарлаж, Парламентыг хуралдмагц батлуулна.
11	Кыргызстан	64 дүгээр зүйл 9. Ерөнхийлөгч нь: 3. бүх нийтийн болон хэсэгчилсэн дайны байдал зарлах, Кыргызстан Улсын бүрэн эрхт байдалд бусад улсаас занал учруулж, зэвсэглэн халдвал дайны байдал зарлах бөгөөд энэхүү асуудлыг Парламентад нэн даруй тавина.

51. 2. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	129 дүгээр зүйл 2. Кассацийн дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Захиргааны хэргийн дээд шүүхийн дарга болон Ерөнхий прокурорыг Шүүхийн дээд зөвлөлийн санал болгосноор Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө. Дахин санал оруулсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгч томилохоос, чөлөөлөхөөс татгалзах эрхгүй байна.
2	Финланд	102 дугаар зүйл Шүүгчдийг Ерөнхийлөгч хуульд заасан журмын дагуу томилно.
3	Серби	105 дугаар зүйл Парламент хүрэлцэн ирсэн гишүүдийн олонхын саналаар Дээд шүүхийн даргыг, шүүхийн дарга нарыг, Улсын ерөнхий прокурор болон улсын прокуроруудыг сонгоно. 144 дүгээр зүйл Кассацийн дээд шүүхийн даргыг Парламент, Шүүхийн дээд зөвлөлийн санал болгосны дагуу Кассацийн дээд шүүхийн хуралдааны санал болон Парламентын холбогдох хорооны саналыг үндэслэсэн шийдвэрлэнэ.
4	Чрна Гора	82 дугаар зүйл Парламент нь Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Үндсэн хуулийн шүүхийн дарга болон шүүгчдийг томилж, чөлөөлнө. 124 дүгээр зүйл Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Чрна Гора Улсын Ерөнхийлөгч, Парламентын спикер болон Ерөнхий сайдын хамтарсан саналын дагуу Парламент томилж, чөлөөлнө. Дээд шүүхийн ерөнхий шүүгчийг 30 хоногийн дотор томилж чадаагүй бол Парламентын холбогдох хорооны саналыг үндэслэн томилно.
5	Хорват	119 дүгээр зүйл Хорват Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгчийг холбогдох Парламентын хорооны санал, Дээд шүүхийн хуралдааны санал зэргийг үндэслэн Ерөнхийлөгчийн санал болгосноор Парламент 4 жилийн хугацаагаар томилно.
6	Исланд	-

7	Сингапур	95 дугаар зүйл 1. Дээд шүүхийн ерөнхий шүүгч болон шүүгчдийг Ерөнхийлөгч, Ерөнхий сайдтай зөвшилцөн томилно. 2. Ерөнхий шүүгчээс бусад шүүгчдийг томилох саналыг Ерөнхий сайд Дээд шүүхийн ерөнхий шүүгчтэй зөвшилцөн гаргана.
8	Словак	102 дугаар зүйл Ерөнхийлөгч нь t. шүүгч, Словак улсын Ерөнхий шүүгч Ерөнхий шүүгчийн орлогчийг, Ерөнхий прокурор болон Шүүхийн зөвлөлийн гурван гишүүнийг томилж, чөлөөлнө, шүүгчийн тангаргийг өргүүлнэ.
9	Турк	Турк Улсын Дээд шүүгчдийг Шүүгч, прокурорын дээд зөвлөлөөс томилно.
10	Македон	105 дугаар зүйл Македон улсын Шүүхийн зөвлөл нь шүүхийн дарга болон шүүгчдийг томилж, чөлөөлнө. Шүүгчдийг томилж, чөлөөлөх асуудлаар хүн амын цөөнхийн бүхий л төлөөллүүдийг багтаасан байна. Хуульд заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл нь жил бүр Парламентад тайлангаа хүргүүлнэ.
11	Кыргызстан	64 дүгээр зүйл 3/ Ерөнхийлөгч нь Шүүхийн томилгооны хорооны саналыг үндэслэн Парламентад Дээд шүүхийн шүүгчдийг нэр дэвшигчдийг өргөн мэдүүлнэ 74 дүгээр зүйл 4/ Парламент нь: Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр Дээд шүүхийн шүүгчдийг томилох, үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр чөлөөлөх.

56. 2. Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	129 дүгээр зүйл 2. Кассацийн дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Захиргааны хэргийн дээд шүүхийн дарга болон Ерөнхий прокурорыг Шүүхийн дээд зөвлөлийн санал болгосноор Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө. Дахин санал оруулсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгч томилох, чөлөөлөхөөс татгалзах эрхгүй байна.
2	Финланд	104 дүгээр зүйл Ерөнхий прокурорыг Ерөнхийлөгч томилох бөгөөд прокурорын ажиллагааг нарийвчлан тусгай хуулиар зохицуулна.
3	Серби	158 дугаар зүйл Улсын Ерөнхий Прокурорыг Парламентын холбогдох хорооны саналыг үндэслэн Засгийн газар Парламентад санал оруулж, Парламент сонгоно. Улсын Ерөнхий прокурорыг хуульд заасны дагуу Парламент, Засгийн газрын саналыг үндэслэн шийдвэрлэнэ. Улсын Ерөнхий прокурорыг чөлөөлөх асуудлыг Парламент хуульд заасны дагуу Засгийн газрын саналыг үндэслэн шийдвэрлэнэ.
4	Чрна Гора	82 дугаар зүйл Парламент нь 14. Дараах албан хаагчдыг үүрэгт ажлаас нь томилж, чөлөөлнө: Ерөнхий прокурор болон улсын прокурор, Омбудсмен, Төв банкны Ерөнхийлөгч болон Төв Банкны зөвлөлийн гишүүд, Улсын Аудитын байгууллагын удирдлага болон Сенатын гишүүдийг болон хуульд бусад албан хаагчдыг.

5	Хорват	125 дугаар зүйл Хорватын парламент нь Парламентын холбогдох хорооны саналыг үндэслэн, Засгийн газартай зөвшилцөн 4 жилийн хугацаатай томилно. Ерөнхий прокурорын орлогчийг Үндэсний прокурорын зөвлөл томилж, чөлөөлж, сахилгын шийтгэл ногдуулна.
6	Исланд	-
7	Сингапур	35 дугаар зүйл 1/Ерөнхий прокурорын албаны бүтэц болон томилгоог Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын зөвлөгөөг зөвшөөрснөөр Дээд шүүхийн шүүгчээр томилогдох болзлыг хангасан этгээд дундаас томилно.
8	Словак	102 дугаар зүйл Ерөнхийлөгч нь t. шүүгч, Словак улсын Ерөнхий шүүгч Ерөнхий шүүгчийн орлогчийг, Ерөнхий прокурор болон Шүүхийн зөвлөлийн гурван гишүүнийг томилж, чөлөөлнө, шүүгчийн тангаргийг өргүүлнэ.
9	Турк	154 дүгээр зүйл Улсын Ерөнхий прокурор болон түүний орлогчийг Ерөнхийлөгч 4 жилийн хугацаагаар томилно. Дээд шүүхийн нэгдсэн хуралдаанаар гишүүд дундаасаа нэг орон тоонд тус бүр 5 нэр дэвшигчдээс нууц санал хураалтаар сонгон Ерөнхийлөгчип өргөн мэдүүлнэ.
10	Македон	91 дүгээр зүйл Македон Улсын Засгийн газар нь Ерөнхий прокурорыг Улсын прокурорын зөвлөлийг саналыг үндэслэн нэр дэвшүүлнэ. 106 дугаар зүйл Ерөнхий Прокурорыг Парламент 6 жилийн хугацаагаар томилно.
11	Кыргызстан	64 дүгээр зүйл 4. Ерөнхийлөгч нь Хуульд заасны дагуу Парламенттай зөвшилцөн Ерөнхий прокурорыг томилно. Парламентын нийт гишүүдийн 1/3-с доошгүй гишүүдийн саналаар Ерөнхий прокурорыг чөлөөлөх, эсхүл Парламентын гишүүдийн 1/3-с доошгүй гишүүдийн саналыг Парламентын нийт гишүүдийн 2/3 зөвшөөрснөөр чөлөөлнө. Ерөнхий прокурорын саналаар дэд прокуроруудыг томилж, чөлөөлнө.

ХАВСРАЛТ
ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООХ, ГҮЙЦЭТГЭХ ЭРХ МЭДЛИЙН ТЭРГҮҮНИЙГ СОНГОХ ЗАРЧИМ

	Улс орон	Төрийн тэргүүнийг хэрхэн сонгодог	Засгийн газрын тэргүүнийг хэрхэн сонгодог	Ерөнхийлөгчийг эсэх	Хууль тогтоох нэгдэлүүдийн тоо	Хууль тогтоох байгууллагын доод танхимыг хэрхэн сонгодог	Хууль тогтоох байгууллагын дээд танхимыг хэрхэн бүрдүүлдэг
Ерөнхийлөгчийн БНУ							
1	Азербайжан	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
2	Алжир	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогддог
3	Америкийн Нэгдсэн Улс	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Сонгогчдын коллери, эсхүл Сонгуулийн хорооноос сонгогдоно.		тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
4	Ангол	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	тийм	1	Шууд сонгуулиар	
5	Аргентин	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
6	Армян	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
7	Афганистан	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогддог
8	Беларусь	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогддог

9	Бенин	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	1	Шууд сонгуулиар	
10	Бирм-Мьянмар	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бусад		тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилдог
11	Болив	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
12	Бразил	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
13	Буркина Фасо	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	
14	Бурунди	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
15	Венесуэль	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
16	Габон	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
17	Гаити	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
18	Гамби	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	1	Шууд сонгуулиар	

19	Гана	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	1	Шууд сонгуулиар	
20	Гватемал	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	1	Шууд сонгуулиар	
21	Гвиана	Бусад	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
22	Гвиней Бисау	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
23	Гондурас	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
24	Гүрж	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
25	Бүгд Найрамдах Доминикан Улс	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
26	Жибути	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	1	Шууд сонгуулиар	
27	Замби	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
28	Зимбабве	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	
29	Зүүн Тимор	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	

30	Индонез	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	
31	Йемен	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	
32	Кабо Верде	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
33	Казахстан	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогддог
34	Камерун	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Бусад
35	Кени	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	
36	Колумби	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
37	Коморос	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
38	Конго	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	
39	Конго (БНАКУ)	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	
40	Коста Рика	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	1	Шууд сонгуулиар	

41	Кот д-Ивуар	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
42	Куба	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
43	Либер	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	
44	Мавритани	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
45	Мадагаскар	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	
46	Малави	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
47	Мали	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
48	Мальдив	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	1	Шууд сонгуулиар	
49	Мексик	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
50	Мозамбик	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	1	Шууд сонгуулиар	
51	Намиби	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар

52	Нигер	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
53	Нигери	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
54	Никарагуа	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
55	Орос	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогддог
56	Өмнөд Солонгос	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
57	Өмнөд Судан	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	
58	Палау	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
59	Панам	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
60	Парагвай	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
61	Перу	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	1	Шууд сонгуулиар	
62	Польш	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
63	Португал	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
64	Руанда	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогддог

65	Румын	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
66	Сан Томе Принсипи	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
67	Сейшелийн Аркууд	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	
68	Сенегал	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	Бусад
69	Сири	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
70	Судан	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шилжилтийн - томилдог	Шууд бус сонгуулиар
71	Сьерра Леон	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	1	Шууд сонгуулиар	
72	Тажикистан	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилдог
73	Тайван	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
74	Танзани	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
75	Togo	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
76	Төв Африкийн Бүгд Найрамдах Улс	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
77	Туркменистан	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	1	Шууд сонгуулиар	

78	Уганда	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	1	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилдог
79	Узбекистан	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	
80	Украин	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
81	Уругвай	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
82	Филиппин	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	
83	Франц	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
84	Хойд Солонгос	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Угсаа залгамжилдаг	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
85	Чили	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
86	Шри Ланка	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна		тийм	1	Шууд сонгуулиар	
87	Эквадор	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	1	Шууд сонгуулиар	
88	Экваторын Гвиней	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	

89	Сальвадор	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	1	Шууд сонгуулиар	
90	Иран						
91	Литв	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
Парламентын засагтай орнууд							
№	Улс орон	Төрийн тэргүүнийг хэрхэн сонгодог	Засгийн газрын тэргүүнийг хэрхэн сонгодог	Ерөнхийлөгчийг эсэх	Хууль тогтоох нэгдсэн байгууллага	Хууль тогтоох байгууллагын доод танхимыг хэрхэн сонгодог	Хууль тогтоох байгууллагын дээд танхимыг хэрхэн бүрдүүлдэг
1	Австри	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
2	Бангладеш	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
3	Болгар	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
4	Босни Герцеговин	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
5	Ботсван	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	Залгамжлах болон томилог
6	Доминика	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар болон томилог	
7	Вануату	Сонгогчдын коллеги, эсхүл Сонгуулийн хорооноос сонгогдоно.	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
8	Вьетнам	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	Бусад
9	Герман	Сонгогчдын коллеги, эсхүл Сонгуулийн хорооноос сонгогдоно.	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	Төлөөллүүд
10	Грек	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	тийм	1	Шууд сонгуулиар	

11	Израиль	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	тийм	1	Шууд сонгуулиар	
12	Ирак	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	тийм	1	Шууд сонгуулиар	
13	Ирланд	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	Намаас нэрийн жагсаалтаар томилдог
14	Исланд	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
15	Итали	Сонгогчдын коллеги, эсхүл Сонгуулийн хорооноос сонгогдоно.	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
16	Кирибати	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно.	тийм	1	Шууд сонгуулиар	
17	Кыргызстан	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Ерөнхийлөгчийн санал болгосноор Парламент томилно	тийм	1	Шууд сонгуулиар	
18	Лаос	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
19	Латви	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
20	Ливан	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
21	Ливи	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог - Бусад	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Төлөөлөгчдийн зөвлөлөөс сонгоно	
22	Маврикий	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
23	Македон	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	тийм	1	Шууд сонгуулиар	
24	Малыг	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	

25	Маршаллын Арлууд	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
26	Микронез	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
27	Молдав	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
28	Монгол	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
29	Науру	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
30	Непал	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
31	Өмнөд Африк	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
32	Пакистан	Сонгогчдын коллеги, эсхүл Сонгуулийн хорооноос сонгогдоно.	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
33	Самоа	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилогддог	байхгүй	1	Шууд сонгуулиар	
34	Сан Марино	Шууд бус/ Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	үгүй	1	Шууд сонгуулиар	
35	Серби	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
36	Сингапур	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
37	Словак	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
38	Словени	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	Сонирхлын бүлгүүдийн төлөөлөл
39	Сомали	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилогддог	тийм	2	Шилжилтийн	Бусад
40	Суринам	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	

41	Тринидад Тобаго	Сонгогчдын коллеги, эсхүл Сонгуулийн хорооноос сонгогдоно.	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Томилдог
42	Тунис	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно.	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	тийм	1	Шууд сонгуулиар	
43	Турк	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
44	Унгар	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
45	Фижи	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	тийм	1	Шууд сонгуулиар	
46	Финланд	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
47	Хорват	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
48	Хятад	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Бусад	
49	Чех	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна. Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоотой.	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
50	Црна Гора	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
51	Швейцар	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
52	Энэтхэг	Сонгогчдын коллеги, эсхүл Сонгуулийн хорооноос сонгогдоно.	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
53	Эстони	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
54	Этиоп	Шууд бус буюу хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар

Хаант засагтай орнууд							
№	Улс орон	Төрийн тэргүүнийг хэрхэн сонгодог	Засгийн газрын тэргүүнийг хэрхэн сонгодог	Ерөнхийлөгчтэй эсэх	Хууль тогтоох байгууллагын тоо	Хууль тогтоох байгууллагын доод танхимыг хэрхэн сонгодог	Хууль тогтоох байгууллагын дээд танхимыг хэрхэн бүрдүүлдэг
1	Австрали	Амбан захирагчийг Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
2	АН Эмират	Бусад	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар болон томилогддог	
3	Андорра	Бусад	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	үгүй	1	Шууд сонгуулиар	
4	Багамын Арлууд	Амбан захирагчийг Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогддог
5	Барбадос	Амбан захирагчийг Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогддог
6	Бахрейн	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогддог
7	Белиз	Амбан захирагчийг Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогддог
8	Бельги	Угсаа залгамжилдаг	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	үгүй	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
9	Бруней	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	байхгүй	байхгүй	
10	Бутан	Угсаа залгамжилдаг	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	үгүй	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогддог
11	Ватикан	Сонгогчдын коллеги, эсхүл Сонгуулийн хорооноос сонгогдоно.	Томилогддог	тийм	1	байхгүй	
12	Гренада	Амбан захирагчийг Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогддог
13	Дани	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар	
14	Йордан	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогддог

15	Испани	Угсаа залгамжилдаг	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	үгүй	2	Шууд сонгуулиар	Шууд болон шууд бус сонгуулиар
16	Их Британи	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогд, залгамжилдаг/ шууд бус сонгуулиар
17	Камбож	Сонгогчдын коллеги, эсхүл Сонгуулийн хорооноос сонгогдоно.	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	
18	Канад	Амбан захирагчийг Эзэн хаан/Хатан хаан томилогддог	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогд
19	Катар	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	1	Томилогд	
20	Кувейт	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар	
21	Лесото	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогд
22	Лихтенштейн	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар	
23	Люксембург	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар	
24	Малайз	Сонгогчдын коллеги, эсхүл Сонгуулийн хорооноос сонгогдоно.	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогд
25	Марокко	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогд
26	Монако	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар	
27	Нидерланд	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Бусад
28	Норвеги	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар	
29	Оман	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогд
30	Папуа Шинэ Гвиней	Амбан захирагчийг Эзэн хаан/Хатан хаан томилогддог	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар	
31	Саудын Араб	Угсаа залгамжилдаг		үгүй	1	Томилогд	
32	Свазиленд	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	2	Орон нутгийн зөвлөлөөс сонгогдох болон томилогд	Доод танхимаасаа сонгогдох болон томилогд

33	Сент Винсент ба Гренадин	Амбан захирагчийг Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар болон томилдог	Шууд сонгуулиар болон томилдог
34	Сент Китс ба Невис	Амбан захирагчийг Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар болон томилдог	Томилогддог
35	Сент Лусиа	Амбан захирагчийг Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогддог
36	Соломоны Арлууд	Амбан захирагчийг Эзэн хаан/Хатан хаан томилдог	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	үгүй	1	Шууд сонгуулиар	Бусад
37	Тайланд	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар болон томилдог
38	Тонга	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар, албан тушаалын дагуу	Бусад
39	Тувалу	Амбан захирагчийг Эзэн хаан/Хатан хаан томилдог	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	үгүй	1	Шууд сонгуулиар	
40	Швед	Угсаа залгамжилдаг	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	үгүй	1	Шууд сонгуулиар	
41	Шинэ Зеланд	Амбан захирагчийг Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар	
42	Ямаик	Амбан захирагчийг Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогддог
43	Япон	Угсаа залгамжилдаг	Шууд бус буюу Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогдоно	үгүй	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар

БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Ө.Мөнхтунгалаа

Сингапур нь 718.3 км² газар нутагтай, нийтдээ 63 жижиг арлаас бүрдэх Зүүн өмнөд Азийн хот улс юм. Тус арал өнөөдөр дэлхий дээрх хамгийн их хүн амын нягтаршилтай газрын нэгд тооцогддог. Засаг захиргааны нэгжийн бүтэц, зохион байгуулалтын асуудлыг Үндсэн хууль болон бие даасан хуулиар тусгайлан зохицуулаагүй байна.

Засаг захиргааны хувьд Сингапур нь 5 тойрогт хуваагддаг. Үүнээс гадна эдийн засгийн төлөвлөлт, статистикийн зорилгоор нутаг дэвсгэрээ 5 бүс болгон авч үздэг байна.

Сингапурын 5 тойргийг тойргийн дарга нар ба Орон Нутгийн Хөгжлийн Зөвлөл (Community Development Council District) удирддаг.

Зөвлөлийн чиг үүрэг, түүний удирдлагын эрх хэмжээ, зохион байгуулалт, үйл ажиллагааг Орон нутгийн хөгжлийн зөвлөлийн дүрэм /Community Development Council Rules 1997/²³-ээр зохицуулна. Орон нутгийн хөгжлийн зөвлөлд засгийн газраас жил бүр тойргийн хүн амын тооноос хамаарч санхүүжилт олгодог.


Орон нутгийн хөгжлийн зөвлөл нь тойрог тус бүрийг хариуцсан салбар зөвлөлийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулна.

Тойргууд нь сонгуулийн тойрогт (*constituencies*) хуваагддаг ба энэхүү сонгуулийн тойрог нь орон нутгийн хотын зөвлөлтэй ижил төстэй юм. Сонгуулийн тойрог нь мөн сонгуулийн хэсэгт хуваагдана (*electoral division/district*).

Сингапур нь дараах 5 тойрогт хуваагдана. Үүнд:

1. Төв Сингапурын тойрог
2. Зүүн- хойд тойрог
3. Баруун- хойд тойрог
4. Зүүн- өмнөд тойрог
5. Баруун-өмнөд тойрог болно.

Зураг 1



²³ Community Development Council Rules 1997/, <http://statutes.agc.gov.sg/aol/search/display/>

Дээр дурдсанчлан Сингапур нь эдийн засгийн төлөвлөлтийн үүднээс нутаг дэвсгэрээ 5 бүс (region) болгон хуваадаг ба эдгээр нь мөн 55 төлөвлөлтийн районд хуваагдана.

Нутаг дэвсгэр нь дараах 5 бүсэд хуваагдана. Үүнд:

1. Төвийн бүс
2. Зүүн бүс
3. Хойд бүс
4. Зүүн- хойд бүс
5. Баруун бүс болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Community Development Council Rules. <http://statutes.agc.gov.sg/aol/search/display/>
2. Administrative divisions of Singapore. <http://www centralsingaporecdc.org.sg/>

ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛЬД ТӨРИЙН ТЭРГҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН СТАТУСЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Ц.Болормаа, Д.Жигваагүнсэл, Б.Нандингэрэл
Ч.Онончимэг, Д.Халиун

1. Судалгаанд НҮБ-ын 192 орны Үндсэн хуулиудыг судлан тухайн улсын төрийн тэргүүнийг хэрхэн тодорхойлсон талаар болон Үндсэн хуульдаа төрийн тэргүүнийг бүх ард түмний бэлэг тэмдэг, ард түмний эв нэгдийн баталгаа хэмээн тодорхойлсон хуулийн зохицуулалтыг шүүн авч үзлээ. Үүнд:
 - а/ Хаантай - 41 улс Үүнээс:
 - Цог жавхлант Элизабет II /Амбан захирагч/ тэргүүлдэг - 16
 - Эзэн хаан /Хаан, Султан, Эмир, Хунтайж, Их ван, Ханхүү/ тэргүүлдэг - 25
 - б/ Ерөнхийлөгчтэй -143 улс.
 - в/ Бусад /Ерөнхийлөгчтэй боловч төрийн тэргүүний үүргийг тусгайлан заасан субъект/ - 8 улс байна. Үүнд:
 - Дээд удирдагч - Иран, Хойд Солонгос;
 - Улсын дарга - Хятад;
 - Тэргүүлэгчид - Босни-Герцеговин;
 - Үндэсний Шилжилтийн Зөвлөл - Ливи;
 - Шилжилтийн үеийн төрийн тэргүүн - Төв Африкийн Бүгд Найрамдах Улс;
 - Хамтарсан эрх баригч - Андorraгийн Хант Улс;
 - Капитан Регент - Сан-Марино зэрэг болно.
2. Үндсэн хуульдаа төрийн тэргүүн нь үндэсний нэгдмэл байдлыг хангах, эв нэгдлийн бэлэгдэл хэмээн
 - тусгасан - 75
 - тусгаагүй - 117 улс байна.

№	Улсын нэр	Төрийн тэргүүнтэй эсэх /Ерөнхийлөгч, хаан г.м/	Төрийн тэргүүний талаарх Үндсэн хуулийн тодорхойлолт /Ерөнхийлөгч нь бүх ард түмний эв нэгдийн илэрхийлэгч гэдэг утга бүхий заалтыг тодруулах үзэх/	Эв нэгдэл	Тайлбар
1	Австрали	Цог жавхлант Элизабет II Амбан захирагч	Хатан хааны томилсон Амбан захирагч нь хатан хааны хүссэн хугацаагаар Хамтын нөхөрлөлийн улсад Цог жавхлант хатан хааныг төлөөлнө. Гэвч Үндсэн хуульд заасны дагуу Цог жавхлант хатан хаанд түүний эрх мэдэл, чиг үүргийг шилжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 2-р зүйл</i>		
2	Австри	Холбооны Ерөнхийлөгч	Холбооны ерөнхийлөгч нь Холбооны ард түмнээс тэгш эрхийн үндсэн дээр шууд, Үндэсний зөвлөлөөс нууц санал хураалтаар сонгогдоно. <i>Үндсэн хуулийн 60-р зүйл</i>		
3	Азербайжан	Ерөнхийлөгч	I. Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Азербайжан улсын тэргүүн байна. Ерөнхийлөгч нь дотоод болон гадаад Азербайджан улсын төрийг төлөөлнө. II. Бүгд Найрамдах Азербайджан улсын ерөнхийлөгч нь ард түмний эв нэгдлийн бэлэг тэмдэг бөгөөд Төрийн залгамж холбоог хангана. <i>Үндсэн хуулийн 8-р зүйл</i>	+	

4	Албани	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн бөгөөд ард түмний эв нэгдлийг илэрхийлнэ. <i>Үндсэн хуулийн 86 зүйл</i>	+	
5	Алжир	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байх бөгөөд үндэсний эв нэгдлийн бэлгэ тэмдэг байна. <i>Үндсэн хуулийн 70 зүйл</i>	+	
6	Ангол	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд Гүйцэтгэх засаглалын тэргүүн, Анголын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. <i>Үндсэн хуулийн 108 зүйл</i>		
7	Андоррагийн Хант улс	Хамтарсан эрх баригч /Co-prince/	1. Андоррагийн төрийн уламжлалын дагуу хамтарсан эрх баригч нар нь төрийн тэргүүний үүргийг хамтран хэрэгжүүлнэ. 2. Хамтарсан эрх баригч нар нь Ургелийн хамба болон Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч нар байна. Тэдгээр нь адил тэгш бүрэн эрхтэй байх бөгөөд энэхүү үндсэн хуульд заасан эрх үүргийг хэрэгжүүлэхээр батламжлах буюу тангараг өргөнө. <i>Үндсэн хуулийн 43-44-р зүйл</i>		Францын ерөнхийлөгч болон Ургелийн Хамба хамтран төрийн тэргүүний үүрэг гүйцэтгэнэ.
8	Антигуа Барбуда	Цог жавхлант Элизабет II Амбан захирагч	Антигуа Барбудагийн Амбан захирагч нь Цог жавхлант хатан хааны томилсон тус улсын харъяат иргэн байх бөгөөд Цог жавхлант хатан хааны хүссэн хугацаагаар Амбан захирагч нь Антигуа Барбуда Цог жавхлант хатан хааныг төлөөлнө. <i>Үндсэн хуулийн 22-р зүйл</i>		Английн хатан хаан Элизабет II-ийн томилсон амбан захирагч төрийн тэргүүн байна.
9	АНУ	Ерөнхийлөгч	-		Үндсэн хуулиар зохицуулаагүй.
10	Арабын Нэгдсэн Эмират Улс	Ерөнхийлөгч	Холбооны дээд зөвлөл нь өөрийн гишүүд дундаас Холбооны Ерөнхийлөгч болон Холбооны Дэд ерөнхийлөгчийн сонгоно. Ерөнхийлөгчийг эзгүйд Дэд ерөнхийлөгч бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 51-р зүйл</i> Холбооны дээд зөвлөл нь 40 гишүүнтэй байх бөгөөд дараах байдлаар хуваарилагдана: Абу Даби - 8 суудал Дубай - 8 суудал Шаржа - 6 суудал Рас аль-Хайма - 6 суудал Ажман - 4 суудал Умм аль-Кайвайн - 4 суудал Фужейра - 4 суудал.		
11	Аргентин	Ерөнхийлөгч	Ард түмнээс "Аргентин Үндэстний Ерөнхийлөгч" хэмээн сонгогдсон Ерөнхийлөгч нь үндэсний гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 87-р зүйл</i>		
12	Ардчилсан Бүгд Найрамдах Конго улс	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах улсын Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн байна. Ерөнхийлөгч нь үндэсний эв нэгдлийн бэлгэ тэмдэг бөгөөд ард түмнээ төлөөлнө... <i>Үндсэн хуулийн 69-р зүйл</i>	+	

13	Армен	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах улсын ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна. Бүгд Найрамдах улсын ерөнхийлөгч нь тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, Бүгд Найрамдах Армен улсын аюулгүй байдлын баталгаа мөн. <i>Үндсэн хуулийн 49-р зүйл</i>	+	
14	Афганистан	Ерөнхийлөгч	Исламийн Бүгд Найрамдах Афганистан улсын төрийн тэргүүн нь Ерөнхийлөгч байх бөгөөд Үндсэн хуульд заасны дагуу гүйцэтгэх, хууль тогтоох, шүүхийн салбарт өөрийн эрх мэдлийг хэрэгжүүлнэ... <i>Үндсэн хуулийн 60-р зүйл</i>		
15	Багамын арал	Цог жавхлант Элизабет II Амбан захирагч	Багамын Амбан захирагч нь Цог жавхлант хатан хааны томилсон тус улсын харъяат иргэн байх бөгөөд Цог жавхлант хатан хааны хүссэн хугацаагаар Багамд Цог жавхлант хатан хааныг төлөөлнө. <i>Үндсэн хуулийн 32-р зүйл</i>		
16	Бангладеш	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн байх бөгөөд Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлж, хуулийн ногдуулсан үүрэг хүлээнэ. <i>Үндсэн хуулийн 48.2-р зүйл</i>		
17	Барбадос	Цог жавхлант Элизабет II Амбан захирагч	Барбадосын Амбан захирагч нь Цог жавхлант хатан хааны томилсон тус улсын харъяат иргэн байх бөгөөд Цог жавхлант хатан хааны хүссэн хугацаагаар тус албан тушаалд байж Барбадост Цог жавхлант хатан хааныг төлөөлнө. <i>Үндсэн хуулийн 28-р зүйл</i>		
18	Бахрейны Вант улс	Хаан	Бахрейны Вант улс нь удам дамжсан үндсэн хуульт хаант засагтай байх бөгөөд Шейх Иса ибн Салман аль-Халифагаас түүний ууган хүү болох Шейх Хамад ибн Иса аль-Халифа үе залгамжилна. Хаан нь өөрийн үе залгамжлагчаар уугаан хүүгээс өөр хүүгээ томилохоос бусад тохиолдолд ууган хүү нь үе залгамжилна. <i>Үндсэн хуулийн 1-р зүйл</i>		
19	Беларус	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Беларусь Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд Үндсэн хууль, хүний болон иргэний эрх, эрх чөлөөний баталгаа байна. Ерөнхийлөгч нь ард түмний эв нэгдлийг хангаж, олон улсын байгууллага болон олон улсын харилцаанд Төрийг төлөөлөж, Беларусь улсын дотоод болон гадаад бодлогыг хэрэгжүүлнэ. Ерөнхийлөгч Бүгд Найрамдах Беларусь улсын бие даасан байдал болон үндэсний аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалж, төрийн эрх мэдлийн байгууллагуудын уялдаа холбоо, төрийн залгамж чанар болон улс төр, эдийн засгийн тогтвортой байдлыг хангана. <i>Үндсэн хуулийн 79-р зүйл</i>	+	

20	Белиз	Цог жавхлант Элизабет II Амбан захирагч	Амбан захирагч нь Белизийн иргэн байх бөгөөд түүнийг Цог жавхлант хатан хаан томилно. Амбан захирагч нь Цог жавхлант хатан хааны хүссэн хугацаанд тус албан тушаалыг хаших бөгөөд Белизд Цог жавхлант хатан хааныг төлөөлнө. <i>Үндсэн хуулийн 30-р зүйл</i>		
21	Бельгийн Вант Улс	Хаан	Үндсэн хууль дахь хааны эрх мэдлийг Эрхэмсэг дээд Саксен-Кобургийн Леопольд-Георг-Христиан-Фредерикийн шууд бөгөөд хууль ёсны өв залгамжлагч эхлэн төрсний эрхийн зарчмаар залгамжилна. Дээр дурдсан өв залгамжлагч нь Хаан, эсхүл түүний эзгүйд Үндсэн хуульд заасан нөхцөлд үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүй гэрлсэн тохиолдолд хаан ширээ залгамжлах эрхээ хасуулна. Хаан, эсхүл түүний эзгүйд Үндсэн хуульд заасан үүрэг гүйцэтгэгч нь хаан ширээ залгамжлах эрхийг хоёр танхимын зөвшөөрөлтэйгээр сэргээж болно. <i>Үндсэн хуулийн 85-р зүйл</i>		
22	Бенин	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна. Ерөнхийлөгч нь ард түмнээс сонгогдох бөгөөд ард түмний эв нэгдлийн бэлгэ тэмдэг байна. Ерөнхийлөгч нь улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын баталгаа болох бөгөөд Үндсэн хууль, олон улсын гэрээг хүндэтгэн сахина. <i>Үндсэн хуулийн 41-р зүйл</i>	+	
23	БНХАУ	Улсын дарга	Ерөнхийлөгч болон Дэд ерөнхийлөгч Ардын Их Хурлаас сонгогдоно. <i>Үндсэн хуулийн 79-р зүйл</i>		Үндсэн хуульдаа төрийн тэргүүн нь хэн байх талаар тодорхой заагаагүй.
24	Болгар	Ерөнхийлөгч	1. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн мөн. Тэрээр олон улсын харилцаанд улс орноо төлөөлөх ба үндэсний нэгдмэл байдлыг хангана. 2. Дэд ерөнхийлөгч нь Ерөнхийлөгчийн аливаа үйл хэрэгт тусална. <i>Үндсэн хуулийн 92-р зүйл</i>	+	
25	Босни-Герцеговины Холбоо	Тэргүүлэгчид	Босни-Герцеговины Тэргүүлэгчид нь гурван гишүүдээс бүрдэнэ. Холбооны нутаг дэвсгэрээс шууд сонгогдсон нэг Хорват, нэг Серби болон Спрскагийн Бүгд Найрамдахаас шууд сонгогдсон нэг тэргүүлэгч тус тус Тэргүүлэгчдийг бүрдүүлнэ. <i>Үндсэн хуулийн 5-р зүйл</i>		3 гишүүнээс бүрдсэн Тэргүүлэгчдийн зөвлөл төрийн тэргүүний үүргийг гүйцэтгэнэ.
26	Бруней Даруссалам улс	Султан	1. Бруней Даруссалам улсын гүйцэтгэх дээд эрх мэдэл нь Цог Жавхлант Султан Янг диПертуанд байна. 1а. Цог Жавхлант Султан Янг диПертуан нь Ерөнхий сайд байна. 1б. Цог Жавхлант Султан Янг диПертуан нь Брунейн Хааны Зэвсэгт хүчний дээд Командлагч байна. <i>Үндсэн хуулийн 4-р зүйл</i>		

27	Буркина Фасо	Ерөнхийлөгч	Фасогийн Ерөнхийлөгч төрийн тэргүүн байна. Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийг дээдлэн Төрийн бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлно. Ерөнхийлөгч нь Үндэсний эв нэгдлийн баталгаа мөн. Ерөнхийлөгч нь улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, Төрийн тасралтгүй залгамж чанарын баталгаа бөгөөд олон улсын гэрээг хүндэтгэн сахина. <i>Үндсэн хуулийн 36-р зүйл</i>	+	
28	Бурунди	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, ард түмний эв нэгдлийн бэлгэдэл бөгөөд Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Төрийн тасралтгүй залгамж чанарыг ханган, төрийн институцын байнгын үйл ажиллагааг батлан даана. <i>Үндсэн хуулийн 35-р зүйл</i>	+	
29	Бутаны Вант улс	Хаан	Бутаны Эзэн Хаан Druk Gyalpo (Луу Хаан) нь төрийн тэргүүн бөгөөд Бутаны вант улсын ард түмний эв нэгдлийн бэлгэ тэмдэг байна. <i>Үндсэн хуулийн 2.1-р зүйл</i>	+	
30	Бүгд Найрамдах Боливи улс	Ерөнхийлөгч	Гүйцэтгэх эрх мэдэл нь улсын Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, төрийн сайд нараас бүрдэнэ. <i>Үндсэн хуулийн 165-р зүйл</i>		Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байх боловч Үндсэн хуульдаа яг үгчлэн заагаагүй байна.
31	Бүгд Найрамдах Ботсван улс	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Ботсван Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 30-р зүйл</i>		
32	Бүгд Найрамдах Конго улс	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн байна. Ерөнхийлөгч нь үндэсний эв нэгдлийг бэхжүүлнэ... <i>Үндсэн хуулийн 56-р зүйл</i>	+	
33	Бүгд Найрамдах Чех улс	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах улсын Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 54-р зүйл</i>		
34	Вануату	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Вануату Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд ард түмний эв нэгдлийг бэлгэдэл байна. <i>Үндсэн хуулийн 33-р зүйл</i>	+	
35	Венесуэль	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн болон гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн бөгөөд Засгийн газрын тэргүүний хувьд засгийн газрын үйл ажиллагааг удирддаг. <i>Үндсэн хуулийн 226-р зүйл</i>		
36	Вьетнам	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд гадаад болон дотоодод улсаа төлөөлнө. <i>Үндсэн хуулийн 86-р зүйл</i>		

37	Габон	Ерөнхийлөгч	Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн мөн. Тэрээр үндсэн хуулийн хэрэгжилтийг хянан сахиж, өөрийн үүрэг үйл ажиллагаагаараа төрийн засаглалын тогтвортой үйл ажиллагаа ба төрийн тогтвортой байдлын баталгаа байна. Ерөнхийлөгч нь үндэсний тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, олон улсын гэрээний биелэлтийн баталгаа мөн. <i>Үндсэн хуулийн 8-р зүйл</i>	+	
38	Гайана	Ерөнхийлөгч	Хамтын нөхөрлөлийн Гайана улс нь Ерөнхийлөгчтэй байх ба, тэрээр төрийн тэргүүн, гүйцэтгэх засаглалын тэргүүн, улсын зэвсэгт хүчний дээд командлагч мөн. <i>Үндсэн хуулийн 89-р зүйл</i>		
39	Гайти	Ерөнхийлөгч	Гүйцэтгэх эрх мэдлийг: а.Төрийн тэргүүн, улсын Ерөнхийлөгч b.Ерөнхий сайдын тэргүүлсэн Засгийн газар тус тус хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 133-р зүйл</i>		
40	Гамби	Ерөнхийлөгч	Гамби улс нь Ерөнхийлөгчтэй байх ба, тэрээр төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн, Зэвсэгт хүчний дээд командлагч мөн. <i>Үндсэн хуулийн 61-р зүйл</i>		
41	Гана	Ерөнхийлөгч	Гана улс нь Ерөнхийлөгчтэй байх ба, тэрээр Төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн, Ганын зэвсэгт хүчний дээд командлагч мөн. <i>Үндсэн хуулийн 57-р зүйл</i>		
42	Гватемал	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь Гватемалын төрийн тэргүүн мөн бөгөөд тэрээр гүйцэтгэх эрх мэдлийг ард түмний мандатаар эдэлнэ. Ерөнхийлөгч нь бүх сайд нартай зөвлөлдөн эсхүл тусдаа тэдгээрийн нэг буюу түүнээс дээш сайд нартай зөвлөлдөн ажиллаж Армийн Ерөнхий командлагч байх ба, үндэстний эв нэгдлийг төлөөлж, улсын нийт хүн амын ашиг сонирхолыг ямагт харгалзана. <i>Үндсэн хуулийн 182-р зүйл</i>	+	
43	Гвиней	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн мөн. Тэрээр Сайд нарын Зөвлөлөө тэргүүлнэ. Тэрээр үндсэн хууль, олон улсын гэрээ хэлэлцээр, шүүхийн хууль, шийдвэрүүдийг хүндэтгэн биелүүлэлтийн баталгаа болно. Тэрээр төрийн захиргааны тогтвортой үйл ажиллагаа, төрийн тогтвортой байдлын баталгаа мөн. Тэрээр улс үндэсний бодлогыг тодорхойлогч, биелэлтийг нь хянагч мөн. Тэрээр үндэсний эв нэгдлийн бэлгэдэл мөн. Улсын Ерөнхийлөгч нь улс төрийн намуудын дээр байна. <i>Үндсэн хуулийн 45-р зүйл</i>	+	

44	Гвиней Бисау	Ерөнхийлөгч	Төрийн Зөвлөлийн Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүн, Ардын хувьсгалт Цэргийн дээд командлагч мөн. Тэрээр Гвиней Бисау улсыг төлөөлнө. <i>Үндсэн хуулийн 65-р зүйл</i>		
45	Герман	Ерөнхийлөгч	1. Холбооны Ерөнхийлөгч нь олон улсын эрх зүйн асуудлаар Холбооны улсыг төлөөлнө. Холбооны Ерөнхийлөгч нь Холбооны нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах бөгөөд дипломат төлөөлөгчдийг томилж, бусад улсын дипломат төлөөлөгчдийг хүлээн авна. <i>Үндсэн хуулийн 59-р зүйл</i>		
46	Гондурас	Ерөнхийлөгч	Гүйцэтгэх эрх мэдлийг ард түмнийг төлөөлж, ард түмний тусын тулд Улсын Ерөнхийлөгч, түүний эзгүйд Дэд Ерөнхийлөгч хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 235-р зүйл</i>		
47	Грек	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Улсын институцийн ажиллагааг хангана. Тэрээр Үндсэн хуулийн 32, 33-р зүйлд заасны дагуу Парламентаас 5 жилийн хугацаагаар сонгогдоно. <i>Үндсэн хуулийн 30-р зүйл</i>		
48	Гренада	Цог жавхлант Элизабет II Амбан захирагч	Гренадыг Амбан захирагч удирдах ба, түүнийг Цог жавхлант Хатан хаан томилж, өөрийн таалсан хугацаагаараа ажиллуулах ба, тэрээр Гренада дахь хатан хааны төлөөлөгч мөн. <i>Үндсэн хуулийн 19-р зүйл</i>		
49	Гүрж	Ерөнхийлөгч	Гүрж улсын Ерөнхийлөгч бол Гүржийн төрийн тэргүүн, улс үндэстний тусгаар тогтнол ба улсын нэгдмэл байдлын баталгаа мөн. <i>Үндсэн хуулийн 69-р зүйл</i>	+	
50	Данийн Вант Улс	Хаан	Хаан болон парламент (Folketinget) хамтран хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлнэ. Гүйцэтгэх эрх мэдэл Хаанд хадгалагдана. <i>Үндсэн хуулийн 3-р зүйл</i>		
51	Доминика	Ерөнхийлөгч	18. Доминика улсын Ерөнхийлөгч нь Танхим (парламентын доод танхим)-аас 5 жилийн хугацаагаар томилогдоно. 29. Доминика улсын парламент нь Ерөнхийлөгч болон Ассамблейн Танхимаас бүрдэнэ. <i>Үндсэн хуулийн 18, 29-р зүйл</i>		Төрийн тэргүүн хэн байх талаар Үндсэн хуульд тусгайлан заагаагүй.
52	Доминиканы Бүгд Найрамдах Улс	Ерөнхийлөгч	Гүйцэтгэх эрх мэдлийг улсын Ерөнхийлөгч ард түмний нэрийн өмнөөс энэ Үндсэн хууль болон бусад хуульд заасанчлан төрийн болон засгийн газрын тэргүүний хувиар хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 122-р зүйл</i>		

53	Египет	Ерөнхийлөгч	Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, гүйцэтгэх засаглалын тэргүүн мөн. Тэрээр ард түмнийхээ ашиг сонирхолыг харгалзаж, улс үндэстнийхээ тусгаар тогтнол, нутагт дэвсгэрийн нэгдмэл ба аюулгүй байдлыг хамгаалж Үндсэн хуульд заасанчлан өөрийн эрх мэдлийг хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 139-р зүйл</i>	+	
54	Жибути	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах улсын Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн байна. Ерөнхийлөгч нь үндэсний эв нэгдлийн илэрхийлэгч бөгөөд Төрийн залгамж чанарын баталгаа мөн... <i>Үндсэн хуулийн 22-р зүйл</i>	+	
55	Зимбабве	Ерөнхийлөгч	Улсын Ерөнхийлөгч нь Засгийн газрын тэргүүн бөгөөд Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. 2/ Ерөнхийлөгч нь а. Зимбабве улсын бүх ард түмний сайн сайхан, үндэстний эв нэгдэл, энх тайвныг дэмжих; ... <i>Үндсэн хуулийн 89, 90-р зүйл</i>	+	
56	Замби	Ерөнхийлөгч	1/ Замбийн Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн бөгөөд Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. <i>Үндсэн хуулийн 33-р зүйл</i>		
57	Зүүн Тимор	Ерөнхийлөгч	1. Бүгд Найрамдах Ардчидсан Зүүн Тимор Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, үндэсний тусгаар тогтнол, төрийн, ардчилсан байгууллагуудын байнгын үйл ажиллагааны эв нэгдлийн бэлгэдэл, баталгаа юм. <i>Үндсэн хуулийн 74-р зүйл</i>	+	
58	Йемен	Ерөнхийлөгч	а/ Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд Үндсэн хуульд заасны дагуу сонгогдоно. Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь Үндсэн хуулиа дээдлэн, үндэсний эв нэгдлийг хамгаална. <i>Үндсэн хуулийн 106, 110-р зүйл</i>	+	
59	Израиль	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн мөн. <i>Үндсэн хуулийн 1-р зүйл</i>		
60	Индонез	Ерөнхийлөгч	1.Индонез Улсын Ерөнхийлөгч нь үндсэн хуулийн дагуу засгийн газрын эрх мэдлийг хэрэгжүүлнэ. 2.Өөрийн үүргийг гүйцэтгэхэд нь Ерөнхийлөгчид Дэд Ерөнхийлөгч туслана. <i>Үндсэн хуулийн 4-р зүйл</i>		
61	Йордан	Эзэн хаан	Йорданы Хашимитын Вант Улсын хаан ширээг Абдуллах ибн аль-Хуссейн хааны эрэгтэй угсаа залгамжлагчид залгамжилна. <i>Үндсэн хуулийн 28-р зүйл</i>		

62	Ирак	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, улс орны эв нэгдэл, тусгаар тогтнолын бэлэг тэмдэг мөн. Тэрээр Үндсэн хуульд заасны дагуу Үндсэн хуулийн хариуцлага болон Иракийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эв нэгдлийг хадгалах, нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын баталгаа мөн. <i>Үндсэн хуулийн 67-р зүйл</i>	+	
63	Иран	Дээд удирдагч	Ерөнхийлөгч нь Удирдагчийн албаны дараа орох улсын хамгийн дээд албан тушаалтан мөн. Түүнийг үүрэг хариуцлага нь үндсэн хуулийг хэрэгжүүлэх, Удирдагч (ийн алба)-тай шууд хамааралтайгаас бусад бүх асуудалд гүйцэтгэх засаглалын тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 113-р зүйл /5-р зүйл, 57-р зүйл/</i>		
64	Ирланд	Ерөнхийлөгч	Ирланд нь Ерөнхийлөгчтэй байна (Uachtarán na hÉireann), цаашид Ерөнхийлөгч хэмээнэ. Тэрээр төрийн албаны бусад бүх хүмүүсээс дээд нэгэн бөгөөд Үндсэн хууль болон бусад хуулиар Ерөнхийлөгчид олгосон эрх мэдэл, үүргийг гүйцэтгэнэ. <i>Үндсэн хуулийн 12-р зүйл</i>		
65	Исланд	Ерөнхийлөгч	Альтинг ба Исландын Ерөнхийлөгч нь хууль тогтоох эрх мэдлийг хамтран хэрэгжүүлнэ. Ерөнхийлөгч ба энэ хууль болон бусад хуульд заасан засгийн газрын албадууд нь гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 2-р зүйл</i>		
66	Испани	Хаан	Хаан нь төрийн тэргүүн, ард түмний эв нэгдэлийн бэлэг тэмдэг юм. Тэрээр олон улсын харилцаанд Испани Улсыг бүрэн эрхтэй төлөөлөх бөгөөд Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 56-р зүйл</i>	+	
67	Итали	Ерөнхийлөгч	Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн бөгөөд үндэсний эв нэгдлийн илэрхийлэл мөн. <i>Үндсэн хуулийн 87-р зүйл</i>	+	
68	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс	Цог жавхлант Элизабет II	Хаан ширээ залгамжлах тухай хууль 2013-ийн талбарын 6-д: ИБУИНВУ болон Хамтын Нөхөрлөлийн бусад 15 орны төрийн тэргүүн Эрхэмсэг дээд Хатан Хаан мөн. ²⁴		
69	Кабо Верде	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн болон ард түмний эв нэгдэл, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын тусгаар тогтнолын баталгаа байна. Ерөнхийлөгч нь Үндсэн хууль болон олон улсын гэрээний биелэлтийг сахин хамгаална. <i>Үндсэн хуулийн 137-р зүйл</i>	+	

²⁴ <http://www.legislation.gov.uk/ukpga/2013/20/notes/division/3>

70	Казахстан	Ерөнхийлөгч	1.Казакстан Улсын Ерөнхийлөгч нь төрүүн тэргүүн, төрийн дотоод ба гадаад бодлогын үндсэн чиг шугамыг тодорхойлогч хамгийн дээд албан тушаалтан, Казакстаныг дотоод ба гадаад харилцаанд төлөөлөгч мөн. 2. Улсын Ерөнхийлөгч нь ард түмний эв нэгдэл, төрийн эрх мэдэл, үндсэн хууль болон иргэний, хувь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхгүй байхын бэлгэдэл бөгөөд баталгаа мөн. 3. Улсын Ерөнхийлөгч нь өөрийн үйл ажиллагаагаараа төрийн эрх мэдлийн бүх салбарын үүрэг, үйл ажиллагааны тууштай байдал, эрх барих байгууллагуудын ард түмний өмнө хүлээх үүрэг хариуцлагын баталгаа мөн. <i>Үндсэн хуулийн 40-р зүйл</i>	+	
71	Камбожийн Вант улс	Хаан	Хаан нь төрийн тэргүүн бөгөөд халдашгүй дархан байна. Камбожийн хаан нь ард түмний эв нэгдэл, үүрд мөнхийн бэлгэ тэмдэг байна. Хаан нь үндэсний тусгаар тогтнол, Камбожийн Вант улсын бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, иргэдийн эрх, эрх чөлөө, олон улсын гэрээний баталгаа мөн. <i>Үндсэн хуулийн 7 болон 8-р зүйл</i>	+	
72	Камерун	Ерөнхийлөгч	1.Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна. 2. Бүх ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгч нь ард түмний эв нэгдлийн бэлгэ тэмдэг байна... <i>Үндсэн хуулийн 5-р зүйл</i>	+	
73	Канад	Цог жавхлант Элизабет II Амбан захирагч	Хааны цол хэргэмийн тухай хууль /Royal Style and Titles Act 1985/ ²⁵		
74	Катар	Хаан	Ханхүү нь төрийн тэргүүн байх бөгөөд халдашгүй, дархан байна. Ханхүү нь зэвсэгт хүчний ерөнхий командлагч бөгөөд түүний шууд удирдлага дор ажиллах Зөвлөлөөр дамжуулж бүх шийдвэрийг гаргана. <i>Үндсэн хуулийн 64, 65-р зүйл</i>		
75	Кени	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь: а. Төрийн болон Засгийн газрын тэргүүн с. Кенийн Зэвсэгт хүчний командлагч е. Үндэсний эв нэгдлийн бэлэг тэмдэг <i>Үндсэн хуулийн 131-р зүйл</i>	+	
76	Кипр	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах улсын Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн байх бөгөөд дээд эрх мэдлийг хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 36-р зүйл</i>		
77	Колумби	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь ард түмний эв нэгдлийн бэлгэ тэмдэг байна. Бүгд Найрамдах улсын Ерөнхийлөгч нь удирдлагын дээд эрх мэдлийг хэрэгжүүлэх бөгөөд Төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 188, 189-р зүйл</i>	+	

²⁵ <http://laws.justice.gc.ca/eng/acts/R-12/page-1.html>

78	Коморосын Холбооны улс	Ерөнхийлөгч	Холбооны Ерөнхийлөгч нь үндэсний эв нэгдлийн бэлгэ тэмдэг байна. ... Холбооны Ерөнхийлөгч нь засгийн газрын тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 12-р зүйл</i>	+	
79	Коста Рика	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах улсын Ерөнхийлөгч болон Засгийн газрын сайд нар хамтран ард түмний нэрийн өмнөөс Гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 130-р зүйл</i>		Төрийн тэргүүн хэн байх талаар тодорхой заалт Үндсэн хуульд байхгүй.
80	Кот д'Ивуар	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах улсын Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн байна. Ерөнхийлөгч нь үндэсний эв нэгдлийн бэлгэ тэмдэг байна... <i>Үндсэн хуулийн 34 зүйл</i>	+	
81	Кирибати	Ерөнхийлөгч	Кирибати нь Ерөнхийлөгчтэй байх ба түүнийг Беретитенти (Beretitenti) гэнэ. 2. Беретитенти нь Төрийн тэргүүн ба Засгийн газрын тэргүүн мөн. <i>Үндсэн хуулийн 81-р зүйл</i>		
82	Куба	Ерөнхийлөгч	Төрийн зөвлөлийн Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн болон Засгийн газрын тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 74-р зүйл</i>		
83	Кувейт	Эмир	Кувейт нь Мубарак Аль Сабахын удмын угсаа залгамжлагч Эмирт улс мөн. <i>Үндсэн хуулийн 4-р үйл</i>		
84	Кыргызстан	Ерөнхийлөгч	1.Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн мөн. 2. Ерөнхийлөгч нь ард түмэн, төрийн эрх мэдлийг эв нэгдлийн бэлэг тэмдэг мөн. <i>Үндсэн хуулийн 60-р зүйл</i>	+	
85	Лаос	Ерөнхийлөгч	Төрийн Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын төрийн тэргүүн бөгөөд дотоодод болон гадаадад Лаосын олон үндэстэн ард түмний төлөөлөгч мөн. <i>Үндсэн хуулийн 65-р зүйл</i>		
86	Латви	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь олон улсын харилцаанд төрийг төлөөлж, Латвийн дипломат төлөөлөгчдийг томилж, бусад улсын дипломат төлөөлөгчдийг хүлээн авна. Ерөнхийлөгч нь олон улсын хэлэлцээрт нэгдэн орохтой холбоотой Саеямагийн шийдвэрүүдийг хэрэгжүүлнэ. 42-р зүйл. Ерөнхийлөгч нь Латвийн Зэвсэгт хүчний ерөнхий командлагч мөн. Дайны цагт Ерөнхийлөгч нь дээд командлагчийг томилно. <i>Үндсэн хуулийн 41-р зүйл</i>		
87	Лесото	Хаан	Хаан нь Үндсэн хуульт эзэн хаант Лесото улсын төрийн тэргүүн мөн. <i>Үндсэн хуулийн 44-р зүйл</i>		

88	Либерии	Ерөнхийлөгч	Улсын гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхийлөгч эдлэх ба, тэрээр Либерийн төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч мөн. <i>Үндсэн хуулийн 50-р зүйл</i>		
89	Ливан	Ерөнхийлөгч	Улсын Ерөнхийлөгч нь Төрийн удирдагч бөгөөд улс орны эв нэгдлийн бэлгэдэл мөн. Тэрээр үндсэн хуулийг дээдэлж, Ливаны тусгаар тогтнол, түүний эв нэгдэл, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангана. Тэрээр Батлах Хамгаалахын дээд зөвлөлийг даргална, Сайд нарын Зөвлөлийн эрх мэдэлд байх зэвсэгт хүчний Ерөнхий командлагч мөн. <i>Үндсэн хуулийн 49-р зүйл</i>	+	
90	Ливи	Үндэсний Шилжилтийн Зөвлөл	Ливийн төрийн хамгийн дээд эрх мэдэл Үндэсний Шилжилтийн Зөвлөлд байх бөгөөд энэ нь төрийн ерөнхий бодлогыг тодорхойлох, хууль тогтоох зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Энэ бол 2-р сарын 17-ны хувьсгалаар Ливийн ард түмний цорын ганц хууль ёсны төлөөлөл мөн. Энэ нь үндэсний эв нэгдэл, улсын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал, үнэт зүйл ба ёс суртахууны тодорхойлолт, тэдгээрийг дэлгэрүүлэх ажил, иргэд ба оршин суугчдын аюулгүй байдал, олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орох ба иргэний үндсэн хуульт, ардчилсан төрийн үндсийг байгуулах зэргийн баталгаа мөн. <i>Үндсэн хуулийн 17-р зүйл</i>	+	Үндэсний Шилжилтийн Зөвлөл
91	Литва	Ерөнхийлөгч	Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн мөн. <i>Үндсэн хуулийн 77-р зүйл</i>		
92	Лихтенштейн	Хунтайж	Регент Хунтайж нь төрийн тэргүүн бөгөөд энэ Үндсэн хууль ба бусад хуулийн заалтуудад нийцүүлэн бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 7-р зүйл</i>		
93	Люксембург	Их ван	Их ван нь төрийн тэргүүн, түүний эв нэгдлийн бэлгэдэл, улс үндэстний тусгаар тогтнолын баталгаа мөн. Тэрээр үндсэн хууль болон улсын бусад хуулиудад нийцүүлэн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 33-р зүйл</i>	+	
94	Маврикий	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Улсын төрийн тэргүүн, ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийг сахин хамгаалж, хууль дээдэлж, Маврикийн үндэсний эв нэгдлийг хадгалж, бэхжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 28-р зүйл</i>	+	

95	Мавритани	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Улсын төрийн тэргүүн байна. Тэрээр муслим шашинтай байна. Ерөнхийлөгч нь улсын бие даасан, хараат бус байдал, нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдлын баталгаа мөн. <i>Үндсэн хуулийн 23, 24-р зүйл</i>	+	
96	Мадагаскар	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, ард түмний эрх мэдэл, тогтвортой байдлын баталгаа байна. <i>Үндсэн хуулийн 45-р зүйл</i>	+	
97	Македон	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Македон Улсын Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Улсаа төлөөнө. Бүгд Найрамдах Македон Улсын Ерөнхийлөгч нь Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд өөрийн үндсэн эрх, үүргийг гүйцэтгэнэ. <i>Үндсэн хуулийн 79-р зүйл</i>		
98	Малави	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн, Бүгд Найрамдах Малави Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. <i>Үндсэн хуулийн 78-р зүйл</i>		
99	Малайз	Хаан	Хаан нь Холбооны улсын тэргүүн байх бөгөөд түүнийг Янг диПертуан Агонг гэж нэрлэнэ. Тэрээр Холбооны Улсын бусад хүмүүсээс дээд нэгэн бөгөөд 15-р хэсэгт заасны дагуу байгуулагдсан тусгай шүүхээс бусад шүүхийн өмнө хариуцлага хүлээхгүй. <i>Үндсэн хуулийн 32-р зүйл</i>		
100	Мали	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь БНУлсын төрийн тэргүүн, үндсэн хуулийн сахин хамгаалагч байна. Ерөнхийлөгч нь үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, ард түмний эрх мэдэл, төрийн тогтвортой байдлын баталгаа байна. Ерөнхийлөгч нь улсын гэрээ, олон улсын гэрээ хэлэлцээрийг хүндэтгэнэ. <i>Үндсэн хуулийн 29-р зүйл</i>	+	
101	Мальдив	Ерөнхийлөгч	б. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. в. Ерөнхийлөгч нь Үндсэн хуулиа сахин хамгаалж, дээдэлж, төрийн эв нэгдлийг хангана. <i>Үндсэн хуулийн 106-р зүйл</i>	+	
102	Мальт	Ерөнхийлөгч	Мальт Улсын парламент нь Ерөнхийлөгч, төлөөлөгчдийн танхимаас бүрдэнэ. Ерөнхийлөгч нь засгийн газрын тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 51, 78-р зүйл</i>		

103	Марокко	Хаан	Марокко Улсын хаан нь Төрийн тэргүүн, Дээд төлөөлөгч, үндэсний эв нэгдлийн бэлэг тэмдэг, байнгын болон улсын дээд арбитрын тасралтгүй байдлын баталгаа бөгөөд иргэдийн эрх, эрх чөлөө, ардчилсан сонголтыг хамгаалж, үндсэн хууль, вант улсын олон улсад өгсөн амлалтыг хүндэтгэн үзнэ. <i>Үндсэн хуулийн 42-р зүйл</i>	+	
104	Маршаллын арлууд	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Маршаллын арлуудын төрийн тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 3 -р зүйл</i>		
105	Мексик	Ерөнхийлөгч	Холбооны гүйцэтгэх дээд эрх мэдлийг нэг хүн хэрэгжүүлэх бөгөөд тэрээр Мексикийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч байна. <i>Үндсэн хуулийн 80-р зүйл</i>		
106	Микронез	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Улсын төрийн тэргүүн байна. Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Улсын засгийн газрын тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 10-р зүйл</i>	+	
107	Мозамбик	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд үндэсний эв нэгдлийг илэрхийлж, улсаа дотоод болон олон улсын хэмжээнд төлөөлж, төрийн үйл ажиллагааг хянана. <i>Үндсэн хуулийн 146-р зүйл</i>	+	
108	Молдав	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Молдав Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна. Молдав Улсын Ерөнхийлөгч нь үндэсний тусгаар тогтнол, бие даасан байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, нэгдмэл байдлын баталгаа болно. <i>Үндсэн хуулийн 77-р зүйл</i>	+	
109	Монако	Ханхүү	Хэмжээгүй эрхт хаан нь халдашгүй дархан бөгөөд гүйцэтгэх засаглалын тэргүүн байна. Хууль тогтоох эрх мэдэл нь ханхүү болон үндэсний зөвлөлд байна. <i>Үндсэн хуулийн 3, 4-р зүйл</i>		
110	Монгол	Ерөнхийлөгч	Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн. <i>Үндсэн хуулийн 30-р зүйл</i>	+	
111	Мьянмар	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь холбооны улсын тэргүүн, холбооны засгийн газрын тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 16-р зүйл</i>		
112	Намиби	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүн, батлан хамгаалах хүчний ерөнхий командлагч байна. <i>Үндсэн хуулийн 27-р зүйл</i>		
113	Науру	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь Засгийн газрын тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 3-р бүлэг</i>		

114	Непал/Балба	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь улс орны төрийн тэргүүн бөгөөд Үндсэн хууль, хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүрээнд өөрийн эрх үүргээ хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 36-а-р зүйл</i>		
115	Нигер	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна. Ерөнхийлөгч нь үндэсний тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдлийн баталгаа юм. Ерөнхийлөгч нь олон нийтийн эрх мэдэл, үйл ажиллагаа, төрийн залгамж халааг баталгаажуулна. <i>Үндсэн хуулийн 46-р зүйл</i>	+	
116	Нигери	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, холбооны засгийн газрын тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. <i>Үндсэн хуулийн 130-р зүйл</i>		
117	Нидерланд	Хаан	Хаан ширээг өв залгамжлах бөгөөд Уильям I, жонон Оранж-Нассагийн хууль ёсны өв залгамжлагчид залгамжлана. <i>Үндсэн хуулийн 24-р зүйл</i>		
118	Никарагуа	Ерөнхийлөгч	Гүйцэтгэх эрх мэдлийг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч хэрэгжүүлэх бөгөөд тэрээр улсын тэргүүн, Засгийн газрын тэргүүн болон Никарагуагийн армийн Дээд дарга байна. <i>Үндсэн хуулийн 144-р зүйл</i>		
119	Норвег	Хаан	Хаант улсын гүйцэтгэх эрх мэдэл хаанд байна. Хаан нь тэнгисийн цэргийн хүчний ерөнхий командлагч байна. <i>Үндсэн хуулийн 3, 9-р зүйл</i>		
120	Оман	Хаан	Эрхэм дээд хаан Султан нь зэвсэгт хүчний ерөнхий командлагч бөгөөд халдашгүй дархан байна. Түүний тушаалыг даган биелүүлж, хүндэтгэх үүрэгтэй. Султан нь үндэсний эв нэгдлийн бэлэг тэмдэг, сахин хамгаалагч байна. <i>Үндсэн хуулийн 41-р зүйл</i>	+	
121	ОХУ	Ерөнхийлөгч	Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна. Ерөнхийлөгч нь Үндсэн хууль, иргэний эрх, эрх чөлөөний баталгаа байна. <i>Үндсэн хуулийн 80-р зүйл</i>		
122	Өмнөд Африк	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь а. Бүгд Найрамдах Улсын төрийн тэргүүн байна; б. Бүгд Найрамдах Улсын дээд хууль болох Үндсэн хуулийг хүндэтгэн сахин хамгаалана; в. Бүгд Найрамдах Улсын үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолыг хангана. <i>Үндсэн хуулийн 83-р зүйл</i>	+	

123	Өмнөд Солонгос	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд гадаад улсад улсаа бүрэн эрхтэй төлөөлнө. Ерөнхийлөгч нь улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, Үндсэн хуулийг сахин хамгаалах үүрэгтэй. Ерөнхийлөгч өөрийн улсын энх тайван, эв нэгдлийн төлөө чин сэтгэлээр ажиллах үүрэгтэй. Төрийн гүйцэтгэх эрх мэдэл нь Ерөнхийлөгчийн тэргүүлэх Засгийн газарт хадгалагдана. <i>Үндсэн хуулийн 66-р зүйл</i>	+	
124	Өмнөд Судан	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь 3/ Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсын Ерөнхийлөгч нь төрийн болон Засгийн газрын тэргүүн, Суданы ардын чөлөөлөх арми болон бусад бүх байнгын цэргийн дээд командлагч, тэргүүн юм. Ерөнхийлөгч нь ард түмний эв нэгдэл, хүслийг илэрхийлэх ба энэ нь Үндсэн хуулиар олгосон бүрэн эрхээр хэрэгжинэ. <i>Үндсэн хуулийн 97-р зүйл</i>	+	
125	Пакистан	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байх бөгөөд Бүгд найрамдах улсын эв нэгдлийн илэрхийлэл байна. <i>Үндсэн хуулийн 41-р зүйл</i>	+	
126	Палау	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь Засгийн газрын тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 8-р зүйл</i>		
127	Панам	Ерөнхийлөгч	Гүйцэтгэх эрх мэдлийг энэхүү Үндсэн хуульд заасны дагуу Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч болон Төрийн сайд нар хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 175-р зүйл</i>		
128	Папуа шинэ Гвиней	Цог жавхлант Элизабет II Амбан захирагч	Хатан хаан 2-р Элизабет нь Папуа шинэ Гвиней болон хамтын нөхөрлөлийн орнуудын хатан хаан байна. Амбан захирагч нь тусгай ажилтан, ерөнхий сайд, сөрөг хүчний удирдагч, дэд ахлагч байна. <i>Үндсэн хуулийн 26, 82-р зүйл</i>		
129	Парагвай	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглалын тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 226-р зүйл</i>		
130	Перу	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд үндэстнийг төлөөлнө. <i>Үндсэн хуулийн 110-р зүйл</i>		
131	Польш	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Польш Улсыг төлөөлөх хамгийн дээд төлөөлөгч, улсын удирдлага тасралгүй явагдах баталгаа мөн. Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангаж, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын баталгаа мөн. <i>Үндсэн хуулийн 126-р зүйл</i>		

132	Португал	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Португал Улсыг төлөөлж, үндэсний тусгаар тогтнол, төрийн эв нэгдэл, ардчилсан засаглалын институцийн тогтвортой байдлын баталгаа байх бөгөөд албан тушаалын дагуу зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. <i>Үндсэн хуулийн 120-р зүйл</i>	+	
133	Руанда	Ерөнхийлөгч	1.Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна. 2.Ерөнхийлөгч нь Үндсэн хууль, үндэсний эв нэгдлийн баталгаа юм. 3.Ерөнхийлөгч нь тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, төрийн залгамж халааг баталгаажуулж, улсын болон олон улсын гэрээ хэлэлцээрийг хүндэтгэнэ. <i>Үндсэн хуулийн 98-р зүйл</i>	+	
134	Румын	Ерөнхийлөгч	Румын улсын Ерөнхийлөгч нь улсаа төлөөлөх бөгөд үндэсний тусгаар тогтнол, эв нэгдэл, газар нутгийн бүрэн бүтэн байдлын баталгаа юм. <i>Үндсэн хуулийн 80-р зүйл</i>	+	
135	Самоа	Ерөнхийлөгч	Төрийн тэргүүнийг Парламентаас сонгоно. Самоа улсын төрийн тэргүүн нь Ерөнхийлөгч буюу Засгийн газрын ахлагч (O le Ao o le Malo) байна.		
136	Сан-Марино	Капитан Регент	Төрийн тэргүүн нь хоёр Капитан Регент /Төр баригч ахмад/ байна. Капитан Регентууд нь үндэсний нэгдмэл улсыг төлөөлж, үндсэн хуулийн дээд баталгаа байна. <i>Үндсэн хуулийн 3-р зүйл</i>	+	
137	Сан-Томе ба Принсипи	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Сан-Томе Принсипи ардчилсан улсын тусгаар тогтнол, тогтвортой байдлын баталгаа байна. <i>Үндсэн хуулийн 73-р зүйл</i>	+	
138	Саудын Араб	Хаан	Хаан нь Шариатын хуулийн дагуу улсаа захирах бөгөөд улсын ерөнхий бодлого, батлан хамгаалах бодлогоо тодорхойлно. <i>Үндсэн хуулийн 55-р зүйл</i>		
139	Свазиланд	Хаан	Хаан iNgwenyama нь Свазиланд үндэсний үүрдийн мөнхийн эв нэгдлийн бэлэг тэмдэг юм. <i>Үндсэн хуулийн 4-р зүйл</i>	+	
140	Сейшелийн Арлууд	Ерөнхийлөгч	- Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлын хувьд зохицуулалт байхгүй. Харин Үндсэн хуульд заасан иргэн бүрийн үүрэгт / Үндсэн хуулийн 40.в-т/ тусгасан байна.		
141	Сенегал	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийг сахин хамгаална. Тэрээр Сенегалын хэл, соёлыг хадгалан хамгаалагч байна. Тэрээр үндэсний эв нэгдлийн баталгаа мөн. <i>Үндсэн хуулийн 42-р зүйл</i>	+	

142	Сент-Винсент ба Гренадин	Цог жавхлант Элизабет II Амбан захирагч	Сент-Винсент ба Гренадин улсыг Амбан захирагч удирдах ба, түүнийг Цог жавхлант Хатан хаан өөрийн томилж, таалсан хугацаагаар Сент-Винсент ба Гренадин дахь хатан хааны төлөөлөгч мөн. <i>Үндсэн хуулийн 19-р зүйл</i>		
143	Сент-Китс ба Невис	Цог жавхлант Элизабет II Амбан захирагч	Сент-Китс ба Невис улсыг Амбан захирагч удирдах ба, түүнийг Цог жавхлант Хатан хаан томилж, өөрийн таалсан хугацаагаараа ажиллуулах ба, тэрээр Сент-Китс ба Невис дахь Хатан хааны төлөөлөгч мөн. <i>Үндсэн хуулийн 21-р зүйл</i>		
144	Сент-Люсия	Цог жавхлант Элизабет II Амбан захирагч	Сент-Люсия улсын Амбан захирагч удирдах ба, түүнийг Цог жавхлант Хатан хаан томилж, өөрийн таалсан хугацаагаараа ажиллуулах ба, тэрээр Сент-Люсия дахь Хатан хааны төлөөлөгч мөн. <i>Үндсэн хуулийн 19-р зүйл</i>		
145	Серби	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Серби Улсын Ерөнхийлөгч нь Серби улсын эв нэгдлийг илэрхийлэх ёстой. <i>Үндсэн хуулийн 111-р зүйл</i>	+	
146	Сингапур	Ерөнхийлөгч	1. Сингапурын Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн байх бөгөөд энхүү Үндсэн хууль, бусад хуулийн дагуу түүнд олгосон эрх, чиг үүргийг хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 17-р зүйл</i>		
147	Сири	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч болон Ерөнхий сайд нь ард түмнээ төлөөлөж гүйцэтгэх эрх мэдлийг Үндсэн хуульд заасан хүрээнд хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 83-р зүйл</i>		Төрийн тэргүүн хэн байх талаар тодорхой заалт байхгүй.
148	Словак	Ерөнхийлөгч	1. Словакийн төрийн тэргүүн нь Ерөнхийлөгч байна. Ерөнхийлөгч нь гадаадад болон дотоодод Бүгд Найрамдах Словак Улсыг төлөөлөх бөгөөд Үндсэн хуулийн институцийн үйл ажиллагааны тогтвортой ажиллагааг хангана. <i>Үндсэн хуулийн 101-р зүйл</i>		
149	Соломоны Арлууд	Цог жавхлант Элизабет II Амбан захирагч	Цог жавхлант Хатан хаан нь төрийн тэргүүн байна. 27-р зүйл. Соломоны Арлуудын Амбан Захирагчийг Парламентаас нэр дэвшүүлж Төрийн тэргүүн томилох бөгөөд тэрээр Соломоны Арал дахь Хатан хааны төлөөлөгч байна. <i>Үндсэн хуулийн 16-р зүйл</i>		
150	Сомали	Ерөнхийлөгч	1/ Бүгд Найрамдах Ардчилсан Сомали Улсын Ерөнхийлөгч нь: а. Бүгд Найрамдах Ардчилсан Сомали улсын төрийн тэргүүн; б. Үндэсний эв нэгдлийн бэлгэ тэмдэг, в. Үндсэн хуулийг сахин биелүүлэгч, хамгаалагч байна. 2/ Бүгд Найрамдах Ардчилсан Сомали Улсын Ерөнхийлөгч Сомали улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу өөрийн үүргийг гүйцэтгэнэ. <i>Үндсэн хуулийн 87-р зүйл</i>	+	

151	Судан	Ерөнхийлөгч	1. Бүгд Найрамдах улсын төрийн дээд удирдлага нь Ерөнхийлөгч болон хоёр дэд ерөнхийлөгчөөс бүрдэнэ. 2. Энх тайвны гэрээ, улс орны тогтвортой байдлыг хамгаалах, хэрэгжүүлэх зорилгоор төрийн дээд удирдлагыг хамтран хэрэгжүүлэх, хамтын шийдвэр гаргана. <i>Үндсэн хуулийн 52-р зүйл</i>	+	
152	Суринам	Ерөнхийлөгч	1. Бүгд Найрамдах Суринам Улсын Ерөнхийлөгч нь Засгийн газрын тэргүүн, Төрийн зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 90-р зүйл</i>		
153	Сьерра Леон	Ерөнхийлөгч	1. Сьера Леон Улсын Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Улсын Төрийн тэргүүн, Зэвсэгт хүчний дээд командлагч байна. 2. Ерөнхийлөгч шударга ёс, үндэсний эв нэгдэл, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг байх ёстой. 3. Ерөнхийлөгч Үндсэн хуулийн баталгаа, үндэсний тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг батлан хамгаалах бөгөөд олон улсын гэрээг хүндэтгэнэ. <i>Үндсэн хуулийн 40-р зүйл</i>	+	
154	Тажикистан	Ерөнхийлөгч	Тажикистан Улсын Ерөнхийлөгч нь Төрийн болон гүйцэтгэх эрх мэдлийн (Засгийн газар) тэргүүн байна. Ерөнхийлөгч нь Үндсэн хууль болон бусад хуулийг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон иргэн, хүний эрх, эрх чөлөө, үндэсний тусгаар тогтнол, эв нэгдэл, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг ханган ажиллана. <i>Үндсэн хуулийн 64-р зүйл</i>	+	
155	Тайланд	Хаан	Тайланд нь ардчилсан дэглэм бүхий улс бөгөөд төрийн тэргүүн нь Хаан байна. <i>Үндсэн хуулийн 2-р зүйл</i>		
156	Танзани	Ерөнхийлөгч	2. Ерөнхийлөгч төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. <i>Үндсэн хуулийн 33-р зүйл</i>		
157	Того	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна. Ерөнхийлөгч нь Үндсэн хууль болон олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийг даган мөрдөж, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолын баталгаа байна. <i>Үндсэн хуулийн 58-р зүйл</i>	+	
158	Тонга	Хаан	Хаант Улсын төрийн байгуулалт нь Үндсэн хуульт хаант засагтай бөгөөд Эрхэмсэг дээд Хаан Тауфаахау Тупоу IV-ийн өв залгамжлагч нь хаан ширээг залгамжилна. <i>Үндсэн хуулийн 31-р зүйл</i>		

159	Төв Африкийн Бүгд Найрамдах улс	Шилжилтийн үеийн төрийн тэргүүн	23.Шилжилтийн үеийн төрийн тэргүүн нь шилжилтийн хугацаанд Шилжилтийн Үндэсний Зөвлөлөөс сонгогдоно. 24. ...Бүгд Найрамдах Улсын оршин тогтнол, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг батлан хамгаалж, энхтайван, ард түмний эв нэгдлийг бэхжүүлж... ажиллахаа Бурханы өмнө, ард түмнийхээ өмнө шударгаар батлан тангаргалаа. <i>Үндсэн хуулийн 23, 24-р зүйл</i>	+	
160	Тринидад Тобаго	Ерөнхийлөгч	Тринидад Тобаго нь энэ бүлэгт заасан дагуу сонгогдсон Ерөнхийлөгчтэй байх бөгөөд Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. <i>Үндсэн хуулийн 22-р зүйл</i>		
161	Тувалу	Цог жавхлант Элизабет II Амбан захирагч	-Цог жавхлант Хатан хаан нь төрийн тэргүүн байна. -Амбан захирагч нь Хатан хааны төлөөлөгч байна. -Тувалу улсын Амбан захирагчийг түүнийг Цог жавхлант Хатан хаан Ерөнхий сайд болон Парламентын гишүүдтэй зөвлөлдөн томилж, өөрийн таалсан хугацаагаараа ажиллуулна. <i>Үндсэн хуулийн 48, 54, 55-р зүйл</i>		
162	Тунис	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд ард түмний эв нэгдлийн бэлэг тэмдэг юм. Тэрээр Үндсэн хуулийг хүндэтгэн өөрийн хараат бус байдал, залгамж чанарыг баталгаажуулна. <i>Үндсэн хуулийн 72-р зүйл</i>	+	
163	Турк	Ерөнхийлөгч	Турк Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна. Энэ утгаараа БНТУлсын болон Турк үндэстний эв нэгдлийг төлөөлнө. Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийн хэрэгжилт, төрийн байгууллагуудыг тогтвортой, уялдаатай ажиллахад хяналт тавина. <i>Үндсэн хуулийн 104-р зүйл</i>	+	
164	Туркменистан	Ерөнхийлөгч	Туркменистаны Ерөнхийлөгч нь төрийн болон гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн бөгөөд Туркменистаны хамгийн дээд албан тушаалтан юм. Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийг хүндэтгэн биелүүлж, төрийн бие даасан байдлын баталгаа, Туркменистан улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, олон улсад хүлээсэн үүргээ биелүүлэн төвийг сахин ажиллана. <i>Үндсэн хуулийн 50-р зүйл</i>	+	
165	Уганда	Ерөнхийлөгч	Уганда улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн, Ардын Батлан хамгаалах хүчний ерөнхий командлагч, шударга ёсны илэрхийлэл болно. <i>Үндсэн хуулийн 98-р зүйл</i>		

166	Узбекистан	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах Узбекистан Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн бөгөөд төрийн эрх мэдлийн нэгдмэл үйл ажиллагаа, төрийн байгууллагуудын харилцан уялдааг хангана. <i>Үндсэн хуулийн 89-р зүйл</i>		
167	Украин	Ерөнхийлөгч	Украин Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд түүний нэрээр ажилладаг. Украины Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийг дээдлэн улсынхаа нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг сахин хамгаалж, тусгаар тогтнол, хүний болон иргэдийн эрх, эрх чөлөөг хангах баталгаа юм. <i>Үндсэн хуулийн 102-р зүйл</i>		
168	Унгар	Ерөнхийлөгч	Унгарын төрийн тэргүүн нь Улсын Ерөнхийлөгч мөн. Тэрээр үндэстний эв нэгдлийн биелэл, төрийн засаглалын ардчилсан үйл ажиллагааг хамгаалагч мөн. <i>Үндсэн хуулийн 9-р зүйл</i>	+	
169	Уругвай	Ерөнхийлөгч	Гүйцэтгэх эрх мэдлийг энэ хэсэг болон бусад холбогдох заалтад заасны дагуу Ерөнхийлөгч холбогдох сайд нарын хамт, эсхүл сайд нарын танхимтай хамтран хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 149-р зүйл</i>		
170	Фижи	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн бөгөөд Төрийн гүйцэтгэх эрх мэдэл Ерөнхийлөгчид олгогдоно. <i>Үндсэн хуулийн 81-р зүйл</i>		
171	Филиппин	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглалын тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 7-р бүлэг</i>		
172	Финланд	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар 6 жилийн хугацаатай сонгоно. <i>Үндсэн хуулийн 54-р зүйл</i>		Төрийн тэргүүн хэн байх талаар тодорхой заалт байхгүй.
173	Франц	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавина. Ерөнхийлөгч төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс хяналт тавьж төрийн залгамж чанарыг хангана. Ерөнхийлөгч нь үндэсний тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, олон улсын гэрээний биелэлтийн баталгаа мөн. <i>Үндсэн хуулийн 5-р зүйл</i>	+	
174	Хойд Солонгос	Дээд удирдагч	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Төрийн дээд эрх мэдэл Ардын Их Хуралд байна. <i>Үндсэн хуулийн 87-р зүйл</i>		Төрийн тэргүүн хэн байх талаар Үндсэн хуульд заагаагүй.
175	Холбооны Бүгд Найрамдах Бразил улс	Ерөнхийлөгч	Гүйцэтгэх эрх мэдлийг Холбооны Засгийн газрын сайд нарын дэмжлэгтэйгээр Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 76-р зүйл</i>		

176	Хорват	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч нь дотоод болон гадаадад Бүгд Найрамдах Хорват улсыг төлөөлнө... <i>Үндсэн хуулийн 94 -р зүйл</i>		Төрийн тэргүүн хэн байх талаар тодорхой заагаагүй.
177	Чад	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна. Ерөнхийлөгч нь улсын тусгаар тогтнол, хараат бус бие даасан байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, ард түмний эв нэгдлийн батлан даагч бөгөөд олон улсын гэрээг хүндэтгэн биелүүлнэ. <i>Үндсэн хуулийн 60-р зүйл</i>	+	
178	Чили	Ерөнхийлөгч	Бүгд Найрамдах улсын Ерөнхийлөгч нь Төрийн захиргаа, удирдлагыг хэрэгжүүлэх бөгөөд Төрийн тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 24-р зүйл</i>		
179	Чрна Гора /Монтенегро/	Ерөнхийлөгч	Монтенегро улсыг Монтенегро улсын ерөнхийлөгч төлөөлнө. <i>Үндсэн хуулийн 11-р зүйл</i>		
180	Швед	Хаан	Хаан ширээ залгамжлах хуулийн дагуу Шведийн хаан ширээнд заларсан Хаан болон Хатан хаан төрийн тэргүүн байна. <i>Үндсэн хуулийн 5-р зүйл</i>		
181	Швейцар	Ерөнхийлөгч	-Холбооны Ерөнхийлөгч нь Холбооны зөвлөлийг даргална. Холбооны зөвлөлийн Ерөнхийлөгч болон Дэд ерөнхийлөгчийг Холбооны Зөвлөлийн гишүүд дундаас Холбооны хурал буюу Парламент нь 1 жилийн хугацаагаар сонгоно. -Холбооны зөвлөл нь Холбооны Улсын төрийн дээд эрх барих, гүйцэтгэх байгууллага байна. <i>Үндсэн хуулийн 176, 174-р зүйл</i>		
182	Шинэ Зеланд	Цог жавхлант Элизабет II Амбан захирагч	-2-р Элизабет хатан хаан нь Шинэ Зеланд болон түүний хамтын нөхөрлөлийн орон, нутаг дэвсгэрийн тэргүүн байна. -Шинэ Зеланд улсыг Амбан захирагч удирдах ба, түүнийг Цог жавхлант Хатан хаан томилж, өөрийн таалсан хугацаагаараа ажиллуулна. <i>Үндсэн хуулийн 2-3-р зүйл</i>		
183	Шри Ланк	Ерөнхийлөгч	1. Шри Ланк Улсын Ерөнхийлөгч нь улсын төрийн тэргүүн, гүйцэтгэх болон Засгийн газрын тэргүүн байх бөгөөд Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. <i>Үндсэн хуулийн 30-р зүйл</i>		
184	Эквадор	Ерөнхийлөгч	Улсын Ерөнхийлөгч нь Засгийн газрын гүйцэтгэх салбарыг тэргүүлэх ба, Төр болон Засгийн газрын тэргүүн, төрийн удирдлагыг хангагч мөн. <i>Үндсэн хуулийн 141-р зүйл</i>		

185	Экваторын Гвиней	Ерөнхийлөгч	Улсын ерөнхийлөгч нь төрийн тэргүүн мөн. Тэрээр улс үндэстний нэгдлийн бэлгэдэл бөгөөд үндэстнийг төлөөлнө. <i>Үндсэн хуулийн 31-р зүйл</i>	+	
186	Эл Сальвадор	Ерөнхийлөгч	Улсын ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, төрийн сайдууд болон дэд сайдууд, тэдгээрийн албадууд нь гүйцэтгэх засаглалыг бүрдүүлнэ. <i>Үндсэн хуулийн 140-р зүйл</i>		Тодорхойлолт байхгүй
187	Энэтхэг	Ерөнхийлөгч	52-р зүйл. Энэтхэг Улс нь Ерөнхийлөгчтэй байна. 53-р зүйл. Холбооны гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхийлөгч шууд, эсхүл Үндсэн хуульд заасан захирагдагчаар дамжуулан хэрэгжүүлнэ. <i>Үндсэн хуулийн 52, 53-р зүйл</i>		
188	Эритри	Ерөнхийлөгч	Эритрийн Ерөнхийлөгч бол төрийн болон Эритрийн Засгийн газрын тэргүүн, Эритрийн Батлан хамгаалах хүчний командлагч мөн. <i>Үндсэн хуулийн 39-р зүйл</i>		
189	Эстони	Ерөнхийлөгч	Улсын Ерөнхийлөгч бол Эстоний төрийн тэргүүн мөн. <i>Үндсэн хуулийн 77-р зүйл</i>		
190	Этиоп	Ерөнхийлөгч	Этиопийн Холбооны Ардчилсан Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн мөн. <i>Үндсэн хуулийн 69-р зүйл</i>		
191	Ямайка	Цог жавхлант Элизабет II Амбан захирагч	1. Ямайкиг Амбан захирагч удирдах ба, түүнийг Цог жавхлант Хатан хаан томилж, өөрийн таалсан хугацаагаараа ажилуулах ба, тэрээр Ямайка дахь хатан хааны төлөөлөгч мөн. <i>Үндсэн хуулийн 27-р зүйл</i>		
192	Япон	Эзэн хаан	Эзэн хаан бол төрийн болон ард түмний эв нэгдлийн бэлгэ тэмдэг бөгөөд түүний байр суурь нь халдашгүй дархан байдлыг өөртөө хадгалах ард түмний хүслээс үүснэ. <i>Үндсэн хуулийн 1-р зүйл</i>	+	

**ПАРЛАМЕНТЫН БҮГД НАЙРАМДАХ УЛСУУДЫН СОНГУУЛИЙН
САНАЛЫН БОСГО БОЛОН 2015 ОНЫ 11 ДҮГЭЭР САРД ЯВАГДСАН
ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ТАЛААРХ ЛАВЛАГАА**

Д.Халиун

2015 оны 11 дүгээр сард явагдсан парламентын сонгуулийн талаарх лавлагаа

1. БНТУ

Төрийн зохион байгуулалтын хэлбэр: Парламентын бүгд найрамдах засаг

Төрийн тэргүүн: Ерөнхийлөгч Раджеп Тайип Эрдоган /Recep Tayyip Erdogan/

Засгийн газрын тэргүүн: Ерөнхий сайд Ахмет Давутоглу /Ahmet Davutoglu/

Хууль тогтоох дээд байгууллага: Туркийн Үндэсний Их Хурал /Türkiye Büyük Millet Meclisi/-ын нь нэг танхимтай бүх нийтийн сонгуулийн эрхийн үндсэн дээр сонгогддог 550 гишүүнтэй.

Парламентын бүрэн эрхийн хугацаа: 4 жил

Сонгуулийн эрх зүйн зохицуулалт:

- Үндсэн хууль, 66 дугаар зүйл /1982 он/
- Үндэсний Их Хурлын гишүүний сонгуулийн тухай хууль /1983 он/

Сонгуулийн тогтолцоо:

Гишүүнийг сонгох сонгууль нь Туркийн 81 засаг захиргааны нэгжийг төлөөлж буй /Станбул хот 3 сонгуулийн тойрог, Анкара болон Измир хотууд нь тус тус 2 сонгуулийн тойрогт хуваагдсан/ олон мандаттай 85 тойргоос намын нэрийн жагсаалтаар санал хурааж, хувь тэнцүүлэн хуваарилах Д'Хонтын аргаар суудлыг хуваарилдаг. Улсын хэмжээнд нийт сонгогчдын 10 хувийн босгыг давсан нам нь Үндэсний Их Хуралд гишүүнээ оруулах эрх нь нээгддэг. 2002 онд 2 нам, 2007, 2011 онд тус тус 3 нам Парламентад суудал авч байсан.


2015 оны Үндэсний Их Хурлын ээлжит бус /2015 оны 11 дүгээр сарын 1/сонгуулийн дүн:

Бүртгэгдсэн нийт сонгогчдын тоо: 56.965.099





Сонгуульд санал өгсөн: 48.523.610

Хүчинтэй санал: 47.838.711

Сонгуулийн ирц: 85.18%




Хүснэгт 1

Нам	Авсан саналын хувь	Авсан суудлын тоо
 Шударга ёс, хөгжлийн нам	49.49%	317
 Бүгд найрамдах ардын нам	25.31%	134
 Үндэсний хөдөлгөөн нам	11.90%	40
 Ардчилсан нам	10.76%	59
Бусад	2.54%	0

Үндэсний Их Хурлын өмнөх сонгуулиуд /2002 оноос хойш/:

- 2015 оны 6 дугаар сарын 7
- 2011 оны 6 дугаар сарын 12
- 2007 оны 7 дугаар сарын 22
- 2002 оны 11 дүгээр сарын 3

БНТУ-ын Үндэсний Их Хурлын сонгууль 2002, 2007, 2011 он



Хүснэгт 2

2002 ОНЫ СОНГУУЛЬ				2007 ОНЫ СОНГУУЛЬ				2011 СОНГУУЛЬ			
Нам	Сүүдлын тоо	Асан санлын тоо	Хувь	Нам	Сүүдлын тоо	Асан санлын тоо	Хувь	Нам	Сүүдлын тоо	Асан санлын тоо	Хувь
Justice and Development Party	363	10,762,131	34.28%	Justice and Development Party	341	16,327,291	46.58%	Justice and Development Party	327	21,399,082	49.83%
Republican People's Party	178	6,090,883	19.40%	Republican People's Party	112	7,317,808	20.88%	Republican People's Party	135	11,155,972	25.98%
True Path Party	-	2,999,528	9.55%	Nationalist Action Party	71	5,001,869	14.27%	Nationalist Movement Party	53	5,585,513	13.01%
Nationalist Movement Party	-	2,619,450	8.34%	Democratic Society Party	-	26	-1.00%	Independents	35	2,819,917	6.57%
Democratic People's Party	-	1,955,298	6.23%	Democratic Left Party	-	-	-1.00%	Felicity Party	-	543,454	1.27%
Others	9	1,923,559	6.13%					People's Voice Party	-	329,723	0.77%
Motherland Party	-	1,923,559	6.13%					Great Union Party	-	323,251	0.75%
Felicity Party	-	778,786	2.48%					Democratic Party	-	279,480	0.65%
Democratic Left Party	-	382,810	1.22%					Rights and Equality Party	-	124,415	0.29%
New Turkey Party	-	-	-					Democratic Left Party	-	108,089	0.25%
								Communist Party of Turkey	-	64,006	0.15%
								Nation Party	-	60,716	0.14%
								Nationalist and Conservative Party	-	36,188	0.08%
								Labour Party	-	32,128	0.07%
								Liberal Democratic Party	-	15,222	0.04%

2. АЗЕРБАЙЖАН УЛС

Төрийн тэргүүн: Ерөнхийлөгч Ильхам Алиев

Засгийн газрын тэргүүн: Ерөнхий сайд Артур Расизаде

Хууль тогтоох дээд байгууллага: Үндэсний Хурал /Milli Məclis/-ын нь нэг танхимтай бүх нийтийн сонгуулийн эрхийн үндсэн дээр сонгогддог 125 гишүүнтэй.

Парламентын бүрэн эрхийн хугацаа: 5 жил

Сонгуулийн эрх зүйн зохицуулалт:

- Үндсэн хууль /1995 он/
- Сонгуулийн тухай хууль /2008 он/²⁶

Сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуулийн дүнг эцэслэн зарлах хугацаа 20 хоног байна. Одоогийн байдлаар сонгуулийн дүн гараагүй байна.

Өмнөх сонгуулиуд:

- 2010 оны 11 дүгээр сарын 7
 - Бүртгэгдсэн нийт сонгогчдын тоо: 4.946.588
 - Сонгуульд санал өгсөн: 2.409.129
 - Хүчинтэй санал: 2.409.129
 - Сонгуулийн ирц: 49%
- 2006 оны 5 дугаар сарын 13 /сонгуулийн 10 тойрогт зөрчил илэрч сонгууль хүчингүй болсонтой холбоотойгоор дахин явуулсан/
- 2005 оны 11 дүгээр сарын 6
- 2000 оны 11 дүгээр сарын 5

2015 оны Үндэсний Хурлын сонгуулийн урьдчилсан дүн:

Бүртгэгдсэн нийт сонгогчдын тоо: 5.2 сая
 Сонгуульд санал өгсөн: 2.89 сая
 Хүчинтэй санал: -
 Сонгуулийн ирц: 55.7%

2015 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр 125 суудлын төлөө 767 нэр дэвшигч өрсөлдсөн.

Нам	Авсан суудлын тоо	Өөрчлөлт +/-
Шинэ Азербайжан нам	70	-2
Иргэдийн эв санааны нэгдлийн нам	2	-1
Азербайжаны нийгмийн хөгжил цэцэглэлтийн нам	1	Шинэ
Иргэдийн эв нэгдлийн нам	1	Шинэ
Ардчилсан гэгээрлийн нам	1	Шинэ
Их хэв журмын нам	1	Шинэ
Эх орон нам	1	-1
Үндэсний шинэчлэл хөдөлгөөний нам	1	Шинэ
Ардчилсан шинэчлэлийн төлөөх нам	1	Шинэ
Социал-демократ нам	1	Шинэ
Эв нэгдлийн нам	1	Шинэ
Азербайжаны ардын фронтын нам	1	Шинэ
Бие даагч	43	-5
Нийт	125	0


Эх сурвалж: <https://www.infocenter.gov.az/archive/millimeclis2015.aspx>

²⁶ Constitution of the Republic of Azerbaijan, Election Code of the Republic of Azerbaijan <http://www.msk.gov.az/en/legislation/>

Парламентын Бүгд Найрамдах Улсуудын парламентын сонгуулийн саналын босгын талаарх лавлагаа

Тус судалгаанд Парламентын Бүгд Найрамдах 50 орны хууль тогтоох байгууллагын сонгуулийн тогтолцоо, сонгуулийн саналын босгыг харьцуулан судалсан болно. Хүснэгтээс харахад сонгон авсан 50 орноос Сомали Улс нь Парламент шилжилтийн тогтолцоотой байгаа бөгөөд гишүүдээ томилдог, 5 нь сонгуулийн холимог тогтолцоотой, 14 нь мажоритар, үлдсэн 30 орон нь сонгуулийн пропорционал тогтолцоогоор парламентын сонгуулиа зохион явуулдаг байна.

Сонгуулийн босгын хувьд пропорционал тогтолцоогоор сонгуулиа явуулдаг орнуудын саналын босгын хувь нь дараах байдалтай байна:



Хүснэгт 3

	Улс	Хууль тогтоох дээд байгууллагын доод танхимыг хэрхэн сонгодог	Хууль тогтоох дээд байгууллагын дээд танхимыг хэрхэн сонгодог	Сонгуулийн тогтолцоо	Сонгуулийн саналын босго
1	Австри	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар	Пропорционал	4%
2	Бангладеш	Шууд сонгуулиар	-	Нэг мандаттай харьцангуй олонх	-
3	Болгар	Шууд сонгуулиар	-	Пропорционал	4%
4	Босни-Герцеговин	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар	Пропорционал	3%
5	Ботсван	Шууд сонгуулиар	Үе залгамжлах болон томилох	Нэг мандаттай харьцангуй олонх	-
6	Вануату	Шууд сонгуулиар		Нэг шилжүүлэхгүй санал	-

7	Герман	Шууд сонгуулиар	Муж улсын төлөөллөөс	Холимог Пропорционал системээр 1. Намын жагсаалт санал өгнө. Босго-5% 2. 299 гишүүнийг мажоритар зарчмаар.	5%
8	Грек	Шууд сонгуулиар	-	Пропорционал	3%
9	Доминика	Шууд сонгуулиар болон томилдог	-	Нэг мандаттай харьцангуй олонх	-
10	Ирак	Шууд сонгуулиар	-	Пропорционал	-
11	Ирланд	Шууд сонгуулиар	Намаас нэрийн жагсаалтаар томилдог	Шилжих нэг санал бүхий пропорционал	-
12	Израиль	Шууд сонгуулиар		Пропорционал	3.25%
13	Исланд	Шууд сонгуулиар		Пропорционал	5%
14	Итали	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар	Пропорционал	4-8%
15	Кирибати	Шууд сонгуулиар	-	Пропорционал /2 шатлалтай/	-
16	Кыргызстан	Шууд сонгуулиар	-	Пропорционал	5%
17	Латви	Шууд сонгуулиар	-	Пропорционал	5%
18	Ливан	Шууд сонгуулиар	-	Олон мандаттай, томсгосон тойрог	-
19	Ливи	Төлөөлөгчдийн зөвлөлөөс сонгоно	-	Параллель пропорциональ	-
20	Маврикий	Шууд сонгуулиар	-	Олон мандаттай, томсгосон тойрог	-
21	Мальт	Шууд сонгуулиар	-	Нэг шилжүүлэгдэхүйц санал	-
22	Македон	Шууд сонгуулиар	-	Пропорционал	Босгогүй
23	Маршаллын Арлууд	Шууд сонгуулиар	-	Нэг мандаттай харьцангуй олонх	-
24	Микронез	Шууд сонгуулиар	-	Нэг мандаттай харьцангуй олонх	-
25	Молдав	Шууд сонгуулиар	-	Пропорционал	5%
26	Науру	Шууд сонгуулиар	-	Алтернатив санал	-
27	Өмнөд Африк	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар	Пропорционал	Босгогүй
28	Пакистан	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар	Параллель пропорционал	-
29	Сан-Марино	Шууд сонгуулиар	-	Пропорционал	3.5%
30	Самоа	Шууд сонгуулиар	-	Нэг мандаттай харьцангуй олонх	-
31	Сингапур	Шууд сонгуулиар	-	Нэг мандаттай харьцангуй олонх + Бусад	-

32	Серби	Шууд сонгуулиар	-	Пропорционал	5%
33	Словак	Шууд сонгуулиар	-	Пропорционал	5%
34	Словени	Шууд сонгуулиар	Сонирхлын бүлгийн төлөөллөөс	Пропорционал	4%
35	Сомали	Шилжилтийн тогтолцоотой	-	Томилогддог	-
36	Суринам	Шууд сонгуулиар	-	Пропорционал	-
37	Тринидад Тобаго	Шууд сонгуулиар	Томилдог	Нэг мандаттай харьцангуй олонх	-
38	Тунис	Шууд сонгуулиар	-	Пропорционал	-
39	Турк	Шууд сонгуулиар	-	Пропорционал	10%
40	Непал	Шууд сонгуулиар	-	Параллель пропорционал	-
41	Унгар	Шууд сонгуулиар	-	Холимог 1. 176 гишүүнийг мажоритариар сонгоно 2. 152 гишүүнийг олон мандаттай нутаг дэвсгэрийн тойргоос пропорционалиар, 5% 3. 58 гишүүн нийт улсын нэг тойргоос пропорционалиар, 5%	5%
42	Фижи	Шууд сонгуулиар	-	Пропорционал	5%
43	Финланд	Шууд сонгуулиар	-	Пропорционал	Босгогүй
44	Хорват	Шууд сонгуулиар	-	Пропорционал	5%
45	Чех	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар	Пропорционал	5%
46	Чрна Гора	Шууд сонгуулиар	-	Пропорционал	3%
47	Швейцар	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар	Пропорционал	0.9%
48	Энэтхэг	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар	Нэг мандаттай харьцангуй олонх	-
49	Эстони	Шууд сонгуулиар	-	Пропорционал	5%
50	Этиоп	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар	Нэг мандаттай харьцангуй олонх	-

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

- <http://aceproject.org/epic-en/CDTable?view=country&question=ES005>
- <http://www.electionguide.org/elections/id/2481/>
- <http://secim.aa.com.tr/indexENG.html>
- <https://www.infocenter.gov.az/archive/millimeclis2015.aspx>

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛИАР
ПАРЛАМЕНТЫН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ДЭГИЙГ ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ**

*Р.Хатанбаатар, А.Пагма, Ц.Болормаа
Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаа, О.Нарантуяа
Б.Нандингэрэл, Д.Халиун*

Судалгаанд ХБНГУ, Норвеги, Франц, Австрали, Канад зэрэг орнуудад Парламентын хэлэлцүүлэг болон мэтгэлцээний дэг, үйл явц болон хэлэлцүүлэг, мэтгэлцээнд үг хэлэх хугацааг Дэгийн тухай хуулиар хэрхэн зохицуулсныг авч үзлээ.

Ингэхдээ ХБНГУ, Норвеги, Францын Дэгийн тухай хуулийн хэлэлцүүлэг явуулах болон хуралдаан зохион байгуулах ерөнхий дэгийн албан бус орчуулга, Австрали, Канадад хуралдааны дэг ба хэлэлцүүлэгт үг хэлэх хугацааг Дэгийн тухай хуулиар хэрхэн зохицуулсныг хүснэгтээр тус тус үзүүлсэн болно.

**ХБНГУ БУНДЕСТАГ
ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬ
2014**

(албан бус орчуулга)

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Хэлэлцэх асуудлын дараалал, Бундестагийн чуулганыг зарлан хуралдуулах,
хуралдаан явуулах журам болон хэв журам сахиулах

19 дүрэм

Хуралдаан

Бундестагийн хуралдааныг нээлттэй явуулна. Тулгуур хууль (Үндсэн хууль)-ийн 42.1-р хэсэгт заасны дагуу хаалттай явуулж болно.

20 дүрэм

Хэлэлцэх асуудлын дараалал

- 1) Бундестагийн хуралдааны төв болон хэлэлцэх асуудлын дарааллыг Бундестаг урьдчилан тогтоосон, эсхүл Ерөнхийлөгч /буюу Бундестагийн дарга, цаашид “Ерөнхийлөгч” гэх/ дүрмийн 21.1-т хэсэгт заасан өөрийн эрх мэдлийн хүрээнд тогтоосноос бусад тохиолдолд Ахмадын зөвлөл тогтоож, зарлан хуралдуулна.
- 2) Хэлэлцэх асуудлын жагсаалтыг Бундестагийн гишүүд, Бундесратын гишүүд болон Холбооны Засгийн газарт тараана. Татгалзах зүйл гараагүй тохиолдолд эхний асуудлыг зарласнаар батлагдсанд тооцно. Бундестагийн чуулганы хуралдаан эхэлснээс хойш Бундестагийн аль ч гишүүн, анхны асуудлыг зарлахаас өмнө хэлэлцэх асуудлын жагсаалтад өөрчлөлт оруулж болох бөгөөд тус хүсэлтийг Ерөнхийлөгчид өмнөх өдрийн 18.00 цагаас өмнө гаргасан нөхцөлд хүчинтэйд тооцно.
- 3) Хэлэлцэх асуудлын жагсаалтыг баталснаас хойш бусад асуудлыг зөвхөн парламентын бүлэг, эсхүл хүрэлцэн ирсэн Бундестагийн гишүүдийн 5 хувийн саналаар, эсхүл энэхүү дүрэмд хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахгүй хэлэлцэхийг зөвшөөрсөн асуудлыг хэлэлцэхийг тус тус зөвшөөрнө. Бундестаг нь энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол аль ч үед хэлэлцэх асуудлын жагсаалтаас асуудал хасах эрхтэй байна.
- 4) Бундестагийн гишүүн нь хэлэлцэх асуудлын жагсаалтад асуудал оруулсан тохиолдолд холбогдох баримт бичиг нь доод тал нь 3 долоон хоногийн өмнө тараагдсан тохиолдолд дараагийн хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж хэлэлцэнэ.
- 5) Хуралдааны ирц хүрээгүй шалтгаанаар хуралдаан хуралдаагүй тохиолдолд Ерөнхийлөгч мөн өдөр давтан зарлаж болно. Тус хэлэлцэх асуудлын хүрээнд санал хураалт явагдаж чадаагүй асуудлаар Ерөнхийлөгч нь парламентын бүлэг, эсхүл хүрэлцэн ирсэн гишүүдийн 5 хувь нь татгалзаагүй тохиолдолд дахин сонгууль, эсхүл санал хураалтын товыг тогтоох, эсхүл хэлэлцэх асуудлын жагсаалтаас асуудлыг хасч болно.

21 дүрэм

Ерөнхийлөгч Бундестагийг зарлан хуралдуулах

- 1) Бундестагаас эрх олгосноор, эсхүл хуралдааны ирц хүрэлцээгүйгээс бусад шалтгаанаар шийдвэр гаргах боломжгүй тохиолдолд Ерөнхийлөгч нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хуралдааны тов болон хэлэлцэх асуудлын дарааллыг тогтооно.
- 2) Ерөнхийлөгч нь Бундестагийн гишүүдийн гуравны нэг, Холбооны Ерөнхийлөгч, эсхүл Холбооны Канцлерийн шаардлагын дагуу Бундестагийг хуралдуулна. (Үндсэн хуулийн 39-р зүйлийн 3-р хэсэг)
- 3) Дээрхээс бусад тохиолдолд Ерөнхийлөгч хуралдааны товыг тогтоосон, эсхүл хэлэлцэх асуудлын жагсаалтад нэмэлт асуудалд оруулсан бол Бундестагаас зөвшөөрөл авч хуралдааныг эхлүүлнэ.

22 дүрэм

Хуралдаан

Хуралдааныг Ерөнхийлөгч нээж, зохион явуулах болон хаана. Ерөнхийлөгч нь хуралдааныг дуусахаас өмнө Ахмадын зөвлөл, эсхүл Бундестагаас тогтоосон дараагийн хуралдааны товыг зарлана.

23 дүрэм

Хэлэлцүүлэг эхлүүлэх

Ерөнхийлөгч нь хэлэлцүүлэг явуулах шаардлагагүй, эсхүл тусгай журмаар шийдэхээс бусад тохиолдолд хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон асуудал тус бүрээр хэлэлцүүлэг явуулна.

24 дүрэм

Холбогдох асуудлаар нэгдсэн хэлэлцүүлэг явуулах

Ижил төстэй, эсхүл хоорондоо холбоотой асуудлаар нэгдсэн хэлэлцүүлэг явуулж болно.

25 дүрэм

Хэлэлцүүлгийг хойшлуулах болон хаах

- 1) Үг хэлэх дарааллын дагуу бүртгүүлсэн бүх илтгэгч нар үгээ хэлж дууссан, эсхүл үг хэлэх хүсэлт гараагүй тохиолдолд Ерөнхийлөгч хэлэлцүүлэг дууссаныг зарлана.
- 2) Бундестаг хэлэлцүүлгийг парламентын бүлгийн, эсхүл хүрэлцэн ирсэн гишүүдийн 5 хувийг саналаар хойшлуулах, эсхүл хаах тухай шийдвэр гаргана. Хуралдааныг хаах тухай санал хураалт нь хойшлуулах санал хураалтаас түрүүлж явагдах бөгөөд хаах тухай санал хураалтыг парламентын бүлэг тус бүрээс илтгэгч нар үг хэлсний дараа явуулна.

26 дүрэм

Хуралдааныг хойшлуулах

Бундестаг нь Ерөнхийлөгч, эсхүл парламентын бүлэг, эсхүл хүрэлцэн ирсэн гишүүдийн 5 хувийн саналаар хуралдааныг хойшлуулах тухай шийдвэрийг гаргана.

27 дүрэм

Үг хэлэх болон үг хэлэх хүсэлт гаргах

- 1) Бундестагийн гишүүд үг хэлэхдээ Ерөнхийлөгчөөс зөвшөөрөл авна. Ерөнхийлөгч нь хэлэлцүүлэгт оролцохдоо суудлаа чөлөөлсний дараа үг хэлнэ. Бундестагийн гишүүн хэлэлцүүлэгт үг хэлэхдээ, холбогдох асуудал хариуцсан нарийн бичигт мэдэгдэнэ. Бундестагийн гишүүнийг горимын санал дэвшүүлэх, эсхүл мэдэгдэл хийхэд дараалал харгалзахгүй.
- 2) Бундестагийн гишүүн нь илтгэгчийг үг хэлж байхад асуулт асуух, эсхүл хэлэлцүүлэг явагдаж байхад тайлбар хийх тохиолдолд Танхим дахь микрофоныг ашиглана. Илтгэгчийн зөвшөөрснөөр асуулт тавих, эсхүл тайлбар хийх бөгөөд асуулт, тайлбар нь товч бөгөөд тодорхой байна. Ерөнхийлөгч нь хэлэлцүүлэгт оролцсон гишүүдэд гурваас дээш минут үг хэлэх эрх олгох бөгөөд, илтгэгч нь нэг удаа хариулах эрхтэй байна.

28 дүрэм

Үг хэлэх дараалал

- 1) Үг хэлэх дарааллыг Ерөнхийлөгч тогтооно. Ингэхдээ Ерөнхийлөгч нь Холбооны Засгийн газрын гишүүн, эсхүл Засгийн газраас үүрэг болгосны дагуу бусад этгээдийн тавьсан илтгэлийн дараа хэлэлцүүлгийг зөв зохистой болон үр дүнтэй явагдахыг хангах бөгөөд улс төрийн намуудын үзэл бодол, хэлэлцэж буй асуудлыг дэмжсэн болон эсэргүүцсэн санал зэргийг тусгахад анхаарна.
- 2) Бундестагийн гишүүний хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулсан асуудлыг хэлэлцэхэд үг хэлэх эхний гишүүн нь тус асуудлыг оруулсан гишүүнээс ялгаатай парламентын бүлгийн гишүүн байна. Санал оруулсан гишүүн болон илтгэл тавигч нь хэлэлцүүлгийн эхэн болон төгсгөлд үг хэлэх эрхтэй байна. Илтгэл тавигч нь аль ч үед ярих эрхтэй байна.

29 дүрэм

Горимын санал

- 1) Ерөнхийлөгч нь горимын санал дэвшүүлэхээр үг хэлэх эрх авч буй гишүүнд давуу эрх олгоно. Тус санал нь хэлэлцэж буй асуудал, эсхүл хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотой байна.
- 2) Дэвшүүлсэн горимын саналыг хүлээн авах шаардлагатай тохиолдолд Ерөнхийлөгч нь зөвхөн санал оруулсан этгээдэд, эсхүл бусад санал оруулсан тохиолдолд парламентын бүлэг тус бүрээс зөвхөн нэг илтгэгчид ярих эрх олгоно.
- 3) Бундестагийн гишүүн нь горимын саналыг өөрөө гаргах хүсэлгүй байгаа нөхцөлд Ерөнхийлөгч үг хэлэх эрхийг өөрийн үзэмжийн дагуу шийднэ.
- 4) Гишүүн нь горимын саналтай холбоотой асуудлаар 5-аас дээшгүй минут ярих эрхтэй байна.

30 дүрэм

Мэдэгдэл хийх

Хэлэлцүүлгийг дүгнэсэн, завсарлуулсан, эсхүл хойшлуулсны дараа мэдэгдэл хийх эрхийг олгоно. Ерөнхийлөгч нь хэлэлцүүлгийн явцад мэдэгдэл хийхийг хүссэн гишүүнд давуу эрх олгоно. Мэдэгдэл хийхийг хүссэн гишүүн нь Ерөнхийлөгчөөс үг хэлэх зөвшөөрөл авахдаа шалтгаанаа тайлбарлана. Хэлэлцүүлэг явагдаж буй хугацаанд хийх мэдэгдэл нь зөвхөн тус хэлэлцүүлэгт тухайн гишүүнтэй холбоотой яригдсан мэдээллийг няцаах, эсхүл тухайн гишүүн хэлсэн үгэндээ залруулга хийхтэй холбоотой байх бөгөөд тус мэдэгдэл нь 5 минутаас хэтрэхгүй байна.

31 дүрэм

Санал хураалт

- 1) Хэлэлцүүлгийн төгсгөлд Бундестагийн гишүүд нь эцсийн санал хураалт явагдахаас өмнө 5 минутаас хэтрэхгүй аман мэдэгдэл, эсхүл чуулганы хуралдааны тэмдэглэлд хавсрагдах товч мэдэгдлийг бичгээр гаргах эрхтэй байна. Ерөнхийлөгч нь санал хураалтын өмнө гишүүдэд мэдэгдэл хийх зөвшөөрөл олгож болно.
- 2) Санал хураалт явуулахаас өмнө Бундестагийн аль ч гишүүн санал өгөхөөс татгалзаж буйгаа зарлах эрхтэй.

32 дүрэм

Хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй асуудлаар мэдэгдэл хийх Ерөнхийлөгч нь хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон эхний асуудлыг зарлах, эсхүл хэлэлцүүлгийг дүгнэсэн, завсарлуулсан, эсхүл хойшлуулсны дараа гишүүнд хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй асуудлаар үг хэлэх эрх олгож болох бөгөөд тус мэдэгдэл нөхцөл байдлыг томъёолсон, эсхүл хувийн чанартай байж болно. Гишүүн нь Ерөнхийлөгчөөс үг хэлэх зөвшөөрөл авахдаа мэдэгдэл хийх шалтгааныг дурдах бөгөөд тус мэдэгдэл нь 5 минутаас хэтрэхгүй байна.

33 дүрэм

Илтгэл

Илтгэгч нар нь илтгэлээ уншихгүй харин илтгэл тавихдаа тэмдэглэл ашиглаж болно.

34 дүрэм

Илтгэл тавих

Илтгэгч нар нь микрофон ашиглах, эсхүл индрээс илтгэлээ тавина.

35 дүрэм

Үг хэлэх хугацаа

- 1) Хэлэлцүүлгийн жагсаалт дахь тодорхой асуудлаар явуулах хэлэлцүүлгийн хэлбэр болон үргэлжлэх хугацааг Ахмадын зөвлөлөөс санал болгосны дагуу Бундестаг тогтооно. Ахмадын зөвлөлөөс нэгдсэн шийдэлд хүрч чадаагүй, эсхүл Бундестаг өөрөөр шийдээгүй тохиолдолд илтгэгч нь 15 минутаас илүүгүй хугацаанд үг хэлнэ. Парламентын бүлгийн шаардсаны дагуу түүний аль нэг гишүүн нь 45 минут хүртэл үг хэлж болно. Ерөнхийлөгч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд дээрх хугацааг сунгаж болно.
- 2) Холбооны Засгийн газрын эсхүл Бундесратын гишүүн, эсхүл тэдгээрийн үүрэг болгосноор бусад этгээд нь 20 минутаас дээш хугацаагаар үг хэлсэн тохиолдолд зарчмын зөрүүтэй санал дэвшүүлэх хүсэлтэй парламентын бүлэг нь мөн адил хугацаанд үг хэлэх эрхтэй байна.
- 3) Бундестагийн гишүүн нь өөрт хуваарилагдсан хугацаанаас хэтрүүлэн ярьсан тохиолдолд Ерөнхийлөгч нь эхний удаа сануулга өгөх бөгөөд яриагаа зогсоохыг шаардана.

36 дүрэм

Хэв журам сахиулах, яриаг зогсоох

- 1) Ерөнхийлөгч нь илтгэгчийг хэлэлцүүлгийн асуудлын хүрээнд ярихыг шаардах эрхтэй. Ерөнхийлөгч нь дэгийг зөрчсөн, эсхүл Бундестагийг үл хүндэтгэсэн гишүүнийг дуудаж, хэв журам сахихыг шаардах эрхтэй байна
- 2) Илтгэгчийг илтгэлээ тавьж байх хугацаанд түүнийг хэлэлцүүлгийн асуудлын хүрээнээс гадуур ярьж байгааг, эсхүл хэв журам сахихыг тус бүр 3 удаа сануулсан ч дахин зөрчсөн тохиолдолд Ерөнхийлөгч илтгэгчийг яриагаа дуусгахыг шаардах бөгөөд тус хэлэлцүүлгийн хугацаанд дээрх асуудлаар дахин үг хэлэх эрхийг нь хасах эрхтэй байна.

37 дүрэм

Торгууль

Бундестагийн гишүүн нь хуралдааны дэгийг ноцтой зөрчсөн, эсхүл хуралдааныг үл хүндэтгэсэн тохиолдолд Ерөнхийлөгч нь хэв журам сахихыг шаардалгүй 1000 евротой тэнцэх хэмжээний торгууль ногдуулж болно. Гишүүн давтан зөрчил гаргасан тохиолдолд торгуулийн хэмжээг 2000 евро хүртэл өсгөж болно. 38.2-т заасан дүрэмд зохих өөрчлөлт оруулан хэрэглэнэ.

38 дүрэм

Бундестагийн гишүүний хуралдаанд оролцох эрхийг хасах

- 1) Ерөнхийлөгч нь хуралдааны дэгийг ноцтой зөрчсөн, эсхүл Бундестагийг үл хүндэтгэсэн гишүүнийг хэв журам сахихыг шаардалгүй, эсхүл торгууль ногдуулахгүй хуралдааныг дуустал Танхимаас гарахыг тушаах эрхтэй байна. Хуралдааныг дуусахаас өмнө Ерөнхийлөгч тухайн гишүүнийг хэдэн өдрийн хуралдаанд оролцохгүйг хуралдаанд мэдэгдэнэ. Бундестагийн гишүүний 30 хүртэл өдрийн хуралдаанд оролцох эрхийг хасаж болно.
- 2) Гишүүн өмнөх хуралдаанд үл хүндэтгэсэн үйлдэл үйлдсэн, эсхүл дэгийг ноцтой зөрчсөн тохиолдолд Ерөнхийлөгч тус гишүүнийг хуралдаанд суух эрхийг дараагийн хуралдаанаас хязгаарлах тухай зарласан тохиолдолд тус арга хэмжээг буцаан

хэрэглэж болно.

- 3) Тухайн зөрчил гаргасан гишүүн нь нэн даруй танхимыг орхих бөгөөд Ерөнхийлөгчийн шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд, Ерөнхийлөгч тус үйлдэл нь шийтгэлийг сунгахад нөлөөлж буйг анхааруулна.
- 4) Зөрчил гаргаж хуралдаанд оролцох эрхээ хасуулсан гишүүн нь мөн байнгын хороодын хуралдаанд оролцох эрхгүй байна.
- 5) Бундестагийн гишүүн нь чуулганы болон байнгын хороодын хуралдаанд хууль бусаар оролцохыг завдсан тохиолдолд энэхүү дүрмийн 3-р хэсэгт заасныг зохих өөрчлөлт оруулан дагаж мөрдөнө.
- 6) Зөрчил гаргасан гишүүнийг чөлөө авсанд тооцохгүй. Мөн тэрээр нэрээ ирцийн бүртгэлд бүртгүүлэх эрхгүй байна.

39 дүрэм

Сахилгын хариуцлагыг үл зөвшөөрөх

Зөрчил гаргасан гишүүн нь дараагийн хуралдаанаас өмнө хуралдааны дэгийг зөрчсөнд хүлээлгэх хариуцлагыг үл зөвшөөрснийг үндэслэлийн хамт бичгээр гаргах эрхтэй. Энэхүү асуудал нь тухайн хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад орох бөгөөд Бундестаг хэлэлцэлгүй, нэн даруй шийднэ.

40 дүрэм

Хуралдааныг түр зогсоох

Ерөнхийлөгч Бундестаг дахь үймээнийг Танхимын хэвийн ажиллагаанд саад учруулж байна гэж үзсэн тохиолдолд Бундестагийн хуралдааныг тодорхой хугацаагаар түр зогсоох эсхүл хуралдааныг цуцлах эрхтэй байна. Ерөнхийлөгчийг гишүүд сонсохгүй тохиолдолд тэрээр суудлаа орхих бөгөөд ингэснээр хуралдааныг түр зогсоосонд тооцно. Ерөнхийлөгч хуралдааныг үргэлжлүүлэн хуралдуулна.

41 дүрэм

Хэв журам сахиулах бусад арга хэмжээ

- 1) Хуралдаанд оролцож буй Бундестагийн гишүүн бус этгээд болон иргэд хуралдааны дэгийг зөрчсөн тохиолдолд Ерөнхийлөгч дээрх этгээдүүдэд хариуцлага хүлээлгэнэ.
- 2) Бундестагийн үйл ажиллагаатай танилцаж буй иргэн дургүйцэл болон сайшаалаа илэрхийлэх, эсхүл зохисгүй үйлдэл гаргасан тохиолдолд түүнийг Ерөнхийлөгчийн тшаалын дагуу нэн даруй танхимаас гаргана.

42 дүрэм

Холбооны Засгийн газрын гишүүнийг зарлан дуудах

Бундестаг нь парламентын бүлэг, эсхүл хүрэлцэн ирсэн гишүүдийн 5 хувийн саналыг үндэслэн Холбооны Засгийн газрын гишүүнийг зарлан дуудах эрхтэй байна. Үндсэн хуулийн 43.1-р хэсэг.

43 дүрэм

Холбооны Засгийн газар болон Бундесратын гишүүний үг хэлэх эрх
Холбооны Засгийн газрын гишүүн, эсхүл Бундесратын гишүүн болон тэднээс үүрэг болгосон этгээдүүд нь шаардлага гаргасны дагуу Үндсэн хуулийн 43.2-р хэсэгт заасныг үндэслэн ямар ч үед үг хэлэх эрхтэй байна.

44 дүрэм

Хэлэлцүүлгийг дахин явуулах

- 1) Хэлэлцүүлгийн төгсгөлд, эсхүл хэлэлцүүлэгт олгосон үг хэлэх хугацаа дууссан ч гишүүн, эсхүл Холбооны Засгийн газрын гишүүн, эсхүл тэдгээрийн эрх олгоснон бусад этгээд, эсхүл Бундесрат нь хэлэлцүүлгийн асуудлын хүрээнд ярьж дуусаагүй тохиолдол хэлэлцүүлгийг дахин нээсэнд тооцно.

- 2) Хэлэлцүүлгийн үеэр гишүүн, эсхүл Холбооны Засгийн газрын гишүүн, эсхүл тэднээс үүрэг болгосон бусад этгээд, эсхүл Бундесратад хэлэлцэж буй асуудлаар үг хэлэх эрх олгосон тохиолдолд тухайн асуудлаарх парламентын бүлэгт олгосон цаг нь дууссан бол өмнө олгогдсон хугацааны дөрөвний нэгтэй тэнцэх хугацааг нэмж олгоно.
- 3) Гишүүн, эсхүл Холбооны Засгийн газрын гишүүн, эсхүл тэдгээрээс үүрэг болгосон бусад этгээд, эсхүл Бундесрат нь хэлэлцэх асуудлын хүрээнд хамаарахгүй асуудлаар үг хэлэх тохиолдолд, тус мэдэгдлээр парламентын бүлэг, эсхүл хүрэлцэн ирсэн гишүүдийн 5 хувийн шаардлагын дагуу хэлэлцүүлэг явуулж болно. Тус хэлэлцүүлэгт зарчмын зөрүүтэй санал оруулахыг хориглоно.

45 дүрэм

Ирц

- 1) Бундестагийн нийт гишүүдийн талаас дээш хувь нь Танхимд хүрэлцэн ирснээр ирц бүрдсэнд тооцно.
- 2) Санал хураалт явуулахаас өмнө парламентын бүлэг, эсхүл хүрэлцэн ирсэн гишүүдийн 5 хувь нь ирц бүрдсэн эсэх талаар санал гаргасан мөн хуралдаан даргалагч нь энэхүү асуудлыг баталгаажуулаагүй, эсхүл санал хураалт явуулахтай холбоотойгоор ирц бүрдсэн эсэх талаар даргалагч нь парламентын бүлэг, эсхүл хүрэлцэн ирсэн гишүүдийн 5 хувьтай хамтран санал гаргасан бол 51 дүрэмд заасны дагуу санал хураах бөгөөд хэлэлцүүлэг явагдаж байгаа тохиолдолд 52 дүрмийг баримтална. Ерөнхийлөгч нь богино хугацаагаар санал хураалтыг түр хойшлуулах эрхтэй байна.
- 3) Ирц бүрдээгүй байгаа нь батлагдсан тохиолдолд Ерөнхийлөгч нь хуралдааныг нэн даруй зогсооно. Гишүүдийн саналын картыг ашиглан санал хураалт явуулах шаардлага нь хүчин төгөлдөр байна. Хуралдааны ирцийг тогтоохдоо хүрэлцэн ирээгүй болон хүчингүй саналуудыг оролцуулан тооцно.
- 4) 45 дүрмийн 1-3-р хэсэгт заасныг үл харгалзан, хэлэлцүүлгийн явцад хуралдаан даргалагч нь Бундестагийн нийт гишүүдийн 25 хувийн ирц бүрдсэн эсэх асуудлаар санал гаргасан тохиолдолд Ерөнхийлөгч нь парламентын бүлэгтэй зөвшилцсөний үндсэн дээр хуралдааныг түр зогсоох эрхтэй байна. Гишүүдийн ирцийн 52 дүрэмд заасан журмын дагуу тогтооно.

46 дүрэм

Асуулт тавих

Ерөнхийлөгч нь асуултаа «тийм», «үгүй» хэлбэрээр хариулт авахаар тавина. Мөн асуултууд нь дэмжсэн, эсхүл эсэргүүцсэнийг ойлгомжтой байдлаар илэрхийлэгдсэн байхаар тавигдана. Асуултын хэлбэрийн хувьд горимын санал оруулах зөвшөөрөл хүсч болох бөгөөд саналыг эсэргүүцсэн санал гарсан тохиолдолд Бундестаг шийднэ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**СТОРТИНГ
НОРВЕГИЙН ВАНТ УЛСЫН ПАРЛАМЕНТ
ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬ
2009**

(албан бус орчуулга)

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ
Хэлэлцүүлэг**

35 ХЭСЭГ

Хэлэлцүүлгийг эхлүүлэхэд Ерөнхийлөгчийн санал болгосноор хуралдаан нь хэлэлцүүлэг явуулах хугацааг хязгаарлах буюу 36 дугаар хэсэгт заасан хугацаанаас богино хугацаа тогтоох, намын бүлгүүдэд цаг хуваарилах эрхтэй байна.

Хэлэлцүүлгийг хуралдаан даргалагч нээх бөгөөд, үг хэлэх дарааллыг Ерөнхийлөгчийн хараанд өртсөн дарааллаар тогтооно. Үг хэлэх хүсэлтийг зэрэг гаргасан тохиолдолд Ерөнхийлөгч өөрийн үзэмжээр шийднэ. Намын бүлгүүд нь Стортингийн тамгын газраар дамжуулан Ерөнхийлөгчид хэлэлцүүлэгт оролцох хүсэлтэй гишүүдийн нэрсийн жагсаалтыг өргөн мэдүүлсэн тохиолдолд, Ерөнхийлөгч тус жагсаалтын дагуу дарааллыг тогтооно. Үг хэлэх дарааллыг намын бүлэг тус бүрийн нэг илтгэгч толгойлно.

Хэлэлцүүлэгт оролцогч нь нэг асуудлаар, эсхүл хэлэлцүүлэг нь хэдэн хэсэгт хуваагдсан тохиолдолд хэсэг тус бүрт хоёроос дээш удаа үг хэлэх эрхгүй байна. Энэ нь дараах этгээд буюу нөхцөлд хамаарахгүй:

- a) Өөрсдийн эрхлэх асуудлаар Байнгын хорооны даргалагч болон Сайдад, Ерөнхий улс төрийн хэлэлцүүлэгт Ерөнхий сайд болон намын бүлгийн дарга нарт.
- b) Ерөнхийлөгч нь товч санал хэлэх, мэдээлэл хийхийг зөвшөөрч болно.
- c) Ерөнхийлөгч нь намын бүлэг тус бүрийн нэг илтгэгчийг хоёроос дээш удаа яриулж болно.
- d) Ерөнхийлөгчийн санал болгосноор Стортинг нь дүрэмд зааснаас өөрөөр тогтоож болно.

36 ХЭСЭГ

Эхний илтгэл 30 минут, хоёр дахь илтгэл нь 10 минут болон удаах илтгэлүүд нь 3 минутаас тус тус хэтрэхгүй байна. Товч санал, мэдээлэл нь 1 минутаас хэтрэхгүй байх. Дэгийн 34 дэх хэсэгт заасан Засгийн газрын гишүүний илтгэл нь нэг цагаас хэтрэхгүй байна. Ерөнхийлөгчийн санал болгосноор Стортинг үг эхлэх хугацааг сунгаж болно. Ерөнхийлөгчийн, эсхүл Стортингийн 10-аас доошгүй гишүүдийн бичгээр гаргасан саналыг үндэслэн Стортинг нь үг хэлэх хугацааг 3 минутаас багагүй байхаар богиносгож болно. Ерөнхийлөгчийн санал болгосноор хугацааг Байнгын хороодын даргалагч, намын бүлгийн дарга нар болон Засгийн газрын гишүүдэд дүрэмд зааснаас өөрөөр тогтоож болно.

37 ХЭСЭГ

Стортинг зөвшөөрснөөр Ерөнхийлөгч нь хэлэлцүүлэгт хамаарах асуудлаар товч мэдэгдэл, тайлбар хийх болон хариу өгөх хэлбэрээр хэлэлцүүлэг/мэтгэлцээн явуулж болох бөгөөд тус бүр 1 минутаас хэтрэхгүй байна. Илтгэгчийн үг нь мэтгэлцээн үүсгэсэн тохиолдолд илтгэгч нарт ээлжлэн хариулна.

Ерөнхийлөгч нь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хамгийн сүүлд хэлэлцсэн асуудлаар шууд асуултад хариулах эсхүл илэрхий үл ойлголцлыг арилгах зорилгоор дараалал харгалзахгүй дээд тал нь хоёр удаа тус бүр 1 минут дотор товч мэдэгдэл, тайлбар хийхийг зөвшөөрнө.

Стортинг нь хэлэлцүүлэгт бүртгүүлсэн бүх илтгэгч нарыг ярьж дуусаагүй байхад нь хэлэлцүүлгийг дуусгаж “хааж” болно. Хааж болон ярих хугацааг богиносгох саналыг Ерөнхийлөгч, эсхүл 10 гишүүн гаргаж гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн бол хүлээн авна. Санал хураалтыг тус саналыг дэмжсэн болон эсэргүүцсэн тус бүр нэг илтгэгч илтгэсний дараа явуулна.

37А ХЭСЭГ

Ерөнхийлөгч нь хуралдааны төгсгөл бүрт Гишүүдээс хуралдааны дэг зөрчигдсөн эсэх талаар санал, шүүмж хүлээн авна.

Хуралдааны төгсгөл бүрт Ерөнхийлөгчийн зөвшөөрснөөр, Тэргүүлэгч /Президиум/ -дэд, эсхүл Засгийн газрын гишүүдэд асуулт тавьж болох бөгөөд энэ нь тодорхой үндэслэлтэй, эсхүл өөр ямарваа нэгэн байдлаар тавьж болохгүй нөхцөлд зөвшөөрөгдөнө. Ийнхүү асуулт тавихдаа гишүүд нь хуралдаан дуусахаас өмнө Ерөнхийлөгчид хандана. Асуулт тавих болон хариулах нь тус бүр 5 минутаас хэтрэхгүй. Хариулт өгсний дараа бусад намын бүлгийн гишүүн тус бүр нэг удаа дээд тал нь 3 минут ярих эрхтэй байна. Төгсөлд нь асуулт тавигч болон хариулагч нь тус бүр нэг удаа 3 минутаас хэтрэлгүй ярих эрхтэй байна.

Хоёрдугаар хэсэгт заасны дагуу хэлэлцэх явцад санал дэвшүүлж болохгүй.

38 ХЭСЭГ

Илтгэгч нь Ерөнхийлөгчид хандан илтгэлээ тавина. Илтгэгч нь зөвхөн илтгэлд хамаарах асуудлаар илтгэл тавина. Гишүүний ёс зүйд үл нийцэх, бусдыг доромжилсон, басамжилсан хэл яриа болон үйлдлийг хориглоно. Дээрхийг Ерөнхийлөгч хянан шийднэ.

39 ХЭСЭГ

Хэлэлцүүлгийн үеэр дургүйцлээ дуу чимээтэйгээр илэрхийлэх, эсхүл алга ташихыг хориглоно.

40 ХЭСЭГ

Ишлэлийг хязгаартай хэрэглэх бөгөөд яриандаа ишлэлийн эхлэл, төгсгөл болон эх сурвалжийг заана.

41 ХЭСЭГ

Төрийн зөвлөлийн гишүүд хэлэлцүүлэгт оролцохдоо Үндсэн хуулийн 74²-т заасны дагуу Стортингийн гишүүнтэй адил Дэгийн тухай хуульд заасан эрх, үүргийг хүлээнэ.

42 ХЭСЭГ

Ерөнхийлөгч хуралдааны дэгийг үл хүндэтгэсэн гишүүнд сануулга өгөх бөгөөд шаардлагатай бол дахин сануулна.

Гишүүн нь хуралдааны дэгийг дахин зөрчсөн тохиолдолд Ерөнхийлөгч нь тухайн гишүүнийг үг хэлэх, асуулт асуух эрхийг нь хасах, эсхүл тухайн өдрийн хуралдаанд оролцуулахгүй байх асуудлаар санал хураалт явуулна.

ФРАНЦЫН ҮНДЭСНИЙ ХУРЛЫН ДЭГ
(Rules of procedure of the National Assembly)
2007
(Албан бус орчуулга)

Бүлэг XI. Нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал
Хэлэлцүүлгийн зохион байгуулалт

47-р зүйл

Нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалд :

- Хуулийн төслүүд, хууль тогтоох саналууд нь 84-р зүйлд тогтоосон журмын хүрээнд дарааллын дагуу,
- Аман асуултууд Зүйл 134-өөр тогтоосон журмын дагуу,
- Бусад асуудлууд дараагийн Зүйлд заагдсан журмын дагуу тус тус орно.
-

48-р зүйл

1. Үндэсний хурлын дарга долоо хоног бүр өөрийн тогтоосон өдөр, цагт Үндэсний хурлын дэд дарга, байнгын хороодын дарга нар, Санхүү, эдийн засгийн ерөнхий асуудал, төлөвлөлтийн хорооны Ерөнхий илтгэгч, намын бүлгүүдийн дарга нарыг хуралдуулж, Засгийн газраас тогтоосон нэн тэргүүнд хэлэлцэх шаардлагатай асуудлуудаас гадна хэлэлцэх асуудлын жагсаалтанд оруулах бусад саналыг хэлэлцэнэ.
 2. Тусгай хороодын дарга нар хүсэлтээ гаргавал энэ зөвлөлгөөнд уригдаж болно.
 3. Үндэсний хурлын дарга зөвлөлгөөн явагдах өдөр, цагийн тухай Засгийн газарт мэдэгдэнэ. Засгийн газар зөвлөлгөөнд төлөөлөгчөө оролцуулж болно.
- 4- 7. Хэлэлцэх асуудлын талаар мэдээлэх

49-р зүйл

1. Үндэсний хуралд хэлэлцэгдэх төслөөр ерөнхий хэлэлцүүлэг хийх журмыг Зөвлөлгөөнөөс тодорхойлж болно.
2. Ерөнхий хэлэлцүүлгийн журмыг тусгайлан тодорхойлсноос бусад тохиолдолд Зөвлөлгөөн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллын хүрээнд зөвхөн ерөнхий хэлэлцүүлгийн үргэлжлэх хугацааг тогтооно. Энэ хугацааг Үндэсний хурлын дарга фракцуудад хуваарилахдаа хэлэлцүүлгийн хугацаанаас хамааран фракц бүрд адилхан бөгөөд хамгийн бага хугацаа оногдохоор зохицуулна. Аль нэг фракцид ордоггүй гишүүдэд хэлэлцүүлгийн хугацааны хүрээнд тэдний тоонд пропорционал хугацаа оногдоно. Үлдсэн хугацааг Үндэсний хурлын дарга фракцуудад тэдний гишүүдийнх нь тоонд пропорционалаар хуваан оногдуулна.
3. Жилийн төсөв хэлэлцэхээс бусад тохиолдолд Зөвлөлгөөнөөс фракц бүрд оногдсон хугацааны хүрээнд гишүүдийн үг хэлэх хугацаанд хязгаар тавьж болно.
4. Фракцийн дарга нар үг хэлэх хүмүүсийн нэрийг бичиж авч Үндэсний хурлын даргад мэдэгдэхдээ тэднийг ямар дарааллаар, ямар хугацаагаар үг хэлүүлэх тухай саналаа мөн хүргүүлнэ. Гэхдээ санал болгож буй үг хэлүүлэх хугацаа нь 5 минутаас бага байж болохгүй.
5. Дээрх саналыг үндэслэн Үндэсний хурлын дарга үг хэлэх дарааллыг тогтооно. Гэхдээ фракцийн даргын шаардлагаар фракцийн нэрийн өмнөөс үг хэлэх гишүүнд эхэлж үг хэлэх боломж олгоно.

БҮЛЭГ XII. НЭГДСЭН ХУРАЛДААН

50-р зүйл

3. Дарга нарын Зөвлөлийн саналаар шаардлагатай тохиолдолд хэлэлцэх асуудлын хүрээнд бусад нэгдсэн хуралдааныг зохион байгуулж болно. Гэхдээ хороод хуралдах ёстой өглөөний цагаар эдгээр хуралдааныг зохион байгуулж үл болно.
4. Ерөнхий сайд Үндэсний хурлын ийм хуралдааныг зохион байгуулахыг шаардах эрхтэй.
5. Үндэсний хурлын дарга, сонирхогч хорооны дарга нар асуудлыг цаг алдалгүй хэлэлцэхийн тулд мөн хурлын ийм хуралдааныг зохион байгуулахыг шаардах эрхтэй. Ингэсэн тохиолдолд тухайн асуудлыг хэлэлцүүлж буй талууд буюу санал оруулагч тал, саналыг үл дэмжигч талын илтгэл, засгийн газар ба хорооны дарга эсвэл илтгэгч оролцсон хэлэлцүүлгийн дараа л Хурлаас нэмэлт хуралдаан явуулах эсэх талаар шийдвэр гаргана.
6. Үндсэн хуулийн 18,35,36,49 дүгээр зүйл, санхүүгийн хуулиудыг хэлэлцэх, ээлжит бус чуулганы үеэр хороод хуралдах ёстой өглөөний цагаар нэгдсэн хуралдааныг зохион байгуулж болно.
7. Засгийн газраас шаардсан, Үндэсний хурлаас түүний Даргын зөвлөснөөр санал нэгтгэйгээр шийдвэрлэснээс бусад тохиолдолд хуралдааныг шөнө дундаас хойш явуулж үл болно.

52-р зүйл

1. Үндэсний хурлын дарга хуралдааныг нээж, хэлэлцүүлгийг удирдан, хуралдааны дэгийг сахиулж, дуртай цагтаа хуралдааныг зогсоож, хааж болно.
2. Хуралд дэг журам сахиулах арга хэмжээг Үндэсний хурлын дарга өөрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлнэ.

54-р зүйл

1. Үг хэлж байгаа илтгэгчийн зүгээс түүний үгийг тасалж дундуур нь үг хэлэхийг зөвшөөрсөн ч гэсэн Хурлын гишүүн, Үндэсний хурлын даргаас үг хэлэх зөвшөөрөл авах үүрэгтэй. Ийм тохиолдолд илтгэгчийн үг 5 минутаас илүү хугацаагаар тасалдах ёсгүй.
2. Үг хэлэхийг хүссэн депутатууд Үндэсний хурлын даргад нэрээ бичүүлж, Дарга үг хэлэх дарааллыг тогтооно.
3. Дэгээр зохицуулсан хэлэлцүүлгээс гадна Дарга, санал өгөх сэдлийг тайлбарлуулах зорилгоор бүлэг бүрээс 1 илтгэгчид 5 минут үг хэлэх зөвшөөрөл өгч болно.
4. Илтгэгч индэр дээр эсвэл суудал дээрээсээ үг хэлж болно. Дарга түүнийг индэр дээр үг хэлэхийг урьж болно.
5. Хэрэв Дарга, Хурал хангалттай мэдээлэл авлаа гэж үзвэл илтгэгчийг үгээ дуусгахыг хүсч болно. Үүний нэгэн адилаар хэлэлцүүлгийн эрх ашгийн үүднээс илтгэгчийн үг хэлэх хугацааг сунгаж болно.
6. Илтгэгч хэлэлцэж буй асуудлаас өөр зүйл ярих ёсгүй. Ингэсэн тохиолдолд Дарга энэ тухай түүнд сануулна. Хэрэв илтгэгч үүнийг хүлээн авахгүй, зөвшөөрөлгүй үргэлжлүүлэн ярьсан бол Дарга түүний үг хэлэх эрхийг хасч болно. Ийм тохиолдолд Дарга, энэ хэсгийн XIV бүлэгт заасан сахилгын арга хэмжээг авсан эсэхээс үл хамааран илтгэгчийн хэлсэн үгийг протоколд оруулахгүй байх шийдвэр гаргана.

55-р зүйл

1. Цаг хязгаарласан хэлэлцүүлэгт үг хэлж буй илтгэгч фракцид олгогдсон хугацааг ямар ч тохиолдолд хэтрүүлж үл болно.
2. Үг хэлэх хугацаагаа хэтрүүлсэн тохиолдолд Үндэсний хурлын дарга 54 дүгээр зүйлийн 5 ба 6 дахь заалтыг хэрэглэнэ.
3. Хэрэв фракц үг хэлэх хугацаагаа дуусгасан бол түүний гишүүдэд үг хэлэх хугацаа өгөхгүй.
4. Хэрэв үг хэлэх хугацаагаа дуусгасан фракцийн гишүүн тухайн хуульд өөрчлөлт оруулах

санал дэвшүүлсэн бол уг саналыг Үндэсний хурлын дарга уншиж, хэлэлцүүлэггүйгээр шууд санал хураана.

5. Үг хэлэх хугацаагаа дуусгасан фракцийн Дарга цаашид ямар нэг хуулийн төсөл, саналын ерөнхий санал хураалтаас бусад тохиолдолд нээлттэй санал хураалт явуулахыг шаардах боломжгүй.
6. Хэрэв хэлэлцүүлгийн явцад цаг хүрэлцэхгүй байдал үүсвэл Хурал, Үндэсний хурлын даргын саналын дагуу шууд хэлэлцүүлгийн цагийг сунгах шийдвэр гаргаж болно.

56-р зүйл

1. Сайд нар, дарга нар, хорооны илтгэгчид хэлэлцүүлж байгаа асуудлаараа хүссэн үедээ үг хэлэх эрх авна.
2. Үүний нэгэн адилаар хуулиар томилогдсон засгийн газрын комиссаруудад хуралдаанд оролцож байгаа засгийн газрын гишүүний хүсэлтээр үг хэлэх эрх өгнө.
3. Үндэсний хурлын дарга илтгэгчид засгийн газар, хороонд хариулт өгөх зөвшөөрөл олгож болно.

57-р зүйл

1. Хэрэв ерөнхий хэлэлцүүлэгт ямар нэгэн зүйл анги эсвэл санал өгөх сэдлийн асуудлаар 2 илтгэгчээс доошгүй тооны хүн эсрэг саналтай байвал Үндэсний хурлын даргын шийдвэр, эсвэл Хурлын гишүүний саналаар хэлэлцүүлгийн энэ шатыг энэхүү дэгийн 49 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд зогсоож болно. Гэхдээ хуулийн талаар бүхэлд нь санал өгөх сэдлийн асуудлаарх санал хэлэх үйл явцыг бүх фракцийн төлөөлөгчид үг хэлж дуусаагүй тохиолдолд зогсоож үл болно.
2. Хурлын гишүүн ерөнхий хэлэлцүүлгийг дуусгах санал гаргасан тохиолдолд үүний эсрэг саналтай нэг л гишүүнд 5-аас илүүгүй минутын үг хэлэх эрх олгоно. Ингэхдээ ийнхүү үг хэлэх эрхийг ерөнхий хэлэлцүүлэгт оролцохоор хамгийн эхэнд нэрээ бичүүлсэн гишүүнд, тэр гишүүн байхгүй бол дараагийн хүнд, хэрэв ерөнхий хэлэлцүүлгийг дуусгахын эсрэг саналтай гишүүд байхгүй бол саналаа хэлэхийг хамгийн түрүүнд хүссэн депутатад үг хэлэх эрх олгоно.
3. Хэлэлцүүлгийг дуусгах эсэх асуудлаар албан ёсны санал хураалт явагдахгүй. Хурлын гишүүд гараа өргөх журмаар саналаа өгнө. Хэрэв санал хураалтын дүн даргад тодорхой бус байвал депутатууд босох хэлбэрээр саналаа илэрхийлнэ. Үндэсний хурлын даргад эргэлзээ үлдвэл хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

58-р зүйл

1. Хэлэлцэж буй асуудлаар дэгийн болон хуралдааны журамтай холбоотой мэдэгдэл хийх бол хэлэлцүүлгийг түр зогсооно. Дэг болон журмын асуудлаар мэдэгдэл хийхийг шаардсан гишүүнд эсвэл шууд үг өгнө, эсвэл индэр дээр үг хэлж буй гишүүн хэлж дуусмагц үг хэлэх эрх өгнө.
2. Хэрэв гишүүний хийж буй мэдэгдэл дэгийн болон хуралдааны журамтай холбоогүй, эсвэл тогтсон хэлэлцэх асуудлыг хөндөж байвал Үндэсний хурлын дарга хэлж буй үгийг нь таслан, зогсооно.
3. Хуралдааныг Үндэсний хурлын шийдвэрээр болон засгийн газрын шаардлагаар түр зогсоож болно. Мөн тухайн асуудлыг хариуцаж буй байнгын хорооны дарга юмуу илтгэгч, эсвэл фракцийн шийдвэрийн дагуу фракцийн дарга юмуу түүний эрх олгон урьдчилан Үндэсний хурлын даргад нэрийг нь мэдэгдсэн гишүүн түр зогсоож болно.

59-р зүйл

1. Хуралдааныг хаахын өмнө хуралдаан даргалагч дараагийн хуралдааны тов, хэлэлцэх асуудлын талаар мэдээлнэ.
- 2-4. Хуралдааны протоколын тухай

АВСТРАЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТАНХИМЫН ХУРАЛДААНЫ ДЭГ
/House of Representatives Standing Orders, Parliament of Australia,
26 March 2015/

Үг хэлэх, илтгэл тавих, хэлэлцүүлгийн үед гишүүд болон хуралд оролцогчид дараах цагийн хязгаарлалтыг баримтална:

<i>Хэлэлцэх асуудал</i>		<i>Хугацаа</i>
Гишүүн хариулт өгөх	Гишүүн тус бүр	20 минут
Төлөөлөгчдийн танхимын хуралдааныг түр завсарлуулах, эсхүл Холбооны Танхимын хуралдааныг дуусгах Төлөөлөгчдийн танхимын нэгдсэн хэлэлцүүлэг Холбооны Танхим /Federation Chamber/ ²⁷ -ын нэгдсэн хэлэлцүүлэг Хэлэлцүүлгийн хугацааг сунгах /сайд хариу өгөх шаардлагатай зэрэг тохиолдолд/	Гишүүн бүр /хугацааг сунгахгүй/ Үг хэлсэн гишүүн, өөр гишүүн үг хэлэх хүсэлт гаргаагүй тохиолдолд Хэлэлцүүлгийг сунгасан /Сайд үг хэлэх/	30 минут Тодорхойгүй 10 минут 5 минут 5 минут 5 минут
Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг	Санаачлагч Сөрөг хүчний дарга, эсхүл төлөөлж буй гишүүн	Хугацаагүй Хугацаагүй
Засгийн газрын бусад асуудал /хоёр дахь хэлэлцүүлэг/	Санаачлагч Сөрөг хүчний дарга, эсхүл төлөөлж буй гишүүн Сайд мэтгэлцээний дүгнэлтийг хийхэд	30 минут 30 минут 15 минут
Гишүүний өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг	Санаачлагч Илтгэл тавих Хэлэлцүүлэг /санаачлагч шаардсан тохиолдолд/	10 минут 5 минут
Хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэг	Дээр заагаагүй бусад гишүүд	15 минут буюу түүнээс доош /Түр хорооноос тогтоосон хугацаа/
Бүх хуулийн төслүүд – нарийвчилсан хэлэлцүүлэг ²⁸ /Bills-all-consideration in detail/	Гишүүн тус бүр /үг хэлэх давтамж харгалзахгүй/	5 минут

²⁷ Холбооны танхим нь тодорхой асуудлын хүрээнд хэлэлцүүлэг явуулах үүрэгтэй. Холбооны танхим нь Төлөөлөгчдийн танхимтай зэрэгцэн хэлэлцүүлэг явуулах бөгөөд танхимын ажлыг хөнгөвчлөн, түргэн шуурхай явуулах зорилготой юм. Төлөөлөгчдийн танхимын бүх гишүүд нь Холбооны танхимын гишүүн байх бөгөөд бүгд хэлэлцүүлэг, хуралдаанд оролцох эрхтэй байна. Холбооны танхимын дарга нь Төлөөлөгчдийн танхимын дэд дарга байна. Холбооны танхим нь 1994 онд байгуулагдсанаасаа хойш “Үндсэн байнгын хороо” нэртэй байсан.

²⁸ Нарийвчилсан хэлэлцүүлэг

Хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг явагдсаны дараа Төлөөлөгчдийн танхим, эсхүл Холбооны танхимын хүсэлтээр нарийвчилсан хэлэлцүүлэг явуулж болно. Тус хэлэлцүүлгээр шаардлагатай бол зүйл, заалт тус бүр хэлэлцэж тохирно. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах веб хуудаснаас харна уу: http://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/practice/chapter10#cons

Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудал	Санаачлагч	30 минут
	Ерөнхий сайд эсвэл хариуцсан сайд	30 минут
	Бусад гишүүд	20 минут
Эмгэнэл, талархал илэрхийлэх /Хааны гэр бүлд эмгэнэл илэрхийлэх гм./	Гишүүн бүр	Хугацаа заагаагүй
Саналын зөрүүтэй байр суурь илэрхийлэх	Нийт хэлэлцүүлгийн хугацаа Санаачлагч	30 минут
	Саналыг дэмжигч	10 минут
	Дараагийн үг хэлэх гишүүн	5 минут
	Бусад гишүүд	5-10 минут
Хурлын дарга, дэд даргыг сонгох	Гишүүн бүр	5 минут
Гишүүдийн санал, гомдол хэлэлцэх /Grievance debate/²⁹	Нийт хэлэлцүүлгийн хугацаа	1 цаг
	Гишүүн бүр	10 минут
Яриа таслах	Гишүүн	30 сек
Олон нийтийн	Нийт мэтгэлцээний хугацаа	1 цаг
	Санаачлагч	10 минут
	Дараагийн гишүүн	10 минут
	Бусад гишүүн	5 минут
Бусад хэлэлцүүлэг-өөрөөр заагаагүй бол /Сайдад итгэл үзүүлэх эсэх, байнгын хороодын мэдээлэл, төрийн ажил, үйлчилгээний зөвшөөрөл олгох гэх мэт/	Санаачлагчийн байр суурь	15 минут
	Бусад гишүүд	10 минут
Асуулт хариулт	Асуулт бүр	30 сек
	Хариулт бүр	3 минут
Хурлын даргаас зөвшөөрсөн мэдээлэл		
Хаалтын үг	Гишүүн	20 минут
Бусад мэдээлэл /хариултад нэмэлт хийх, хувийн тайлбар, давуу эрх гэх мэт/	Гишүүн	Хурлын даргын үзэмжээр
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахтай холбоотой асуудлаар завсарлага авах	Нийт мэтгэлцээний хугацаа	25 минут
	Санаачлагч	15 минут
	Дараагийн үг хэлэх гишүүн	10 минут
	Бусад гишүүн	5 минут
Татвар, эсхүл хураамжийн төсөл	Санаачлагч	20 минут
	Сөрөг хүчний дарга эсвэл гишүүн	20 минут
	Бусад гишүүн	10 минут
Яаралтай асуудал	Нийт хэлэлцүүлгийн хугацаа	20 минут
	Гишүүн бүр	5 минут

²⁹ Гишүүдийн санал, гомдол хэлэлцэх
Холбооны танхим нь Даваа гариг бүр 20:00 цагаас 1 цагийн турш гишүүдэд санал, сонмдол илэрхийлэх боломж олгодог байна. Гишүүний ярих хугацаа 10 минутаас хэтрэхгүй байна. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаар орж харна уу.
http://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/00_-Infosheets/Infosheet_6_-_Opportunities_for_private_Members

КАНАДЫН ПАРЛАМЕНТЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ /МЭТГЭЛЦЭЭН/ ҮГ ХЭЛЭХ ХУГАЦААГ
ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛИАР ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ
/TIME LIMITS ON DEBATES AND LENGTHS OF SPEECHES/

Үйл ажиллагаа	Хэлэлцүүлгийн хугацаа	Тайлбар	Хэн үг хэлэх	Үг хэлэх хугацаа
Индэрээс хэлсэн үгийг хэлэлцэх	50(1). Хуралдааны 6 өдрөөс хэтрүүлэхгүй хугацаанд хэлэлцэнэ.	50(4), (5), (7). Хэлэлцүүлэг мэтгэлцээний эхний өдөр 15 минутын өмнө, 2 дахь өдөр тогтоосон хугацаа дуусахаас өмнө оруулах өөрчлөлтийн тухай асуултыг тавина. 4 дэх өдрийн тогтоогдсон хугацаа дуусахаас 30 минутын өмнө (хэрвээ байгаа бол) 2 дахь болон бусад оруулах өөрчлөлтүүдийн тухай асуулт тавина. 6 өдрийн хэлэлцүүлтийн хугацаа дуусахаас 15 минутын өмнө үндсэн саналын тухайд асуулт тавина.	Аль ч гишүүн*	50(2). 20 минут, 43(1) (b)10-минут асуулт ба тайлбарын хугацаа.
Завсарлага авах	38(1). 30 минут.	38(2). Асуулт тус бүрд ихдээ 10 минут (3 -аас илүү асуултанд завсарлага авахгүй)	Асуулт тавьж байгаа гишүүн	38(5). 4 минут ба хариултанд 1 минут.
Хуулийн төслийн орхих саналын танилцуулга	68(2). Хэлэлцүүлэггүй		Сайд эсхүл Парламентын нарийн бичгийн дарга хариулт өгөх нь	38(5). 4 минут ба, хариу үгэнд хариулахад 1 минут.
Хуулийн төслөөр Сайдын гаргасан саналыг бэлтгэж, хуралд оруулж ирэх комиссын санал	68(4). 90 минут		Санал оруулж буй гишүүн	68(2). Саналын нөхцөлийн тухай товч тайлбар.
Хуулийн төслийн, Засгийн газрын 2 дахь хэлэлцүүлэг болон 3 дахь хэлэлцүүлэг	Хугацаагүй.	73(5). Хязгаарлалт: Засгийн газрын тогтоолын 2 дахь өдөр дуусгавар болохоос 15 минутын өмнө, саналын эрх мэдлийг шилжүүлэх 2 дахь хэлэлцүүлгийн тухай асуулт тавих 68(6) , 68(7) ба тогтоолыг саналын дагуу өөрчилсөн 2 дахь хэлэлцүүлгийн үеэр мэтгэлцээн байхгүй.	Аль ч гишүүн	68(4). 10 минут. 43(1)(c). 5 минут, асуулт ба тайлбарын хугацаа.
			Эхний үг хэлэх ээлжинд албан ёсны нам бүрийн эхний гишүүд*	74(1)(a). 20 минут.
			Эхний үг хэлэх ээлжийн дараах мэтгэлцээн хэлэлцүүлгийн 5 цагийн дотор ярьж эхэлсэн аль ч гишүүн*	74(1)(b). 20 минут.
			5 цагийн дараа ярьж эхэлсэн аль ч гишүүн	74(1)(c). 20 минут.

2 дахь хэлэлцүүлгийн өмнө хорооноос тайлбар лавлагаа авах	73(1)(d). 5 цаг:	73(1)(a) Үг хэлэх дараалал: засгийн газар, албан ёсны сөрөг хүчин, бусад албан ёсны намууд хэмжээнийхээ дарааллаар, аль нэгэн намаас үг хэлэх ээлжиндээ гарахгүй бол өөр нэгэн гишүүн	Аль ч гишүүн	73(1)(c). 10 минут
Тайлан илтгэлийн шатны санал эсхүл саналуудын бүлэг (2 дахь хэлэлцүүлгийн дараах тайлан илтгэлийн санал)	Хугацаагүй.	-	Аль ч гишүүн	76.1(7). 10 минут. 43(1)(c). 5 минут- асуулт болон тайлбарын хугацаа .
Тайлан илтгэлийн шатны санал эсхүл саналуудын бүлэг (2 дахь хэлэлцүүлгийн дараах тайлан илтгэлийн санал)	Хугацаагүй.	76(1) .Танхимд тайлан илтгэл тавьсаны дараах хурлын 3 өдрөөс өмнө хэлэлцэхгүй. 76(7).20 минут үг хэлэх анхны өөрчлөлтийн тухай эхний ээлж өнгөрсөний дараа аль ч гишүүн тухайн шатны бусад өөрчлөлтийн тухайд нэгээс илүү эсхүл 10 минутаас илүү үг хэлэхгүй.	Албан ёсны намын анхны гишүүн анхны өөрчлөлтийн тухай хэлэлцүүлэгт үг хэлэх	76(7).20 минут.
Сенатын өөрчлөлт оруулалт, саналыг хүндэтгэх	Хугацаагүй.		Өөр бусад аль ч гишүүн	76(7). 10 минут.
Төсвийн хэлэлцүүлэг	84(2). Хурлын 4 өдөр дахин хэлэлцэнэ.		Санал оруулж буй сайд эсхүл сайдын нэрийн өмнөөс үг хэлж буй эхний гишүүн ба яг дараагаар нь үг хэлж буй гишүүн -Аль ч гишүүн	43(1)(a) Хязгаарлалтгүй. 43(1)(b) 10 минутын асуулт ба тайлбар. 43(1)(b). 20 минут**
Хаалт, хэлэлцэж тогтсон саналуудыг оруулах	57, 67.1(1)(a) Хэлэлцүүлэггүй, гэхдээ асуулт, хариултаас 30 минутын өмнө	84(4), (5), (6). Засгийн газрын тогтоол уншихаас 15 минутын өмнө өөрчлөлт оруулах тухай асуулт тавина. 2 дахь ба 3 дахь өдөр оруулах өөрчлөлтийг хэлэлцэх ба, 4 дэх өдөр нь үндсэн саналыг үйлдэнэ.	Сангийн Яамны сайд ба Сөрөг хүчний гишүүн үг хэлэх	84(7). Хязгаарлалтгүй 43(1)(b). 10 минут, асуулт хариулт 84(7). 20 минут 43(1)(b). 10 минут асуулт хариулт 67.1(1)(a). Товч асуулт.
		67.1(1)(b). Нэгтгэн дүгнэх 30 минутын хугацаанд асуулт тавих	Аль ч гишүүн	67.1(1)(a). Тавьсан асуултын түүний нэрийн өмнөөс үүрэг гүйцэтгэж буй сайд хаалт хийнэ.

	Санал хаасан	57. Аль ч гишүүн оройн 8:00 цагаас хойш энэ талаар үг хэлэхгүй	57. Бүх асуултыг тэр даруйд нь шийдвэрлэнэ.	Аль ч гишүүн	57. 20 минут** 43(1)(b). 10 минут асуулт ба тайлбар
	Байнгын хороо, санал оруулах	Хугацаагүй.	Үндсэн үнэлгээний хэлэлцүүлэг үүнд хамаарахгүй.	Аль ч гишүүн (нэгээс илүү удаа үг хэлж болно)	101(3). Тухайн үест 20 минут (Ерөнхий сайд ба сөрөг хүчний удирдагчийн үг хэлэх хугацаа хязгааргүй)
	Дүрмийн танилцуулгыг цуцлах шийдвэр бүхий илтгэл тавих	Хэлэлцүүлэггүй		Илтгэл тайлан тавьж буй хорооны гишүүн	123(4). Тухайн илтгэл тайланд шийдвэр ба дүрмийн арга хэрэгсэлүүд багтсан ба дараагийнхийг тодорхойлсон болохыг мэдэгдэх ёстой.
	Саналыг хүлээж авалгүй шийдвэрлэх	126(1). 1 цаг		Аль ч гишүүн	126(1)(a). 10 минут
	Хурлын даргыг сонгох, нэр дэвшигчдийг зарлах	Хэлэлцүүлэггүй	Үйл ажиллагааны тухай санал хураалт эхлэхээс өмнө нэр дэвшигчдийг зарлах ёстой	Аль ч нэр дэвшигч	3.1. 5 минут
	Шуурхай хэргийн мэтгэлцэн (Emergency Debate)	52(12). Шөнийн 12 цагаас эсхүл Баасан гаргийн өдрийн 4:00 цагаас оройтуулалгүйгээр	52(9), (10), (11). Хурлын дарга дараагийн хурлыг товллоогүй бол өдөр тутмын завсарлагааны ердийн цагаар мэтгэлцээнийг эхлүүлэх эсхүл Баасан гаралт яаралтай хуралдах	Аль ч гишүүн	52(13). 20 минут 43(1)(b). 10 минут асуулт ба тайлбар
	Санал (дэгийн тухай хуульд өөрөөр заагаагүй бол ерөнхий саналууд)	Хугацаагүй		Засгийн газрын тогтоол санал оруулж буй сайд (эсхүл Сайдын нэрийн өмнөөс үг хэлж буй эхний гишүүн) ба тэр даруй дараа нь үг хэлж буй гишүүн	43(1)(a) Хугацаагүй 43(1)(b) 10 минут асуулт ба тайлбар
	Өргөдөл танилцуулах	36(7). Хэлэлцүүлэггүй.	36(6). Өргөдөл танилцуулах гишүүн 15 хүртэлх минут	Өөр бусад аль гишүүн (эсхүл хэрвээ санал нь Засгийн газрын тогтоол биш бол аль гишүүн)	43(1)(b) 10 минут асуулт ба тайлбар**
	Хуулийн төслийн 2 дугаар хэлэлцүүлгийн үед Гишүүн санал нийлээгүй	96(1). 1 цаг.	-	Гишүүн өргөдлийн талаар танилцуулга хийх	Өргөдлийн товч агуулга
				Санал оруулсан гишүүн эсхүл өөр ямар ч гишүүн	95(2). Санал оруулсан гишүүн хэлэлцүүлгийг нээж 15 минут, хааж 5 минут үг хэлнэ. Бусад гишүүд 10 минут үг хэлэх бөгөөд хэлэлцүүлгийн нийт ургэлжлэх хугацаа 40 минутаас ихгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар хэлэлцүүлэг	93(1), 2 цаг.	93(1). Хуралдааны 2 өдрөөс хэтрүүлэхгүй 1 цаг. 93(2). Хуралдааны 10 өдрийн дотор эхний болон эцсийн хэлэлцүүлэг явагдана.	Санал оруулсан гишүүн Аль нэг гишүүн	95(1). Санал оруулсан гишүүн 15 минут, 5 минут асуулт асуух, санал хэлэх. Бусад гишүүд 10 минут.
Хуулийн төслийн 3 дугаар хэлэлцүүлэг	98(2), 2 цаг.	98(4). 2 өдөр хэлэлцэж дуусаагүй бол эцэслэн шийдвэрлэнэ. 98(3). Хэлэлцүүлгийг эхний 30 минутад шийдвэрлээгүй бол дараагийн хэлэлцүүлгийн 2 өдөр 5 хүртэлх цаг сунгана.	Бусад гишүүд мэдээлэл хийх 3 дугаар хэлэлцүүлэгт санал оруулсан гишүүн Бусад гишүүдийн хэлэлцүүлэг	76.1(7). 10 минут. 95(1). Санал оруулсан гишүүн 15 минут, 5 минут асуулт асуух, санал хэлэх. 97.1(2)(c)(i), 10 минут .
Хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэх эсэх талаар санал нийлэх	97.1(2)(c), 1 цаг.	97.1(2)(c) Хурлын дарга хэлэлцүүлгийн үргэлжлэх хугацааг өдөр тутмын ердийн цагаар тогтооно. 97.1(2)(c) Хэлэлцүүлгийн дараа асуулт, хариулт	Аль ч гишүүн	
Сенатын оруулсан нэмэлт, өөрчлөлт санал	90. Хугацаагүй.	30(6), (7). 1 цагаас ихгүй.	Санал оруулсан гишүүн Бусад гишүүд	95(1). Санал оруулсан гишүүн 15 минут, 5 минут 95(1). 5 минут асуулт, санал 95(1). 10 минут.
Санал хүргүүлэх	97(2), 2 цаг.	97(2). Хэлэлцүүлгийн 1 цаг 50 минутын дараа Сайдыг төлөөлж парламентын тамгын газраас хүргүүлсэн саналыг хэлэлцүүлнэ. 30(6), (7). Хэлэлцүүлгийн 2 өдөр 1 цагаас хэтрүүлэхгүйгээр хэлэлцэнэ.	Санал оруулсан гишүүн Бусад гишүүд Сайдын нэрийн өмнөөс парламентын тамгын газраас хэлэлцүүлэгт оролцож болно.	97(2). Санал оруулсан гишүүн 15 минут. 95(1). 5 минут асуулт, санал 95(1). 10 минут. 97(2). 5 минут.
Байнгын хорооны танилцуулга	Хэлэлцүүлэггүй	-	Байнгын хорооны гишүүн	35 (1). Асуудлын товч тайлбар
Заримын зөрүүтэй санал гарсан бол	Хэлэлцүүлэггүй	-	Албан ёсоор санал гаргасан гишүүн, эдгээр саналыг дэмжиж буй гишүүдийн төлөөлөл	35 (2). Товч тайлбар
Зөвшилцсөн санал	66(2), 3 цаг.	66(2). Хэлэлцүүлэг хойшлогдсон бол хэлэлцэх асуудлын дараалалд багтаана. 66(2). Хэлэлцүүлгийн дараа асуулт тавихгүй.	Аль ч гишүүн *	43(1)(b). 20 минут** 43(1)(b). 10-минут асуулт, санал
Ёс зүйн комиссын гишүүний тайлан	Хэлэлцэхгүй	Section 28(9). Тайлантай холбоотой асуудлаар яаралтай биш бол 10 хоногийн дараа асуулга тавина.	Тухайн гишүүн	Section 28(9), 20 минут.
	Хугацаагүй	66(1). Хэрэв хэлэлцүүлэг завсарласан бол журмын дагуу Засгийн газарт шилжүүлнэ.	Аль ч гишүүн *	43(1)(b), 20 минут** 43(1)(b). 10-минут асуулт, санал.

	Хугацаагүй	66(1). Хэрэв хэлэлцүүлэг завсарласан бол журмын дагуу Засгийн газарт шилжүүлнэ.	Аль ч гишүүн *	43(1)(b). 20 минут** 43(1)(b). 10-минут асуулт, санал.
	28(11). 2 цаг.	-	Аль ч гишүүн *	section 28(11). 10 минут. 43(1)(c). 5-минут асуулт, санал.
Дээд танхимын төлөөлөгч танилцуулга, тайлан	Хэлэлцэхгүй	-	Төлөөлөгч гишүүн	34 (2). Асуудлын товч танилцуулга.
Сайдын оруулсан саналыг 6 дугаар сард 10 хоногоор сунгах	27 (2). 2 цаг.	27 (1). Журмын дагуу 06.23-наас өмнө 10 өдөр.	Аль ч гишүүн *	43 (1) (б). 20 минут ** 43 (1) (б). 10 минут асуулт, санал .
Сайдын оруулсан яаралтай асуудлаар	53 (3) (а). 1 цаг.	53 (3) (г). Хэлэлцүүлэг завсарлага авах болон хойшуулахгүй.	Аль ч гишүүн *	53 (3) (ө). 10 минут. 43 (1) (ө). 5 минут асуулт, санал.
Хурлын Дэгийн асуудлыг авч үзэх	51 (2). 1 өдөр.	51 (1). 60- 90 хоногийн дотор чуулганы 1 улиралд багтаан шийдвэрлэнэ.	Аль ч гишүүн *	51 (3). 10 минут 43 (1) (ө). 5 минут асуулт, санал хугацаа.
Сайдын тайлан	-	33 (2). Сайдын тайланг сонсоны дараа Сөрөг хүчний төлөөлөгч санал хэлнэ.	Сайд Сөрөг хүчний намын аль нэг гишүүн	33 (1). Товч тайлан тайлбар
Гишүүн тайлан	Хэлэлцэхгүй	30 (5). Тайланг 15 минут.	30 (5). Сайд болон Аль ч гишүүн	31.1 минут.

* Ерөнхий сайд болон сөрөг хүчний тэргүүн хязгааргүй хугацаагаар ярих хэдий ч асуулт болон сэтгэгдэл 10 минут байна.

** Any Member rising to speak or the Whip of a party may indicate that one or more of the periods of debate are to be divided in two. — S.O. 43(2) [motions in general] or S.O. 74(2) [2nd, 3rd reading motions- Аль ч гишүүн мэтэлцээний хугацаанд хоёр хэсэгт хуваагдаж болох ба нэг намын гишүүний үг хэлэх хугацаанд гар өргөж ярих.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Stortinget the norwegian parliament rules of procedure <https://www.stortinget.no/Global/pdf/Diverse/StortingetsForretENGELSK.pdf>.
- Rules of Procedure of the German Bundestag and Rules of Procedure of the Mediation Committee <https://www.btg-bestellservice.de/pdf/80060000.pdf>
- Standing Orders of Australia- <http://www.aph.gov.au/~media/05%20About%20Parliament/53%20HoR/532%20PPP/StandingOrders/fullreport.pdf>
- Rules of procedure of the National Assembly, January 2007-
- Standing Orders of Canada-<http://www.parl.gc.ca/about/house/standingorders/toc-e.htm>
- Rules of procedure of the National Assembly) January 2007 . www.legislationline.org/download/action/download/id/2084/file/

БАЙНГА ТӨВИЙГ САХИХ СТАТУСТАЙ УЛСУУД: ТУРШЛАГА, СУРГАМЖ

А.Пагма, Ц.Болормаа,
Д.Жигваагүнсэл

1. *Байнга төвийг сахих статусаа зарласан орнуудын тухай*

Олон улсын эрх зүйд байнга төвийг сахих статус гэдэг нь тодорхой улс орон ямар нэгэн дайн байлдааны үйл ажиллагаанд үл оролцох, энх тайван үед цэргийн эвсэлд үл нэгдэх байр суурь баримтлахаа илэрхийлж, түүнийгээ олон улсын гэрээ, дотоодын эрх зүйн баримт бичгээр баталгаажуулсан улс төр, эрх зүйн статус юм.

Энэ үүднээс байнга төвийг сахих статусаа зарласан улс орон нь өөрийн нутаг дэвсгэрт гадаадын цэргийн бааз байрлуулахгүй, дайны үед нутаг дэвсгэр, усан ба агаарын орон зайгаа дайтаж буй талуудад ямар нэг байдлаар ашиглуулахгүй, тэдгээрийн аль алинд нь шууд ба шууд бусаар тусламж үзүүлдэггүй байна.³⁰

Дайн байлдаан, зөрчилдөөнд төвийг сахих байр суурь баримтлах улсуудын эрх, үүргийг 1907 оны Гаагын V конвенцид тодорхойлсон.

Байнга төвийг сахих статустай орон нь тус улсад бусад улсын зүгээс халдсан тохиолдолд өөрийгөө хамгаалах эрхтэй. Үүний зэрэгцээ эдгээр улс нь олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцох, өөрийгөө хамгаалахад шаардлагатай цэрэг, армитай байх эрхтэй юм.

Урд нь Бельги (1813—1919), Люксембург (1867—1944) улсууд байнга төвийг сахих статустай байсан ба өнөө үед Мальт, Туркменистан, Лаос, Камбож, Австри, Швейцар улсууд байнга төвийг сахих статустай байна.

Швейцар улсын байнга төвийг сахих статусын тухай гэрээнд 1815 онд Австри, Их Британи, Франц, Орос, Португал улсууд гарын үсэг зурж, Швейцарын байнга төвийг сахих статусыг хүлээн зөвшөөрсөн ба 1919 онд Версалийн энх тайвны гэрээгээр баталгаажуулсан байна. Гэрээнд гарын үсэг зурсан улс орнууд Швейцарын байнга төвийг сахих статус болон тус улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг ийнхүү баталгаажуулахын зэрэгцээ ийм байдал алдагдахад хүрсэн тохиолдолд Швейцарын байнга төвийг сахих статусыг хамгаалах үүрэг хүлээсэн ажээ.

1955 оны 4 дүгээр сард гарын үсэг зурсан Зөвлөлт-Австрийн санамж бичгийн дагуу Австри улс Швейцар улсын нэгэн адил төвийг сахих статустай болох тухай тунхаглалыг гарган зарлах үүрэг хүлээсэн ба 1955 оны 12 дугаар сард Австрийн парламент “Австрийн төвийг сахих статусын тухай” Холбооны хуулийг баталж байнга төвийг сахих статусаа зарласан байна.

1962 оны 7 дугаар сарын 23-ны өдөр Лаосын асуудлыг зохицуулах зорилго бүхий 14 улсын Женевын олон улсын зөвлөлгөөны үеэр Лаосын төвийг сахих статусын тухай Тунхаглалд гарын үсэг зурсан ба зөвлөлгөөнд оролцогч улсууд Лаосын засгийн газрын 1962 оны 7 дугаар сарын 9-ны өдрийн төвийг сахих статусын тухай мэдэгдлийг хүлээн авч, Лаос улсын тусгаар тогтнол, бие даасан байдал, эв нэгдэл, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүлээн зөвшөөрөн, хүндэтгэж байгаагаа илэрхийлсэн байна.

1991оны 10 дугаар сарын 23-ны өдөр Парисын бага хурлын Төгсгөлийн баримт бичигт Камбожийн төвийг сахих статусыг тодорхойлсон. Тус улсын тусгаар тогтнол, бие даасан

³⁰ Convention (V) respecting the Rights and Duties of Neutral Powers and Persons in Case of War on Land. The Hague, 18 October 1907. / www.icrc.org/ihl/INTRO/200?OpenDocument

байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, төвийг сахих статусын халдашгүй байдал, Камбожийн үндэсний эв нэгдлийн талаарх Төгсгөлийн баримт бичгийн бүрэлдэхүүн хэсэг болсон Гэрээнд Камбож улсад байнга төвийг сахих статусаа өөрийн Үндсэн хуулиар баталгаажуулахыг үүрэг болгожээ. Гэрээнд гарын үсэг зурсан бусад улсууд Камбожийн төвийг сахих статусыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэх үүрэг хүлээсэн байна.

Камбож улс 1993 онд батлагдсан Үндсэн хуулийнхаа 1 дүгээр зүйлд байнга төвийг сахих, эвсэлд үл нэгдэх статусаа баталгаажуулжээ.³¹

Бүгд Найрамдах Мальт Улс 1981 оны 5 дугаар сарын 14-ны өдөр байнга төвийг сахих статусын тухай Тунхаглал гаргаж тус улс нь төвийг сахисан орон бөгөөд цэргийн ямар нэгэн эвсэлд орохоос татгалзаж байна хэмээн зарлажээ.

Туркменистан улс нь байнга төвийг сахих статусын тухайгаа 1995 оны 12 дугаар сарын 12-ны өдөр “Туркменистан улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Туркменистаны байнга төвийг сахих статусын тухай” зэрэг хуулиудыг батлан зарласан байна. НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1995 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн “Туркменистаны байнга төвийг сахих статус” гэсэн тогтоолоор тус улсын байнга төвийг сахих статусыг хүлээн зөвшөөрч дэмжсэн.

2. Төвийг сахих статусаа баталгаажуулсан туршлага, сургамж, үр дагавар

1 . ШВЕЙЦАР УЛС³²

Швейцарын “байнга төвийг сахих статус”-ыг төвийг сахихын уламжлалт сонгодог загвар гэж үздэг. Хэдийгээр эртнээс өөрсдөө төвийг сахих статусыг баримталсан боловч 1815 оны Венийн их хурлын тунхаглалаар Швейцарын тусгаар тогтнолыг сэргээж, төвийг сахих статусыг нь тогтоосныг мөн онд Парисын гэрээгээр Австри, Англи, Орос, Прусс, Франц улсууд хүлээн зөвшөөрсөн байдаг. Дэлхийн I дайныг эцэслэсэн Версайлийн 1919 оны гэрээгээр Швейцарын төвийг сахих статусыг баталгаажуулсан юм. 1815 оны Холбооны зөвшилцөл ба 1848, 1874, 1999 оны Үндсэн хуулиудад нь төвийг сахих статус нь тус улсын төр захиргааны гадаад бодлогын хэм хэмжээ болж хуульчлагдсан байдаг. Тодорхой хэлбэл, Швейцарын Үндсэн хуулинд “төвийг сахих статус нь тус улсын тусгаар тогтнолыг хамгаалах хэрэгсэл”³³ гэж заажээ.

Швейцар нь төвийг сахисан улсын хувьд олон улсын харилцаанд ажиглах, зуучлах, эвлэрүүлэх, энхийг дэмжих үйл ажиллагааг маш идэвхтэй явуулдаг бөгөөд нутаг дэвсгэрээ олон улсын яриа хэлэлцээр явуулах, олон улсын байгууллага байрлах талбар болгодог байна. Тухайлбал, 1953 онд Солонгосын дайн, 1967 онд Ойрхи Дорнодын зэвсэгт мөргөлдөөний дараа эвлэрлийн нөхцөлийг хянахад оролцсон, олон орны сонгуульд ажиглагч илгээдэг, НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцдог, Европын Зөвлөл, Европын Аюулгүй Байдал, хамтын ажиллагааны байгууллагын гишүүн бөгөөд олон улсын 26 байгууллагыг нутаг дэвсгэртээ байрлуулдаг.

Хэдийгээр 1986 онд хүн амын 75% буюу дийлэнх олонхийн саналаар НҮБ-д элсэхээс татгалзаж байсан боловч 2002 онд бүх нийтийн санал асуулгаар хүн амын 54,6 % дэмжсэнээр НҮБ-ийн гишүүнээр элсэхдээ: «Швейцар нь олон улсын эрх зүйд үндэслэсэн төвийг сахих статустай орон мөн. Тиймээс НҮБ-д гишүүнээр элссэн ч төвийг сахисан хэвээр байна» гэж мэдэгджээ. Ийнхүү Швейцар нь түүхэнд анх удаа бүх нийтийн санал асуулгаар НҮБ-ын гишүүн болсон анхны орон болсон юм.

³¹ The Constitution of the Kingdom of Cambodia ,Article 1, on September 21, 1993. <http://faolex.fao.org/docs/pdf/cam117198.pdf>

³² “Swiss neutrality” brochure, 2004. www.vbs.admin.ch/internet/vbs/en/home/documentation/publication.parsys.

³³ Constitution of Switzerland- https://www.constituteproject.org/constitution/Switzerland_2014?lang=en

Төвийг сахих статусаа баталгаажуулсан туршлага, сургамж:

Швейцар нь дотооддоо хэд хэдэн өөр хэл соёл, шашинтай улс тул төвийг сахих байр суурь нь ямагт дотоод эв нэгдлийн баталгаа болж иржээ. Учир нь төвийг сахих бодлогын зарчмуудыг холбооны дотоод зөрчлийг шийдвэрлэхдээ тухайн нөхцөл байдал ба улс орны эрх ашигт тохируулан маш уян хатан хэрэглэсээр иржээ.

Эхэн үедээ төвийг сахих нь дайныг яаралтай зогсоох маягийн хэв шинжтэй байжээ. Гэхдээ түүхэн явцдаа энэ нь маш тодорхой бөгөөд бодитой давуу талуудыг бүрэлдүүлж өгөх болсон байна.

Швейцарын хувьд төвийг сахих статусыг сонгох болсон хамгийн гол түүхэн сурвалж нь Европт өрнөсөн 30 жилийн дайн байжээ. Энэ дайны явцад Швейцар нь хэдийгээр аль ч улсаас дутахааргүй цэргийн хүчтэй боловч зарим үед гадаад орныг эзлэх, зарим үед гадаадын цэргийн хүчинд автагдахын сацуу ард олон дайн самууны хөлд олон талаар нэрвэгдэж байв. Жишээлэхэд, Италийн нутаг дэвсгэр дээр маш амжилттай тулалдаж явсан Швейцарын 20 гаруй мянган цэрэгтэй холбооны арми 1515 онд өөрийн хүчнээс давуу хүчтэй тулгарч Мариньяногийн тулалдаанд ялагдал хүлээсэн байдаг. Үүний дараа Францын Франсис I Хаан 1516 онд Швейцартай энхийн гэрээ байгуулахдаа гадаад бодлогын тал дээр тус улсыг ихэд хязгаарлах нөхцөлийг тулгасан юм. Үүнээс хойш 1797-1798 оны хооронд Франц улс Швейцарийг 4 үе шаттайгаар довтлон эзэлж, улмаар түүнийг өөрийн цэргийн холбоотон болохыг тулгаснаар Швейцарын төвийг сахих статус 16 жилийн туршид цуцлагдсан юм. Энэ хугацаанд тухайлбал, 1799 онд Швейцар нь Европын зонхилох гол хүчнүүдийн хооронд өрнөсөн дайны талбар болж хувирсан байдаг. Энэ үед энгийн ард иргэд дайн тулалдааны хөлд асар ихээр нэрвэгдэн зовж байсан тул Швейцар нь Франц улсаас өөрийн төвийг сахих статусыг сэргээж өгөх шаардлагыг хүргүүлсэн боловч Франц улс зөвшөөрөөгүй байдаг.

Харин 1815 онд Швейцар нь Наполеоны цэргийн эсрэг тулалдаанд оролцож, бас Хантингенийг бүслэхэд ч оролцсон. Швейцарын зэвсэгт хүчний энэхүү сүүлчийн гадаад орны нутаг дэвсгэр дээр хийсэн байлдааны ажиллагаанаас үүдэн Францын эрх мэдэлтнүүд Швейцарын байнгын төвийг сахих статус ба түүний нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Эндээс харахад өөрийн төвийг сахих статусыг хүлээн зөвшөөрүүлэхэд Швейцарын цэрэг арми маш том үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой байна. Бас нэгэн чухал түүхэн үйл явдал бол Франко-Пруссийн дайны үед Швейцар нь бут цохигдсон генерал Чарльз Боурбакийн командалсан Францын зүүн жигүүрийн армийг (93,000 хүнтэй) нутагтаа хүлээн авч орогноулах хүсэлтэй буйгаа зарласан болон бусад (1863 онд Улаан Загалмай Нийгэмлэгийг байгуулсан гэх зэрэг) санал санаачилгууд нь Швейцарын төвийг сахих статусыг олон улсад өргөнөөр хүлээн зөвшөөрөх үндэс болжээ.

Швейцар нь 1907 онд Төвийг сахисан улсын эрх, үүргийн тухай Гаагийн хэлэлцээрт гарын үсэг зуржээ.

Дэлхийн I дайны үед, дайны дараагаар Швейцар төвийг сахисан байр суурийг хуульд нийцүүлэн сахиж мөрдөж байсныг түүхэн баримтууд гэрчлэн харуулж байна. Тухайлбал,

- Дэлхийн хоёрдугаар дайн эхлэхэд Швейцарын Холбооны Зөвлөл нь Швейцарын төвийг сахих статусыг батлан илэрхийлж, үүнийг нь дайтагч талууд бүгд хүлээн зөвшөөрсөн юм. Ийнхүү хүлээн зөвшөөрсөн нь олон улсын хууль, эрх зүйгээс гадна тус улсын эдийн засгийн болон цэрэг армийн хүчин чадал сайн байсантай холбоотой юм.
- Дайны дараах үед Холбооны Консул Макс Петитпьерре-гийн баримталсан Швейцарын гадаад бодлогын уриа нь «Төвийг сахих статус ба нөхөрлөл» байв. Үүгээр тэрээр өөрийн улсын төвийг сахисан статусыг олон улсын хэмжээнд хүлээн

зөвшөөрүүлж, нэр хүндийг нь улам өргөсөн.

- 1953 онд бүх талууд харилцан зөвшөөрсний үндсэн дээр Швейцарын ажиглагчид Солонгосын хилийг тогтоох ажилд оролцсон. Энэ нь төвийг сахих идэвхтэй байр суурийн эхлэлийг тодорхой харуулсан хэрэг байсан бөгөөд өнөөг хүртэл Швейцар нь хилийн чандад энхийг дэмжих олон талт үйл ажиллагаанд оролцсоор ирсэн.
- Ирак улс Кувейтыг эзлэсний дараа НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс Иракт эдийн засгийн хориг тавьсан. Швейцарын Холбооны Зөвлөл нь эдийн засгийн хоригийг бие даан хэрэгжүүлэх нь төвийг сахих статустай нийцнэ хэмээн тунхагласан боловч Швейцар нь энэ хоригт оролцоогүй юм.
- Югославт дэгдсэн дайны үед Швейцар нь зөвхөн Босния ба Герцеговинатай хамааралтай олон улсын энхийг сахиулах хүчний (IFOR/SFOR) цэргийнхэн болон тэдний зэвсэг хэрэгслийг дамжин өнгөрүүлэхийг зөвшөөрч байсан. Энэ нь НҮБ-ийн Аюулгүйн Зөвлөлийн мандаттай ажил байсан тул төвийг сахих статустай нь харшлаагүй ажээ.
- 1996 оноос эхлэн НАТО-гийн санаачилгаар байгуулагдсан Энхийн үйлсийн төлөөх хамтын ажиллагаа (Partnership for peace (PFP)) хөтөлбөрт оролцдог. PFP нь Европын аюулгүй байдлын бодлого ба цэргийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилготой хөтөлбөр бөгөөд Швейцарын оролцоо нь үүнд юуны түрүүнд заавал НАТО-гийн гишүүн байх албагүй, зэвсэгт мөргөлдөөний үед цэргийн дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээддэггүй тул төвийг сахих статустай нь бүрэн нийцэж байгаа юм. Тийм учраас, 1996 оны 11-р сарын 30-нд гаргасан Швейцарын албан баримтанд: «Швейцар нь байнгын бөгөөд зэвсэгт хүчнээрээ баталгаажсан төвийг сахих статустай. Тиймээс энэ нь бид төвийг сахих бодлого, байр сууриа орхисон хэрэг биш. Мөн НАТО-д элсэхийг ч хүсч байгаа хэрэг биш юм» гэжээ.
- 1999 оны Косовогийн хямрал тэмцлийн үед Швейцар нь НАТО-гийн цэргийн онгоцыг болон цэргийн зэвсэг хэрэгслийг нутаг дэвсгэрээрээ нислэг үйлдэх ба дамжин өнгөрүүлэх хүсэлтийг хүлээж аваагүй байдаг. Учир нь энэ үед НАТО-ын цэрэг дайны үйл ажиллагаа НҮБ-ын мандатгүй явагдаж байсан тул төвийг сахих хуулийг даган биелүүлэх учиртай байв. Европын бусад төвийг сахисан улс орнуудын нэг адилаар Швейцар нь НҮБ болон Европын Холбооноос Югославт тавьсан цэргийн бус хоригуудад нь нэгдэн орсон байдаг. Учир нь эдгээр хоригууд нь төвийг сахисан байр суурь, үүнтэй холбогдох хуультай зөрчилдөхгүй юм. Энэ сацуу Швейцар нь хямрал тэмцэлтэй буй бүс нутгуудад хүмүүнлэгийн тусламж үзүүлж байлаа. Швейцарын Агаарын цэргийн хүчнийхэн UNHCR ба Швейцарын гамшгийг бууруулах корпусын нэрийн өмнөөс дүрвэгсэд, шархдагсад ба тусламжийн эд зүйлсийг тээвэрлэж байсан юм.
- Саддам Хуссейны эсрэг 2003 оны дайн нь НҮБ-ын мандатгүй байсан учраас Швейцарын хувьд төвийг сахих хуулийн сонгодог хэлбэрийг баримталсан бөгөөд Холбооны Зөвлөлөөс хүмүүнлэгийн тусламж ба эм тариа тээвэрлэснээс бусад нислэгийг Швейцарын агаарын орон зайгаар дамжин өнгөрүүлэхийг хориглосон юм. Улмаар, Холбооны Зөвлөл нь дайтаж буй талуудад дайны эд зүйлс экспортлохыг зөвхөн төв захиргааны мэдлийн асуудал болгосон байдаг.

Швейцарын аюулгүй байдлын бодлогын үндсэн зарчмын баталгаа нь байнгын бөгөөд зэвсэгт хүчнээр баталгаажсан төвийг сахих байр сууринаас хамтын ажиллагааг явуулж аюулгүй байдлаа хангах явдал мөн гэдгийг эдгээр үйл явдлууд нотолж байна.

Зэвсэгт хүчнээрээ баталгаажуулсан төвийг сахих статус ба тусгаар тогтнол³⁴:

Швейцар нь 2001 оны 9-р сарын 1-ний өдөр Цэргийн хуулийнхаа³⁵ хэсэгчилсэн өөрчлөлтүүдийг хүлээн зөвшөөрч хүчин төгөлдөр болгосон. Шинэчилсэн Цэргийн хууль нь OSCE ба НҮБ-ын энхийг дэмжих үйл ажиллагаан дахь Швейцарын оролцоог

³⁴ Гитлер ч довтолж зүрхлээгүй улс- <http://www.assa.mn/content/26207.shtml?a=photo>

³⁵ Military penal code- <https://www.icrc.org/casebook/doc/case-study/switzerland-military-penal-case-study.htm>

хуульчлан зохицуулж, өөрийгөө батлах хамгаалах зорилгоор Швейцарын энхийг сахиулах хүчнийг дээрх үйл ажиллагаанд оролцуулах үндэслэлийг бүрэлдүүлж өгчээ. Энэ тухайд Швейцарын цэргийн хуулийг хэсэгчлэн өөрчилсөн талаарх Холбооны Зөвлөлөөс гаргасан албан баримтанд Швейцарын энэхүү оролцоо нь «Төвийг сахих тухай хууль ба Швейцарын төвийг сахих бодлоготой нийцнэ» хэмээн бичжээ. Гэхдээ энэхүү Цэргийн хуулинд энхийг сахиулах хүчний байлдааны ажиллагаанд Швейцарийг оролцож болно гэж заагаагүй юм.

Швейцарын Үндсэн хуулийн³⁶ 57, 58, 59-р зүйлд зааснаар Швейцар улсын 20-50 насны бүх эрчүүд цэргийн алба хаах үүрэгтэй. Мөн дүйцүүлэн хааж болно. Харин эмэгтэйчүүд сайн дураараа хааж болдог. Иргэний хамгаалалтын албыг мөн эрэгтэйчүүд заавал хаах ба эмэгтэйчүүд сайн дураараа хааж болно.

- 20-32 хүртэлх насны бэлтгэл цэргийг “аусцуг”,
- 42 хүртэлхийг “ландвер”,
- 50 хүртэлх насныхныг “ландштурм” гэнэ.

“Аусцуг” байлдагч 10 жилийн хугацаанд өөрийн ангидаа гурван долоо хоногоор найман удаа ирж бэлтгэл хийнэ. Ландвер нь хоёр долоо хоногоор гурван удаа, ландштурм нь хоёр долоо хоногоор нэг удаа ирж цэргийн бэлтгэл хийнэ. 51 нас хүрэхээр цэргийн албанаас албан ёсоор халж, гар буу, винтов, ангийн буу өгдөг. Офицер болохыг хүсэгч нэмэлт бэлтгэлтэй. Энэ нь дунджаар 100 хоног байдаг.

Швейцарын арми нь дэлхийд ганц цагдаагийн бүтэц бүхий боловсон хүчинтэй арми бөгөөд улсын батлан хамгаалахын төсөв нь бараг таван тэрбум доллар байдаг байна.

Цэргийн мэргэжлийн боловсон хүчин офицер нь нисэх хүчнийх 9000 орчим, байнгын арми нь 10-15 мянган хүнтэй. Цэргийн албыг 90 хоног хаагаад халагдахад нь тэдэнд хувийн зэвсэг, хоёр дайз сум, дөрвөн улирлын гурван иж бүрдэл хувцас, сумнаас хамгаалах хантааз, дуулга өгдөг.

Байнгын армийн цэргүүд нь долоо хоногт хоёр амралтын өдөртэй, энэ өдрүүдээр гэртээ харьж болно. Төмс арилгаж, цэргийн байр цэвэрлэхгүй. Энэ бүхнийг хувийн компаниуд гэрээгээр хийнэ. Цэргийн ангийг бас хувийн хамгаалалтын алба хамгаалдаг учир цэргүүд харуулд гардаггүй. Харин ажлын тав хоногтоо бол өглөө 5:00-д босоод гүйлт, биеийн тамирын дасгал, цэргийн бэлтгэл, гардан тулаан, ууланд авирах, буудлага гээд орой 24:00-д амарна.

Швейцарт Женевээс Давос, Цюрихээс Лугано хүртэл үргэлжлэх өндөр уулсад цөмийн бөмбөгнөөс хоргодох байр, нууц хонгил, зэвсгийн агуулах, пуужин, их бууны галын цэг, хориглолтын шугам байдаг. Зэвсэглэлийн паркаа байнга шинэчилж байдаг бөгөөд буу галт хэрэгслээ шинэчлэх бүрийдээ хуучнаа иргэдэд хямдруулсан үнээр худалдаалдаг бөгөөд харин гар дамжуулж худалдаалахыг хориглоно. Швейцар улс иргэдийн гар дээр байгаа зэвсгийн тоогоороо дэлхийд дөрөвт ордог байна.

Төвийг сахих байр суурийн эерэг болон сөрөг үр дагавар:

Тус улсын төвийг сахих статусыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэхэд амаргүй байсан нь туулж ирсэн түүхээс нь тодорхой байна. Олон удаагийн түүхэн үйл явдлууд дээр төвийг сахих статусыг баримтлахаа батлан харуулсны зэрэгцээ цэрэг армийн хүч нь гадаадад өөрийн статусыг хүлээн зөвшөөрүүлэхэд асар их түлхэц болсон нь түүхэн баримтаас харагдаж байна.

Төвийг сахих статусаа олон улсад хүлээн зөвшөөрүүлсний хойно ч цэрэг арми нь улсынхаа тусгаар тогтнол ба төвийг сахих статусаа хамгаалахын төлөө бэлэн байдалд байдаг байна. Тийм ч учраас, дэлхийн I, II дайны үед дайтагч талууд Швейцарын төвийг

³⁶ Constitution of Switzerland- https://www.constituteproject.org/constitution/Switzerland_2014?lang=en

сахих статусыг хүндэтгэж, түүнийг аль нэг талын цэргийн хүчнийг нутаг дэвсгэрээрээ нэвтрүүлэхийг зөвшөөрөхгүй гэдэгт бат итгэлтэй байсан аж. Өөрөөр хэлбэл, арми нь тус улсын төвийг сахих статусын баталгаа болдог байна.

Үүнээс гадна Швейцар улс олон улсын тусламж, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд маш идэвхтэй оролцдог. Төвийг сахих нь аюулаас зайлсхийн амар суухын нэр биш харин харилцан ойлголцол, энх тайван, хүмүүнлэгийн төлөөх маш идэвхтэй байр суурь, үйл ажиллагаа юм гэдгийг батлан харуулдаг.

Төвийг сахих статусын учир дутагдалтай тал гэвэл орчин үеийн терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг гэх зэрэг аюул заналхийлэлээс хамгаалахад дангаараа хангалтгүй байна гэх зарим нэг баримт тус улсын тайлан илтгэл, албан баримтуудад дурдагдсан байна. Тухайлбал, Швейцар улс «2000 оны Гадаад бодлогын тайлан мэдээ»-ндээ орчин цагийн аюул заналхийлэл, эрсдэл ба халдлагууд нь олон улсын хамтын үйл ажиллагааг улам бүр илүүтэй шаардах болжээ: «Иймд хамтын ажиллагааны хэлбэрээр аюулгүй байдлаа хангах нь Швейцарын аюулгүй байдлын шинэ бодлогын үндсэн агуулга болж байна. Энэ нь төвийг сахих статусыг дэлхий нийтийн аюулгүй байдал ба энх тайвны үйл хэрэгт хувь нэмэр болох ямарваа зохистой арга хэлбэр бүхий үйл ажиллагааны хүрээнд нийцүүлэн хэрэглэх явдал юм» гэжээ.

2. АВСТРИ УЛС

Австрийн төвийг сахих бодлогын өнөөгийн байдал, түүхэн сургамжийн талаар Австрийн Үндэсний Ассамблейн гаргасан тогтоол болон Австрийн олон улсын улс төр судлалын институтын доктор профессор, улс төр судлаач Heinz Gaertner болон Otmar Hoell нарын бичсэн эрдэм шинжилгээний нийтлэл, батлан хамгаалах яамнаас гаргасан бодлогын хураангуй тайлбар (policy brief)-аас харьцуулсан судалсан болно. Улс төр судлаач Otmar Hoell нь Австрийн гадаад бодлого, европын интеграчлал, олон улсын хөгжлийн болон хүрээлэн буй орчны бодлого, аюулгүй байдлын иж бүрэн бодлого, зөрчил болон эрсдлийн менежментээр нарийн мэргэшсэн эрдэмтэн юм. Gaertner нь Стэнфорд, Оксфорд, Харвард, Иелийн их сургуулиудад улс төр судлал, интеграчлал, аюулгүй байдлын бодлого, гадаад бодлогын сэдвээр багшилдаг болно.

Австри улсын төвийг сахих тухай хуулийн зохицуулалт

1955 оны 10 дугаар сарын 26-нд Австрийн парламентаас баталсан “Төвийг сахих тухай Үндсэн хууль”³⁷ нь 2 зүйлээс бүрдэх бөгөөд хуулийг судалгаанд бүрэн эхээр нь авч үзлээ. Үүнд:

Нэгдүгээр зүйл:

1) Австри улс өөрийн тусгаар тогтнолоо олон улсын түвшинд урт хугацаагаар баталгаажуулах, нутаг дэвсгэрийн халдашгүй байдлаа баталгаажуулах зорилготойгоор өөрийн хүслээр байнгын төвийг сахихаа зарлан тунхаглаж байна. Энэ статусаа хадгалж хамгаалах бүхий л эрх мэдэл нь Австри улсад байна.

2) Энэ зорилгоо хангахын тулд ирээдүйн аль ч цаг үед Австри улс нь аль нэг цэргийн холбоонд нэгдэхгүй, өөрийн нутаг дэвсгэрт гадаадын цэргийн бааз байгуулахыг зөвшөөрөхгүй байх болно.

Хоёрдугаар зүйл:

1) Холбооны засгийн газар нь тус хуулийг бүрэн биелүүлнэ. Герман хэл дээрх эх хувийг хавсаргана.

Энэхүү Үндсэн хуулийн ойлголтыг АНУ-ын Засгийн газарт оруулснаар, Австрийн Холбооны Засгийн газар нь Австрийн байнга төвийг сахих статусыг дээр дурдсан хуульд заасны дагуу хүлээн зөвшөөрөхийг АНУ-ын Засгийн газраас хүндэтгэлтэйгээр хүсч байна.

Эх сурвалж: Constitutional Law on the Neutrality of Austria (26 October 1955)

http://www.cvce.eu/content/publication/1999/1/1/670aa09c-4d4b-451a-84f2-23f2f9c8cb06/publishable_en.pdf

³⁷ Constitutional Law on the Neutrality of Austria (26 October 1955).
http://www.cvce.eu/content/publication/1999/1/1/670aa09c-4d4b-451a-84f2-23f2f9c8cb06/publishable_en.pdf

Төвийг сахих байр сууринаас нэгдмэл байр суур руу

Австрийн Үндэсний Ассемблей 1955 онд Төвийг сахих тухай Үндсэн хуулиараа төвийг сахих бодлого баримтлана гэдгээ зарлан тунхагласан бөгөөд ингэхдээ Швейцар улстай ижил загвараар хэрэгжүүлнэ хэмээн төлөвлөж байжээ. Гэвч тун удалгүй 1955 оны 12 сард Австри улс НҮБ-д элссэнээр тэгэх боломжгүй болох нь тодорхой болсон юм.

Австри улс 1990 он хүртэл НҮБ-ын зүгээс тухайн улсын төвийг сахисан байр суурийг хүндэтгэн үзэж, гуравдагч орнуудын зөрчилдөөнтэй холбогдуулан тэднээс ямар нэгэн цэрэг зэвсгийн арга хэмжээнд оролцуулахгүй байна гэдэгт итгэлтэй байлаа. Гэвч 1991 онд Персийн булангийн дайн эхэлснээр Австри улс өөрсдийн төвийг сахисан статусаас илүүтэй НҮБ-ын гишүүний үүргээ биелүүлэх хэрэгтэй гэх үзэл бодол давамгайлж, улмаар Швейцарын төвийг сахих бодлогыг хуулбарлан хэрэгжүүлсээр байх боломжгүй болсон юм.³⁸ 1995 онд Европын Холбоонд элссэнээрээ Австри улс Маастрихын гэрээний хэсэг болох Европын Холбооны аюулгүй байдал, гадаад бодлогын нэгдмэл байр суурийг хүлээн зөвшөөрнө гэдгээ мэдэгдсэн байна. Тухайн гэрээний J.4 заалтын дагуу нэгдмэл батлан хамгаалахын бодлого баталж, түүнийгээ хамтран хэрэгжүүлнэ гэсэн байдаг. Үүнийгээ баталгаажуулж Холбооны Үндсэн хуульд шинээр 23f зүйлийг нэмж оруулсан байна. ***Ингэснээрээ Австри улс төвийг сахих бодлого баримтлана гэдэг нь хүчингүй болов.***³⁹

Амстердамын гэрээг баталснаас хойш 1998 онд Австрийн Үндэсний Ассамблей Үндсэн хуулиндаа ахин нэг өөрчлөлт оруулсан нь *“Петерсбургийн үүрэг даалгавар”-ын дагуу зэвсэгт мөргөлдөөний болон энхийг сахиулах үйл ажиллагааны үед байлдааны даалгавар гүйцэтгэх болно* гэжээ.⁴⁰ Гэхдээ энэ нь зөвхөн Европын Холбооны шийдвэрээр хийгдэх аж. Ийнхүү Европын Холбооны аюулгүй байдал, гадаад бодлогын нэгдмэл байр суурийг хүлээн зөвшөөрснөөр Австри улс олон улсын өмнө төвийг сахих статустай гэдэг нь эрс өөрчлөгдсөн юм. Одоогийн байдлаар Австри улсыг олон улсын эрх зүйн үүднээс төвийг сахисан гэхээсээ илүүтэйгээр ***“эвсэлд нэгдээгүй статустай”*** гэж тодорхойлж болох юм.

Австри улс нь тусгаар улс болохынхоо хувьд аюулгүй байдлын ямар бодлого баримтлах нь бүрэн эрхийнх нь асуудал боловч олон улсын зүгээс авч хэрэгжүүлж байгаа аюулгүй байдлын нэгдмэл бодлогыг хүлээн зөвшөөрөх нь илүү аюулгүй байдлаа хангах, энхийг сахих, тогтвортой, энх тайван амьдралыг бий болгох зорилттой нь илүү нийцтэй, үр өгөөжтэй байна гэж үзжээ.

Австри улсын төвийг сахих бодлогын түүх

1955 оноос өдийг хүртэл Австрийн төвийг сахих статус нь тус улсын гадаад бодлого болон аюулгүй байдлын бодлогын хэрэгсэл болохын хувьд сайн үйлчилж ирсэн. Хэдий тийм ч 1980-аад оны сүүлээр Австрийн төвийг сахих бодлогод эрх зүйн болон улс төрийн хувьд нэлээд өөрчлөлт гарч, зарим улс төрийн судлаачид Австрийг ***“төвийг сахигч асан”*** орон гэж нэрлэж байна.

Учир нь Австри нь энхийг сахиулах хамтын ажиллагаагаар дамжуулан НАТО-гийн гишүүн, 1995 онд Европын Холбооны гишүүн болсон. Австри улс нь Европын Холбоонд нэгдэхдээ төвийг сахих статустайгаа холбогдуулан ямар нэгэн нөхцөл тавилгүйгээр элссэн. Харин ч Европын Холбоонд Австри улс нэгдэх гэрээ хийхдээ ***“Европын Холбооны аюулгүй байдал, гадаад бодлогын нэгдмэл байр суурийг хэрэгжүүлэх явцыг Төвийг сахих бодлого нь хязгаарлахгүй”***⁴¹ гэсэн заалтыг Холбооны Үндсэн хуульд шинээр 23f зүйл болгон нэмж оруулжээ.

³⁸ Resolution by the Austrian Parliament. Security and Defence Doctrine, <http://www.bka.gv.at/DocView.axd?CobId=3604>

³⁹ Мөн тэнд

⁴⁰ Мөн тэнд

⁴¹ Resolution by the Austrian Parliament. "Security and Defence Doctrine"

Улс төрийн хувьд, Австри байнгын төвийг сахих бодлогыг хэрэгжүүлсэн явдал нь 1955 оны “Австрийн Төрийн Хэлэлцээр”-тэй (*Austrian State Treaty*) холбоотой юм. Тодруулбал, Австри улс өөрийн орны бүрэн тусгаар тогтносон байдлаа сэргээх зорилготойгоор 1955 оны 4-р сарын 15-ны “Москвгийн Санамж бичиг”-т **“ЗХУ нь Австри улс төвийг сахих бодлого зарласан тохиолдолд Төрийн хэлэлцээрт гарын үсэг зурахыг зөвшөөрнө”**⁴² гэж тусгасан ажээ. Энэ нь тухайн үед Австри улс өөрийн орны бүрэн тусгаар байдлаа сэргээн тогтоохын тулд буюу шахалтаар байнгын төвийг сахих бодлогыг зарласан байдаг.

1990-ээд оны Австрийн Төвийг сахих бодлогын илт өөрчлөлтүүд нь *Социал демократ нам (SPÖ)* болон *Ард түмний намын (ÖVP)* эвслийн засгийн газрын зөвшилцлийн бодлогын үр дүн гэж үздэг. Үндсэн өөрчлөлтүүд нь 1999 оны 10-р сарын сонгуулиар бүрдсэн Ард түмний нам болон Эрх чөлөөний намуудын эвслийн засгийн газраас улбаатай. Энэ нь Дэлхийн II дайнаас хойших Австрийн улс төрийн системийн эргэлтийн цэг болсон гэж шинжээчид үзэж байна.

Хэдийгээр 1955 онд байнгын төвийг сахих статусаа зарласан ч эрх зүйн хүрээнд Австри нь төвийг сахих улсын дүр төрхөөс зайлсхийж байсан гэж улс төр судлаачид үздэг.⁴³ Учир нь байнгын төвийг сахих статус нь Австрийн олон улсын тавцан дахь нэр хүндэд харшилж, их гүрнүүдтэй харилцах харилцаанд тус улсыг үл хүндлэх хандлага үүсгэнэ гэж үзжээ. Австрийн төвийг сахих тухай хууль нь зөвхөн цэргийн эвсэлд нэгдэх болон өөрийн нутаг дэвсгэрт гадаадын зэвсэгт хүчнийг байршуулахыг хориглодог. Үүний тулд Австри нь ирээдүйд ямар ч цэргийн эвсэлд нэгдэхгүй, гадаад орны цэргийн баазыг өөрийн нутаг дэвсгэрт байршуулахгүй байх үүргийг хүлээдэг. 1907 оны Далайн болон хуурай замын дайны талаарх Гаагын Конвенцийн дагуу төвийг сахисан орон нь дайны шууд болон шууд бус оролцооноос зайлсхийх шаардлагатай.

Австрийн байнгын төвийг сахих үзэл баримтлал нь түүхийн хувьд онцлогтой юм. Энэ хэлбэрийн төвийг сахих статус нь төвийг сахих бусад үзэл баримтлалтай ижил түвшинд авч үзэж болохгүй гэж тус улсын улс төр судлаачид бичжээ. Австрийн төвийг сахих бодлого нь эрх зүйн бүтцийн хувьд Швейцарийн жишээтэй ижил боловч Өрнө-Дорнын зөрчилдөөний үр дүнд бий болсон байна. Финляндын төвийг сахих бодлого нь мөн ижил Хүйтэн дайнаас улбаатай боловч өөр эрх зүйн үндэстэй байдаг.

Өнгөрсөн жилүүдэд Австрийн олон улсын нөхцөл байдал Хүйтэн дайны үеэс ихээхэн өөрчлөгдсөн байдаг. Үүний улмаас Австрийн удаан хугацааны тогтвортой бодлого өөрчлөгдсөн бөгөөд 1945 оноос хойш Австри нь дайны хор уршиг, эдийн засгийн гачигдал, нийгмийн тогтворгүй байдал, улс төрийн хагаралтай орноос Европ дахь эдийн засгийн болон улс төрийн хамгийн тогтвортой, сайн хөгжсөн эдийн засагтай улс орон болсон гэж улс төрчид үзжээ. Үүнд Австрийн гадаад бодлого, Европын Холбоонд элссэн зэрэг нь ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. 1994 онд Европын Холбоонд элсэхийг нийт сонгогчдын 2/3 нь дэмжиж байсан бол өдгөө 40 орчим хувь нь Европын Холбоон нэгдсэн бодлогыг дэмждэг байна.

Бүгд найрамдах засаглалын үед гадаад бодлогын асуудал нь зөвшилцлийн асуудал болсон бөгөөд шаардлагатай нөхцөлд бүх улс төрийн нам болон иргэний нийгмийн байгууллагууд нь шийдвэр гаргах үйл явцад оролцдог тогтмол уламжлал тогтсон. Гэвч, 1980-аад оны хоёрдугаар хагасаас гадаад харилцааны нөхцөл байдал нарийн төвөгтэй болж, уламжлалт арга хэрэгслүүд үр дүнгүй болсноор Австрийн гадаад бодлогод суурь өөрчлөлтүүд гарч эхэлжээ

⁴² http://www.bundesheer.at/pdf_pool/publikationen/05_small_states_14.pdf

⁴³ Мөн тэнд

Австри дахь төвийг сахих бодлогын өөрчлөлтүүд

Байнгын төвийг сахих статус нь Хүйтэн дайны үед Австрийн өрнө, дорнын цэргийн блокуудаас хамгаалах үр дүнтэй арга болсон. Хэдий тийм ч холбоотны үзэл баримтлалтай уялдан төвийг сахих бодлого мөн өөрчлөгдөх шаардлагатай болсон. Австрийн төвийг сахих бодлого нь өөрчлөгдөж буй нөхцөл байдалд хэд хэдэн удаа “de facto”⁴⁴ дасан зохицож, НҮБ-ийн гишүүн болсноор Швейцарийн загвараас холдож, 1990-ээд оны үед Иракийн эсрэг эвсэлд Австрийн агаарын орон зайг ашиглах зөвшөөрлийг олгосон нь төвийг сахих хууль болон үзэл баримтлалтай зөрчилдсөн ч Европийн Холбооны зүгээс Австрийн төвийг сахих статусыг өргөн хүрээнд тайлбарласнаар зөвшөөрөгдсөн байдаг. Европын Холбоонд элссэн нь төвийг сахих бодлогын уламжлалт үзэл баримтлалтай төдийлөн уялдаагүй.

Австрийн байнгын төвийг сахих бодлогын цөмд цэргийн асуудал байсан. Австри нь ямар ч цэргийн эвсэлд нэгдэж болохгүй, мөн гадаадын цэргийн хүчийг өөрийн газар нутагт байршуулахгүй байхаар хуульчлан тогтоосон. Үүнээс гадна багц үүргүүд мөн байсан. Энх тайвны үед ч Австри нь төвийг сахих арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй. Гэвч 2010 онд Европийн Холбооны 450 цэргийн танк Австрийн нутаг дэвсгэрт сургуулилтад оролцсон бөгөөд 1995 оноос НАТО-ийн энхийг сахиулах үйл ажиллагаанд өндөр үүрэгтэйгээр оролцож эхэлсэн байдаг.

Австри улс болон НАТО-гийн харилцаа

1995 онд Австри улс нь НАТО-ийн Энхийн төлөөх хамтын ажиллагаанд нэгдэн орсон бөгөөд өнөөг хүртэл энхийг сахиулах салбарт идэвхтэй үйл ажиллагаа үзүүлж, төрөл бүрийн практик хамтын ажиллагааг өргөжүүлсээр байгаа тухай НАТО-ийн албан ёсны сайтад дурдсан байна.⁴⁵

1995 онд: Энхтайвны Түншлэлийн суурь баримт бичигт гарын үсэг зурав.

1996 онд: НАТО-гийн Төлөвлөлт болон Хяналтын процесст нэгдэн, НАТО-гийн Босни Герцоговена дахь энхийг сахиулах үйл ажиллагаанд энхийг сахиулагчдаа илгээв.

1997 онд: НАТО-ийн удирдлагын төвд Австри төлөөлөгчийн газраа нээв.

1999 онд: Косовод болсон НАТО-ийн энхийг сахиулах ажиллагаанд цэргээ оруулав.

2002 онд: Австрийн Ерөнхийлөгч Томас Клештил НАТО-гийн Ерөнхий нарийн бичгийн дарга Лорд Робертсонтой уулзаж олон улсын аюулгүй байдлын асуудлаар санал солилцов.

2002 онд: Афганистан дахь НАТО-ийн Аюулгүй Байдалд Дэмжлэг Үзүүлэх Олон Улсын Хүчинд Австрийн цэрэг нэгдэв.

2005 онд: Австри НАТО-ийн PfP-ийн нэгж болж өргөжсөнөө тунхаглан зарлав.

2008 онд: KFOR-ийн Үндэстэн дамнасан Өмнөдийн Бодлогын Хүчний удирдлагыг авав.

2011 онд: НАТО-гийн ерөнхий нарийн бичгийн дарга Андерс Фог Расмуссен 2011 оны зургадугаар сарын 30-нд Венад айлчилж, Австрийн Ерөнхийлөгч Хайнц Фишер, Гадаад харилцааны сайд, дэд канцлер Майкл Шпиндэлэггэр, сайд Батлан хамгаалах Норберт Дарабос нартай уулзлаа. Тэд баруун Балкан, Ливи, Афганистан дахь НАТО-гийн болон Австрийн хамтын үйл ажиллагааны нөхцөл байдлын талаар санал солилцжээ. Расмуссен Косово болон Баруун Балкан дахь НАТО-гийн үйл ажиллагаа амжилттай болоход Австри томоохон үүрэг гүйцэтгэсэнд онцгой талархал илэрхийлжээ.

⁴⁴ <http://legal-dictionary.thefreedictionary.com/de+facto>

⁴⁵ http://www.nato.int/cps/en/natohq/topics_48901.htm

3. ТУРКМЕНИСТАН УЛС

Туркменистан улс нь 2015 оны 12 дугаар сарын 12-ны өдөр байнгын төвийг сахих статустай болсныхоо 20 жилийн ойг тэмдэглэх гэж байгаа бөгөөд Ерөнхийлөгч Гурбангулы Бердымухамедовын санаачилгаар Туркменистаны Ахмадын Зөвлөлөөс тогтоол гарган 2015 оныг Төвийг сахих ба энх тайвны жил болгон зарлажээ.

1991 онд тусгаар тогтнолоо зарласнаас хойших хугацаанд дэлхийн 120 гаруй улстай дипломат харилцаа тогтоож, олон улсын 40 гаруй байгууллагад гишүүнээр элссэн ба Туркменистаны дипломат төлөөлөгчийн болон консулын газар дэлхийн 26 оронд ажиллаж, харин тус улсад 30 гаруй орны дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар ажилладаг. Туркменистан улс НҮБ, Европын Холбоо, Европын Аюулгүй байдал, Хамтын ажиллагааны байгууллага, НАТО, ЮНЕСКО, ТУХН зэрэг олон улсын нэр хүндтэй байгууллагуудад төлөөлөгчтэй юм.

Тус улсын албан ёсны эх сурвалжуудаас үзэхэд байнга төвийг сахих статусын үр нөлөөгөөр Туркменистан улс нь Төв Азийн бүс нутагт улс төрийн тогтвортой байдлыг хадгалан хамгаалах хэрэгт НҮБ-ын найдвартай холбоотон, үр ашигтай түнш болсон гэж тэмдэглэжээ⁴⁶.

2007 онд тус улсын нийслэл Ашхабад хотод НҮБ-ын превентив дипломатын бүсийн Төв нээгдсэн. Түүнчлэн НҮБ-ын ивээл дор Ашхабадад Таджикистан улсад энх тайван байдал, зөвшилцөлд хүрэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн цуврал уулзалтууд, 90-ээд оны сүүлчээр Афганистаны дотоодын зөрчилдөөнийг зохицуулах уулзалтуудыг зохион байгуулсан зэрэг нь үүний баталгаа болно.

Сүүлийн жилүүдэд Туркменистан улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар олон улсын хэд хэдэн чухал арга хэмжээг өөрийн оронд зохион байгуулжээ. Тухайлбал, Каспийн тэнгис орчмын улсуудын тэргүүнүүдийн анхдугаар дээд хэмжээний уулзалт, Каспийн асуудлаарх дараагийн хэлэлцээрийн үйл явцыг урагшлуулах, орчин үеийн тулгамдсан асуудлууд болох энх тайвныг хамгаалах, зэвсэг хураах, эрчим хүч, хүнс, тээвэр, ус, хил нэвтрэх, хүмүүнлэгийн зэрэг асуудлаар олон улсын дээд хэмжээний хэд хэдэн цуврал чуулганыг зохион байгуулжээ.

Эдгээр бүх арга хэмжээ нь Туркменистаны олон улсын харилцаанд нэгдэн нийлэх үйл явцыг эрчимжүүлэх, өөрийн орны геополитик, эдийн засаг, нөөц бололцоо, хүний хүчин зүйлийг ашиглан улсаа амьдралын өндөр чанар, эрчимтэй хөгжилтэй эдийн засагтай, гадаад ертөнцтэй тогтвортой, үр ашигтай харилцаатай орнуудын түвшинд хүргэх цогц зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байгаа ажээ.

Өнөөдөр Туркменистан улс нь өөрийн олон улсын харилцаандаа төвийг сахих статусын эдийн засгийн аспектэд онцгой ач холбогдол өгч байгаа бөгөөд жилээс жилд дэлхийн олон арван улстай эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагаагаа бэхжүүлж, эдгээр улсуудтай хамтран том том төслүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, эрчим хүчний хуучин уламжлалт маршрутаас гадна өөрийн эрчим хүчний нөөцийг дэлхийн зах зээлд гаргах зорилгоор Туркменистан-Узбекистан-Казахстан-Хятад ба Туркменистан-Иран гэсэн байгалийн хийн хоолойн 2 шинэ төслийг хэрэгжүүлжээ.

Түүнчлэн эрчим хүчний өөр нэг том төсөл болох Туркменистан-Афганистан-Пакистан-Энэтхэг (ТАПИ) гэсэн хий дамжуулах хоолой барих ажлын бэлтгэл амжилттай хийгдэж байгаа ажээ. Эдгээр хийн экспортын шугамуудыг хийгээр баталгаатай хангах зорилгоор

⁴⁶ Превентивная дипломатия – инвестиции в мирное будущее. Государственное информационное агентство Туркменистана (TDH) <http://www.turkmenistan.gov.tm/?id=2934>
День нейтралитета Туркменистана. <http://www.calend.ru/holidays/0/0/1417/>

дотоодын Зүүн-Баруун гэсэн транстуркмены асар том хийн хоолойг барьж байгаа юм байна.

Эдгээр бүх төслүүдийг хэрэгжүүлэх нь зөвхөн эдийн засаг, арилжааны үүднээс үр ашигтай гэхээсээ илүү бүс нутгийн дотоод, гадаад байдал, улс төр, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны тогтолцоонд тогторжуулах нөлөө үзүүлж, бүхэлдээ Евроазийн эрчим хүчний орон зайд эрх ашгийн тэнцвэржилтийг хадгалахад үр нөлөө үзүүлнэ гэж үзэж байгаа юм.

Ийнхүү өнөөдрийн 20 жилийн өндөрлөгөөс харахад Туркменистаны байнга төвийг сахих статус нь олон улсын харилцаанд идэвхтэй, нааштай байр суурь баримтлах, улс хоорондын зөрчил, зөрөлдөөнийг хүч хэрэглэх замаар бус улс төрийн арга хэрэгслээр шийдвэрлэх, олон улсын харилцаанд хүнлэг, бүтээлч дэг журмыг тогтоох үзэл санааг илэрхийлдэг байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Constitution of Switzerland. www.constituteproject.org/constitution/Switzerland
- The Constitution of the Kingdom of Cambodia.1993. <http://faolex.fao.org/docs/pdf/>
- Constitutional Law on the Neutrality of Austria (26 October 1955). www.cvce.eu/content/publication/1999/1/1/670
- The Law of Neutrality-<http://lup.lub.lu.se/luur/>
- Military penal code. www.icrc.org/casebook/doc/case-study/switzerland-military-penal
- Convention (V) respecting the Rights and Duties of Neutral Powers and Persons in Case of War on Land. The Hague, 18 October 1907. [/www.icrc.org/ihl/INTRO/200?OpenDocument](http://www.icrc.org/ihl/INTRO/200?OpenDocument)
- Resolution by the Austrian Parliament. "Security and Defence Doctrine" Vienna, 12 December 2001. www.bundesheer.at/pdf_pool/publikationen/05_small_states_14.pdf
- Austria's Security and Defence Policy within the framework of ESDP. Vienna, July 2005. www.nato.int/cps/en/natohq/topics_48901.htm
- "Swiss neutrality" brochure, 2004 www.vbs.admin.ch/internet/vbs/en/home/documentation
- Switzerland and neutrality- <http://www.expatica.com/ch/insider-views/Swissworld>
- Heinz Gaertner and Otmar Hoell. Neutrality of Austria. www.cvce.eu/content/publication/1999/1/1/670
- Превентивная дипломатия – инвестиции в мирное будущее. (TDH) <http://www.turkmenistan.gov.tm/?id=2934>
- День нейтралитета Туркменистана. <http://www.calend.ru/holidays/0/0/1417/>
- Гитлер ч довтолж зүрхлээгүй улс- <http://www.assa.mn/content/26207>.
- Монгол - Төвийг сахих- <http://politics.news.mn/content/221667.shtml>

СОНГУУЛИЙН ПРОПОРЦИОНАЛ ТОГТОЛЦОО БҮХИЙ УЛС ОРНУУДЫН СУУДАЛ ХУВААРИЛАХ АРГА, БОСГЫН ХУВЬ БОЛОН ТОЙРГИЙН ХЭЛБЭР

*Ц.Болормаа, Ч.Онончимэг,
Д.Халиун, Д.Жигваагүнсэл*

Одоогийн байдлаар пропорционал тогтолцоогоор сонгууль явуулдаг нийт 82 орон байна. Үүнээс 80 улс нь намын жагсаалтаас санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоогоор, харин Мальт болон Ирланд улс санал шилжүүлэх тогтолцоо бүхий хувь тэнцүүлсэн тогтолцоогоор сонгуулиа зохион байгуулж байна.

Намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцооны хамгийн энгийн хэлбэр нь намууд олон мандаттай тойрогт нэр дэвшигчдийн жагсаалтыг танилцуулдаг хэлбэр юм. Ингэснээр сонгогч аль нэгэн намын төлөө саналаа өгөх ба намууд тухайн сонгуулийн тойрогт авсан саналынхаа хувьтай тэнцүү суудал авна. Нэр дэвшигчдийг намын жагсаалтад орсон дарааллын дагуу ялагчаар тодруулдаг.

Намын жагсаалт нь:

- Нээлттэй
- Хаалттай
- Чөлөөт гэх хэлбэртэй.

Нээлттэй намын жагсаалт нь дан ганц нам төдийгүй тухайн намаас нэр дэвшиж буй нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтаас сонгогч сонголтоо хийх боломжит хувилбар юм. Баруун европын орнууд ихэвчлэн энэ хувилбарыг сонгодог. Хаалттай намын жагсаалт гэдэг нь намын жагсаалтаар сонгогдох нэр дэвшигчдийн дарааллыг нам тогтооно. Энэ тохиолдолд сонгогч тодорхой нэг нэр дэвшигчийг сонгох боломжгүй юм.

Мальт болон Ирланд улсын сонгосон санал шилжүүлэх тогтолцоо гэдэг нь олон мандаттай тойргоор сонгуулийг явуулах бөгөөд сонгогчид саналын хуудсыг бөглөхдөө альтернатив саналын тогтолцоотой адил нэр дэвшигчдийг сонголтын дарааллаар нь дугаарлаж тэмдэглэдэг. Энэ нь сонгогч заавал бүх нэр дэвшигчийг дугаарлах шаардлагагүй бөгөөд хэдэн хүнийг сонгохоо сонгогч өөрөө мэдэх хувилбар бүхий тогтолцоо юм.

Саналын хуудаснаас эхний буюу нэгдүгээр сонголт бүхий саналуудыг тоолж дүнг гаргасны дараа суудалд хүрэхийн тулд нэр дэвшигчдийн авах шаардлагатай саналын квотыг тооцно. Ингэхдээ дараах энгийн томъёог ашиглана. Үүнд:

$$\text{Квот} = \frac{\text{саналын тоо}}{\text{суудлын тоо}} + 1$$

Энэ тогтолцоог Ирланд улс 1921 оноос хойш, Мальт улс 1949 оноос хойш хэрэглэж байна.

Лавлагаа мэдээлэлд судалгаанд хамрагдсан пропорционал тогтолцоо бүхий 82 орны:

- Намын болон нэр дэвшигчдийн жагсаалтын хэлбэр,
- Саналын босгын хувь,
- Суудал хуваарилах арга,
- Тойргийн хэлбэр,
- Суудлын тоо зэргийг харьцуулсан мэдээллийг хүснэгтээр оруулав.

*Сонгуулийн пропорционал тогтолцоо бүхий улс орнуудын суудал хуваарилах арга,
босгын хувь болон тойргийн хэлбэр*

№	Улсын нэр	Жагсаалтын хэлбэр	Босгын %	Суудал хуваарилах арга	Тойргийн хэлбэр	Суудлын тоо
1	Австрали -дээд танхим	Нээлттэй	нуугдмал	D'Hondt	12 мандаттай 6 тойрог, 2 мандаттай 2 тойрог	76
2	Австри -доод танхим	Хаалттай	4%	D'Hondt Харе	3-12 мандаттай 9 тойрог	183
	-дээд танхим	Хаалттай	нуугдмал	D'Hondt Харе	7-36 мандаттай 9 тойрог	62
3	Албани	Хаалттай	Нам -3% Эвсэл -5%	D'Hondt Сент Лагийн арга	4-32 мандаттай 12 тойрог	140
4	Алжир -доод танхим	Нээлттэй	нуугдмал	Сент Лагийн их үлдэгдлийн	Олон мандат бүхий 48 тойрог	389
5	Ангол	Хаалттай	нуугдмал	D'Hondt	Үндэсний 1 тойрог	220
6	Аргентин -Доод танхим	Нээлттэй	3%	D'Hondt	Олон мандаттай 24 тойрог	257
	-дээд танхим	Нээлттэй	-	Тойрогтоо хамгийн их санал авсан намд 2 суудал, дараагийнхад нь 1 суудал хуваарилдаг	3 мандаттай 24 тойрог	72
7	Бельги -доод танхим	Нээлттэй	Нуугдмал	D'Hondt	Олон мандаттай 11 тойрог	150
	Дээд танхим	Нээлттэй	нуугдмал	D'Hondt	Олон мандаттай 3 тойрог	40
8	Бенин	-	-	-	Олон мандаттай 24 тойрог	83
9	Болгар	Хаалттай	4%	Харе	Холимог: Олон мандаттай 31 тойрог 31 суудал – мажоритар / харьцангуй олонх/ 209 суудал- намын жагсаалтаар санал хураах пропорционал тогтолцоо	240
10	Босни Герцеговин	Нээлттэй	3%	-	-	42
11	Бразил -доод танхим	Нээлттэй	нуугдмал	D'Hondt	8-70 мандаттай 24 тойрог	513

12	Буркина-Фасо	Нээлттэй	нуугдмал	Их үлдэгдлийн	15 мандаттай үндэсний хэмжээний 1 тойрог, 2-10 мандаттай 13 тойрог	111
13	Бурунди-доод танхим	Хаалттай	нуугдмал	D'Hondt	Олон мандаттай 17 тойрог	118/100
14	Гайана	Хаалттай	нуугдмал	Харегийн хамгийн их үлдэгдлийн	10 тойрогт 2: суудал, 40 мандаттай үндэний 1 тойрог	65
15	Гватемал	Хаалттай	-	D'Hondt	Холимог: 127 суудал- Олон мандаттай 22 тойрог 31 суудал- Үндэсний 1 тойрог	158
16	Гвиней-Бисау	Нээлттэй	нуугдмал	Их үлдэгдлийн	Олон мандаттай 27 тойрог	102
17	Гондурас	Хаалттай	-	Харе	Холимог: 18 тойрог	128
18	Грек	Нээлттэй	3%	Хагенбах Бишхофф	Олон мандаттай 56 тойрог, 12 мандаттай үндэсний 1 тойрог	300
19	Дани	Нээлттэй	нуугдмал	Сент Лагийн	Олон мандаттай 10 тойрог	179
20	Доминикан-доод танхим	Хаалттай	нуугдмал	D'Hondt	Олон мандаттай 29 тойрог, Үндэсний 1 тойрог	183
21	Зүүн Тимор	-	3%	D'Hondt	Үндэсний 1 тойрог	65
22	Израйль	Хаалттай	2%	D'Hondt	120 мандаттай үндэсний 1 тойрог	120
23	Индонез-доод танх.	Нээлттэй	2,5%	Заяцын хүчин зүйл	Олон мандаттай 33 тойрог	560
24	Ирак	Нээлттэй	нуугдмал		7-70 мандаттай 18 тойрог	325/318
25	Ирланд	-	-	-	<u>Санал шилжүүлэх тогтолцоо</u> 3-5 мандаттай 43 тойрог	166
26	Исланд	Хаалттай	5%	D'Hondt	10-11 мандаттай тойргууд	63
27	Испани-доод танхим-дээд танхим	Хаалттай Хаалттай	Нуугдмал Байхгүй	D'Hondt Шууд бус	Олон мандаттай 50 тойрог Олон мандаттай 52 тойрог	350 208
28	Итали-доод танх.-дээд танх.	Хаалттай	2-4%	Олон суудлыг урамшуулах	Олон мандаттай 26 тойрог	630
29	Кабо-Верде	Хаалттай	нуугдмал	D'Hondt	2-15 мандаттай 16 тойрог	72
30	Казахстан-доод танхим	-	7%	Их үлдэгдэл	Пропорционал: 98 суудал- Үндэсний 1 тойрог 9 суудал – Ардын Чуулга	107
31	Камбодж	Хаалттай	нуугдмал	Харе	Олон мандаттай 21 тойрог	123
32	Кипр	Нээлттэй	нуугдмал	Харе	Олон мандаттай 6 тойрог	80
33	Кипр /Хойд/	Нээлттэй	-	-	-	50

34	Колумб -доод танхим -дээд танхим	Хаалттай	Нуугдмал	D'Hondt	Олон мандаттай 33 тойрог 100 мандаттай үндэсний тойрог, 2 мандаттай тусгай тойрог	166
		Хаалттай	нуугдмал	D'Hondt		102
35	Косово	-	5%	-	-	120
36	Коста-Рика	Хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	4-21 мандаттай 7 тойрог	57
37	Кыргызстан	-	7%	-	Үндэсний 1 тойрог	120
38	Латви	Нээлттэй	5%	Сент лагийн	14-29 мандаттай 5 тойрог	100
39	Лихтенштейн	Нээлттэй	8%	Хамгийн их үлдэгдлийн арга	10,15 мандаттай 2 тойрог	25
40	Люксембург	Нээлттэй	нуугдмал	Хагенбах Бишхофф	7-23 мандаттай 4 тойрог	60
41	Македон	-	-	-	-	120-140
42	Мальта	Нээлттэй	нуугдмал	Үлдэгдлийг дахин хуваарилах	<u>Санал шилжүүлэх</u> <u>тогтолцоо</u> 5 мандаттай 13 тойрог	65
43	Мозамбик	-	5%	D'Hondt	12-50 мандаттай 11 тойрог 1 мандаттай 2 тойрог	250
44	Молдав	Хаалттай	Нам-5% Бие даагч-3%	D'Hondt	Үндэсний 1 тойрог	101
45	Марокко -доод танхим	Хаалттай	6% 3%	-	305 суудал- сонгуулийн тойрог 90 суудал- Үндэсний 1 тойрог	395
46	Намиби	Хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	Үндэсний 1 тойрог	72
47	Нигер	-	-	-	Холимог: 105 суудал- Олон мандаттай 8 тойрог /намын жагсаалтаар санал хураах пропорционал тогтолцоо/ 8 суудал – 8 тусгай тойрог/ мажоритар:энгийн олонх/	113
48	Нидерланд -доод танхим -дээд танхим	Хаалттай	0,67%	D'Hondt	Олон мандаттай 18 тойрог	150
		Хаалттай			12 мужийн зөвлөл	75
49	Нидерландын Антилья	-	-	-	-	22
50	Никарагуа	Хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	20 мандаттай Үндэсний 1 тойрог, 2-19 мандаттай 17 тойрог	90
51	Норвеги	Нээлттэй	4%*	Шинэчилсэн Сент Лагийн арга	150 суудал - 3-17 мандаттай 19 тойрог 19 суудал – Үндэсний 1 тойрог	169

52	ОХУ Доод танхим	Нээлттэй	7%	Харе	Үндэсний 1 тойрог	450
53	ӨАБНУ -доод танхим	Хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	4-43 мандаттай 9 тойрог	400
54	Палестин	-	-	-	-	132
55	Парагвай -доодтанхим	Хаалттай	Нуугдмал	D'Hondt	Олон мандаттай 18 тойрог.	80
	-дээд танхим	Хаалттай	Нуугдмал	D'Hondt	Үндэсний нэг тойрог	45
56	Перу	Хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	Олон мандаттай 25 тойрог	120
57	Польша -Сейм	Нээлттэй	5%	D'Hondt	7-19 мандаттай 41 тойрог	460
58	Португали	Нээлттэй		D'Hondt	Олон мандаттай 22 тойрог	230
59	Руанда -доод танхим	Хаалттай	5%	Их үлдэгдэл	Үндэсний 1 тойрог	53
60	Сан Марино	Нээлттэй	>3.5%	D'Hondt	Нэг болон олон мандаттай 33 тойрог	60
61	Сан-Томе ба Принсип	Хаалттай	нуугдмал	D'Hondt	Олон мандат 7 тойрог	55
62	Серб	Хаалттай	5%	D'Hondt	Үндэсний 1 тойрог	250
63	Словак	Нээлттэй	5%	Хагенбах Бишхофф	Үндэсний 1 тойрог	150
64	Словени -доод танхим Дээд танхим	Нээлттэй	4%	D'Hondt	11 мандаттай 88 тойрог, италичуудад зориулсан 2 мандаттай 1 тойрог	90
65	Суринам	Хаалттай	нуугдмал	D'Hondt	Олон мандаттай 10 тойрог	51
66	Того	Хаалттай	Байхгүй	-	2-10 мандаттай 30 тойрог	81
67	Тунис	-	-	Их үлдэгдлийн	33 тойрог: 4-10 мандаттай 27 тойрог 18 суудал -6 тойрог /гадаад дахь төлөөлөл/	217
68	Турк	Нээлттэй	10%	D'Hondt	Олон мандаттай 79 тойрог	550
69	Уругвай -доод танхим	Хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	Олон мандаттай 19 тойрог.	99
	-дээд танхим	Хаалттай			30 мандаттай үндэсний 1 тойрог	31/30
70	Фижи	Нээлттэй	Бие даагч - 5% Нам -5%	-	Үндэсний 1 тойрог	50
71	Финланд	Нээлттэй	нуугдмал	D'Hondt	6-33 мандаттай 14 тойрог	200

72	Хорват	Нээлттэй	5%	D'Hondt	14 мандаттай 10 тойрог, 8 мандаттай үндэсний тойрог, гадаадад оршин суугчдад зориулсан тойрог /мандатын тоо заагаагүй/	153
73	Чех Доод танхим	Нээлттэй	Нам-5% Эвсэл(2 нам)-10% Эвсэл(3 нам)-15% Эвсэл(4 нам)-20%	D'Hondt	Олон мандаттай 14 тойрог	200
74	Чили -дээд танхим Доод танхим	Хаалттай	-	Намын олонхийн систем	13 олон мандаттай тойрог, 60 олон мандаттай тойрог	38 120
75	Чрна Гора	Хаалттай	3%	D'Hondt	Үндэсний 1 тойрог	81
76	Швед -Риксдаг	Нээлттэй	4% -үндэсний хэмжээнд, 12%тойрог	Сент Лаг	2-34 мандаттай 29 тойрог, 39 мандаттай үндэсний 1 тойрог	349
77	Швейцар -доод танхим	Нээлттэй	нуугдмал	Хагенбах Бишхофф	Олон тандаттай 26 тойрог	200
78	Шри Ланк	Хаалттай	1/8 тойрогтоо	-	4-20 мандаттай 22 тойрог, 29 мандаттай үндэсний 1 тойрог	225
79	Эквадор	-	-	-	Холимог: 116 суудал- мажоритар /харьцангуй олонх/ 15 суудал- олон мандаттай 3 тойрогос пропорционал тогтолцоо + 8 суудал- олон мандаттай тойрог / гадаад дахь иргэдийн төлөөлөл/	137
80	Экваторын Гвиней	Хаалттай	нуугдмал	D'Hondt	Мужийн тоогоор олон мандаттай тойрог	100
81	Эль Сальвадор	Хаалттай	-	-	64 суудал- 3-16 мандаттай 14 тойрог 20 суудал- Үндэсний 1 тойрог	84
82	Эстони	Нээлттэй	5%	D'Hondt	6-13 мандаттай 13 тойрог	101

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Сонгуулийн эрх зүйн тогтолцооны онол, арга зүйн үндэс, түүнийг сонгох зарчим СТ/10-217 Ц.Товуусүрэн
- Table of Electoral Systems Worldwide, International Institute for Democracy and Electoral Assistance
- <http://www.idea.int/esd/world.cfm>
- Electoral system, PARLINE database, <http://www.ipu.org/parline-e/Modlist.asp>
- Electoral system of national legislature, The Electoral knowledge network, <http://aceproject.org/epic-en/CDTable?view=country&question=ES005>

**ХУУЛЬ БОЛОН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ КОНВЕНЦИЙГ АЛБАН ЁСООР ХЭВЛЭН
НИЙТЛЭХ, ХҮЧИН ТӨГӨЛДӨРТ ТООЦОХ, АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА ХИЙХ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТҮРШЛАГА**

*Г.Алтан-Оч (PhD), Ц.Болормаа, И.Жаргалзаяабямба
Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаа, Б.Нандингэрэл
О.Нарантуяа, Ч.Онончимэг, А.Пагма
Д.Халиун, Г.Чулуун*

Судалгаанд гадаадын 20 орны хууль эрх зүйн актуудын хүрээнд хуулийг албан ёсоор хэвлэн нийтлэх, хүчин төгөлдөрт тооцох эрх зүйн зохицуулалтын талаарх мэдээллийг Хүснэгт 1-ээр, гадаадын 8 орны Олон улсын гэрээ хэлэлцээрийг хэвлэн нийтлэх, албан ёсны орчуулгыг гүйцэтгэх хууль эрх зүйн зохицуулалтын талаарх мэдээллийг Хүснэгт 2-оор тус тус бэлтгэлээ.

Мөн “Олон улсын гэрээ хэлэлцээрийг бүртгэх, нийтлэх тухай НҮБ-ын дүрэм” (Charter of the United Nations), “Олон улсын гэрээний эрх зүйн тухай венийн конвенц” (The Vienna Convention on the Law of Treaties (VCLT)-ыг Англи хэлнээс Монгол хэлэнд бүрэн эхээр нь орчуулсан болно. /Хавсралт/

Судалгаанаас үзэхэд, судалгаанд хамрагдсан 20 орноос 8 нь буюу ОХУ, Молдав, Финланд, Канад, Армен, Украин, Герман, Австри зэрэг оронд хууль, дүрэм журмыг хэвлэн нийтлэх харилцааг зохицуулсан бие даасан хуультай байгаа бол ихэнх улс оронд Үндсэн хууль болон Парламентын тухай хууль, Парламентын дэгийн тухай хуулиар тус тус зохицуулсан байна.

Хууль хүчин төгөлдөр болох, хэвлэн нийтлэх хугацааны тухайд судалгаанд хамрагдсан ихэнх орнуудад хуулийг ёсчлон баталснаас хойш 3-30 хоногийн хугацаанд хэвлэн нийтлэх, хүчин төгөлдөрт тооцохоор зохицуулсан байх боловч зарим нэг оронд хууль ёсчлон батлагдснаар хүчин төгөлдөр болохоор зохицуулжээ.

Ихэнх улс оронд хуулийг албан ёсоор хэвлэн нийтлэх төрийн төв хэвлэл болон цахим хэлбэрээр байршуулах хуулийн нэгдсэн портал сайттай байна. Цахим портал сайтын хувьд Австри улс онцлогтой байна. Австрийн төрийн хэвлэх үйлдвэрт, дараа нь “Print Media Austria” хувьцаат компанид хэвлэгддэг байсан хэвлэмэл хувийг 2004 оноос хойш халж, “RIS” (Холбооны эрхзүйн мэдээллийн систем) системд он-лайн нийтлэгдсэн хувийг албан ёсны хувь гэж үздэг болсон. Энэ нь тухайн үедээ европод цорын ганц бөгөөд анхны тохиолдол байв. Үүнийг 2004 оны “Зарлан тунхагийг шинэчлэх тухай хууль”-ийн дагуу хийж гүйцэтгэсэн болно. Техникийн түвшинд, он-лайн зарлан тунхаг нь цахим гарын үсэг хэрэглэснээр боломжтой болжээ.

ОИГ.МН
СУДАЛГААНЫ САН

Хуулийг албан ёсоор хэвлэн нийтлэх, хүчин төгөлдөрт тооцох талаарх эрх зүйн зохицуулалт

Хүснэгт 1

№	Улсын нэр	Хууль эрх зүйн акт	Хэвлэн нийтлэх	Хууль хүчин төгөлдөр болох	Албан ёсны хэвлэл, сайт
1	ОХУ	-Үндсэн хууль, хэсэг1, 2 зүйл 107 -"Холбооны үндсэн хуульжсан хууль, холбооны хууль, холбооны Хурлын танхимуудын эрх зүйн актүүд батлагдсанаас хойш 10 хоногийн дотор хэвлэн нийтлэнэ."	- Холбооны үндсэн хуульжсан хууль, холбооны хуулийг Ерөнхийлөгч гарын үсэг зурснаас хойш 7 хоногийн дотор албан ёсоор хэвлэн нийтлэнэ. - Холбооны Хурлын танхимуудын эрх зүйн актүүд батлагдсанаас хойш 10 хоногийн дотор хэвлэн нийтлэнэ.	Холбооны үндсэн хуульжсан хууль, холбооны хууль, Холбооны Хурлын танхимуудын эрх зүйн актүүдэд өөрт нь хүчин төгөлдөр болох өөр журам заагаагүй бол эдгээр хууль нь албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.	"Парламентын сонин", "Оросын сонин", "Оросын Холбооны Улсын хуулийн эмхэтгэл" ба албан ёсны сайт нь "Эрх зүйн мэдээллийн албан ёсны интернет портал" (www.pravo.gov.ru)
2	Молдав	-Үндсэн хууль, хэсэг 3, 3.зүйл 76 -"Албан ёсны эрх зүйн актүүд хүчин төгөлдөр болох, хэвлэн нийтлэх журмын тухай" хууль" ⁴⁸	-Хуулийг Ерөнхийлөгч гарын үсэг зурснаас хойш 3 хоногийн дотор Терийн мэдээллийн агентлаг "Moldpress"-д хүргүүлж, Албан ёсны мэдээллийн сэтгүүл "Официальный монитор"-т хэвлэн нийтлэнэ.	Албан ёсны хууль эрх зүйн актүүд нь Албан ёсны мэдээллийн сэтгүүл "Официальный монитор"-т нийтлэгдсэн өдрөөс болон хэрэв хуульд өөрт нь хугацаа заагдсан бол тэр хугацаанд хүчин төгөлдөр болно. Хуульд өөрт нь заагдсан хугацаанд хүчин төгөлдөр болсон хуулийг батлагдсанаас нь хойш 10 хоногийн дотор "Официальный монитор"-т нийтлэнэ.	Албан ёсны мэдээллийн сэтгүүл "Официальный монитор", Засгийн газрын албан ёсны веб-сайт http://www.gov.md/ro
3	Серби	-Үндсэн хууль 2006. 113 зүйл. Хуулийг ёсчлох ⁴⁹	196-р зүйл. Хууль эрх зүйн актыг хэвлэн нийтлэх Бүх хууль эрх зүйн актүүд нь хүчин төгөлдөр болохоос өмнө хэвлэн нийтлэгдсэн байна. Үндсэн хууль, хууль болон дотоод дүрэм журмуудыг төрийн албан ёсны сэтгүүлд (<i>public official journal</i>), автономит мужуудын тогтоол, шийдвэр болон эрх зүйн актүүд нь мужийн албан ёсны сэтгүүлд (<i>provincial official journal</i>) нийтлэгдэнэ. Орон нутгийн өөрөө удирдах нэгжийн тогтоол, шийдвэрүүд, эрх зүйн актүүд нь орон нутгийн албан ёсны сэтгүүлд (<i>local official journal</i>) нийтлэгдэнэ.	196-р зүйл. Хууль болон бусад эрх зүйн актүүд нь хэвлэн нийтлэгдсэнээс хойш 8 хоногийн дараа хүчин төгөлдөр болох бөгөөд хуулийг батлахдаа тухайн хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг хугацаанаас өмнө тогтоох үндэслэл гаргасан тохиолдолдт хугацаанаас нь өмнө тогтоож болно. ⁵⁰ Үндэсний Ассамблейн дэг: 247-р зүйл. Үндэсний Ассамблейгаар батлагдсан хууль болон Үндэсний Ассамблейн холбогдох хороодын тогтоол боловсруулах арга зүйн онцгой журмууд нь БНСерби Улсын Албан ёсны сонин (<i>Official Gazette</i>)-д хэвлэн нийтлэгдэнэ. ⁵¹	Албан ёсны сонин (<i>Službeni Glasnik</i>) http://www.sglasnik.com/ http://www.pravno-informacioni-sistem.rs/SlGlasnikPortal/pages/home.xhtml

⁴⁷ Федеральный закон "О порядке опубликования и вступления в силу федеральных конституционных законов, федеральных законов, актов палат Федерального Собрания", www.pravo.gov.ru

⁴⁸ Закон Молдовы "О порядке опубликования и вступления в силу официальных актов", <http://base.srbimol.gov.tu>
⁴⁹ Тодруулав. Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь хуулийг зарлиг гарган ёсчлох, эсхүл хуулийг Парламенттад дахин хэлэлцүүлэхээр бичсэн тейлбарын хамт хуулийг баталснаас 15 хоногдоос хэтрэлгүй, хуулийг онцгой журмаар баталсан бол 7 хоногдоос тус тус хэтрэлгүй буцаах эрхтэй байна. Буцаагдсан хуулиар дахин санал хураалт явуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд нийт гишүүдийн олонхын саналаар батална. Ийнхүү батлагдсан хуулийг Ерөнхийлөгч ёсчлох үүрэгтэй байна. Үндсэн хуульд заасан хугацаанд Ерөнхийлөгч тус хуулийг ёсчлох зарлиг гаргаагүй тохиолдолд, Парламентын спикер тус зарлигаар гаргана.

⁵⁰ http://www.srbija.gov.rs/ci/enice_o_srbiji/ustav.php?change_lang=en

⁵¹ <http://www.parlament.gov.rs/national-assembly/important-documents/rules-of-procedure-%28consolidated-text%29/entire-document---rules-of-procedure.1424.html>

4	Сингапур	-Үндсэн хууль 1963, 58 зүйл. Хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх ⁵² -22. Н зүйл. Ерөнхийлөгч зарим хуулийг зөвшөөрөхөөс татгалзах эрх ⁵³	58. 2. Хуулийн төслийг Ерөнхийлөгч зөвшөөрч, Албан ёсны сонин (Gazette)-д хэвлэн нийтлүүлсэн өдөр хүчин төгөлдөр болно. Эсхүл энэхүү хууль, Сингапурт хүчин төгөлдөр үйлчилж буй өөр бусад хуульд, өөр өдөр хүчин төгөлдөр болохоор заасан бол тухайн өдөр хүчин төгөлдөр болно.	22.Н. Зөвшөөрөл авахаар өргөн барьсан хуулийг 30 хоногийн дотор Ерөнхийлөгч зөвшөөрөл өгөхөөс татгалзаагүй, эсхүл "дээд шүүхийн зөвлөл"-өөс санал авах хүсэлт гаргаагүй тохиолдолд 30 хоног дууссаны дараагаар Ерөнхийлөгчийг зөвшөөрөл өгсөнд тооцно.	-“Сингапурын хууль эрх зүйн актуудын онлайн вебсайт” (Singapore Statutes Online) ⁵⁴ -“Сингапурын төрийн цахим мэдээллийн сэтгүүл” (Electronic gazette) http://www.egazette.com.sg
5	Финланд	-Үндсэн хууль ⁵⁵ , зүйл 79 -Финландын Дүрэм журмын тухай хууль ⁵⁶ , бүлэг 2, зүйл 7	79-р зүйл. Хуулийг Ерөнхийлөгч гарын үсэг зурж, холбогдох яамны сайд хоёр дахь гарын үсэг зурж баталгаажуулан хүчин төгөлдөр болсон даруйд нь Засгийн газар "The Statutes of Finland" цувралд хэвлэн нийтлэнэ. Хуулийг Финланд болон Швед хэл дээр батлан хэвлэн нийтлүүлнэ.	7-р зүйл. Батлагдсан хууль, эрх зүйн актууд нь "The Statutes of Finland" цувралд нийтлэгдсэн өдрөөс болон хэрэв хуульд хүчин төгөлдөр болох хугацаа заагдсан бол тэр хугацаанд хүчин төгөлдөр болно. -Хэрэв хүчин төгөлдөр болох өдрөөсөө өмнө хэвлэгдээгүй бол хэвлэн нийтлэгдсэн өдрөөсөө хүчин төгөлдөр болно.	-Албан ёсны батлагдсан хууль дүрэм журмыг нийтэлдэг "The Statutes of Finland" цуврал сэтгүүл, -Хууль зүйн яамны хуулийн нэгдсэн мэдээллийн портал www.Finlex.fi
6	Канад	Хууль, журмын тухай хууль ⁵⁷ , зүйл 9,10,11,12	-Батлагдсан хуулийг бүртгүүлснээс хойш Хатан хааны албан ёсны хэвлэл болох "Canada Gazette"-д 23 хоногийн хэвлэн нийтлэнэ. Хэвлэлийн хэлбэр маяг ба цахим хэлбэрээр хэвлэхийг оролцуулан бүхий л хэвлэлийн үйл явцыг Зөвлөлийн захирагч хариуцна. -"Canada Gazette" сонины албан ёсны хэвлэлийн цахим хувилбарыг веб сайтад pdf хэлбэрээр байршуулдаг. -"Canada Gazette" сонины албан ёсны хэвлэлийн цахим хувилбарыг веб сайтад pdf хэлбэрээр байршуулдаг.	-Батлагдсан хууль болон эрх зүйн актууд нь бүртгэгдсэн өдрөөсөө хүчин төгөлдөр тооцогдох бөгөөд зарим тохиолдолд бүртгэгдэхээсээ өмнө хүчин төгөлдөр болно гэж хугацаа заагдсан үед Хууль тогтоох байгууллагаас Нууцын түшмэлд тухайн шалтгааныг тодорхой бичихийг зөвлөдөг.	-Хатан хааны албан ёсны хэвлэл "Canada Gazette" сонин, -Хууль зүй яамны албан ёсны хуулийн нэгдсэн сайт http://laws.justice.gc.ca

⁵² <http://statutes.agc.gov.sg/aol/search/display/view.w3p;page=0;query=DocId%3A%22cd2412ff-fca5-4a64-a8ef-b95b987728e%22%20Status%3Ainforce%20Depth%3A0;rec=0;whole=yes>

⁵³ Singapore Attorney-General's Chamber, Legislative division
The e-Publication Group is responsible for maintaining the Legislation Editing and Authentic Publishing System Versioned Legislation Database (LEAP-VLDB) and the Singapore Statutes Online website to ensure

24/7 online public access to Singapore's written laws.
⁵⁴ https://www.agc.gov.sg/What_We_Do/Legislation_Division/Legislation_Division.aspx

⁵⁵ The constitution of Finland and parliament's rules of procedure - https://www.eduskunta.fi/Fi/ietoeduskunnastajulkaisu/Document/ekj_3+2013.pdf -

⁵⁶ Act on the Statutes of Finland (188/2000) <http://www.finlex.fi/en/laki/kaanokset/2000/en20000188>.

⁵⁷ Statutory Instruments Act R.S.C., 1985, c. S-22 - <http://laws-lois.justice.gc.ca/eng/acts/S-22/>

7	Болгар	Үндсэн хууль ⁵⁸ <i>Тайлбар:</i> Болгарын "Rules of procedure of the national assembly" ⁵⁹ хуульд Үндэсний Ассамблейн олон нийтэд мэдээлэх, хэвлэн нийтлэн процессын талаар нарийвчлан тусгаагүй болно.	88-р зүйл. 3 Үндэсний Ассамблей батласан шийдвэрийг төрийн хэвлэл (State Gazette) /-д баталснаас хойш 15 хоногийн дотор нийтэлж зарлан мэдэгдэнэ. 10-р зүйл. 1. Ерөнхийлөгч нь энэ хуулийн 88-р зүйлийн 3 дахь хэсэгт тогтоосон хугацаанд хуулийг дахин хэлэлцүүлэхээр Үндэсний Ассамблейд буцааж болно. 2. Ийнхүү буцаагдсан хууль Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн дийлэнх олонхийн саналаар батлагдсанд тооцно. 3 Үндэсний Ассамблейгаар батлагдсан шинэ хуулийг Ерөнхийлөгч долоон өдрийн дотор хүлээн авч гарын үсэг зурж зарлан тунхагладаг.	5-р зүйл. Бүхий л хэм хэмжээ тогтоосон актыг хэвлэнэ. Хуульд хүчин төгөлдөр болох хугацааг зааснаас бусад тохиолдолд төрийн хэвлэл /State Gazette/-д хэвлэн нийтэлснээс хойш гурав хоногийн дотор хүчин төгөлдөр болно.	Үндэсний Ассамблейн албан ёсны сайт http://www.parliament.bg
8	Эстони	Үндсэн хууль ⁶⁰ <i>Тайлбар:</i> Эстонийн "Riigikogu Rules of Procedure and Internal Rules Act" ⁶¹ -д хуулийг баталсанаар олон нийтэд мэдээлэх, хэвлэн нийтлэх процессын талаар нарийвчлан тусгаагүй болно.	107-р зүйл. Ерөнхийлөгч хуулийг ёсчлох, албажуулах Ерөнхийлөгч Рийгикогу-аар баталсан хуулийг ёсчлох буюу татгалзсанаас хойш 14 хоногийн дотор Рийгикогу Ерөнхийлөгчийн татгалзсан үндэслэлийг дахин шинээр хэлэлцүүлэн шийдвэр гаргана. Хэрэв Рийгикогу нь ерөнхийлөгчийн будаасан хуулийг хэвээр нь дахин баталсан тохиолдолд Ерөнхийлөгч уг хуулийг зарлан тунхаглана, эсвэл уг татгалзсан хуулийг татгалзсан шалтгааны хамт Улсын дээд шүүхэд санал гаргана. 108-р зүйл. Хууль хүчин төгөлдөр болох тухай Хуульд өөрөөр заагаагүй бол Рийгикогу-аар батлагдсан хууль нь төрийн хэвлэл болох Riigi Teataja-д хэвлэгдсэнээс хойш 10 дахь хоногтоос хүчин төгөлдөр болно.	Төрийн албан ёсны хэвлэл "Riigi Teataja" Албан ёсны мэдээллийн сайт https://www.riigiteataja.ee/	
9	Румын	-Үндсэн хууль. 2003 он -Румыны Албан ёсны Хэвлэлийн байгууллагын тухай хууль ⁶²	5-р зүйл. Дараах төрлийн бичиг баримтыг хэвлэнэ: А. Парламентын хууль тогтоомж: а) Хууль, шийдвэр, гишүүдийн санал; б) Парламентийн хоёр Танхимын шийдвэр болон саналууд; III бүлэг Румыны Албан ёсны Хэвлэлд бичиг баримт хэвлэх процедур 10-р зүйл. Румыны Албан ёсны Хэвлэлд хууль тогтоомжийг хэвлэхдээ Төлөөлөгчдийн Танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга эсхүл түүний орлогчийн гарын үсэг зурсан эрх бүхий эх хувийг хүргүүлнэ. 11-р зүйл. Эрх бүхий байгууллага нь Румыны Албан ёсны Хэвлэлд хэвлэн нийтлэх шаардлага хангасан мэдээ, мэдээллийг бичгээр, цаг алдалгүйгээр Ерөнхий Нарийн бичгийн даргад илгээх үүрэгтэй. 12-р зүйл. Баримт бичгийг хэвлэх ажиллагааг хүчингүй болгохдоо зөвхөн хэвлэхийг захиалагчийн хүсэлтээр хүчингүй болгох ба ингэхдээ Ерөнхий нарийн бичгийн даргын зөвшөөрлийн дагуу хүчингүй болгоно. Батлах, нийтлэх явцад гарсан зардлыг хүсэлт гаргасан этгээд даана.	5-р зүйл. Румыны Албан ёсны Хэвлэл (Official Gazette of Romania) нь Румыны төрийн хууль тогтоомжийг хэвлэх албан ёсны хууль зүйн хэвлэл http://www.dreptonline.ro/en_resources/en_official_gazette_romania.php 77-р зүйл. Хуулийг ёсчлох 1. Хуулиудыг Румын Ерөнхийлөгчөөр ёсчлуулахаар өргөн шилжүүлнэ. Хуулийг хүлээн авсанаас хойш 20 хоногийн дотор ёсчилно. 2. Ерөнхийлөгч хуулийг ёсчлохоосоо өмнө хянаж үзээд зөвхөн нэг удаа парламент руу буцааж болно. 78-р зүйл. Хууль хүчин төгөлдөр болох Хууль тогтоомжийг Румыны Албан ёсны Хэвлэлд (Official Gazette of Romania) хэвлэх бөгөөд хэвлэсэнээс хойш 3 хоногийн дотор хүчин төгөлдөр болох ба эсхүл хуульд тусгайлан заасан өдөр хүчин төгөлдөр болно.	

⁵⁸ https://www.constituteproject.org/constitution/Bulgaria_2007?lang=en

⁵⁹ <http://www.parliament.bg/en/rulesoftheorganisations>

⁶⁰ https://www.constituteproject.org/constitution/Estonia_2011?lang=en

⁶¹ <https://www.riigiteataja.ee/en/eli/51811201/4003/consolide>

⁶² Law on organization of "Monitorul Oficial" of Romania Published in the Official Gazette no. 423 of 10 November 1998

10	Бүгд Найрамдах Турк	-Үндсэн хууль -Туркийн Үндэсний Их Хурлын Дэг ⁶³	Дэгийн тухай хуулийн 81-р зүйл. Хэрэв Ерөнхийлөгч хуулийг Ардын Их Хуралд буцаасан бол хуулийг хэсэгчлэн хэвлэхгүй бөгөөд Чуулганы нэгдсэн хуралдаан болон байнгын хороонд хуулийг хэлэлцүүлэхээр буцаана. Ардын Их Хурлаас баталсан хууль Албан ёсны Хэвлэл (Official Gazette)-д хэвлэх хүртэл хүчин төгөлдөр бус байна. Хуульд хугацааг өөрөөр заагаагүй бол Албан ёсны Хэвлэл (Official Gazette)-д хэвлэгдсэн өдрөөс хойш 45 дахь өдөр хууль хүчин төгөлдөр болно.	Үндсэн хууль: 89.1. Бүгд Найрамдах улсын Ерөнхийлөгч нь Үндэсний Их Хурлаас баталсан хууль тогтоомжийг 15 хоногийн дотор ёсчилно. 89.3. Хэрэв Ассамблей хууль батласан бол Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч хуулийг хэвлүүлэх ёстой. 91.6. Хууль тогтоомж нь Албан ёсны Хэвлэл (Official Gazette)-д хэвлэгдсэнээр хүчин төгөлдөр болно. Хэрэв хүчин төгөлдөр болох өдрийг тусгайлан заасан бол тухайн өдрөөс хүчин төгөлдөр болно. Тусгайлан заагаагүй бол Албан ёсны Хэвлэл (Official Gazette)-д хэвлэгдсэнээр хүчин төгөлдөр болно.	http://www.resmigezete.gov.tr/default.aspx Албан ёсны хууль тогтоомжийн сайт
11	Франц	Үндсэн хууль ⁶⁴	Хууль болон зарлигийг Францын хууль зүйн албан ёсны сэтгүүл "Le Journal Officiel"-д хэвлэн нийтэлнэ.	10-р зүйл. Эцэслэн баталсан хуулийг Засгийн газарт шилжүүлснээс хойш 15 хоногийн дотор Ерөнхийлөгч батламжилна. ⁶⁵	Францын албан ёсны сэтгүүл le Journal Officiel
12	БН Солонгос	Үндсэн хууль, 53-р зүйл	ҮХ-ийн 53 дугаар зүйл. ⁶⁶ 1. Ассамблейгаас батлагдсан хуулийг Засгийн газарт хүргүүлснээс хойш 15 хоногийн дотор Ерөнхийлөгч соёрхон батална. ⁶⁷	Үндэсний Ассамблейн албан ёсны хэвлэлд хэвлэгдсэнээр хүчин төгөлдөр болно.	-
13	Хорват	-Үндсэн хуулийн 89-р зүйл ⁶⁸ - Парламентын тухай хуулийн 169-р зүйл ⁶⁹	Үндсэн хууль, түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу парламентаас баталсан хууль бусад шийдвэрийг төрийн төв хэвлэл "Narodne novine" болон "Parliament's bulletin" сэтгүүлд хэвлэн нийтлэнэ. Парламентын Тамгын газрын нарийн бичгийн дарга батлагдсан хууль бусад шийдвэрийг төрийн төв хэвлэл "Narodne novine" болон "Parliament's bulletin" сэтгүүлд хэвлэн нийтлэх, хяналт тавих үүрэгтэй.	Парламентаас баталсан хуулийг 8 хоногийн дотор Хорватын Ерөнхийлөгч ёсчилсноор хүчин төгөлдөрт тооцно.	-Албан ёсны сэтгүүл "Narodne novine", - "Parliament's bulletin"

⁶³ Rules of procedure of the Grand National Assembly of Turkey

⁶⁴ <http://www.conseil-constitutionnel.fr/conseil-constitutionnel/english/constitution/constitution-of-4-october-1958.25742.html>

⁶⁵ <http://about-france.com/political-system.htm>

⁶⁶ http://korea.assembly.go.kr/res/low_02_read.jsp?boardid=10000000036

⁶⁷ http://korea.assembly.go.kr/res/low_03_read.jsp

⁶⁸ www.constituteproject.org

⁶⁹ <http://www.sabor.hr/acts-of-parliament>

14	Унгар	-Үндсэн хуулийн 6-р зүйл ⁷⁰	Парламентаас баталсан хууль бусад шийдвэрийг Улсын Их Хурлын дарга гарын үсэг зурж ёсчилсны дараа Ерөнхийлөгчийн тамгын газарт илгээнэ. Ерөнхийлөгч Парламентаас баталсан хууль бусад шийдвэрийг баталгаажуулж гарын үсэг зурснаас хойш ажлын 5 хоногийн дотор төрийн төв хэвлэл "Magyar Kézilap" сэтгүүлд хэвлэн нийтлэнэ.	Парламентаас баталсан хууль бусад шийдвэрт хүчин төгөлдөр болох хугацааг өөрөөр заагаагүй бол Төрийн төв хэвлэл "Magyar Kézilap" сэтгүүлд хэвлэн нийтлэгдсэнээс хойш 5 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.	-Албан ёсны сэтгүүл "Magyar Kézilap", http://www.magyarkezlapi.hu/ -Эрх зүйн мэдээллийн албан ёсны интернет портал ⁷¹ (http://www.njt.hu/)
15	Нидерланд	Үндсэн хуулийн 88-р зүйл ⁷¹	Хууль болон бусад шийдвэрийг хэвлэхдээ парламентын хуульд заасны дагуу хэвлэнэ.	Батлагдсан хууль болон бусад шийдвэрт хууль зүйн сайд гарын үсэг зурж, засгийн газрын албан ёсны тогтмол хэвлэл "Staatscourant" gazetta-д хэвлэгдсэнээр хүчин төгөлдөр хэрэгжинэ. ⁷²	Албан ёсны хэвлэл "Staatscourant" gazetta
16	Армен	-Үндсэн хуулийн 6-р зүйл - Эрх зүйн баримт бичгийн тухай хуулийн 62-р зүйл.	-БНАрмен улсын албан ёсны сэтгүүл, БНАрмен улсын тогтоол шийдвэрийн агентлаг нь Арменийн улсын хууль болон бусад шийдвэрийг хэвлэн авсан өдрөөс 10 хоногийн дотор хэвлэн нийтлэх үүрэгтэй. -БНАрмен улсын албан ёсны сэтгүүл нь долоо хоног бүрийн Лхагва гаригт, БНАрмен улсын тогтоол шийдвэрийн эмхтгэл нь сар бүрийн 1, 15-нд хэвлэгддэг. -Хэрэв хэвлэлийн өдөр амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр хэвлэн нийтлэх бөгөөд албан ёсны хэвлэн нийтлэх ёстой байсан өдрийг тэмдэглэн бичсэн байна. -Армений хууль зүйн яам нь батлагдсан хууль, бусад шийдвэрийг албан ёсны агентлагт хүргүүлэх бөгөөд тус агентлаг нь улсын төсвөөс санхүүжинэ.	Арменийн улсын хууль болон бусад шийдвэр нь БНАрмен улсын албан ёсны сэтгүүл, БНАрмен улсын тогтоол шийдвэрийн эмхтгэлийн аль нэгэнд хэвлэгдсэнээр хүчин төгөлдөр хэрэгжинэ. ⁷³	Албан ёсны сэтгүүлд: 1."Official journal of republic of Armenia", 2."Agency regulatory acts of the Republic of Armenia"
17	Украин	-Украины Үндсэн хууль, Зүйл 94 - Украины Ерөнхийлөгчийн "Эрхзүйн хэм хэмжээ тогтоосон Акт"ыг нийтэд албан ёсоор ил болгох (официальное обнародование хийх) журмын тухай Зарлиг (10.06.1997 г. N 503/97) –ийн 1 –т;	"... хуулийг батлагдсан ба гарын үсэг зуралдсанаас нь хойш 15 хоногт багтаан албан ёсны хэвлэлд албан ёсоор нийтэлнэ гэж заасан. Зарим тохиолдол (ч.4 ст.1 – Зарл. N 503/97) –д онц чухал хууль тогтоомжийг Улсын Радио ба ТВ –ийн шугамаар нийтэд ил болгож болно; Зарлигт "албан ёсны хэвлэл" –ийн нэрийг тухайлан заасан байна." ⁷⁴	Украины Дээд Рада –аар баталсан хууль, Дээд Рада –ийн дарга гарын үсэг зурж, Украины Ерөнхийлөгчид даруй илгээнэ. Украины Ерөнхийлөгч хуулийг хүлээж авсанаасаа хойш 15 хоногийн дотор уг хуульд гарын үсэг зурж батламжлан нийтэд ил болгоно, эсхүл дахин хэлэлцүүлэхээр Дээд Рада –д буцаана. Ерөнхийлөгч тогтоосон хугацааны дотор "хуулийг буцаагаагүй" бол уг хуулийг батламжлагдсанд	Албан ёсны хэвлэлүүд: Үүнд: -"Офіційний вісник України"; -"Ведомости Верховной Рады Украины"; -"Урядовий курьер" сонин;

⁷⁰ www.constituteproject.org

⁷¹ www.constituteproject.org

⁷² <http://www.houseofrepresentatives.nl/>

⁷³ <http://www.parliament.am/>

⁷⁴ Ведомости Верховной Рады Украины (ВВР), 2004, N 50, ст.540)

				тооцно. Ерөнхийлөгчийн зүгээс "албан ёсоор буцаагдсан (хориг тавигдсан) хууль" –ийг Дээд Рада (нийт бүрэлдэхүүний 2/3 –ын дэмжлэгээр) өөрчлөхгүйгээр дахин баталсан бол Ерөнхийлөгч уг хуулийг шууд (буцаах эрхгүй) батламжилна. Энэ тохиолдолд, хэрэв Ерөнхийлөгч батламжлахаас татгалзвал, Дээд Рада –ийн дарга гарын үсэг зуран батламжилна, улмаар нийтлэгдэнэ. Хуулийг (догтор нь хугацаа тухайлан заагаагүй бол) албан ёсоор нийтлэгдсэнээс нь хойш 10 хоногийн дараа дагаж мөрдөж эхэлнэ. Хуулийн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн хугацааг тогтоохдоо албан ёсны 3 хэвлэлийн аль эхэнд хэвлэсэн огнооноос тооцно.		- Казахстаны "Парламентын мэдээлэл"-д;
18	Казахстан ⁷⁵	Ерөнхийлөгчийн 1995 оны 2679 дүгээр зарлигийн 27 дугаар зүйлд Ерөнхийлөгчийн 1995 оны 2679 дүгээр зарлигийн 27 дугаар зүйлд ⁷⁶	-Засгийн газраас гаргасан журмын дагуу сонгон шалгаруулалтад эрх авсан үндэсний хэмжээний сонин хэвлэлүүдэд төрийн хуулийг албан ёсоор нийтлүүлнэ.		- Албан ёсоор хэвлэн нийтлэгдсэн өдрөөс хойш хуанлийн 10 хоногийн дараа хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ. ⁷⁷	
		Казахстан Улсын хууль, Казахстаны Ерөнхийлөгчийн хуультай адилтаасан зарлигийг хэвлэн нийтлэхдээ:	- Засгийн газраас гаргасан журмын дагуу сонгон шалгаруулалтад эрх авсан үндэсний хэмжээний сонин хэвлэлүүдэд төрийн хуулийг албан ёсоор нийтлүүлнэ.		- Ард нийтийн санал асуулгаар баталсан Үндсэн хууль, мөн Үндсэн хуульчилсан хуулийг албан ёсоор хэвлэн нийтэлсэн өдрөөс эхлэн (хуулийн агуулгад нь энэ тухай өөрөөр заагаагүй бол) хүчин төгөлдөр мөрдөгдөнө. ⁷⁸	
		Казахстаны парламентын болон түүний Палатуудын тогтоолыг хэвлэн нийтлэхдээ:			- Тогтоолын агуулгад "дагаж мөрдөх хугацааны талаар" өөрөөр заагаагүй бол тэдгээрийг ёсчлогдсон өдрөөс нь дагаж мөрдөнө.	- Казахстаны "Парламентын мэдээлэл"-д;
					- Хуулийг дагаж мөрдөх хугацааг товлосон тогтоолын төслийг, тухайн хуулийн төсөлтэй нь хамт парламентаар хэлэлцэх бөгөөд, энэ тохиолдолд уг тогтоол	

⁷⁵ Тодруулаа: Казахстан улсын хууль тогтоомжид эрхзүйн актыг батлах, ёсчлох, хэвлэн нийтлэх, дагаж мөрдөхийг болон тухайн актыг хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацааг тэр бүр нарийн заагаагүй, тэдгээрийг багц ерөнхий ойлголтын хүрээнд "хамтруулан, бүрхэх орхисон" байдал зарим талаар ажиглагдаж, Казахстан Улсын Эрхзүйн хэм хэмжээ тогтоосон актыг тухай хууль (1998) зөвхөн "хуулийн тухай хууль" биш, илүү өргөн агуулгатай. Казахстан Улсын Хууль зүйн сайдын 2002 оны 125 дугаа тушаалд "эрхзүйн хэм хэмжээ тогтоосон аливаа акт "улсын эрхзүйн актыг нэгдсэн бүртгэлд орсны дараа хүчин төгөлдөр болно" гэсэн нь "гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд" гарсан баримт бичигт илүү хамаарах өгүүлэмж юм.

⁷⁶ [http://cons.paras.uald.asp=0005]

⁷⁷ (Казахстаны "Эрхзүйн хэм хэмжээ тогтоосон Актын тухай хуулийн 36 дугаар зүйл)

⁷⁸ (Казахстан Улсын Ард нийтийн санал асуулга «О республиканском референдуме» -ын тухай хуулийн 34 дүгээр заалт)

					(холбогдох) хуулийг нь Казахстаны Ерөнхийлөгч батламжилсны дараа хүчин төгөлдөр болно. Тогтоолд Мажилисын дарга гарын үсэг зурна. - Парламентын Дэг батлагдсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр. - Парламентын Сенатын Дэгийг батлагдсан өдрөөс нь эхэлж мөрдөнө. - Мөн зарим тогтоолыг албан ёсоор нийтлэгдсэн өдрөөс нь дагаж мөрдөх зэрэг бусад тухайсан тодорхой зохицуулалтай.	
					-Татварын хувь хэмжээг тогтоосон, өөрчилсөн хууль тогтоомжийг тухайн оны 12 дугаар сарын 1 –нээс өмнө батлах бөгөөд тэдгээрийн мөрдөж эхлэх хугацааг дараа оны 1 дүгээр сарын 01 –ний өдрөөс өмнө байхаар тогтоохгүй. ⁷⁹	
19	Герман	Үндсэн хуулийн 82-р зүйл. ⁸⁰ -Эрхзүйн актыг болон тунхаглах танилцуулах хууль ⁸¹	Үүнд: 1. Бүндэстэй (хэрэв зөвшилцөх хууль бол Холбооны зөвлөл) батласны дараа холбооны хуулинд Холбооны канцлер болон холбогдох сайд хоёул гарын үсэг зурна. 2. Түүний дараа Холбооны ерөнхийлөгч эх хувьд гарын үсэг зурах замаар ёсчлох үйл явдал болно. 3. Ерөнхийдөө энэ оноогоор хуулийн огноог тодорхойлдог. 4. Холбооны зар мэдээний хэвлэх цех олшруулсаны дараа Холбооны хуульзүйн яамнаас эрхлэн нийтэлж, тунхагийн өдрийг хэвлэгдэн гарсан өдрөөр тооцно. Өөрөөр хэлбэл, хэвлэгдэн гарсан “Хуулийн хуудас”-ын дугааруудыг Шууданд хүлээлгэж өгсөн өдөр. Энэ огноог “Хуулийн хуудас”-ын тухайн дугаарын толгой мөрөнд бичсэн байна. 5. Холбооны хуулийн хүчинтэй болох хугацааг ихэвчлэн хууль дотор нь яв цав заасан байдаг. 6. Хэрэв ингэж заагаагүй бол хууль нь “Хуулийн хуудас”-наа хэвлэгдэн гарснаас хойш 14 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.		Германы “Холбооны Хуулийн Хуудас” (Bundesgesetzblatt) ⁸² бол ХЕНГУ-ын нийтийн ⁸³ тунхагийн ⁸⁴ хуудас юм. Түүнийг Бонн дахь Холбооны Хуульзүйн Яам эрхлэн нийтэлж, ⁸⁵ Холбооны Зар мэдээний ⁸⁶ Хэвлэх үйлдвэр ⁸⁷ хэвлэж түгээдэг.	
20	Австри	Холбооны хуулийн хуудасны тухай хууль, 1985	1986 онд оруулсан өөрчлөлтийн дагуу 1997 оноос эхлэн уг хуудас нь 3 хэсгээс бүрдэх болсон. Үүнд: 1. Холбооны хууль I хэсэг 2. Яамдын тогтоол шийдвэр (II хэсэг) /Хоёрдогч эрхзүйн акт ⁸⁸ 3. Төрийн гэрээ хэлэлцээр (IIIхэсэг) /Үндэстнүүдийн эрхзүй [Олон улсын хууль] -Анх Австрийн төрийн хэвлэх үйлдвэр, дараа нь “Print Media Austria” хувьцаат компанид хэвлэгддэг байсан хэвлэмэл хувийг 2004 оноос хойш халж, “RIS” ⁸⁹ (Холбооны эрхзүйн мэдээллийн систем) системд он-лайн нийтлэгдсэн хувийг албан ёсны хувь гэж үздэг болсон. Энэ нь тухайн үедээ европод цорын ганц бөгөөд анхны тохиолдол байв. Үүнийг 2004 оны “Зарлан тунхагийг шинэчлэх тухай хууль”-ийн дагуу хийж гүйцэтгэсэн болно. Техникийн түвшинд, он-лайн зарлан тунхаг нь цахим гарын үсэг хэрэглэгдсэнээр боломжтой болжээ. RIS системээр 1920-1938 он болон 1945-аас 2003 он хүртэлх хуулиудыг хайж олох боломжтой.			

⁷⁹ (Казахстан Улсын Татварын .. тухай хууль (2001, №209-II) -ийн 3 дугаар заалт)⁸⁰ Professor Dr. Christoph Groepi, Universitaet des Saarlands, „Jura“ 1995, S. 641-643⁸¹ Gesetz ueber die Verkueundung von Rechtsverordnungen und Bekanntmachungen, 30.01.1950⁸² Bundesgesetzblatt (Deutschland) https://de.wikipedia.org/wiki/Bundesgesetzblatt_%28Deutschland%29⁸³ public-attribution: ueffentlich-germanaap⁸⁴ Promulgation-angliap: Verkuendung-germanaap⁸⁵ Publication-angliap: Herausgabe-germanaap⁸⁶ Anzeige-germanaap⁸⁷ Verlag-germanaap⁸⁸ Rechtsinformationssystem der Republik Uesterreich http://en.io.gov.molinks/record/29.aspx⁸⁹ Rechtsinformationssystem des Bundes-germanaap

ХАВСРАЛТ

Олон улсын гэрээ хэлэлцээрийг бүртгэх, нийтлэх тухай олон улсын эрх зүйн акт**1. НҮБ-ын дүрэм⁹⁰ (Charter of the United Nations)**

XVI бүлэг: Бусад заалт

102 дугаар зүйл.

1. Энэхүү дүрэм хүчин төгөлдөр болсноос хойш Нэгдсэн Үндэстний Байгууллагын аль ч гишүүний байгуулсан аливаа гэрээ болон олон улсын хэлэлцээрийг Нарийн бичгийн дарга нарын газарт аль болохоор шуурхай бүртгүүлж, тэндээс хэвлэн нийтлүүлж байвал зохино.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу бүртгүүлээгүй аливаа гэрээ буюу олон улсын хэлэлцээрт оролцогч этгээд Нэгдсэн Үндэстний Байгууллагын аль ч байгууллагад тийм гэрээ буюу хэлэлцээрийг иш татах ёсгүй.

103 дугаар зүйл.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүдийн энэхүү дүрмээр хүлээсэн үүрэг олон улсын өөр ямар нэг хэлэлцээрээр хүлээсэн үүрэгтэй нь харшлах тохиолдолд энэхүү дүрмээр хүлээсэн үүрэг нь давуу хүчинтэйд тооцогдоно.

2. Олон улсын гэрээний эрх зүйн тухай венийн конвенц (The Vienna Convention on the Law of Treaties (VCLT))

1969 оны 5 дугаар сарын 23-ны өдөр.

33-р зүйл. Эх бичвэрийн адил хүчинтэй байх нь хоёр буюу хэд хэдэн хэлээр тогтоогдсон гэрээг тайлбарлах

1. Хэрэв гэрээний эх бичвэр адил хүчинтэй байх нь хоёр буюу хэд хэдэн хэлээр тогтоогдсон бөгөөд эдгээр эх бичвэрийн хооронд зөрөө гарсан тохиолдолд тодорхой ямар нэг эх бичвэр давамгайлах хүчинтэй байна гэж гэрээнд заагаагүй буюу оролцогчид тохиролцоогүй бол хэл тус бүр дээрх эх бичвэр адил хүчинтэй байна.
2. Адил хүчинтэй нь тогтоогдсон хэлээс өөр хэлээрх гэрээний хувийг, хэрэв энэ тухай гэрээнд заасан буюу энэ талаар гэрээнд оролцогчид тохиролцсон тохиолдолд л, адил хүчинтэй эх бичвэр гэж үзнэ.
3. Гэрээний нэр томьёо нь адил хүчинтэй эх бичвэр бүрт ижил утгатай байх шаардлагатай.
4. Хэрэв адил хүчинтэй эх бичвэрүүдийг харьцуулахад гарсан утгын зөрөөг 31, 32 дугаар зүйлийг хэрэглэн арилгаж чадахгүй бол 1-д заасны дагуу ямар нэг тодорхой эх бичвэрийг давамгайлах хүчинтэй байхаар тогтоосноос бусад тохиолдолд гэрээний объект, зорилгыг харгалзан дээрх эх бичвэрүүдэд илүү тохирч байгаа утгыг хэрэглэнэ.

77-р зүйл. Гэрээ хадгалагчийн үүрэг

1. Хэрэв гэрээнд өөрөөр заагаагүй буюу хэлэлцэн тохирогч улсууд өөрөөр тохиролцоогүй бол гэрээ хадгалагч дор дурдсан үүрэгтэй байна:
 - а/ гэрээний жинхэнэ эх бичвэр, гэрээ хадгалагчид гардуулсан бүрэн эрхийн үнэмлэхийг хадгалах;
 - б/ гэрээний жинхэнэ эх бичвэрээс баталгаатай хуулбар бэлтгэх, гэрээгээр зааж болох аль нэг хэлээр гэрээний эх бичвэрийг бэлтгэх, түүнчлэн тэдгээрийг оролцогч улсууд болон оролцох бүхий улсуудад илгээх;
 - в/ гэрээнд гарын үсэг авах, гэрээтэй холбогдсон баримт бичиг, мэдэгдэл, мэдээг хүлээн авах, хадгалах;

⁹⁰ <http://www.un.org/en/sections/un-charter/chapter-xvii/index.html>

- г/ гэрээнд хамаарах гарын үсэг, баримт бичиг, мэдэгдэл буюу мэдээ нь зохих хэлбэр, журмааг үйлдэгдсэн эсэх тухай асуудлыг судлах, шаардлагатай тохиолдолд энэ асуудлыг холбогдох улсад мэдэгдэх;
 - д/ гэрээнд хамаарах баримт бичиг, мэдэгдэл болон мэдээний талаар оролцогчдод болон оролцох эрх бүхий улсуудад мэдэгдэх;
 - е/ гэрээ хүчин төгөлдөр болоход шаардагдах тооны гарын үсэг, батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн, баталсан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хүлээн авсан буюу хадгалуулсан тухай гэрээнд оролцох эрх бүхий улсуудад мэдэгдэх;
 - ё/ Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт гэрээг бүртгүүлэх;
 - ж/ энэхүү Конвенцийн бусад заалтад дурдсан үүргийг гүйцэтгэх.
2. Гэрээ хадгалагчийн үүргийг биелүүлэхтэй холбогдон гэрээ хадгалагч болон өөр ямар нэг улсын хооронд саналын зөрөө гарсан тохиолдолд гэрээ хадгалагч уг асуудлыг гэрээнд гарын үсэг зурсан улсууд болон хэлэлцэн тохирогч улсуудад, эсхүл холбогдох тохиолдолд, сонирхогч олон улсын байгууллагын эрх бүхий байгууллагад мэдэгдэж байна.

79-р зүйл. Гэрээний эх бичвэр буюу баталгаатай хуулбар дахь алдааг залруулах

1. 1Гэрээний эх бичвэрийн адил хүчинтэйг тогтоосны дараа гэрээнд гарын үсэг зурсан болон хэлэлцэн тохирогч улсууд гэрээний эх бичвэрт алдаа байгааг нийтээр зөвшөөрсний үндсэн дээр тогтоосон бөгөөд тэд өөр арга хэрэглэхээр шийдвэрлээгүй бол, алдааг дор дурдсан замаар залруулна:
- а/ гэрээний эх бичвэрт холбогдох залруулга оруулж, эрх олгогдсон төлөөлөгчид зохих ёсоор үзэглэх;
 - б/ оруулахаар тохиролцсон залруулгыг агуулсан баримт бичгийг зохиох, эсхүл ийм баримт бичгийг солилцох;
 - в/ жинхэнэ эх бичвэрийг боловсруулсан журмаар гэрээний залруулсан эх бичвэрийг бүхэлд нь зохиох.
2. Хэрэв энэ нь гэрээ хадгалагчид хадгалуулах ёстой гэрээ бол, гэрээ хадгалагч алдааны тухай, түүнчлэн алдааг залруулах тухай саналын талаар гарын үсэг зурсан улсууд болон хэлэлцэн тохирогч улсуудад мэдэгдэж, энэ саналын эсрэг татгалзал гаргаж болох хугацааг тогтооно. Хэрэв энэ хугацааг дуусахаас өмнө:
- а/ татгалзал гараагүй бол гэрээ хадгалагч гэрээний эх бичвэрт залруулгыг оруулан үзэглэж, энэ тухай протокол үйлдэж хуулбарыг гэрээнд оролцогч улсууд болон оролцох эрхтэй улсуудад илгээнэ;
 - б/ татгалзал гарсан бол түүнийг гэрээнд гарын үсэг зурсан улсууд болон хэлэлцэн тохирогч улсуудад гэрээ хадгалагч мэдэгдэнэ.
3. Эх бичвэрүүдийн адил хүчинтэйг хоёр болон хэд хэдэн хэлээр тогтоосны дараа тэдгээр эх бичвэрийн хооронд зөрөө гарсан бөгөөд түүнийг нийтээр зөвшөөрсний үндсэн дээр залруулах ёстой тохиолдолд 1, 2-т дурдсан журмыг мөн хэрэглэнэ.
4. Гэрээнд гарын үсэг зурсан улсууд болон хэлэлцэн тохирогч улсууд өөрөөр шийдвэрлээгүй бол залруулсан эх бичвэр нь алдаатай эх бичвэрийг ad initio орлож чадна.

80-р зүйл. Гэрээг бүртгүүлэх, нийтлэх

1. Гэрээг хүчин төгөлдөр болсны дараа бүртгүүлэх буюу хэрэгт хадгалуулах, тухайн тохиолдлоос хамааран жагсаалтад оруулах болон нийтлүүлэхээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлнэ.

2. Гэрээ хадгалагчийг томилсноор дээрх заалтад дурдсан үйлдлийг гүйцэтгэх бүрэн эрхийг түүнд олгоно.
5. Бүртгэгдсэн гэрээний эх бичвэрийг залруулсан тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэж байна.
6. Хэрэв гэрээний баталгаатай хуулбарт алдаа илэрвэл гэрээ хадгалагч түүнийг залруулсан тухай протокол үйлдэж, хуулбарыг гэрээнд гарын үсэг зурсан болон хэлэлцэн тохирогч улсуудад илгээнэ.

*Гадаадын зарим орны олон улсын гэрээ хэлэлцээрийн хэвлэн нийтлэх,
албан ёсны орчуулгын талаарх эрх зүйн акт*

Хүснэгт 2

№	Улсын нэр	Хууль эрх зүйн акт	Хэвлэн нийтлэх	Албан ёсны орчуулгыг хариуцах байгууллага
1.	ОХУ	“Оросын Холбооны Улсын олон улсын гэрээний тухай” Холбооны хууль ⁹¹ , хэсэг 3, зүйл 28	Хүчин төгөлдөр болсон олон улсын гэрээг албан ёсоор Олон улсын мэдээ сэтгүүлд нийтэлж, “Эрх зүйн мэдээллийн албан ёсны интернет портал”-д байршуулна.	Тус хуулийн дагуу ОХУ-ын олон улсын гэрээний эх бичмэлийг хадгалагч буюу depositary нь Гадаад хэргийн яам бөгөөд олон улсын гэрээний албан ёсны орчуулгын эх бичмэлийг хадгалагч хариуцахаар заажээ.
2.	Молдав	–“Албан ёсны эрх зүйн актууд хүчин төгөлдөр болох, хэвлэн нийтлэх журмын тухай” хууль –“Олон улсын гэрээний тухай” хууль ⁹²	Олон улсын гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 10 хоногийн дотор “Официальный монитор”-т нийтлэнэ.	Молдав улсын төрийн хэл дээр хийсэн олон улсын гэрээний орчуулгыг тус улсын Гадаад хэрэг, европын интеграцийн яам гэрчилнэ, уг орчуулгын үнэн зөв байдлыг олон улсын гэрээ байгуулах үйл ажиллагааг хариуцдаг байгууллага хангана.
3.	Финланд	Финландын Дүрэм журмын тухай хууль, бүлэг 2, зүйл 14	Финланд улс олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон нь хүчин төгөлдөр болж мэдэгдсэн даруйд нь “The Statutes of Finland”-уувралд хэвлэн нийтлэнэ.	Олон улсын гэрээ хэлэлцээр, хуулийн орчуулгыг Финландын Хууль зүйн яам хариуцдаг. Албан ёсны орчуулгын эх хувь Хууль Зүйн Яам-д хадгалагдана.
4.	Хорват	Парламентын тухай хуулийн 169 дүгээр зүйл ⁹³	Хорватын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцыг төрийн төв хэвлэл Narodne novine болон Parliament's bulletin сэтгүүлд хэвлэн нийтлэнэ.	Гадаад харилцааны яам
5.	Унгар	Үндсэн хууль, Fundamental law Article Q ⁹⁴	Олон улсын гэрээг Гадаад харилцааны яам Унгарын хууль эрх зүйн баримт бичиг хэвлэн нийтлэх журмыг баримтлан албан ёсны “Hivatalos Írtesntő” сэтгүүлд нийтлэнэ.	Гадаад харилцааны яам

⁹¹ Федеральный закон "О международных договорах Российской Федерации". Consultant.ru

⁹² Закон "О международных договорах Республики Молдова". base.spinform.ru

⁹³ <http://www.sabor.hr/acts-of-parliament>

⁹⁴ www.constituteproject.org/w.constituteproject.org

6.	Украин	<i>Украины Олон улсын гэрээний тухай хуулийн 21-р зүйл</i>	-Олон Улсын гэрээг “Украин улсын олон улсын хүчин төгөлдөр гэрээ хэлэлцээр”-ийн <i>эмхэтгэлд болон албан ёсны бусад хэвлэлд украин хэл дээр нийтэлнэ</i> ; -Украины хүчин төгөлдөр үйлчилж байгаа Олон улсын гэрээ нь Эрхзүйн баримт бичгийн үндэсний реестр –т зохих журмын дагуу бүртгэгдсэн байна.	-Олон улсын гэрээг украин хэл рүү хөрвүүлэх асуудлыг Гадаад харилцааны яам хариуцна. -Олон улсын гэрээний депозитарын үүргийг Украины гадаад харилцааны яам гүйцэтгэнэ.
7.	Казахстан	Ерөнхийлөгчийн 1995 оны 2679 дүгээр зарлигийн 27 дугаар зүйл	-Олон улсын гэрээ ⁹⁵ ний хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацаа нь талуудын харилцан тохирсон товоор, эсхүл, тухайн гэрээний дотор заасан хугацаагаар тодорхойлогдоно. Казахстан Улсын олон улсын гэрээ (бюллетень) сэтгүүлд болон Төр засгийн мэдээллийн албан ёсны сонин сэтгүүлд тус тус нийтлэгдэнэ.	-“Гэрээний баталгаажсан (депозитарийн нотолсон) эхийн (талуудын албан ёсны хэл дээрх) хуулбар гадаад харилцааны яаманд хадгалагдах”-аар тусгагдсан байна. ⁹⁶
8.	Герман	<p>Германд хуулиудыг тухайн асуудлыг хариуцсан яам буюу тэдгээрийн харьяа газруудын хэлний үйлчилгээ эрхэлсэн нэгж нь хэн нэгэнтэй (ихэвчлэн профессор, доктор) хамтарч бусад хэл рүү хөрвүүлдэг юм байна. Жишээ нь: <i>Германы Үндсэн хуулийг Германы Бүндэстайгийн гадаад хэлний албатай хамтран професор Кристьян Томушат, професор Доналд Кюри нар⁹⁷, Эмийн бүтээгдэхүүний тухай хуулийг Холбооны эрүүл мэндийн, харин Төсвийн тухай хуулийг Холбооны сангийн яамны гадаад хэлний алба тус тус ангил хэлнээ хөрвүүлжээ.</i></p> <p>-Харин зарим нэр томъёог Холбооны гадаад харилцааны яам дэлхийн 30 шахам хэл рүү хөрвүүлсэн⁹⁸ байна. Үүнд азиас хятад, япон, солонгос (Өмнөд болон Хойд Солонгосын) гэсэн зүүн азийн 4 хэл, мөн араб, ховрой гэсэн нийт 6 хэл багтсан байна.</p> <p>Эрхзүйн актын орчуулга хөрвүүлэлтийн талаар тодруулга: НҮБ-ын албан ёсны хэл нь араб, хятад, англи, франц, орос, испани гэсэн 6 хэл бөгөөд англи, франц хоёр хэлийг ажлын хэлээр ашигладаг⁹⁹. НҮБ-ын ЕНБД-ын Тамгын газар луу дээрх 2 ажлын хэлийн аль нэгээр хандах ба харин ЕНБД-ын ТГ-аас гарч буй бүх албан ёсны мэдээлэл дээрх 2 хэлээр нэгэн зэрэг гарч байдаг. -НҮБ дэх Герман хэлний орчуулгын алба¹⁰⁰ нь хамгийн чухал бичиг баримтуудыг маш ахар хугацаанд герман руу орчуулж байдаг. Тус албыг Герман, Австри, Швейцар, Лихтенштейн болон Белеи гэсэн 5 улс хамтран санхүүжүүлдэг байна¹².</p>		

⁹⁵ Харьцуулсан тодруулга

Олон улсын гэрээг нийтлэх, түүний хүчин төгөлдөр болох хугацааг тодорхойлох, гэрээний промультацийн болон албан ёсны орчуулгын асуудал дэлхийн улс орнуудад Олон улсын эрхзүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээгээр зохицуулагддаг.

Олон улсын гэрээ нь гэрээнд заасан, эсхүл хэлэлцээрт оролцсон талуудын тохиролцсон хугацаанд хүчин төгөлдөр болдог тул гэрээнд ийм заалт байхгүй, эсхүл талууд энэ талаар тусгайлсан тохиролцоогүй бол Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венцийн 1969 оны Конвенцийн 24 дүгээр зүйлд зааснаар гэрээнд оролцогч улс орон бүр гэрээг заавал даган биелүүлэхийг хүлээн зөвшөөрснөө илэрхийлсэн тохиолдолд гэрээ хүчин төгөлдөр болно.

Олон улсын гэрээг байгуулсан, эсхүл түүнд нэгдэн орсон улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болох журмыг гэрээнд тусгайлан заасан байвал олон улсын гэрээг өөрөө хүчин төгөлдөр болсон хэдий ч тухайн улс орны хувьд зөвхөн энэ журмын дагуу хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 -д “Монгол Улсын Их Хурлаар соёрхон баталсан олон улсын гэрээг нийтлэхдээ Монгол Улсын хууль нийтлэх журам, олон улсын бусад гэрээг нийтлэхдээ Засгийн газрын тогтоол нийтлэх журмыг тус тус баримтлана” гэж тус тус заасан нь бий. Монгол Улсын Олон улсын гэрээний 25 дугаар зүйлийн 2-т “олон улсын гэрээг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрхлэн тусгай эмхтгэл болгон хэвлэнэ” гэж заасан. Гадаад хэргийн яамнаас олон улсын гэрээг албан ёсоор орчуулсан хэийг “Төрийн мэдээлэл” сэтгүүлд хэвлэн нийтэлснийг “олон улсын гэрээний албан ёсны нийтлэл” гэж үзнэ.

Улсын Дээд Шүүхийн хууль тайлбарласан тогтоол (2008, №09) –д “Гадаад хэргийн яамны гэрээ, эрх зүйн газар, Монгол Улсын олон улсын гэрээний албан ёсны орчуулга, гэрээний жагсаалт, тэдгээрийн хүчинтэй байх хугацаа, хүчин төгөлдөр болсон хугацаа, Монгол Улсын нэгдэн орсон хугацаа, албан ёсоор хэвлэн нийтлэгдсэн байдал зэрэг асуудлаар” (шаардлагаатай тохиолдолд) албан ёсны мэдээлэл гаргана; гэж үүрэгжүүлсэн байдаг.

⁹⁶ Олон улсын гэрээний тухай Казахстан улсын хууль (2005, № 54-III) –ийн 5 дугаар зүйлийн 6- хэсэг:

⁹⁷ Basic Law for the Federal Republic of Germany http://www.gesetze-im-internet.de/englisch_gg/

⁹⁸ Terminologie http://www.auswaertiges-amt.de/DE/Infoservice/Terminologie/Uebersicht_node.html

⁹⁹ UN-Sprachen-repmanaar <http://www.lexas.net/sprachen/un-sprachen.asp>

¹⁰⁰ Deutsche Bbersetzungsdienst-repmanaar <http://www.un.org/Depts/german/>

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Федеральный закон «О порядке опубликования и вступления в силу федеральных конституционных законов, федеральных законов, актов палат Федерального Собрания». www.pravo.gov.ru
- Закон Молдовы “О порядке опубликования и вступления в силу официальных актов”. <http://base.spinform.ru>
- The constitution of Finland and parliament's rules of procedure https://www.eduskunta.fi/FI/tietoaeduskunnasta/julkaisut/Documents/ekj_3+2013.pdf -
- Constitution of Finland - https://www.constituteproject.org/search?lang=en&compare=Finland_2011
- Act on The Statutes of Finland (188/2000) - <http://www.finlex.fi/en/laki/kaannokset/2000/en20000188.pdf>
- Statutory Instruments Act R.S.C., 1985, c. S-22 - <http://laws-lois.justice.gc.ca/eng/acts/S-22/>
- Олон улсын гэрээ хэлэлцээрийг бүртгэх, нийтлэх тухай олон улсын эрх зүйн акт <http://www.legalinfo.mn/law/details/1214>
- Rechtsinformationssystem des Bundes-германаар
- Федеральный закон «О порядке опубликования и вступления в силу федеральных конституционных законов, федеральных законов, актов палат Федерального Собрания». www.pravo.gov.ru
- Закон Молдовы “О порядке опубликования и вступления в силу официальных актов”. <http://base.spinform.ru>
- Singapore Attorney-General's Chamber, Legislative division
- The e-Publication Group is responsible for maintaining the Legislation Editing and Authentic Publishing System Versioned Legislation Database (LEAP-VLDB) and the Singapore Statutes Online website to ensure 24/7 online public access to Singapore's written laws.
- https://www.agc.gov.sg/What_We_Do/Legislation_Division/Legislation_Division.aspx
- The constitution of Finland and parliament's rules of procedure - https://www.eduskunta.fi/FI/tietoaeduskunnasta/julkaisut/Documents/ekj_3+2013.pdf
- Act on The Statutes of Finland (188/2000) <http://www.finlex.fi/en/laki/kaannokset/2000/en20000188>.
- Statutory Instruments Act R.S.C., 1985, c. S-22 - <http://laws-lois.justice.gc.ca/eng/acts/S-22/>
- https://www.constituteproject.org/constitution/Bulgaria_2007?lang=en
- <http://www.parliament.bg/en/rulesoftheorganisations>
- http://www.srbija.gov.rs/cinjenice_o_srbiji/ustav.php?change_lang=en
- <http://www.parlament.gov.rs/national-assembly/important-documents/rules-of-procedure-%28consolidated-text%29/entire-document---rules-of-procedure.1424.html>
- <http://statutes.agc.gov.sg/aol/search/display/view.w3p;page=0;query=DocId%3A%22cf2412ff-fca5-4a64-a8ef-b95b8987728e%22%20Status%3Ainforce%20Depth%3A0;rec=0;whole=yes>

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ДЭГИЙГ ТОГТООДОГ ЭРХ ЗҮЙН АКТЫН ЛАВЛАГАА

*Ц.Болормаа, О.Нарантуяа, Б.Нандингэрэл
И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл,
Ч.Онончимэг, Д.Халиун, А.Пагма*

Судалгаанд нийт гадаадын 56 орны парламентын дэгийг тогтоодог эрх зүйн зохицуулалтыг судалснаас парламентын дэгийг хуулиар тогтоодог 14, тогтоолоор тогтоодог 41 орон байна. Дэлгэрэнгүйг доорх хүснэгтээс үзнэ үү.

№	Улсын нэр	Эрх зүйн акт	Эрх зүйн актын нэр, эх сурвалж
1	Австри	Хууль	Federal law on the rules of procedure of the Austrian national council. Rules of procedure law of 1975 https://www.parlament.gv.at/engl/perk/rges/gognr/index.shtml
2	Австрали	Тогтоол	House of representatives standing orders 2015 http://www.aph.gov.au/about_parliament/house_of_representatives/powers_practice_and_procedure/house_of_representatives_standing_orders
3	Англи	Тогтоол	Standing orders of the house of commons - Public business 1998 http://www.publications.parliament.uk/pa/cm199798/cmstords/1mpubbs.htm Standing orders of the house of commons - Private business 2001 http://www.publications.parliament.uk/pa/cm200102/cmstords/pubbs01.htm
4	Америк	Тогтоол	Rules of the house of representatives Of the united states 112th congress 2015 http://www.house.gov/content/learn/ Standing rules of the senate 2013 http://www.rules.senate.gov/public/index.cfm?P=rulesofsenatehome
5	Бангладеш	Тогтоол	Rules of procedure of parliament of the peoples's republic of bangladesh http://www.parliament.gov.bd/index.php/en/parliamentary-business/procedure/rules-of-procedure-english
6	Болгар	Тогтоол	Rules of organisation and procedure of the national assembly http://www.parliament.bg/en/rulesoftheorganisations
7	Босни Герцеговин	Тогтоол	Rules of procedure of the house of representatives of the parliamentary assembly of bosnia and herzegovina 2006 http://www.oscebih.org/download.aspx?Id=68&lang=en
8	Ботсван	Тогтоол	Standing orders of the national parliament http://www.pacii.org/pg/parliament/parliamentary%20standing%20orders.htm
9	Бельги	Тогтоол	The rules of procedure of the Belgian house of representatives 2010 http://www.parliament.am/library/kanonakarger/belgia.pdf
10	Герман	Тогтоол	"Geschftsordnung des deutschen bundestages" https://www.bundestag.de/bundestag/aufgaben/rechtsgrundlagen/go_btg
11	Гүрж	Хууль	Закон о парламенте парламента Грузии от 22 июня 2012г. Parliament.am
12	Грек	Тогтоол	Standing orders of the Hellenic parliament http://www.hellenicparliament.gr/en/vouli-ton-ellinon/kanonismos-tis-voulis/
13	Дани	Тогтоол	Standing orders of the Danish parliament http://www.thedanishparliament.dk/publications/standing%20orders%20of%20the%20folketing.aspx?Page=all
14	Доминика	Тогтоол	Standing orders of the house of assembly http://www.assembly.nl.ca/business/standingorders/standing_orders.pdf
15	Ирак	Хууль	Rules of procedure of the assembly- http://assembly.coe.int/nw/xml/rop/rop-xml2html-en.asp
16	Ирланд	Тогтоол	Standing orders of the northern Ireland assembly http://www.niassembly.gov.uk/assembly-business/standing-orders/standing-orders/ http://www.oireachtas.ie/documents/proceduraldocuments/standing-orders-english.pdf

17	Итали	Депутатын дэгийн тухай журам	"Депутатын танхимын дэгийн тухай журам" 1922 батлагдаж, 1971, 1999, 2001, 2012 онуудад нэмэлт өөрчлөлт орсон. Http://en.camera.it/4?Scheda_informazioni=31
18	Канад	Тогтоол	Standing orders of the house of commons Http://www.parl.gc.ca/about/house/standingorders/toc-e.htm
19	Кыргызстан	Хууль	Закон Кыргызской республики. г.Бишкек, от 25 ноября 2011 года п 223. О регламенте Жогорку Кенеша Кыргызской республики Http://www.kenesh.kg/ru/articles/1099-reglament.aspx
20	Казахстан	Тогтоол	Регламент парламента республики Казахстан. Постановление парламента Республики казахстан от 20 мая 1996 года Http://www.parlam.kz/ru/regulation
21	Латви	Хууль	Закон о регламенте Сейма. 28 июля 1994 г. Pravo.lv
22	Литви	Хууль	Statute of the seimas of the republic of lithuania 1994 www.lrs.lt/pls/inter2/dokpaieska.showdoc_e?P_id=492370
23	Маврикий	Тогтоол	Standing orders and rules of the national assembly 1995 онд батлагдсан, 2008 онд нэмэлт өөрчлөлт, www.mauritiussassembly.govmu.org
24	Мальт	Тогтоол	Standing orders of the house of representatives 1964, www.parliament.mt
25	Македон	Тогтоол	Rules of procedure of the assembly of the republic of macedonia Www.parliament.am
26	Микронез	Тогтоол	Official rules of procedure of congress of the federated states of Micronesia Www.publicofficialsfinancialdisclosure.worldbank.org
27	Молдав	Хууль	Закон республики Молдова От 2 апреля 1996 года №797-xiii О принятии регламента парламента. Http://base.spinform.ru/show_doc.fwx?Rgn=3271
28	Нидерланд	Тогтоол	House of representatives of the Netherlands-rules of procedure 1994, www.houseofrepresentatives.nl
29	Норвеги	Тогтоол	The norwegian parliament rules of procedure and the constitution 2001, www.stortinget.no
30	ОХУ	Тогтоол	О регламенте государственной Думы федерального собрания российской федерации. Постановление от 22 января 1998 г. N 2134- гд. Http://www.consultant.ru/law/review/lawmaking/reglduma/
31	Өмнөд Африкийн БНУ	Тогтоол	Rules of the national assembly-2008 Http://www.parliament.gov.za/content/na%20rules%202014.pdf
32	Пакистан	Тогтоол	Rules of procedure and conduct of business in the national assembly-2007 Http://www.na.gov.pk/uploads/publications/rules_procedure.pdf
33	Португал	Тогтоол	Rules of procedure of the assembly of the republic-2010 Http://www.en.parlamento.pt/legislation/rules_of_procedure.pdf
34	Польш	Тогтоол	The standing orders of the sejm of the republic of poland Http://oide.sejm.gov.pl/oide/images/files/dokumenty/standing_orders_2009.pdf
35	Сингапур	Тогтоол	Standing orders of the parliament of singapore-2010 Http://www.parliament.gov.sg/sites/default/files/standing%20orders%20%282010%29.pdf
36	Серби	Тогтоол	Rules of procedure of the national assembly-2010 Http://www.parlament.gov.rs/upload/documents/06.06.2014.%20eng%20rules%20of%20procedure%20edit%202014.pdf
37	Словак	Хууль	Act of the national council of the slovak republic no. 350/1996 on rules of procedure http://www1.worldbank.org/publicsector/civilservice/epublishdocs/immunity/legislation/slovakiaactnationalcouncil_on_rules_of_procedure.pdf
38	Словени	Тогтоол	Rules of procedure of the national assembly-2002 Https://www.dz-rs.si/wps/portal/en/home/odrzavnemzboru/pristojnostifunkcije/rulesoftheproceduretext

39	Солонгос	Хууль	National assembly act-2014 Http://korea.na.go.kr/res/low_02_read.jsp?Boardid=1000000036
40	Турк	Тогтоол	Rules of procedure of the grand national assembly of turkey september 1, 1973. Https://global.tbmm.gov.tr/docs/rules_of_procedure_en.pdf
41	Унгар	Тогтоол	Resolution 10/2014. (ii. 24.) Ogy On certain provisions of the rules of procedure Http://www.parlament.hu/documents/125505/138409/resolution+on+certain+provisions+of+the+rules+of+procedure/968f2e08-f740-4241-a87b-28e6dc390407
42	Узбекстан	Хууль	Закон республики узбекистан «о регламенте законодательной палаты олий мажлиса республики узбекистан». принят 29.08.2003 г. Http://www.parliament.gov.uz/ru/regulations.php
43	Украин	Хууль	Закон україни про регламент верховноу ради україни (відомості верховноу ради україни (ввр), 2010, № 14-15, № 16-17, ст.133) Http://zakon2.rada.gov.ua/laws/show/1861-17
44	Франц	Тогтоол	Rules of procedure of the national assembly January 2007 http://www.legislationline.org/download/action/download/id/2084/file/france_rules_procedure_nationalassembly_2007htm/preview
45	Финланд	Тогтоол	Parliament's rules of procedure 17 december 1999 (40/2000) Www.legislationline.org/documents/id/15070
46	Хорват	Тогтоол	Standing orders of the croatian parliament http://www.legislationline.org/download/action/download/id/2056/file/croatia_standingordershtm/preview
47	Чех	Хууль	Rules of procedure of the chamber of deputies Http://www.psp.cz/en/docs/laws/1995/90.html#s1
48	Чрна гора	Тогтоол	Rules of procedure of the parliament of montenegro december http://www.parliament.am/library/kanonakarger/montenegro.pdf
49	Швейцар	Хууль	The riksdag act Http://host.uniroma3.it/progetti/cedir/cedir/lex-doc/sv_riks-act.pdf Http://www.riksdagen.se/en/how-the-riksdag-works/democracy/the-constitution/the-riksdag-act---almost-a-fundamental-law/
50	Швед	Тогтоол	Standing orders of the council of states (status as of 1 june 2015) Https://www.admin.ch/opc/en/classified-compilation/20030743/index.html
51	Шинэ зеланд	Тогтоол	Standing orders of the house of representatives. 2014.08.15 Http://www.parliament.nz/resource/en-nz/00hohp/preferences/orders4/eb7c8b9e4a6c7aa88a47d14dc4100513b2557e60
52	Энэтхэг	Тогтоол	Дээд танхим: rules of procedure and conduct of business in lok sabha. 2014 он. 15 дахь хэвлэл Http://164.100.47.192/loksabha/rules/rules-2010-p-final_1.pdf
53	Эстони	Хууль	Закон о регламенте и порядке работы рийгикору. Принят 11 февраля 2003 г. Http://www.skylaser.ee/
54	Этиоп	Тогтоол	The house of peoples representatives regulation no. 3/1998 "the house of peoples representatives of the federal democratic republic of ethiopia rules of procedures and members code of conduct regulation Https://chilot.files.wordpress.com/2012/09/house-of-peoples-representatives-rules-and-code-of-conduct-regulation.pdf
55	Япон	Тогтоол	Дээд танхим: the rules of the house of councillors http://www.sangiin.go.jp/eng/law/rothoc/index.htm

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

3

БҮЛЭГ

ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ САЛБАР

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ УУЛ УУРХАЙН БАЯЛГИЙН САНГИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА

О.Нарантуяа, Б.Нандингэрэл
Ч.Онончимээ

Судалгааны нэгдүгээр хэсэгт эрсдэлийн сангуудын тухай ойлголт, төрөл хэлбэрүүд болон одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн баялгийн сангуудын статистик мэдээлэл, хоёрдугаар хэсэгт уул уурхайн салбарт баялгийн санг амжилттай хэрэгжүүлсэн Норвеги, Канад, Австрали, Чили, Азербайжан зэрэг орнуудыг сонгон авч тухайн улсын уул уурхайн салбарыг хөгжүүлэхэд баримталсан төрийн бодлого, баялгийн сангийн зохицуулалт, ашиглалт болон түүний зөв зохистой зарцуулалтын талаар авч үзлээ.

Нэг. ЭРСДЭЛИЙН САНГУУДЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ, ХЭЛБЭРҮҮД:

Баялгийг хүн бүрт тэгш хуваарилахдаа бэлэн мөнгөөр бус ногдол ашиг хуваарилах хуримтлалын сан хэлбэрээр шийдэх нь цаашдаа хүн амын орлого хэлбэртгүй дээшлэх сайн талтай юм.

Эрсдэлийн сангийн төрөл хэлбэрүүдийг судлаачид дараах байдлаар авч үзсэн байдаг. Үүнд:

- Тогтворжилтын;
- Хадгаламжийн;
- Хөрөнгө оруулалтын;
- Бусад гэсэн дөрвөн үндсэн төрөлд хувааж болохоор байна.

Одоогоор эдгээр сангуудыг тодорхойлсон тодорхойлолт, шалгуур үзүүлэлтүүд байхгүй ч **Тогтворжилтын сан** гэдгийг засгийн газрын орлого, зарлагыг тогтвортой байлгах зорилгоор байгуулсан, үйл ажиллагааны тодорхой дүрэмтэй тусгай мөнгөн сан гэж үзэх ойлголт давамгайлж байна. Ийм тогтворжилтын сангууд нь улс орны эдийн засгийг тогтворжуулах болон засгийн газрын татварын орлогын хэлбэлзэлийг тогтворжуулах гэсэн хоёр гол үүргийг хэрэгжүүлдэг байна.

Тогтворжилтын сангууд тогтоосон тодорхой дүрмийн дагуу бүрдэж, зарцуулалт нь хуулийн дагуу, төрийн эрх барих дээд байгууллагын хяналтын доор хэрэгждэг байна. Ийм сангуудыг байгуулсан төр, засгийн өндөр эрх мэдэл бүхий албан тушаалтнуудаас бүрдсэн удирдах зөвлөл ерөнхий удирдлагаар хангаж, орон тооны аппарат бүхий сангийн удирдлага өдөр тутмын ажлыг эрхэлдэг байна.

Тогтворжилтын сан байгуулсан ихэнх орнуудад санг бүрдүүлэгч орлогын эх үүсвэр нь нефть болон зэс зэрэг эрдэс баялаг, хөдөө аж ахуйн түүхий эд борлуулсны орлого зонхилж, тэдгээрийн дэлхийн зах зээлийн үнэ урьдчилан тогтоосон дээд түвшингээс дээш гарсан тохиолдолд зөрүүг нь санд төвлөрүүлэх, хэрэв тогтоосон доод түвшнээс буурсан тохиолдолд сангаас гарган зарцуулах нийтлэг зарчмыг удирдлага болгож байна. Эрдсийн сангийн хатуу журамтай зарим нэг орон эрдэс баялгаас орсон хямд мөнгөний үндэсний эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах зорилгоор сангийн мөнгийг тухайн орны нутаг дэвсгэр, хуулийн үйлчлэх хүрээнд байлгахыг хориглож, удирдлагыг гадны мэргэжлийн байгууллагуудад шилжүүлэх хүртэл арга хэмжээ авдаг байна.

Зориулалт, үйлчилж байгаа салбар зэргээс нь хамааруулан тогтворжилтын санг хөдөө аж ахуйн, эрдэс баялгийн, санхүүгийн, худалдааны, валютын ханшны тогтворжилтын гэх мэтээр хуваан үзэж болохоор байна. Хөгжиж байгаа олон оронд хөдөө аж ахуйн тодорхой нэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тогтворжуулахаар сангууд байгуулсан жишээ түгээмэл байна.

Энэтхэгт цай, кофены, өмнөд америкийн орнуудад кофе, каучикийн тогтворжилтын сангууд байдаг байна. Чилид байгуулсан зэсийн тогтворжилтын сан сайн удирдлагатай, амжилттай ажилладаг сангийн нэг гэж дэлхий нийтэд үзэгддэг байна.

Хадгаламжийн сангууд тогтворжилтын сантай төстэй боловч санд мөнгө хуримтлуулах, сангаас санхүүжилт хийх зарчим нь өөр байдаг. Тогтворжилтын сангаас ялгагдах гол онцлог нь нефть, эрдэс баялгийн дэлхийн зах зээлийн үнийн өөрчлөлттэй сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг холбодоггүй, голдуу нийт борлуулалтын орлогын юмуу төсвийн орлогын тодорхой хувийг санд төвлөрүүлдэг. Хадгаламжийн сангууд нь ихэвчлэн гадаад орнуудад байршиж өндөр зэрэглэлийн мөнгө, санхүүгийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалтын хэлбэрээр хадгалагдаж байдаг байна.

Хадгаламжийн сангийн удирдлагад тавих шаардлага, сангаас хөрөнгө оруулалт хийх болзол, нөхцөл бусад сангуудынхыг бодвол ихээхэн хатуу бөгөөд олонх тохиолдолд энэ сангийн удирдлагыг гадны мэргэжлийн байгууллагад гэрээлэн шилжүүлдэг байна.

Өндөр хөгжилтэй орнуудад голдуу байгуулан ажиллуулж ирсэн **Хөрөнгө оруулалтын сангууд** нь нефть зэрэг эрдэс материал, хөдөө аж ахуйн түүхий эдтэй үндсэндээ холбоогүй тухайн орнуудын эдийн засагт бий болсон мөнгө, санхүүгийн асар их хуримтлалыг ухаалгаар байршуулан ажиллуулж байгаа зах зээлийн үеийн эдийн засгийн удирдлагын ердийн нэг арга хэрэгсэл юм. Иймээс ч санг бүрдүүлж зарцуулах журам нь орон бүрт адилгүй өөр өөрийн онцлогтой. Эдгээр сангуудын зарцуулалт, байршуулалт нь өргөн хүрээтэй, ихэнх тохиолдолд засгийн газрын төсвийн нэг хэсэг болж гадаад дотоодод томоохон хөрөнгө оруулалт, төслүүдийг хэрэгжүүлэхэд зориулагддаг байна.

Ийм эрдсийн бус хөрөнгө оруулалтын сангуудыг гадаад валютын нөөц ихээр хуримтлуулсан Сингапур, Хонг Конг, Өмнөд Солонгос мэтийн Азийн өндөр хөгжилтэй орнууд голлон байгуулж бүс нутагтаа болон дэлхийн орнуудад том хэмжээний төсөл хөтөлбөр хэрэгжүүлж хөрөнгө оруулахад зарцуулж байна.

Буурай хөгжилтэй зарим нэг орнууд байгалийн болон дэлхийн зах зээлийн сөрөг нөлөөллөөс эдийн засаг, экспортоо хамгаалах зорилгоор цэвэр гадны тусламжаас бүрдсэн тусгай сан байгуулан ажиллуулж амжилтад хүрч байгаа туршлага ч мөн байдаг байна. Гадны хөрөнгө санхүүжилтээр байгуулагдсан эдгээр сангууд нь тухайн орны засгийн газар, хандивлагч орнуудын хооронд тохирсон зарчим, зорилгын дагуу зарцуулагдаж, сангийн удирдлагыг эдгээр орноос бүрдсэн олон улсын удирдах зөвлөл хэрэгжүүлдэг байна.

Түүнээс гадна төрийн өмчийг хувьчилснаас олсон орлогын байгалийн баялаг олборлосонтой адил түр зуурын гэнэтийн орлого гэж үзэн тусгай санд төвлөрүүлэн ард түмний хяналтын доор тэдний саналын дагуу зарцуулдаг журам үйлчилдэг туршлага ч мөн байна. Ингэж байгуулагдсан **хувьчлалын сангууд** нь хадгаламжийн болон хөрөнгө оруулалтын сангуудтай нэгэн адил зарчмаар захиран зарцуулагддаг байна.

Одоогоор дэлхийн хэмжээнд 79 сан үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд эдгээрийн 52 нь уул уурхайн баялгаас бүрдэж байна.¹⁰¹

¹⁰¹ <http://www.swfinstitute.org/sovereign-wealth-fund-rankings/>

**Хүснэгт 1. Уул уурхайн орлогоос эх үүсвэр нь бүрддэг баялгийн
сангуудын талаарх лавлагаа**

2015 оны эхний хагас жилийн байдлаар

№	Улс	Сангийн нэр	Хөрөнгийн хэмжээ тэрбум.ам долл	Бий болсон он	Эх үүсвэр	Лина- Мэдуэллийн ил тод байдлын индекс
1	Норвеги	Тэтгэвэрийн сан Government Pension Fund- Global	873	1990	Газрын тос	10
2	АНЭ- Абу Даби	Абу Даби Хөрөнгө оруулалтын сан Abu Dhabi Investment Authority	773	1976	Газрын тос	6
3	Саудын Араб	SAMA Foreign Holdings	671.8	-	Газрын тос	4
4	Кувейт	Kuwait Investment Authority	592	1953	Газрын тос	6
5	Катар	Qatar Investment Authority	256	2005	Газрын тос Байгалийн хий	5
6	АНЭ- Абу Даби	Abu Dhabi Investment Council	110	2007	Газрын тос	-
7	Казахстан	Kazakhstan National Fund	77	2000	Газрын тос	2
8	ОХУ	Reserve Fund	76.8	2008	Газрын тос	5
9	ОХУ	National Welfare Fund	75.7	2008	Газрын тос	5
10	АНЭмират- Абу Даби	International Petroleum Investment Company	66.3	1984	Газрын тос	9
11	АНЭмират- Абу Даби	Mubadala Development Company	66.3	2002	Газрын тос	10
12	Ливи	Libyan Investment Authority	66	2006	Газрын тос	1
13	Иран	National Development Fund of Iran	62	2011	Газрын тос Байгалийн хий	5
14	АНУ-Аляска	Alaska Permanent Fund	53.9	1976	Газрын тос	10
15	Алжир	Revenue Regulation Fund	50	2000	Газрын тос Байгалийн хий	1
16	Бруней	Brunei Investment Agency	40	1983	Газрын тос	1
17	АНУ-Техас	Texas Permanent School Fund	37.7	1854	Газрын тос бусад	9
18	Азербайжан	<u>State Oil Fund</u>	37.3	1999	Газрын тос	10

19	АНУ-Нью Мексико	New Mexico State Investment Council	19.8	1958	Газрын тос Байгалийн хий	9
20	Канад	Alberta's Heritage Fund	17.5	1976	Газрын тос	9
21	АНУ-Техас	Permanent University Fund	17.2	1876	Газрын тос Байгалийн хий	-
22	Зүүн Тимор	Timor-Leste Petroleum Fund	16.9	2005	Газрын тос Байгалийн хий	8
23	Чили	Social and Economic Stabilization Fund	15.2	2007	Зэс	10
24	АНЭУ	Emirates Investment Authority	15	2007	Газрын тос	3
25	Оман	State General Reserve Fund	13	1980	Газрын тос Байгалийн хий	4
26	Чили	Pension Reserve Fund	7.9	2006	Зэс	10
27	Мексик	Oil Revenues Stabilization Fund of Mexico	6.0	2000	Газрын тос	4
28	Оман	Oman Investment Fund	6.0	2006	Газрын тос	4
29	Ботсвана	Pula Fund	5.7	1994	Алмаз болон бусад ашигт малтмал	6
30	АНУ- Ваойминг	Permanent Wyoming Mineral Trust Fund	5.6	1974	Ашигт малтмал	9
31	Тринадад ба Тобаго	Heritage and Stabilization Fund	5.5	2000	Газрын тос	8
32	Саудын Араб	Public Investment Fund	5.3	2008	Газрын тос	4
33	Ангол	Fundo Soberano de Angola	5.0	2012	Газрын тос	8
34	АНУ-Хойд Дакото	North Dakota Legacy Fund	3.2	2011	Газрын тос Байгалийн хий	-
35	АНУ-Алабама	Alabama Trust Fund	2.5	1985	Байгалийн хий	9
36	Казахстан	National Investment Corporation	2	2012	Газрын тос	-
37	Нигери	Nigerian Sovereign Investment Authority	1.4	2012	Газрын тос	9
38	АНУ- Луизиана	Louisiana Education Quality Trust Fund	1.3	1986	Газрын тос Байгалийн хий	-
39	Арабын Нэгдсэн Эмират- Рас аль Хайма	RAK Investment Authority	1.2	2005	Газрын тос	3
40	Ирак	Development Fund for Iraq	0.9	2003	Газрын тос	-
41	Венесуэл	FEM	0.8	1998	Газрын тос	1
42	Кирибати	Revenue Equalization Reserve Fund	0.6	1956	Фосфорит	1

43	Габон	Gabon Sovereign Wealth Fund	0.4	1998	Газрын тос	-
44	Гана	Ghana Petroleum Funds	0.45	2011	Газрын тос	-
45	Мавритани	National Fund for Hydrocarbon Reserves	0.3	2006	Газрын тос Байгалийн хий	1
46	Австарли	Western Australian Future Fund	0.3	2012	Ашигт малтмал	-
47	Монгол	Fiscal Stability Fund	0.3	2011	Ашигт малтмал	-
48	Экваторын Гвиней	Fund for Future Generations	0.08	2002	Газрын тос	-
49	Папуа шинэ Гвиней	Papua New Guinea Sovereign Wealth Fund	-	2011	Байгалийн хий	-
50	Туркменистан	Turkmenstan Stabilization Fund	-	2008	Газрын тос Байгалийн хий	-
51	АНУ-Баруун Виржиниа	West Virginia Future Fund	-	2014	Газрын тос Байгалийн хий	-
52	Мексик	Fondo Mexicano del Petroleo	-	2014	Газрын тос Байгалийн хий	-
		НИЙТ	4 126.5			

Хоёр. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

2.1 НОРВЕГИЙН ТЭТГЭВРИЙН САН

Баялгийн менежментийг хэрэгжүүлсэн сайн жишээнд Норвеги улсын туршлага авч үзсэн бөгөөд Норвеги улсын хувьд байгалийн баялгийг хамгийн зөв зохистой хэрэгжүүлж, дэлхийн хэмжээний томоохон баялгийн санг хөгжүүлж чадсан төдийгүй дэлхийд гуравдугаарт орох газрын тос экспортлогч бөгөөд ямар ч өргүй улс юм.

Норвегийн баялгийн сангийн хувьд:

1990 онд Норвеги улс байгалийн баялгийн зөв зохистой хуваарилалтыг бий болгох Норвегийн нефтийн санг байгуулсан бөгөөд уг сангийн зорилго нь компаниудын татвар, мөн хайгуулын тусгай зөвшөөрөл болон төрийн шууд санхүүжилтийн хүү, төрийн өмчит “State Oil Hydro” компаний ногдол ашгаас үндсэндээ бүрдсэн Норвегийн газрын тосны салбарын илүүдэл их хэмжээний орлогын зарим хэсгийг хөрөнгө оруулахад чиглэгдэж байв.

Нефтийн экспорт өндөр байсан үе буюу 2005 онд экспортын 45 хувийг эзлэж байх үед Норвеги улс сандаа бүтцийн болон зохицуулалтын өөрчлөлт хийж, баялгийн хараалаас сэргийлэх арга хэмжээ авчээ.

2006 оноос Норвегийн нефтийн сангийн нэрийг–Төрийн тэтгэвэрийн сан болгон өөрчилсөн бөгөөд Төрийн тэтгэвэрийн сан-Глобал нь Норвегийн газрын тосны орлогын ашгийн илүүдлээс бүтсэн хадгаламжийн сан юм.

Норвегийн төрийн тэтгэвэрийн сан нь Норвегийн Засгийн газрын эзэмшдэг хоёр тусдаа Үндэсний баялгийн сан /Sovereign Wealth Fund/ болох Төрийн тэтгэвэрийн сан-Глобал /өмнө нь Төрийн нефтийн сан гэдэг байсан/, Төрийн тэтгэвэрийн сан-Норвеги /өмнө нь Үндэсний даатгалын схемийн сан гэдэг байсан/ хоёроос бүрддэг.

Тус санг Норвегийн Төв банкны харьяа Norges Bank Investment Management (NBIM) тусгай нэгжид хариуцуулах бөгөөд Сангийн яамны нэрийн өмнөөс, Сангийн яамны гаргасан зааврын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг байна. Европын хамгийн том тэтгэврийн сан болохын хувьд хэмжээгээрээ АНУ-ын хамгийн том төрийн тэтгэврийн сан болох Калифорнийн төрийн албан хаагчийн тэтгэврийн сантай дүйцэж очино.

Түүнчлэн энэхүү нэгж нь Засгийн газрын урт хугацааны бусад сангуудын менежментийг мөн хариуцдаг. Үүнд гадаад валютын нөөцийн сан, нефтийн даатгалын сан зэрэг орох бөгөөд хамгийн гол нь эдгээр сангийн хөрөнгийг нэг цэгээс төвлөрүүлэн удирдаж, зарцуулалтад хяналт тавьж, урт хугацааны хөрөнгө оруулалтын үр шимийг нэмэгдүүлэх зорилготой юм.

Сангийн хөрөнгийн хувьд 2015 онд 873 тэрбум болсон байна. 1998 оноос эхлэн сангийн хөрөнгийн 40% хүртэлхийг олон улсын хөрөнгийн биржийн зах зээлд байршуулахыг зөвшөөрдөг болжээ. 2007 онд Сангийн яам 60% хүртэл хөрөнгө оруулахаар шийдвэрлэсэн байна. Одоогийн байдлаар нийт хөрөнгө оруулалтын 40 орчим хувийг үнэт цаасны зах зээл оруулсан хөрөнгө оруулалт байх бөгөөд Засгийн газраас сангийн нөөцийг хянахдаа янз бүрийн салбарт болон бүс нутагт хөрөнгө оруулж байна.

Сангийн яам сангийн санхүүгийн үйл ажиллагааг хариуцдаг учраас сангийн хөрөнгө оруулалтын зах зээлд мониторинг хийж, сангийн хөрөнгийн ашиглалтыг тусгай шалгуурын үндсэн дээр үнэлгээ хийдэг.


Норвегийн сангийн нэг онцлог нь иргэний нийгэм, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, парламентын хүрээнд яригдаж тогтсон бүрэн ил тод байдлыг хангасан явдал юм.

2.2 КАНАДЫН АЛЬБЕРТАГИЙН ӨВИЙГ ХАДГАЛАХ САН

Альбертагийн өвийг хадгалах сан нь урт хугацааны хадгаламжийн сан бөгөөд анх дахин сэргээгдэхгүй байгалийн нөөцийн орлогын тодорхой хэсгийг хуримтлуулж хойч үедээ өвлүүлэх зорилгоор байгуулагдсан юм.

Альберта сангийн эрх зүйн гол баримт бичиг нь “Альбертагийн өвийг хадгалах сангийн акт” юм. Энэхүү актаар сангийн зорилго, бүтэц, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, эрх зүйн харилцааг зохицуулсан байдаг.

Зураг 1.



“Альбертагийн өвийг хадгалах сан”-г ерөнхийд нь баялгийн сангийн Зөвлөлийн ерөнхийлөгч, Санхүүгийн сайд хоёр удирддаг.

Эдгээрийн удирдлага дор “Баялгийн сангийн зөвлөлийн болон санхүүгийн алба”

“Альбертагийн хөрөнгө оруулалт менежментийн корпораци” ажилладаг.

Баялгийн сангийн зөвлөлийн ерөнхийлөгч, санхүүгийн сайд хоёр нь Альбертагийн сангийн хуримтлалаас оруулсан хөрөнгө оруулалтын урт хугацааны ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтаас үүдэн санхүүгийн алдагдалд орох эрсдлээс сэргийлэх гол үүрэгтэй ажилладаг.

“Альбертагийн өвийг хадгалах сан”-ын бүтцийн нэгжийг тус бүрт нь авч үзвэл:

1. “Баялгийн сангийн зөвлөлийн болон санхүүгийн алба” нь сангийн хөрөнгө оруулалтын бодлого, удирдамжийг боловсруулах, сангийн нягтлан бодох бүртгэл, хөрөнгө оруулалтын талаар тайлагнах, сангийн хөрөнгө оруулалт, эрсдлийн удирдлагад дүн шинжилгээ хийх үүрэгтэй ажилладаг.
2. “Альбертагийн хөрөнгө оруулалт менежментийн корпораци” нь хөрөнгө оруулалтын бодлого, удирдамжид нийцүүлэн сангийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлж, удирдан зохион байгуулах үүрэгтэй. Корпораци нь Канадын Эдмонтонд төвтэй орон нутгийн корпораци бөгөөд хөрөнгө оруулалтын менежментийн удирдлагууд, туршлагатай бизнесменүүдээс бүрдсэн удирдлагын зөвлөлийг удирдан ажилладаг.
3. 3/ Альбертагийн өвийг хадгалах сангийн байнгын хороо нь 9 гишүүнээс бүрдэх бөгөөд Альберта мужийн хууль тогтоох Ассамблейн гишүүд буюу бүх намын төлөөллөөс 6 гишүүн, бие даан сонгогдсон 3 гишүүн байна.

Байнгын хороо нь сангийн жилийн эцсийн тайланд үнэлэлт, дүгнэлт хийх, сангийн эрхэм зорилго биелэж байгаа эсэх талаар тайлагнах үүрэгтэй ажилладаг. Мөн сангийн жилийн эцсийн тайланг байнгын хорооны хурлаар баталдаг. Байнгын хороо нь жил бүр иргэдтэй уулзаж санал солилцдог бөгөөд энэхүү уулзалтыг Альберта мужийн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулдаг.

Анх Альбертагийн сан нь 1976 онд дахин сэргээгдэхгүй байгалийн нөөцийн орлогын 30 хувийг хадгалж үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол 2014-2015 оны сангийн нийт хөрөнгө 17,9 тэрбум доллар, хөрөнгө оруулалтын нийт ашиг 1,825 сая доллар, үүнээс тухайн жилийн зардал 147 сая доллар, инфляцыг тогтворжуулахад 210 сая доллар зарцуулж үлдсэн 1,468 сая долларыг Альбертагийн орлогын санд төвлөрүүлсэн байна. Альбертагийн сан нь төрөлжсөн буюу багц хөрөнгө оруулалтын бодлого баримталдаг бөгөөд үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Хөрөнгө оруулалтын бодлогын хувь

Төрөл	Бодлогын зорилтот хувь	Доод хувь	Дээд хувь
Валют, тогтмол орлого	20%	15%	45%
Валютын зах зээл		0%	25%
Тогтмол орлого		10%	35%
Урт хугацааны бонд		0%	10%
Хувийн үл хөдлөх хөрөнгө		0%	10%
Инфляцын мэдрэмжтэй хөрөнгө оруулалт	30%	15%	40%
Үл хөдлөх хөрөнгө		10%	20%
Дэд бүтэц		5%	15%

Ойн аж ахуй		0%	5%
Богино хугацааны бонд		0%	10%
Хувийн зээл		0%	5%
Үнэт цаас	50%	35%	70%
Канад	8%	5%	15%
Дэлхийн хөгжингүй орнууд	42%	20%	65%
Хөгжиж буй зах зээл		0%	10%
Хилийн зах зээл		0%	5%
Хувийн өмч		0%	10%
Эрсдлийн сан		0%	6%

2.3 АВСТРАЛИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН ИРЭЭДҮЙН САН

Австрали улс нь уул уурхайн үйлдвэрлэлийн 200 гаруй жилийн түүхтэй бөгөөд энэ чиглэлийн хууль эрх зүйн орчныг бүрдүүлээд 150 жил болжээ.

Австралийн муж улсууд нь тус тусдаа “Mineral law” буюу ашигт малтмалын хуультай, эдгээр нь хоорондоо зохицуулалтын нарийн ялгаатай боловч ашигт малтмалын хуулийн үйлчлэх ерөнхий хүрээ нь ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа, түүнтэй шууд хамаатай байгаль орчныг нөхөн сэргээх, хаягдал зайлуулах, тээвэрлэх харилцааг зохицуулахаар хязгаарлагддаг. Ашигт малтмалын болон байгалийн баялгийн хуваарилалтыг дараах хууль тогтоомжуудаар зохицуулж байна. Тухайлбал:

- Австралийн Ашигт малтмалын тухай
- Газрын тосны хууль (Petroleum Law)
- Үндэсний парк, онгон байгалийг хамгаалах тухай хууль
- Нийтийн удирдлага, хяналт, хариуцлагын тухай хууль, 2013¹⁰²
- Нийтийн үйлчилгээний акт
- Ирээдүйн сангийн акт, 2006¹⁰³
- Боловсролын хөрөнгө оруулалтын сангийн акт
- Австралийн бүтээн байгуулалтын сангийн акт, 2008
- Эрүүл мэнд болон эмнэлгийн сангийн акт
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн сангийн акт, 2013
- Анагаахын судалгааны ирээдүйн сангийн акт, 2015

Австралийн Засгийн газрын Ирээдүйн сан /Баялгийн сан-sovereign wealth fund/

- Сангийн зорилго: Австралийн Засгийн газрын ирээдүйн сан нь бие даасан удирдлагатай хөрөнгө оруулалтын сан юм. Ирээдүйн санг 2004 онд Peter Costello-ийн туслалцаатайгаар анх байгуулсан бөгөөд Ирээдүйн сангийн актын дагуу 2006 оны 5 сард 18 тэрбум австрали долларын хөрөнгө оруулж, өөрчлөн байгуулсан. Сангийн зорилго нь төсвөөс санхүүжүүлээгүй хамтын нийгэмлэгийн өндөр насны тэтгэврийн хариуцлагад зориулан нөөц байгуулах замаар Австралийн засгийн газрын урт хугацааны санхүүгийн байдлыг бэхжүүлэх явдал юм.

Энэ нь хүн амын насжилт Австралийн засгийн газрын санхүүд бодитой дарамт үзүүлэх үед өр төлбөр болох юм. Ирээдүйн сан нь тодорхой хэмжээний төсвийн илүүдэл хөрөнгө, Telstra-н үлдэгдэл хувьцааны шилжүүлэг болон Telstra¹⁰⁴-н засгийн газрын эзэмшлийн борлуулалтын орлого зэрэг хэд хэдэн хандив авсан.

¹⁰² Public Governance, Performance and Accountability Act 2013

¹⁰³ Future Fund Act 2006

¹⁰⁴ Австралийн хамгийн том харилцаа холбоо, мэдээллийн технологийн компани

Ирээдүйн сангийн хяналтын зөвлөл нь сангийн хөрөнгөөр хэрхэн хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг гаргадаг. Ирээдүйн сангийн тухай хуульд заасанаар сангийн үлдэгдэл хөрөнгө төлөвлөсөн төвшинг давсан эсвэл хурлын үйл ажиллагаанд зориулсан зардлуудаас бусад тохиолдолд Ирээдүйн сангаас 2020 он хүртэл хөрөнгө гаргахыг зөвшөөрөхгүй байхаар тусгасан.

Сан нь 2020 он гэхэд сангийн хөрөнгийн хэмжээг 140 тэрбум австрали долларт хүргэх зорилготой байгаа бөгөөд холбооны төсвөөс жил бүр өндөр насны тэтгэврийн төлбөрт 7 тэрбум австрали долларын санхүүжилт хийдэг. Сангийн хөрөнгө нь үл хөдлөх хөрөнгө, бараа, таваар, хувьцаа, валют болон бондоос бүрдэх бөгөөд төрийн хяналтанд байдаг. Ирээдүйн сан нь сангийн тусгай данс болон хөрөнгө оруулалтын сангаас бүрдэнэ.

Ирээдүйн сан нь дараах сангуудаас бүрдэнэ.

Зураг 2.



Хүснэгт 3. Сангуудын хөрөнгийн үлдэгдэл

2015 оны 9 сарын 30-ны байдлаар

Сангийн нэрс	Хандив	Орлого	Зарлага	Хэмжээ (австрали доллар)
Ирээдүйн сан	60.5	56.7	0	117.83 тэрбум
Боловсролын хөрөнгө оруулалтын сан	6.5	1.3	4.1	3.69 тэрбум
Бүтээн байгуулалтын сан	10.9	1.8	9.1	3.64 тэрбум
Эрүүл мэнд болон эмнэлэгийн сан	5.0	1.0	4.5	1.5 тэрбум
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн сан	2.5	0	0	2.5 тэрбум
Нийт хэмжээ	85.4	60.8	17.7	128.5

- Үндэсний бүтээн байгуулалтын сан:
2008 оны Үндэсний бүтээн байгуулалтын сангийн актын дагуу байгуулагдсан.
Хөрөнгийн хэмжээ: 3.6 тэрбум австрали доллар.
Сангийн зорилго: Тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч, усны дэд бүтцийн хөгжил, бүтээн байгуулалт болон хэрэгцээтэй үндэсний өргөн зурвастай холбоотой Хамтын нийгэмлэгийн төлбөрийн чадварыг сайжруулахад оршино.
Ирээдүйн сангийн хяналтын зөвлөл нь сангийн хөрөнгөөр хэрхэн хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг гаргадаг. Сангаас гарах төлбөрүүдийг хууль тогтоомжийн дагуу Австралийн дэд бүтцийн зөвлөгөөтэй уялдуулан Засгийн газар тогтооно.

- Боловсролын хөрөнгө оруулалтын сан:
2008 оны Үндэсний бүтээн байгуулалтын сангийн актын дагуу байгуулагдсан.
Хөрөнгийн хэмжээ: 3.69 тэрбум австрали доллар.
Сангийн зорилго: Хамтын нийгэмлэгийн дээд боловсролын бүтцийг бий болгох, эрдэм шинжилгээ судалгааны дэд бүтэц, мэргэжлийн боловсрол болон сургалтын дэд бүтцийг хөгжүүлэх, хэрэгцээт боловсролын дэд бүтэц болон шилжилтийн дээд боловсролын хандивын сангийн төлбөрүүдийг хийх болон төлбөрийн чадварыг дээшлүүлэхэд оршино. Ирээдүйн сангийн хяналтын зөвлөл нь сангийн хөрөнгөөр хэрхэн хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг гаргадаг. Сангаас гарах төлбөрүүдийг хууль тогтоомжуудын хүрээнд Боловсролын хөрөнгө оруулалтын сангийн зөвлөлийн зөвлөгөөтэй уялдуулан Засгийн газар тогтооно. Хууль тогтоомжийн дагуу ТУЗ-ийн зөвлөгөөний дагуу Засгийн газраас тогтоосон төлбөрийг сангаас санхүүжүүлнэ.
- Эрүүл мэнд, эмнэлгийн сан:
2008 оны Үндэсний бүтээн байгуулалтын сангийн актын дагуу байгуулагдсан.
Хөрөнгийн хэмжээ: 1.5 тэрбум австрали доллар
Хамтын нийгэмлэгийн эрүүл мэндийн салбарын дэд бүтцийн хөгжил, бүтээлтэй холбоотой төлбөрийн чадварыг сайжруулах, хөгжүүлэх зорилготой.
Ирээдүйн сангийн хяналтын зөвлөл сангийн хөрөнгөөр хэрхэн хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг гаргадаг. Хууль тогтоомжийн дагуу ТУЗ-ийн зөвлөгөөний дагуу Засгийн газраас тогтоосон төлбөрийг сангаас санхүүжүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн сан¹⁰⁵: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн австралийн сангийн актын дагуу 2013 онд байгуулагдсан.
Хөрөнгийн хэмжээ: 2.5 тэрбум австрали доллар.
Сангийн зорилго нь: Хамтын нөхөрлөлийн орнуудын нутаг дэвсгэр дээр 2013 оны үндэсний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн даатгалд хамруулах тухай хууль болон хуулийн хэрэгжилт, нөхөн төлбөрийг санхүүжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- Анагаахын судалгааны ирээдүйн сан:
Анагаахын судалгааны ирээдүйн сангийн актын дагуу 2015 онд байгуулсан.
Хуулийн зорилго нь: эрүүл мэндийн судалгаа, эрүүл мэндийн инновацийг дэмжих, санхүүгийн туслалцаа, буцалтгүй тусламж үзүүлэх замаар Австралийн эрүүл мэндийн салбарыг сайжруулах явдал юм. Зөвлөл хууль тогтоомж болон хөрөнгө оруулалтын захиран зарцуулах эрхийн хүрээнд хөрөнгө оруулалтын стратегийг хэрэгжүүлнэ. Сангаас гарах тусгай төсөл хөтөлбөр болон санаачилгуудад зориулсан төлбөрүүдийг хууль тогтоомжийн дагуу засгийн газар шийдвэрлэнэ.

Хүснэгт 4. Ирээдүйн сангийн хөрөнгийн хуваарилалт

2015 оны 9 сарын 30-ны байдлаар

Салбар	Хэмжээ \$ million	Сангийн хөрөнгийн хувиар
Австралийн салбарт	7.597	6.4
Дэлхийн хэмжээнд		
Хөгжингүй зах зээл	22.115	18.8
Хөгжиж буй зах зээл	9.266	7.9
Хувийн салбарт	14,115	12.0
Өмч хөрөнгө	7,504	6.4
Дэд бүтэц болон ойн аж ахуй ¹⁰⁶	9,052	7.7
Өрийн бичиг	14,993	12.7
Альтернатив хөрөнгө	15,451	13.1
Бэлэн мөнгө	17,740	15.1
Дүн	117,832	100

¹⁰⁵ The Disability Care Australia Fund


¹⁰⁶ Infrastructure & timberland

Хүснэгт 5. Хөрөнгө оруулалтын хөрөнгийг бүс нутгаар авч үзвэл

Австрали	20%
Америкийн нэгдсэн улс	29%
Европ	14%
Англи	5%
Япон	9%
Хөгжилтэй бусад орнууд	4%
Хөгжиж буй орнууд	20%

Хүснэгт 6. Салбараар авч үзвэл

Эрчим хүч	6%
Эд материал	9%
Аж үйлдвэр	12%
Discretionary	13%
Хэрэглээний түүхий эд	10%
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	10%
Санхүү	23%
Мэдээллийн технологи	12%
Харилцаа холбооны салбар	4%
Бусад	1%

Зураг 3. Сангийн бүтэц, зохион байгуулалт

- *Хяналтын зөвлөл-futur fund board of guardians*

Зөвлөлийн зорилго: Хяналтын зөвлөл нь хууль тогтоомжийн дагуу сангийн хөрөнгийг хэрхэн хөрөнгө оруулах талаар шийдвэр гаргах үүрэгтэй.

Энэхүү үүргээ хэрэгжүүлэхдээ хяналтын зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий менежментийг агентлагаас зөвлөмж, зөвлөгөө авна.

Хяналтын зөвлөл нь засгийн газраас хараат бус байна. Сангийн хуулиар төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус байдлыг хангах зорилгоор сангийн хяналтыг баялгийн сангийн эрхлэгч болон сангийн сайдаар дамжуулан Засгийн газарт олгосон.

Засгийн газар нь Хяналтын зөвлөлийн гишүүдийг томилж, сан тус бүрийн хөрөнгө оруулалтын мандатын байгуулах үүрэгтэй.

Хяналтын зөвлөлийн гишүүд нь хөрөнгө оруулалтын талаар туршлагатай, мэргэжлийн нэр хүнд бүхий, санхүүгийн хөрөнгө эсвэл аж ахуй нэгжийн удирдлагын менежмент эзэмшсэн зэрэг хууль эрх зүйн шаардлагыг хангасан байх ёстой. Хяналтын зөвлөл нь макро эдийн засгийн удирдлага, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх талаар зөвлөгөө өгч оролцохгүй бөгөөд энэхүү асуудлуудад хөрөнгө оруулалтын зорилгын үүднээс зөвхөн анхаарлаа хандуулан ажиллана. Зөвлөл нь хууль тогтоомжид заасны дагуу сангийн жилийн тайланд аудит хийж хариуцлага тооцох арга хэмжээг тусган парламентад өргөн мэдүүлнэ. Мөн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, сангийн гүйцэтгэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг улирлаар гарган өгөх бөгөөд хэвлэл мэдээллээр нийтлэх талаар шийдвэр гаргана.

Мөн менежментийн агентлагтай хамтран хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл /төлөөлөгчдийн ерөнхий бүтэц, цалин хөлс, хүний нөөцийн менежмент/, хүрээлэн буй орчны хяналт /санхүүгийн хяналт, үйл ажиллагааны эрсдлийг оролцуулан/, зохион байгуулалтын зураг төслүүдийн талаар жил бүр тайлан гаргаж өгнө.

Хяналтын зөвлөл нь Баялгийн сангийн олон улсын чуулга уулзалтын хүрээнд баялгийн сангийн засаглал, хариуцлага, ил тод тогтолцоог бий болгох Сантьягогийн зарчмын хэрэгжилтийн талаар жил бүр өөрийн үнэлгээний тайланг гаргаж өгдөг. Хяналтын зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэх хэлбэр нь хуралдаан байх бөгөөд зөвлөлийн дарга хэдийд ч хуралдааныг зарлан хуралдуулж болох бөгөөд хэрэв зөвлөлийн гишүүн санал гаргасан тохиолдолд бичгээр хүсэлт хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор хуралдана. Хяналтын зөвлөл нь аливаа асуудлыг хэлэлцээд олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хэрэв саналын тоо тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналыг харгалзан шийдвэрлэнэ.

Бүтэц зохион байгуулалт: Хяналтын зөвлөл нь дарга, 8 гишүүнээс бүрдэнэ. Зөвлөлийн гишүүдийг хариуцсан сайд нь томилдог бөгөөд санхүүгийн хөрөнгө оруулалтаар мэргэшсэн байдал, компанийн удирдлагын чиглэлээр өндөр дадлага туршлагатай, санхүүгийн хөрөнгө оруулалтын мэдлэг туршлагыг харгалзан сонгодог. Хяналтын зөвлөлийн гишүүд нь 5 жилийн хугацаагаар ажлын хагас өдрөөр ажиллана.

Хяналтын зөвлөл нь дотроо дараах 4 хороотой байна. Үүнд:

- *Цалин хөлс, нэр дэвшүүлэх хороо: дарга, 4 гишүүний бүрэлдэхүүнтэй. Хороо нь зөвлөлд зөвлөх, хөрөнгө оруулагч компанийн орон тоо, ажилтнуудыг албан тушаалд томилох, тэдгээрийн цалин хөлстэй холбоотой асуудлуудыг хариуцдаг.*
- *Зөрчлийн хороо: дарга, 3 гишүүний бүрэлдэхүүнтэй. Тус хороо нь зөвлөл болон зөвлөлийн хорооны гишүүдийн дунд ашиг сонирхлын зөрчил үүсэх асуудлын талаар зөвлөлд зөвлөгөө өгөх болон түүнд хяналт тавина.*

- *Аудит, эрсдлийн хороо: дарга, 8 гишүүний бүрэлдэхүүнтэй. Хороо нь хяналтын хүрээнд гадаад тайлан тооцоо, хууль тогтоомжийн биелэлт, гадаад, дотоод аудит, эрсдлийн менежментийн асуудлыг хариуцдаг.*
- *Гүйлгээний хороо: дарга, 3 гишүүний бүрэлдэхүүнтэй. Зөвлөлийн ямар нэгэн гүйлгээ хийхтэй холбоотой ажилд дэмжлэг тусалцаа үзүүлэн ажилладаг.*

Хууль эрх зүйн үндэслэл: Хяналтын зөвлөл нь 2006 оны Ирээдүйн сангийн актын 4 дүгээр бүлэгт заасны дагуу эрх, үүргээ хэрэгжүүлнэ.

- Менежментийн агентлаг-future fund management agency

Зорилго: Ирээдүйн сангийн Хяналтын зөвлөлд хөрөнгө оруулалтын хамгийн тохиромжтой стратегийг хэрэгжүүлэх, хөгжүүлэх талаар зөвлөмж боловсруулж өгөх, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Сангийн менежментийн агентлаг нь сангийн хөрөнгө оруулалтын хамгийн үр өгөөжтэй стратегийг боловсруулан Хяналтын зөвлөлд өгөх үүрэгтэй бөгөөд стратегийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л удирдлага болон захиргааны ажлыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Агентлаг нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- *Зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах*
- *Зөвлөлд захиргааны үйлчилгээ үзүүлэх*
- *Зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах*
- *Зөвлөлийн үйл ажиллагаанд зөвлөмж, зөвлөгөө өгөх*
- *Зөвлөлд боломжтой нөөц бололцоогоороо туслах*
- *Хуулиар олгосон бусад чиг үүрэг*

Агентлаг нь зөвлөлөөс өгсөн чиглэл, гаргасан бодлогуудын дагуу ажиллах ёстой. Бүтэц, зохион байгуулалт: Дарга, 4 гишүүний бүрэлдэхүүнтэй.

Эрх зүйн зохицуулалт: Ирээдүйн сангийн актын 5 дугаар бүлгээр эрх, үүрэг болон бусад холбогдох асуудлуудыг зохицуулсан. Агентлаг нь 2013 оны олон нийтийн удирдлага, хяналт, хариуцлагын тухай хуулийн дагуу байгуулагдсан бөгөөд ажилтнууд нь нийтийн үйлчилгээний актын дагуу ажилладаг.

2.4 ЧИЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН САН

Чилийн тогтвортой байдлын сан нь Чилийн ард түмний өмч бөгөөд Чили улсын ирээдүйн тогтвортой байдлын баталгаа юм. Иймд уг сангийн хөрөнгийг хамгийн хатуу, ил тод стандартын дагуу удирддаг.

Сангийн зорилго нь зэсийн ханш унасан үед татварын алдагдлыг нөхөх, улсын өр төлбөрийг барагдуулах, бондын баталгаа гаргах зэрэгт зарцуулагдах юм.

Тогтвортой байдлын сангийн эрх зүйн зохицуулалтын гол баримт бичиг нь Чили улсын конгрессоос 2006 онд баталсан “Төсвийн хариуцлагын тухай” хууль юм. Энэ хуулиар сангийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, хөрөнгө оруулалтын тогтолцоо, эрх зүйн харилцааг нарийвчлан зохицуулсан байдаг.

Тогтвортой байдлын сан нь Чилийн сангийн яамны мэдэлд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд

- эдийн засаг, нийгмийн тогтворжуулалтын;
- тэтгэвэрийн гэсэн 2 салбар сантай.

Гэхдээ тэтгэвэрийн нөөцийн сан нь эдийн засаг, нийгмийн байдлыг тогтворжуулах сангийн үндсэн бүрэлдэхүүнд багтаж байдаг боловч тусдаа данс тооцоотой, тусад нь салгаж удирдлагыг хэрэгжүүлж, өгөөжийг нь тооцож байдаг юм байна.

Зураг 4.



- Эдийн засаг, нийгмийн тогтворжуулалтын сангийн эх үүсвэрийг тэнцвэржүүлж тооцсон төсвийн төлөвлөгөөт орлогоос давсан төсвийн бодит бүх илүүдэл орлого ба төсвийн ашиг, олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийсэн үйл ажиллагаанаас олсон нэмэлт орлогоос бүрдүүлдэг.
- Харин тэтгэвэрийн сангийн эх үүсвэрийг эдийн засаг, нийгмийн тогтворжуулалтын сангаас, уг сангийн хөрөнгө хүрэлцэхгүй бол төсөвт тусгах замаар төсвийн санхүүжилтийн хэлбэрээр, эсвэл төв банкнаас засгийн газар зээл авах байдлаар жил бүр наад зах нь ДНБ-ний 0,2 хувьтай тэнцэх хэмжээгээр тооцож уг санд мөнгөн хуримтлалын зузаатгал хийж байхаар хуульчилсан байдаг. Энэ сангийн гол зориулалт нь тэтгэвэрийн санг бүрэн мөнгөжүүлэх, засгийн газраас тэтгэвэрийн доод хэмжээг тогтоож түүнийг хангах урт, дунд хугацааны зорилтыг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц хөрөнгийг бодит мөнгөн хэлбэрээр хуримтлуулан бий болгох зорилготой ажээ.

Тогтвортой байдлын санг Чилийн сангийн сайд толгойлох бөгөөд сайд нь сангийн бодлогыг тодорхойлох, мөн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны менежментийг хариуцах үүрэгтэй ажилладаг.

Сангийн яамны дэргэд санхүүгийн хороо ажиллах бөгөөд хороо нь санхүү эдийн засгийн өндөр мэдлэгтэй, энэ чиглэлээр ажилласан туршлагатай, өндөр нэр хүндтэй гишүүдээс бүрддэг. Санхүүгийн хороо нь тогтвортой байдлын сангийн хөрөнгө оруулалтын стратеги, бодлогын талаар сангийн яаманд зөвөлгөө өгөх үүрэгтэй ажилладаг.

Чилийн төв банк нь засгийн газартай гэрээ байгуулж ажилладаг бөгөөд энэхүү санг бүхэлд нь Төв банкинд засгийн газрын нэрийн тусгай дансанд байршуулдаг. Төв банк нь тус сангийн хөрөнгийг олон улсын санхүүгийн зах зээлд байршуулж нэмэлт мөнгөн хөрөнгө босгох, эрсдлээс хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэдэг.

Тогтвортой байдлын сангийн хөрөнгө оруулалтын зорилго нь эрсдэл багатайгаар хуримтлалаа өсгөх бөгөөд хуримтлагдсан орлогоосоо зөвхөн гадаадад хөрөнгө оруулах бодлого баримталдаг.

Энэ нь 2 шалтгаантай байдаг.

1. Чилийн эдийн засагт инфляцыг хөөрөгдөх, үнэ өсөхөөс зайлсхийх буюу уул уурхайн бус салбарын хамгаалдаг.
2. Улс төрийн дарамтанд орохоос сэргийлдэг.

Эдийн засаг, нийгмийг тогтворжуулах сан, тэтгэвэрийн сангийн хөрөнгө оруулалтын бодлого нь 2013 онд шинэчлэгдсэн бөгөөд хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7. Эдийн засаг, нийгмийн тогтворжуулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлогын хувь

Төрөл	Хувь
Гадаад улсуудын засгийн газрын бонд	55%
Валютын зах зээл	34%
Үнэт цаас	7,5%
Инфляцтай уялдаатай засгийн газрын бонд	3,5%

Хүснэгт 8. Тэтгэвэрийн сангийн хөрөнгө оруулалтын бодлогын хувь

Төрөл	Хувь
Улсын болон засгийн газрын бонд	48%
Корпорацийн бонд	20%
Инфляцыг индексжүүлж тооцсон засгийн газрын бонд	17%
Үнэт цаас	15%

Гадаад валютын хөрөнгө оруулалтын сагсыг тодорхой судалгааны дагуу тодорхойлдог бөгөөд 40% нь америк доллар, 25% евро, 20% иен, 7,5% Швейцар франк эзэлж байна. Ийм арга замаар сангаа арвижуулж, хөрвөлтийн бэлэн байдлыг хангаж, эрсдлээс хамгаалдаг.

2.5 АЗЕРБАЙЖАНЫ ГАЗРЫН ТОСНЫ САН

Азербайжан улс 1999 онд газрын тосноос олсон орлогыг удаан хугацаанд тогтвортой өсөлтийг хангах зорилгоор төрийн мэдлийн газрын тосны санг Ерөнхийлөгчийн зарилгаар байгуулсан байна. Энэхүү сан нь байгалийн баялгийн менежментийг сайжруулах, уул уурхайн олборлох салбарыг төрийн бодлогоор дэмжих, ядуурлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах зорилготой байгуулагджээ.

Сан нь тус улсын төсвөөс гадуур байх бөгөөд Азербайжаны төрийн мэдлийн газрын тосны компанийн бүтээгдэхүүн хуваах гэрээгээр орох орлого, ногдол ашиг, ашиг хуваах гэрээгээр авах ашиг, урамшууллын төлбөрийг хуримтлуулдаг.

Түүнчлэн газар ашигласны төлбөр, нефть дамжуулах хоолойгоор газрын тос тээвэрлэсний хөлс, газрын тос болон байгалийн хий дамжуулах бусад хоолой ашиглалтаас орох төлбөр хураамж, нефтийн сангийн хөрөнгө оруулалтын ашиг зэрэг орлогыг төвлөрүүлдэг. Гэхдээ энэ санд орох орлого газрын тосны зах зээлийн үнийн хэлбэлзэлээс хамаарахгүй тогтсон хэмжээтэй байдаг.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах санаачлагын дагуу Азербайжаны засгийн газар нефтийн сангийн орлого, зарлагын тухай мэдээллийг веб сайтаар дамжуулан олон нийтэд ил тод байлгадаг ажээ.

Уг санд 2004 онд 964 сая ам.доллар, 2005 онд 1.4 тэрбум ам.доллар төвлөрчээ. Энэ сан үйл ажиллагааны зардлаа хаахын сацуу хэд хэдэн чиглэлээр хөрөнгө зарцуулдаг.

Тухайлбал, улсын төсөвт нийлүүлэх, улс орны дотоодод дүрвэгсдийн асуудлыг шийдэх, тэдэнд зориулж хөрөнгө гаргах, нефть дамжуулах хоолойг санхүүжүүлэх, төрийн мэдлийн компанид дүрмийн сан бүрдүүлэх зэрэгт мөнгө зардаг.

Гэхдээ санаас хөрөнгө гаргахдаа улсын нэгдсэн төсвөөр дамжуулан хөрөнгө оруулалтын бодлогод нийцүүлэн гаргана.

Хамгийн хэрэгцээтэй, өндөр ашиг оруулж чадах тэр төсөлд л хөрөнгө гаргахыг зөвшөөрдөг ажээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- http://www.futurefund.gov.au/about_the_future_fund/governance
Австрали улсын Ирээдүйн сангийн цахим хаяг
- <http://www.swfinstitute.org/swfs/future-fund/>
Австрали улсын Ирээдүйн сангийн цахим хаяг
- http://www.futurefund.gov.au/__data/assets/pdf_file/0003/6969/2015_Portfolio_update_to_30_September_2015.pdf /2015 оны 9 сарын 30-ны байдлаар Австрали улсын Ирээдүйн сангийн хөрөнгийн талаарх мэдээлэл/
- Австралийн Ирээдүйн сангийн акт- <https://www.comlaw.gov.au/Details/C2007C00620>
- “Уул уурхайн салбарын бодлогын зарим асуудлууд”. ННФ, 2009 он.
- Natural Resource Funds/Stabilization Funds: International Experience. Mauricio Villafuerte. 2009 он
- www.nationalfund.kz
- www.minfin.ru
- www.miningtopnews.com
- www.regjeringen.no
- Норвегийн төрийн тэтгэврийн сан-Government Pension Fund of Norway
http://en.wikipedia.org/wiki/The_Government_Pension_Fund_of_Norway
- <http://www.swfinstitute.org/sovereign-wealth-fund-rankings/>

МОНГОЛ БОЛОН ГАДААДЫН УЛС ОРНУУДЫН УУЛ УУРХАЙГААС АНГИД БҮС БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ПРАКТИК АЧ ХОЛБОГДОЛ

Ц.Болормаа, Д.Жигваагүнсэл
Д.Халиун, Г.Чулуун

АГУУЛГА

1. Судалгааны тойм
2. Монгол болон гадаадын зарим орны уул уурхайн үйл ажиллагааг хориглох эрх зүйн орчин
 - 1.1. Монгол Улс
 - 1.2. Австрали
 - 1.3. АНУ
 - 1.4. БНХАУ
 - 1.5. Канад
 - 1.6. ОХУ
 - 1.7. Филиппин
3. Ашигласан материал

1. СУДАЛГААНЫ ТОЙМ

Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд иргэдээс ирүүлсэн саналыг судлах хүрээнд УИХ-ын Өргөдлийн байнгын хорооноос “уул уурхайгаас ангид бүс байгуулах”-тай холбоотойгоор Хойд Америк, Ази, Номхон далай, Австрали, Европын нийт 6 орны эрх зүйн орчныг судалсан болно.

Холбооны улс орнуудын хувьд (АНУ, Австрали, Канад) муж улс, нутаг дэвсгэрүүд нь холбооны хуулиудаас гадна уул уурхайн аливаа харилцааг бие даасан эрх зүйн зохицуулалтаар зохицуулж байна. Хамтын нөхөрлөлийн орнууд болох Австрали болон Канадад төрийн эзэмшлийн газрыг Титмийн газар буюу **Crown land** гэж нэрлэдэг бөгөөд хуулиар тогтоосон тодорхой газруудад ашигт малтмалын эрэл хайгуул хийх, уул уурхайн ажил эрхлэхийг хориглосон байна. Филиппин Улсын хувьд уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглосон газруудыг Уул уурхайн тухай хуулиар тогтоосон бөгөөд тус улсын Конгресс нь “Уул уурхайгаас ангид бүс” (*Mining-free zone*)-ийг байгуулах асуудлыг хэлэлцэх шатандаа явж байна. ОХУ-д улсын ба орон нутгийн хэрэгцээнд зориулан газар нөөцлөх асуудал Газрын тухай хуульд тусгагдсан бөгөөд газрын хэвлийг (байгалийн эрдэс баялаг) хожим ашиглах зорилгоор 2–3 жил, зарим тохиолдолд 20 хүртэл жилээр улсын нөөцөд авдаг байна.

АНУ-ын хувьд тодорхой бүс нутагт уул уурхайн аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглосон болон хязгаарласан эрх зүйн орчин бүрдээд 100 гаруй жилийн турш хэрэгжиж байна. Тодорхой газар нутгийг төрийн хамгаалалтад авч уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглох эрх АНУ-ын Ерөнхийлөгч болон Конгресст байна. Тухайлбал, археологийн олдвор бүхий газар нутаг, түүхийн болон балар эртний соёлын байгууламж бүхий газар нутаг, түүхийн болон шинжлэх ухааны ач холбогдолтой объект бүхий байгалийн цогцолбор газрыг Үндэсний Дурсгалт газарт тооцон ерөнхийлөгч тунхаг бичиг гарган хамгаалалтад авна. Энэ харилцааг Antiquities act-аар зохицуулах бөгөөд тус хууль батлагдсанаас хойш нийт 140 орчим газар нутгийг Үндэсний Дурсгалт газарт тооцон, түүх соёлын дурсгал, архелогийн олдвор бүхий 1,05 сая км² газар нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглосон байна.

Нөгөө талаас АНУ-ын муж улсууд болон Холбооны түвшинд Захиргааны хуулиар Холбооны болон Мужийн дархан цаазат газар, ойн сан, гол мөрний сав газар, гол мөрний

үндсэн сүлжээ, усан сан бүхий газар, зэрлэг онгон байгалийн цогцолборт газар, зэрлэг ан амьтад бүхий газарт уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглодог байна.

Монголд уул уурхайн үйлдвэрлэл хөгжихийн хэрээр хайгуул, олборлолт, тээвэрлэлтээс үүдсэн агаар, хөрс, усны бохирдол зэрэг байгаль экологийн тэнцвэр алдагдах явдал түгээмэл гардаг.

Газрын тухай хуульд “бичил уурхайн зориулалтаар олгосон газар” гэсэн заалтыг 2010 оны 7 сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн нь Ашигт малтмалын тухай хуулийн “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг хязгаарлах хориглох...” тухай **заалтуудтай зөрчилдөж, ингэснээр** улсын тусгай хамгаалалттай газарт бичил уурхай нэрээр ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явагдах боломж нээгдсэн .. гэх мэт. Иргэдээс малчдын бэлчээр, усыг хамгаалж, ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг нэмж олгохгүй байх, гар аргаар алт олборлогчдын үйл ажиллагааг зогсоож, байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээ авч өгөхийг уламжлан хүсэх нь их байна.

Мөн сүүлийн үед анхаарлын төв болоод байгаа Ноён уул нь Евроазийн усан сан бүрэлдэх эх, мөнх цэвдэгт ойн сан (Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 6 хувийг эзэлдэг) бөгөөд эндээс Монгол орны хамгийн том мөрөн голууд болох Орхон Сэлэнгийн ай савд багтах 12 гол мөрний урсац бүрэлдэж, улмаар Монгол орны гол мөрний нийт уртын 40 гаруй хувийг эзлэх Сэлэнгэ мөрнөөр дамжин Байгал нуурт цутгаж, нуурын усны 50 хувийг хангадаг. Харин Байгаль нуур нь дэлхийн хамгийн гүн, цэвэр усны хамгийн их нөөцтэй нуур бөгөөд дэлхийн гадаргын цэвэр усны нийт 20% нь Байгаль нуурт байдаг. Ноён уулын бүс нутагт нийт хүрэл зэвсгийн үе, хүннү, дундад зууны үед холбогдох 374 дурсгал одоогоор бүртгэгдээд байна. Ноён ууланд Төрт ёсны 2200 жилийн түүхтэй Хүннү гүрний ихэс, язгууртны ихдээ 300 орчим, нийтдээ 1500 шахам булш бүхий Хүннүгийн язгууртны оршуулгын 7 газар байдгийг 1924 онд анх нээж 90 жилийн турш судалж байна. Ноён ууланд өнөөг хүртэл язгууртны булш 13-ыг малтсанаас эхэн үеийн малтлагаар илэрсэн үнэт чухаг олдворууд нь XX зууны дэлхийн их нээлт хэмээн зарлагдаж, ОХУ-ын Эрмитаж музейд хадгалагдаж байна.

2009 онд Монгол Улсын Их Хурал “**Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль**»-ийг баталсан. Учир нь уул уурхайн үйл ажиллагааны улмаас 15 жилийн хугацаанд Монголын 13000 орчим гол горхи, нуур цөөрмийн 5000 орчим нь буюу 38,5 хувь нь ширгэсэн тул 2009 онд парламентаас байгаль хамгаалах чиглэлд гаргасан хамгийн том бодлого нь энэ хууль байв.

Тус хуулиар **Ноён уулын алтны орд нь гол, мөрний урсац бүрэлдэх эх, усан сан, ойн сан бүхий газарт багтана** гэх үндэслэлээр уул уурхайн үйл ажиллагаанд өртөхөөс хамгаалагдаж байв.

Гэтэл 2015 оны 2 дугаар сард тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулж, мөн Ноён уулыг стратегийн ордод оруулах замаар Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн үйлчлэлээс гаргаснаар түүх соёлын үнэт өв бүхий Ноён ууланд уул уурхайн үйл ажиллагаа явуулахад хуулийн хувьд харшлах зүйлгүй болов.

“Уул уурхайгаас ангид бүс байгуулах” –тай холбогдсон гадаадын орны эрхзүйн зохицуулалтын жишээ туршлагыг авах судлах нь, манай орны хувьд юун түрүүнд, уул уурхайн үйлдвэрлэлийн цар хүрээ байгаль хамгаалал, бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга соёлд сөргөөр нөлөөлдгөөс үүдсэн элдэв зөрчилдөөнийг зохистой шийдэхэд эерэг нөлөөтэй. Үүнтэй холбогдуулан хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн орчны хүрээнд доорх мэдээллийг бэлтгэв.

2. МОНГОЛ БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХОРИГЛОХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2.1. МОНГОЛ УЛС

а. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг

Байгалийн унаган төрхөө харьцангуй сайн хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухаан болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн цогцолборт газар гэнэ. Байгалийн цогцолборт газрыг байгалийн хэв шинж, аялал жуулчлал хөгжүүлэх нөхцөл, амьтны аймгийн байршил зэргээс нь хамаарч ашиглалтын дараах бүсүүдэд хуваана. Үүнд:

- Онцгой бүс
Хамгаалалтын арга хэмжээ авах, судалгаа шинжилгээ хийх, хөрс нөхөн сэргээх, байгалийн гамшгаас учирсан хор уршгийг арилгах арга хэмжээ авахыг зөвшөөрнө.
- Аялал жуулчлалын бүс
Байгальд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр аялал жуулчлал зохион байгуулах, зөвшөөрөгдсөн газар загас барих, уул овоо тахихыг зөвшөөрнө.
- Хязгаарлалтын бүс
Энэ уламжлалт аргаар мал маллах, зам тавих, биеийн тамирын нийтийн арга хэмжээний талбай засч тохижуулахыг зөвшөөрнө.

Иймээс, Монголд, улсын тусгай хамгаалалттай газрыг [хэрэг дээрээ] уул уурхайгаас ангид бүс –т хамаатуулж үзэж болно.

б. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг

Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах журамд,

- Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авахад **Газрын тухай хуулийн 18, 19 дүгээр зүйл, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлд** заасныг баримтална;
- Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - “орон нутгийн хамгаалалттай газар” гэж тухайн орон нутгийн байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгал, амралт, аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах зорилгоор аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтад авсан газрыг;
 - “байгалийн бүс, бүслүүрийн төлөөлөл” гэж байгалийн мужлалын хувьд өөр хоорондоо ялгаатай хам бүрдэл хэсгээс бүрдсэн тэдгээрийн онцлог шинж чанар, амьтан, ургамлын төрлүүдийг агуулсан нутгийг;
 - “улсын хэмжээнд шинжлэх ухааны ач холбогдолтой” гэж улс, бүс нутгийн хэмжээнд байгалийн иж бүрдэл, тогтолцоо, түүний хувирч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэхэд ач холбогдолтой шинжилгээ судалгааны мэдээ, мэдээллийг цуглуулах талбар бүхий газрыг
 - “улсын хэмжээнд түүх, соёлын ач холбогдолтой” гэж улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгалт зүйлийн жагсаалтад орсон хадны зураг, бичигт хад, эртний булш бунхан, буган ба хүн чулуун хөшөө, тахилгат уул, овоо, хот балгасын туурь, чулуун болон хүрэл, төмөр зэвсгийн орд газар, суваг шуудуу, түүхэн үйл явдал болсон нутгийг тус тус хэлнэ.

Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах зорилго, шалгуур

- Газар нутгийг дор дурдсан зорилгоор орон нутгийн хамгаалалтад авна. Үүнд:
 - байгалийн унаган төрх, түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах, доройтсон орчныг нөхөн сэргээх;
 - байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах;
 - аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар экологийн боловсрол, хүмүүжил олгох;
- Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авахад дараах шалгуурыг баримтална:
 - байгалийн унаган төрхөө хадгалсан байдал;
 - байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээх шаардлага;
 - хамгаалалтад авах газрын хэмжээ нь хамгаалалтын үүрэг, зорилгыг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц талбайтай байх;
 - элбэг ан амьтан, ургамлын ангилалд багтах боловч тухайн аймаг, сумын хэмжээнд нөөц багатай, хязгаарлагдмал тархац бүхий амьтан, ургамлын байршил нутаг;
 - байгалийн өвөрмөц тогтоцтой газар нутаг /геологийн ховор илэрц, мөнх цас, мөсөн гол, агуй, хүрхрээ, хясаа, хавцал, хунх, явар, цонж, рашаан булаг, баян бүрд, элсэн манхан, солирын цар, өрх, галт уулын тогоо, эртний ургамал, амьтдын олдвор бүхий газар/
 - аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын жагсаалтад орсон газар нутаг;
 - амралт, аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой нутаг;
 - ашигт малтмалын онцгой ач холбогдолтой хуримтлал бүхий нь судалгаагаар илэрч, түүнийг улс, аймгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн эрх ашгийн үүднээс зайлшгүй ашиглах хэрэгцээ шаардлага байгаа эсэх;

с. Орон нутгийн тусгай хамгаалалттай хамгаалалттай газрын ангилал

- Аймаг, нийслэл, сумын хамгаалалттай газар нутгийг дараах байдлаар ангилна:
 - ой, амьтан, ургамал, усны нөөц газар
 - байгаль, түүхийн дурсгалт газар
 - Аймаг, сумын нөөц газрыг хамгаалалт, ашиглалтын бүсэд хувааж болно.
 - Орон нутгийн хамгаалалтад авсан газар нутагт дараах дэглэмийг хэрэгжүүлж болно. Үүнд:
 - ургамал, амьтны өсч үржих нөхцөлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах арга хэмжээ авах;
 - зохих зөвшөөрөлтэй ан амьтан агнах, барих;
 - батлагдсан зураг төсөл, зөвшөөрлийн дагуу амралт, аялал жуулчлалын бааз, үйлчилгээний цэгүүд байгуулах, зам тавих;
 - ойд арчилгаа цэвэрлэгээ хийх болон ахуйн зориулалтаар мод бэлтгэх, байгалийн дагалт баялаг болон рашаан, эмчилгээний зориулалттай эрдсийг ашиглах;
 - судалгаа, шинжилгээний ажил явуулах, сонгосон талбайд ашигт малтмалын хайгуул хийх;
 - экологийн боловсрол хүмүүжил олгох сургалт зохион байгуулах;
 - уламжлалт аргаар мал аж ахуй эрхлэх;
 - орон нутгийн хэрэгцээг хангах чиглэл бүхий байгаль орчинд халгүй жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах;

d. Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай санал гаргах, шийдвэрлэх

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга **Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт** заасан бүрэн эрхийнхээ дагуу нутаг дэвсгэрийнхээ зарим хэсгийг улсын болон орон нутгийн хамгаалалтад авах тухай саналаа боловсруулж зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.
- Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай саналд дараах зүйлийг тусгана. Үүнд:
 - хамгаалалтад авах тухай үндэслэл, шаардлага, хилийн зааг;
 - авах газрын байршил, хилийн заагийг тодорхойлсон зураг;
 - Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах асуудлыг Засаг даргын өргөн мэдүүлснээр Газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3-т заасныг үндэслэн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэх ба түүний хилийн заагийг тогтоож, өөрчилж болно;
 - Орон нутгийн хамгаалалтад авсан газар нутагт ашигт малтмалын онцгой ач холбогдолтой хуримтлал байгаа нь судалгаагаар илэрч, түүнийг улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийн эрх ашгийн үүднээс зайлшгүй ашиглах шаардлагатай нь мэргэжлийн шинжээчдийн дүгнэлтээр нотлогдсон тохиолдолд ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн газар нутгийг хамгаалалтаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлж болно;
 - Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авсан тухай шийдвэрийг холбогдох материалын хамт жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Байгаль орчныг хамгаалах албанд ирүүлнэ;
 - Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгалийн бүс, бүслүүрийн төлөөлөл, нэн ховор, ховор амьтан, ургамлын үндсэн байршил нутаг, байгалийн унаган төрхөө хадгалсан, улсын хэмжээнд шинжлэх ухаан, түүх, соёлын ач холбогдолтой, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой, байгалийн нэн ховор, өвөрмөц тогтолцоо бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээнд хамруулах тухай саналаа байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагад уламжилж болно;
 - Орон нутгийн хамгаалалтад авсан ой, амьтан, ургамал, усны нөөц газрыг аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой хугацаа, төлбөртэйгээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлж болно;
 - Бусдын эзэмшилд байгаа газрыг орон нутгийн хамгаалалтад авах тохиолдолд **“Газрын тухай” Монгол хуулийн 36 дугаар зүйлийн 3; 4; 37 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасныг** баримтална;

[Өмнө дурдсанаас үзвэл] Орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг **уул уурхайгаас ангид бүс –т** хамаатуулан ойлгож болохооргүй байна.

2.2 АВСТРАЛИ

Австралид уул уурхайн үйл ажиллагааг төрийн зохицуулалтаар журамлах ба Австралийн Уул уурхайн тухай хууль (*Mining act*)-аар зохицуулдаг. Энэ нь Хамтын нөхөрлөлийн орнуудын холбогдох хуулийн зохицуулалтуудаас илүү дээгүүрт тавигдана.

Австрали нь Нийслэлийн нутаг дэвсгэр Шинэ Өмнөд Уэльс, Умард нутаг дэвсгэр, Квийнслэнд, Өмнөд Австрали, Тасмани, Викториа, Баруун Австрали хэмээх муж улсуудтай

ба эдгээрийн зарим муж улсуудад Уул уурхайн аливаа харилцааг дараах хуулиудаар зохицуулдаг. Тухайлбал,

- Баруун Австралийн 1978 оны Уул уурхайн хууль (*the Mining Act 1978 (WA)*),
- Квийнслэнд муж улсын 1989 оны Эрдэс баялгийн тухай хууль (*the Mineral Resources Act 1989 (Qld)*) ба 2003 оны Эрдэс баялгийн журам (*the Mineral Resources Regulation 2003 (Qld)*),
- Шинэ Өмнөд Австрали муж улсын 1992 оны Уул уурхайн хууль (*the Mining Act 1992 (NSW)*), 2010 оны Уул уурхайн журам (*the Mining Regulation 2010 (NSW)*) зэрэг болно.

Австралийн Уул уурхайн тухай хуулиар Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон газруудыг тогтоосон байдаг. Тухайлбал, хуулийн 3-р хэсгийн 1.5-д¹⁰⁷ зааснаар дараах Титмийн газар */Crown land/*¹⁰⁸ -уудад эрэл хайгуул хийх, уул уурхайн ажил эрхлэхгүй. Үүнд:

- (a) тариалан эрхэлж буй газар эсхүл түүнээс 100 м зайд орших газар;
- (b) хашаа, малын хашаа, цэцэрлэг, хагалсан талбай, жимсний цэцэрлэг, усан үзмийн цэцэрлэг, тариалангийн талбай, нисэх буудлын зориулалтаар ашиглагдаж байгаа эсхүл тэдгээрээс 100 м дотор байрлах газар;
- (c) байшин эсхүл томоохон барилга байгууламж бүхий аливаа эзэмшил газарт 100 м дотор орших газар;
- (d) чандрын болон оршуулгын газар эсхүл түүнд 100 м дотор орших газар;
- (e) 1997 оны Газрын Захиргааны Хуулиар хөдөө аж ахуй, бэлчээрийн зориулалтаар түрээслэгдсэн газар ба түүний гадна захаас, ямарваа усны ажил, усан замын уралдаан тэмцээн, усан далан, худаг ус, тэрхүү бэлчээрийн газрыг түрээслэгчээс өөр хэн нэгэн урьд өмнө малтлага хийж байгаагүй газар ба уурхайн зорилгоор ашиглаж байгаагүй газар зэргээс 400 м дотор орших газар,
- (ea) эзэмшигчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр, хэрвээ үгүй бол —(c) догол мөрд зааснаас бусад аливаа газрын тухайд захирч буй хүнээс; эсхүл
- (eb) уурхайн тухайд бол, газрын байгалийн гадаргуугаас доош 30 м -с багагүй гүнийх байна.

Гэхдээ ийм зөвшөөрөл бүхий хүнийг дараах Титмийн газрын зайд орших газраар дамжин өнгөрөх, дахин дамжих зэргийг энэ хэсэг хориглохгүй.

Үүнээс гадна Австралийн уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох шатанд байгаль орчин болон соёлын өвд холбогдох газруудыг хэрхэн хамгаалах тухай зохицуулалтуудыг дараах холбогдох хуулиудаар зохицуулсан байна.¹⁰⁹ Үүнд:

- Баруун Австралид 1986 оны Байгаль орчныг хамгаалах тухай хууль (*the Environmental Protection Act 1986 (WA)*),
- Квийнслэндэд 1994 оны Байгаль орчныг хамгаалах тухай хууль (*Environmental Protection Act 1994 (Qld)*),

¹⁰⁷ [http://www.parliament.wa.gov.au/Parliament/Bills.nsf/21EE5E11F81B9ABF48257C14002A222D/\\$File/Bill046-1.pdf](http://www.parliament.wa.gov.au/Parliament/Bills.nsf/21EE5E11F81B9ABF48257C14002A222D/$File/Bill046-1.pdf) - Mining act

¹⁰⁸ **Титмийн газар /Crown land/** гэдэг нь [доор дурдсанаас] бусад бүх газрыг хэлнэ -

- (a) доор дурдсанаас өөр бусад зорилгоор нөөцөлсөн эсхүл зориулсан газар -
 - (i) уул уурхайн эсхүл нийтийн хэрэглээнд нөөцөлсөн газар;
 - (ii) 1997 оны Газрын Захиргааны Хууль (*the Land Administration Act 1997*)-д заасан аль нэг зорилгоор нийтийн эзэмшилд нөөцөлсөн ба зориулсан газар;
- (b) төлбөртэйгөөр эсхүл титмийн /Хатан хааны/ нэрийн өмнөөс хууль ёсоор олгосон эсхүл гэрээ байгуулсан газар;
- (c) доор дурдсанаас бусад олгосон эсхүл титмийн нэрийн өмнөөс түрээслэсэн аливаа газар-
 - (i) 1997 оны Газрын Захиргааны Хуулийн хүрээний бэлчээрийн газрын түрээс эсхүл зөвхөн бэлчээрийн зорилгоор түрээслүүлсэн газар; эсхүл
 - (ii) мод хийх зорилготой түрээс; эсхүл
 - (iii) Уугуул хүмүүсийн чухал ач холбогдол бүхий ба хэрэглээнд зориулж түрээслэсэн Титмийн газар;
 - (d) 1997 оны Газрын Захиргааны Хуулийн хүрээнд хотын газар гэж тодорхойлогдсон газар;

¹⁰⁹ Mining law in asia- <http://www.herbertsmithfreehills.com/-/media/HS/Insights/Guides/PDFs/Asia%20Guides/Mining%20Law%20in%20Asia.PDF>

- Шинэ Өмнөд Уэльст 1979 оны Байгаль орчны төлөвлөлт ба үнэлгээний тухай хууль (*the Environmental Planning and Assessment Act 1979 (NSW)*) зэрэг Байгаль хамгааллын тухай хуулиуд (*the Environment Acts*)
- Нийслэлийн Нутаг дэвсгэрийн 1979 оны Байгаль орчны хамгаалал ба биологийн олон зүйлийг хадгалах тухай хууль (*the Environment Protection and Biodiversity Conservation Act 1999 (Cth)*);
- 1984 оны Уугуул болон Торрес Стрейт Арлын Өвийг хамгаалах Хууль (*The Aboriginal and Torres Strait Islander Heritage Protection Act 1984 (Cth)*)
- Шинэ Өмнөд Уэльсийн 1974 оны Үндэсний Паркууд ба Зэрлэг Амьтдын тухай Хууль (*the National Parks and Wildlife Act 1974 (NSW)*)
- 1977 оны Соёлын өвийн тухай хууль (*The Heritage Act 1977 (NSW)*)
- Квийнслэндийн 2003 оны Уугуул Соёлын Өвийн тухай хууль (*Aboriginal Cultural Heritage Act 2003*)
- мөн нутгийн уугуул нэр, усанд нөлөөлөхүйц бол 1993 оны Уугуул нэрийн тухай хууль (*Native Title Act 1993 (Cth) (NTA)*) -ийн «ирээдүйн хууль» (*the 'future act'*) хэмээх заалтуудыг тус тус баримтална.

Австралийн байгаль хамгаалах болон соёлын өвийн хуулиуд нь Үндэстний (Хамтын нөхөрлөлийн орнуудын) ба муж улс болон Нутаг дэвсгэр тус бүрийн түвшинд байдаг. Тэдгээр нь Австралийн үндэстний байгаль, уугуул соёлын өв ба түүхэн өвийг хамгаалах, хадгалах, танилцуулах ба уламжлуулах зорилготой. Тухайлбал,

1999 оны Байгаль Орчны хамгаалал ба биологийн олон зүйлийг хадгалах тухай хууль¹¹⁰ (*The Environment Protection and Biodiversity Conservation Act 1999*) нь Дэлхийн өв, Үндэстний өв ба Хамтын нөхөрлөлийн өвийн жагсаалтад орсон Холбооны түвшний цахилгаан холбооны станцууд, батлан хамгаалах зориулалтын газрууд, нүүдлийн төвүүд, гаалийн барилга байгууламжууд, гэрлийн байгууламжууд, Парламент ба Дээд Шүүхийн барилгууд зэрэг улсын байгууллагууд, дурсгалын газрууд, Үндэсний Парк, арлууд ба тэнгисийн цэргийн газрууд зэрэг газруудыг хамгаална. Австралийн Үндэсний Өвийн Жагсаалт бол Австралийн онцгой ач холбогдол бүхий соёлын өв хэмээн тооцогдсон байгаль, түүх ба уугуул газрууд зэрэг өвийг бүртгэгч мөн. Хуульд зааснаар Дэлхийн болон Үндэсний, хамтын нөхөрлөлийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн газруудад уул уурхайн эрэл хайгуул, үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон байдаг. Мөн Уугуул хүмүүс уугуул соёлын үнэ цэнэтэй хэмээх учир шалтгаанаар аль нэгэн газар эсхүл эд өлгийг Үндэсний Өвийн Жагсаалтад эсхүл Дэлхийн Өвийн Жагсаалтад оруулахаар өргөдөл хүсэлт гаргах эрхтэй.

Үүнээс гадна дээрх өвийн жагсаалтад бүртгэгдээгүй ч соёлын болон байгаль орчны чухал ач холбогдол бүхий газруудад байгаль орчинд ихээхэн нөлөөлөхүйц уул уурхайн төслийг тухайн муж улсын Байгаль Орчныг Хамгаалах Захиргаанаас шалгаж байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээг гаргах ба, Байгаль Орчны Сайд холбогдох хуулийн дагуу зөвшөөрөл олгоно. Ийм зөвшөөрлийг авахад 6-18 сар шаардагдах боловч зарим тохиолдолд үүнээс ч удаан хугацаа шаардагдана. Дээрх байгаль орчны «үндсэн» зөвшөөрлөөс гадна дагалдах бусад зөвшөөрлүүдийг авах шаардлагатай байдаг. Эдгээр бусад зөвшөөрлүүдэд: хууль журамд нийцсэн (үүнд хог хаягдлын асуудлаа шийдвэрлэсэн, дуу чимээ, үнэр эсхүл цахилгаан соронзон туяа зэргийг журмын дагуу шийдвэрлэсэн байх зэрэг орно) байр байгууламжийг барих ажлын зөвшөөрөл, уугуул газар нутгийн байгаль орчинтой холбогдох зөвшөөрөл, аюултай эд зүйлсийн хадгалах агуулах, аюулгүй ажиллагаа ба тээвэрлэлт зэрэгтэй холбоотой лиценз, ховор амьтны болон ургамлын зүйлс хэмээн бүртгэгдсэн амьтан, ургамалтай холбоотой тусгай зөвшөөрөл, усан хангамж ба бохир усны асуудалтай холбоотой зөвшөөрөл зэрэг орно. Уул уурхайн үйл ажиллагааг усаар хангах ба хаягдал бохир усыг зайлуулахтай холбоотой хэд хэдэн зүйл өөр өөр зөвшөөрлийг авдаг. Усны зөвшөөрлийн асуудлын хуулийн зохицуулалт нь муж улс бүрт өөр өөр байна.

¹¹⁰ The Environment Protection and Biodiversity Conservation Act 1999- <https://www.environment.gov.au/epbc>

Ингээд тухайн нэг төслийг «хяналтын үйл ажиллагаа» хийж үнэлэгдсэний дараа хуулийн дагуу үнэлгээ болон зөвшөөрөл авах үйл ажиллагаанд шилжүүлнэ. Гэхдээ Хамтын нөхөрлөлийн орнуудын Хамтын нөхөрлөл ба гишүүн улсуудын хоорондын харилцан зөвшилцлийн үндсэн дээр Хамтын нөхөрлөл нь холбогдох улсын үнэлгээнд тулгуурлан зөвшөөрөл олгож болно.

Мөн уул уурхайн хотхон байгуулах нь нутгийн уугуул нэр, усанд нөлөөлөхөөр бол тухайн зөвшөөрөл хүсэгч 1993 оны Уугуул нэрийн тухай хууль¹¹¹ (*Native Title Act 1993 (Cth)*)-ийг даган биелүүлэх шаардлагатай. Хууль ёсоор бол уугуул нэрийн эрх ашиг хөндөгдсөн бол эсхүл цаашдын оршин байхуй, хэрэглээнд нь бүхэлд нь болон зарим талаар нийцэхгүй бол хууль зөрчигдсөн гэж үзэн талууд Уугуул Газрын Ашиглалтын Зөвшилцөлд (*Indigenous Land Use Agreements-ILUA*) орж тухайн үйл ажиллагааг газар эзэмшигчийн ашиг сонирхолд нийцүүлэн тухайн үйл ажиллагааг шийднэ. Үүнд «хэлэлцэх эрх» хэмээх заалтууд эсхүл «Уугуул Газар Нутгийг Ашиглах Зөвшилцөл» -ийн «уугуул эзэд ба тухайн нэг уугуул нэрийг бүртгүүлсэн этгээдтэй зөвшилцөх» (*'Indigenous Land Use Agreement' (ILUA)*) тухай заалтуудыг үндэслэн уламжлалт эзэдтэй нь зөвшилцөх зэрэг үйл ажиллагаа багтана. «Хэлэлцэн зөвшилцөх эрх» үйл ажиллагаа нь 12-18 сар болдог бол ILUA хэлэлцээр ба бүртгүүлэх үйл ажиллагаа нь 18 сараас 3 жил ч шаардагдаж болно.

1984 оны Уугуул болон Торрес Стрэйт Арлынханы Соёлын Өвийн Хамгааллын тухай хууль¹¹² (*the Aboriginal and Torres Strait Islander Heritage Protection Act 1984 (Cth)*) -ийн дагуу уугуул иргэд эсхүл хүмүүс өөрсдийн соёл, өв уламжлал, шашин шүтлэгтэй холбогдох газар, эд өлгийн зүйлд хохирол учруулсан болон болзошгүй тухайд өргөдөл гомдол гаргаж шийдвэрлүүлэх, хориг тавиулах тухай хүсэлт эсхүл тавьсан хүсэлтийн талаар дахин өргөдөл хүсэлт гаргаж болно.

Мөн 1990 оны Баруун Австралийн Соёлын Өвийн хууль (*the Heritage of Western Australia Act 1990 (WA)*) ёсоор тариалан болон байшин барилгын эсхүл өвлөн хамгаалах захирамжтай ямарваа газрын соёлын өвийн шинж чанарыг алдагдуулахаар аливаа үйл ажиллагаанд Баруун Австралийн Соёлын Өвийн Зөвлөлөөс зөвшөөрөл авах ёстой байдаг.

1987 оны Төлөвлөлт ба Байгаль Орчны Хууль (*The Planning & Environment Act 1987*) -д Орон нутгийн төлөвлөлтийн бодлого ба Хот төлөвлөлтийн схем соёлын өвтэй давхцсан газруудын жагсаалт гаргах зэргээр байгаль орчин болон соёлын өвийг хамгаалах заалтууд орсон байдаг байна.

Энэ мэтчилэнгээр Австралид Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг газар тариалангийн бүс нутаг, хүнсний бүтээгдэхүүний тариалан, ховор нэр төрлийн ургамал, амьтны бүс нутаг, нутгийн уугуул иргэдийн ахуй соёлын чухал дурсгалт газрууд, дэлхий болон үндэсний соёлын өвд бүртгэгдсэн газрууд, үндэсний батлан хамгаалахын газрууд, стратегийн ач холбогдол бүхий газруудад олгодоггүй бөгөөд хуульд заасан зөвшөөрөгдсөн газруудад зөвшөөрөл олгох тохиолдолд лицензийн тавигдах шаардлагуудыг нарийвчлан хянан үзэж шийдвэрлэдэг.

Австрали улс нь газар тариалан, мал аж ахуй, фермер, уул уурхайн үйлдвэрлэл өндөр хөгжсөн орон юм. Австралийн Квийнслэнд муж улсад уул уурхай өргөжин газар тариалан эрхэлдэг нутагт уул уурхайн сөрөг нөлөөнөөс, ялангуяа нүүрсний уурхайн газар тариалангийн бүтээгдэхүүнд нөлөөлөхөөс болгоомжлох үүднээс Өндөр үржил шимтэй газар тариалангийн бүс нутгийн ач холбогдлыг тодорхойлон хамгаалалтад авах, хүнс үйлдвэрлэлийн гол газар нутгийг (үр тариа үйлдвэрлэх стратегийн газар нутаг) хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсний үр дүнд эдгээр өндөр үржил шимтэй газарт газар тариалангийн үйлдвэрлэл газар ашиглалтын бусад хэлбэрээс давуу эрхтэй байна.

¹¹¹ Native Title Act 1993- http://www.austlii.edu.au/au/legis/cth/consol_act/nta1993147/s223.html

¹¹² the Aboriginal and Torres Strait Islander Heritage Protection Act 1984-http://www.austlii.edu.au/au/legis/cth/consol_act/aatsihpa1984549/

Газар тариалангийн өндөр үржил шимтэй газрыг газарзүйн мэдээллийн систем, зайнаас тандалтын аргаар тодорхойлдог байна.

2.3. АНУ

АНУ-д зарим газар нутгийг төрийн хамгаалалтад авах, уул уурхайн болон бусад байдлаар газрын гадарга, газрын гүнийг ашиглахыг хязгаарласан, хориглосон эрх зүйн орчин нэлээд эртнээс бүрдсэн бөгөөд олон талын хууль тогтоомжоор зохицуулагдсан байна. Тухайлбал Нэгдсэн улсын хэмжээнд хүчин төгөлдөр үйлчлэх дараах эрх зүйн актууд байна. Үүнд:

- Нэгдсэн Улсын ерөнхий хууль (*US CODE Title*)
- Захиргааны хууль (*Administrative code*)
- Соёлын биет өвийн тухай хууль 1906 (*Antiquities act 1906*)
- Холбооны газрын бодлого болон менежментийн тухай хууль (*The Federal Land Policy and Management Act of 1976*)
- Үндэсний байгаль орчны бодлогын тухай хууль (*National Environmental Policy Act of 1969*) болон эдгээр хуульд нийцүүлэн гаргасан журам болон бусад хуульчилсан актаар зохицуулж байна.

Хялбаршуулан ойлговол Үндэсний дурсгалт газар болон Дархан цаазат газар нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хуулиар хориглосон байна.

Үндэсний дурсгалт газар гэдэгт археологийн олдвор бүхий газар нутаг, түүхийн болон балар эртний соёлын байгууламж бүхий газар нутаг, түүхийн болон шинжлэх ухааны ач холбогдолтой объект бүхий газар нутаг, ойн сан, усан сан, онгон байгаль бүхий байгалийн цогцолбор газрыг багтаах бөгөөд National Monument гэнэ. Үндэсний дурсгалт газарт тооцох, түүнд аливаа уул уурхайн үйл ажиллагаа болон газрын гүний түрээс, дэд бүтэц шинээр барьж байгуулахыг хориглохтой холбоотой зохицуулалтыг Нэгдсэн улсын ерөнхий хууль, Соёлын биет өвийн тухай хууль (*Antiquities act*)-аар зохицуулж байна.

Харин уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглосон Дархан цаазат газар болон бусад нөөцийн болон онцгой газар нутгийн тухай зохицуулалтыг Захиргааны хууль, Холбооны газрын бодлого болон менежментийн тухай хууль, Үндэсний байгаль орчны бодлогын тухай хуулиар зохицуулсан байна.

Эдгээрээс Захиргааны ерөнхий хуулийн дагуу уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглосон болон хязгаарласан бүс болон Соёлын биет өвийн тухай хуулийн зохицуулалт, түүний хэрэгжилтийн тухай товчхон авч үзье.

а) Соёлын биет өвийн тухай хууль 1906 (*Antiquities act 1906*)

Соёлын биет өвийн тухай хуулийг 1906 онд АНУ-ын ерөнхийлөгч Теодор Рузвельт санаачилсан бөгөөд тус хуулиар АНУ-ын зэрлэг онгон газар нутаг, үндэсний болон түүхийн дурсгалт газар нутгийг төрийн хамгаалалтад авах эрхийг ерөнхийлөгчид олгосон байна. 1906 онд тус хууль батлагдсанаас хойш сонгогдсон 19 ерөнхийлөгчөөс 16 нь тус хуулийг хэрэглэж байсан бол Ричард Никсон, Роналд Рейган болон Жорж Буш нар огт хэрэглэж байгаагүй байна. Барак Обама 2009 оноос хойш Соёлын биет өвийн тухай хуульд заасан эрх мэдлээ ашиглан 19 газар нутгийг Үндэсний дурсгалт газарт багтаан төрийн хамгаалалтад авснаар 2015 оны 7 сарын байдлаар АНУ-д нийт 260 сая гаруй акр (*1.052.182 км.квадрат*) газар төрийн хамгаалалтад байна. Үүнд түүх дурсгалт газар болон ойн сан, усан сан гэх мэт байгалийн цогцолбор газар нутаг багтсан байна. Тухайлбал,

- 2014 оны 10 сарын 10-ны өдөр ерөнхийлөгч Обама Анжелес болон Сан Бернардиногийн Үндэсний ойн сан бүхий 346,000 акр газрыг Сан Габриел уулсын Үндэсний дурсгалт газарт тооцох тунхаг бичиг батласнаар тус нутгийг төрийн хамгаалалтад авсан байна. Ерөнхийлөгчийн тунхаг бичигт зааснаар Үндэсний

дурсгалд оруулсан **Сан Габриел уулын ойр орчмын 346,000 акр газар уул уурхайн аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглох болон газрын гүний түрээсийг хориглосон байна.** Үндэсний дурсгалт газар одоо ашиглагдаж байгаа усны нөөц, үерийн далан, нийтийн зориулалтын байгууламж, дамжуулах хоолой болон харилцаа холбооны байгууламжийн засварын асуудалд тус хориг нөлөөлөхгүй. Гэвч эдгээр байгууламжийг өргөжүүлэх болон тус байгууламжуудтай холбоотой шинэ бүтээн байгуулалт нь тус тунхагаар хориглогдсон байна.

Соёлын биет өвийн тухай хууль (*Antiquities act 1906*)-ийн гол үзэл баримтлалыг Нэгдсэн Улсын Ерөнхий хуулийн (*United States Code Title*) 16 дахь гарчиг болох “Conservation” буюу “Хамгаалах, хадгалах” тухай хуулийн 431-433 дугаар зүйлээр хуульчлан тогтоосон байна. Үүнд:

USC, 16 title, 431-433 зүйл: Америкийн соёлын биет өвийн хуулийн тухай (1906.06.08 батлаа) 431.2. Нэгдсэн улсын Ерөнхийлөгч нь дараах бүрэн эрхтэй: АНУ-ын Засгийн газрын эзэмшлийн болон хяналтын газар нутагт орших түүхэн болон балар эртний байгууламж, түүхийн болон шинжлэх ухааны ач холбогдолтой бусад объект бүхий газар нутгийг Үндэсний Дурсгалт газар гэж албан ёсоор зарлан тунхаглах замаар төрийн хамгаалалтад авах эрхтэй. Ерөнхийлөгчийн шийдвэрээр тунхаг бичиг гаргана.

Мөн Соёлын биет өвийн тухай хуульд Үндэсний дурсгалт газар болон Дархан цаазат газрын ялгааг тогтоосон бөгөөд газар нутгийг Дархан цаазат газар нутаг гэж тогтоох эрх нь Конгресст хадгалагдах бол газар нутгийг Үндэсний дурсгалд авах эрх нь Ерөнхийлөгчид байна. Үндэсний дурсгалт газар уул уурхайн үйл ажиллагааг хориглох бөгөөд ямар нэгэн газар шорооны ажил хийх бол Хууль зүйн яам болон Байгаль орчин хөдөө аж ахуйн яамны сайд нараас зөвшөөрөл авахаар хуульчилсан байна.

Хэрэв Үндэсний дурсгалд авахуйц онцгой ач холбогдол бүхий чухал олдвор, объект нь хувийн эзэмшлийн газар нутагт байвал тухайн газар нутгийн эзэмшигч болон өмчлөгч нь газар өмчлөлийн эрхээсээ сайн дураар татгалзахаар заасан байна. Зарим тохиолдолд газар өмчлөгчийн хүсэл сонирхлоос үл хамааран тэдний газар ашиглах эрхийг хязгаарлан газар дээрх өмчийг Үндэсний дурсгалт газарт тооцож болно. Үндэсний дурсгалт газарт тооцон төрийн хамгаалалтад авсан газар нутгийг хадгалах, хамгаалах асуудлыг холбогдох хуулиудаар эрх олгогдсон байгууллагууд хариуцна.

Ийнхүү ерөнхийлөгч тунхаг бичиг гарган Үндэсний дурсгалт газарт тооцон төрийн хамгаалалтад авсан аливаа газар нутагт ашигт малтмал эрэх хайх, олборлох, ашиглах болон газрын гүний түрээс хийхийг хориглодог байна.

б) Захиргааны хууль (*Administrative code*)

Тодорхой газар нутагт уул уурхайн үйл ажиллагааг хориглох болон хязгаарлах тохиолдлуудыг Захиргааны хуулиар тогтоосон байдаг бөгөөд Америкийн муж бүр Нэгдсэн Улсын Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн захиргааны хууль батална. Судалгаанд АНУ-ын Пенсилвани мужийн Захиргааны хуульд заасан уул уурхайн үйл ажиллагааг хориглох буюу хязгаарлах тухай зохицуулалтыг орчуулан оруулав. Үүнд:

§ 86.102. Уул уурхайн үйл ажиллагааг хориглосон буюу хязгаарласан бүс.

86.1-т зааснаар дараах газарт уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- (1) Үндэсний дархан цаазат газрын тогтолцоонд хамаарах Дархан цаазат газар:
 - Үндэсний дархан цаазат газар,
 - Үндэсний зэрлэг ан амьтан бүхий газар (National Wildlife Refuge System),
 - (National System of Trails),
 - Үндэсний зэрлэг онгон байгалийн цогцолбор газар (National Wilderness Preservation System),
 - Зэрлэг болон үзэсгэлэнт голуудын тухай хуулийн 5 дугаар хэсэгт заасан Зэрлэг болон үзэсгэлэнт гол мөрний ай сав, гол мөрний үндсэн сүлжээ газар (Wild and Scenic Rivers System),
- (2) Үндэсний Ойн сан бүхий газар,
- (3) Үндэсний Бүртгэлт Түүх Дурсгалын газарт (National Register of Historic Places) хамаарах олон нийтийн өмчийн газар, түүнчлэн Холбооны яамдын хамтран баталсан, Мужийн болон орон нутгийн төрийн байгууллагуудын хамтран баталсан цэцэрлэгт хүрээлэн,
- (4) Төрийн цэцэрлэгт хүрээлэнд хамаарах газар,
- (5) Мужийн ойн сан бүхий газар: (State forest area, State picnic area, State forest natural areas and State forest wild areas) зэрэг газарт уул уурхайн аливаа үйл ажиллагааг хориглоно.

Хэрэв мод, ус, зэрлэг ан амьтад болон байгалийн нөөцөд сөргөөр нөлөөлөхгүй бол АНУ-ын Дотоод хэргийн яам, Байгалийн баялаг болон байгаль хамгаалах яамны сайдын зөвшөөрлөөр Үндэсний ойн сан бүхий газар, Үндэсний Бүртгэлт Түүх Дурсгалын газар, Мужийн ойн сан бүхий газруудад ил уурхай ашиглахыг зөвшөөрч болохоор заажээ. Ийнхүү зөвшөөрөх тохиолдолд зөвшөөрөл авах, ил уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих, түүнийг зогсоох үндэслэлүүдийг мөн Захиргааны хуулиар зохицуулсан байна.

2.4. БНХАУ

Өвөрмонголын малчдын амь зуулгыг тэтгэгч газар нутаг, бэлчээрийг ашиглах эрхийг хууль тогтоомжийн талаас нь авч үзвэл тариачин хүний эдэлж буй эрхээс бага байдаг.

1979 оноос 1983 оны хооронд хятадын газрын систем нь хамтралын өмчлөлийн хэлбэрээс айл өрх гэрээгээр өмчлөх систем руу шилжсэн. Бүхий л орон нутагт явагдсан энэ реформ нь мөн өвөрмонголын бэлчээрт үйлчилсэн. Ингэснээр зах зээлийн шинэтгэл явагдаж, улмаар газраас гарах бүтээгдэхүүнээр хязгаарлагдахгүй газрыг өөрийг нь мөн өмчлөх бололцоо эрхзүйн талаасаа нээгдсэн гэж үздэг.

Өвөрмонголд явагдсан бэлчээрийн шинэтгэл нь газрын өмчлөлийн асуудлыг хөндөөгүй ч уг шинэтгэлийг “ардчилсан шинэчлэл” гэж нэрлэсэн. Ардчилсан шинэтгэлийн үеэр ӨМӨЗО-ний коммунист нам өвөр монгол дахь бүх газар монгол түмний дундын өмч хэмээн үзэж “чөлөөт бэлчээр” хэмээх бодлогын дор бүх малчинд ижил тэгш эрх олгосон.

1953 онд Төрийн зөвлөлөөс Өвөрмонголын бэлчээрт нутаг нь монголчуудад харьяалагдахыг баталсан бичиг гаргасан байдаг. Тэрхүү бичигт “одоо өвөрмонголд байгаа бүх газар нь, үүнд өмнө нь үндэсний хэмжээнд эсвэл аль нэг отог аймагт харьяалагдаж байсан, эсвэл отог аймаг хооронд түрээслэгдсэн байсан эсэхээс үл хамааран монголчуудын мэдэлд байх болно. Чөлөөт бэлчээр, бэлчээрийн засвар өөрчлөлт нь ӨМӨЗО-ийн бүх нутгаар хэрэгжинэ” гэж тунхагласан.

БНХАУ-ын 1954 оны үндсэн хуульд “онгон газар” улсын өмч хэмээн тодорхойлсон нь энэ үгийг хэрхэн тайлбарлах вэ гэдгээс маш их зүйл хамаарахаар “тодорхойгүй” болсон. Хятадууд тариалангийн зориулалтаар ашиглагдаагүй аливаа газрыг зэрлэг газар, харин,

бэлчээрийн газрыг хагалж боловсруулсныгаа “хэрэглэгдээгүй, эсвэл хэрэггүй газрыг боловсруулах” гэж үздэг байлаа.

ӨМӨЗО-ийн бэлчээрийг төр эзэмших талаар 1973 оны ӨМӨЗО-ий бэлчээрийн зохицуулах газрын бичигт бэлчээрийг төр эзэмшинэ; гэж дурдсаныг монголчууд нь үндсэн хуулийн дагуу боловсруулагдаагүй зохицуулалт гэж эсэргүүцэж байв. Газрын хууль тогтоомжийн тодорхойгүй байдлаас үүдээд хятадын бизнесийн бүлэглэлүүд газрыг булаах, дээрэмдэх зэрэг ёс бус үйлдэл гаргах нь элбэг байдаг.

2003 оны БНХАУ-ийн бэлчээрийн тухай хуульд “бүх бэлчээрийг төр юмуу эсвэл тусгайлан хуулиар зохицуулсан бол орон нутгийн хамтрал эзэмшинэ, төр гэдэгт төрийн зөвлөлийг ойлгоно” гэж заасан. 2004 оны бэлчээрийг зохицуулах ӨМӨЗО-ны хуульд “бэлчээрийг төр юмуу хамтрал эзэмшинэ” хэмээн заасан нь асуудлыг тодорхой болгох чиглэлд ахиц дэвшил болж чадаагүй. Хууль тогтоомжид нь “нутгийн удирдах газар нь улсын бизнес, байгууллага, цэрэг арми зэргийн хэрэгцээнд зориулан хамтралын бэлчээрийн газрыг улсын мэдлийн газар болгон шилжүүлэх эрх мэдэлтэй” гэж заасан байдаг.

Одоогоороо монгол нутгийн бэлчээрийг улсын өмч гэж заахаас өөрөөр ялгаж салгаж тодорхойлсон хууль байхгүй. Үүний улмаас хятадын хөдөө аж ахуйн хамтралуудад байдаг газар эзэмших сертификат мэтийн зүйл Монголын мал аж ахуйн хамтралуудад байдаггүй байна.

Төр болон бүх шатны засаг захиргаа нь хамтралын газрыг өөрийн хэрэгцээ шаардлагад тааруулан хамтралын хүсэл зоригоос үл хамааран шууд авах эрхтэй болохоор хөдөө аж ахуйн хамтралууд ч зөвхөн “онолын хувьд” л газар өмчлөгчид юм. Тиймээс хөдөө, орон нутгийн газрыг маш бага үнээр авч дэд бүтэц, бусад салбарт бизнес эрхлэгчдэд өндөр үнэ хүргэн их хэмжээний ашиг олдог нь засгийн газрын түшмэдүүдийн ердийн ажил болсоор ирсэн. Хятадад хаа сайгүй ингэж газар нутаг дээрэмддэг, булаадаг бусармаг явдал түгээмэл. Монгол малчдын газар ашиглах эрх нь хуулиар бусдыг бодвол сул хамгаалагдсан.

Хятад улс эдийн засгийн реформ хийж эхэлсэн 1978 оноос хойш зах зээлийн эдийн засаг руу аажим шилжиж, эдийн засгийн бүтээмжийг дээдлэх болсноор нийт олны сайн сайхны төлөө жижиг бүлэг, үндэстэн ястныг эрх ашгийг хохироох үзэгдэл нэмэгдсэн гэж үздэг. Зах зээлийн эдийн засаг өмнөх төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоог “халснаар” бүс нутгийн, хот, хөдөөгийн ялгаа их болж, бага үндэстнүүдийн эрх ашиг хохирох байдаг гарсаар байна. Ийм байдал нь ялангуяа газрын эрхийн хүрээнд хамгаалалт султай малч монголчуудыг хятад бизнесийн бүлэглэл, болон олон улсын хөрөнгө оруулалтын дарамтад өртөхөд ихээр нөлөөлж байна.

Бэлчээрийн газрыг хашиж эзэнжүүлэн ашиглах болсны үр дүнд тухайн “эзэн”-ий газар уул уурхайгаас бүрэн ангид болж чадсан гэж хэлж болохоор байдаг. Үүнийг нотлох олон жишээ дурдаж болно. Бэлчээрийн зориулалтаар хашигдсан газарт юун уурхай эрхлэх, бүр уурхайн машин техникч дамжин зорчиход бэрхшээлтэй болсон сайн тал бий. Хашсан газар дээгүүр нь зам гаргаж хүнд даацын машин давхилдсаныг эсэргүүцсэн малчид ба уурхайн ажилчдын хоорондын толхилцоон “хүн амины хэрэг” болж “төгссөн” нь цөөнгүй.

Өвөрмонголд бэлчээр нутаг доройтож байгаатай холбогдуулан эрдэмтэд өөрсдийнхөө дүгнэлтийг гаргасан. Ихэнх нь малын тоо толгой бэлчээрийн даацаас хэтэрч, бэлчээр муудлаа гэдэгтэй санал нэгдсэн. Ингээд сүүлийн жилүүдэд өвөрмонголчууд ямар нэгэн арга хэмжээ авахгүй бол болохгүй нь гэдгийг ухаарсан. Эдүгээ нам засаг, малчид гээд хаа хаанаа үүнийг бодож байна.

Хятадад (өвөрмонголд) бэлчээрийн газрыг малчдад оноон эзэмшүүлснээр гарсан бас нэг аюултай үзэгдэл гарсан. **Малчид эзэмшсэн газраа уул уурхайн компанид зарах болсон.**

Энэ бүр муу уршигтай. Үүнээс болж олон малчин газар нутаггүй болсон. Бэлчээрийн газар малчдын өмч болоод ирэхээр худалдах сөрөг дагавар гарч байгаа. Тиймээс малчдад газрыг өмчлүүлж, эзэмшүүлэх нь ихээхэн эргэлзээтэй шийдэл юм. Үүнийг Өвөрмонголын жишээн дээрээс харж болно.

2.5. КАНАД

Канад Улсын уул уурхайн тогтолцооны эрх зүйн орчин

Канад нь холбооны улс бөгөөд харьцангуй бие даасан муж болон холбооны нутаг дэвсгэрүүдээс бүрдэнэ. 10 муж бүр болон Юкон нь уул уурхайн салбарыг бие даасан хууль эрх зүй, бодлогоор зохицуулдаг. Баруун-хойд нутаг дэвсгэр болон Нунавут нутаг дэвсгэрийн тогтоолууд нь зөвхөн тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх бол холбооны хууль тогтоомжууд болох:

- Загасны аж ахуйн тухай хууль (*Fisheries Act*);
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (*Environmental Assessment Act*);
- Тэсэрч дэлбэрэх бодисын тухай хууль (*Explosives Act*)-иуд нь Канадын бүх газар нутаг дахь уул уурхайн үйл ажиллагаанд хамаарна.

Тус улсад холбооны, мужийн болон нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаль, экосистемийг хамгаалах зорилгоор ашигт малтмал хайх, ашиглахыг хязгаарлах буюу хориглодог.

Канад нь холбооны хэмжээнд үндэсний ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах зорилго бүхий Канадын Үндэсний дархан цаазтай газрын тухай /Үндэсний Парк/ (Canada National Parks Act, S.C.2000, с.32)¹¹³ хуулийн дагуу Үндэсний дархан цаазтай газруудтай байх бөгөөд одоогийн байдлаар нийт 39 дархан цаазтай газартай байна. Дархан цаазтай газар нутаг нь Канадын нийт нутаг дэвсгэрийн хуурай газрын 2,25% буюу 300,000км²-ийг эзэлж байна. Үндэсний дархан цаазтай газарт ашигт малтмалын хайгуул явуулах, ашиглах лиценз олгох зэргийг хориглоно. Үндэсний дархан цаазтай газраас гадна дараах хоёр төрлийн хамгаалалттай бүс байдаг нь Үндэсний зэрлэг ан амьтны бүс болон Нүүдлийн шувуудын нутаглах газар (National Wildlife Areas and Migratory Bird Sanctuaries) байна. Эдгээр нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглоогүй, ч тусгай зөвшөөрөл авах шаардлагатай байна.

Муж болон нутаг дэвсгэрүүд нь мөн хамгаалалттай бүс тогтоох эрхтэй байх бөгөөд ихэнх нь ашигт малтмалын хайгуул болон ашиглалт явуулахыг хориглодог. Эдгээр хамгаалалттай бүсүүдийн хэмжээ нь муж мужаасаа хамаараад ялгаатай байна. Дээрх хамгаалалттай бүс нутаг нь Канадын нийт хуурай газрын 9.4% тэнцэх бөгөөд ихэнх буюу 94% нь уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Хамгаалалттай бүсэд уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа нь тухайн бүс нутгийг хамгаалалтын бүс тогтоохоос өмнө уул уурхайн зөвшөөрөл олгосон байдгаас үүдэлтэй байна. Өмнө нь ашигт малтмалын лиценз болон бусад зөвшөөрөл олгосон байсан газар нутагт хамгаалалтын бүс байгуулах, бүсийг өргөтгөх зэрэг нь хүндрэлтэй байдаг бөгөөд Юкон дахь Томбстоун Парк, Баруун-хойд нутаг дэвсгэр дахь Наханни Үндэсний Парк, Квебек дахь Ривьера хамгаалалттай бүс болон Онтарио дахь Волф лэйк ойн нөөц газар зэрэгт энэхүү асуудал тулгарч байгаа юм.

Нова Скотиа болон Шинэ Брунсуикэд усны нөөцийг хангах зорилгоор усны сав газрыг хамгаалахыг хуулиар тогтоосон. Дээрх газруудад уул уурхайн үйл ажиллахыг хязгаарлах, эсхүл хориглосон. Шинэ Брунсуик, Цэвэр усны тухай хууль¹¹⁴ (Clean Water Act)-иар, Нова

¹¹³ <http://laws-lois.justice.gc.ca/eng/acts/n-14.01/>

¹¹⁴ 14-р зүйл, <http://laws.gnb.ca/en/showdoc/cs/C-6.1/se:14?splitmode=true#anchorse:14>

Скотиа, Байгаль орчны тухай хууль¹¹⁵ (Environmental Act)-иар усны сав газар уул уурхайн бүхий хөрс, ус бохирдуулах аливаа үйл ажиллагааг хязгаарлах буюу хориглосон.

Бритиш Колумбия мужийн эрх зүйн орчин

Бритиш Колумбия мужийн газар нутгийн 13%-д нь уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглодог. Тухайлбал:

- Барилга, байгууламж бүхий газар;
- Орон сууц бүхий барилга байгууламжаас 75 метрийн зайд;
- Жимсний аж ахуйн газар;
- Газар тариалангийн газар;
- Уул уурхайн зориулалтаар ашиглагдаж буй газар;
- Соёлын өв бүхий газар, орон нутгийн засаг захиргаа, холбогдох яамнаас зөвшөөрөл олгогдсоноос бусад;
- Парк, холбогдох журмаар зөвшөөрөгдсөнөөс бусад газруудад уул уурхайн үйл ажиллагааг хориглосон байна.

Үүнээс гадна:

- Уугуул иргэдийн газар нутагт Бритиш Колумбиягийн индианчуудын газар нутаг дахь ашигт малтмалын тухай хууль (*British Columbia Indian Reserves Mineral Resources Act*)¹¹⁶-ийн дагуу, зөвшөөрөл олгогдсоноос бусад;
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль (*Heritage Conservation Act*)-иар хамгаалагдсан соёлын өв;
- Канадын Үндэсний дархан цаазтай газрын тухай /Үндэсний Парк/ (*Canada National Parks Act*, S.C.2000, с.32)¹¹⁷ хуулийн дагуу Үндэсний дархан цаазтай газар;
- Бритиш Колумбиягийн дархан цаазтай газрын тухай хууль (*BC's Park Act*)-ийн дагуу паркууд;
- Орон нутгийн засаг захиргааны тухай хууль (*Local Government Act*)-ийн дагуу орон нутгийн паркуудад;
- Бритиш Колумбиягийн хамгаалалттай бүсийн тухай хууль (*Protected Areas of British Columbia Act*)-ийн дагуу парк, экологийн нөөц газрууд;
- Бритиш Колумбиягийн Экологийн нөөцийн тухай хууль (*Ecological Reserve Act*)-ийн дагуу экологийн нөөц газрууд;
- Байгаль орчин болон газар ашиглалтын тухай хууль (*Environment and Land Use Act*)-ийн дагуу уул уурхайн үйл ажиллагааг хориглосон газар;
- Бритиш Колумбиягийн Газрын тухай хууль (*Land Act*)-ийн дагуу “титмийн газар” (*crown land*);

Ашигт малтмалын нөөцийн тухай хууль (*Mineral Tenure Act*)-ийн дагуу ашигт малтмалын нөөц бүхий газар;

Уул уурхайн үйл ажиллагааг хориглосон бүсийг соёлын, экологийн болон бусад зориулалт бүхий бүс гэж 3 ангилж үзэж болохоор байна.

Бритиш Колумбиягийн ашигт малтмалын нөөцийн тухай хуульд Эрчим хүч болон уул уурхайн сайд нь тухайн газар нутаг нь соёлын өв бүхий газар нутаг гэж үзсэн тохиолдолд тус газрыг уул уурхайн үйл зориулалтаар ашиглахыг хориглох эрхтэй байна.

Соёлын өвийг: “Бритиш Колумбия, уугуул ард иргэдийн түүхэн, соёлын эсхүл археологийн ач холбогдол бүхий эд зүйл, талбай, уламжлалт нийгмийн зан үйлийн газрыг хэлнэ” гэж тодорхойлсон байна. Сайд хориг тавьсан тохиолдолд, хуульд заасны дагуу нөхөн төлбөр олгодоггүй байна.¹¹⁸

¹¹⁵ 105-р зүйл, <http://nslegislature.ca/legc/statutes/envromnt.htm>

¹¹⁶ *British Columbia Indian Reserves Mineral Resources Act*, SC 1943-44, с 19, s 3: “provided...that no prospecting or right of entry on the said Indian Reserve shall be authorized or permitted until permission so to do has been obtained from the Indian Agent for such Reserve”.

¹¹⁷ <http://laws-lois.justice.gc.ca/eng/acts/n-14.01/>

¹¹⁸ *Mineral Tenure Act*, RSBC 1996, с 292, ss 17(1),(2).

Бритиш Колумбиягийн соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу дараах газар нутаг хамгаалагдана:

- Мужийн соёлын өв бүхий газар, эсхүл эд зүйл;
- Түүхэн, эсхүл археологийн ач холбогдол бүхий булш, бунхан;
- Уугуул иргэдийн чулуун зураг, эсхүл сийлбэр, болон
- 1846 оноос өмнө хүмүүсийн амьдарч байсан эд баримт, талбай, газар зэрэг орно.

Экологийн бүс нутгийн хувьд Канадын Үндэсний дархан цаазтай газар уул уурхайн үйл ажиллагаа явуулж болохгүйгээс гадна дараах экологийн бүсэд хориотой байдаг байна.

Тухайлбал:

- Байгаль орчин болон газар ашиглалтын тухай хууль (*Environment and Land Use Act*)-д заасны дагуу уул уурхайн үйл ажиллагааг хориглосон газар;
- Газрын тухай хууль (*Land Act*)-ийн 93.1-д заасны дагуу “титмийн газар”;
- Бритиш Колумбиягийн дархан цаазтай газрын тухай хууль (*BC's Park Act*)-ийн дагуу паркууд;
- Орон нутгийн засаг захиргааны тухай хууль (*Local Government Act*)-ийн дагуу орон нутгийн паркуудад;
- Бритиш Колумбиягийн хамгаалалттай бүсийн тухай хууль (*Protected Areas of British Columbia Act*)-ийн дагуу парк, экологийн нөөц газрууд;
- Бритиш Колумбиягийн Экологийн нөөцийн тухай хууль (*Ecological Reserve Act*)-ийн дагуу экологийн нөөц газрууд;

Экологи болон түүх, соёлыг хамгаалахаас гадна бусад зориулалтаар уул уурхайн үйл ажиллагааг хориглож болдог нь Бритиш Колумбиягийн Ашигт малтмалын нөөцийн тухай хууль (*Mineral Tenure Act*)-ийн дагуу ашигт малтмалын нөөц газарт уул уурхайн үйл ажиллагааг хориглох /No Registration Reserves (NRRs)/, эсхүл хязгаарладаг /Conditional Registration Reserves (CRRs)/ байна.

2.6. ОХУ

ОХУ-ын Газрын тухай хуулийн 70.1–р заалтад “[улсын] төв ба орон нутгийн хэрэгцээнд зориулан газар нөөцлөх” зарим зохицуулалтыг тусгасан байдаг. Үүнд:

- Иргэн, хуулийн этгээдэд олгогдоогүй, мөн түүнчлэн батлан хамгаалах зориулалтаар, улс нийтийн болон хэрэгцээний инженерийн байгууламж, зам тээврийн сүлжээний болон дэд бүтцийн объект барих байгуулах, байгалийн онцгой хамгаалалт бүхий ба эдийн засгийн тусгай статус бүхий бүс тогтоох; -ын тулд газрыг улсын ба орон нутгийн хэрэгцээнд зориулан нөөцөлж (резервирование земель) болно.
- Мөн газрын хэвлийг (байгалийн эрдэс баялаг) хожим ашиглах зорилгоор тодорхой хэсэг газрыг нөөцлөн хадгалж болно.
- Дээр дурдсан зориулалтаар хадгалах газрын нөөцөд байх хугацааг 2–3 жил, зарим тохиолдолд 20 хүртэл жилээр тогтооно.
- Газрыг улсын ба орон нутгийн нөөцөд авах нарийвчилсан журмыг ОХУ-ын Засгийн газар тогтоон хэрэгжүүлнэ.

Газрыг улсын болон орон нутгийн нөөцөд авах зарим асуудлыг зохицуулсан ОХУ-ын Засгийн газрын 2008.7.22 -ны өдрийн 561 дугаар тогтоолд:

- Барьж байгуулахаар төлөвлөж буй улсын (Холбооны) чанартай барилга байгууламж, объектын хилийн бүс (цэс) -ийг Хот байгуулалтын тухай хуулийн холбогдох заалтад нийцүүлэн, 2010.01.01 –нээс өмнө тогтоолгосон байх; -аар тусгасан нь, газар нөөцлөх үйл явцыг нэгдсэн бодлогын дагуу, тухай бүр, төлөвлөн хэрэгжүүлэх горимтойг харуулж байна.
- Газрыг улсын нөөцөд авах шийдвэрт дор дурдсан нөхцөлүүдийг зааж тусгана.

Үүнд:

- Нөөцөд авах хэрэгцээ шаардлага (зорилго) –ыг болон нөөцөд авах хугацааг тодорхой заана;
 - Газрын нөөцөд авах шийдвэр гаргахад шаардагдах хууль тогтоомжид заасан баримт бичгийн бүрдлийг гүйцэд хангасан байна;
 - Газрыг нөөцөд авснаар тухайн бүсэд хориглох эрхийн хязгаарлалтуудыг тусгана, нөөцөд авсан газрын координатыг заасан кадастрын схемийг хавсаргана;
- Газрын нөөцөд авсан тухай эрх бүхий байгууллагын шийдвэрийг гарсан даруйд нь нийтэд (харьяалах субъектийн нутаг дэвсгэрт) мэдээлнэ гэж заасан байна.

2.7. ФИЛИППИН

Дэлхийн улс орнуудын хэмжээнд Филиппин нь ашигт малтмалын нөөцөөр баян орнуудын тоонд ордог. Алтны нөөцөөр 3-р, зэсийн нөөцөөр 4-р, никелийн нөөцөөр 5-рт орж байгаа бөгөөд ашигт малтмалын нөөцөөр дэлхийд 5 дугаарт бичигдэж байна.

Филиппиний Уул уурхайн тухай хууль (sec. 19 of RA No. 7942)¹¹⁹-ийн 19 дүгээр зүйлд Уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглосон газруудыг тогтоосон байдаг. Үүнд:

- Цэргийн буюу батлан хамгаалах болон засгийн газрын бусад нөөц газар;
- Төрийн болон хувийн барилга байгууламжийн орчимд, эсхүл газар доор (төр, эсхүл хувь этгээдийн бичгээр зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд);
- Хүчин төгөлдөр уул уурхайн зөвшөөрөл олгогдсон газар;
- Хуулиар тусгайлан хориглосон газар;
- Хуульд заасны дагуу бичил уурхайн газар (дээрх этгээд нь зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд);
- Ойн болон усны нөөц газар, зэрлэг ан амьтны нутагладаг газар, мангрын ой (*mangrove forest*), дархан цаазтай газар, хот, мужийн ой, паркууд, ногоон бүс, шувуудын нутагладаг газар зэрэг Үндэсний нэгдсэн хамгаалалттай бүсийн тогтолцооны тухай хуульд тусгайлан заасан газар нутгууд болон бусад газрууд орно.

2012 оны 7 дугаар сарын 9-ны өдөр Ерөнхийлөгч уул уурхайн салбарыг шинэчлэхтэй холбоотой зарлиг¹²⁰ гаргасан нь холбогдох бодлого, төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах, хариуцлагыг өндөржүүлэх, байгаль орчныг хамгаалах зэрэгт чиглэгдсэн байна. Тус зарлигаар уул уурхайн үйл ажиллагааг хориглосон бүсэд нэмэлт гурван төрлийг оруулсан нь:

- аялал жуулчлалын бүс /Үндэсний аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөний дагуу Аялал жуулчлалын яамнаас тогтоосон нийт 78 газар/;
- хөдөө аж ахуйн бүс,
- Үндэсний нэгдсэн хамгаалалттай бүсийн тогтолцооны тухай хууль (*National Integrated Protected Areas System*)-ийн дагуу арлын экосистемууд орсон байна.

Уул уурхайгаас ангид бүс (*Mining free zone*)

Филиппин Улсын Конгресс нь Уул уурхайгаас ангид бүс байгуулах тухай хэлэлцэж байгаа бөгөөд 2015 оны 6 дугаар сарын 21-ний өдөр доод танхим 2 хот (Кагаян де Оро, Давао) болон 6 дүүрэгт уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг бүр мөсөн хориглох төслийг баталсан байна. Төсөл санаачлагчид нь тус төслүүдэд уул уурхайн үйл ажиллагаа нь

¹¹⁹ http://www.lawphil.net/statutes/repacts/ra1995/ra_7942_1995.html

¹²⁰ executive order 79, series of 2012, institutionalizing and implementing reforms in the philippine mining sector providing policies and guidelines to ensure environmental protection and responsible mining in the utilization of mineral resources <http://www.denr.gov.ph/component/content/article/831.html>

байгаль орчин, хүний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдгөөс гадна байгалийн үзэсгэлэнт газрыг устгаж байгааг тэмдэглэжээ. Химийн хорт болон аюултай бодис хэрэглэж байгаа нь усны эх, нөөцийг бохирдуулж, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөхөөс гадна их хэмжээгээр хөрсийг хуулж ургамал, амьтанд аюул учруулж, хөрсний гулсалт, үерийн хэмжээ, давтамжийг үлэмж ихэсгэж байгаа зэргийг үндэслэж, учруулсан хохирлын хэмжээний хамт тусгасан байна.

Хуулийн төсөлд:

1 дүгээр зүйл. Төр нь иргэдийн эрүүл, аюулгүй ээлтэй орчинд амьдрах эрхийг хамгаалах бодлого баримтлах хүрээнд уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс ард иргэд болон байгаль орчныг хамгаална.

2 дугаар зүйл. Хуулийн төсөлд уул уурхайн үйлдвэрлэл гэдэг нь ашигт малтмал эсхүл бусад геологийн эрдэс, барилгын материал болох элс, хайрга, чулуу, цементийн түүний эд, өнгөлгөөний чулуу зэргийн ордын эрэх, хайх, судалгаа хийх, олборлолтод бэлтгэх, олборлох зэргийг хориглосон. Харин засгийн газраас төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээ (зам, гүүр, сургууль, ус, цахилгаан хангамж зэрэг) үзүүлэхэд шаардагдах бүтээн байгуулалтад элс, хайргын олборлолтыг тус хуулиар хориглохгүй боловч хүчин төгөлдөр үйлчилж буй ашигт малтмал болон байгаль орчны тухай хуульд нийцүүлсэн байна.

3 дугаар зүйл. Торгууль. Энэхүү хуулийг зөрчсөн аливаа этгээд, ажилтан эсхүл ажил олгогч нь 6 дээш, 12 доош жилээр хорих ял болон 100,000-500,000 песогийн торгууль ногдуулна. Зөрчил гаргагч нь хуулийн этгээд, эсхүл холбоо байх тохиолдолд тухайн компанийн эзэн болон менежер/үүд-ийг, гадаадын хуулийн этгээд тохиолдолд тухайн хуулийн этгээдийн Филиппин дахь төлөөлөгчид хариуцлага ногдуулахаар тус тус заасан байна.

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Mining act- [http://www.parliament.wa.gov.au/Parliament/Bills.nsf/21EE5E11F81B9ABF48257C14002A222D/\\$File/Bill046-1.pdf](http://www.parliament.wa.gov.au/Parliament/Bills.nsf/21EE5E11F81B9ABF48257C14002A222D/$File/Bill046-1.pdf)
- Mining law in asia- <http://www.herbertsmithfreehills.com/-/media/HS/Insights/Guides/PDFs/Asia%20guides/Mining%20Law%20in%20Asia.PDF>
- The Environment Protection and Biodiversity Conservation Act 1999- <https://www.environment.gov.au/epbc>
- Native Title Act 1993- http://www.austlii.edu.au/au/legis/cth/consol_act/nta1993147/s223.html
- the Aboriginal and Torres Strait Islander Heritage Protection Act 1984-http://www.austlii.edu.au/au/legis/cth/consol_act/aatsihpa1984549/
- [1] Өвөрмонголын судлаач Т. Тэмцэл, Өвөрмонгол дахь газрын шинэтгэлийн түүхэн тойм” өгүүлэл (нийтэлсэн “Монголын үнэн” сонин, 2014. VI., орчуулсан д-р. М. Энхсайхан) -ээс тухайн сэдэвт холбогдох хэсгийг товчлон авав.
- [2] ӨМӨЗО -ны Багшийн их сургуулийн Газар зүйн сургуулийн багш, доктор, проф. Б. Хайшаан, “Бэлчээрийн газраа хашаад буруудсан Өвөрмонголын түүх” (ярилцлага), Өдрийн сонин,
- “Байгаль орчны багц хууль” эмхтгэл, редактор д-р. С. Оюун, ~400 х., УБ, 2014;
- ОХУ –ын Земельный кодекс, ОХУ –ын Засгийн газрын 2008 оны 561 дүгээр тогтоол;
- бусад;
- Үндэсний дархан цаазтай газрын тухай (Canada National Parks Act, S.C.2000, с.32) <http://laws-lois.justice.gc.ca/eng/acts/N-14.01/index.html>
- Шинэ Брунсвик, Цэвэр усны тухай хууль, 1989 (14 дүгээр зүйл) <http://laws.gnb.ca/en/showdoc/cs/C-6.1/se:14?splitmode=true#anchorse:14>
- Нова Скотиа, Байгаль орчны тухай хууль, 1994 (105 дугаар зүйл) <http://nslslegislature.ca/legc/statutes/envromnt.htm>
- Канадын уул уурхайн эрх зүйн орчны тойм, <http://www.miningwatch.ca/publications/introduction-legal-framework-mining-canada>
- <http://www.fairmining.ca/code/the-surface-versus-subsurface-divide/alternative-use-no-go-zones/>
- <http://www.mb.com.ph/cdo-davao-to-be-declared-mining-free-zones/>
- Ерөнхийлөгчийн зарлиг № 79, 2012 <http://www.denr.gov.ph/component/content/article/831.html>
- Филиппины Уул уурхайн тухай хууль, 1995 http://www.lawphil.net/statutes/repacts/ra1995/ra_7942_1995.html
- Пенсилвани мужийн Захиргааны хууль <http://www.pacode.com/secure/data/025/chapter86/s86.102.html>
- National Monuments and the Antiquities Act
- US Code title 16, Conservation <http://www.nps.gov/history/local-law/anti1906.htm>
- Antiquities Act 1906

**МЕГА ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШИЙДВЭР ГАРГАХ ПРОЦЕСС, ОРОЛЦОГЧ ТАЛУУД,
ТЭДГЭЭРИЙН ОНЦЛОГ**

*Ц.Болормаа, Д.Жигваагүнсэл, Ч.Онончимэг
Б.Нандингэрэл, Д.Халиун*

АГУУЛГА**ОРШИЛ****НЭГ. ТАЙЛАНД БОЛОН МОЗАМБИК УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

- Тайланд улсын эрх зүйн зохицуулалт
- Мозамбик улсын эрх зүйн зохицуулалт

ХОЁР. МЕГА ТӨСЛИЙН ОРОЛЦОГЧИД, ТЭДНИЙ ҮҮРЭГ ОРОЛЦОО

- Оролцогчид гэж хэн бэ?
- Оролцогчдын менежмент

ГУРАВ. МЕГА ТӨСӨЛД ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ

- Шийдвэр гаргах үйл ажиллагааны үе шатууд
- АНУ-ын туршлага
- Япон улсын туршлага

ДӨРӨВ. МЕГА-ТӨСӨЛ: МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ОРШИЛ

МЕГА ТӨСӨЛ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Оксфордын их сургуулийн профессор Бент Фливбьер (Bent Flyvbjerg)-гийн тодорхойлсноор: “Мега төсөл гэдэг нь томоохон хэмжээний, ихэвчлэн 1 тэрбум ам.доллараас дээш өртөгтэй, гүйцэтгэх хугацааны хувьд удаан, цар хүрээ, хэмжээний хувьд олон сая иргэдэд нөлөөлөхүйц төслийг хэлнэ. Энэ нь төслүүдийн томруулсан хувилбар бус харин цар хүрээ, оролцогч талууд зэргээрээ ялгаатай төсөл юм” гэсэн байна.

ОХУ, АНУ-д мега төслийн өртгийн босгыг заагаагүй бөгөөд өртөг нь 1 тэрбум ам.доллар давж байгаа боловч нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн хувьд хязгаарлагдмал байгаа тохиолдолд мега төсөлд төдийлөн хамруулж үзэхгүй байна.

Түүнчлэн судлаачид “мегатөсөл” гэхээс гадна томоохон хэмжээний инженерийн төсөл (large-scale engineering project), шинжлэх ухааны мега төсөл (mega science project), шинжлэх ухааны томоохон төсөл (large science project), олон улсын төсөл (international project) гэж мөн томъёолж байна.

Олон улсын төсөл буюу мега төслийн онцлог шинж чанар:

- Төслийн гол зорилго бол суурь шинжлэх ухааны ахиц дэвшилд нөлөөлөхөд чиглэсэн байдаг.
- Төсөл нь бүс нутгийн болон дэлхий нийтийн анхааралд байх асуудалд нэг талын томоохон боломж нөөцийг ашиглахад эсвэл ялгаатай олон талуудын хязгаарлагдмал тооны жижиг нөөц боломжийг нэгтгэсэн цогц системийг ашиглахад чиглэгдсэн байдаг.
- Төсөлд маш их хэмжээний хөрөнгө мөнгө шаардлагатай байдаг ба хөрөнгө оруулалтын зардал нь багадаа 1 тэрбум ам.доллар, урсгал зардал нь жилийн 0.2 тэрбум ам.доллараас дээш хэмжээтэй байдаг.
- Төсөл нь бүс нутаг хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжих бол төслийг хэрэгжүүлэх тогтолцоо нь дэлхийн хэмжээнд тодорхойлогддог.

Мөн тухайн улс орны хөгжлийг хангах, хүн ардын амьдрах нөхцөлийг нь сайжруулах зорилгоор улсын хэмжээний томоохон Мега төслүүдийг боловсруулан хэрэгжүүлдэг бөгөөд түүнд өргөн хүрээний асуудлууд багтана. Ийм төслүүдэд асар их хөрөнгө оруулалт шаардагддаг бөгөөд эдгээр нь урт хугацааны явцад хувь хүний болон нийгмийн түвшний эдийн засгийн баталгааг бүрэлдүүлэхүйц бусад олон салбарын тогтвортой хөгжлийн үндэс болдог байна.

Түүнчлэн судалгаанд хамрагдсан улс орнуудын туршлагаас харахад зарим улс нь мега төсөлтэй холбогдох харилцааг бие даасан хууль болон журмаар зохицуулж байна. Тус судалгаанд Тайланд улсын засгийн газрын журам болон Мозамбик улсын хуулийн зохицуулалтыг тусгайлан судалсан болно. Тухайлбал, Тайланд улсын засгийн газрын журамд зааснаар:

“Улс орныг хөгжүүлэх улсын мега төсөл” гэж Засгийн газрын агентлагаас хэрэгжүүлэх аливаа асуудлыг шийдвэрлэж, ард түмний үндсэн хэрэглээг шуурхай хангаж, амьжиргааны чанарыг дээшлүүлэх, эсхүл бусад орнуудтай өрсөлдөх чадварыг дээшлүүлэх эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх, мөн үр дүнд нь улс орны цаашдын хөгжилд түлхэц болохуйц тусгай мэдлэг, туршлага, орчин үеийн технологи, их хэмжээний хөрөнгө оруулалт, сайн менежмент шаардагдсан нийтийн үйлчилгээ, хэрэглээний барилга байгууламж, үйлчилгээний ажлын төслийг хэлнэ гэж заажээ.

Харин Мозамбик Улс 2011 онд Мега төслийн тухай хуулийг баталсан (Мега-төслийн тухай хууль 15/2011.08.10) бөгөөд тус хуулиар нэг талаас гадаадын хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, нөгөө талаас улс орны баялгийг үр ашигтай, үр дүнтэй зарцуулах, нийгэм, иргэдэд үр шимийг нь хүртээхэд буюу төслийн шууд болон шууд бүс үр өгөөжийг хөрөнгө оруулагч болон улс орон, иргэдийн хооронд “шударга” хуваарилахад чиглэсэн байна.

Мега төслийн шийдвэр гаргах үйл явцын тухай судалсан хэсэгт АНУ болон Япон улсын мега төсөлд шийдвэр гаргах процессийг жишээ болгон оруулсан болно. Судалгааны хайлтын явцад тухайлсан улс орны жишээг нарийвчлан судлахад шаардагдах мэдээ материал хангалттай бүс байсныг дурьдах нь зүйтэй.

Бүс нутгийн болон дэлхийн хэмжээний мега төслүүдэд шийдвэр гаргах үйл ажиллагаа нь дараах 4 үе шаттайгаараа онцлог байдаг. Үүнд:

1. Төслийг тодорхойлох үе шат
2. Хариуцсан агентлагуудын зүгээс төслийн үнэлгээг хийх
3. Агентлагуудын зүгээс ЗГ-ууддаа төслийн тухай мэдээллийг өгөх
4. Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хийх гэсэн дөрвөн үе шатны онцлог

болон тэдгээрт оролцогчдын онцлогийн талаар судалгааны мэдээлэл хайх явцад олдсон мэдээ материалд тулгуурлан судалсан болно.

Том хэмжээний төсөл, хэлэлцээрийн гол зохицуулалтын нэг нь маргааныг хэрхэн шийдэх зохицуулалт бөгөөд үүнийг судалгааны тайлангийн дөрөв дэх хэсэгт оруулсан болно. Асуудал, маргаан үүсэхэд хэн, хаана хандах, шийдвэрлэх механизм нь гэрээний оролцогч талуудад тодорхой байх нь чухал бөгөөд хөрөнгө оруулалтын гол нөхцөлүүдийн нэг нь энэ юм. Иймд аливаа гэрээ хэлэлцээр, түүнчлэн мега-төслүүдийн хувьд маргааныг шийдвэрлэх зохицуулалтгүй хийх боломжгүй юм. Үүссэн маргааныг шийдэх аргыг сонгох нь оролцогч талуудын сонгох эрх боловч үндэстэн дамнасан том компанийн хувьд дотоодын шүүхээс илүү мэргэшсэн олон улсын арбитраар шийдвэрлүүлэх нь практикт өргөн дэлгэрсэн.

Талууд бие даасан, тухайн салбарт мэргэшсэн, нэр хүндтэй арбитрадыг өөрсдөө сонгодог нь зөв, шударга, бие даасан, хараат бус байдлаар маргааныг шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлдэг бол дотоодын шүүх нь үр чадвар, гадны буюу улс төрийн нөлөө их зэрэг шалтгаанаар эргэлзээ төрүүлдэг байна. Түүнчлэн арбитрын шийдвэрийг талууд биелүүлэх үүрэгтэй, шүүхэд давж заалдах боломж хязгаарлагдмал зэрэг онцлогтой юм. Өнөөгийн байдлаар үндэстэн дамнасан компаниуд арилжаа, бизнес, хөрөнгө оруулалтын маргааныг арбитраар шийдвэрлүүлэх нь давамгай байна. Гэхдээ арбитр нь өөрийн гэсэн сул талтай бөгөөд шүүхэд давж заалдах боломж, бие даасан байдал зэрэг нь зарим тохиолдолд шүүмжлэл дагуулдаг. Судалгааны дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны тайлангаас үзнэ үү.

СУДАЛГААНЫ САН

НЭГ. ТАЙЛАНД БОЛОН МОЗАМБИК УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

➤ *Тайланд улсын эрх зүйн зохицуулалт*

Тайландад улс орны хөгжлийг хангах, хүн ардын амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор улсын хэмжээний томоохон Мега төслүүдийг боловсруулан хэрэгжүүлдэг бөгөөд мега төсөл хэмээн зарлагдсан төслийг 2006 онд Засгийн газраас баталсан журмаар нарийвчлан зохицуулдаг байна.

Мега төслүүдэд асар их хөрөнгө оруулалт шаардагддаг бөгөөд эдгээр нь бас урт хугацааны явцад хувь хүний болон нийгмийн түвшний эдийн засгийн баталгааг бүрэлдүүлэхүйц бусад олон салбарын тогтвортой хөгжлийн үндэс болдог.

Ийм Мега төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэхдээ «Улс орны хөгжилд чиглэсэн төрийн мега төслийг хэрэгжүүлэх тухай Ерөнхий Сайдны Ажлын албаны журам В.Е. 2549 (2006)» (Regulation of the Office of the Prime Minister on the Undertaking of public Mega-Project for Country Development, В.Е.2549(2006))-ыг¹²¹ баримтална.

Тус журамд:

- *Төслийн хамрах хүрээ,*
- *Төсөл хэрэгжүүлэх процесс,*
- *Төслийн хяналт мониторингийг хэрхэн хийх асуудлыг тус тус тусгасан байна.*

Уг журмыг Ерөнхий Сайд нь Сайд нарын Зөвлөлтэй зөвлөлдөж Төрийн Захиргааны Байгууллагын Хууль В.Е. 2534 (1991)-ийн Хэсэг 11(6), (8) ба (9)-ийн заалтыг үндэслэн 2006 онд батлан гаргасан байна. Журам нь 5 бүлэг, 22 заалт бүхий бүтэцтэй. Үүнд:

- Нэгдүгээр бүлэг: Ерөнхий үндэслэл
- Хоёрдугаар бүлэг: Хороо
- Гуравдугаар бүлэг: Төслийг санаачлах ба санал болгон дэвшүүлэх
- Дөрөвдүгээр бүлэг: Үнийн санал өгөхийг урих, Төслийн саналыг өргөн барих ба төслийг хэлэлцэх тухай
- Тавдугаар бүлэг: Удирдлага ба мониторинг
- Бусад

Энэхүү журмын биелэлтийг Ерөнхий сайд хянаж, хариуцах бөгөөд хэрэгжүүлэх явцад үүсэх аливаа асуудлыг шийдвэрлэх ба журмын хэрэгжилтээс чөлөөлөх зэргийг Сайд нарын Зөвлөл хариуцна.

Журамд зааснаар «Улс орныг хөгжүүлэх улсын мега төсөл» гэж Засгийн газрын агентлагаас хэрэгжүүлэх аливаа асуудлыг шийдвэрлэж, ард түмний үндсэн хэрэглээг шуурхай хангаж, амьжиргааны чанарыг дээшлүүлэх, эсхүл бусад орнуудтай өрсөлдөх чадварыг дээшлүүлэх эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх, мөн үр дүнд нь улс орны цаашдын хөгжилд түлхэц болохуйц тусгай мэдлэг, туршлага, орчин үеийн технологи, их хэмжээний хөрөнгө оруулалт, сайн менежмент шаардагдсан нийтийн үйлчилгээ, хэрэглээний барилга байгууламж, үйлчилгээний ажлын төслийг хэлнэ.

Сайд нарын Зөвлөлөөс зөвшөөрөгдсөн аливаа төслийг тус Зөвлөлөөс өөрөөр заагаагүй бол энэ хуулийн дагуу хэрэгжүүлэх ба дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. *төслийн ажил хэрэгт нэгдмэл,*
2. *ил тод байх,*

¹²¹ www.Tailaws.com - Regulation of the Office of the Prime Minister on the Undertaking of public Mega-Project for Country Development, В.Е.2549(2006)

3. шударга ёсны зарчмуудыг баримталж,
4. Төрөөс хүлээж буй үр дүнд оновчтойгоор хүрэх зорилго, зорилтыг анхааран үздэг байна.

Төслийг “**Улсын хөгжилд чиглэсэн улсын мега төслийн бодлогын хороо**” хариуцан ажиллах ба, түүнийг «CPPM» гэж товчлон нэрлэнэ.

Энэ хороог Ерөнхий сайд тэргүүлж, Ерөнхий сайдын итгэмжилсэн хоёр Орлогч сайдууд Дэд тэргүүнээр, Сангийн сайд болон засгийн газрын гишүүд, улс төрийн намуудад ямар нэгэн алба хашдаг хүмүүсээс бүрдэх ба салбар тус бүрээс нэг хүн байна.

Гишүүд нь хоёр жилийн хугацаатай алба хаших ба, Төсөл санал болгож буй ямарваа этгээдтэй ашиг сонирхлын зөрчилтэй байж болохгүй. Энэ талаарх гомдол эсхүл ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэхдээ Захиргааны хэргийн хуулийг баримтална.

CPPM нь Сайд нарын Зөвлөлд улсын мега-төслийн тухайд бодлогын санал оруулах; Захиргааны Хороонд бүртгэгдсэн төслийн саналуудыг судлан үзэж, санал бодлоо өгөх эсхүл Сайд нарын Зөвлөлд өөр хувилбарыг санал болгох; Энэ журмын хүрээнд эсхүл Сайд нарын Зөвлөлийн итгэмжлэлээр бусад үйл ажиллагааг эрхлэх; Салбар хороог болон ажил үүрэг гүйцэтгэх итгэмжилэгдсэн хүнийг томилох зэрэг эрх үүрэгтэй ажилладаг.

Мөн Засгийн Газрын агентлаг бүр дээр Улсын Хөгжлийн төлөөх улсын мега-төсөл хариуцсан Захиргаа болон Удирдлагын Хороотой байх ба, хороо нь Төслийн саналыг судалж, нягтлан үзэх; Саналуудыг судалж үзсэн үр дүнгийн талаар илтгэх хуудас бэлтгэж CPPM -д өргөн барих, бусад хувилбаруудын саналыг бэлтгэх; Төслийн ажлыг гэрээнд заасан бүх зорилт, нөхцөл, заалтуудын дагуу явуулах ажлыг удирдан захирамжлах; Засгийн газрын агентлаг ба Сайд нарын Зөвлөлд улирал тутамд төслийн ажлын үр дүн, ахиц дэвшил, учирч буй бэрхшээл ба авсан арга хэмжээний талаар тайлагнах; CPPM эсхүл Сайд нарын Зөвлөлийн итгэмжлэлээр бусад үйл ажиллагааг эрхлэн явуулах эрх үүрэгтэй. Засгийн газрын нэг агентлаг нэгээс илүү төслийг хариуцах тохиолдолд төсөл тус бүр дээр тусгай Захиргааны Хороо байгуулна.

Үнийн санал өгөхийг урих:

Захиргааны Хорооны зөвшөөрөлтэйгөөр холбогдох Засгийн газрын агентлаг нь Төслийн саналыг Сайд нарын Зөвлөлөөс баталсны дагуу зарлах хэлбэрээр үнийн саналын урилгыг гаргах бөгөөд үнийн саналын урилгыг холбогдох Засгийн газрын агентлагийн болон Ерөнхий Хянан Шалгах Газрын цахим хуудсуудад нийтлэх ба, Олон нийтийн харилцааны газар, радио эсхүл телевиз зэрэг өргөн нэвтрүүлгийн станцууд, сонин хэвлэлүүдэд илгээж, Тайландад буй Элчин сайдын яамд зэрэг гадаад орны байнгын төлөөлөгчдөд ГХЯ-аар дамжуулан мэдэгдэж мэдээллийг аль болох өргөн хүрээнд түгээхэд анхаарна. Үнийн саналын урилгыг Төслийн саналын бичиг баримтыг хүлээн авахаар товлосон өдрөөс наанадаж 30 өдрийн өмнө зарлана.

Үнийн саналын урилгыг Тайланд хэлээр Англи хэлнээ хөрвүүлсэн орчуулгын хамтаар гаргах ба үнийн саналын урилгад наанадаж дараах мэдээллүүд агуулагдсан байх ёстой байдаг байна. Тухайлбал,

- Төслийн талаар Төрөөс дэвшүүлж буй зорилт
- Төслийн санал өгөх талын хангах шаардлагууд
- Төслийн ажлын зорилтууд ба цар хүрээ
- Төслийн саналыг өгөх өдөр, цаг ба газар. (Үнийн санал хүлээж авах сүүлийн хугацаа, саналыг хэлэлцэх шалгаруулалтын эхлэх хугацаа)
- Төслийг хэрэгжүүлэх шалгуур ба нөхцөл, техник үндэслэлийн санал, хэрэгжүүлэх төлөвлөгөө ба үр ашгийн тооцоо, Төслийн хугацаа болон ач холбогдол бүхий

- бусад саналууд
- Үнийн саналыг сонгон шалгаруулахдаа Засгийн газраас хэрэглэх анхдагч шалгуур ба арга
- Санхүүгийн болон хөрөнгө оруулалтын саналыг Сангийн Яамнаас гаргаж, Сайд нарын Зөвлөлөөс баталсан маягтын дагуу бэлтгэх.

Үнийн саналын урилгын дагуу төслийн саналыг бүртгүүлэхдээ төслийн санал гаргагч тал нь Засгийн газрын агентлагийн үнийн саналын урилганд тодорхойлсон зорилтоос зарим талаар тодорхой ялгаатай саналыг гаргах эсхүл арай өөр бусад хувилбарыг санал болгож болно.

Төслийн саналыг өргөн барих ба төслийг хэлэлцэх:

Ерөнхий сайдын ерөнхий нарийн бичгийн дарга, эсхүл түүний итгэмжлэгдсэн хүн урилгад заасан өдөр, цаг, газарт Төслийн санал гаргагчдаас бичиг баримтыг хүлээн авч, Засгийн газрын агентлагт зохих цаг хугацааны дотор нягталж урьдчилсан шалгуурыг хангаж буй эсэхийг шалгуулахаар хүргүүлэх ба, дараа нь бүх бичиг баримтыг зохих Захиргааны Хороонд өргөн барина. Засгийн газрын агентлаг нь шалгаруулалтанд орж буй төслийн саналуудыг хураангуйлсан санамж бичгийг бэлтгэж тус засгийн газрын агентлаг ба Ерөнхий Хянан Шалгах газрын цахим хуудсуудад наанадаж долоон хоногоос багагүй хугацаанд байршуулна.

Санхүү болон хөрөнгө оруулалтын саналгүй аливаа төслийн тухайд төслийг судлах үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө дараах арга хэмжээг авна. Үүнд:

1. Саналын урилганд санхүү болон хөрөнгө оруулалтын саналыг шаардалгүйгээр техникийн болон бусад саналыг бүртгүүлэхийг зарласан тохиолдолд Захиргааны Хорооноос техникийн болон бусад саналаа хэдийнээ өгсөн төслийн санал гаргагчаас санхүү болон хөрөнгө оруулалтын саналаа өгөхийг хүсч болно.
2. Төслийн санал гаргагч санхүү, хөрөнгө оруулалтын саналаа хараахан бүртгүүлж амжаагүй тохиолдолд Захиргааны Хороо техник-эдийн засгийн болон хөрөнгө оруулалтын саналуудыг хамтад нь судлах нь зүйтэй гэж үзвэл Захиргааны Хорооноос тэрхүү санал гаргагчаас тодорхой заасан хугацаанд санхүү, хөрөнгө оруулалтын саналаа бэлтгэж өгөхийг мэдэгдэж болно.
3. (1)(2)-оос өөр бусад тохиолдолд, CPPM-с үйл ажиллагааг нь тодорхой зааж өгнө.

Төслийн саналууд нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу концесс эсхүл хамтарсан компани оролцоотой холбогдох ёсгүй ба, төрийн агентлагуудад үнийн санал өгөхтэй холбоотой Гэм зөрчлийн тухай хуулийг зөрчих ёсгүй. Эс бөгөөс Захиргааны Хорооноос Төслийн санал гаргагчдыг өөрсдийн саналыг засаж залруулахыг мэдэгдэх ба энэ талаар зааварчилгааг өгч болно.

Төслийг хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурснаас бусад тохиолдолд бүх төслийн саналтай холбоотой Засгийн газрын агентлаг ба төрд ямарваа үүргийг хүлээлгэж болохгүй.

Төслийн санал бүрийг судлан үзээд Захиргааны Хороо нь төслийн техник-эдийн засгийн, хөрөнгө оруулалтын ба бусад үндэслэлүүдийг судлан үзсэн үр дүнгийн талаар илтгэх хуудас бэлтгэнэ. Бүх төслийн саналыг судлан үзсэн үр дүн, эсхүл Захиргааны Хороо зохистой гэж үзсэн өөр бусад хувилбаруудыг CPPM-д өргөн барих ба, гол анхаарах зорилтуудыг тогтооно.

Захиргааны Хорооны маргаан хэлэлцүүлгүүд нь бүх нийтэд нээлттэй байх ба, радио, телевизээр нэвтрүүлж болно.

Захиргааны Хорооноос ирүүлсэн илтгэх хуудсыг хүлээн авсан даруйдаа CPPM нь Захиргааны Хороонд зааварчилж болох бөгөөд төслийн санал гаргагчтай үнэ, нөхцөл, цаг эсхүл нэмэлт тодорхой зүйлс дээр хэлэлцээр хийхийг хүсч болно. Гэхдээ CPPM нь Төслийн аль ч санал гаргагчийг тухайн асуудал дээр шууд хэлэлцэхээр урьж болно.

CPPM-ийн хэлэлцүүлэг шийдвэрүүд нь олон нийтэд нээлттэй байх ба радио, телевизээр нэвтрүүлж болно. Үүнээс гадна, CPPM нь энэ мэт Төслийг хэрэгжүүлэх талаар мэдлэгтэй Тай эсхүл гадаадын мэргэжилтэн эсхүл мэргэжлийн багаас бүхэлд нь эсхүл хэсэгчлэн үг хэлэх болон зөвлөгөө өгөхийг хүсч болно.

CPPM нь Төслийн шалгаруулалтын хэлэлцүүлгийн үр дүнгийн тухай илтгэх хуудас бэлтгэж тэдгээр бүх үр дүн ба бусад сонгогдсон саналын хувилбаруудыг Сайд нарын Зөвлөлд өргөн барьж, голлон анхаарах асуудлуудыг тогтооно.

Сайд нарын Зөвлөлд хэлэлцүүлэхээр асуудлыг оруулахдаа Кабинетын Тамгын газраас холбогдох агентлагуудыг ажил хэргийн дагуу саналаа өгөхийг бас хүснэ.

Сайд нарын Зөвлөлөөс Төслийн саналыг баталснаар Засгийн газрын агентлагаас болзол, нөхцөл ба нэмэлт бичиг баримтуудыг бүрэн хавсаргасан гэрээний эхийг Тай болон Англи хэлээр Ерөнхий Прокурорын Албанд гэрээг үзэглэхийн өмнө нягтлуулахаар хүргүүлнэ.

Ерөнхий Прокурорын Алба нь төслийг санаачлагч Засгийн газрын агентлагаас бичиг баримтыг хүлээн авсанаас хойш 60 хоногийн дотор гэрээний эх, нөхцөл ба нэмэлт баримтуудыг нягтлан шалгаж үзнэ.

Гэрээ байгуулагч талуудын хоорондох маргааныг тухайн гэрээний нөхцөлөөр шийдвэрлэх ба, энэ нь олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын хэм хэмжээтэй нийцэж байх ёстой.

Ханган нийлүүлэх тухай Ерөнхий сайдын Албаны журмаар Төслөөр гүйцэтгэх ажлыг хүлээн зөвшөөрөх, хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгах арга, хянах ба шалгах, хянан шалгах хороог томилох, хороо, удирдагчид, хорооны алба хаагчдыг хөлслөх зэрэгтэй холбоотой зохих нэмэлт өөрчлөлтүүдийг хийж болно. Гэхдээ Захиргааны Хороо нь Сайд нарын Зөвлөлд Төслийн тухайлсан онцлогт нийцсэн процедурыг тохируулах саналыг тавьж болно.

19 дүгээр зүйл:

Энэ журмын дагуу бүх цаг хугацааны заалтыг Захиргааны Хороо, CPPM, эсхүл Сайд нарын Зөвлөлөөс түүний цаг хугацааг хэлэлцэх үедээ, уян хатан байх зарчмын үүднээс, Төрийн ашиг сонирхол ба шударга ёсны үүднээс багасгаж эсхүл сунгаж болно.

Удирдлага ба мониторинг:

Гэрээнд үзэглэсэн даруйд, Захиргааны Хорооноос дараах ажлыг гүйцэтгэнэ:

1. Гэрээний нөхцөл заалт, зорилтуудад нийцүүлэн төслийн ажлын хэрэгжилтийг удирдан захирамжлах
2. Төслийн ажил хэргийн үр дүн, ахиц дэвшил, тулгарч буй бэрхшээлүүд ба авсан арга хэмжээний тухай тайланг улирал тутамд цаашид Сайд нарын Зөвлөлд уламжлуулахаар Засгийн газрын агентлагт өгнө.

Хөгжлийн төлөө хамтран ажиллах бодлогын хэрэгжилтийн Зохицуулах Хороо нь төслийн хэрэгжилтийг хангах үүднээс ерөнхий зохицуулагч болно.

Энэ журам хүчин төгөлдөр болохоос өмнөх Засгийн газрын агентлаг ба Сайд нарын Зөвлөлөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг хүчин төгөлдөр гэж үзнэ. Гэхдээ тэдгээрээс хойших бүх үйл ажиллагаанд энэ журмыг баримтална.

Иймээс дээрх тодорхойлолтонд нийцсэн зарим мега төслүүдийг *Хөгжлийн бодлогын Хамтрагчдын* хамтаар тусгай үндэслэлээр төслүүдийг бусад ерөнхий төслүүдээс ялгаатай тусгай гэрээ ба менежментийн үйл явцаар авч үзнэ. Үүнтэй холбоотойгоор, Засгийн Газар нь аж ахуйн нэгжүүдийг өөрсдийн төслийн саналыг Үндсэн хуульт эрх зүй ба уламжлалын дагуу сайн удирдлагын зарчимд суурилсан, ил тод, нээлттэй бөгөөд шударга хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах явдлыг баталгаажуулах боломж чадвартай байх ёстой. Бүх бизнесийн үйл ажиллагаа нь ардчилсан засаглал ба хуулийн үйл явцын олон улсын стандартын дагуу хамгаалагдах ёстой байдаг байна.

➤ МОЗАМБИК УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Мозамбик нь нүүрс, газрын тосны нөөцөөр баялаг орон бөгөөд 2011 онд тус улсын хойд эрэгт их хэмжээний байгалийн хийн нөөц илрүүлсэн. Хэдийгээр дэд бүтэц муу хөгжсөн ч далайд гарах гарц, татварын бодлого, улс төрийн харьцангуй тогтвортой орчин зэрэг нь гадаадын хөрөнгө оруулалтыг эрчимтэй татаж байна. Үүнтэй холбоотойгоор Мозамбик Улс 2011 онд Мега төслийн тухай хуулийг баталсан (Мега-төслийн тухай хууль 15/2011.08.10). Энэхүү хууль нь нэг талаас гадаадын хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, нөгөө талаас улс орны баялгийг үр ашигтай, үр дүнтэй зарцуулах, нийгэм, иргэдэд үр шимийг нь хүртээхэд буюу төслийн шууд болон шууд бүс үр өгөөжийг хөрөнгө оруулагч болон улс орон, иргэдийн хооронд “шударга” хуваарилахад чиглэсэн байна.

Мозамбикийн мега төслийн тухай хууль нь өөр хоорондоо ялгаатай харилцааг нэг хуулиар зохицуулахыг оролдсон бөгөөд төр хувийн хэвшлийн түншлэл нь гэрээний үндсэн дээр хувийн хэвшил төрийн үйлчилгээ үзүүлэх, харин уул уурхайн салбарт хийгдэх концессын гэрээ нь цэвэр ашгийн төлөө хэлбэр юм, түүнчлэн 490 сая ам.доллараас илүү гарсан бүх төслүүд салбараас үл хамааран тус хуульд хамаарах юм. Хуульд тусгасан олон давхар хяналт, мониторингийн механизм, мөн мега гэсэн тодотголд хамаарах бүх төслүүдийг тендер зарлан явуулах нь гадаадын хөрөнгө оруулалтыг сааруулах үндэслэл болж болзошгүй гэж судлаачид үзсэн байна. Мөн хуульд заасан “шударга” хуваарилалт гэж тусгасан нь тодорхой бус байна гэж НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлаас тус улсын хөрөнгө оруулалтын орчинд хийсэн тайланд дурдсан байна.

Мозамбикийн мега төслийн тухай хуулийн гол зохицуулалтын орчуулгыг доор оруулав.

Мега төслийн тухай хууль 2011¹²²

2 дугаар зүйл. Хуулийн зорилт

Тус хуулийн зорилго төр хувийн хэвшлийн түншлэл, том хэмжээний төсөл болон концессын гэрээ байгуулах, гүйцэтгэх болон хяналт тавих механизмын дагаж мөрдөх журам тогтооход оршино.

1. Төр хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ) нь төрийн эсхүл, нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэх зорилгоор хувийн хэвшлийн хэсэгчилсэн эсхүл, бүрэн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэхийг хэлнэ. Үүнд ашигт малтмал болон газрын тосны салбар хамаарахгүй болно.
2. Том хэмжээний төсөл (ТХТ) нь Засгийн газраас зөвшөөрөл олгосон, эсхүл төрийн хөрөнгөөр хэрэгжих 12,5 их наяд MZN буюу 2009 оны ханшаар ойролцоогоор 490 сая ам.доллараас дээш өртөг бүхий төслийг хэлнэ.

¹²² Хуулийг бүрэн эхээр дараах хаягаар орж үзнэ үү:

[http://www.acismoz.com/lib/services/translations/Law%20no%20%2015%202011%20of%2010%20August%20\(Mega%20Projects%20Law\)%20%20SC%20free%20translation.pdf](http://www.acismoz.com/lib/services/translations/Law%20no%20%2015%202011%20of%2010%20August%20(Mega%20Projects%20Law)%20%20SC%20free%20translation.pdf)

3. Концесс нь холбогдох гэрээ, эсхүл Засгийн газраас олгосон эрхийн дагуу байгалийн баялаг, бусад нөөцийн эрэл, хайгуул, ашиглалт явуулах гэрээг хэлнэ. Төрийн шилжүүлж үл болох үүргийн ТХХТ, ТХТ болон концессын гэрээгээр гүйцэтгүүлэхийг хориглоно.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

1. Энэхүү хууль нь улс орны хэмжээнд төрийн, орон нутгийн болон дүүрэг, эсхүл хотын санаачилга, эсхүл шийдвэр, удирдлага дор хэрэгжиж буй бүхий л ТХХТ, ТХТ болон концессын гэрээтэй холбоотой ажиллагаанд хамаарна.
2. Энэхүү хууль нь дараахад үйлчлэхгүй:
 - а. Засгийн газрын бараа үйлчилгээ худалдан авах ажиллагаа.
 - б. Нийгмийн, хүмүүнлэгийн, соёл, спорт зэрэг ашгийн бус төр хувийн хэвшлийн түншлэл.

4 дүгээр зүйл. Зарчим

ТХХТ, ТХТ болон концессын гэрээг байгуулахдаа дараах зарчмыг баримтална.

- Холбогдох нийгэм, эдийн засгийн салбарт баримталж буй бодлого стратеги, болон хөгжлийн төлөвлөгөөнд нийцсэн байна.
- Улсын нөөц баялгийг зохистой ашиглахад анхаарна.
- Оролцогч талууд, болон холбогдох талууд ашгийг зохистой хуваарилах.
- Эрсдэлийг урьдчилан тооцоолох, бууруулах арга хэмжээ авах.
- Төслийг хэрэгжүүлэхэд, мөн эдийн засгийн хувьд саад учруулж болох хязгаарлалтуудыг устгах, бизнесийн эрх чөлөө, өрсөлдөөнт орчныг хангах.
- Ажлын байр бий болгох, мэргэшүүлэх, Мозамбикажилчид болон менежерүүдэд ноу-хау нэвтрүүлэг шилжүүлэх.
- Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах, Мозамбик иргэдийн эдийн засагт оролцох оролцоог нэмэгдүүлэх.
- ТХХТ, ТХТ болон концесс болон микро, жижиг, дунд үйлдвэрлэлийн хооронд бизнесийн түншлэлийг дэмжих, ноу-хау шилжүүлэх.
- Нийгмийн хариуцлага болон тогтвортой байдлыг хангах, орон нутгийн иргэдийн нийгмийн хөгжлийг хангах, өндөржүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.
- Хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн орчинд нийцүүлэх.
- Захиргааны шүүхээс хуульд нийцсэн, хуулийн дагуу явуулах шаардлагыг хүлээн авах.

5 дугаар зүйл. Салбарын хяналт

1. ТХХТ, ТХТ болон концессын гэрээний үндсэн дээр хийгдэж буй төслүүдийн хяналтыг холбогдох салбар хариуцсан төрийн байгууллага хяналт тавина.
2. ТХХТ, ТХТ болон концессын гэрээний үндсэн дээр хийгдэж буй төслүүдийн хяналтыг салбарын хяналтын үүргийг холбогдох дэд салбарын зохицуулах байгууллага гүйцэтгэнэ.
3. Холбогдох салбар, дэд салбарын зохицуулагч байгууллага нь оролцогч талуудын хооронд эдийн засаг, санхүүгийн тэнцвэрийг хангах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах болон тогтвортой байдлыг хангах үүрэгтэй байна.

6 дугаар зүйл

1. ТХХТ, ТХТ болон концессын гэрээний үндсэн дээр хийгдэж буй төслүүдийн санхүүгийн хяналтыг санхүү хариуцсан төрийн байгууллага нь хариуцах бөгөөд салбар тус бүрийн хяналт хариуцсан байгууллага хоорондын хамтын ажиллагааг уялдуулах, механизм болон процедурыг тогтооно.

2. Засгийн газар нь байгууллага хоорондын хамтын ажиллагаа уялдуулах байгууллагыг нэр дэвшүүлэх, эрх олгох бөгөөд эдийн засаг, санхүүгийн анализыг төвлөрүүлэх, ТХХТ, ТХТ болон концессын хяналт, үнэлгээ болон үр ашгийг хуваах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй байна.

7 дугаар зүйл. Төсөл хэрэгжүүлэх нэгж

ТХХТ, ТХТ болон концессын гэрээний үндсэн дээр ажиллагаа явуулж буй байгууллага нь:

1. Холбогдох хуулийн дагуу компанийн хэлбэртэй байна.
2. Тухайн төслийн гүйцэтгэх боломж, бололцоотой байх.
3. Тухайн төслийн гүйцэтгэх гэрээний хугацаанд хүчин төгөлдөр байх.

8 дугаар зүйл. Төслийн үе шат

1. ТХХТ, ТХТ болон концессын гэрээний үндсэн дээр хийгдэж буй төсөл нь тодорхойлох, гүйцэтгэх, дуусгавар болох гэсэн бүхий л үе шаттай байна.
2. Засгийн газар нь төслийн бүхий л үе шат, мөн үе шат бүрийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлно.

9 дүгээр зүйл. Төслийн санал хүлээн авах

1. Засгийн газар нь ТХХТ, ТХТ болон концессын гэрээ байгуулах хүсэлт төв, орон нутаг, дүүрэг болон хотын түвшинд хүлээн авах процессыг тогтооходоо бусад нөхцөлөөс гадна дараахыг хангуулна:
 - а. Байгууллага хоорондын хамтын ажиллагааны уялдаа холбоог хангах.
 - б. Эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, үр ашгийг хуваарилах
 - в. Гэрээний талууд, улс орон болон гуравдагч этгээдүүдэд урьдчилан сэргийлж болохуйц алдагдлаас сэргийлэх, шийдвэр гаргах ажиллагааг түргэн шуурхай явуулах,
2. Дээрх заалтын б хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор компанийн дотоод нууц болох арилжааны болон өрсөлдөх чадварт нөлөөлөх мэдээллийг энэхүү хуульд заасан мониторингийн ажиллагаанд шаардагдах мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй байна.
3. Төслийн санал хүлээн авахад тухайн төслийн бүхий л үе шатанд зайлшгүй хангах чанарын шалгуурыг, холбогдох яамдын эрх үүргийг тогтооно.

10 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын баталгаа, хөнгөлөлт

1. ТХХТ, ТХТ болон концессын гэрээний үндсэн дээр хийлгэж буй ажил нь тус салбарт хамаарах хуулийн дагуу улс оронд хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын баталгаа болон хөнгөлөлтөд хамрагдана.
2. Татварын болон бусад санхүүгийн хөнгөлөлтийг холбогдох хуулийн дагуу санхүүгийн хяналт хариуцсан байгууллага бүртгэлд авч холбогдох санхүүгийн жилд Улсын Ерөнхий Нягтлан бодогчид мэдээлнэ.

22 дугаар зүйл. Гэрээний хугацаа

1. ТХХТ-ийн гэрээний хугацааг эдийн засаг-санхүү, төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах цаг хугацаа, хувь нийлүүлсэн хөрөнгийн нөхөх хугацаа зэргийг харгалзан тооцно. Ингэхдээ доор заасан хугацаанаас хэтрэхгүй байна:
 - а. Барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээний хувьд 30 жил;
 - б. Концессын гэрээ болон хэрэгжиж буй төслийн хувьд нөхөн сэргээх буюу өргөтгөх гэрээний хувьд 20 жил;
 - в. Ашиглалт менежментийн гэрээний хувьд 10 жил;

2. Дээрх заалтын а-д заасныг том хэмжээний барих-ашиглах-шилжүүлэх гэрээний хувьд, мөн технологийн болон биологийн шаардлагаар урт хугацаа шаардагдах тохиолдолд 10 хүртэл жилээр сунгаж болно.
3. Засгийн газар нь гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах замаар 1 дэх хэсэгт заасан хугацааг нөхөн олговорт зориулж хугацааг сунгаж болно:
 - а. Засгийн газар нэмэлт хөрөнгө оруулалт хийх хүсэлт гаргаж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар тохиролцож холбогдох байгууллага баталсан бол,
 - б. Засгийн газраас тогтоосон үнэ, тариф нь үйлдвэрлэлийн өртөг болон харилцан тохиролцсон ашгийн хэмжээнээс доош байгаа тохиолдолд,
 - в. Давагдашгүй хүчин зүйлээс үүдсэн нөлөөг бууруулах арга хэмжээ.

Төслийн хугацаа дууссан бол цаг дууссан болон шинэ гэрээний тендер зарлагдах бөгөөд урьд нь тендерт шалгарсан байгууллага нь өмнөх төслөө гүйцэтгэсэн ажил нь хангалттай сайн гүйцэтгэсэн тохиолдолд техник-эдийн засгийн үндэслэлийн хувьд 5%-ийн давуу эрх эдэлнэ.

39 дүгээр зүйл. Маргаан хянан шийдвэрлэх

1. ТХХТ, ТХТ болон концессын гэрээний бүхий л шатанд үүсэх аливаа маргааныг тухайн асуудлаар хүчин төгөлдөр үйлчилж буй холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангасан, оролцогч талуудын тодорхойлсон журмын дагуу шийдвэрлэнэ.
2. Маргааныг хянан шийдвэрлэх хугацааг багасгах, мөн бизнесийн учрах хохирлын хэмжээг бага байлгах үүднээс ТХХТ, ТХТ болон концессын гэрээ нь үүсэх маргааныг хуулийн хүрээнд аль болох эвлэрүүлэн зуучлал эсхүл арбитраар шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

ХОЁР. МЕГА ТӨСЛИЙН ОРОЛЦОГЧИД, ТЭДНИЙ ҮҮРЭГ ОРОЛЦОО

1. Мега төсөлд оролцогчид

Юуны өмнө мега төслийн оролцогч талуудын тухай ярихын тулд төслийн цар хүрээ болон төслийн аль шатанд байгаагаас шалтгаалан оролцогчдыг харилцан адилгүй тогтоодог гэдгийг анхаарах шаардлагатай. Тухайлбал, мега төслийн боловсруулах шатанд ихэнхдээ салбар бүрийн мэргэжлийн байгууллагаас бүрдсэн бүрэлдэхүүн байх ба шийдвэр гаргах, хэрэгжүүлэх шатанд төслийн оролцогчид өөрчлөгддөг. Иймд төслийн бүх шатанд оролцогчдыг дараах байдлаар ерөнхийлөн томъёолно. Үүнд:

1. Засгийн газар, түүний мэргэжлийн байгууллагууд
2. Хувийн хэвшил
3. Олон нийт

Харин дэлхийн хэмжээний шинжлэх ухааны мега төслийн оролцогчдийг дараах ерөнхий гурван түвшинд хуваадаг. Үүнд:

1. Бие даасан судлаач, судлаачдын баг, их сургууль факультет, үндэсний лаборатор судалгааны институци болон олон улсын шинжлэх ухааны байгууллагуудыг оролцуулсан **Шинжлэх ухааны нийгэмлэгүүд**,
2. Шийдвэр гаргах үйл явцад үнэлгээ болон зөвлөгөө өгөх чадавхитай, судалгаа шинжилгээний зөвлөлийг бүрэлдэхүүндээ багтаасан институцийн бүтэц зохион байгуулалт бүхий **Шинжлэх ухааны агентлагууд**,
3. Шинжлэх ухааны асуудал хариуцсан Засгийн газрын бүтцийн байгууллага болон Засгийн газрын мэдлийн шинжлэх ухааны байгууллагыг багтаагаад зогсохгүй тухайн улсын үндэсний хууль тогтоох байгууллага буюу парламент зэрэг шийдвэр гаргах үйл явцад шууд оролцдог байгууллагуудын оролцоог нэгтгэсэн **Төрийн төлөөлөл**.

Мега төслүүдэд оролцогчдыг ерөнхийд нь ийнхүү ангилдаг ч зарим улс орнуудын холбогдох байгууллагуудын чиг үүргийн онцлогоос хамаарч харилцан адилгүй байх тохиолдол гардаг. Жишээ нь, АНУ-ын Эрчим хүчний Төрийн Департамент нь шинжлэх ухааны агентлаг болон Засгийн газрын хоёулангийнх нь үүргийг гүйцэтгэдэг. Японы Үндэсний их сургууль хоорондын судалгааны институци нь шинжлэх ухааны нийгэмлэгийн төлөөлөл болох ба зарим тохиолдолд шинжлэх ухааны агентлагийн үүргийг гүйцэтгэдэг байна.

Өөрөөр хэлбэл Шинжлэх ухааны төслүүдийн анхдагч сэдэл нь шинжлэх ухааны нийгэмлэгүүдээс гардаг. Нийгэмлэг нь өгөгдсөн салбарын шинжлэх ухааны хөгжлийн төлөөх хамгийн шилдэг хувилбарыг тодорхойлж, стратегийн үр дагаврыг тооцоолж, зорилгодоо хүрэхэд шаардагдах хамгийн шилдэг бүрэлдэхүүнийг тодорхойлдог. Мөн түүнчлэн ерөнхий зохицуулалтын хүрээнд шинжлэх ухааны болон техникийн нөхцөл байдлыг бэлтгэн, хамгийн шилдэг төслийн санал болон шинжлэх ухааны гол асуудлыг тодорхойлон боловсруулж шинжлэх ухааны агентлагуудад танилцуулдаг.

Шийдвэр гаргах үйл явц дахь шинжлэх ухааны агентлагуудын үүрэг оролцоо нь:

- Шинжлэх ухааны нөхцөл байдалтай холбогдох төслийн санал,
- Техник эдийн засгийн үндэслэл,
- Шаардагдах хөрөнгөнд бие даасан үнэлгээ хийж, дүгнэлт гаргах явдал юм.

Агентлагууд нь шинжлэх ухааны нийгэмлэгүүд болон Засгийн газар хоорондын зохицуулагчийн үүргийг гүйцэтгэх ба тухайн шинжлэх ухааны гол асуудалд хамаарах төслийн төсөв санхүүгийн тооцоо, шаардагдах нөөц, хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй холбогдох мэдээллийг ижил болон бусад шинжлэх ухааны салбарын холбогдох мэдээллүүдээс авч

нэгтгэх ажлыг мөн хариуцна. Эцэст нь Засгийн газрын бодлогын байр суурьтай холбогдох санал зөвлөмжийг гаргадаг.

Засгийн газар (Парламентийг оролцуулан) нь өөрсдийн боломж бололцоонд тулгуурлан томоохон олон улсын төслүүдэд оролцох өөрийн улсын оролцоо болон төслийн нийт төсөвт оруулах санхүүжилттэй холбоотой шийдвэрийг гаргадаг. Шийдвэр гаргах үйл ажиллагаанд нийгэм эдийн засгийн нөхцөл байдлыг үнэлэх, үндэсний шинжлэх ухааны бодлогод нийцүүлэх, Засгийн газар хоорондын хэлэлцээр хийх гэх мэт бусад ач холбогдол бүхий олон үйл ажиллагаа ордог.

Шийдвэр гаргах үйл ажиллагааны чанар болоод эцсийн гаргаж буй шийдвэрийн нягт уялдаатай байдалд шийдвэр гаргах үйл явцад оролцогчдын **сайн хамтын ажиллагаа** ихээхэн нөлөөтэй байдаг. Шийдвэр гаргах үйл ажиллагаанд дээш доош чиглэсэн мэдээлэл солилцох, хамтран ажиллах харилцаа олонтой давтагдах нь зайлшгүй. Том олон улсын шинжлэх ухааны төслүүдэд шийдвэр гаргах үйл явц нь илүү хэцүү, цогц шинжтэй байдаг. Ялгаатай шинжлэх ухааны систем, шинжлэх ухаан технологийн бодлого, уламжлал, бодлогын соёл, сонирхол бүхий улс орнууд нэгдсэн хэлцэлд хүрэх зайлшгүй шаардлага тулгардаг. Тиймээс тухайн улс орны дотоод дахь босоо чиглэлтэй харилцаан дээр бусад улс орнуудын харгалзах шинжлэх ухааны нийгэмлэгүүд, агентлагууд, Засгийн газруудын хоорондоо харилцах хөндлөн чиглэлтэй харилцаа нэмэгддэг.

ТХХТ буюу мега төсөл (PPP and Mega project)

Түүнчлэн бүтээн байгуулалт явагдах тул мега төслүүдэд Төр хувийн хэвшлийн түншлэл (Public private partnership)-ийн харилцаа зайлшгүй яригдана.

Мега төслүүд дэх төр хувийн хэвшлийн түншлэлийн /ТХХТ/ асуудал дэлхий дахины анхаарлыг татах болсон бөгөөд гол агуулга нь засгийн газар төслийг бэлтгэж, барилгын ажил гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан өөрсдөө үйл ажиллагаа удирдлагаар хангах, эсхүл эдгээр ажлуудыг тусад нь гэрээгээр гүйцэтгүүлэх замаар хийдэг байсан уламжлалт үйл явцыг сайжруулахад оршиж байна.

Төрийн шийдвэр гаргах явц улс төрчдийн ашиг сонирхлоос ихээхэн хамааралтай бөгөөд мөнгөн хуримтлалын хөрөнгийг хувийн компани, төрийн байгууллага, улс төрчдийн нэгдэл бүхий ашиг сонирхлын бүлэг рүү чиглүүлэн зарцуулдаг, ингэснээр эдийн засгийн үр ашиггүй төслийг сонгох, хугацаа, төсвийг асар ихээр хэтрүүлэх гэх мэт бэрхшээл үүсдэг.

Төрийн үйлчилгээний нөхцөл нь ялангуяа хөгжиж буй болон шилжилтийн эдийн засгуудад чанар болоод үр ашиг муутай, инноваци хангалтгүй, өртөг шингэсэн үнэ бага, үйлчлүүлэгч, иргэдийн ядуу хэсгийг анхаарлаас гадуур орхидог гэх мэт шинж ажиглагддаг. Дэлхий даяарх дэд бүтцийн салбарын хувьчлал харилцаа холбоо, эрчим хүчний салбарт зах зээлээс илүү их хөрөнгө хуримтлагдах, илүү үр ашигтай байх, илүү сайн үйлчилгээ, инноваци бий болно гэсэн санаан дээр үндэслэсэн байдаг. Үүнтэй хамт зах зээлийн алдагдлаас шалтгаалж тодорхой үйлчилгээ бараа хүргэгдэж чадахгүй болж ингэснээр дэд бүтцийг тойрсон салбаруудад асуудал үүсэх, хэт их ашиг хонжоо харснаас үнэ өсөх, үйлчилгээ хангамжийн хангалтгүй байдал, эргэлтийн хөрөнгөгүй болох гэх мэт бусад төрлийн ачаалал үүсч байгаа нь мэдэгдэх болсон. Эдгээр сөрөг нөлөөллийг зохицуулахын тулд өргөн хүрээний менежмент шаардлагатай болсон нь Төр хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ) юм. (Johnstone and Wood, 2001; Koppenjan and Enserink, 2005).

Нийтийн хэрэгцээний төслүүдэд хувийн хэвшлийг оролцуулах нь нийгмийн үнэ цэнийг хамгаалах, сурталчилахтай хослох боломжтой. ТХХТ-ийн нэр томъёо нь төрийн байгууллага хувийн хэвшлийн дундах олон тооны хамтын ажиллагааы хэлбэрийг ерөнхийлөн тодорхойлсон ойлголт юм. (Whettenhall, 2003). Гэсэн хэдий ч энэ ойлголтод юуг багтааж ойлгох юуг оруулахгүй талаар нэгдсэн ойлголт бий.

ТХХТ-ийг тодорхойлох нь: Өргөн утгаараа ТХХТ–ийн төсөл нь урт хугацааны гэрээ, хэлцлийн үндсэн дээр хувийн хэвшлийн байгууллагууд нийтийн дэд бүтцийн төслийн зураг төсөл, барилгын ажил, техникийн үйлчилгээ үзүүлэх эсвэл бүтээн байгуулалтыг гүйцэтгэх, мөн хамтран санхүүжүүлэх цогц үйл ажиллагаа юм.

2. Оролцогчдын менежмент

COST буюу Европын Холбооны Шинжлэх Ухаан Технологийн хамтын ажиллагааны байгууллага нь 1971 онд 19 гишүүн оронтой байгуулагдаж байсан бөгөөд одоогоор Европ, Израилийн 35 гишүүн оронтойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Уг байгууллагаас 2015 оны 4 дүгээр сард мега төсөлд талууд ямар үүрэгтэйгээр оролцдог, оролцоонд тулгуурласан загвар боловсруулах талаар судалгааны ажлын тайланг танилцуулсан бөгөөд уг судалгааны зорилго нь доорх хоёр асуултанд хариулт өгөх явдал байлаа. Үүнд:

- 1/ *Мега төсөлд оролцогч талуудтай хамтран ажиллахад тохиолддог асуудлууд юу байна вэ?*
- 2/ *Эдгээр асуудлууд, төсөлд оролцогч талуудыг хэрхэн удирдах вэ?*

COST-оос явуулсан энэхүү судалгааны үр дүнг дараах байдлаар товч авч үзлээ. Үүнд:


Нэгдүгээрт: Олон Улсын хэмжээнд хэрэгжүүлсэн томоохон дараах 15 мега төслийг судлан, уг төсөлд оролцогч талуудыг тодорхойлох, мөн талууд хэрхэн, ямар үүрэгтэйгээр оролцож байгаа талаар тойм шинжилгээ хийсэн.

№	Мега төсөл	Улс	Салбар
1	Victoria	Австрали	Дэд бүтэц
2	Daocheng Yading Airport	БНХАУ	Тээвэр
3	ARJ21 C919 COMAC Aircraft	БНХАУ	Агаарын тээвэр
4	Metroselskabet Copenhagen	Дани	Тээвэр
5	Copenhagen Ringsted rail connection	Дани	Тээвэр
6	Anholt Offshore Wind farm	Дани	Эрчим хүч
7	Oresunds bridge	Дани Швед	Дэд бүтэц
8	Celtel / Zain Group	Зүүн Африк	Харилцаа холбоо
9	Yme	Норвеги	Далайн гүний газрын тос
10	Hardanger Bridge	Норвеги	Дэд бүтэц
11	ROGFAST tunnel	Норвеги	Дэд бүтэц
12	RYFAST tunnel	Норвеги	Дэд бүтэц
13	Taipeh 101	Тайвань	Барилга
14	Apple Headquarters	АНУ	Барилга
15	Hudson Yards	АНУ	Барилга

Table 1: Overview of megaprojects analyzed (Pau, L-F, Njaa, O., Langeland, A., 2014)

Хоёрдугаарт: Дээрх шинжилгээнд үндэслэн, мега төсөлд оролцогчдыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх хамгийн тохиромжтой бөгөөд тогтвортой байдлын загвар нь “5P загвар” юм гэж үзсэн. Энэ загвар нь ашиг сонирхол, нөлөөллийг хамтад нь тодорхойлох боломжтой. 5P загвар нь төсөлд оролцогч талуудын дотоод, гадаад нөлөөллийг салгаж авч үзэх бөгөөд дотоод нөлөөлөл гэдэгт мега төслийн процесс, бүтээгдэхүүнийг авч үздэг бол гадаад нөлөөлөл гэдэгт нийгэм, эдийн засаг, экологийн асуудлыг хамааруулан авч үздэг.

Зураг 1. Мега төслийг гүйцэтгэх явцад тогтвортой байдлыг хангах талаар оролцогч талуудын үр нөлөө



Гуравдугаарт: Зураг 1-т үзүүлсэн 5P загварын хувьд оролцож буй байдлаар нь ангилан авч үзэж, оролцогч талуудын төрөл, төслийн удирдлагын зүгээс хандах, хандлагын талаар дараах хүснэгтээр харуулав.

Оролцогч талуудын ангилал	Мега төсөлд оролцогч талууд	Удирдлагын арга барил, хандлагын хэлбэр
Аврагч /Saviours/	Харилцагчид, Төслийн баг, Засгийн газар, Хөрөнгө оруулагч	Эдгээр нь төслийн чухал хэсэг/тоглогч бөгөөд төслийн удирдлагын зүгээс анхаарвал зохих хэсэг юм.
Ажлыг хойшлуулагчид /Saboteurs/	Хүрээлэн байгаа орчныг хамгаалагч, экологич	Тэдгээрийн хувьд Засгийн газар, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл хүчтэй зэвсэг байдаг. Төслийн менежер нь нэхэмжлэлийн шаардлагыг хангах, төслийн талаарх мэдээллийг ил тод, тодорхой болгоход хандлагаа өөрчилж болно
Найзууд /Friends/	Сонирхлын бүлэг болон гүйцэтгэгч компани	Төслийн менежерийн хувьд сонирхлын бүлэгт тулгуурлан өөрийн хийгдэж буй төслийн талаарх үйл ажиллагаагаа олон нийтэд таниулах талаар ашигтай байдаг.
Өдөөгчид, цочроогчид /Irritants/	Орон нутгийн оршин суугчид	Нийгэм, байгаль орчны аюулгүй байдлын асуудлаар хамтран анхаарч, уг харилцааны талаар ил тод, тодорхой харилцаа холбоог гаргаж ирдэгээрээ чухал ач холбогдолтой.
Унтаа хэсэг /Sleeping Giants/	Хэвлэл мэдээлэл, агентлаг, төлөөлөгчийн газар	Хэвлэл мэдээлэл болон агентлагуудын хувьд ихэвчлэн “унтаа” байдалтай байдаг. Харин орон нутгийн байгууллага, оршин суугч зэрэг бусад этгээдээс “нэхэмжлэл” ирүүлсэн тохиолдолд ихэвчлэн шаардлага хүргүүлдэг. Энэ тохиолдолд төслийн удирдлагын зүгээс төслийн талаар танилцуулан, татан оролцуулах талаар идэвхтэй ажиллах ёстой байдаг.
Танил тал /Acquaintances/	Худалдааны төлөөлөгч, Нийлүүлэгч, Мэргэжлийн холбоод, Олон нийтийн байгууллагууд, Хэрэглэгчид	Эдгээр бүлгийхэн зөвхөн дамжуулах, харилцаа холбоо мэдээлэл шинжтэйгээр оролцдог.

Дөрөвдүгээрт: Төслийг хэрэгжүүлэх явцад оролцогч талуудыг үзүүлэх нөлөөллийн төвшингөөр нь зэрэг болон сөрөг байдлаар хүснэгтээр харуулсан бөгөөд үзүүлэх нөлөөллийн хэмжээг доорх байдлаар тодорхойлов.

	Үр нөлөө, ангилал	Зэрэг талууд	Сөрөг талууд
Маш их	Нийт нөлөө	Харилцагчид, Төслийн баг, Засгийн газар, Хөрөнгө оруулагч, Орон нутгийн засаг захиргааны байгууллага, Гүйцэтгэгч компани	Захиргааны байгууллага, Гүйцэтгэгч компани
Их	PMS, PE нөлөө	Захиргааны байгууллага	Харилцагчид, Засгийн газар
	PMS, 3P нөлөө	Нийлүүлэгч,	Орон нутгийн удирдлага, Хүрээлэн байгаа орчныг хамгаалагч, экологич
	PE, 3P нөлөө	-	Орон нутгийн засаг захиргааны байгууллага, Сонирхлын бүлэг
Дунд зэрэг	PMS нөлөө	Олон нийтийн байгууллага,	Худалдааны төлөөлөгч
	PE нөлөө	Мэргэжлийн холбоод	Хэвлэл мэдээлэл, нийлүүлэгчид
	3P нөлөө	Хэрэглэгчид,	-
Бага зэрэг	Бага нөлөө	Орон нутгийн удирдлага, Худалдааны төлөөлөгч, Хэвлэл мэдээлэл, сонирхлын бусад бүлэг	Хэрэглэгчид, Төслийн баг, мэргэжлийн холбоо, олон нийтийн байгууллага, хөрөнгө оруулагч.

PMS - /Project management success/ Энэ нь оролцогч талуудын цаг хугацаа, зардал, гүйцэтгэлийн чанарт үзүүлсэн ерөнхий үр нөлөө юм;

PE - /Project execution/ Энэ нь төслийн гүйцэтгэл үйл явц болон эцсийн бүтээгдэхүүн нийлүүлэх хүртлэх ерөнхий үр нөлөө юм;

3P - /impact or sustainability/ Энэ нь тогтвортой байдлын үр нөлөө бөгөөд байгаль орчин, нийгмийн болон эдийн засгийн зэрэг төслийн тогтвортой ажиллагаанд үзүүлэх нөлөө юм.

Мега төсөл дэх иргэдийн оролцоо: Мега төслийг хэрэгжүүлэхэд маш олон талууд хамтран ажилладаг бөгөөд эдгээр оролцогч талууд нь тухайн мега төслийн аль түвшинд, хэрхэн оролцохоос шалтгаалан оролцооны аргаа сонгодог.

Оролцооны аргаа сонгохын тулд мега төсөл дэх оролцогч талууд тодорхой болсон байх, мөн тэдний зорилго, хүчин чадал, цаг хугацаа тодорхой болсон байх нь чухал юм.

Мега төсөл дэх оролцогч талуудын нэг чухал субъект нь нийгмийн оролцоо юм. Тухайн төслийг нийгэм зөв ойлгож, хүлээн авах нь төсөл илүү амжилттай хэрэгжих нөхцлийг бүрдүүлдэг.

Иймд тухайн мега төсөлд оролцогч талууд иргэдийн оролцоог хангахын тулд хэлэлцүүлэг, зөвшилцөл, олон нийтийн уулзалт, санал асуулга, зөвлөлдөх хороо байгуулах, сургалт зохион байгуулах зэрэг арга замуудаар дамжуулан тэдний оролцоог ханган ажилладаг.

Мега төсөл нь энгийн төслөөс ихээхэн өөр бөгөөд мега төсөл амжилттай хэрэгжихэд төсөв болон цаг хугацаа хэдий чухал ч үүнээс гадна иргэдийн оролцоо буюу тухайн төслийг нийгэм хүлээн зөвшөөрөх нь маш чухал нөлөө үзүүлдгийг эрдэмтэд ажигласан байна. Учир нь маш хүчтэй нийгмийн хандлага нь тухайн мега төслийг алдаршуулж ингэснээр тухайн төсөл амжилттай хэрэгжих хөшүүрэг болдог. Амжилттай хэрэгжиж байгаа төсөл нь бүс нутгийн хөгжилд маш ихээр нөлөөлдөг.

Тэгэхээр мега төсөл дэх нийгмийн оролцоог хангах тогтолцоог бүрдүүлэх нь хамгийн чухал юм.

ГУРАВ. МЕГА ТӨСӨЛД ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ**Шийдвэр гаргах үйл ажиллагааны үе шатууд:**

Томоохон олон улсын төслүүд, бүс нутгийн болон дэлхийн хэмжээний мега төслүүдэд шийдвэр гаргах үйл ажиллагаа нь дараах 4 үе шаттайгаараа онцлог байдаг. Үүнд:

1. Төслийг тодорхойлох үе шат
2. Хариуцсан агентлагуудын зүгээс төслийн үнэлгээг хийх
3. Агентлагуудын зүгээс ЗГ-ууддаа төслийн тухай мэдээллийг өгөх
4. Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хийх.

Төслийг тодорхойлох үе шатанд дараах үйл ажиллагаа багтана. Үүнд:

- Шинжлэх ухааны нийгэмлэгүүдийн хурал, чуулганаар шинжлэх ухааны гол асуудлыг дэвшүүлэн тавих,
- Техникийн сонголтуудыг судлах (судалгаа, хөгжлийн асуудлыг оролцуулан) болон хэрэгжүүлэх техникийн шаардлагыг үнэлэх,
- Үйлдвэрлэлийн хүчин чадлын урьдчилсан загварыг гаргах,
- Хувь нийлүүлсэн төсөл хэрэгжүүлэх бүтцийг тодорхойлох,
- Шаардагдах хөрөнгө оруулалт болон урсгал зардлын тооцоог хийх, төсөв зохиох,
- Сонгогдсон салбарын шинжлэх ухаан технологийн төсөөллийг гаргах.

Энэ үе шатанд маш хүчтэй зохицуулалт хэрэгтэй бөгөөд энэхүү үйл ажиллагааны үр дүн нь төслийн эцсийн санал юм.

Хариуцсан агентлаг болон судалгааны зөвлөлөөс төсөлд үнэлгээ хийх үе шат: Үнэлгээ хийх үе шатны гол чухал хэсэг нь тухайн агентлагаас нэг шинжээчийг эсвэл хэд хэдэн шинжээчид бүхий багийг бүрдүүлэн нарийвчилсан үнэлгээ хийлгэхээр томилох юм. Энэхүү үе шатанд агентлагууд төслийн саналд өөрсдийн үнэлгээг хийдэг.

Агентлагуудын зүгээс Засгийн газарт төслийн тухай мэдээллийг өгөх: Эхлээд агентлагууд 2 дахь үе шатанд хийгдсэн төслийн саналд хийсэн үнэлгээ болон өөрсдийн улсын бодлогын байр суурь, дагалдах саналыг харилцан солилцдог. Үүний дараа агентлагууд өөрсдийн Засгийн газартаа өөрсдийн боловсруулсан санал болоод бусад улс орнуудын агентлагийн зүгээс ирүүлсэн санал үнэлгээг мэдээлдэг.

Засгийн газар хоорондын хэлэлцээр хийх: Энэ үе шатанд гол анхаарах асуудал нь төсөлд оролцох тухайн улсын сонирхлыг тодорхойлох, хамтын эзэмшил, бүтээн байгуулалтын төсөв, үйл ажиллагааны зардал зэрэгт өөрийн сонирхлоо оруулах юм. Өөр чухал зүйлс нь талуудын зүгээс төслийн үйл ажиллагаанд нэвтрэх боломж хандалтыг тодорхойлох, байрлал сонгох, мөн төсөл хэрэгжүүлэх байгууллага аж ахуйн нэгжийн хууль ёсны статусыг тодорхойлох зэрэг байдаг.

Эдгээр дөрвөн үе шат нь шугаман дараалалтай байдаггүй гэдгийг онцлох ёстой. Улс орон болгонд хамаарах шинжлэх ухааны нийгэмлэгүүд, агентлагууд, Засгийн газрууд хооронд мэдээлэл болон санал солилцох үйл явц нь доороос дээш, дээрээс доош чиглэн явагдах ба бусад улс орнуудын ижил төст байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож байдаг. Тиймээс практикт, олон тооны буцах холбоо, урагшлах холбооны зангилаасууд бий болдог. Үүний дотор шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцогч талуудыг бүхий л цаг хугацааны туршид ижил мэдээллээр хангах, мэдээлэлжүүлэх үйл явц орох ба ингэснээр гэнэтийн таагүй байдал, осол аюулаас сэргийлдэг байна.

Дэлхийн хэмжээний мега төслүүдэд зарим улс орнуудын шийдвэр гаргах үйл ажиллагааны туршлага:

АНУ-ЫН ТУРШЛАГА

АНУ-ын хувьд дэлхийн хэмжээний мега төслүүдийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцогчдыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- *Шинжлэх ухааны нийгэмлэгүүд,*
- *Агентлагууд:* голчлон Үндэсний Шинжлэх ухааны байгууллага /National Science Foundation NSF/, Эрчим хүчний газар /Department of Energy DOE/
- *Засгийн газар:* Хоёр талаас бүрдэнэ. Нэг дэх нь нарийн бичгийн даргын түвшний департаментууд, зохицуулагч агентлагууд болон Ерөнхийлөгчийг багтаасан Гүйцэтгэх засаглал. Хоёр дахь нь АНУ-ын Конгрессийн хоёр танхимаас бүрдсэн Хууль тогтоох байгууллага.

Эдгээр оролцогчид нь шийдвэр гаргах үйл ажиллагаанд дараах байдлаар оролцдог байна.

Төсөл тодорхойлох үе шат: АНУ-д том хэмжээний шинжлэх ухааны төслүүд нь доороос дээш уламжлах маягаар анх санаачлагддаг. Тиймээс санаачилга нь төсөл тодорхойлох үе шатанд гол үүрэг гүйцэтгэгч болох шинжлэх ухааны нийгэмлэгүүдээс төрөн гардаг. Шинжлэх ухааны нийгэмлэгүүдийн үүрэг нь анхдагч санааг эхлүүлэх, үндэсний болон олон улсын түвшинд хэлэлцүүлэг зохион байгуулах, судалгаа хөгжлийн ажлыг өрнүүлэх замаар төслийн санааг хөгжүүлэх, үүний дараа шинжлэх ухааны судлагдахууныг бий болгох замаар үргэлжлүүлнэ. Энэ шатны турш шинжлэх ухаанчид голчлон холбогдох агентлагтай харилцан холбоотойгоор ажилладаг бол зарим тохиолдолд Засгийн газрын түвшинд харилцан үйлчлэл бий болдог байна. Бусад түвшинтэй харилцан хамааралтай байх нь төслийг хөгжүүлж, өргөжүүлэхэд чухал нөлөөтэй юм.

Анхан шатанд, жишээлбэл, төлөвлөх болон эхэн үеийн судалгаа хөгжлийн ажлын үед агентлагууд болон Засгийн газартай маш бага харилцаа холбоотой байдаг. Агентлагийн ажилтан хөтөлбөрийн түвшинд төслийн төлөвлөлт болон шинжлэх ухааны уулзалтууд, лабораторын ажлын гүйцэтгэл болон төсвийн төсөл боловсруулах шатанд ижил түвшинд оролцдог байна. Үүнтэй холбоотойгоор төсөл тодорхойлох болон үнэлгээ хийх үе шат нь үнэндээ онцын ялгаагүй байдаг. Голлох ялгаа нь анхан шатанд аливаа ахиц дэвшлийг нарийвчлан шалгах болон хяналт шинжилгээ хийх нь харьцангуй бага байдаг.

Төсөл тодорхойлох үе шатны туршид төлөвлөж буй төсөл нь үндэсний шинж чанартай байсан ч хамаагүй хилийн чанад дахь шинжлэх ухааны нийгэмлэгүүдтэй өргөн харилцаатай байх нь бий.

Төсөл үнэлэх үе шат: Төсөл бүрэн боловсрогдож бэлэн болох үед шинжлэх ухааны нийгэмлэг болон агентлаг хоорондын харилцаа илүү албан ёсны болж өргөждөг. Агентлаг нь ерөнхийдөө төслийг ахин нягтлан хянах ажлыг илүү өргөн хүрээнд хийдэг ба үүндээ өөрийн улсын болон гадаадын хөндлөнгийн шинжлэх ухааны нийгэмлэгүүдийн мэргэжилтнүүдийг татан оролцуулдаг. Агентлагт зөвлөгөө өгөх хөндлөнгийн баг нь шүүмж, саналыг гаргадаг. Хэрвээ хоёр эсвэл түүнээс дээш тооны төслүүд санхүүжилт авахаар өрсөлдөж байгаа тохиолдолд зөвлөх баг төслүүдийг эрэмбэлдэг. Энэхүү үйл ажиллагааны үр дүнд агентлагийн зүгээс Засгийн газарт өгөх төслийг дэмжсэн эсвэл эсрэг санал шүүмж бэлэн болно. Агентлаг нь мөн тухайн санхүүгийн жил болон түүний дараагийн жилүүдийн төслийн төсөв санхүүгийн тооцоог боловсруулдаг. Эцсийн төсөвлөлт нь Гүйцэтгэх засаглалын дээд шатны байгууллагууд болох Ерөнхийлөгчийн ажлын алба, Шинжлэх ухаан технологийн бодлогын газар /OSTP/, Удирдлага, төсвийн газар /OMB/ болон Төрийн нарийн бичгийн даргын газартай хэлэлцэсний үндсэн дээр боловсруулагддаг.

Шинжлэх ухааны агентлагууд нь шинжлэх ухааны нийгэмлэгүүд болон Засгийн газар хоорондын зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг. Тэд Засгийн газартай шинжлэх ухааны нийгэмлэгийн өмнөөс, шинжлэх ухааны нийгэмлэгтэй Засгийн газрын өмнөөс харилцах нь олонтой. Тэдний үүрэг нь шинжлэх ухааны үйл ажиллагаануудыг ерөнхийд нь хянах ба ингэснээр ирээдүйд төслийн хяналт шинжилгээ үнэлгээний үе шатанд голлох үүрэг хүлээдэг. Энэ үе шатанд агентлагийн зүгээс шинжлэх ухааны нийгэмлэгтэй харилцах харилцаа нь дээд шатны байдаг. Тэд тухайн төслүүдэд дэмжсэн эсвэл эсрэг санал шүүмжийг гаргах ба төслийн санхүүжилтийн хуваарийг тодорхойлох, хэрэв шаардлагатай гэж үзвэл өрсөлдөгч төслүүдийн хооронд тохируулга хийдэг.

Шинжлэх ухааны нийгэмлэгүүдийн зүгээс Засгийн газрын салбартай харилцах харилцаа энэ үе шатны туршид конгрессийн гишүүд эсвэл хороотой холбогдох байдлаар өргөсдөг байна. Конгрессийн гишүүд өөрийн болон зэргэлдээ дүүрэг дэх лабораторын ахлах ажилтнуудтай тодорхой цаг үеүдэд харилцаатай байдаг. Шинжлэх ухааны нийгэмлэгүүдийн ахлах гишүүд тодорхой цаг үеүдэд АНУ-ын Конгрессийн өмнө өөрсдийн шинжлэх ухааны хөтөлбөр болон ирээдүйн төслийн талаарх мэдээллийг хийдэг. Зарим тохиолдолд томоохон хэмжээний төслүүдийн талаар тусгай сонголыг хийдэг байна. Энэ тохиолдолд, хэдийгээр 3 дугаар үе шатанд ороогүй байсан ч төсөлд холбогдох үнэлгээг агентлагийн зүгээс хийчихсэн байдаг ба цааш нь Засгийн газрын шийдвэр гаргах дээд түвшинд шилжүүлдэг байна.

Мэдээж шинжлэх ухааны нийгэмлэг нь удирдах түвшинд гүйцэтгэх засаглалын гишүүдтэй албан бусаар харилцаатай байх ба нарийн бичгийн дарга нарт шууд мэдээлэл өгөх зөвлөх багт оролцдог. Гэхдээ, эдгээр харилцааны ихэнх нь агентлагаар дамждаг байна.

Мэдээлэл солилцох үе шат: Энэ үе шатанд агентлаг нь шинэ төслийн танилцуулгыг Засгийн газарт танилцуулна. Эрчим хүчний департаментийн хувьд дотооддоо Нарийн бичгийн даргын ажлын албанаас дэмжлэг болон зөвшөөрлийг авдаг. Үүний дараагаар холбогдох департамент нь Удирдлага, санхүүгийн газарт төсвөө танилцуулан хэлэлцдэг. Ерөнхийлөгчийн шинжлэх ухааны зөвлөх энэ шатанд том хэмжээний санхүүжилт шаардлагатай төслүүд бэлтгэгдэх тохиолдолд илүү чухлаар оролцдог.

Агентлагууд мөн хууль тогтоох байгууллагатай харилцдаг ба энэ нь ихэвчлэн тухайн төсөлд санхүүжилт шийдүүлэхтэй холбоотой байдаг. Жишээлбэл, Үндэсний шинжлэх ухааны байгууллагын захирал болон Нээлттэй мэдлэгийн сангийн захирал АНУ-ын Конгресст өөрсдийн хариуцаж байгаа хөтөлбөрийн талаар тодорхой хугацаанд мэдээлэл хийдэг. Агентлагийн ажилтан мөн Конгрессийн зүгээс тавьсан асуулгад хариулт бэлдэх ажлын хүрээнд Конгрессийн ажилтнуудтай албан бусаар харилцаатай байж болдог. Олон улсын төслүүдийн хувьд агентлаг илүү нарийвчилсан хэлэлцээрийн ажлыг удирдан явуулдаг. Гэхдээ Шинжлэх ухаан технологийн газар ерөнхий удирдамжаар хангадаг.

Шийдвэр гаргах: Засгийн газар үндэсний хэмжээний төслийн хувьд эцсийн шийдвэрийг гаргана. Түүнчлэн олон улсын шинжлэх ухааны төсөлд тухайн улс оролцох эсэхэд ч мөн эцсийн шийдвэрийг Засгийн газар гаргадаг. Энэ шийдвэр нь оролцогч улс орнуудтай өргөн хүрээнд хэлэлцсэний дараагаар гардаг байна. Хэрвээ эерэг шийдвэр гарвал, төслийн хамтын ажиллагааны асуудлаар болон төслийн гүйцэтгэх үйл ажиллагаанд хяналт тавих асуудлуудаар хэлэлцээр хийх үүрэгтэй байдаг. Зарим олон улсын төслүүдэд, ялангуяа АНУ тэргүүлэх үүрэгтэйгээр оролцдог төслүүдэд шийдвэр гаргах үйл ажиллагаа нь олон улсын хэлэлцээр эцэслэгдэхээс өмнө хийгддэг.

Төсөвлөх үйл ажиллагаа нь АНУ-ын хувьд 2 шаттай байдаг. Засгийн газраас өргөн мэдүүлэх болон Конгрессоос батлах гэсэн 2 шаттай. Албан ёсоор бол 3 дахь үе шат байдаг ба Ерөнхийлөгч эцсийн зөвшөөрлийг өгч гарын үсэг зурдаг байна. Энэ шатанд ховорхон

тохиолдолд өөрчлөлт хийдэг. Нарийвчилсан төсвийн саналыг холбогдох газруудаас Удирдлага, санхүүжилтийн газарт хүргүүлдэг ба урт хугацааны төсвийн удирдамжинд Шинжлэх ухаан технологийн бодлогын газрын төсвийн багцад оруулан тусгадаг. Том хэмжээний болон өндөр ач холбогдол бүхий төслүүдэд шийдвэр гаргах үйл ажиллагаанд Ерөнхийлөгч өөрийн биеэр оролцдог.

2 дахь үе шатанд Конгресс дээр хэлэлцүүлдэг ба төсөвт тодорхой өөрчлөлтүүдийг оруулдаг. Конгресс мөн шинэ том төслүүдийг санаачлахад шууд зөвшөөрөл өгдөг ба төслийн санхүүжилт болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг хэзээ ч зогсоох эрхтэй байдаг. Шинжлэх ухааны төслүүдийг хэлэлцүүлэхэд намын бүлгээр хуваадаггүй ба үүнтэй холбоотойгоор Цагаан ордон болон Конгресст өөр өөр намууд хяналтаа тогтоосон байсан ч эцсийн зөвшөөрлийг өгөхөд тэгтлээ том саад тогтор учирдаггүй.

ЯПОН УЛСЫН ТУРШЛАГА

Шинжлэх ухааны мега төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд Засгийн газрын байгууллагууд болох дараах 5 яамд оролцдог.

- Боловсрол, шинжлэх ухаан, соёлын яам (Monbusho),
- Шинжлэх ухаан технологийн агентлаг (STA),
- Олон улсын худалдаа, үйлдвэрийн яам (MITI),
- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын яам,
- Эрүүл мэнд, нийгмийн хангамжийн яам.

Бусад байгууллагууд нь зорилгод чиглэсэн төслийг санхүүжүүлдэг бол БШУСЯ нь их сургуулиуд болон их сургууль хоорондын шинжлэх ухааны институциудын шинжлэх ухааны судалгааг дэмжих үүргийг гүйцэтгэдэг. Эдгээр 5 яамдаас БШУСЯ болон ШУТА нь илүүтэй мега шинжлэх ухааны төслүүдтэй холбогддог бол ОУХҮЯ нь мега төслүүдийг хариуцдаг байна. БШУСЯ болон ШУТА нь хоёулаа сансрын шинжлэх ухаан, цөмийн шинжлэх ухаан, халуун цөмийн судалгаа, нетрон болон цацраг идэвхийн судалгаа, материалын шинжлэх ухаан, амьдралын шинжлэх ухаан гэх мэт өндөр эрчим хүчний болон сансар огторгуйн судалгааг голчлон харицдаг.

БШУСЯ болон ШУТА-ын ялгаа нь тэдний шийдвэр гаргах үйл ажиллагааны механизмд байдаг. БШУСЯ нь шинжлэх ухааны нийгэмлэгүүдээс санаачлан доороос дээш өргөн барьсан академик түвшний шинжлэх ухааны төслийн санал, бусад үйл ажиллагааг хариуцдаг бол ШУТА нь хувийн хэвшил болон академик байгууллагуудын аль алинаас нь санаачилсан үндэсний болон нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан хөтөлбөрүүдийн шийдвэр гаргалтанд оролцдог байна.

Японы Шинжлэх ухааны зөвлөл


Японы шинжлэх ухааны зөвлөл (JSC) нь Японы шинжлэх ухаанчдыг төлөөлсөн байгууллага юм. Энэ нь Ерөнхий сайдын ажлын албаны дор байх ба гишүүд нь Японы бүхий л шинжлэх ухаанчдын зүгээс санал болгон сонгосон хүмүүс байдаг. Энэ байгууллага нь төслийг санхүүжүүлдэггүй, харин хороод, салбар хороодоороо дамжуулан зөвлөлдөх замаар шинжлэх ухааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чухал үүрэгтэй юм.

Японы шинжлэх ухааны зөвлөл нь шийдвэр гаргах үйл ажиллагаанд маш чухал оролцоотой ба төслүүдэд голлох санал шүүмжийг өгдөг. ЯШУЗ нь зарим онцгой тохиолдолд БШУСЯ-наас эерэг шийд аваагүй мега төслүүдийг дэмждэг байна. ЯШУЗ-ын санал шүүмж нь зарим тохиолдолд БШУСЯ-ны Шинжлэх ухааны зөвлөлийн шийдвэр гаргалтанд маш чухал нөлөө үзүүлдэг байна.

БШУСЯ-ны Шинжлэх ухааны зөвлөл

БШУСЯ-ны Шинжлэх ухааны зөвлөл нь Сайдынхаа хүсэлтээр түүнд шинжлэх ухааны бодлогын зөвлөмж өгдөг. Зөвлөлийн гишүүдийг Засгийн газраас томилдог. Зөвлөл бүх салбарын шинжлэх ухааны төлөөлөл болох эрдэмтэд болон хувийн болон нийгмийн салбарыг төлөөлсөн эрдмийн бус гишүүдээс бүрддэг. Энэхүү зөвлөл нь томоохон төслийн үед төслийн техник эдийн засаг, шинжлэх ухааны үндэслэлийг нягтлан шалгадаг. Энэхүү шалгах үйл ажиллагаанд ЯШУЗ-ийн санал дүгнэлт маш чухал хүчин зүйл болдог. Төслийг Сайдад танилцуулах үед БШУСЯ-наас Сангийн яаманд төслийн санхүүжилтийн төсвийг хамгаалдаг байна.

Зураг 2. Өндөр эрчим хүчний төслүүдэд доороос дээш шийдвэр гаргах үйл ажиллагааны схем



Төсөл тодорхойлох болон үйл ажиллагааг хянан шалгах: Том хэмжээний төслийн саналыг шинжлэх ухааны нийгэмлэгээс анхлан санаачилдаг. Цөмийн шинжлэх ухааны салбарт физикчид өндөр эрчим хүчний физик, цөмийн физик, сансрын туяаны физик болон онолын физик гэсэн 4 хэсэгт хуваагддаг. Хэсэг тус бүр Засгийн газрын үйл ажиллагаанаас хамааралгүй бие даасан хороодтой бөгөөд шинэ төслийн саналыг нарийвчлан хэлэлцдэг.

Төслүүдийг тодорхойлсны дараагаар нийгэмлэгийн зүгээс ЯШУЗ-ийн Цөмийн шинжлэх ухааны хороонд төслийн саналаа хүргүүлдэг. ЯШУЗ-ын Физикийн холбооны хороонд бүх физикчдэд төслийн саналыг танилцуулдаг. Энэ бол маш чухал алхам бөгөөд нэгдсэн шийдэлд хүрэхээс гадна боломжит нэмэлт үйл ажиллагаануудыг нэмдэг байна. ЯШУЗ-ийн хороодод хийгддэг энэхүү хяналт үнэлгээний ажлын үр дүнд төсөл илүү боловсронгуй болж, шаардлага хангахуйц болдог ба үүний дараагаар ЯШУЗ-ийн Ерөнхий ассемблей Засгийн газарт хүргүүлэх санал зөвлөмжийг гаргадаг байна.

Засгийн газрын үйл ажиллагаа: Засгийн газар төслийн шийдвэрлэх хяналт үнэлгээг БШУСЯ-ны ШУЗ-ын Хурдасгуурын шинжлэх ухааны дэд хороонд хийдэг. Хэрэв дэд хороо нь төслийн саналд эерэг үнэлгээг өгвөл БШУСЯ-ны ажилтнууд үндэсний их сургууль хоорондын судалгааны институцийн мэргэжилтнүүд эсвэл дүйцэхүйц бусад мэргэжилтнүүдтэй холбогдон төслийг илүү нарийвчлан тодорхойлдог. Хамгийн шийдвэрлэх хяналт үнэлгээ болон нарийвчилсан нягтлан шалгах ажлыг Засгийн газрын агентлаг хийдэг. Дэд хороо төслийг дэмжсэн тохиолдолд Сурталчилгаа судалгааны хороо руу илгээх ба улмаар ШУЗ-ын Ерөнхий Ассемблей руу явуулдаг.

БШУСЯ-ны Шинжлэх ухааны зөвлөл Сайдад ерөнхий зөвлөмжийг өгөх ба БШУСЯ-наас Сангийн яам руу төсвийн хүсэлтийг явуулдаг. Японы доороос дээш шийдвэр гаргах үйл ажиллагаа нь олон улсын хэлэлцээрийн үед уян хатан байхад ихээхэн дутагдалтай байдгийн улмаас хүндрэлтэй байдаг. Японы шийдвэр гаргах систем нь дийлэнх төслүүдэд хийгддэг доороос дээш механизмд бат бөх суурилсан гэдгийг онцлох ёстой. Энэ бол суурь шинжлэх ухааныг дэмжихэд чиглэсэн Японы бодлогын гол ялгагдах шинж юм.

ДӨРӨВ. МЕГА-ТӨСӨЛ: МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ

Аливаа маргаан үүсэхэд сонгодог утгаараа шүүхэд ханддаг. Шүүхэд маргаан шийдэх нь бүх шатны шүүхээр явахад хугацаа их алдах, уян хатан биш, аль нэг салбараар нарийн мэргэшээгүй зэрэг сул талтай. Харин шүүхээс гадуур маргааныг шийдэх олон арга байдгийн хамгийн түгээмэл нь арбитр болон эвлэрүүлэн зуучлах аргууд юм.

Том хэмжээний төсөл, хэлэлцээрийн гол зохицуулалтын нэг нь маргааныг хэрхэн шийдэх зохицуулалт юм. Асуудал, маргаан үүсэхэд хэн, хаана хандах, шийдвэрлэх механизм нь гэрээний оролцогч талуудад тодорхой байх нь чухал бөгөөд хөрөнгө оруулалтын гол нөхцөлүүдийн нэг юм. Иймд аливаа гэрээ хэлэлцээр, түүнчлэн мега-төслүүдийн хувьд маргааныг шийдвэрлэх зохицуулалтгүй хийх боломжгүй юм. Үүссэн маргааныг шийдэх аргыг сонгох нь оролцогч талуудын сонгох эрх боловч үндэстэн дамнасан том компанийн хувьд дотоодын шүүхээс илүү мэргэшсэн олон улсын арбитраар шийдвэрлүүлэх нь практикт өргөн дэлгэрсэн.

Талууд бие даасан, тухайн салбарт мэргэшсэн, нэр хүндтэй арбитрчдыг өөрсдөө сонгодог нь зөв, шударга, бие даасан, хараат бус байдлаар маргааныг шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлдэг бол дотоодын шүүх нь ур чадвар, гадны буюу улс төрийн нөлөө их зэрэг шалтгаанаар эргэлзээ төрүүлдэг байна. Түүнчлэн арбитрын шийдвэрийг талууд биелүүлэх үүрэгтэй, шүүхэд давж заалдах боломж хязгаарлагдмал зэрэг онцлогтой юм. Өнөөгийн байдлаар үндэстэн дамнасан компаниуд арилжаа, бизнес, хөрөнгө оруулалтын маргааныг арбитраар шийдвэрлүүлэх нь давамгай байна. Гэхдээ арбитр нь өөрийн гэсэн сул талтай бөгөөд шүүхэд давж заалдах боломж, бие даасан байдал зэрэг нь зарим тохиолдолд шүүмжлэл дагуулдаг.

Хэдийгээр арбитрын шийдвэр зарчмын хувьд эцсийн байдаг боловч цөөн нөхцөлөөр маргах боломжтой байдаг нь гадаадын арбитрын шийдвэрийг гүйцэтгүүлэхэд дотоодын шүүх баталгаажуулдаг явдал юм. Дээрх нөхцөлүүдийг НҮБ-ын Гадаадын арбитрын шүүхийн

шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, албадан гүйцэтгэх тухай конвенцид нарийвчлан тусгасан. Монгол Улс 1995 онд гадаадын арбитрын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, албадан гүйцэтгэх тухай конвенцид нэгдэн орсон бөгөөд арбитрын шийдвэр нь дэлхийн 156 оронд хүлээн зөвшөөрөгдөх, биелэгдэх боломжтой юм. Харин талууд нэгэнт гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх тал дээр хэлэлцээ хийх, тохиролцох боломж нээлттэй байдаг.¹²³

Гадаадын арбитрын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, албадан гүйцэтгэх тухай конвенц (Нью-Йоркийн Конвенц) 1958

5 дугаар зүйл:

1. Арбитрын шийдвэрээр хариуцлага хүлээх тал гагцхүү дараахь нотолгоог эрх бүхий байгууллагад гаргаж өгсөн нөхцөлд арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс татгалзаж болно:
 - а) 2 дугаар зүйлд заасан хэлэлцээр байгуулсан талууд тэдгээрт хэрэглэх хуулиар эрх зүйн чадамжгүй байсан, эсхүл талууд хэлэлцээр байгуулахдаа баримталсан буюу хэрэв үүнийг заах боломжгүй бол арбитрын шийдвэр гаргасан улсын хууль тогтоомжийн дагуу уг хэлэлцээр хүчингүй болсон;
 - б) арбитрчийг томилох буюу хэргийг арбитраар хянан шийдвэрлэх талаар хариуцагч талд зохих ёсоор мэдэгдээгүй, эсхүл хариуцагч тал нь бусад шалтгаанаар тайлбараа гаргаж өгч чадаагүй;
 - в) арбитрын хэлэлцээр буюу гэрээнд оруулсан арбитрын заалтын нөхцөлд тусгаагүй буюу түүнд заасан хэмжээнээс хэтэрсэн асуудлаар шийдвэр гаргасан; гэхдээ энэ тохиолдолд хэрэв арбитрын хэлэлцээрт заасан асуудлаар гарсан шийдвэрийн заалтыг арбитрын хэлэлцээрт заагаагүй асуудлаар гарсан шийдвэрийн заалтаас зааглан салгаж болох бол арбитраар шийдвэрлүүлэхээр хэлэлцээрт заасан асуудлын талаар гаргасан шийдвэрийн зарим хэсгийг хүлээн зөвшөөрч, албадан биелүүлж болно;
 - г) арбитрын бүрэлдэхүүн буюу арбитрын хэрэг хянан хэлэлцэх ажиллагаа талуудын байгуулсан хэлэлцээрт нийцээгүй эсхүл ийм хэлэлцээр байгуулаагүй бол арбитрын шийдвэр гаргасан орны хуулийг зөрчсөн;
 - д) арбитрын шийдвэр талуудын хувьд эцсийнх болоогүй эсхүл шийдвэр гаргасан буюу хууль тогтоомжийг нь хэрэглэсэн улсын эрх бүхий байгууллагаас шийдвэрийг хүчингүй болгосон буюу шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлсэн.
2. Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх орны эрх бүхий байгууллага дараах тохиолдолд түүнийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс татгалзаж болно:
 - а) тухайн орны хууль тогтоомжоор уг маргааны объект нь арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зүйл байж болохгүй бол; арбитрын тухайн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх явдал нь тухайн орны нийтийн дэг журамд харшилж байвал.

Монгол Улсын хувьд чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш гадаадын хөрөнгө оруулалт татах таатай эрх зүйн орчин бүрдүүлэх зорилгоор олон улсын гэрээ хэлэлцээрт идэвхтэй нэгдсэн. Энэ нь нэг талаар таатай нөлөө үзүүлэх боловч нөгөө талаар Монгол Улсад олон давхар үүрэг үүсгэдэг.

¹²³ Улс орнуудтай, мөн тэдний байгууллагуудтай байгуулсан гэрээнээс үүсдэг нийтлэг маргаанууд:

Нью-Йоркийн Конвенцийн дагуу явагдсан арбитрын ажиллагааны шийдвэрийг гүйцэтгэх нь хялбар байдаг ч янз бүрийн харьяаллын дагуу улс орнуудын эсрэг гаргасан шийдвэрийг гүйцэтгэх нь төрийн дархан эрхийн улмаас бэрхшээлтэй байдаг. Их Британи, Австрали, Сингапур, Франц (гэхдээ Хятад, Хонконгийг оруулахгүй) зэрэг орнууд төрийн байгууллагуудын арилжааны хэлцлээс үүссэн маргааныг шийдвэрлэх ажиллагааг төрийн дархан эрхийн хүрээний асуудалд тооцдоггүй. Гэвч шийдвэрийг гүйцэтгэх дархан эрх гэдэг нь тусдаа асуудал бөгөөд улсын эд хөрөнгийг нийтийн ашиг сонирхлын төлөө, эсвэл бусад дархан эрх (өөрөөр хэлбэл, дипломат ажиллагааны зорилгоор)-д хамаарах асуудлаар бус, харин зөвхөн арилжааны зорилгоор ашигласан тохиолдолд тухайн шийдвэрийг гүйцэтгэх боломжтой.

Монгол Улс болон хөрөнгө оруулалтын гэрээний арбитр¹²⁴

- 43 улстай хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээ байгуулснаас 37 гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна.¹²⁵
- Эрчим хүчний хартийн гэрээний гишүүн.
- ICSID-ийн Конвенцид нэгдэн орсон.
- Нью-Йоркийн Конвенцид нэгдэн орсон.

Гадаадын хөрөнгө оруулагчдын үндсэн эрх, эд хөрөнгийг хамгаалах механизмыг авч үзвэл 1950-аад оныг хүртэл олон улсын заншлын хэм хэмжээний хүрээнд буюу улс орнуудын хоорондоо тогтоосон дипломат харилцааны хүрээнд шийдвэрлэдэг байсан бол олон улсын худалдаа нэмэгдэж хөрөнгө оруулагчид хоорондын маргааныг улс төржүүлэхгүйн тулд шууд шийдвэрлэх арга зам шаардлагатай болж ирсэн байна.

Энэхүү шаардлагын хүрээнд олон улсын хоорондох хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх, арилжааны бус эрсдэлүүдээс сэргийлэх зорилгоор маргаан шийдвэрлэх олон талт мэргэшсэн байгууллага буюу Хөрөнгө Оруулалтын Маргааныг Шийдвэрлэх Олон Улсын Төв (International Center for Settlement of Investment Disputes (ICSID)) нь 1965 онд Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны удирдлагын санаачилгаар байгуулагджээ.

ICSID нь АНУ-ын Вашингтонд төвтэй, Дэлхийн Банкнаас санхүүждэг хэдий ч тусдаа эрх зүйн хүрээнд буюу 1966.10.14-нөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн ICSID-ийн Конвенцийн дагуу байгуулагдсан, бие даасан байгууллага юм. Өнөөгийн байдлаар 151 улс ICSID-ийн Конвенцийг соёрхон баталсан. Тус Конвенциор ICSID-аас гаргасан арбитрын шийдвэрийг ICSID-ийн Конвенцид нэгдэн орсноос үл хамааран хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэхийг бүх хэлэлцэн тохирсон улсуудад үүрэг болгосон байдаг. Тус байгууллага нь эвлэрүүлэх болон арбитрын ажиллагаа явуулдаг арбитрын комисс, арбитрын бүрэлдэхүүн, бусад хороодод институцийн болон процессын дэмжлэг үзүүлдэг бөгөөд дараах 2 багц дүрмийн хүрээнд хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлж, явуулдаг:

1. Конвенц, Журам болон Дүрэм
2. Нэмэлт зохицуулалтын дүрэм

Одоогийн байдлаар 3,000 орчим хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээ (BIT's) хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Статистик тоо мэдээллээс харахад хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотой нэхэмжлэлийн тоо байнга нэмэгдэж байгаа ажээ. Дэлхийн улс орнуудад хөрөнгө оруулалтыг хамгаалах зорилго бүхий гэрээ байгуулах нь байнга өсөн нэмэгдэж байна. Тухайлбал:

- ЕХ-АНУ-ын хоорондох Атлантын далай дамнасан Чөлөөт худалдааны хэлэлцээр (TAFTA);
- Канад-ЕХ-ны хоорондох Эдийн засаг, худалдааны иж бүрэн хэлэлцээр (CETA);
- АНУ – Хятадын хоорондох хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээний талаарх хэлэлцээр сэргээсэн;
- Номхон далай дамнасан Түншлэлийн худалдааны хэлэлцээр (TPPA) Австрали, Канад, Япон, Малайз, Мексик, Перу, АНУ болон Вьетнам;

¹²⁴ Олон улсын хэмжээнд хөрөнгө оруулалтын гэрээнээс үүссэн асуудлаар Монголтой холбоотой дараах 5 хэрэг гарч байсан нь:

1. Сергей Паушок нар болон Монголын Засгийн Газар, Орос-Монголын хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээний дагуу Юнистрал-д гаргасан нэхэмжлэл (Монгол Улс хариуцлага хүлээсэн)
2. Хан Ресурсес Инк. болон Монголын Засгийн Газар, Эрчим хүчний хартийн гэрээ болон Монголын Гадаадын хөрөнгө оруулалтын хуулийн асуудлаар Юнистралд гаргасан нэхэмжлэл (асуудал хянан хэлэлцэгдэх шатандаа явж байгаа)
3. Хятадын Хейлонгжиян олон улсын эдийн засаг, техникийн корпораци болон Монголын Засгийн Газар, Хятад-Монголын хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээний дагуу Юнистрал-д гаргасан нэхэмжлэл (асуудал хянан хэлэлцэгдэх шатандаа явж байгаа)
4. SGS Ресурсус болон Монголын Засгийн Газар, Сингапур-Монголын хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээний дагуу (нэхэмжлэлийг татаж авсан)
5. Алстон Пауэр Италиа ХХК болон Монголын ЗГ, Эрчим хүчний хартийн гэрээтэй холбоотой үг нэхэмжлэлийг ICSID No. ARB/04/10 тоот хэргээр бүртгэж авсан байна (маргааныг 2004 онд шийдвэрлэсэн) зэрэг болно.

¹²⁵ <http://investmentpolicyhub.unctad.org/IIA/CountryBits/139>

Харин зарим орнууд нь хөрөнгө оруулалтыг хамгаалах хэлэлцээрийг цуцлах шийдвэр гаргаж байна:

- Өмнөд Африк Улс Европын Холбооны зарим улстай байгуулсан анхны хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээнүүдээ цуцалжээ.
- Эквадор, Венесуэл, Боливи улсууд мөн адил аргаар хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээгээ цуцалж, маргааныг хөрөнгө оруулагч болон улсын хоорондох маргаан шийдвэрлэх байгууллагаар шийдвэрлүүлэхээс татгалзаж байна. Түүнчлэн Индонез Улс нь мөн адил маргааныг хөрөнгө оруулагч болон улсын хоорондох маргаан шийдвэрлэх байгууллагаар шийдвэрлүүлэхээс татгалзах шийдвэр гаргаад байна. Дээрх шийдвэрүүдийг улс төрийн шалтгаантай гэж тайлбарлаж болох бөгөөд тус байгууллагыг Үндэстэн дамнасан корпорациудын талд шийдвэр гаргадаг гэж шүүмжлэн эсэргүүцлээ илэрхийлсэн байна.
- Австрали Улс цаашид хөрөнгө оруулалтыг хамгаалах хэлэлцээрт хөрөнгө оруулагч-улсын хоорондох маргааныг арбитраар шийдвэрлүүлэх заалт оруулахгүй гэж мэдэгдсэн байна.

Зарим хөрөнгө оруулалтын хүлээж авсан улсууд тухайн тодорхой маргааныг арбитраар шийдвэрлүүлэх санал тавихын тулд хөрөнгө оруулагч ижил маргааныг бусад арбитрайн байгууллагаар, жишээ нь, тухайн улсын шүүхээр, эсвэл өөр өмнө тохиролцсон маргаан шийдвэрлэх механизмаар шийдвэрлүүлэх нэхэмжлэл гаргаагүй байх ёстой гэж шаарддаг. Ижил маргаан нь нэг адил талууд холбогдсон байх, нэхэмжлэл гаргасан үндэслэл нь адил байх, адил зорилготой байхыг хэлнэ. Хөрөнгө оруулалтын зарим хуучин гэрээнүүдэд тухайн маргааныг дотооддоо шийдвэрлэх бүх шатыг барагдуулсан байхыг шаарддаг бол бусад нь тодорхой хугацааны дотор дотоодын шүүхээр шийдвэрлүүлэх оролдлого хийсэн байхыг шаарддаг.

Томоохон төслүүдийн хувьд аливаа маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх, маргаан үүсэхээс өмнө илрүүлэх тал дээр ихээхэн ач холбогдол өгч байгаа бөгөөд арбитрайн шүүх гэхээсээ өмнө асуудлыг эвээр шийдвэрлэхийг эрхэмлэж байна. Мэргэжлийн зуучлагчийн тусламжтайгаар оролцогч талууд хэн, ямар үүргээ зөрчиж байгаа талаар ярилцаж, авах арга хэмжээний талаар хэлэлцэн тохиролцох боломжтой юм.

Маргаан зохицуулах бусад аргууд

Томоохон төслүүдийн хувьд үүссэн маргааныг арбитраар шийдвэрлүүлэх нь хамгийн түгээмэл байдаг ч сүүлийн жилүүдэд арбитраар маргаан шийдвэрлүүлэх нь хугацаа болон зардлын хувьд зарим тохиолдолд шүүхээс илүү хүндрэл, чирэгдэлтэй болж ирсэн. Иймд зардал хямд, түргэн шуурхай шүүхийн бус журмаар маргаан хянан шийдвэрлэх завсрын буюу олон шатлал бүхий маргаан шийдвэрлэх механизмууд хөгжиж байна. Түгээмэл хэрэглэгдэж буй дунд шатны маргаан шийдвэрлэх механизмууд нь олон хэлбэртэй байдаг. Үүнд: маргаан таслах зөвлөл, шинжээчийн дүгнэлт, шүүхийн болон арбитрайн шийдвэр мөн эвлэрүүлэн зуучлах зэрэг юм. Арбитрайн өмнөх шатанд маргааныг шийдвэрлэх арга нь хоёр ангилагддаг:

- эхнийх нь тохиролцох - нөхөрсгөөр шийдвэрлэх; зуучлах; маргаан таслах зөвлөл (Dispute Resolution Board),
- хоёр дахь нь шийдвэрлэгч - шүүхийн шийдвэр гаргах; шинжээчийн дүгнэлт, маргаан хянан шалгах зөвлөл (Dispute Adjudication Board).

Дээрх тохиолдлуудад, эцсийн шийдвэр болон эцсийн гуравдагч этгээдийн шийдвэр гардаггүй, харин маргаан хянан шийдвэрлэх эцсийн шийдвэрийг арбитра, эсхүл зарим тохиолдолд шүүх гаргана.

Маргаан шийдвэрлэх зөвлөл нь гурван төрөлтэй байгаа бөгөөд эдгээр нь DRB, DAB болон Олон улсын худалдааны танхим (ICC)-аас байгуулсан Нэгдмэл маргааны зөвлөл (Combined Dispute Board) юм.

Дээрх зөвлөлүүдийн гол ялгаа нь DRB тодорхой маргааны асуудлаар холбогдох талуудад зөвлөмж гаргадаг бол DAB-ын шийдвэрийг талууд заавал дагаж мөрдөх бөгөөд тухайн шийдвэрийг арбитраар хүчингүй болгож болно. Энэхүү шийдвэрийг гэрээний дагуу биелүүлэх ёстой бөгөөд шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд гэрээг зөрчсөнд тооцно. CDB гэдэг нь оролцогч талууд нь өөрсдөө маргаан таслах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг зөвлөмж байх уу, эсхүл шийдвэр байх уу гэдгийг өөрсдөө тогтооно.

DRB нь АНУ-д түгээмэл хэрэглэгддэг бол DAB нь АНУ-аас гадна түгээмэл хэрэглэгдэж байна.

Маргаан хянах зөвлөл нь ихэвчлэн гэрээний эхэнд түр байгуулагдаж, томоохон төсөл дээр ихэнхдээ гурван гишүүнтэй байна. Төслийн нийт хугацааны туршид оролцогч талуудаас мэдээлэл авч, төслийн хэрэгжилттэй танилцана. Зөвлөл нь оролцогч талуудтай албан бус уулзалтуудыг тогтмол зохион байгуулах бөгөөд цөөнгүй тохиолдолд маргааныг даамжрахаас өмнө албан бус байдлаар шийдвэрлэдэг байна.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Монголын хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээнүүд,
- <http://investmentpolicyhub.unctad.org/IIA/CountryBits/139>
- ХОМШОУТ-ийн Конвенци, Журам болон Дүрэм
- https://icsid.worldbank.org/ICSID/StaticFiles/basicdoc/CRR_English-final.pdf
- Venezuela's Withdrawal From ICSID: What it Does and Does Not Achieve, <https://www.iisd.org/itn/2012/04/13/venezuelas-withdrawal-from-icsid-what-it-does-and-does-not-achieve/>
- Investment Policy Review, Mozambique 2012 UNCTAD
- https://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=1&ved=0ahUKEwjX6sya77nKAhVGnJQKHTmmCY4QFggdMAA&url=http%3A%2F%2Functad.org%2Fen%2FPublicationLibrary%2Fdiaepcb2012d1_en.pdf&usq=AFQjCNGi28b_zDSc2as_6MLQqplkvly_g&cad=rja
- Law on PPP's, LSP's and BC's, Mozambique, 2011
- [http://www.acismoz.com/lib/services/translations/Law%20no%20%2015%202011%20of%2010%20August%20\(Mega%20Projects%20Law\)%20%20SC%20free%20translation.pdf](http://www.acismoz.com/lib/services/translations/Law%20no%20%2015%202011%20of%2010%20August%20(Mega%20Projects%20Law)%20%20SC%20free%20translation.pdf)
- Гадаадын Арбитрын Шийдвэрийг Хүлээн Зөвшөөрөх, Биелүүлэх тухай Конвенц, 1958 <http://www.legalinfo.mn/law/details/1251?lawid=1251>
- Нэмэлт зохицуулалтын дүрэм, ICSID
- <https://icsid.worldbank.org/ICSID/StaticFiles/facility/iii.htm>
- http://trade.ec.europa.eu/doclib/docs/2015/january/tradoc_153046.pdf
- General Distribution OCDE/GD(95)82
- Megascience: the oecd forum. Connections among scientists, agencies and governments in decision making for regional and/or global megaproject <http://www.oecd.org/officialdocuments/publicdisplaydocumentpdf/?cote=OCDE%2F%2FGD%2895%2982&docLanguage=En>
- www.Tailaws.com - Regulation of the Office of the Prime Minister on the Undertaking of public Mega-Project for Country Development, B.E.2549(2006)



УИХ-ын Тамгын газар ©
“СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ – XXII БОТЬ”

УИХ-ын Тамгын газрын Хэвлэх, олшруулах цех
Хэвлэлтэнд шилжүүлсэн: 2016.03.28
Хэвлэлийн хуудас: 26.5, Хэвлэсэн тоо: 350
Цаасны хэмжээ: B5

УБ., 2016